

# СИДНИ ШЕЛДОН

ОД НЬ ГИЙСЭН БҮСГҮЙ

ЭНЭ ГЭРЭЭНИЙ  
ЭРЭГТЭЙ ХАМТАН "САНДАН" ХЭМЖЭЭГЭЭР  
ЭХЭЛЭГЭЭР...



bestseller

**СИДНИ ШЕЛДОН**

# ОД НЬ ГИЙСЭН БҮСГҮЙ

[www.kiebooks.com](http://www.kiebooks.com)

# Тэргүүн дэвтэр

## Нэгдүгээр бүлэг.

1992 оны 9-р сарын 10 Пүрэв гариг.  
20 цаг 00 минут

"Боинг-727" онгоц зах хязгааргүй үргэлжлэх тэнгисийн дээгүүр хөшиглөх өтгөн хар үүлэнд далдран оров. Хүчирхэг хөдөлгүүртэй онгоц, муухай аашлах тэнгэрт яг л мөнгөлөг цагаан бяцхан өд аятай үзэгдэнэ.

Гэнэт онгоцны чанга яригчаар хөлгийн даргын сандруу дуу гарав.

-Хатагтай Камерон! Та хамгаалалтын бүсээ бэхэлсэн үү?

Хариу алга байсанд хөлгийн дарга дахин,

-Хатагтай Камерон... Хатагтай Камерон! гэв.

Хүүхэн нүдээ алгуур нээж,

-Бэхэлсээн гэлээ. Жаргалтай сайхан өнгөрсөн үеэ дурсан, алсад тэнүүчлэн байсан бодол санаа нь эргэн бодит байдалд шилжихэд түүнд их л хүнд байх ажээ.

-Та айгаагүй биз? Аянгын өтгөн хар үүлнээс мөдхөн гарна.

-Рожер оо, миний бие тун сайн

байна. Санаа бүү зов хэмээн хатагтай Лара Камерон хариу өгүүлэв.

Хэрэв онгоц газарт хэмх уначихгүй, бидэнд аз дайрвал тэр шүү хэмээн Лара боджээ. Тэгвэл мөн ч тааламжтай төгсгөл болж, бүгд л хаа нэгтээ, хэн ч мэдэхгүй газар үнсэн товрог болох биз. Хувь заяа гэсэн бодол түүний санаанд гялсхийн ороод гарав. Хувь заяатайгаа бүү арсалд. Жилийн өмнө болсон тэр нэгэн явдал урьдаас таахын эцэсгүй эргэлт болж, амь амьдрал нь дээсэн дөрөөн дээр дэнжигнэж, Ларад хамаг байдагаа алдах аюул заналхийлсэн юмсанж. Одоо муу

зүйл тохиолдохгүй биз ээ. Муу зүйл тохиолдлоо гэхэд тэр нь юу ч биш.

Нисгэгчийн бүхээгний хаалга цэлийтэл нээгдэж, онгоцны зааланд хөлгийн дарга орж ирлээ. Тэрээр өөрийн зорчигч бүсгүйгээ шимтэн ширтэж хормын төдийд хөшиж орхив. Онгоцны гэгээвчийн дэргэд суух гялалзсан тас хар үс, өөгүй зуйван царай, уян зөөлөн харцтай нүдэнд дулаахан саарал нүдтэй эл бүсгүй үнэхээрийн гоо үзэсгэлэнтэй ажээ. Риногийн нисэх зурваснаас онгоц тасрах тэр үед бүсгүй хувцсаа сольж амжсан байлаа. Гүн ухлаадас бүхий гоёлын цагаан палааж нь түүний гоолиг сайхан бие хааг улам



тод болгох аж. Хүзүүн дэх очир алмаазан сондор нь онгоцны бүдэгхэн гэрэлд бүүдийн гялалзана. Чөтгөр алгад гэж, дасаж дадсан ертөнц нь сүйрч баларч дуусах гэж байхад, ийм амар амгалан байж яаж чадаж байна? хэмээн нисгэгч эр бодов. Тэр хүүхний нэр алдрын эргэн тойрон дахь дуулиан шуугиан сар гаруй хэвлэлийн хуудаснаас салаагүй билээ.

-Рожер, холбоо ажилд орсон уу?

-Үгүй л болов уу даа, хатагтай Камерон. Аянгат үүл холбоонд ихээхэн саатал гаргадаг юм. Ла-Гуардад газардахад дор хаяж хагас

цагаар саатах нь байна, гүнээ хүлцэл өчье.

"Тэгэхээр би төрсөн өдрийнхөө хүлээн авалтанд хоцрох болох нь ээ" хэмээн Лара бодлоо. Гэтэл тэнд дэлхийн өнцөг булан бүрээс зочид ирцгээх гээд байдаг. АНУ-ын дэд ерөнхийлөгч, Нью-Йорк мужийн амбан захирагч, хотын дарга, Голливудын одод, нэр цуутай тамирчид, олон арван улс гүрний мөнгөний тулам болсон баячуулыг багтаасан хоёр зуугаад зочид ирнэ. Лара зочдынхоо нэрсийн жагсаалтыг өөрөө гардан хийсэн юмсанж.

Түүний нүдний нь өмнө хүлээн авалт

болох "Камерон-Плаза"-гийн  
хээнцэр танхим үзэгдэх шиг болов.  
Танхимын чийдэнгийн болор  
бүрхүүл, өндөр үнэтэй гялалзсан  
мөнгөн хэрэглэл, голландын цас шиг  
цагаан, цардмал ширээний бүтээлэг,  
нимгэн гоёмсог шаазан эдлэл болон  
жүнзнүүд... ширээ бүхний голд  
тавьсан болор савтай өнгө  
алаглуулан хуар нийлүүлсэн ховор  
цэцэгс...

Хүлээн авалтын танхимын хоёр  
талаар уужим саруул амралтын  
тасалгаа-хавч, түрс тэргүүтэй тансаг  
хүйтэн зууш, мөнгөн хувинтай  
мөсөнд сойн хажуулдуулан тавьсан  
оргилуун дарс овоолсон баарын

лангуу үзэгдэнэ. Гал зуухны өрөөнд асар том тансаг бялуу цагаа хүлээн сүндэрлэнэ. Рестораны ерөнхий үйлчлэгч, хамгаалагч гээд бүх л үйлчилгээний ажилтнууд өөр өөрийн байраа хэдийнэ эзэлчихсэн.

Зааланд тоглож буй хөгжмийн эгшиг сулхан сонсогдоно. Хүлээн авалтийн эзэн хатагтайн дөчин насны ойн баяр ёслолын ажиллагаа туйлын хөгжилтэй байх ёстой тул алдартай рок-группийнхэн зочдын сэтгэлийг бүжгийн талбай руу аажим татна. Бүх юм бэлэн болж, энэ үдшийн зоог тансаг болох нь гарцаагүй.

Баярын ажиллагаа нь ч гэсэн

амжилттай болох нь мэдээж. Хүүхэн тэргүүнээ өндөрт өргөн зочдын зүг алхлан орж очиход, тэдний хэн нь ч юуг ч эс сэжиглэнэ. Тэгээд ч тэрээр Лара Камерон шүү дээ.

Онгоц нисэх буудалд газардсаны дараа Лара хүлээн авалтнаас хагас цаг хоцорч байгаагаа мэдсэн ч тэрээр гарах хаалганы дэргэд очоод нисгэгчид хандан,

-Рожероо, бид Рино руу өнөөдөртөө буцна шүү. Шөнө дөлөөр байсан ч хамаагүй хэмээхэд,

-Мэдлээ, хатагтай Камерон, би таныг эндээ хүлээж байя гэж нисгэгч эр

хариулав.

Онгоцны шатны дэргэд урт хар  
лимузин ажухан ойртон ирж,  
дотроос нь жолооч эр гарч ирээд, их  
л найрсагаар хойт хаалгыг  
онгойлгон,

-Хатагтай Камерон, бид ч сандарч  
эхэлсэн шүү гэхэд нь,

-Аянгын үүл жаахан саад боллоо,  
Макс аа. Алив, "Плаза" руу хурдалж  
үз гэв.

-Мэдлээ, хатагтай.

Лара лимузинд суунгуутаа хүлээн

авалтыг зохион байгуулж буй Жерри Таунсендын утсанд залгав. Түүнд зочид нь өөрсдийгөө хэнд ч хэрэггүй улс хэмээн бодоогүй байгаасай гэдгийг лавлах нь туйлын чухал байлаа. Харилцуурт дуудах дохио удтал хангинав. Жерри танхимд байгаа бололтой хэмээн Лара бодоод,

-Макс минь хурдлаарай хэмээн яаравчлуулав.

-Санаа бүү зовоо, хатагтай Камерон.

Аварга том "Камерон-Плаза" зочид буудлын төрх нь бүсгүйн сэтгэл зүрхэнд өдий зэрэгт хүрсэн гэх

бахархах мэдрэмжийг үргэлж  
төрүүлдэг байсан боловч энэ  
үдшийн тухайд тэр нэгэн тааламжит  
бодол нь түүний тархинаас ор  
мөргүй арчигдсан байв. Ээ бурхан  
минь, хүмүүс аль хэдийнэ  
цугларчихсан, одоо ч уйтгарт  
дарагдчихсан сууж байгаа биз!

Лара зочид буудлын эргэдэг, хүнд  
хаалгыг хүчтэй түлхэн ороод  
шийдэмгий алхаагаар хүлээлгийн  
танхимыг хөндлөн гарч явтал хаа  
нэгтээ хажуугаас нь туслах менежер  
Карлос нь гэнэт гарч ирээд, -Хатагтай  
Камерон... гэж дуудав.

-Карлос, дараа больё.



Лара том танхимын үүдэнд ирээд амьсгаагаа дарахаар түр зогслоо. Би бүрэн тайван байна. Бусгүй нүүрэндээ туйлын амарлингуй инээмсэглэл тодруулсаар хаалгыг нээмэгцээ гайхширч орхин хөшчихөв. Танхим тас харанхуй. Юу болох нь энэ вэ, зочид түүнд онцгой бэлэг бэлдсэн хэрэг үү?

Лара зүүн гараараа унтраалга тэмтрэн олоод дарвал танхим дүүрэн нүд гялбам хурц гэрэл аслаа. Хэн ч, юу ч байхгүй хов хоосон танхим бүсгүйгхирдхийн цочирдуулав.

Хоёр зуун хүн хаашаа алга болчих нь

тэр вэ? Урилган дээр оройн найман цагт гэж тов тодоор бичсэн юмсан. Гэтэл одоо есөд арваад минут дутуу байдаг. Тэд агаарт замхраад алга болно гэж байх уу? За хаанаас даа, ямар хий үзэгдэл биш дээ. Том танхимыг тойруулан харах Ларагийн хамаг бие нь чичрүүдэс оргин мөрөө хавчлаа. Яг нэг жилийн өмнөх энэ өдөр, энд түүний найз нехөд цугларч, хөгжим эгшиглэн баярлан хөөрсөн тэдний инээд ханиад энд тэндгүй цангинаж байсныг тун сайн санаж...

## Хоёрдугаар бүлэг.

Яг нэг жилийн өмнөх энэ едер Ларагийн ажлын хуваарь ийм байлаа.

1991 оны 9-р сарын 10 нд:

5. 00. Өглөөний дасгал хийх

7.00. Телевизийн студид очиж "Өглөөний мэнд, Америк орон!" нэвтрүүлэгт оролцох.

7. 45. Японы банкны эзэдтэй уулзах.

9. 30. Жерри Таусендтэй уулзах.

10.30. Шинэчилэн байгуулалтын талаар хорооны хурал.

11.00. Факс, утсаар ярих, шуудан үзэх.

11.30. Барилгын талаар зөвлөлгөөн.

12.30. Ажил хэргийн талаар комиссын төлөөлөгчидтэй уулзах.

13.00. Үдийн цай, "Форчун" сэтгүүлийн Хью Томпсонд ярилцлага өгөх.

14.30. "Метрополитен юнион" банкинд уулзалтанд очих.

16.00. Төлөвлөлтийн талаар хотын комисстой уулзах

17.00 Грейси-Мэншнд хотын захирагчтай уулзах.

18.15. Архитекторуудтай уулзах.

18.30. Орон сууцны барилгын хэлтэсийнхэнтэй уулзах.

19.30. "Даллас инвестмент групп"-ийн эрхэм төлөөлөгчидтэй уулзах.

20.00. "Камерон-Плаза"-д хүлээн авалттай,

\* \* \*

Дасгалжуулагч Кенийг тэсэн ядан  
хүлээж байсан тод хөх цэнхэр  
өнгийн өмсгөлтэй Лара,

-Өнөөдөр яагаад оройтов, анд минь  
гэсээр угтав.

-Өршөөгөөрэй, хатагтай Лара  
Камерон. Сэрүүлэг ажилсангүй,  
тэгээд би.

..

-Хэзээ ч бүү хоцорч бай. Алив  
эхэлцгээе.

-Ойлголоо.

Тэрээр хагас цаг шахам хөшсөн биеийнхээ чилээг гарган биеэ халаасны эцэст аэробикийн хүнд дасгалдаа орцгоов. Түүний бие яг л цэл залуу хорин насгай юм шиг байх юм. Ийм хүүхнийг өвөртөө оруулбал ч тэнгэрийн умдаг атгалаа л гэсэн үг хэмээн санаашран бодох Кен өглөө бүр энд ирж, өөрөөр нь дасгал заалгадаг үйлчлүүлэгч хүүхнээ шүлэнгэтэн ширтлээ.

Танилууд нь: "За хөө, цаад Лара Камерон чинь хэр юм бэ дээ?" гэж асууж шалгаахад тэрээр баруун гарынхаа эрхий хурууг гозойлгон байж,

-Ийм шүү гэсэн хариултыг үргэлж өгдөг ажээ.

Хүнд дасгалуудыг ядаж цөхөх юмгүй хийх Ларагийн ухаан бодол хаа нэгтээ тэртээ алсад тэнүүчилнэ.

Аэробикийн хичээл дуусахад Кен,

-Явж таны оролцох "Өглөөний мэнд, Америк орон!" нэвтрүүлгийг үзлээ гэж өгүүлэхэд,

-Чи юу гэсэн бэ? хэмээн гайхан асуух үедээ Ларагийн уураг тархи японы банкны эзэдтэй хэлэлцэх асуудлаа тунгаан бодож байжээ.



-Баяртай, хатагтай Камерон.

-Дахин хоцорч ирэв ээ, Кен!

Шүршүүрт орсон Лара бүсгүй хувцсаа солиод, харшийнхаа саравчит тагтан дээр орь ганцаараа суун өглөөний цайгаа уулаа. Өглөөний зоогондоо тэрээр ногоон цай, шилэн аяга жүржийн ундаа, багахан шиг үзэм иджээ.

Лара ажлынхаа өрөөнд орсноо, дотуур холбоогоороо нарийн бичгийн дарга хүүхэнд хандаж,

-Би далайн чанад руу хэд хэдэн холын дуудлага хийнэ. Долоон цаг

гэхэд Эй-би-си-гийн студид очих ёстой. Макс доор хүлээж байг гэв.

"Өглөөний мэнд, Америк орон!" хэмээх нэвтрүүлэг шууд явагдсан тул ямар ч эвлүүлэг бульхайгүй болов. Хөтлөгч Жоан Лунден цаг ямагт нэвтрүүлгийн санаачлагыг гартаа атган чамбай хөтлөх тул ямар ч өө сэвгүй болж байлаа. Жоан,

-Хэрвээ андуураагүй бол дөрвөн жилийн өмнө билүү дээ, та манай нэвтрүүлэгт оролцож байхдаа дэлхийн хамгийн өндөр, тэнгэр баганадсан байшин барина хэмээн дурьдсан байхаа гэхэд Лара толгой дохин,

-Тэр үнэн. Арван хоёр сарын дараа гэхэд "Камерон-таур" ашиглалтанд орно гэлээ.

-Танд ямар мэдрэмж төрж байгаа нь тун сонин байна. Та бизнесийн хүрээнд ийм өндөрт хүрчихээд, яаж ийм сэтгэл татам гоо үзэсгэлэнтэй хэвээр байж чадав аа? Хатагтай Камерон, та манай зонхилох олон үзэгч бүсгүйчүүлийн маань туйлын хүсэл нь болсноо мэдэх үү?

-Энэ ч дэндүү хэтрүүлсэн тодорхойлолт байна. Ажил маань надад өөрийнхөө тухай бодох цаг зав олгодоггүй юм гээд Лара инээмсэглэв.

-Гэвч та үл хөдлөх хөрөнгийн бизнесийн хүрээнд гайхалтай амжилтанд хүрсэн, гэтэл энэ салбар маань эрчүүдийн эрхэлдэг ажил биш үү? Таныг ийм өндөрлөгт оршин тогтноход чинь юу тусалдаг бэ? Жишээ нь: Шинэ барилга байшин хаана барихаа та хэрхэн шийддэг вэ?

-Барилга барих талбайг би сонгодоггүй, харин талбай намайг сонгодог юм. Би сул цулгүй газрын дэргэдүүр машинтай явж байхдаа энэ бол эзгүй зэлүүд газар бус харин гоё ганган албан газар ч юм уу, эсвэл оршин суугч болгон нь тохь тухтай таатай байгаагаа мэдэрсэн орон

сууц байх уу гэдгийг олж хардаг. Би ердөө л энэ бүхнийг мөрөөддөг юм.

-Таны мөрөөдөл биелэх болтугай. Эрхэм хүндэт үзэгчдээ богинохон рекламн дараа ярилцлагаа үргэлжлүүлье. Сувгаа бүү солиорой.

Лара бүхэл бүтэн 12 цагийн нислэг хийн чилээрхсэн гийчид нь ухаанаа төвлөрүүлэх тэнхээгүй байхыг нь бодолцон Токиогоос урд өдрийн үдэш оройхон ирсэн японы банкны эзэдтэй өглөө эртлэн 7.45-д уулзахаар товлосон байна.

Зочин эрхмүүд ширээний ард суусан даруйдаа алжааж чилээрхсэнээ

гайхан халаглаж, баашлан башир  
арга хэрэглэхэд нь,

-Эрхэм ноёд оо! Энэ бол миний та  
нарт гаргаж чадах цорын ганц  
боломжит цаг. Би уулзалтын дараа  
шууд нисэх онгоцны буудал орно.  
Учир нь Өмнөд Америкт  
хойшлуулшгүй шийдэх ганц, нэгэн  
асуудал байгаа хэмээн Лара түс тас  
хэлэхэд нь самуурайн илд шигээ  
хурц соргог ухаантай, гойд эелдэг  
дөрвөн япон жентельменүүд  
эвлэрэхээс өөр замгүй болжээ.  
Арван жилийн өмнөх ажил хэргийн  
ертөнц тэдний башир аргыг илт  
дутуу үнэлэх байсан биз. Гэвч ийм  
алдаа хойшид давтагдахгүй нь

лавтай.

Тэдний уулзалт Америк-өргөн чөлөө дэхь Камерон төвд болж байв.

Зочдын янзын нь харвал даруухан загнах авч дэндүү үнэтэй япон үндэсний бэлгээ урьдчилан ширээн дээр нь дэлгэн тавьсан хэлэлцээрийн уужим өрөөнд орууллаа. Лара ч гэсэн гар хоосон байсангүй хүн бүрт бэлэг гардуулав.

Нарийн бичиг хүүхэнд бэлгийг ердийн бор эсвээс саарал өнгийн цаасанд боох ёстойг урьдчилсан сануулсан ажээ. Үхэлтэй холбон үздэг тул цагаан өнгө Наран ургах

зүгийн хүүхдүүдэд цээртэй байдаг  
агаад өчүүхэн төдий тод енгийн  
баглаа боодлыг дорд үзэж,  
доромжилсон хэрэг хэмээн үздэг  
ажээ,

Япончууд Ларагийн барих гэж буй  
зочид буудлын иж бүрэн цогцолборт  
зуун сая долларын хөрөнгө оруулах  
санаатай байжээ,

Ларагийн хувийн зөвлөх Трэйси  
зочдод цай, харин боссдоо аяга  
кофе авчирч өгөхөд цайны дэг жаяг  
ая данг ёсчлон биелүүлэх төрөлхийн  
мэдрэмжтэй япон эрхмүүд цайлах  
ёслолыг гүн хүндэтгэлтэйгээр хүлээж  
авав. Тэднийг аягаа хоослон цайгаа



ууж дуусангуут Трэйси эзэгтэйнхээ дохиогоор дахин цай аягална.

Өрөөнд Ларагийн хамтран зүтгэгч Говард Келлер орж ирлээ. Тавин насыг шүргэж яваа хатингар бие, цонхигор царайтай, элсний өнгө мэт өрвийсөн сиймгэр шингэн үстэй, үрчийж үнгэгдсэн костюмтай мань эр дөнгөж сая орноосоо өндийсөн болов уу гэлтэй харагдана. Лара

Говардыг японы санхүүч нарт хэлэлцээрийн эх нооргийн хуулбарыг өгсний дараагаар тэдэнд хоршоо эрээ танилцуулаад, -За ийм байна даа, жентельменүүд ээ. Хөрөнгө оруулалтын анхны хувилбар

энэ юм. Цогцолборт долоон зуун хорин өрөө тасалгаа, гучин мянган квадрат фут талбайг нь хурлын заал болон хэлэлцээний өрөөнд зориулагдаж, газар доорх хэсэгт мянгаад автомашины зогсоол...

Хэдийгээр илтгэгч бүсгүйн бат итгэлтэй дуу хоолойд зориг төгөлдөр эрч хүч оргилох боловч хэлэлцээрийн хуудсыг удаан гэгч эргүүлэн суух зочид нойртойгоо тэмцэж буй нь илт.

Хоёр цаг шахам үргэлжилсэн яриа туйлын амжилттай өндөрлөж, олон саяын хэлэлцэрийг ядах юмгүй байгуулсан нь гүйж гувшиж байж

банкнаас тавин сая доллар зээлснээс ч амар хялбар бүтлээ гэдгийг Ларатун сайн ойлгов.

Япончуудтай хийсэн уулзалт дөнгөж өндөрлөмөгц Жерри Тауненд түүний өрөөнд орж ирлээ. Голливудын даамал байсан өндөр нуруутай, үргэлжийн урам зоригтой явдаг тэрээр өдгөө "Камерон Энтерпрайз"-ын нийгмийн харилцааны хэлтсийг толгойлж буй ажээ.

-Өнөөдрийн теле ярилцлага амжилттай болж өнгөрлөө. Сэтгэл нь хөөрсөн шүтэн бишрэгч бүсгүйчүүл зогсоо зайгүй утасдаж байна. -  
"Форбс"-оор сонин юу байна?

-Би тэдэнтэй аль эрт тохиролцчихсон. "Пипл" сэтгүүлийн дараагийн дугаарын хавтсанд чиний зургийг хэвлэнэ. Харин чи "Нью-Йоркер" сэтгүүлийн өгүүллийг уншсан уу? Мөн ч сайн бичсэн байна билээ дээ.

-Муугүй болсон байна билээ.

-Үдээс хойш чи "Форчун"-д ярилцлага өгөх ёстой.

-Би түүнд чинь бага зэрэг засвар хийнээ.

-Ямар өөрчлөлт вэ? гэж Жерри ихэд сонирхон асуув.

-Би сурвалжлагчдыг энд үдийн хоолонд урихаар шийдээд байна.

-Сэтгэлийг нь уяраах гэж үү?

Лара дотуур холбооны товчийг дарж,

-Кэти, наашаа ороод ирээч гэв.

Лара, Жерри тийш хандан толгой өргөж,

-Өнөөдрийн хувьд боллоо Жерри. Чиний хүмүүс "Камерон-тауэр" тийш анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

-Аль хэдийнэ хандуулчихсан.

-Хийсэн ажил чинь тун бага байна.

Бүхий л хэвлэлээр төслийн талаар шуугиж байх нь надад хэрэгтэй.

Чөтгөр алгад, энэ дэлхийд хосгүй хамгийн өндөр барилга болно.

Дэлхий дээр шүү! Энэ байшингийн тухай далан хэлээ дэлгэн ярьцгааж, хүмүүс тэнд дэлгүүр эсхүл орон байр худалдаж авах боломж бий эсэхийг мөрөөдөж байхыг би хүсч байна.

Туансенд хаалга тийш эргэх зуур,

-Чиний зөв гэв.

Өрөөний хаалга нээгдэн, хатагтай

Камероны хувийн туслах Кэти орж ирлээ. Ажил хэрэгч эмэгтэйн костюм бүхий гуч эргэм насны негр бүсгүй үнэхээрийн дур булаам сайхан харагдах ажээ.

-Та түүний ямар хоолонд дуртайг нь тодруулсан уу? хэмээн Лараг асуухад Кэт,

-Тодруулсан. Тэр франц зоогийг илүүд үздэг, тансаг хоолонд дуртай нэгэн гэнэ. Би "Лё цирком" зоогийн газар руу утасдаж, Сириог хоёр хүний үдийн зоог авчирч өгөхийг захиалсан гэв.

-Сайн байна. Түүнийг миний хоолны

өрөөнд оруул.

-Ярилцлага хэр удаан үргэлжлэх болоо? Та хоёр хагаст "Метрополитен юнион" банкныхантай уулзах ёстой.

-Түүнийгээ гурван цагт болгож хойшлуулаад, банкны эздийг энд ирээч гэж гуй.

Кэти тэмдэглэлийн дэвтэртээ ямар нэг юм бичсэнээ, -Хэд хэдэн мэдээлэл байна. Танд уншиж өгөх үү? -Унш.

-Хорин найманд таныг хүндэт зочны хувиар хүүхдийн фондынхон урьсан.



-Гүн хүндэтгэл үзүүлсэнд нь талархаж байгааг минь уламжлаад, чек илгээчих. Би очиж амжихгүй.

-Мягмар гаригт Талсад уулзалттай, тэгээд...

-Түүнийг хойшлуул.

-Ирэх лхагва гаригт Манхэттений эмэгтэйчүүдийн клубт таныг үдийн зоогонд урьсан.

-Амжихгүй. Хэрэв тэд мөнгө гуйвал, чек бичээд явуул.

-Бөхчүүдийн холбооноос уулзалт хийх бодолтой байна, тэгэхээр

дөрөвний үдээс хойш та тэнд очиж  
үг хэлэх ёстой. -Үүнийг чинь бодье.  
Яаж ч мэднэ.

-Булчингийн дистрофитой тэмцэх  
фондоос урилга ирсэн. Гэвч та энэ  
үед Сан-Францискод байх тул  
хугацаа нь давхцчихаад байна. -  
Тэдэнд чек явуул.

-Дараагийн бямба гаригт Сербын гэр  
бүлийнхэн таныг оройн зоогонд  
урьсан.

-Түүнд чинь би очихыг бодно.

Лара Дебер болон Кристин Серб  
нарыг дотнын найз нараа хэмээн

тооцдог. Энэ гэр бүлтэй хамт цагийг өнгөрөөх нь түүнд гойдын халуун дотно уур амьсгал төрүүлдэг ажээ.

-Кэти, яг одоо таны нүдэнд хэдэн босс харагдаж байна даа? -Юу-уу?

-Энэ өрөөнд хэдэн би байна вэ? Кэтигийн нүд бүлтийн эргэлзсэн байдалтайгаар, -Та ганц л байна шүү дээ, Камерон авхай гэлээ. -Яг зев. Би-ганц. Тэгэхээр би 2.30-д банкны эзэнтэй. 4.00-д хот төлөвлөлтийн талаар хотын комисстой, 5. 00-д хотын мэртэй, 6.15-д архитекторуудтай, 6.30-д орон сууцны хэлтэст, 7.30-д инвестеруудтай, 8.00-д зочид хүлээн

авах хэмээн олби оготно шиг л  
үсчиж байж амжих ёстой болох нь ээ  
дээ. Хойшид өдрийн ажлын  
төлөвлөгөө зохиож байхдаа тархиа  
ажиллуулахыг оролдох хэрэгтэй  
болж дээ, хонгор минь.

-Бурхан минь, уучлаарай. Та  
намайг...

-Тийм ээ, би таны бодсоныг чинь  
хүсч байна. Ухвар муутай хүмүүс  
надад хэрэггүй. Архитекторуудын  
болон барилгын хэлтэс дэхь  
уулзалтыг хойшлуул.

-Тэгье хэмээн Кэти аягүйрхэн толгой  
гудайлгав. -Хүү чинь яаж байна?

Эзэгтэй нь гэнэт ийн хүү асуусан нь  
Кети бүсгүйг сандраалаа.

-Дэйвид үү? Тэр... тэр дажгүй ээ.

-Том болж байна уу?

-Одоо бараг хоёр ой хүрлээ.

-Сургуулийн нь тухай бодож байгаа  
юу?

-Үгүй дээ. Одоохондоо арай л эрт  
байна, тэгэхдээ...

-Эндүүрч байна Кэт. Хүүгээ сайн  
боловсролтой болгох бодолтой л  
байгаа бол хорвоод мэндэлсэн

цагаас нь эхлэх ёстой шүү дээ.

Лара бүсгүй өдөр тутмын  
тэмдэглэлийн дэвтэртээ хэдэн мөр  
тэм-дэглэв.

-Би Долтоны нэгэн сургуулийн  
захирлыг танина. Миний бодлоор,  
Дэйвидыг тэнд оруулахад муугүй л  
болов уу хэмээн санагдана.

-Баярлалаа, Камерон авхай.

-Ингээд гүйцэв үү гэж Лараг  
лавлахад,

-Тийм ээ, авхай хэмээн Кэти товчхон  
хариуллаа.

Нарийн бичгийн дарга хүүхэн үүд чиглэн явах зууртаа дарга авхайгаа шүтэн бишрэх үү, үзэн ядах уу гэдгээ нэг л ухварласангүй. Тэрээр "Камерон энтертрайз"-д хөл тавин ажилд орсон анхны өдрөө л "Цаад төмөр хүүрзгэнэ чинь ааш гэж адсага болсон ширээлдсэн арматур төмөр л гэсэн үг. Хатагтай Камерон бол жинхэнэ дэлт бүргэд, түүний нарийн бичгийн дарга нар нь хормын хэмжүүртэй цагийн нарийн хуваарьтай ажилладаг юм даа. Гэнэн амьтан минь чи ч амьдаараа тасдуулж дуусах бий вий" гэсэн хатуухан анхааруулга сонссон ажээ, Тэд хэрхэн танилцсанаа эргэн

саналаа. Кэти урд өмнө нь олон арван сэтгүүлийн хуудаснаас боссынхоо зургийг хэдэнтээ харсан боловч тэд нь бүгд эх хүнээсээ тэс еөр байлаа, Лара Камерон авхай сүрдмээр үзэсгэлэнтэй, сайхан хүүхэн харагджээ.

Лара шинэхэн хамтрагч бүсгүйнхээ товч намтар бүхий хуудас цаасыг хойш нь тавиад,

-Кэти, суугаач. Таны намтар сэтгэгдэл төрүүлж байна гэх үл ялиг сөөнгөдүү түүний дуу хоолойноос гайхамшигтай эрч хүч мэдрэгджээ.

-Танд, баярлалаа.



-Энд овоохон шиг уран сэтгэмж оруулсан уу?

-Өршөөгөөрэй, ойлгосонгүй?

-Ажил хайгч хэн бүхэн голдуу овоохон түүх зохиож ирцгээдэг. Ингэхэд та өөрийн мэргэжлээ хэр зэрэг эзэмшсэн юм бэ дээ?

-Тун сайн, Камерон авхай.

-Би хоёр ч нарийн бичгийн даргын нүүр үзчихээд байна. Та урьд өмнө барагдашгүй их ажилд хутгалдаж үзсэн үү? Ачаалал дааж хүчрэх үү? Эсвээс?...

-Мэдээж, чадна.

-Энд асуулт хариултын наадам явагдаагүй байна. Тийм үү, эсвэл үгүй юм уу?

Яг энэ мөчид орох гээд байгаа энэхүү атаархмаар ажлын байр түүний сэтгэлийг нэг ч их татахгүй байна даа гэсэн бодол Кэтид төржээ.

-Хүчирнэ.

-Маш сайн. Туршилтын хугацаа долоо хоног. Та "Камерон Энтерпрайз" дээр боссынхоо болон ажил хэргийн тухай хэзээ ч, хэнтэй ч, ямар ч тохиолдолд зөвшин

хэлэлцэхгүй гэсэн гарын үсэг өгөх ёстой. Энэ нь сэтгүүлч, өдрийн тэмдэглэлийн дэвтэртэйгээ харьцахаас татгалзана гэсэн үг ч гэсэн бүх юм энэ дөрвөн хананы дотор дээд зэргийн нууцлалтай явагдах болно.

-Ойлголоо. -Тэгвэл бүр сайн!

Ийнхүү таван жилийн тэртээ түүний ажил эхэлсэн юм. Энэ он жилүүдийн туршид Кэти Лара Камероныг хайрлаж, үзэн ядаж, жигшиж, бахархах эл бүгдэд суралцжээ. Гурван долоо хоног ажилласны хойт дээр Кэтигийн нөхөр нь,

-За чиний амьд домог болсон эзэгтэй чинь хэнтэй адилхан байна гэж асуужээ. Энэ тийм ч амар бус асуулт байлаа.

-Түүнийг ямар нэг хэм хэмжээнд тавьж болохгүй. Тэр санаанд оромгүй гоо үзэсгэлэнтэй, тэр ямар ч эрийг өөрийн гараа өчүүхэн ч цуцаалгүй сөхрөөж денгөнө. Хэзээ унтдагийг нь Бурхан л ганцхан мэддэг байх аа. Тэрээр агуу хүн, түүний дэргэд байх хэнбугай ч өөрийгөө шалихгүй амьтан болохоо мэдэрдэг. Өөрийнх нь бодлоор тэр суу бэлэгтэн. Тэр туйлын ялдам бас аймшигтай өс хонзон авагч байж чаддаг. Бас тэр гайхалтай өглөгч хүн.

-Нөхөр нь инээд алдан,

-Т одруулж хэлбэл, тэр-бүсгүй хүн л юм шив дээ. Нөхөр рүүгээ эгцэлж харсан Кэтигийн царайд өчүүхэн төдий ч инээмсэглэлийн ул мөр үзэгдсэнгүй.

-Түүнийг яг хэн болохыг сайн мэдэхгүй. Би заримдаа түүнээс айн чичрүүдэс хүрч, жийрхдэг.

-Боль доо, охин минь. Энэ ч арай хэтэрнээ. -Үгүй дээ. Хатагтай Камероны замд хөндөлдсөн хэн ч байг гэсэн... тэрээр түүнийг арвайсан аалз мэт тэр дор нь няц гишгэнэ,

Лара факс, утасны дуудлагаа авч дуусмагц түүний бүх санхүүг удирддаг, эрх тушаалд чамгүй санаархагч Чарли Хантер гэгч залууг дуудууллаа. -Орооч, Чарли.

-За хатагтай Камерон. Таныг сонсож байна. -Би өнөө өглөө чиний "Нью-Йорк-таймс"-т өгсөн ярилцлагыг чинь уншлаа.

Чарлигийн царай илт гэрэлтээд ирлээ.

-Өө, би уншиж амжаагүй л явна. Танд таалагдсан уу?

-Та "Камерон энтертрайз"-ын тухай,  
манай зарим нэг асуудлын тухай  
шүүмжлэх бүдүүн зүрх гаргаа юу,  
аан?

Залуу эр баахан аягүйрхсэнээ,

-Аа... аа... сурвалжлагч миний зарим  
нэг үгийг буруу ойлгож...

-Та халагдсан.

-Юу-уу? Яаж байгаа нь энэ вэ? Би...

-Анх ажилд орохдоо та ямар ч  
ярилцлагаас сайн дураараа  
татгалзана гэж цагаан цаасан дээр  
хар бэхээр гарын үсэг зураа биз дээ.

Явж эд хогшлоо бөөгнүүл. Үдийн хоолноос өмнө элбэг амжих цаг байна.

-Би... та ингэх ёсгүй! Хэн миний ажлыг хийх юм бэ?

-Тохирох хүн аль хэдийнэ олчихсон.

\* \* \*

Үдийн хоолны цаг дуусах тийш дөхөж байв. "Форчун" сэтгүүлийн редакцийн хариуцлагатай ажилтан Хью Томпсон гэгч нь хуучин загварын дугариг нүдний шилний цаанаас гялалзсан гярхай хурц нүдтэй гавшгай, эрдэм төгс нэгэн байлаа.



-Хоол унд ямар ч сайшаал  
магтаалаас илүү гэдгийг хэлмээр  
байна. Зоог тань санаанд нийцлээ,  
баярлалаа.

-Танд таалагдсанд баярлалаа.

-Дэндүү их төвөг уджээ! Ингэж санаа  
тавих хэрэггүй байсан юм.

-Санаа зовсны хэрэггүй. Аав минь эр  
хүний зүрхэнд хүрэх зам ходоодоор  
нь дамждаг хэмээн үргэлж хэлдэгсэн  
гээд Лара инээлээ.

-Өө, тэгвэл та ярилцлагаас өмнө  
миний зүрхэнд хүрэх гарц хайжээ  
дээ, аан?

-Мэдээж шүү дээ.

-Компани тань үнэхээр хүнд асуудалд ороо юу?

Бүсгүйн инээмсэглэл бөхөн,

-Өршөөгөөрэй, ойлгосонгүй гэж гайхширан асуухад,

-За боль доо, та! Ийм юм түмний нүд, чихнээс далд нууц үлддэггүй юм. Асар их өр төлөлтөөс үүдээд таны актив данс улайн сүйрлийн ирмэг дээр байна гэж хүмүүс дээр доргүй ярьж байна. Компанийн өр шир үндсэн хөрөнгийн зээл "Камерон энтертайз"-ийн хувьд тун

ч эмзэг байдлыг үүсгээд байгаа  
гэсэн,

Лара тас тас хөхрөн,

-Нөгөө хүмүүсийн яриад байгаа дэл  
сул яриа гэдэг чинь энэ юм шив!  
Ноён Томпсон, иймэрхүү мангуу  
яриаг үнэн гэж бодон шүүрч авахын  
хэрэггүй байдаг юм, итгэж үзээрэй.  
Би танд факсаар санхүүгийнхээ  
тайланг илгээе. Та өөрөө гардаж  
аваарай. Зөвшөөрч байна уу?

-Бүрэн дүүрэн зөвшөөрч байна. Өө,  
дашрамд асуухад шинэ зочид  
буудлын нээлтийн ёслол дээр би  
яагаад ч юм таны нөхрийг олж

харсангүй.

-Филипп маань очихыг тун их хүссэн л дээ, харамсалтай нь тэрээр айлчлан тоглолт хийхээр явсан юм гээд Лара санаа алдав.

-Надад ганц удаа ч гэсэн түүний тоглолтыг үзэх аз тохиох байгаа даа. Хөгжмийн зохиолч ч ижилгүй юм билээ. Эндүүрээгүй бол та нар гэрлээд жил болж байгаа байхаа?

- Тийм ээ, энэ миний амьдралын хамгийн аз жаргалтай жил. Нөхөр бид хоёр үе үе аялалаар явна, би нөхрийнхөө тоглолтын бичлэгийг хаа явсан газраа авч явдаг юм.

-Харин тэр хаа сайгүй таны барьж босгосон бүхнийг эрхэм дээд хэмээн бахархаж явдаг байх даа гээд Томпсоны уруул чичигнэн инээмсэглэв.

- Бүү бялдуучил, Томпсон.

-Би үнэнийг хэлж байна, та ч бас үүнийгээ мэдэх юм хойно. Таны бүтээж босгосон барилга байгууламж улс орон даяар сүндэрлэж, бүхэл бүтэн орон сууцны цогцолбор, ажил хэргийн төв, зочид буудлын сүлжээ таны мэдэлд байгаа шүү дээ. Та ер нь яаж ийм амжилтанд хүрэв?

Лара эелдэгээр инээн,

-Шидэт тольны тусламжтайгаар.

-Та бол хүчин мөхөс бүсгүй хүн биш,  
харин оньсого таавар юм гээч.

-Аа тийм үү? Яагаад тэр вэ?

-Одоо цагт Нью-Йоркод тан шиг ийм  
амжилттай явж байгаа үйлдвэрийн  
эзэн алга. Таны нэр хотын үл хөдлөх  
хөрөнгийн тал хагасыг эзэмшдэг  
хүмүүсийн жагсаалтанд орсон байна  
лээ. Одоо та дэлхийд хосгүй өндөр  
байшин барихаар завгүй байгаа  
гэсэн. Өрсөлдөгчид тань таныг Төмөр  
хүрзгэнэ гэж хочилсон байна.

Уламжлал ёсоороо бол эрчүүдийн хэмээгдэх бизнесийн хүрээнд та амжилтанд хүрчээ.

- Тэгээд энэ бүхэн таныг бухимдуулаа юу?

- Үгүй дээ. Хатагтай Камерон, өдий болтол таны хэн болохыг мэдээгүй байгаа маань намайг бухимдуулж байна. Хоёр хүнээс таны хэн болохыг асууж хариуд нь гурван санал олж сонссон. Бүгд таныг гойд авьяастай, ажил хэрэгч эмэгтэй гэдэгтэй санал нийлж байна. Би барилгачидтай багагүй ажиллалаа, тэд нилээд бүдүүн ширхэгтэй, бахим залуус байна билээ. Тан шиг ийм танхил

бүсгүй тэднийг яаж зочид буудлын  
багагүй сүлжээ байгуулах санаа төрж  
банкны эздэд хандахад бүтэхгүй л  
болов уу гэж хулганаж явтал тэд ч  
намайг хүлээж авсан шүү гээд Лара  
мөрөө үл мэдэгдэм хавчисхийснээ,

-Ингээд, зам минь шулуудсан гэдэг  
байхаа. Сэтгэл зүйч намайг өөрийн  
эзэнт гүрний эргэн тойронд өөрийн  
ертөнцийг барьж босгож байна  
гэсэн боловч энэ бүхнийг би  
эцгийнхээ хүндэтгэлд зориулж байж  
юуны магад. Эцэг Жеймс Камерон  
миний сэтгэл зүрхэнд үүрд ер бусын  
гайхамшигтай хүн чигээрээ үлдэх  
болно гэв.



-Та түүнд хайртай байжээ дээ?

-Ухаангүй. Тэр ч гэсэн надад амиа тавьдаг байсан юм. Гэрэлт хорвоод намайг мэндэлсэн тэр өдөр аав минь Глэй-Бэйн бүх оршин суугчдыг архи дарсаар дайлж байсан гэж би нэг удаа сонссон.

-Тэгэхээр бүх юм тэндээс эхэлжээ дээ. Тийм үү?

-Яг үнэн. Бүх юм Глэй-Бэйгээс эхэлсэн. Бараг дөчөөд жилийн тэртээгээс...

## Гуравдугаар бүлэг.

Глэй-Бэй. 1952 оны 9 сарын 10.

Эхнэр нь ихэр хүү охин хоёр бэлэглэсэн тэр нэгэн шөнө Жеймс Камерон эмсийн хүрээлэнд шал согтуу хэвтэж байжээ. Тэрээр хоёр залуухан скандинов эрх муужгайн дунд шалиглан хэвтэж байтал хаалганы цаана хүрээлэнгийн эзэгтэй Кристи,

-Хөөе Жеймс! гэж хашгиртал хаалга нь хатавчаараа салж унав уу гэлтэй дэлгэгдэн босгон дээр мариалаг бүдүүн эзэн авгайн дүрс үзэгдэв.

-Зайл цаашаа, муу хөгшин бүдүүн тахиа! Энд ч гэхнээ намайг амар тайван байлгаж болохгүй нь уу? хэмээн Жеймс зэвүүцтэй муухайгаар ориллоо.

-Өршөөж үз, та нарын зугаа цэнгэлийг чинь тасдахаас өөр аргагүй боллоо. Эхнэр чинь...

-Би түүнийг зодчихсон!

-Эргэлзэх юм алга. Тэгвэл одоо эхнэр чинь төрж байна.

-Тэгээд юу гэж? Энэ чинь хүүхнүүдийн хэрэг биз дээ.

-Эмч сая утасдсан. Тэр чамайг хоёр цаг шахам хайжээ. Муухан юм болсон бололтой. Чамд л гэж хэлэхэд яаравчлахыг зөвлөх байна.

Шал согтуу шалиг Камерон орон дээрээ арай ядан өндийж, хөлөө унжуулан суугаад толгой сэгсрэн,

-Хараал идсэн, ноорхой шалны алчуур. Түүний нүднээс далд орчих газар олдохгүй юмаа. За заа, авхай явлаа гээд гоолиг хоёр хүүхний нүцгэн биеийг харамсангүй ширтсэнээ,

-Би энэ хоёр банзал хүүхнүүдийн чинь хөлсийг төлөхгүй шүү гэлээ.

-Тэг ээ, тэг. Шалавхан хувцаслаад  
хоног төөрүүлдэг оромж руугаа гүйж  
үз гээд Кристи нөгөө хоёр хүүхэн  
тийш эргэн,

-Харин та хоёр наашаа хүрээд ир  
гэжээ.

Хэзээ ч билээ нэгэн цагт Жеймс  
Камерон цэвэрхэн төрсөн дур  
булаам сайхан эр байсан бол одоо  
үй олон гэмт явдал нь түүний  
царайд мартагдахааргүйгээр ул  
мөрөө үлдээжээ. Түүнийг харсан хэн  
ч өлхөн тавь шүргэж яваа гэхээс бус  
түүнээс доош хэлчих хүн ганц ч  
олддоггүй байв. Гучин настай Жеймс  
хотын цорын ганц банкны эзэн Шон

Макаллистерийн мэдлийн хоног  
төөрүүлэх газар ч гэмээр юм уу эсвэл  
хөлсний байр ч гэмээр юм уу нэгэн  
байранд эрхлэгчээр нь ажиллаж  
байлаа. Сүүлийн таван жилийн  
туршид Жеймс Камерон эхнэр  
Пеггитэй энд хамтран ажилласан аж.  
Мань эр зугаацан архидаж, харин  
эхнэр нь борви бохисхийлгүй  
хөлсний байрны өрөө тасалгааг  
угааж цэвэрлэн, байрлаж буй  
хориод хүний хоол ундыг бэлтгэх  
гэсэн ажил үүргийн хатуу зарчим  
баримталсаар иржээ. Баасан гариг  
бүрд нөхөр нь Макаллистерын өмч  
болох бүх таван хөлсний байрны  
төлбөрийг хураадаг байв. Энэ нь

Камероны хувьд хэдийнэ таалагдахаа байсан зхнэрээ орхин, хоолойгоо норгон юм балгаж явах бас нэгэн шалтаг болдог ажээ.

Жеймсийн тэсвэрлэхийн нөхцөлгүй адаар ааш нь түүний хувьд баяр бахдал нь болж, бах тав ханаж явдаг хэцүүхэн хүн байлаа.

Тэрээр өөрөө урагш муутай, заяагүй залхуу амьтан атлаа эдэлж яваа энэ зовлонд нь зөвхөн хавь ойрын хүмүүс буруутай хэмээн мухарлан итгэж явдаг нэгэн байжээ. Гэтэл яваа яваандаа Жеймс өөрийн азгүй хувь заяандаа дасаж тайвширан эвлэрэх болсон байна.

Жеймсийг дөнгөж ойндоо хүрч  
явахад нь түүний гэр бүл ойр зууын  
чухаг эд хогшлоо бөөгнүүлэн  
Шотландаас Глэй-Бэйд нүүж иржээ.  
Эцэг эх нь харийн нутагт амь зуух  
гэхдээ борви бохисхийлгүй сөхөрч  
унатлаа ажиллаж байв. Эцэг нь  
арван дөрвөн настай хүүгээ  
нүүрсний уурхайд ажиллуулжээ.  
Жеймс арван зургаан насандаа  
нуруундаа гэмтэл авсны улмаас  
уурхайг орхисон аж. Гай газар  
дороос гэгчээр жилийн дараа эцэг эх  
нь төмөр замын осолд өртөн амь  
үрэгдэж, гай зовлон өөрийн нь хувь  
заяаг түүний гарт нь даатгажээ.  
Залуу эр: харчуудад ховорхон



заяадаг гоо үзэсгэлэн, бусдын дур татах төрөлхийн хүч гэсэн маргахын аргагүй хоёр давуу эрхэм чанартай төржээ. Жеймс нэгэн удаа Глэй-Бэй тосгоны зэргэлдээ Сиднейд эцэг, эхийн хамт амрахаар ирсэн нүдэнд дулаахан Пегги Максүэлл гэгч бүсгүйтэй учирлаа. Хатуухан хэлбэл, Пеггийг царайлаг гоо сайхан гэж хэлэхээргүй боловч эцэг нь мөнгөтэй, харин Жеймс сохор зоос ч үгүй хов хоосон байжээ. Тэрээр гойдын хүч чармайлт гаргалгүйгээр бүсгүйн сэтгэлийг татаж дөнгөв. Хоёр долоо хоногийн дараа гэхэд бүсгүй эцгээсээ зөрж, тэрсэлдэн байж түүнтэй гэрлэжээ.

-Би охиныхоо инжинд таван мянган доллар өгнө. Ингэж л чи нэг хөл дээрээ босч хүн болох боломжтой юм. Үл хөдлөх хөрөнгөнд мөнгө оруулахыг зөвлөх байна, тэгвэл таван жилийн дараа гэхэд мөнгө чинь хоёр дахин өсөх байх, Миний тусламжинд найдаж болно шүү гэж Жорж Максүэлл сүйт хүргэндээ хэлжээ.

Гэтэл сүйт хүргэн таван жил хүлээхийг хүссэнгүй. Тэр хэнтэй ч зөвлөсөнгүй, голио азаа үзэхээр шийдэн нэгэн нөхөртэйгээ хамсран нефтийн цооног боловсруулалтанд мөрий тавьчихжээ. Хоёр сарын дараа гэхэд хэрэг явдал балран,

мөнгө нь салхинд хийсэх мэт алга болов. Уурлан байж ядсан хадам эцэг нь үг хэлэхээс ч дургүй нь хүрэн,

-Жеймс, чи ч ёстой нэг гашилсан толгойтой мангуу амьтан юм даа. Хойшид надаас сохор зоос ч олж долоохгүй шүү гэжээ. Ядуу зүдүүгийн тамаас гэтэлгэж чадах байсан Камеронд тохиосон гэрлэлт нь түүнийг ёроолгүй ангалын ирмэгт авчирч, тэрээр яаж ийгээд эхнэрээ тэжээх хэрэгтэй болжээ. Ядахад ажил ч үгүй байдаг.

Гэтэл Шон Макаллистер түүнийг аварчээ. Дөнгөж тавь шүргэж яваа намхан нуруутай, цүндгэр гэдэстэй,

торгон хантааз, хүдэр том алтан  
гинжнээс салдаггүй банкны эзэн тэр  
эр Глэй-Бэйд хорин жилийн өмнө  
ирсэн бөгөөд алс ирээдүйгээ тун ч  
сайн олж харжээ. Тосгоны  
гудамжаар хэр тааруу сууц хайсан  
нүүрсчид, модчингууд холхилдоно.  
Шон хөрөнгө гарган тэдэнд байр  
бариад өгчихөж дөнгөх байсан авч  
үүнийг тэс өөрөөр хийх ёстой гэж  
тунгаан бясалгав. Түүний  
тооцоогоор хөлсний байр илүү  
ашигтай гарчээ. Хоёр жил ч хүрэхгүй  
хугацаанд бага шиг зочид буудал,  
таван хөлсний байр барьж босгож  
амжсан хэдий ч өрөөний булан  
тохой хөлслөхийг хүсэгчидийн цуваа

үл тасрах аж.

Хөрөнгө зарж босгосон өмчөө захирах, эрхлэх хэрэгтэй болоход нь чамгүй ажилтай энэ албанд хүн болгон тэнцэхгүй гачлантай. Энэ менежерийн үүрэг нь байр хөлслөгч олох, тэднийг халуун хоолоор хооллох, хоол хүнс бэлтгэх, өрөөний ариун цэврийг сахиулах ёстой юмсанж. Шоны ивээн тэтгэгч гэж нэрлэгдэх эрхлэгчийн цалин пүнлүү нь хүмүүсийн сонирхлыг ч нэг их татсангүй.

Шон Маккаллистер анхны менежер хийж байсан дөргүй амьтнаас ангижирсныхаа дараагаар Жеймс

Камероныг сонгожээ. Залуу эр үе үе  
банкаар эргэлдсээр багахан  
хэмжээний зээл авсаар байгаад адаг  
сүүлд нь овоохон өртэй болчихжээ.  
Шон өрт эрийг зарлагаараа  
дуудуулав. -Чамд нэг ажил санал  
болгох гэсэн юм. -Ажил ий?

-Өөрийгөө азтайд тооцож болно  
шүү. Дөнгөж сая нэг аятайхан орон  
тоо суларлаа. -Энд, банкинд уу?  
Кассын дэргэд зогсоно гэсэн бодол  
Жеймсын санаанд ихээхэн нийцжээ.  
Мөнгөтэй харьцдаг ажил хийвэл хэд  
гурван зоос халааслаад байж  
дөнгөнө дөө.

-Энд бишээ. Жеймс, чи хүмүүсийг ая

эвийг олох төрөлхийн авьяастай хүн.  
Кейбл-хедийн өргөн чөлөө дэхь  
миний хөлсний байрны эрхлэгчийн  
алба чамд ямар санагдаж байна.

-Хөлсний байранд уу, эрхэм ээ? гэх  
Камероны дуунд урам хугарсан  
сонсогдов.

-Эхнэртэйгээ үнэгүй өрөөнд сууж,  
дээр нь бага шиг цалин авна. -  
Багадаа хэд гэж?

-Залуу минь, би чамд өгөөмөр  
загнана. Долоо хоногт хорин таван  
доллар.

-Хорин...

-Өөрөө л мэд. Өөр хүн бол ч ийм цалинг мөрөөднө дөө. Камеронд голж гоочлоод байх өөр сонголт байсангүйд, -Зөвшөөрч байна хэмээв,

-За сайн байна. Баасан гариг бүрд бүх таван байраар явж хөлсийг хураагаад, маргааш нь надад өгөх ёстой.

Жеймс шинэ сониноо Пеггид дуулгавал эхнэр нь хий нь гарсан гүзээ сулдайн үгээ сунжруулан, -Гэвч хонгор минь бид чинь энэ тухай юу ч мэдэхгүй шүү дээ! гэв.

-Сурнаа. Ажлаа хувааж хийнэ. Эхнэр



нь нөхөртөө итгэжээ. -За яахав. Үзээд алдая.

Туршилтын хугацаа амжилттай өндөрлөж, эхнэр нөхөр хоёр дотуур байрыг мэдэлдээ авчээ.

Яваандаа Жеймст чамгүй орлоготой, бас ч үгүй нийгмийн байдал нь дөнгүүр арай ирээдүйтэй хэд хэдэн ажил олдсон боловч золгүй хувь заяандаа гомдон хэдийнэ багагүй балгачихдаг болсон Камерон юуг ч өөрчлөхийг хүссэнгүй. Харин "Яах гэж тэр вэ? Нэгэнт хувь заяа нүүр буруулж байхад, илүүг горьдохын хэрэггүй" гэж тэрбээр хамар дороо үглэдэг аж.

Одоо есөн сарын золгүй энэ шөнө:  
"Тэр яахлаараа намайг алтан шар  
үст хоёр янхантай цэнгүүлдэггүй,  
миний амар заяаг үзүүлдэггүй  
билээ? Хараал идсэн эхнэр чөтгөр  
шулам руугаа тонилоосой билээ!"  
гэсэн бодол Жеймсийн зэвүүг  
хүргэнэ.

Хатагтай Кристийн үүдээр гармагц  
хүйтэм салхи түүний нүүрэн дундуур  
нь дэлсээд авах шиг болов. Айсуй  
хэрэг явдалд бэлтгэн зүрхээ  
чангалбал ч муугуй дээ гэж Камерон  
бодмогц "Далайн чоно" баарыг  
чиглэн шийдэмгий алхжээ.

Цагийн дараа гэхэд тэрээр Абердин-

роуд байрлах Глэй-Бэйн хамгийн ядуу хороолол дахь хөлсний ядуу дорой сууцандаа дуртай дургүй сажилсаар дөхөж ирэхэд түгшиж мэгдсэн суугчид түүнийг хонгилд бүчин авчээ.

-Пеггигийн дэргэд эмч байгаа. Чи шалавлахгүй яагаав дээ гэж хэн нэг нь хэлэв.

Камерон хачвиг бяцхан унтлагын өрөө рүүгээ оров. Хажуу өрөөнөөс нялх хүүхдийн уйлах дуу цангинана. Пегги орон дээр огт хөдөлгөөнгүй хэвтэж, Патрик Дункан эмч түүний дээрээс толгой гудайлган тонгойжээ.

Ард нь хөлийн чимээ гарахыг  
сонссон эмч толгойгоо өндийлгөв.

-Наадах чинь юу болоод байна? гэж  
Камерон залхсан аятай асуухад нь  
эмч биеэ цэхлэн, түүнийг хөлөөс  
толгой хүртэл зэвүүцэн хараад,

-Та долоо хоногийн өмнө эхнэрээ  
над руу явуулах байж дээ гэхэд нь,

-Уухай, чиний ширээн дээр зоос  
овоолох гэж тэр үү. За, хоёр яс  
хагацаа биз. Юун асуудал босгоод  
байгаа юм бэ? гэжээ.

-Пегги өнгөрчихлөө. Би чадах бүхнээ  
хийсэн. Ихэр байж. Нэг хүүхдийг нь

аварч чадсангүй. Тэр нь хүү байжээ.

-Ээ Бурхан минь! Хувь заяа. Дахиад л хувь заяа!

-Юу?

-Хувь заяа гэж байна. Заяа тавилан минь үргэлж надаас нүүр буруулах юм даа. Одоо үр удмыг минь хүртэл аваад явчихлаа. Би...

Хуучин бүтээлгэнд боодолтой юм тэвэрсэн сувилагч унтлагын өрөөнд гулсах мэт чимээгүйхэн алхалсаар орж ирлээ.

-Ноён Камерон, таны охин.

-Охион? Би тэгээд наадахыг чинь-охиныг чинь яах болж байна? гэж Камерон утга авцалдаагүй бөвтнөв.

-Чи миний зэвүүг хүргэж байна шүү, залуу минь хэмээн эмч шүдэн завсраар сийгүүлэн бүвтнэхэд нь,

-Би өглөө болтол үлдэж болох юм. Хүүхдийг хэрхэн асрахыг зааж өгье гэж сувилагч өгүүлэв.

Жеймс томдсон боодлын ухлаадас дундаас арай ядан үзэгдэх час улаан, үрчгэр бяцхан нүүрийг ажиглах зуур:

Магадгүй, өглөө болтол тэр амьдрахгүй ч юм билүү? хэмээн

горьдлого тээн бодов.

\* \* \*

Эхний гурван долоо хоногийн хугацаанд охиныг эсэн мэнд үлдэнэ гээд хэлчих цөс ихтэй хүн гарсангүй. Эмч охиныг хуурайлж, угжих жижүүр явуулж байв. Тэгээд, бараг сар өнгөрсний дараагаар Дункан эмч,

-Ноён Камерон, таны охин одоо алзахгүй гээд баргар царайлах эцгээс нь нүд салгалгүй гярхай ширтэн байснаа, -Түүнийг Бурхан ивээг хэмээн нэмж хэлэв.

-Охинд нэр өгөх хэрэгтэй, ноён

Камерон гэж жижүүр сувилагчийг  
хэлэхэд,

-Хэн гэж нэрлэх нь надад ялгаа алга.  
Та нар нэр өгцгөөчих гэв.

-За тэгье. Тэгвэл-Лара. Ийм сайхан...

-Та нарт л тэгж санагдаж байгаа юм  
биз дээ. Ингээд албан ёсны  
бяримтдээр "Лара" хэмээн  
бүртгэжээ.

\* \* \*

Охин хэн нэгний хайр халамж,  
энхрийлэл амсалгүй өслөө. Цаг  
наргүй ажиллах эрчүүд голдуу



оршин суугчид нь бяцхан охиныг анзаарах ч сөгөөгүй байх ажээ. Хөлсний байранд байх цорын ганц эмэгтэй болох тарган швед авгай бохир гал зуухны өрөөнд хоол хутгасан болж, өрөөнүүдийг цэвэрлэнэ.

Охиныг төрсөн цагаас нь хойш эцэг Жеймс Камерон түүнтэй хахь хамаагүй байхаар хатуу шийджээ. Хараал идсэн хувь тавилан нь түүнийг бас дахин нэгэн удаа мэхэлж ямар ч арчаа дэмгүй нэгэн амьтныг амьд үлдээчихжээ. Жеймс олон шөнийг гартаа шил виски бариад нийтийн танхимд хөзөр тоглох уурхайчдын дэргэд суун,

-Энэ муу гөлчгийнөөс болж миний эхнэр, хүү хоёр минь эрсэдсэн юм хэмээн чалчина.

-Анд минь, ингэж ярих хэрэггүй. - Тэгнэ чиш. Хүү минь жинхэнэ эр хүн болж өсөөд, боловсрол эзэмшин, дориун цалин пүнлүү хүртэж, эцэст нь өөрийнхөө хажуугаар трсөн эцгийгээ дуртайяа тэжээх байсан юм.

Тоглогчид түүний улиглан үглэх дэмий яриаг чихнийхээ хажуугаар өнгөрөөнө.

Жеймс хэд хэдэн удаа охиныг гар дээрээ аваач хэмээн Жорж

Максуэллыг ятгахаар хайсан боловч хадам эцэг нь газрын гаваар орсон мэт алга болжээ.

Хэрэв зээ хөгшин ухна нүд аньсан байвал ч намайг бузгай аз дайрч дээ хэмээн Камерон боддог байв.

\* \* \*

Глэй-Бэйн хүн ам нь голдуу нэг хөлсний байрнаас нөгөө рүү нүүдэллэн олныг хэсэж, олгойгоо тэжээгчид байжээ. Хятад, Франц, Орос, Польш, Украйнаас, Америкт шилжин ирцгээсэн тэд Мэйн-стрит, Белл-стрит, Уотер-стритэд тэнгисийн эрэг хавиар байр хөлслөдөг ажээ.

Тэдэн дунд грек, итали, турк  
мужаан, оёдолчин, арьс шир,  
төмрийн дархчууд бий. Тэдний  
олонхи нь нүүрсний уурхайд, ойн аж  
ахуйд модчин эсвэл гувчуурт  
онгоцоор далайд загасчилна.  
Хилийн бүсэд байрлах Глэй-Бэй  
гацаа цэцэглэн хөгжөөгүйд  
тооцогдох ч гэлээ арай л тартагтаа  
тулсан ядуу бишээ. Харин байн байн  
цас орж дөрвөн сарын дунд хүртэл  
үргэлжилдэг хүйтэн өвөлтэй,  
тэнгисийн булангийн арвин мөснөөс  
нь болж таван сар нь хүйтэн бас  
салхитай, харин 7-10 сард  
уйлагнасан шиврээ бороо салдаггүй,  
дур гутам цаг агаартай юмсанж.

Хотын тэг дотор арван найман хөлсний байр байвч оршин суугчдын тоо нь наян байшин байсан ч шингэхээр олон болжээ. Жеймс Камероны эрхэлж буй хөлсний байранд ихэнх нь шотланд голдуу хорин дөрвөн хүн амьдрана. Энэ асар том ертөнцийн дунд бяцхан Лара амиа хоохойлон амьдарсаар. Охин тоглоом гэж юу байдгийг мэдэхгүй, хэзээ ч хүүхэлдэй үзээгүй, найз охин ч үгүй ажээ. Тэр зөнгөөрөө эцгийнхээ сэтгэлийг татах гэхдээ өөрийн гараар урласан бүдүүн баргийн бэлэг бэлдэвч Жеймс нэг бол элэглэн шоолж нэг бол түүнийг нь эс тоодог байлаа.

Лара таван настай байхдаа эцэг нь  
оршин суугчдын хэн нэгэнтэй,

-Хар даа, хөгшөөн. Миний үхэх ёсгүй  
хүүхэд мажийсан юм шүү дээ. Одоо  
энэ гудмаар миний хүү гүйж явах  
ёстой байсан юм гэж ярихыг нь  
сонсжээ.

Бүх л шөнийн турш дэрээ нэвтэртэл  
уйллаа. Охин эцэгтээ ямар их  
хайртай гээч! Гэтэл одоо түүнийг  
үзэн ядах болжээ!

\* \* \*

Туранхай, цонхигор царай, том  
бүлтгэр нүдтэй, зургаан настай Лара

шотландын үлгэрийн баатрыг санагдуулна. Нэгэн өдөр хөлсний байрных нь гудмаар шинэ суугч хүнд алхаагаараа өгөрч муудсан шалыг пижигнүүлэн алхалж явлаа.

Баавгайнх шиг болхи хүнд биетэй мань эрийг Мунго Максунин хэмээнэ. Үзтэл танхилхан үлгэрийн дагина мэт охиныг хараад түүний зүрх уясан,

-Чамд мэдээж нэр бий биз, хөөрхөн охин минь гэв.

-Байгаа. Лара гэдэг.

-Өөх! Сайхан нэр байна. Сургуульд явдаг уу?

-Сургуульд уу? Үгүй.

-Яагаад үгүй гэж?

-Мэдэхгүй.

-Зүгээр ээ. Одоохон учрыг нь олцгооё гээд Мунго Камерон руу очоод,

-Охин чинь сургуульд явдаггүй гэж надад хэллээ гэв. -Тэгээд юу гэж? Охин хүүхдэд эрдэм номны хэрэг юу байхав. -Анд минь, чи андуурч байна шүү. Ларад боловсрол хэрэгтэй. Хэн ч байсан амьдралдаа боломж эдлэх ёстой.



-Цааш нь үргэлжлүүлэх хэрэггүй.  
Санашгүй санаа. Гэвч Максун  
өөрийнхөөрөө зүтгэсэн хэвээр  
байлаа. Жеймс энэ муйхарлан зүтгэх  
хашир модчин эрийн шалаанаас  
мултрахын тулд дуртай дургүй  
зөвшөөрчээ. Ядахдаа, зэвүү нь  
хүрдэг оготнын гөлчгий түүний  
нүдэнд үзэгдэж хог мэт торохгүй  
байх нь.

\* \* \*

Сургуульд орно гэсэн бодол Ларад  
айдас төрүүллээ. Богинохон  
аьдралынхаа бүх хугацааг  
томчуулын дунд өнгөрүүлсэн Лара  
охин үе тэнгийнхэнтэйгээ хэрхэн

харьцах ёстойгоо мэдэхгүй байлаа.

Даваа гаригийн өглөө тогооч Берта авгай Лараг Гэгээн Аннагийн сургуульд хүргэж өгөв.

-Энэ бол Лара Камерон гэж тогооч түүнийг захирал авхайд танилцуулжээ.

Захирал эмэгтэй Каммингс аль эрт эр нөхрөө алдан бэлэвсэрч, гурван хүүхдээ ганцаар өсгөжээ. Тэрээр охины өмссөн багадсан палаажийг гярхай нүдээр гүйлгэн хараад, эелдэгээр инээмсэглэн, -Лара. Ямар гоё нэр вэ? Хонгор минь чи хэдэн настай вэ? гэв. -Зургаа хэмээн Лара

арай ядан нулимсаа барин байж  
хэлэхэд нь,

Хөөрхий минь, айчихаж хэмээн  
хатагтай Каммингс ойлгов.

-Лара чамайг ирсэнд бид их  
баярлаж байна. Манай энд чамд  
таалагдана, чи сонирхолтой олон  
юм мэдэж авна.

-Би энд үлдэж чадахгүй гэж охин  
палхийтэл хэлэв.

-Тийм үү? Яагаадтэр вэ?

-Аав маань намайг санана. -Охин  
минь, чи өдөрт сургуульд дээрээ

хэдхэн цаг л байна шүү дээ. Түүнд дүүрэн сурагчтай ангид орохоос өөр арга зам олдсонгүй. Цорын ганц сул суудал хамгийн ард хананы дэргэд байжээ. Багш хатагтай Тервел чулуун самбараа тогшин,

-За тэгэхээр өнөөдөр бид үсэг үзнэ. "А" үсэг -энэ үсгээр "apple" гэдэг үг эхлэнэ. "В" үсэг-"Воу". Хэн нэг нь ямар үг "С" үсгээр эхэлдэгийг мэдэх үү?

-"Candy".

-Сайн байна. Одоо "O" үсгээр.

-"Oод".

-Зүйтэй."E"?

-"Eaү.

-Гайхалтай! За одоо "P" үсгээр эхэлсэн үг хэлээрэй.

-Би болох уу? гэж Лара анх удаа ам нээв.

-Бололгүй яахав. За зоригтойхон. Ларагийн хэлсэн "Риск" гэсэн үгийг сонсоод хатагтай Тервел нүдээ анивчин дуугаа хураачихав.

\* \* \*

Лара анги дотроо насаараа хамгийн

бага нь байсан боловч хатагтай  
Тервелд шинэ охин бусдаасаа хэдэн  
насны эгч мэт санагджээ. Охиноос  
нэг л түгшүүртэй, насанд хүрсэн  
хүний гэмээр араншин мэдрэгдэх нь  
хачирхалтай.

-Тэр өсөлт нь зогсчихсон, аль  
хэдийнэ нас бие гүйцсэн юм шиг  
байх юм гэж багш захиралдаа  
хэлжээ.

Эхний хичээлийн өдрийн их  
завсарлагаанаар хүүхдүүд мөнгөн  
цаасанд боолттой хачиртай талх,  
зарим нэг нь гэрийн жигнэмэг  
гаргаж ирэн цайлж эхэллээ.

Ларагийн хоолны тухайд бодох хэн ч байгаагүй нь лав.

-Лара, чиний идэх юм хаа байна хэмээн Тервел авхай асуув.

-Би өлсөөгүй байна. Аав надад өег хоол өгсөн хэмээн охин гөжүүдлэн хариулав.

Ангийн бүх охид цэвэрхэн палааж гоё ганган цамцтай ирсэн байлаа. Ларагийн цоорхой хувцас нь тоодойж багаджээ.

Хичээл тараад Лара эцэгтээ,

-Надад шинэ даашинз хэрэгтэй

байна гэжээ.

-Тэгээд яах юм бэ? Би ямар мөнгө тарих биш. Өглөгийн газар руу оч.

-Аав аа, тэнд чинь дандаа хуучин хувцас байдаг шүү дээ.

Жеймс Камерон охиныгоо тасхийтэл алгадаад авчээ.

Ангийнхан нь завсарлагаанаар Ларагийн огг сонсож мэдээгүй тоглоомыг их л баяр хөөртэйгээр тоглоцгооно. Охидууд хүүхэлдэй манцуйлан өлгийдөж, түүнийгээ Ларад тоглуулахаар баяртайгаар гар сунгавч Энэ бүхэн минийх биш



гэдгийг ухамсарласан тэрээр омог бардам татгалзана. Лара яваа яваандаа эцэг эх нь үр хүүхдээ хайрлаж, тэдэнд зориулан үдшийн наадам зохион, бэлэг гардуулдаг энэ хорвоод төдөлгүй дасан, үүгээр дутагдаж яваагаа ойлгожээ. Ийм нэгэн бодол нь түүнийг улам зожиг, илүү ганцаардмал болгож байв.

Хөлсний байр гэдэг Ларагийн хувьд тэс өөр сургууль байлаа. Орой үдшийн цагаар нийтийн танхим нь бөөн хөл үймээн болно. Охин тэнд ирэгсдийн нэрийг сонсонгуутаа түүнийг аль нутгийн гаралтай болохыг амархаан тодорхойлж чаддаг болжээ. Мак Шотландаас,

Ходдер Панк-Ньюфаундлендээс...  
Жон, Люк Францаас, харин Дудаш,  
Кочек хоёр польшоос ирсэн гэдгийг  
нь андахаа байжээ. Эрчүүд модчин,  
мужаан, уурхайгаас нүүрс малтагч,  
загас барих ажил хийцгээнэ. Томоо  
гэгчийн ширээний ард өглөө, оройи  
хоолон дээрээ тэ | д өөр хоорондоо  
сонин хачинаа хуучлан хөөрөлдөж,  
энэ яриаг нь сонсох бяцхан  
Ларагийн толгой нь эргэж орхидог  
байв. Тэд нэг л нууцлаг тусгай хэлээр  
ярилцах мэт санагдана.

Глэй-Бэйд хавьгүй олон модчин  
байдаг ба хойг дээрх тэдний тоо  
бараг мянга шүргэж яваа гэлцэх аж.  
Тэднээс шинэхэн үртэс, нарсны

холтосны толгой мансууруулам үнэр  
ханхалж, ямар нэгэн мод  
буулгагчийн тухай, тайрсан  
гишүүний тухай ширүүхэн хэлэлцэнэ.

-Энэ жил бараг хоёр зуун сая футыг  
авах ёстой! гэж чийрэг биетэй залуу  
хооллох зуураа хэлэхэд нь,

-Юун фут, квадрат биз дээ? гэж Лара  
тээнэгэлзэн түүнээс асуусанд,

Танхим тэр аяараа цагаахан  
сэтгэлийн инээдэнд доргих шиг  
болов.

-Охин минь, квадрат фут гэдэг чинь 1  
футын урт, 1 дюймын зузаантай

модны тайрдас шүү дээ. Өсөж том болоод нөхөрт гарч, сайн чанарын банзаар таван өрөө товхийсэн байшин барих болбол нөхөрт тань арван хоёр мянган квадрат хэрэгтэй болно доо.

-Би нөхөрт гарахгүй ээ.

\* \* \*

Загасчид ойчидоос арай л цөөн ажээ. Тэд тэнгисийн үнэр ханхлуулсаар хөлсний байрандаа ирээд, тэнгисийн гүехэн усанд хясаа үржүүлэхийг оролдох тухай, үзэгдэж харагдаагүй аварга том май загас, макрель, тунц загас барьсан

тухайгаа сайрхан ярьцгаана.

Гэтэл эд бүгдийн дотроос хэн хэн нь ч уурхайчид шиг Ларагийн сэтгэлийг татсангүй. Кэйн-Бретонд гурван мянга таван зуу илүү уурхайчид ажилладаг. Тэдний уурхай нь Лингэн, Принс, Фаллендад байдаг ажээ. Уурхайнууд "Түүхт ойн", "Сүүлчийн боломж", "Хар бриллиант" гэсэн нэр нь охины чихэнд ихэд уянгалаг сонсогдоно.

Уурхайчид ширээний ард сууцгаан өдрийн ажлаа хэлэлцэж эхлэхэд Ларагийн хамаг бие нь тавирч ер бусын мэдрэмж төрдөг ажгуу. -Майк юу болсон бэ? Үнэн яриад байна уу

эсвэл цуу яриа юу? -Чин үнэн шүү.  
Тэр амсаргүй уурхай руу буутал  
араас нь вагонцор гулган шааж  
орсон. Хөөрхий минь, бяц  
дайрагдсан. Бригадын дарга гэж  
гичийний зулбасга түүнийг цагийг нь  
олж харайж чадаагүй өөрөө  
буруутай гэж чалчиж байна. Бас ч  
үгүй, түүний дэнлүүг нь унтраасан  
гэсэн шүү.

-Юу ч ойлгосонгүй гэж Лара  
аягүйрхэн асуухад нь,

-Майк уурхайн мөргөцөгт унаж,  
дугуйтай жижигхэн төмөр тэвшинд  
дарагдсан даа. Хэн нэг нь замын  
сумыг нь шилжүүлээгүйгээс болж

ачааны вагонцор түүнийг дарсан аж.  
Ингээд бүх юм өнгөрсөн дөө.  
Хөөрхийс хэмээн нөгөөх хүн  
тайлбарлав.

-Түүний "дэнлүүг унтраасан" гэж юу  
гэж байгаа юм бэ?

Уурхайчид хөхрөлдөж,

-Дэнлүүг нь унтраана гэдэг нь  
хөөрхийг халлаа гэсэн үг.

Лара арван таван насандаа Гэгээн  
Михайлын дунд сургуульд элсэн  
орлоо. Энэ үед тэрээр эв хавгүй урт  
чацтай, туг тугаар өрвийсэн  
долгиотой ширүүн хар ус, одоо

хүртэл түүний нимгэн цонхигор царайд томдсон юм уу гэлтэй ухаалаг саарал нүдтэй нэгэн болон хувирчээ.

Эцсийн эцэст энэ нугасны муухай дэгдээхэй хэрхэхийг хэлэхэд тун хэцүү байлаа. Байгалийн хувирал нь тун ч алгуур явагдаж, гоо үзэсгэлэн, царай муутай алин болохыг хэн ч тааж тааварлахын аргагүй байв.

Жеймс Камероны хувьд гар дээр үлдсэн ганц охин нь ерийн нэг мануухай мэт санагдана.

-Ямар нь тааралдсан ч бай, эхний тэнэгтэйгээ гэрлэж үз. Нүд шүдээрээ



хуурдаг нь лав чи биш гэж тэрээр  
Ларад яншихад нь Лара  
дуугарсангүй.

-Тэгээд надаас инж горьдсоны  
хэрэггүй гэдгийг сайн хэлэх хэрэгтэй  
гэж эцэг Жеймс хэлэв.

Өрөөний босгон дээр Мунго  
Максуины дүрс сүүтэгнэн, модчин эр  
уураа арай ядан дарж хамаг цээж нь  
оволзон байв.

-Гүйцээ. Гал зуух руугаа зайлж үз  
хэмээн Камерон охин руугаа  
давшилсанд Лара ч ум хумгүй гарч  
явлаа.

-Чи охинтойгоо яаж ярьж байгаа чинь энэ вэ? хэмээн Мунго зэвүүцэн асуухад,

Камерон орж ирэх эрийг зэвхий саарал нүдээр хайхрамжгүй ширвэн харж,

-Чамд хамаагүй гэлээ.

-Өө, чи согтуу байх шив.

-Согтуу байнаа. Хэнд юуны ялгаа байна?

Максуин гэдрэг эргэн гал зуух руу ороход, Лара нүд дүүрэн нулимс мэлтэгнүүлэн бохир аяга таваг угааж

ЗОГСОВ.

-Бүгдийг март. Эцэг чинь  
халамцсандаа л тэгж байна хэмээн  
Мунга намуухан дуугаар хэлэв.

-Тэр намайг үзэн яддаг.

-Үгүй дээ, бяцхан хонгор минь үгүй.

-Би түүний амнаас сайн сайхан үг ер  
сонсож байгаагүй. Ганц ч удаа үгүй  
шүү.

Энэ тухайд модчин эр Мунгад хариу  
хэлэх аятайхан үг олдсонгүй.

Зундаа Глэй-Бэйд чамгүй олон

жуулчид ирдэг ажээ. Тэд үнэтэй машин унан хотоор давхилдаж, чамин гоё костюмтай гудамжаар зугаацан дэлгүүр мухлаг хэсэн, санаанд оромгүй үнээрээ зартай

Жаспер, Седрын ресторанд хооллоод эцэст нь шувуудын арал тийш хөдөлцгөөдөг байлаа. Эд нар бол тэндхийн оршин суугчдаас тэс өөр заншилтай, аз жаргалтай ертөнцийн элч төлөөлөгчид шиг санагдана.

Лара тэднийг харан атаархаж зуны сарын эцэст хувь заяа нь түүнийг энэ азтай хүмүүсийн араас илгээгээсэй хэмээн мөрөөддөг байв. Эцэг нь

заримдаа Жорж Максүэллын тухай ярих нь охины чихийг сортойлгох болжээ.

-Эрваа хөгшин чинь, надад эрдэнэ мэт үнэтэй охиноо өгөхгүй санаатай байсан шүү. Чи бод доо, цүлхийсэн мөнгөтэй илжиг надад ядаж сохор зоос ч гэхнээ явуулсан уу? Хаа байна тэр нь! Гэтэл би түүний охин Пеггиг асран халамжилсаар... хэмээн нэгэн оршин суугч хүнд уйлаггнан гомдоллож байжээ.

Лара заримдаа өдрийн турш өвөг эцэг Жорж нь хүрч ирэн түүний уншиж мэдсэн ид шидийн мэт Лондон, Париж, Рим хот руу аваад

яваасай хэмээн мөрөөднө. Тэгвэл би ч бүхэл бүтэн шүүгээ дүүрэн тансаг сайхан палааж, ороолт, цамцтай болно доо. Тэгээд бас мянгаад хос гуталтай.

Сар, жил улиран өнгөрөх авч, хүсэн мөрөөдөх өвөөгөөс нь сураг чимээ ч алга. Лара өөрийн мөрөөдлөө хүлцэх боллоо.

Үзтэл өөрийн бүхий л амьдралаа Лара улиг болон залхаасан Глэй-Бэйд өнгөрүүлэх төөрөгтэй бололтой.

## Дөрөвдүгээр бүлэг

Глэй - Бэйн багачуулд жилийн улиралтайгаа зохицон хөл бөмбөг хоккей, өвөлд нь цана, тэшүүрээр гулгах, зунд нь загас жараахай барин усанд наадаж, цагийн байдлаас үл хамааралгүй боулингийн танхимд өнгөрүүлэх гээд тоглож наадах талбай мундахгүй. Хөвгүүд, охид хичээлийн дараа эзэн нь өндөр лангуун дээр шилтэй хүйтэн ундаа, тавагтай амттан, аяга кофе өрж тавьдаг "Карлынд" гэдэг эмийн санд цуглах дуртай ажээ. Хоёр ч кино театрт муугүй кино гарч, бүжиглэх гэж хөл нь загатнагсад шууд л Форум

эсвэл Венецийн цэцэрлэг рүү явдаг байлаа.

Гэвч Ларагийн хувьд энэ хорхой хүрэм наадгайнууд огтын падгүй хэрэг. Лара өдөр бүр тогооч Бертад туслахаар өглөөний таван цагт босон хөлслөгчидийнхөө ундыг бэлтгэн өрөөг нь цэвэрлээд сургуульдаа явна. Харин хичээл тармагц байр руугаа оройн хоолны ширээ засахаар яаравчлах хэрэгтэй болдог аж. Лара тогоочтойгоо хамжин байж өлссөн харчуулыг хооллоод, сав суулгаа угаана.

Зоогийн үеэр сонссон хэсэг бусаг ярианаасаа Хайлендсын уулсын ер



бусын үзэсгэлэнтэй болохыг нь Лара нүдэндээ ургуулан бодно. Суугчид хурц бус наранд толь мэт гялалзах Лох-Несс, Лохи, Линнийн нурууд бүхий уудам хөндийн тухай, тэнгисийн хойгоос наран шингэх зүг тийш армаг тармаг цацагдсан мэт жижигхэн арлуудын тухай олонтоо ярина.

Нийтийн танхимын буланд хуучин, хагархай төгөлдөр хуур байх ба эрчүүд орой үдшийн цагаар түүний дэргэд цуглан чадварлаг хоолойгоор:

"Бяцхан Энни", "Хөх тариан талбай", "Байшингийн дэргэдэх дов" хэмээн

алс нутгийн дуугаа дуулцгаана.

Глэй-Бэйн оршин суугчид жилд ганц удаа баярын жагсаал хийнэ.

Шотландууд үндэсний хувцсаараа гоёцгоон, хөөрөгт цуурын гунигтай аялгуу дор гудамжаар омог бардам алхалцгаана.

-Яагаад эрчүүд банзал өмсдөг юм бэ? гэж Лара нэг удаа Мунгогоос асуухад нь, тэрээр хөмсөг зангидан,

-Энэ банзал бишээ, хөөрхөн хүүхэд минь. Энэ бол килт. Манай танай өвөг дээдэс үүнийг олон зуун жилийн тэртээгээс өмсөж эхэлсэн юм. Уулынхан цээжин биеэ том

ноосон алчуураар хучиж, ан агнах  
дайсантай сайн тулалдах гэхдээ  
хөлөө хөнгөн шаламгай байлгах гэж  
сул чөлөөтэй үлдээж байжээ.

Шөнийн цагаар зузаан ноосон  
даавуу нь тэдэнд хөнжил дэвсгэр  
болдог юм гэжээ.

.Лара Бредолбэйн-Гленфинна,  
Килбрайд, Килнинвер, Кил-майкл  
гэх шотландын тосгодын нэрийг  
бахдалтайяа сонссон "кил" гэдэг нь  
дундад зууны тэнэмэл даянч гэсэн үг.  
Хэрэв тосгоны нэр "инвер" эсвээс  
"абер"-ээр эхэлсэн байвал голын  
эхэнд байрласан гэсэн утгатай.  
Харин тосгоны нэрэнд "страт" гэдэг  
үе орсон байвал хөндийд

байрласан, "бад" гэж байвал ойд юм уу төгөлд байдаг гэдгийг Лара мэдэх болжээ.

Ширээний ард ширүүхэн маргаангүй өнгөрөх нэг ч үдэш байдаггүй гэж хэлэхэд дэгэсдүүлсэн хэрэг болохгүй биз ээ. Шотландчууд л дурын шалтаг гарган мөрийцөх язгуурын дуртай улс. Олонхи хуланц эцгүүд нь цэргийн омогт харьяалагдаж, бас тэдний жич, зээнцэр нь хэний ч өмнө толгой бөхийлгөж яваагүй уг удмынхаа нэр төрийг гутаах ёсгүй хэмээн үздэг ажээ.

Брюсийн омгийнхон зүрх зоригоороо тодорч яваагүй шүү дээ.

Тэд англичуудаас айхдаа хавчигнан гийнах хамуутай нохой шиг орилон амь зулбан зугтаж байсан.

-Хөөе чи Кен, дандаа амьтны амнаас гаршгүй дэмий үг чалчиж байх юм. Тэгж яривал Брюсийнхан англичуудын өмнөөс анхлан боссон байх шүү. Тэгж яривал Стюартууд л өөрсдийнхөө нэрийг мөнхөд бузарласан даа.

-Годил толгой! Танайхан бүгд хас чулууг ялгадаггүй, мөчид бодолтой улс байдаг уу?

Ширээний ар дахь уур амьсгал аажим ширүүсэв. -Тэгвэл чи

Шотландчууд юу тогтоон барьж чадаагүйг мэдэх үү? II Роберт шиг ухаантай удирдагчийг шүү дээ. Тэр бол жинхэнэ баатар эр байсан юм. Бас хорин нэгэн сайхан хүүг-зовох юмгүй амжуулж бүтээсэн дээ!

-За, гэвч тэдний талыг нь шахуу гудамжны янхан хүүхнүүд ертөнцөд тээж төрүүлсэн гэх чинь билээ.

Маргаан алгуур еөр голдрил тийшээгээ эргэв. Тэдний яриаг сонсоод зургаан зуун жилийн тэртээд болсон явдлын талаар улайран маргалдах нь тэдэнд тийм л сонин байгаа юм гэдэгт Лара нэг л итгэж өгсөнгүй. Аягүйхэн байх

охиныг харсан Максун,

-Эдний чалчаа яриаг тогтоож  
сонсохын хэрэггүй, хараацай минь.

-Шотландчууд сүүдэртэйгээ ч  
маргалдаж, зодолдохоос сийхгүй улс  
гэжээ.

Гал руу тос нэмэх мэт Вальтер  
Скотын шүлгийн мөрүүд түүний  
санаанд урган орж ирэн түүний  
найраглалын Лохинварын баатрын  
дүр нүдэнд тодрон: "Цаг нь ирэхээр  
үзэсгэлэнт баатар Лохинвар намаайг  
аврахаар наашаа ирнэ" хэмээн Лара  
бодов.

Нэгэн удаа Лара гал зуухны өрөө  
цэвэрлэж яваад зар сурталчилгааны  
сэтгүүлийн тасархай хуудас олжээ.  
Сэтгүүлийн гялгар хуудсан дээрээс  
урт хормойтой хар хөх фрак өмсөж,  
цасан цагаан эрвээхэй зангиа зүүсэн  
өндөр нуруутай, цайвар үстэй  
эрэлхэг нэгэн эр түүний өөдөөс  
ширтэнэ. Айхтар харцтай цэнхэр  
нүдтэй үл мэдэг инээмсэглэл  
тодруулсан залуу эр хунтайж мэт  
харагдана. Энэ байна, миний  
Лохинвар энэ байна шүү дээ. Тэр аль  
хэдийнэ энд ирчихээд намайг хайж  
байна. Би угаагуурын дэргэд сав  
суулга угаан зогсож байхад тэр араас  
минь чив чимээ ч үгүй хүрч ирэн



мөрөөр минь тэвэрч, намуухан  
дуугаар "Танд туслахыг зөвшөөрнө  
үү" гэнэ. Тэгэхэд нь би эргэн түүнийг  
эгцлэн тиртээд, -"Та таваг арчих уу?"  
гэж асууна даа хэмээн бодож  
байлаа.

Гэнэт ардхан талд нь Бертагийн дуу  
гарч,

-Би туслах уу гэж асуув.

Лара сандран гэдрэг эргэн харлаа.  
Бурхан минь гэж арай сонсчихоогүй  
байгаа даа. Тогооч яг дэргэд нь  
зогсож байлаа.

-Хэрэггүй, Би өөрөө угаана.

Газрын эзэд, фермерүүдийг газраас нь хөөж тууж байсан газрын хонзонтой цэвэрлэгээний тухай түүх түүний сэтгэлийг бусдаас илүү догдлуулав.

-Алив дахиад нэг яриач гэж түүний гуйхад Максун түүнд хэзээ ч үгүй гэж татгалзалгүйгээр,

-Энэ бүхэн 1792 оноос эхлэн, бараг 70 жил үргэлжилсэн гэхэд худлаа гэхгүй л байх. Эхний жилд энэ компанит ажлыг хонины жил гэж нэрлэж байсан юм. Газрын эзэд хонин сүрэг тэдэнд ялихгүй газрын түрээснээс илүү үлэмж илүү ашиг авчирна гэж мэджээ. Хайлендст асар

их тууврын хонин сүрэг оруулж ирэн удалгүй хүмүүс бүх л өвлийн турш дутагдах юмгүй тэжээж болохыг ойлгожээ. Ийнхүү цэвэрлэгээний ажлын суурь тавигдсан юм.

Үгээгүй хоосон ядуучууд зовлонд автаж хөндий даяар:

-Ээ газар дэлхий минь чамд гаслан учирч өнөөх үй олон хонь ирж явна!  
Зуу, хоёр зуу, гурван зуу араас нь мянга, бас араас нь хэдэн арван мянга! хэмээн гаслан гангинах сонсогдоно.

Эд баялаг Лордын гарт урсан орж эхлэхэд өдөр, шөнөгүй нуруугаа

бөгтийлгөн алга дарам газартаа  
ажиллах түрээслэгчдээс ангижрах  
хэрэгтэй болжээ. Жирийн ард түмэн  
хөрөнгө зөөр гэх юмгүй болсныг  
Бурхан гэрчлэнэ. Ажилчид яндангүй  
тэр ч бүү хэл цонх ч үгүй хэцүүхэн  
чулуун овоохойд амьдарч байтал  
төдөлгүй тэндээс нь хөөж тууж  
эхэлсэн дээ.

-Яагаад тэр вэ? хэмээн сэтгэл  
түгшсэн Ларагийн нүд аль  
байдгаараа бүлтийв.

-Засгийн газрын цэрэг тосгоныг  
эзлэн, оршин суугчдыг нүүлгэн  
шилжүүлэх тушаал авсан байсан.  
Тосгоны цэргүүд орж ирмэгц, юм

хумаа цулуулж бэлтгэхэд нь ердөө л зургаан цагийн хугацаа өгч, эцэст нь нуруу руу нь бууны бөгсөөр нүдэн гэрээс нь хөөж гаргаж байсан. Ургац тэр чигээрээ үхэж, ядуу муусайн овоохойнуудыг буулган эвдэж байлаа. Саяын дөрөвний нэг шахам эр, эм, хүүхэд өчүүхэн төдий хөөрхийлөлтэй өмч хөрөнгөнөөсөө үүрд хагацацгаан тэнгисийн нүцгэн эрэг тийш шахагдан хөөгджээ.

-Яагаад тэдний газрыг авсан юм бэ?

-Тэд газрыг эзэмшиж байгаагүй юм. Тэд ердөө л акр, хоёр акраар нь эзнээсээ түрээсэлж авч байсан. Үүнийхээ хөлсийг эзэндээ

хөдөлмөрөөрөө эсвэл бараа таваараар төлж, хариуд нь газраа эдлэн түүн дээрээ амь зогоох ганц нэг ямаа, амьтан шувуу тэжээж байжээ. -Явахгүй гэснийг нь яасан бэ? хэмээн Лара амьсгаагаа дарж ядан шивнэн асуухад, -Эрхээ эдлэхийг оролдсон хөгшчүүдийг овоохойтой нь шатаасан. Засгийн газар энэрэх гэдгийг даанч мэдэхгүй. Хүмүүс талхны булан ч үгүй болж, үй олон өлсгөлөн хүний амийг тахал аваад явчихсан. -Ямар аймшигтай юм бэ?

-Аймшиг, хэлэхийн эцэсгүй аймшиг, хонгор минь. Ургаж байгаа цагт нь таван салааны зутан хийж амь

аврагдаж байсан. Засгийн газар

Хайлендсийн оршин суугчдын цорын ганц эд болох-омог бардам занг нь хотойлгож чадаагүй дээ. Хүмүүс чадлынхаа хэрээр сөргөлдөн

эсэргүүцэж байлаа. Овоохой орон сууцаа нураалгасан хүмүүс ил задгай гадаа хоног төөрүүлэн, эвдэлж хэмхэлсэн оромж овоохойноосоо үлдсэн жаахан эд хогшлоо аварч чадсан. Тэд зотон даавуугаар хийсэн цоорхой майхнаар борооны халхавч хийж байжээ. Би энэ бүгдийг хүланц эцгээсээ мэдсэн юм. Ийм нэгэн гашуун түүх бидний сэтгэлийг түймэрдсэн юм даа.

Лара заяа нь орхисон мянга мянган  
уулынхан гаслан уйлж, цөхөрч  
тэврэлдэн байхыг ургуулан бодлоо.

-Энэ бүхэн юу болж төгссөн бэ,  
Мунго?

-Амь зулбан гарсан олон хүн  
хэврэгхэн завинцарын оронцогт  
сууцгаан харийн нутаг тийш сайн  
сайхан хувь заяагаа эрэлхийлэхээр  
мордоцгоосон гэдэг. Хумхаа. цусан  
суулганаас олон ч хүний амь  
хохирсон доо. Далайн шуурга тэдний  
зарим нэгийн завийг замаас нь  
гаргаж хаян, мөн хүнс тэжээл нь  
барагдаж, хамгийн сул доройнууд  
нь өлсөн үхэцгээж байв. Арай



дөнгүүр тэнхээтэй нь Канадын эрэгт очиж чадаж байсан. Шинэ газар нутаг зүрхтэй эрчүүдэд урьдын амьдралдаа хэзээ ч байгаагүй юмыг өгсөн.

-Тэр бол "газар" Лараг хэлэхэд нь,

-Чиний зөв өө охин минь гэв.

Хэзээ нэг цагт, би ч гэсэн өөрийн газартай болж, хэн ч түүнийг надаас авахгүй! хэмээн Лара боджээ.

\* \* \*

Долоон сарын нэгэн өдрийн үдэш оройхон Жеймс Камерон ээлжит

янханаа өвөртлөн хэвтэж байтал  
түүнд гай учиржээ. Чамгүй ууж  
хөлчүүрхсэн Жеймс өөдөө харан  
атиралдахад түүнийг унтчих нь  
хэмээн бодсон Кристи авхайн  
харъяат янхан,

-Алив аа, сэрээч ээ! Ганц чи байгаа  
биш намайг өөр хүн бас хүлээж  
байна шүү дээ, Жеймс ээ, сэрээч!  
хэмээн дугтчихад,

Камероны уруул чичигнэн  
шуналтайяа агаар сороод,

-Бурхныг бодож, эмч дуудаач гэж  
сонсогдох төдий сөөнгөтөн  
дуугарчээ.

"Түргэн тусламж"-ийн дамнуурга дээр хэвтэх Жеймсийг Куорри-стрит дэх жижгэвтэр эмнэлэгг авчирч, Дункан эмч Лараг дуудуулжээ. Махнаас тасарсан мах, цуснаас үсэрсэн цус нь болсон төрсөн ганц охин нь цээж дүүрэн зовлон тээсээр хүлээн авах өрөөнд орж ирэв.

-Аав яасан бэ? Тэр үхчихсэн үү?

-Тайвшир, Лара. Хараахандаа үгүй л байна. Түүний зүрх нь мууджээ.

-Тэр... амьд гарна биз дээ? хэмээн Лара хэл нь үл захирагдаж буй бололтой түгдчин асуулаа.

-Хэрхэхийг үнэндээ хэлж мэдэхгүй байна. Бид чадах бүхнээ хийж байна.

-Би түүн дээр орж болох уу? -  
Одоохондоо хэрэггүй. Өглөө дээр биз дээ. Тэрээр сандарч мэгдсэн хэвээр харилаа.

Бурхан минь, аавыг минь битгий үхүүлээн, надад түүнээс өөр хэн ч байхгүй шүү дээ!

Тогооч Берта Лараг хөлсний байрандаа тэсэн ядан хүлээж байлаа. -Юу болоов?

-Ээ Бурхан минь! Очиж очиж

Баасанд шүү! гэж охин хэллээ.

-Юун баасан вэ?

-Баасан гаригт аав байрны хөлсийг хураадаг юм даа. Миний мэдэхээр энэ бузар Макаллистер мөнгөө гар дээрээ тавихгүй л бол огт тээнэгэлзэлгүйгээр биднийг гудамжинд хөөж гаргана даа.

Урьд өмнө нь Жеймс Камерон архидахаар явахдаа нэг бус удаа охиныгоо таван байраар явуулж, түрээсийн төлбөр нэхүүлж явсан удаатай. Лара эргэж ирээд хураасан мөнгөө эцэгтээ гардуулахад нь маргааш өдөр эцэг нь банкны эзэнд

тушааж байжээ.

-Одоо яах вэ? гэж арга тасарсан  
Берта ёолох дуулдав.

Лара гэнэт шийдэмгийгээр,

-Бүү санаа зов. Би өөрөө энэ талаар  
санаа тавина гэв.

Оройн хоолон дээр тэрээр ширээ  
тойрон суугчдад хандан,

-Жентельменүүдээ, ганцхан минут  
анхаарлаа хандуулахыг хүсье гэсэнд  
танхимд ялаа нисэх нь хүртэл  
дуулдмаар нам гүм болж, хооллож  
байсан хүмүүс охиныг гайхсан

харцаар харцгаав.

-Аав...бие нь муудаад. Яасныг нь тодруулахаар түүнийг эмнэлэг рүү аваачсан. Түүний эзгүй байх хооронд би мөнгө хураана. Оройн хоолны дараа би та нарыг албаны өрөөнд хүлээж байя.

-Жеймсэд муу юм болохгүй гэж найдаж болох уу? гэж хэн нэгэн сонирхон асуув.

-Тэгэхээр... гээд охин хүчлэн байж инээмсэглэснээ,

-Онцын юмгүй дээ гэлээ.

Оройн гүнцэгээ барьсны дараа эрчүүд албаны өрөө рүү ганц нэгээрээ цувралдан орцгоолоо.

-Үзэсгэлэнт охин минь, аав чинь удахгүй гарна...

-Туслалцаа хэрэгтэй болбол дуулгаарай...

-Сайн байна! Уруу царайлахгүй...

-Бусад байруудыг яах болж байна? Бас цаана нь дөрөв байна шүү дээ гэж Берта сэтгэл зовнин асуув.

-Мэдэж байна. Сав суулгаа угааж бай, би очоод ирье.



-Амжилт хүсье хэмээн түүний араас хэлэх Бертагийн дуунд эргэлзсэн аяс тодров.

Гэтэл хачирхалтай нь Ларагийн ажил тун амархан бүтжээ. Суугчдын олонхи нь Жеймсийг үнэн сэтгэлээсээ асууж сураглаад элдэв шалдав асуудалгүйгээр хөлсөө төлцгөөв.

Охин маргааш өглөө эртлэн мөнгөө дугтуйлаад Шон Макаллистер руу явжээ. Банкны эзэн өрөөндөө байв.

-Нарийн бичгийн дарга чамайг надтай уулзахаар яваа гэсэн шиг билээ?

-Тийм ээ, эрхэм ээ.

Макаллистер үзэмж муу, ядуу  
хувцастай охиныг үл итгэсэн харцаар  
харан,

-Чи Жеймс Камероны охин, тийм үү?  
гэв.

-Тийм ээ, эрхэм ээ.

-Сара байхаа?

-Үгүй ээ, Лара.

-Эцгийн чинь тухай сонссон.

Харамсалтай, тун харамсалтай гэж  
банкны эзэн залхан, үл тоон

өгүүлснээ,

-Одоо шинэ хүн хайх хэрэгтэй болж дээ. Хэрэв зээ Жеймс хойшид албан үүргээ биелүүлж чадахаа больсон бол би...

-Үгүй, үгүй эрхэм ээ! Аав намайг албан үүргээ биелүүлэхийг гуйсан...

-Таныг уу?

-Тийм ээ, эрхэм ээ.

-Энэ боломжгүй гэж айх...

Лара дугтуйтай мөнгийг ширээн дээр тавьлаа.

-Энэ өнгөрсөн долоо хоногийн хөлс!

-Мөнгө бүрэн бүтнээрээ байгаа юу?  
хэмээн Макаллистер үл итгэсэн  
янзаар асуув.

Лара толгой дохилоо.

-Чи тэгээд өөрөө цуглуулаа юу?  
Ганцаараа юу?

-Тийм, эрхэм ээ. Аавыг эмнэлгээс  
гартал би үүнийг түүний оронд хийж  
чадна гэдэгтээ бүрэн итгэлтэй байна.

-За за. Харж л байя. Байрны эзэн  
дугтуйг нээн, мөнгөө нягтлан  
тоолоод дүнг хар дэвтэртээ нямбай

гэгч нь тэмдэглэж авахыг нь Лара харж зогсов.

Макаллистер архидах дон шүгэлсэн, балай хэрүүлч Жеймс Камероныг дуулгавартай нэгэн хүнээр солих тухай бараг хагас жилийн туршид боджээ. Яг одоогийн тохиолдол нь түүнд нэн таатай боломж олгож аз дайрсан байна.

Доожоо муутай охин эцгийнхээ үүргийг биелүүлэхэд хүчин мөхөсдөнө гэдэгт Шон итгэлтэй байв. Гэвч Камерон болон түүний охин хоёрыг хөлсний байрнаас хөөж гаргавал хот даяар түүний тухай ямаршуухан цуурхал тарах тухай

эрүүл саруул уураг тархи нь хэлэн түүний гэгээн мэлмийг нээж өгсөн байна.

-Танд сарын туршилтын хугацаа өгье. Энэ бүхэн хэрхэх нь гуч хоногийн дараа мэдэгдэнэ биз ээ.

-Ноён Макаллистер, танд гялайлаа. Эрхэм ээ...

-Хүлээгээрэй. Ямар ч хөдөлмөр үнэлэгдэх ёстой гээд мань эр охинд хорин таван долларын дэвсгэрт сарвайв.

\* \* \*

Мөнгөө тас атгасан Ларад ер бусын эрх чөлөөний амт мэдрэгдэж, тэрээр амьдралдаа анх удаа хөдөлснийхөө хөлсийг авч үзэх нь тэрээ.

Лара Банкнаас гараад шууд эмнэлэг рүү явлаа.

Охин эцгийнхээ хэвтээ тасгийн босгон дээр Дункан эмчтэй халз мөргөлдөв.

-Аав муудаа юу? гэж охин айн асуув.

-Үгүй... Бүү шанал даа, Лара, тэр зүгээр ээ гэж эмч хэлснээ хэсэг зуур түдгэлзэн,

-Би "зүгээр" гэж хэлж байвал... тэр...  
үхэхгүй. Ядахнаа ойрын өдрүүдэд  
тэр шүү. Харин Жеймс хоёроос  
гурван долоо хоног хэвтрийн дэглэм  
сахих хэрэгтэй. Өө тийм, түүнийг  
сахих хүн хэрэгтэй байна гэж нэмж  
хэлэв.

-Би өөрөө сахинаа.

-Эцэг чинь мэдээж үүнийг төсөөлөх ч  
үгүй байгаа л даа, хонгор минь, гэвч  
тэр их азтай хүн юм хэмээн эмч чин  
сэтгэлээсээ өгүүлэв. -Би түүн дээр  
орж болох уу? -Бололгүй яахав.

Лара тасаг руу орвол цонхийсон  
царайтай, сул дорой, гэнэт



мэдэгдэхүйц хөгширсөн Жеймс  
бүтээлгээр хучаатай хэвтэнэ. Охинд  
гэнэт туйлгүй өрөвдөх сэтгэл төрж  
эцгийнхээ тусын тулд ямар нэг  
юм хийж эцэгтээ хайртайгаа батлах  
хэрэгтэй...

Лара чимээ гаргалгүй ор руу дөхлөө.  
-Аав аа...

Жеймсын зовхи нь чичирсхийснээ  
нээгдэж,

-Ямар чөтгөр нь чамайг наашаа  
авчраа вэ? Өөр хийх юм алга уу? гэж  
бөглүү дуугаар бөвтнөв. Лара хөшиж  
орхилоо. -Би... би ойлгож байнаа,  
аав аа. Би Шон Макаллистерт очиж

мөнгийг нь өгсөн хэмээн хэлэх гэж л ирсэн юм. Бид тохиролцсон, би таны оронд хөлсийг цуглуулах...

-Чи, чи хөлс цуглуулах гэж үү? Тэнэг минь битгий инээд хүргэчих гээд гэнэт цочмог хатгалтаас болж өвчтөний нүүр ярвайн таталдан, дуу нь цааш орон сулбайж,

-Хувь заяа. Хараал идсэн хувь заяа. Намайг хаалгаар гаргаж хаях.. хэмээн хяхтан хэллээ.

Тэр охиныхоо тухай огтхон ч бодсонгүй. Лара минут хэртээ эцгийгээ ширтэн таг дуугүй зогссоноо гарч явлаа.

Гурав хоногийн дараа Камероныг гэрт нь гарган оронд нь хэвтүүлэв.

-Та дахиад хоёр долоо хоног босохгүй хэвтэнэ шүү. Би нөгөөдөр ирж үзнэ гэж Дункан эмч захихад нь,

-Намайг битгий оронд минь хөрвөөлгөх гээд бай. Хэн тэгээд ажиллах болж байна? гэж Жеймс зэвүүцэн хэлэхэд нь,

-Нэг бол хэвтэж амь гар, эсвэл босч яваад төрөл арилжих эсэхээ өөрөө сонго хэмээн эмч өвчтөн эрийн нүд рүү эгцлэн ширтэн хатуухан хэлжээ.

\* \* \*

Зан ааш нь эвдэрээгүй залуухан  
бүсгүй баасан гариг бүр  
Макаллистерын хөлсний байрны  
хонгилоор түрээсийн мөнгө  
цуглуулахаар явах нь оршин  
суугчдад бүр эхнээсээ таалагджээ.

Нэг ч их удалгүй тэд мянга мянган  
шалтагаар Лараг булж эхэлцгээсэн  
байна,

-Би бүтэн долоо хоног өвдөөд,  
эмчид бөөн өртэй...

-Хүү маань долоо хоног бүр надад  
мөнгө явуулдаг юм, гэтэл өчигдөр

яагаад ч юм шуудан ирээгүй...

-Шинэ бензин хөрөө худалдаж,..

-Ирэх баасан гаригт заавал төлнө,  
итгэж болно.,.

Гэтэл эцгийнхээ ажил үүргийг орлон  
гүйцэтгэхгүй бол Ларагийн төдийгүй  
түүний эцгийн амьдрал ч гэсэн ээлж  
дугаараа хүлээн байхыг үгүй гэх  
газаргүй.

Охин оршин суугчдыг туйлын тайван  
сонсоод, эцэст нь,

-Өршөөгөөрэй та, маргааш Шон  
Макаллистерт хөлсийг өгөх учиртай.

Хэрэв та хөлсөө төлж чадахгүй бол өрөөгөө суллахыг хүсч байна хэмээхэд шаардсан мөнгө нь ид шид гэлтэй гараад ирдэг байлаа, Ларагаас өршөөл энэрэл гуйж аргандаа оруулна гэдэг санасны гарз ажээ.

-Чиний эцэгтэй чинь хэл амаа амархан ололцдог байжээ. Тэр хүлцэн хүлээхийг зөвшөөрдөг байсан юм шүү гэж дургүйцсэн ганц хүн нь хий дэмий л амандаа бөвтнөөд өнгөрдөг байв.

Гэвч эрчүүд санасныхаа мухарт охины хатуу чанд занг нь бахархдаг байлаа.

Эцгийнх нь өвчин тэднийг хэн хэндээ ойр дотно болгоход дэм болно гэж найдаж байсан Ларагийн итгэл талаар өнгөрчээ.

Охин өвчтэй хүний ялархуу зан биз хэмээн бодоод, илүү халамжлах тусам Жеймс тэсвэрлэхийн эцэсгүй аашладаг байв. Лара өдөр болгон баглаа цэцэг, шинэ жимс авчирахад нь,

-Буян санаж, наад жүжгээ больж үзээч! Нүдний үзүүрт бүү бөртөлзөөд бай! Явж ажлаа хий! гэж эцэг нь бархирна.

-Би бодохдоо, та...

-Эндээс зайл! гээд Жеймс нүүр  
буруулан хана руу эргэнэ. Үзэн ядаж  
байна. Намайг нүдэнд орсон хог шиг  
үзэн ядаж байна хэмээн Лара  
боддог байв.

\* \* \*

Лара сарын эцсээр пиндийтэл чихсэн  
дугтуйтай мөнгө барьсаар  
Макаллистерийн өрөөнд ороход  
банкны эзэн дүнг нөгөө дэвтэртээ  
бичээд,

-Залуу авхай, та намайг гайхшруулж  
орхисныг би хүлээн зөвшөөрөх ёстой



гэж бодож байна. Жеймс Камерон  
охиныхоо чигчий хуруунд ч хүрэхгүй  
юм байна гэжээ.

Түүний хэлсэн найрсаг үг Ларагийн  
сэтгэлд нийцлээ. Охины царай нь  
чавга шиг улайв.

-Баярлалаа, эрхэм ээ.

-Энэ сард ганц ч өртэй хүн үлдээгүй  
гэдгийг шударгаар хүлээн  
зөвшөөрмөөр байна.

-Тэгэхээр аав бид хойр байрандаа  
үлдэж болох нь ээ?

Шон охиныг хуял шингэсэн нүдээр

ширтэв.

-Үлдэж болно. Ингэхэд та аавдаа  
амь юмаа даа.

-Ноён Макаллистер аа, би ирэх  
бямба гаригт ирнэ.

## Тавдугаар бүлэг

Эв хавгүй, болхи охин арван долоон нас хүрч бие хаа нь галбиржсан залуу бүсгүй болон хувирчээ.

Шотланд удмын цусны өө сэвгүй цайвар арьс, нум мэт матийсан хөмсөг, аянгын үүл мэт саарал нүд, нүүрсэн тас хар үс Ларагийн царайд тодорчээ. Ёроолгүй гүнзгий мэт хүүхэн хараа нь эрх чөлөөг эрхэмлэх уулынхны эмгэнэлт түүхийн цуурайн өгүүлшгүй их гунигийг далдлан нуух ажээ. Бүсгүйн араас сүүрс алдан эргэн харахыг хүлцэн, биеэ барьж дөнгөчих эрчүүд тун ховор олдох болов.

Орших суугч гонь бие эрчүүд  
ганцаардлынхаа уйг хатагтай  
Кристигийн хүрээлэнд ч юм уу, өөр  
иймэрхүү цэнгээний газар очиж  
тайлдаг байлаа. Цөс ихтэй, зүрх  
зоригтой зарим нэг нь сэтгэл  
хөдлөлөө илэрхийлэхээр гал зуухны  
дэргэд Лараг отон хүлээж байгаад,

-Лара минь, эелдэгхэн байж үзээч,  
би чиний төлөө үхэхийг... гэх ч юм уу  
эсвэл,

-Чи одоо хүртэл залуу хархүүгүй яваа  
гэж үнэн үү? Жинхэнэ эр хүнийг үзэх  
үү?

-Канзас-Ситигээр зугаалбал ямар вэ?

Би тийшээ пүрэв гаригг явна, хамт явах уу? гэлцэнэ.

Янагламтгай ажилчдын өвөртөө оруулах гэсэн ээлжит хоргоолтыг сонсоод Лара хедөлгөөнгүй хэвтэх Жеймс дээр очин,

-Аав аа, таны буруу байжээ. Эрчүүд намайг ганц ч алхуулахгүй байна гэв.

Түүнийг гарч явснаас хойш Камерон хаалттай хаалга руу удтал ширтэн хэвтлээ.

Хаврын эхэн сарын нэгэн өглөө үхэл эцгийг нь авахаар морилон иржээ. Даруухан оршуулгын ажиллагаа

Глэй-Бэйгээс милийн зайтай  
Гринвудын оршуулгын газар болж,  
Лара, Берта хоёр авсыг булшны  
нүхэнд хийн булахыг хоёулхнаа  
харан зогсов.

Гэвч талийгч эрийн араас ганц дусал  
нулимс ч газарт унасангүй.

\* \* \*

Гурав хоногийн дараа Билл Рожерс  
гэгч дал шахам настай лухгар  
биетэй, халзан америк эр хөлсний  
байранд суухаар ирлээ. Оройн  
хоолны дараа тэрээр Ларатай хэд  
гурван үг хэлцэхээр үлджээ.

-Хонгорхон бүсгүй минь, чи энэ баавгайн ичээ шиг газар өөрийгөө хөнөөн сууна гэхэд дэндүү үзэсгэлэнтэй юмаа. Бүгдийг хөсөр хаяад Нью-Йорк руу, Чикаго руу яв!

-Заавал ч үгүй явна. Гэхдээ маргааш л биш шүү.

-Таны амьдрал дөнгөж эхэлж байна. Юу хүсч байгаагаа мэдэж байна уу?

-Мэднэ. Би ихийг хүсч байна.

-Ойлгож байна! Гоёл бас бус...

-Үгүй. Надад газар хэрэгтэй. Эцэгт минь хэзээ ч байгаагүй тэр л газрыг

би эзэмшинэ. Тэр амьдралынхаа эцсийн мөчийг хүртэл сайн санаат хүмүүсийн өглөг буянаар амь зогоосон юм.

Биллийн дугариг царай гэрэлтэж,

-Үл хөдлөх хөрөнгө үү? Тэр нэгэн цагт би үүнийг оролдож явсан юм шүү! гэв.

-Нээрээ юу?

-Би Дундад Өрнөдийн хот болгонд шахуу байртай байлаа. Тэр ч бүү хэл би бага шиг зочид буудлын сүлжээний эзэн байсан шүү гэх Рожерсийн дуунд үлэмжийн



харуусал сонсдов.

-Тэгээд юу болсон бэ?

Билл мөрөө хавчисхийлгэн,

-Хомхой сэтгэл намайг сүйрүүлж аль байдгаа алдсан. Гэсэн хэдий ч одоохондоо дураараа дургиж дунд чөмгөөрөө жаргаж л явна.

Энэ ярианаас хойш орой болгон үл хөдлөх хөрөнгийн тухай өрнөх боллоо.

-Нэн тэргүүнд чиний бүхий л амьдралд юу хэрэгтэй вэ гэвэл тэр нь Б. Х. М. За чи, үүнийг л сайн санаж

аваарай.

-БХМ-ий? гэж Лара өөрийн мэдэлгүй давтав.

-Бусад Хүний Мөнгө. Жинхэндээ бол үндсэн хөрөнгийн хүчирхэг бизнес нь ашгийн албан татвар, бэлэн ба активийн өсөлтийн хорогдлыг хувь бууруулан улсаас чамд өгөх тэр хөрөнгөн дээр дөрөөлөн хөдөлдөг юм. Дэлхий гурван халим дээр тогтдог гэдэг эртний төсөөлөл шиг үл хөдлөх хөрөнгө гэдэг маань газар, байрлал, байр гэсэн гурван үндсэн зарчим дээр тулгуурлана, юу гэж нэрлэхээ өөрөө мэднэ биз. Уулын толгой дээр барьсан ямар ч сайхан

орд харш бол - гүн далай рүү  
шидсэн сохор зоос мэт ердөө л  
мөнгөний гарз болно. Харин хотын  
төвд барьсан яйжгий оромж бол  
ёстой нэг бууршгүй буяны хөрөнгө  
гэсэн үг шүү дээ.

Рожерс барьцааны үүргийн болон  
давхар санхүүжилтийн нууц, банкны  
зээл, түүний давуу талын тухай  
мэддэг бүхнээ ярихад, Лара чих  
тавин сонсож сэтгэл харамгүй өгөх  
түүний мэдээллийг уудаг цаас мэт  
өөртөө шингээн авч байлаа.

Гэвч хамгийн ач холбогдол бүхий  
яриа нь,

-Глей-Бэйд орон сууцны хангамж хүрэлцэхгүй, сүйрэлд хүрчихсэн газар байна. Ханцуй шалман орохсон гэхээс гар минь, тэсгэлгүй загатнаж байна. Ээ дээ, ядахнаа хорин насаар залуу бол ч...

Энэ мөчөөс эхлэн Лара төрөлх хотоо тэс өөр нүдээр харах боллоо. Сул газар болгон бүсгүйн нүдэнд барилгын суурь талбай, ой мод нь тэнгэр өөд тэмүүлсэн барилгын хана болон үзэгдэнэ.

Цаглашгүй оргилох хүсэл мөрөөдөл нь урам оруулж, бас ч үгүй айдас төрүүлнэ. Даанч гачлантай үүнийг хэрэгжүүлэхчих бэл хөрөнгө үгүй

Билл Рожерс Глэй-Бэйгээс явах  
өдрөө,

-Б.Х.М-ийг бүү мартаарай. Амжилт  
хүсье, охин минь гэжээ.

Яг долоо хоногийн дараа түүний  
өрөөг өндөр нуруутай, жар эргэм  
насны нямбайлан зассан үстэй Чарлз  
Коэн гэгч эрхэм эзэгнэв. Шинэхэн  
ирсэн зочин эрийг костюмынх нь  
оёдлоор нь шинжвэл чамгүй  
мэдрэмжтэй нь илт. Коэн нийтийн  
ширээний ард үдийн, оройн хоол  
зооглосон авч ярианд оролцсонгүй.  
Хөндлөнгөөс нь харахад тэрээр  
гадагш гарах гарцгүй өөрийн бяцхан  
ертөнцөд цоожтой оршдог

бололтой.

Коэн өчүүхэн төдий ч төвөгшөөлгүй  
бохирдсон хувин сав суулгатай  
зууралдан, модон шал зүлгэн,  
нүүрэндээ инээмсэглэл тодруулсаар  
цонх угаах Лараг анзаарч харвал  
харахаар байлаа.

-Та манайд удах уу? гэж бүсгүй нэг  
удаа ирсэн зочноос үг дуулахаар  
асуувал,

-Хараахан шийдээгүй байна. Ганц  
нэг долоо хоног ч юм уу эсвээс ганц  
хоёр сар ч болж магад.

Чарлз Коэн Ларагийн хувьд

тайлагдашгүй оньсого мэт байх ажээ. Тэрээр бусад амьдрагчидтай огтын адилгүй. Бүсгүй түүний эрхэлдэг ажлыг нь таахыг оролдон, уурхайчин, модчин яавч биш, худалдаачин бас бишээ. Сайн боловсролтой нь мэдрэгдэх Коэн бусад суугчдын дэргэд цагаан хон хэрээ болон үзэгдэхийг хүссэнгүй. Оройн хоолны дараа тэрээр хотдоо ганцхан тооцогддог зочид буудалд өрөө авахыг оролдсон боловч хүсэхэд хясах гэгчээр тэнд сул өрөө байсангүй. Лара бас мань эрийг ширээний ард суугаад юу ч идэхгүй шахам байхыг нь анзаарчээ.

Харин бүсгүйн асуултанд зовсон

байдалтай,

-Надад бага зэргийн жимс... эсвэл ногоо байхад болоо гэв.

-Дэглэм барьж байгаа юм уу?

-Тэгж хэлж болно. Би голдуу шашны дэг жаягтай хоол иддэг гэтэл Глэй-Бэйд ховор байдаг бололтой.

Маргааш өдөр нь Коэныг ширээнд суусаны хойт дээр Лара өмнө нь хонины шарсан хавиргатай таваг тавилаа. Зочин эр бүсгүй тийш гайхсан харцаар ширтэн гэмшсэн байдалтай,



-Уучлаарай, энэ надад хориотой. Би танд тайлбарласан гэж бодсонсон...

-Тийм ээ, би санаж байна. Хонины махыг сүм хийдийн мухлагаас авсан шүү дээ хэмээн Лара инээмсэглэв.

-Юу гэнээ ээ?

-Би Сиднейн сүм хийдийн мухлагаар зөндөө хайж явсан. Та идээч! Таны өрөөний хөлсөнд өглөөний цай, оройн хоолны үнэ орно шүү дээ. Маргааш бифштекс өгөмз.

Энэ өдрөөс хойш Чарлз Коэн Ларатай ганц ч үг солих завшааныг алдахаа байжээ. Залуу бүсгүйн хурц

ухаан, биеэ даасан, эргэцүүлэн бодох чадвар нь түүнийг эрхшээлдээ оруулжээ.

Богинохон хугацаа өнгөрсний дараа Коэн Глэй-Бэйд ирсэнийхээ нууцыг Ларад дэлгэжээ.

- "Континентал сэплайерс" компани намайг нааш нь явуулсан юм. Энэ компани улсыг тэр чигээр нь хамарсан худалдааны сүлжээ эрхэлдэг. Удирдлагууд танай энд шинэ дэлгүүр байгуулах боломж байгаа эсэхийг мэдээд ирнэ үү гэж надад даалгасан юм.

- Хөөх! Дэлгүүр барих нь уу? хэмээн

Лара уулга алдаад:

Түүнийг нөлөөтэй том хүн гэдгийг мэдээд байсан юмаа хэмээн бодов.

-Үгүй ээ. Барилгын ажлыг өөр бусад хүмүүс эрхэлнэ. Бид голдуу боломжийн барилгыг түрээслэдэг юм.

Лара өглөөний гурван цаг хүртэл нам унтаж байснаа гэнэт өндийн босоод суучихлаа. Цээжин дэх бяцхан зүрх нь галзуутайяа цохилно. Энэ чинь юу вэ? Зүүд үү? Үгүй! Тэгвэл юу вэ? Тархи нь хариу олохоор шаналж эхлэв.

Чарлз Коэнийг өглөөний.цайнд орж ирэхэд тэсэж ядсан бүсгүй, -Ноён Коэн миний санааны мухарт нэг аятайхан газар байна. -Юун газар вэ? гэх нь бүсгүй үг зочин эрийг гайхшруулсан бололтой.

-Ингэхэд та чинь өчигдөр хэлэхдээ...

-Өө, тэгэлгүй яахав! Тэгээд тэр газар чинь хаа байна?

Лара түүний асуултыг чихнийхээ хажуугаар өнгөрөөн,

-Эхлээд хэдэн юм асуухыг болгооно уу. Би газрын эзэн гэж бодъё. Хэрэв би газар дээрээ барилга бариад, тэр

нь танд таалагдвал та таван жилээр  
түрээслэхийг зөвшөөрөх үү? гэсэнд  
Чарлз толгой сэгсрэн,

-Лара та барилгын талаар ямар нэг  
ойлголттой юу? гэв.

-Би өөрөө барихгүй л дээ. Чадварлаг  
архитекторч хөлсөлж, дориун  
ажилтай барилгын фирм олно.

Коэн бүсгүйн тос шиг гялалзах тас  
хар нүднээс харц салгалгүй,

-Ойлголоо. Тэгэхээр энэ аятайхан  
газар чинь хаа байгаа юм бэ? гэв.

-Би одоохон үзүүлье. Таны сэтгэл

хангалуун байх болно. Үүнээс дөнгүүрийг эндээс олохгүй.

Маргааш өдөр нь Лара Чарлзыг Глэй-Бэйн төв рүү авч явлаа. Хотын амьдрал Мэйн стрит, Коммершиэл стридэд бөөгнөрөн төвлөрчээ. Уулзвараас тавиад метрийн зайд хэсэгхэн сул газар байх үзэгдэв. Коэн хоёр хоногийн өмнө чухамдаа яг энэ газрыг нарийвчлан үзсэн юмсанжээ.

-Миний танд ярьсан газар энэ дээ гэж Лара хэллээ.

Чарлз үнэлсэн харцаар газрыг ажиглаад,

-За яахав, хонгор минь, танд мэдрэмж байна гэдгийг хэлэхгүй байж чадахгүй нь. Үнэхээр муугүй газар байна шүү гэжээ.

Коэн зарим нэг лавлах баримтнаас уг талбай Шон Макаллистерийн мэдэлд байгаа болохыг хэдийнэ мэджээ. Компанийн удирдлагаас Чарлз ашигтай байрлалтай дэлгүүрийн газар олж, барьсан барилгыг нь урт хугацаагаар түрээслэнэ гэдгийг тохиролцоод ирэхийг даалгажээ.

Ханыг хэн босгох нь чухал биш, гагцхүү байгууламж компанийн шаардлагыг л хангасан байх ёстой.

Дэндүү насан бага балчир бүсгүй. За үгүй дээ. Ямар нэг мангуу... Тэгээд гүйцээ... "Би Сиднейн сүм хийдийн мұхлагаир зөндөө хайж явсан".

Тэрээр хатуу хүтүүг давах төрөлхийн тэвчээртэй заяагджээ.

-Хэрэв зээ би энэ газрыг худалдаж аваад, таны сэтгэлд нийцсэн барилга баривал та таван жилээр түрээслэх үү? хэмээн Лара сэтгэл догдлон асуув.

Коэн удтал дуугүй байсны эцэст,

-Гэрээг арван жилээр хийнэ гэж сунжруулан хэлжээ.



Лара үдээс хойш Макаллистертай уулзахаар явлаа. Өрөөний үүднийг нээн Лараг орж очтол банкны эзэн толгой өндийлгөөд түүнийг гайхан ширтэж,

-Лара, арай эрт байгаа юм биш үү? Өнөөдөр чинь гурав дахь шүү дээ.

-Мэднээ. Би танаас тусламж хүсэх гэсэн юм, эрхэм ээ.

Шон түүнээс харц салгасангүй. Чөтгөр ав гэж, нөгөө охин чинь боловсорч гуйцсэн жимс мэт насанд хүрсэн бүсгүй болсон юм биш үү.

Үгүй, гайхамшигтай эмэгтэй болжээ!  
Хөх цээжийг нь чавхайтал барьсан  
даавуун цамц, өндөр гоолиг биетэй  
Лара түүний хуял тачаалыг өөрийн  
эрхгүй хөөрөгдөнө.

-Суугаач, хүүхэлдэйхэн минь. Би  
чиний тусын тулд юу хийж чадахсан  
бол?

Сэтгэл нь догдолсон Лара хуялт  
эрийн дууны өнгө хэрхэн  
өөрчлөгдөхийг анзаарсангүй.

-Надад зээл хэрэгтэй байна.

Макаллистер ийм юм хэлнэ чинээ  
бодоогүй байв.

-Юу-у?

-Би танаас мөнгө зээлмээр байна.

-Татгалзаад байх шалтгаан алга. Гоё ганган хувцас өмсөх бодол төрсөн бол чамд баяртайгаар туслах... гэх банкны эзний дуунд хүлцэнгүй аяс илт тодорлоо.

-Би хоёр зуун мянган доллар авмаар байна.

Агшин зуурын төдийд банкны эзний шалиг инээмсэглэл нүүрнээс нь оргүй арчигдав.

-Даажигнаж байна уу. Чи?

-Үгүй ээ, эрхэм ээ гээд Лара ширээн дээгүүр ялимгүй урагш бөхийж, - Хотод барилга барьчихмаар нэг сул газар байна. Би түүнийг арван жилээр түрээслэхэд бэлэн байгаа нэг хүн олсон. Таны мөнгө эргэн төлөгдөх бүрэн баталгаатай гэлээ.

Макаллистер царайгаа барайлган,

-Газрын эзэнтэй, чи бас тохирчихсон уу? гэв.

-Чухам үүнийг ярих гээд сууж байна.

Шон түүний санааг тэр даруй ойлгосонгүй.

-Байз, байз. Тэр газрыг минийх гэж хэлэх гээд байх шив, аан?

-Тийм ээ, Энэ газар маань Мэйн-стрит, Коммершиэл стритын буландбий.

-Чи тэгээд миний газрыг худалдан авахаар, надаас мөнгө зээлэх гэж ирсэн хэрэг үү?

-Би лавласан, тэр газар хорин таван мянгаас хэтрэхгүй. Гучийг санал болгоё. Та арван мянган долларын хонжоо дээр нь барилгад зориулж надад өгөх хоёр зуун мянгаас хувь аваарай. Банкны эзэн толгой сэгсэрч,  
-Ямар ч баталгаагүйгээр хоёр зуун

мянган долларын зээл! Ёстой  
солиорол гэдэг чинь энэ байх!

Лара цээжээрээ ширээ тэгнэн  
хэвтэж,

-Баталгаа байна аа. Танд газар,  
барилгаас барцаа өгнө. Ингэхэд та  
юу ч алдахгүй гэлээ. Макаллистер  
хэсэг зуур бодолд автсанаа төдөлгүй  
түүний даравгар уруул дээгүүр  
инээмсэглэл бүжиглэж,

-Хараач Лара, чи гүйлгээ ухаантай  
юм. Гэвч би ийм зээлийн тухай  
захирлуудын зөвлөлд юу гэж  
тайлбарлах вэ?

-Танайд ямар ч захирлуудын зөвлөл байхгүй шүү дээ. Банкны эзний малигар нүүрэн дээр бүжиглээд байсан өнөөх инээмсэглэл нь арилан таталдан ярвайлаа.

-Тэр ч бас үнэн гээд түүний харц бүсгүйн цээжинд төмбийх дур татам бөмбөлөг дээр өөрийн эрхгүй уналаа.

-Эрхэм ээ? Та зөвшөөрвөл өөрийнхөө шийдвэрт харамсахгүй шүү. Танд амлая. Шон хатаж омголтсон уруулаа хэлнийхээ үзүүрээр шилэмдээд, -Чи аавтайгаа огт адилгүй юм гэлээ.

-Тийм ээ, эрхэм ээ гэж Лара батлахад, түүний тархинд: Огтхон ч адилгүй гэсэн бодол зурсхийн орж ирлээ.

-Чиний санал сонирхлыг минь татаж байна, боломжийн л санаа байна гээд үгээ олж ядан болгоомжтой хэлснээ,

-Ингэхэд тэр өгөөмөр түрээслэгч маань хэн гэгч вэ? гэв.

-Түүнийг Чарлз Коэн гэдэг юм. "Континентал сэпплайерс"-д ажилладаг хүн. -Худалдааны сүлжээний компани уу? -Тийм ээ.



Энэ удаад банкны эзний сонирхлыг үнэн сэтгэлээсээ татав бололтой. - Тэд нар уурхайчид, ойчдыг хэрэгцээтэй тоног төхөөрөмжөөр хангахын тулд манайд салбараа нээх санаатай байх шив. -Ийм бизнес эрсдэлгүй гэж Макаллистер бодоод хайхрамжгүйгаар,

-Чи түүнтэй хаа танилцаа вэ? гэж асуув.

-Тэр хөлсний байранд буудалласан юм.

-Ойлгомжтой. Ингэхэд байна шүү, Лара. Надад бодох хугацаа хэрэгтэй байна. Энэ тухай маргааш ярилцъя.

Тэсэн ядсан бүсгүй арай л гэж биеэ барив. -Баярлалаа, ноён Макаллистер. Та харамсахгүй.

-Магадгүй ээ гээд Шон хариуд ёжтой гэгч жуумалзжээ.

\* \* \*

Орой болохын алдад тэрбээр Коэнтэй танилцахаар тарчиг ядуу хөлсний байранд бараалхав,

-Тантай энд Глэй-Бэйд уулзаж байгаадаа тун их баяртай байна. Би банкны эзэн Шон Макаллистер байна. Таныг хөлсний байранд буусныг чинь дуулаад ирлээ. Миний

зочид буудалд илүү тохилог шүү.

-Тэнд сул өрөө байхгүй гэсэн юм  
Коэн тайлбарлавал,

-Тэгэлгүй яахав, таны хэн болохыг  
бид мэдээгүй шүү дээ.

-Тэгвэл би хэн байна вэ? хэмээн  
Чарлзыг аргагүй болтол нь асуув.

Макаллистер ивээл эрэн долдогнон  
инээмсэглэж,

-Ноён Коэн, муур хулгана болж  
тоглоод яахав. Манай суугчид, сонин  
сайхнаа хуваалцаж сурсан улс. Хэрэв  
би бүсгүйг зөв ойлгосон бол та

миний өмчийн газар дээр баригдах  
бололтой байшинг түрээслэхэд  
бэлэн байгаа гэнэ.

-Юун өмчийн газар билээ?

-Мэйн, Коммершиэл стритийн  
буланд байгаа газар. Дажгүй  
байрлалтай байгаа биз, тийм үү?  
Миний бодлоор, бид хэлэлцээр  
байгуулахад тийм ч их төвөг удахгүй.

-Танаас урьтжээ. Аль хэдийнэ  
хийгдсэн.

Макаллистер инээд алдан,

-Ларатай юу? Хорхой хүрмээр

хошигнол байна, тийм ээ? Банк руу хамт явж гэрээгээ байгуулах үү?

-Эрхэм Макаллистер, та намайг ойлгоогүй юм болов уу гэхээс айж байна. Гэрээ хийгдсэн.

-Харин та намайг ойлгосонгүй, ноён Коэн. Газар Ларагийнх биш, минийх.

-Гэвч бүсгүй танаас худалдаж авах санаатай байгаа гэсэн биш үү?

-Тэр ч тийм л дээ. Гэсэн ч юу ч намайг чухамдаа түүнд газраа худалдахыг албадахгүй.

-Тэгвэл үүнтэй яг адил, өөрийн

сонголтоо таны газраар  
хязгаарлахыг юу ч надад албадахгүй.  
Хотод үүнээс доргүй өөр газар бий.  
Тантай танилцахад таатай байлаа.

Банкны эзэн эрхэм тэвдэн,

-Та...үнэхээр үү?

-Чин үнэн. Би зөвхөн бурханд үнэн  
шүтлэгтэй байдаг шигээ адил  
шударга хэлэлцээр л хийдэг. Тэгээд  
хэзээ ч хэлсэн амнаасаа  
буцаж үзээгүй.

-Гэтэл Лара барилгын тухай "А" ч  
үгүй шүү дээ! Тэр... -Тэр  
мэргэжилтнүүдийг олж чадна.

Барилгын ажлын явцыг манай компани хянах болно. Макаллистер эргэлзэн, -Миний ойлгосноор "Континентал сэпплайерс" барилгыг арван жилээр түрээслэх бодолтой байгаа гэв үү?

-Яг тийм.

-За, за. Тэгэхээр энэ тухайд... би бодох хэрэгтэй. \* \* \*

Шөнө орой болсон хойно Чарлз Ларатай хонгилд тааралдан банкны эзэнтэй ярилцсан тухайгаа түүнд дуулгав.

Энэ мэдээ бүсгүйн урмыг хугалжээ.

-Тэгэхээр эрхэм Макаллистер өөрөө өрөм таргаа хураахаар шийдээ шив.

-Лара, санаа бүү зов. Та түүнтэй гэрээ байгуулна.

-Нээрэн үү?

-Тэр санхүүч хүн учраас ашгаа алдахыг хүсэхгүй.

-Та ч гэсэн адил биз дээ? Та яагаад надад ийм их ивээнгүй хандсан юм бэ?

-Догь асуулт байна. Чиний залуу нас. Энд, Глэй-Бэйд чиний байх газар бишээ. Би ийм охинтой болохсон



гэж Коэн бодов. Тэрээр мэдээж үүнд юу ч хариулсангүй.

-Лара би ямар нэг юм алдана гэж үү? Хэд хэдэн боломжийн газар нүдэнд минь туссан. Хэрэв чи Макаллистерын газрыг нь худалдаж авч чадах л юм бол, би дуртайяа чиний талд байх болно. Миний хэнтэй тохирох нь компанид огг хамаагүй хэрэг. Зээлээ аваад, барилгачидаа олчиход бид бизнестээ орчихлоо гэсэн үг.

Лара юу юугүй далавч урган, хөл нь хөнгөрөөд ирэхийг мэдэрлээ.

- Надад... танд хэрхэн талархахаа

мэдэхгүй нь. Макаллистер руу  
гүйлээ, тэгээд...

-Таны оронд байсан бол би ингэхгүй  
л байсан даа гээд Коэн долоовор  
хуруугаа гозойлгон сэрэмжлүүлээд,

- Тэр өөрөө тан дээр ирвэл сайнсан  
гэжээ.

- Тэр гэнэт... хэмээн Лара сандран  
эхэлтэл,

- Ирнээ, ирнэ гэснээ Чарлз түүнд  
машинаар цохисон бичиг сунган,

-Энэ бол түрээсийн гэрээ. Хугацаа  
арван жил. Манай бүх шаардлага

гүйцэтгэнэ гэсэн болзолтой хэмээн ойлгож болно. Энд байгууламжийн бүхий л хэсгүүдийг үзүүлсэн байгаа гээд цүнхнээсээ зураг бүхий хуйлаастай калькан цаас гаргаж ирлээ.

Лара шөнөжингөө зургийг эргүүлж тойруулан өнгөрөөжээ. Өглөө эрт Макаллистер утасдан,

-Лара, чи банкин дээр хүрээд ирж чадах уу? гэлээ.

Бүсгүйн зүрх нь түг түг цохилон,

-Арван таван минутын дараа очлоо гэв.

Түүнийг хүлээж байсан банкны эзэн,

-Бидний ярианы тухай би бодож үзлээ. Ноён Коэны гэрээг ядаж нэг нүднийхээ булангаар ч гэхнээ харахсан гэвэл,

-Би аваад ирсэн гээд Лара цүнхнээсээ нямбайлан эвхсэн хуудас цаас гаргаж ирэв.

Макаллистер гэрээний зүйл тус бүрийг өө эрэн няпглаад,

-Гэрээнд бүгдийг нь тусгажээ гэхэд нь,

-Тэгвэл тохирох шив? гээд Лара

санаа алдвал Шон Макаллистер  
толгой сэгсэрч,

-Үгүй гэв.

-Гэхдээ надад...

Банкны эзний бүдүүн хуруунууд  
ширээ бөмбөрдөж эхэлснээ,

-Лара, үнэнийг хэлэхэд надад газраа  
зарчих гойд хэрэгцээ алга. Жил ирэх  
тутам улам үнэ хүрэх болно гэхэд нь,

-Та чинь... гэх бүсгүй золтой л  
уйлчихсангүй.

-Би анх удаа ийм хүсэлттэй тулгарч

байгаа маань энэ шүү дээ. Чамд ч гэсэн туршлага алга, тиймээс үүнийг бүтээхэд чамбай нэгэн шалтгаан хэрэгтэй.

-Ойлгосонгүй... Юун шалтгаан билээ?

-Үүнийг... бяцхан шагнал гэж нэрлэе. Эсвэл урамшуулал ч гэх юм уу, хүссэнээрээ л бол доо. Лара, надад үнэнээ хэлээч, чамд хэзээ ч юм найз хархүү байсан уу? гэх түүний асуулт бүсгүйн гайхашийг тасартал сандаргав.

-Би... байхгүй. Энэ юунд... гэснээ хэлэлцээ биелэхэд ганц хуруу дутуу бүх юм өөрийн нь гарт байгааг

мэдэрчээ.

Макаллистер элгээрээ ширээ тэгнэн,

-Хонгор минь, илэн далангүй байгааг минь өршөөгөөрэй. Би чиний үзэсгэлэн гоод сэтгэл татагдаад байна. Өврийг минь мялайх юм биш үү? Ачийг ачаар гэдэг. Энэ чинь...

-Энэ юу гэсэн үг болохыг би мэднэ гээд Ларагийн царай хөрзийлөө.

-Асуудлыг нөгөө талаас нь авч үзье л дээ. Чамд өөр хүн болох боломж бий болоод байна. Чи газрын эзэн болж болно. Чи эцэгтэйгээ огт адилгүй гэдгээ өөртөө баталж чадах

болно. Ларагийн тархи тэчъядан ажиллана.

-Ийм азтай тохиолдол олдохгүй шүү. Магадгүй, чи эргэцүүлэн бодох...

-Үгүй. Хэрэггүй. Би хариулахад бэлэн биш байна гэх түүний дуу хүйтэн, хоосон цуурайтах мэт санагдав.

Лара биеийнхээ дагжин чичрэхийг болиулахаар гуян завсраа гараа шургуулан хавчлаа. Яг одоо түүний амнаас унах хэдэн үгнээс түүний ирээдүй шалтгаална. Бас түүний амьдрал.

-Зөвшөөрч байна. Би тантай унтанаа.



Шон сэтгэл хангалуун жуумагнан  
өндийн босоод богинохон гараа  
урагш сунгахад нь,

-Одоо, энд бишээ. Эхлээд гэрээгээ  
үсэглэчихье гэж бүсгүй ширүүхэн  
хэлжээ..

Маргааш нь банкны эзэн түүнд  
зээлийн тухай банкны гэрээг  
гардуулав.

-Хонгор минь, энд төвөгтэй асуудал  
юу ч алга. Арван жилийн хугацаатай  
хоёр зуун мянган доллар, жилийн  
найман хувийн хүүтэй.

-Энд нэрээ бичээд гарын үсгээ

зурчих гээд Макаллистер түүнд үзгээ өгөв.

-Хэрэв та татгалзахгүй бол би ямар ч гэсэн уншиж танилцмаар байна гээд Лара цагаа хяламхийн харснаа,

-Яг одоо амжихгүй л болов уу. Би аваад явж болох уу? Гэрээ маргааш гэхэд таны ширээн дээр байна гэв. - Тааллаараа л бол, хонгор минь. Бидний болзооны тухай бүү мартаарай. Ирэх бямбад би Галифакс орно. Чамайг зугаалахаас татгалзахгүй гэж бодож байна.

Ноён Макаллистерын чихсэн хошног шиг үрчийсэн уруул өөрийн

эрхгүй Ларагийн огиудасыг хүргэв.

-Тэгье гэж тэрээр дуулдах төдий хэллээ.

-Сайн байна. Гарын үсгээ зураад, аваад ир, тэгээд бид ажилдаа орно гээд Шон Макаллистер агшин зуур бодолд автсанаа, -Чамд туршлагатай гүйцэтгэгч хэрэгтэй байх даа.

Барилгын компанийн талаар ямар нэг сураг ажиг гаргасан уу? Базз Стилийн бригадынхныг мэдэх үү? Ларагийн царай ялимгүй туяарав.

-Би Базз Стилийн бригадынхныг мэднэ.

Эрхэм Базз Стилийн удирдсан бригадынхны гараар босгосон томоохон барилга Глэй-Бэйд хэд хэд бий билээ. -Тун сайн. Бүрэн итгэлтэй залуус гэж зөвлөх байна. -Тэгвэл би маргааш Баззтай ярилцана.

\* \* \*

Тэр оройдоо Лара Чарлз Коэнд гэрээгээ үзүүлсэн авч ичсэндээ түүнд үсэглэхээр тохиролцсон Шоны болзлыг хэлж зүрхэлсэнгүй. Коэн гэрээг анхааралтай уншаад бүсгүйд эргүүлэн өглөө.

-Таны оронд байсан бол би наана чинь өөрийн нэрээ тавихгүй юм

байна.

-Яагаад? гэж Лара илт айсан янзтай асуув.

-Гэрээнд таныг 12 сарын 31 нд дуусгах үүрэг хүлээлгэсэн зүйл оруулсан байна. Үүнийг зөрчсөн тохиолдолд барилга банкны өмч болно гэсэн нь өөрөөр хэлбэл, тэр Макаллистерын мэдэлд очиж, манай компани дэлгүүрийн түрээсийг түүнтэй хийхээс аргагүй болно. Ойлгож байна уу? Гэрээ цуцлагдаж, харин та урьдын адил Макаллистерын зээлийн хүү төлсөөр байх болно. Энэ зүйлийг хасахыг шаард.

Ларагийн чихэнд: Үнэнийг хэлэхэд  
надад газраа зарчих гойд хэрэгцээ  
алга. Жил ирэх тутам улам үнэ хүрэх  
болно хэмээх банкны эзний үг  
хангинав. Бүсгүй толгой сэгсэрч,

-Шон хэзээ ч зөвшөөрөхгүй ээ гэсэнд,

-Лара, дэндүү их эрсдэлтэй байна. Та  
хүүг эс тооцвол хоёр зуун мянган  
долларын зээлтэй хоосон гуяа  
ганзагалаад үлдэх болно.

-Гэхдээ би амжвал...

-Хэрэв... барилга эхэлмэгц та өөрийн  
мэдэлгүй маш олон хүнээс  
хамааралтай болно. Урьдаас тааж

мэдэхийн аргагүй хичнээн асуудал танд тулгарахыг Бурхан л ганцхан мэдэх байх.

-Сиднед олон арван байшин барьсан барилгын сайн фирм бий. Би бригадын ахлагчийг нь танина. Түүний хүмүүс товлосон цагт нь багтаадаг гэсэн, тэгэхээр үзээд алдахаас.

Бүсгүй нүд нь Коэныг тээнэгэлзлээ таягдан хаятал итгэлтэйгээр гялалзаж байжээ.

-О'кэй. Бригадын даргатай ярилц гэж тэрээр эцэст нь хэлэв.

Лара Базз Стилийг Сиднед таван давхар байшин барьж буй газраас нь олж уулзав.

Дөч эргэм насны борлосон царайтай, бригадын дарга эр түүнийг нүүр дүүрэн инээмсэглэн угтав.

-Хөөх, ёстой нэг гэнэтийн бэлэг байх шив! Үзэсгэлэнт бүсгүй минь, гаэрын хаанаас гараад ирэв ээ?

-Ноён Стил, тантай уулзах чухал хэрэг байна. Танд ажил санал болгох гэсэн ЮМ.



Бригадын дарга бүр ч дарвайтлаа  
инээд алдан,

-Өө тийм үү? Юу бариулах нь вэ?  
Хүүхэлдэйн байшин уу? гэлээ.

-Үгүй гээд Лара цүнхнээсээ Коэны  
өгсөн зургийг гаргаж ирэн,

-Май, төсөл зургийг үз гэв.

Стил калькин цааснуудыг нүд гүйлгэн  
харснаа гайхсандаа хүнгэнэн,

-Овоо ажил байна. Гэвч энэ чамд  
ямар хамаа байна, Лара? гэлээ.

-Энэ гэрээг би байгуулсан юм.

Барилга минийх болно гэх бүсгүйн дуунд үл далдлах омог бардам өнгө сонсдов.

Бригадын дарга исгэрэв.

-Үгүй яах вэ, баяр хүргэе!

-Гэвч хоёр нөхцөл бий.

-Хэлээч.

-Нэгд: Барилга 12 сарын 31 нд дууссан байх ёстой. Хоёрт: Нийт зардал нэг зуун далан мянган доллараас хэтрэхгүй байх ёстой, хийх үү?

Стил дахиад л зураг руу тонгойлоо.  
Түүний уруул үл мэдэг хөдлөхийг  
харсан Лара Базз цээж тооцоо  
хийгээд завгүй байгааг нь ойлголоо.

-Бардаагаар болмоор юм гэж бодож  
байна хэмээн бригадын дарга удтал  
чимээгүй байсны эцэст нь хэллээ.

-Тэгвэл тохирох уу? гэх Лара  
баярласандаа золтой л дуу алдан  
хашгирчихсангүй.

Хэн хэнийх нь санаанд нийцэн  
хөөрсөн Лара, Стил хоёр баярласнаа  
илэрхийлцгээн падхийтэл алга  
нийлүүлэн цохицгоолоо.

-Урьд өмнө нь ийм гуа үзэсглэнтэй-  
эмэгтэй босстой учирч яваагүй  
юмсан гээд Стил инээд алдав.

-Баярлалаа. Та хэзээ эхэлж чадах вэ?

-За тэгэхээр ингэнээ хөө. Би маргааш  
Глэй-Бэй орж газрыг чинь үзье. Охин  
минь, санаа бүү зов, чи жинхэнэ  
харш гардаж авах болно!

Лара аз жаргалдаа умбан хөл нь  
газар хүрэхээ байлаа.

\* \* \*

Бүсгүй хөлсний байрандаа эргэж  
ирмэгцээ л шинэ мэдээгээ Коэнтэй

хуваалцав.

-Энэ фирм ажлыг чинь хөөдөхгүй гэдэгт чи найдаж байна уу, Лара?

-Би тэднийг сайн мэднэ. Тэд энд, Сиднед, Галифаксад олон барилга... гэх бүсгүй илт урам орсон аж.

Чарлз инээмсэглэн,

-Сайн байна. Бид ч бизнестээ орох болжээ, аан? гэв.

-Өөр яахав!

Ноён Шон Макаллистертэй учрах болзоогоо санамагц түүний хөөрсөн

сэтгэл хийсэн алга боллоо. Ирэх бямбад би Галифакс орно. Чамайг зугаалахаас татгалзахгүй гэж бодож байна.

Хагас сайн хүртэл хоёр хоног үлджээ.

\* \* \*

Маргааш өглөө нь гэрээнд гарын үсэг зурлаа. Шон Макаллистер Ларагийн араас тачаангуй хүсэл бах нь ханасан янзтай шүлэнгэтэн ширтэх ажээ. Банкны эзэн эр барилга түүнийх болно гэдэгт өчүүхэн ч эргэлзсэнгүй. Ээ дээ, богино жолоотой гэнэн хонгор хүүхэн минь хэмээн бодоод

тачигнатал хөхрөв. Ларад зээл өгөх үү? Тийм ээ, энэ чинь өөртөө л зээл өгч байгаа гэсэн үг биз! Бүсгүйн торго шиг булбарай арьсыг таалан эдлэх жаргалаа урьдаас бахдан бодох Шоны сэрэл нь хөдлөн, эд нь гандайтал босон хатуурчээ.

Лара хоёр ч удаа Галифаксад очиж байсан. Глэй-Бэйтэй харьцуулахад гудамжнаа хөлхөх явган зорчигчид, нааш цааш сүлжих машинууд, дэлгүүрийн гялалзсан шилэн лангуунуудыг хараад үүнээс цаадахыг үзээгүй гэнэн бүсгүйд энэ хотыг орчлон ертөнцийн төв гэмээр санагдах ажээ.

Шон Макаллистер хотын тэг доторх жижигхэн дэн буудал руу эргэн, хоосон шахуу машины зогсоол дээр ирмэгцээ махлаг гараараа Ларагийн евдгийг эелдэгээр илээд,

-Намайг бүртгүүлтэл эндээ хүлээж бай, хонгор минь гэв.

Бүсгүй мэгдэн сандарлаа. "Би чинь юу хийж байна? Би чинь ёстой нэг больж гүйцсэн янхан шиг биеэ худалдаж байх шив! Гэтэл надад төрсөн биенээс минь өөр зарчих юм алга биш үү! Мань эр намайг хоёр зуун мянган долларын үнэтэй гэж бодож байгаа биз. Эцэг маань амьдралдаа ийм мөнгө барих нь бүү



хэл үзээ ч үгүй. Тэр даанч...

Макаллистерийн тагдгар дүрс  
сүүтэгнэж үзэгдэв.

-Хөөрхий минь, уйдав уу? Явцгаая!

Гэнэт хоолой нь зангиран  
амьсгалахад хэцүү боллоо. Зүрх нь  
хормын дараа гэхэд хэнхдэгнийхээ  
ясаа нэвтлэн бүлт үсрэн гараад ирэх  
нь үү гэлтэй галзуутай цохилоно.  
Аавтай адилхан зүрхний дайрлага  
бүү учраасай билээ хэмээн Лара  
бодлоо.

-Хөөе охион. Чи зүгээр үү? гэх Шоны  
түгшин сандрах дуу сонсдов.

Үгүй, Би үхэх нь. Намайг э.мнэлэгт  
аваачаач тэнд дээр байх. Би чинь  
эхээс төрсөн охин биеэрээ байгаа  
шүү дээ!

-Зүв зүгээр.

Лара арайхийн хүчээ шавхан  
машинаас буун, цаазын тавцан тийш  
явж буй мэт Макаллистерын араас  
толгой гудайлган алгуурхан явсаар  
банзан хана, тартаггаа тултал  
хуучирсан ор, хоёр сандал, ширээ  
тавьсан өрөөнд орлоо. Өрөөний  
буланд наамал банзан хаалганы  
цаана шүршүүр бүхий угаалгын өрөө  
байх ажээ.

Аймшиг гэгч тамын оронд л байдаг бололтой. -Тэгэхээр, чи юм үзээгүй байх нь ээ? гэж Шон нэгэн хэмийн дуугаар хүнгэнүүлэн лавлав.

Хичээлийн завсарлаганаар хөвгүүд түүнийг тэврэхийг оролдож, зарим нэг бүдүүлэг нь салтаа руу гараа шургуулахыг оролдож байсан нь санаанд орж ирэв.

-Тийм ээ, Хамгийн гол нь бүү сандар. Жам ёсны сексээс илүү зугаа цэнгэлийг хүн төрөлхтөн бодож олоогүй байгаа шүү.

Лара Макаллистерын хувцсаа тайчиж эхлэхийг хайхрамжгүй харан зогсоно. Түүний бие нь шалхайж

үлбийн үрчийжээ.

-Хувцсаа тайлаач! гэх тушаал  
ташуураар шавхуурдах мэт сонсдов.

Лара сааталд орсон хашин  
хөдөлгөөнөөр цамц, юбка, туфлиэ  
тайллаа. Түүний нүцгэн биеийг нь  
дотоож, хөхөвчнөөс өөр халхлах юм  
үлдсэнгүй.

Шон бүсгүйн өгзөг, хөхийг шалиг  
нүдээр ширтэж,

-Ээ Дарь эх минь! Чи үзэсгэлэнтэй  
юм! Чи үүнийгээ мэдэх үү?гэлээ.

Хэвлийн доод хэсгээр ямар нэгэн

хатуу юм хатгахыг Лара мэдэрчээ.  
Макаллистер нойтон уруулаараа  
түүний амнаас зуурав. Лара золтой л  
огиулчихсангүй.

-Энэ новшийн даавууны тасархайг  
чинь чөтгөр аваг! Тайл наадхаа!

Шон ор руу дөхөж очин, бүтээлгийг  
хуу татан чулуудаад дотоожоо  
тайлав. Түүний час улаан, сүрдмээр  
том эрхтэн нь түрэмгий гэгч нь  
харагдана.

Бурхан минь, энэ эрдэнэ шиш-надад  
багтахгүй, Би үхэх нь ээ гэж Лара  
бодлоо.

-За алив, хурдал, хурдлаач! Бүсгүй хөхөвчөө тайлан, дотоожоо аажим тайлан шалдлав.

-Ээ буян заяа минь! Энэ чинь үлгэр домог уу? Алив нааш ирээч!

Лара алхам ухран орон дээр суув. Шар сэмжилсэн хөгшин төгцөг балцгар бахим гараараа хөхийг нь базан тачаадахад бүсгүй өвдсөндөө хашгирмаар санагджээ.

-Эр хүн гэж юу байдгийг үзэх цаг чинь болсон! хэмээн Макаллистер шүдэн завсраар исгэчүүлэн хэлээд Лараг тааз харуулан хэвтүүлээд бүсгүйн хөлийг өвдгөөрөө алцайлган

ТЭЛЭВ.

Бүсгүй гэнэт санан,

-Надад юу ч байхгүй. Би... би  
жирэмсэн болчихож магад! гэвэл  
Шон,

-Бүү ай, муужгайхан минь. Гадуур нь  
тавина гэлээ.

Дараагийн агшинд Лара айдаст  
автлаа.

-Болиоч! Хүлээгээч! Би...

Гэвч Шон хүлээхийг завдсангүй.  
Тэсэхийн эцэсгүй өвдөлт мэдрэгдэж,

өнөөх эрдэнэ шиш мэт лужир том эд  
огцом огцом нудчисаар онгон  
биеийг нь тасар татан шуналтайяа  
гэгч улам гүн шурган орлоо. Лара  
ёолж орилохгүй гэхдээ алгаа хазан:  
Энэ эрүү шүүлт минутын дараа гэхэд  
дуусч, би гоёмсог барилгын эзэгтэй  
болж, дараа нь хоёр дахийг...  
гуравдахийг барина даа.

Эрүү шүүлт үргэлжилсээр,

-Бөгсөө! Бөгсөөрөө хөдлөөч! Алив  
хөдөлж үз! Битгий хөлдүү дүнз шиг  
хэвтээд бай! гэж Макаллистер  
зандран тушаав.

Бүсгүй шалиг эрийн тушаалыг



биелүүлэх гэсэн боловч өвдсөндөө  
нүд нь ч хөдөлж чадахаа байлаа.

Гэнэт хоршоо эр азарга унгалдах мэт  
янцаглан байснаа сэтгэл нь уужрав  
бололтой түүний бие нь сулдайн  
шүүрс алдсанаа гараа алдлан тарайн  
хэвтэв. Лара сандран,

-Чи гадуур нь тавина гээ биз дээ!  
гэсэнд,

Макаллистер тохой дээрээ тулан  
толгой өндийлгөөд,

-Хонгор минь өршөөгөөрэй. Чинийх  
мөн ч амттай байна шүү! Амжсангүй  
ээ. Айдас хүйдсээ март.

Жирэмсэлбэл-эмч олчихно, тэр  
бүгдийг цэвэрлээд өгчихнө гэлээ.

Лара жигшин ярвайсан царайгаа  
түүнд харуулахгүй нүүр буруулан,  
хөлсөндөө хутгалдсан эр гахайн  
дороос арай чамай сугаран гарч  
шүршүүр рүү хазганасаар явж очив.  
Зүү мэт хурц усны урсгал шинэхэн  
мэдрэмжийг төрүүлэн, бүсгүй  
толгойгоо бахдалтайяа гэдийлгэн  
хамаг биеэ үрэн бузар эрийн хир  
хөлсийг угаалаа. Бурхны минь аврал  
гэж, бүх юм ард хоцорлоо.  
Тэсвэрлэж, давж гарлаа. Газар  
минийх! Одоо эд баялагаа алга  
тосон хүлээх л үлдлээ.

Үгүй, яарах хэрэггүй. Одоо  
хувцаслаад Глэй-Бэй руу буцаж  
очин, барилгын ажлын эхлэлийг  
хянах хэрэгтэй. Лараг өрөөнд орж  
ирэхэд Макаллистер,

-Давгүй байлаа шүү. Дахин амтлах  
хэрэгтэй гэв.

## Зургаадугаар бүлэг.

Чарлз Коэн барилгын фирмийн Глэй-Бэйд барьсан таван барилгыг биечлэн шалгаад,

-Ажлын чанар нь шаг хийсэн юм байна. Та нарын дунд ямар нэг асуудал үүснэ гэж бодохгүй байна хэмээн Ларад хэлжээ.

Хоёр хоногийн дараа Лара, Коэн, Базз Стил нар газрыг үзэхээр цуглажээ.

-Үүнээс дээр газар олдохгүй. Хэмжээнээс нь үзвэл Лара чи хорин мянган квадрат фут ашигтай

талбайтай болох юм байна.

-Та 12 сарын 31 гэхэд барилгыг дуусгаж чадах уу? хэмээн Коэн лавлав.

-Түүнээс өмнө ч амжина. Барилга Зул сарын өмнө дуусчихна.

-Хэзээ эхлэх вэ? гэж Лара сонирхов.

-Ирэх долоо хоногийн дундуур миний хүмүүс наашаа ирнэ.

\* \* \*

Барилгачдын тасралтгүй жигд ажиллахыг анзаарсан Лара ихэд

бахархжээ.

-Би өөрөө бүгдийн учрыг ойлгож авах ёстой. Энэ миний ажлын охь манлай. Эхний барилгын араас бусад нь хэдэн зуун барилга сүндэрлэх болно.

Ингэхэд энэ бүсгүй чухам юутай орооцолдсоноо мэдэж байгаа эсэх нь тун сонин байна гэж Чарлз дотроо бодсон аж.

Хамгийн урьдаар газрын хэлбэр судлаачид хүрч ирэн талбайн албан ёсны хэмжээг тогтоон булан бүрд нь тод өнгөтэй гадас шаалаа. Үүнийг хийх гэж хоёр өдөр болжээ.

Дараа өглөө нь эртлэн Базз Стил газар ухах аварга том бульдозер авчирлаа.

Түүнийг харан гайхсан Лара,

-Одоо яах гэж байгаа юм бэ? хэмээн асуув.

-Үндэснээс нь салган, хөрсийг нь хуулж газрыг тэгшилнэ.

Бульдозерын араас барилгын суурь, шуудууны хоолой тавих нүх ухах эксковатор орж ирлээ.

Энэ мэдээ аль хэдийнэ хөлсний байрны суугчдийн чихийг дэлсчээ.

Ширээний ард өрнөдөг ярианы гол сэдэв нь барилга болж, суугчид шинэ мэдээ бүрийг илэн далангүй шүүн хэлэлцэх болжээ.

-За алив, илтгээд байгаарай хэмээн тэд өглөөний цайнд орж ирүүт Ларагаас шаардацгаана.

-Өнөөдөр усны түгээгүүрийн хоолойг тавиад, маргааш суурийг нь цутгана. Дараа нь гагнуурчид төмөр баганыг босгоно хэмээн тайлбарлах нь бүсгүй өөрийгөө хэзээ язааны мэргэжилтэн мэт санах ажээ.

Дараагийн шат нь зуурмаг цутгах ажил байсан агаад зуурмагийг



хатмагц барилгын талбайд машин  
машинаар мод буулгаж, мужаан  
харчуул давцан, дамнуур хийх  
ажилд ханцуй шамлан орцгоов.  
Тэдний алх, хадаасны дуу  
тэсвэрлэхийн аргагүй тан ян хийх  
боловч энэ нь Ларагийн чихэнд  
ялалтын симфони эгшиглэх мэт  
сонсогдоно. Хоёр долоо хоногийн  
дараа барилгын суурин дээр хаалга.  
цонх суулгах онгорхой бүхий модон  
хананцар сүндэрлэв. Энэхүү барилга  
ид шидээр буугаад ирэв үү гэлтэй  
нүд ирмэхийн зуур босчээ.

Хавь ойроор өнгөрөх зорчигчид  
барайж сэртийсэн тавцан, төмөр  
багануудыг хайхрамжгүй харан,

Лара ч гэсэн Баззын амласан нөгөөх орд харш нь мөн эсэхэд итгэл муутайхан ширтэх ажээ. Түүний зүүд биелэх нь гарцаагүй. Лара өдөр болгон өглөө оройдoo барилга дээр хүрч ирээд:

"Энэ бүхэн-минийх" гэсэн цорын ганц бодолд автана.

Галифакс яваад ирснээс хойш амар заяаг нь үзүүлэхээ байсан арай жирэмсэлчихээгүй байгаа гэсэн бодлоос болон хамаг бие нь дагжин чичирч байсан бол сарын юм нь ирж удтал шаналсан сэтгэл нь арай гэж нэг юм уужирчээ.

Одоо надад барилгаас өөр бодох юм алга.

Хаа нэгтээ толгой хоргодох хэрэгтэй байсан тул Лара урьдын адил суугчдынхаа хөлсийг цуглуулан, Шонтой уулзах бүрийдээ ёстой нэг тамын ял эдлэх болжээ.

-Бид цагийг сайхан өнгөрөөсөн шүү, хонгор минь. Яагаад үргэлжлүүлж болохгүй байх вэ? гэж Шоны шалиглахад,

-Би барилга дээр их завгүй байна хэмээн бүсгүй түс тас хариулдаг байв.

Ажлын явц ч улам тургэсэн эхний өдрийг бодвол талбай дээр гурван ч удаа машин машинаар материал буулгаж эхлэн Баззын хүмүүс ч ажлаа чадмаг гэгч нь гүйцэтгэнэ.

Чарлз Коэн буцсан боловч долоо хоногтоо заавал ч үгүй Ларатай утсаар ярьж байлаа.

-Ажил ямаршуу явж байна?

-Гайхалтай!

-Ямар ч сааталгүй юу? Хожигдохгүй биз?

-Бид хэдийнэ хуваараа товлосон.

-Таны өмнөөс тун их баярлаж байна.  
Бүх юм ингэж өө сэвгүй байх юм  
гэдэгт би итгэхгүй байснаа хүлээе.

-Та надад боломж өгсөн шүү, Чарлз.  
Баярлалаа! -Сайн санааны үзүүрт  
шар тос гэдэг байхаа, Лара. Хэрэв та  
байгаагүй бол би өлдөж үхэх байсан  
шүү.

Шон Макаллистер мэр сэр барилгын  
талбайгаар үзэгдэнэ. -Давшингүй  
яваа нь алган дээр байгаа юм шиг  
үзэгдэж байна шүү,

Лара?

-Тийм ээ!

Банкны эзэн сэтгэл хангалуун буй нь илт. Гялайсан юм болж байна, Харин ноён Коэн түүний талаар андуу боджээ. Макаллистер яагаад ч намайг хуурахыг оролдохгүй.

\* \* \*

Арван нэгэн сарын сүүлч ирэхэд барилга хугацаандаа дуусах нь илт боллоо. Бетон хананы дундуур дотор хануудыг босгон онгойн харлаж байсан нүхнүүд цонх хаалга болон өөрчлөгдөж, цахилгааны шугам мэтийн аар саар зүйл л хийгдээгүй дутуу үлдээд байв.

Арван хоёр сарын гуравны даваа

гаригт энд тэндгүй оргилон буцалж байсан ажил нь гэнэт зогсчээ.

Дадсан зангаараа өглөө эрт Лараг иртэл барилга дээр нэг их төвөгшөөсөн янзгүй хоёрхон хүн ёрдойн ажиллана.

-Бусад нь хаачаа вэ? гэж Лара гайхан асуув.

-Тэднийг шинэ объект руу явуулсан. Маргааш гэхэд ирцгээнэ гэж нямбай гэгч өмссөн ажлын хувцастай залуу хариулав.

Маргааш өдөр нь талбай бүр ч хов хоосон боллоо.

Лара Баззтай уулзахаар автобусаар  
Галифакс хүрч очив.

-Юу болоод байна? Хүмүүс хаана  
байна?

-Тайвширч үзээ, Лара. Бидэнд бага  
зэрэг ажил гараад, түр саатах  
хэрэгтэй болчихлоо.

-Хэдий хугацаагаар тэр вэ?

-Долоо хоногийн дараа очимз.  
Санаа бүү зов, бид хожимдохгүй.

-Базз аа, барилга миний хувьд ямар  
учир утгатай болохыг чи мэднэ шүү  
дээ.



-Мэдэлгүй яахав, Лара минь.

-Хэрэв бид хугацаандаа дуусгахгүй бол, барилга бусдын гарт орж би бүгдийг алдана.

-Тайвширч үз гэж хэлээд байна шүү дээ. Ийм юм болохгүй.

Буцах замд нь Лараг түгших сэтгэл зовоожээ. Долоо хоног енгөрсөн хэдий ч юу ч өөрчлөгдсөнгүй. Мэгдэж сандарсан Лара дахиад Галифакс руу явлаа.

-Өршөөгөөрэй, ноён Стил байхгүй хэмээн фирмийн нарийн бичгийн дарга түүнд дуулгав.

-Яаралтай хэргээр түүнтэй уулзмаар байна. Хэзээ уулзаж болох вэ?

-Ноён Стил хотод байхгүй байгаа. Хэзээ ирэхийгээ ч надад хэлээгүй.

Ларагийн аюулхай дээр айдас хуран хоолой нь горойлоо.

-Базз Стил надад барилга барьж өгч байгаа юм. Гурван долоо хоногийн дараа ажил дуусах ёстой юмсан.

-Камерон авхай. Таны оронд байсан бол би огтхон ч зовохгүй. Ноён Стил амласан л бол хэлсэндээ хүрдэг хүн.

-Бүх ажил зогсчихлоо шүү дээ!

-Та бригадын даргын туслах  
Эриксентэй ярилцаад үзэхгүй юу?

-Тэгье.

Эриксен гэгч нь нүсэр том бие, бодь  
сэтгэлтэй норвег эр байлаа. Тэрээр  
туйлын тайван, итгэл төгс дуугаар,

-Таны асуудлыг ойлгож байна,  
Камерон авхай, гэхдээ Базз энэ  
тухай мартаагүй гэж дамжуулахыг  
хүссэн. Бид шинэ төсөл авсан  
болохоор ажлаа түр зуурхан  
зогсоосон. Хуваарийн дагуу бидэнд  
дахиад гурван долоо хоног байна  
гэдгийг хэлмээр байна гэв.

-Тэнд чинь өчнөөн олон ажил...

-Тэгээд юу гэж? Дарга ирэх нэг дэхэд барилга дээр очино.

-Танд баярлалаа. Нойтон хамуу шиг салж өгөхгүй байгааг минь өршөөгөөрэй, би үнэндээ их бухимдаад. Барилга миний хувьд ихээхэн утга учиртай юм л даа.

-Мэдээжийн хэрэг шүү дээ, Камерон авхай. Гэртээ хариад амарч бай. Та найдвартай хүмүүсийн гарт байгаа.

\* \* \*

Нэг дэхэд талбайд ганц ч амьд

амьтан ирсэнгүй. Дахиад л жаахан удвал Лара галзуурах нь хэмээн бодлоо. Гэсэн ч Коэн гэсэн цорын ганц найдвар түүнд үлджээ.

-Бүх ажил зогссон. Хүмүүс байхгүй. Би асуудлыг шийдэхийг оролдсон боловч хариуд нь бэлэн амлахаас хэтрэхгүй байна. Хоосон ам хэмээн гомдоллов.

-Фирмийн нэр нь юу билээ? "Шинэ Шотланд Констракшн" билүү?

-Тийм ээ.

-Хүлээж бай. Би эргээд ярина.

Хоёр цагийн дараа утасны хонх  
жингэнэн дуугарлаа.

-Хэн танд түүнийг зуучилсан бэ? Би  
энэ фирмийн л хэлээд байна л даа.

-Шон Макаллистер зуучилсан.

-Би ч бас тийм болов уу гэж бодсон  
юм, Лара. Мань эр эзэн нь юм байна  
шүү дээ.

Ларагийн нүд харанхуйлаад ирлээ.

-Тэгэхээр Шон Макаллистер  
барилгын ажлыг удаашруулах  
бодолтой байгаа юм байх даа? -Тэгж  
л таарах нь.

-Ээ Бурхан минь!

-Еврейчүүд ийм хүнийг-хорт могой гэж зөв тодорхойлсон байдаг юм.

Коэны Ларад хэлж зүрхлээгүй байсан тэр сануулга нь дэндүү хэрцгий ажээ.

-Магадгүй... магадгүй, би ямар нэг гарц олж ч юу магад.

Чарьлз үнэн голоосоо залуу бүсгүйгээр бахархахын зэрэгцээгээр Макиллистерийг ч үнэн голоосоо үзэн ядна. Гэвч түүнд юугаар туслах вэ? Тэр юу хийж чадах билээ?

Шөнөжингөө нойр нь хулжин, цурам хийгээгүй Лара: "Одоо барилгыг Макаллистер булаан авч, бүсгүй өөдгүй шаарын өмнө бүх насаараа төлөөд баршгүй асар их өртэй үлдэх нь. Тэгээд банкны эзэн эр түүнийг хэрхэн төлж дуусга гэх бол" гэж бодохоос дургүй нь хүрэн зогсоо зайгүй хөрвөөжээ.

Лара маргааш өглөө нь банкинд хүрч очив.

-Чамтай уулзахад сайхан байна шүү, хонгор минь. Чи сайхан харагдаж байна!

-Та хугацаагаа сунгах хэрэгтэй



байна. Би хугацаандаа амжихгүй нь гэх бүсгүй бүхнийг тайлбарлан цаг алдахгүй гэж шийдсэн бололтой.

-Хэрэгтэй гэнээ? Сунгах хэрэг үү? Пөөх, хонгорхон охин минь яасан олиггүй мэдээ дуулгаж байна даа?

-Надад дахиад сарын хугацаа хэрэгтэй байна.

-Энэ огт боломжгүй хэрэг. Үгүй, хонгор минь, яагаад ч үгүй. Бид гэрээнд гарын үсэг зурцгаасан. Хэлэлцээр бол хэлэлцээр гэж Макаллистер сүүрс алдан өгүүлэв.

-Гэвч...

-Өршөөгөөрэй, Лара. 12 сарын 31-нд барилга банкны мэдэлд шилжих болно.

\* \* \*

Энэ аймшигт мэдээ хөлсний байрны оршин суугчдыг ихэд бухимдуулжээ.

-Өмхий гичийн зулбасга! Тэр ингэх ёсгүй хэмээн хэн нэгний шүдэн завсраар исгэчүүлэн зүхэх сонсдов.

-Тэр санаснаа хийгээд эхэлчихсэн. Бүх юм өнгөрсөн хэмээн Лара цөхрөн өгүүлэв.

-Залуус аа! Ингэхэд бид түүнд ийм ч

амархан бууж өгөхгүй шүү!

-Яасан ч үгүй ээ! Лара чамд хэдий хэр хугацаа үлдсэн бэ? Гурван долоо хоног уу?

Бүсгүй толгой сэгсрэн,

-Түүнээс ч бага. Ердөө л хоёрхон долоо хоног үлдээд байна гэлээ.

-Явцгаая! Барилгыг өөрсдийн нүдээр харцгаая!

-Яадаг хар чөтгөр вэ, тэр...

-Явцгаая, явцгаая!

Хагас цагийн дараа гэхэд хэдэн

арван суугчид талбайд ирцгээлээ.

-Тэгэхээр усны хоолой тавиагүй юм байна гэж нэг нь хэлэв.

-Цахилгааны тэжээл бас алга.

Тэд арван хоёр сарын тэсгэм хүйтэн салхинд дуусгалгүй дутуу хаясан ажлыг ярилцан зогсоцгоосны эцэст,

-За тэгэхээр, Лара. Чиний банкны эр тийм ч мулгуу амьтан биш бололтой. Барилга бараг дуусах дөхөж, тэр түүнтэй зууралдах ч үгүй, Өмхий муу санаандаа бүгдийг тооцоолжээ! Бид хоёр долоо хоногг барилгыг дуусгаж чадна гэдэгт би бүрэн итгэлтэй

байна хэмээн өндөр биетэй уулын эр хэлээд нөхдийгөө нүд гүйлгэн харав.

Эрчүүд ч түүнийг дэмжин өөр хоорондоо хүнгэнэлдэв.

-Та нар ойлгохгүй байиа гэж үү? Барилгын ажилчидгүй болчихоод байна шүү дээ! гэж Лара сандчин өгүүлэв.

-Охин минь, сонсож байгаач! танайд слесарь, цахилгаанчин, мужаан амьдардаг шүү дээ. Хүрч ирээд тус болохоос татгалзахгүй тэдний найз нөхөд ч хотод олон бий.

-Гэвч би та нарт хөлс төлж чадахгүй шүү дээ. Макаллистер сохор зоос ч...

-Энэ чамд өгөх бидний шинэ оны бэлэг болог.

Эрчүүд хэдийгээр ийнхүү шийдсэн авч нэг л итгэл муутай санагдах авай. Глэй-Бэй хот даяар агшин зуурын төдийд зар таран, өөр барилга дээр ажиллаж байсан олон ажилчдыг цуглуулахад, тэдний тэн хагас нь Ларад сэтгэл татагдаж байсан бол, нөгөө хагас нь Макаллистерийг жигшин зэвүүцэж байлаа.

-Өөдгүй амьтанг сургаад өгөмз

хэмээн тэд үглэцгээнэ.

Эрчүүд унтаж амрахаа умартан шөнө дөл болтол ажиллаж, эл хуль байсан барилгын талбай амь орох нь тэр ээ. Барилгын ажлыг дуусгах хугацаа тэдний уриа болж, тэд гар хүмхилгүй ажиллацгаана. Шон Макаллистер энэ тухай сонсоод барилга дээр тэсгэлгүй харайлган ирэв.

-Энд юу болоод байна? Билл эднийг хөлслөөгүй шүү!

-Энэ миний ажилчид билээ. Гэрээнд намайг өөрийн бригадаа оруулахыг хориглосон зүйл байхгүй хэмээн

Лара тайвуу гэгч нь хариулахад,

-За за. Барилга техникийн бүхий л нөхцлийг хангасан байх ёстой гэдгийг бүү мартаарай гэж банкны эзэн заналтайяа бувтнав. - Түүнийг ч мэдэлгүйдээ.

12 сарын 30-нд, шинэ он гарахад ганцхан хоног дутуу байхад ажилчид барилгыг дуусгалаа.

Лара өөлөх юмгүй баригдсан барилгыг нүд салгаж чадахгүй ширтэнэ.

-Барилга чинийх. За бүгдээрээ амжилтаа яаж тэмдэглэцгээх вэ?



хэмээн ханхар цээжтэй  
цахилгаанчин эр бахдан өгүүллээ.

Тэр шөнө Глэй-Бэй хот унтсангүй.  
Хотын бараг бүх оршин суугчид  
Ларагийн ялалтыг тэмдэглэжээ. Гэвч  
энэ бол түүний зөвхөн эхлэл байлаа.

Баланд шунах баавгай шиг амтанд  
нь орсон Ларагийн толгойд бас  
нэгэн санаа төржээ.

-Таны шинэ хамтран зүтгэгчид хаа  
нэг газар амьдрах нь гарцаагүй биз.  
Би тэдэнд дуртайяа байшин барьж  
өгөхсөн. Та зөвшөөрөх үү? хэмээн  
Лара Коэнд хэлэхэд,

-Тэрэн шиг үнэн үг алга гэжээ.

Ингээд Лара орон нутгийн банкнаас хоёр дахь төслөө санхүүжүүлэх зээл авахаар Сидней оров. Шаргуу зүтгэн орон сууцыг ашиглалтанд өгсний дараагаар тэрээр ээлжит саналаа хэлэхээр Коэнтэй уулзлаа.

-Чарлз аа, таны бодлоор энд өөр юу дутагдаж байна? Надад бол жуулчид зуны тохилог байрнаас татгалзахгүй байх хэмээн санагдах юм. Санааны минь мухарт тэнгисийн булангаас холгүй онцгой сайхан газар бий, ТЭНД...

Удалгүй Коэн түүний санхүүгийн

хувийн зөвлөх болжээ. Удаах гурван жилийн туршид Лара Глэй-Бэйд албан газар, олон арван анчны болон загасчдын байр, худалдааны үзэсгэлэн барьж босгожээ. Галифакс, Сиднейн банкнууд цуцашгүй эзэгтэйд хүссэн мөнгийг өгөх нь нэр төрийн хэрэг хэмээн үзэцгээх болов.

Хорин дөрвөн сарын дараа Лара өр авлагаа цуглуулж дуусахад, түүний дансанд гурван сая доллар цугларав.

Яг энэ үед бүсгүй хорин нэгэн нас хүрчээ.

Ийнхүү наймаагаа хийснээс хойш нэг өдрийн дараа тэрээр Глэй-Бэйг

орхин Чикагог зорьлоо.

## Долдугаар бүлэг.

Галифаксаас өөр газар очиж үзээгүй асан Лараг Чикаго хот гайхшруулж орхив. Загасчид, модчины бяцхан гацаатай Дундад Өрнөдийн гайхалтай хот юугаараа ч эн зэрэгцэхгүй ажээ. Чикаго хотоос тасралтгүй эрч хүч, амьдрал буцлан хотын иргэд тодорхой зорилготой түүндээ тэмүүлэн байх нь үзтэл илт.

Лара бүсгүй "Стивенс" зочид буудалд өрөө хөлслөв. Хүлээлгийн танхимын гантиг чулуун шалаар өндөр өстийтэй ганган туфли жийн, чансаагаа мэдэн дээгүүр харан алхлах дэгжин хувцастай нэгэн

хатагтайг хараад Лара өөрийн өмссөн хувцасныхаа ядуу тарчиг байгааг нь ойлголоо. Глэй-Бэйд гацаандаа л нар сар мэт боломжийн байжээ дээ. Чикагод бол гологдож байна! хэмээн Лара бодлоо.

Маргааш өглөө нь тэрээр санаснаа хэрэгжүүлэн "Кейж", "Ультимо"-гийн тансаг дэлгүүрээс санаандаа таарсан ганган костюм, "Жозеф"-оос үнэтэй туфль, Сакс-авенюгээс дотуур хувцас, "Траберт ба Хеффери"-ээс ажил хэрэгч бүсгүйд зохисон ээмэг, бөгж, нэмэрт нь "Уэар"-аас усны булган нөмрөг авсан байна. Кассын дэргэд зогсож байх бүрдээ Лара: Би мөнгө үйлдвэрлэдэггүй. Авралын арми орж

үз" гэж байсан эцгийнх нь дуу чихэнд нь хангинана. Зочид буудлынх нь нүсэр том шүүгээ дүүрсэн хэдий ч дэлгүүр хэсэх ажил нь үргэлжилсээр.

Ажлынх нь дараагийн төлөвлөгөө бол утасны лавлахны "шар хуудас"-ыг эргүүлэн нилээд дөнгүүрт тооцогдох үл хөдлөх хөрөнгийн брокерын конторыг бүртгэх ажил байлаа. Жагсаалтын эхэнд "Паркер энд Ассошиитс" орлоо. Лара дугаарт залган, ноён Паркертэй холбохыг хүсэв.

-Хэн түүнтэй ярих гэж буйг мэдэж болохсон болов уу? хэмээн нарийн

бичгийн дарга лавлав.

-Лара Камерон байна.

Хормын дараа харилцуурт эр хүний  
дуу сонсдон,

-Брюс Паркер байна. Танд юугаар  
туслах вэ? гэлээ.

-Би зочид буудал барьчих газар хайж  
байна.

Харилцуур дахь дуу хоолой илтэд  
зөөлрөн,

-Хатагтай Камерон, бид энэ  
асуудлаар мэргэшсэн улс.



-Камерон авхай гэвэл ямар вэ.

-Өршөөгөөрэй. Ингэхэд танд анзаарч товлосон газар байна уу?

-Үгүй. Үнэнийг хэлэхэд би Чикаготой сайн танилцаж амжаагүй явна.

-Сүйдтэй юм огт алга. Манай фирм танд муугүй сонголт хийж өгч чадна хэмээн баттай хэлэх байна.

Уучлаарай, ингэхэд ямар хөрөнгөө барих вэ гэсэн бодол таны толгойд байна уу?

-Надад гурван сая доллар бий хэмээн Лара бардам хэлбэл харилцуурт хэсэг зуур таг чимээгүй

боллоо.

-Гурван сая гэнэ ий?

-Яг тийм. -Тэгээд та барилга барих санаатай байгаа хэрэг үү?

-Тийм ээ.

Удтал чимээ тасрав.

-Камерон авхай, та бэлэн болсон барилга сонирхохгүй биз?

-Хэрхэвч үгүй. Би хотын үзэсгэлэнтэй дүүрэгт хосгүй сайхан зочид буудал барихаар...

-Үүндээ гурван саяыг зарцуулах гээ

юу? гэснээ Паркер гайхсанаа  
илэрхийлэн хамраараа дуугарснаа,

-Тэгвэл ч манай хүч мөхөсдөнө гэж  
айж байна гэв.

-Танд баярлалаа.

Лара харилцуураа тавьлаа.

Паркерын брокерын пүүс огтын  
хэрэггүй болох нь үзтэл илт ажээ.

"Шар хуудас"-аа дахиад эргүүлэн  
нилээд хэдэн газар руу утасдав.

Орой болохын алдад гурван сая  
долларын төсөв оруулах зочид

буудлын цогцолбор босгочих

таалалд нь нийцсэн газар олоод өгөх  
брокерын пүүс Чикагогоос олдохгүй

нь илэрхий болов. Үл хөдлөх хөрөнгийн мэргэжилтнүүд олон санал тавих авч тэр нь хотын захад жирийн нэгэн хөлсний байр санал болгохоос үл хэтэрнэ. Яасан ч үгүй шүү. Тэгж үхсэнээс тээглэж үхсэн нь дээр гэгчээр тэнд газар авснаас Глэй-Бэйдээ харьж буцсан минь хавьгүй илүү хэмээн Лара бодно.

Буудлын булан тохой, бүрдэл хэсэг болгон нүдэнд нь тодрон дүрслэгдэж, зочид буудал барьж босгох гэсэн хүсэл нь Ларад амар заяа үзүүлсэнгүй. Буудал нь замд яваа хэн хүний гэр нь, хоёр дахь гэр нь болох ёстой. Тэрээр дийлэнх нь ханан зуух бүхий зочдын ерөө бүхий

люкс өрөөнүүдээс бүрдэж тохилог номын сан, арьсан бүрээс бүхий буйдан ор, буйдан сандалтай, бас дээр нь асар том төгөлдөр хуур заавал ч үгүй тавих ёстой! Хоёр унтлагын өрөө, өрөөний энгээр үргэлжлэх уужим саравчит тагт. Мэдээжийн хэрэг угаалгын өрөөндөө жааз хөгжим хангинан, зочдын өрөөндөө авсаархан мини баартай байна.

Лара юу хүсч байгаагаа сайн мэдэж байв. Зөвхөн бодсоноо хэрхэн биелүүлэх вэ? гэдгийг л шийдэх хэрэгтэй байлаа.

Лара Лейк-стрит дэхь бага шиг

хэвлэлийн газраар орж, -Та надад зуугаад нэрийн хуудас хэвлээд өгч чадахсан болов уу? гэсэнд,

-Чадалгүй яахав, авхай. Та овог нэр, албан тушаал, утсаа хэлчих дээ гэв.

-"Лара Камерон авхай", голд нь доохно талд "Үл хөдлөх хөрөнгийн шинжээч" гээрэй.

-Ойлголоо, Камерон авхай. Та хоёр хоногийн дараа ирээрэй. -Үгүй. Нэрийн хуудас надад өнөө орой хэрэгтэй байна. Хичээж үзээч!

Одоо хоттой танилцах л үлдлээ.

Лара Мичиганы өргөн чөлөө, Стейт-стрит, Чикагогийн төв дэх Ласалль, Лейк-Шор-драйваар хөндлөн гулд огтлон, Линкольны амьтны хүрээлэн, гольфын талбай, нуурын үзэсгэлэнг шимтэн сонирхож тэнэв. Тэр Чикагогийн бараан зах, "Кротч-Брентано"-ийн номын дэлгүүрээс Чикагог хоёрдох эх орноо болгосон Карл Сэндберг, Фрэнк Ллойд Райт, Луис Генри, Салливан, Сол Беллоу зэрэг агуу цуут хүмүүсийн тухай лавлах ном худалдан авчээ. Лара Мичиган нуурын эрэг дээр анхны шилжин ирэгсэд, Жорж Бэйрдс, Гэйлорд Доппели, Маршал Филдс, Поттера

Паммера, Уолдгрин нарын тухай толгой өндийлгүй уншиж тэр нэгэн цагт тэдний харш хэмээгдэж байсан байшинг бахдан харав. Харин Латви, Шотландаас ирсэн польш, шведүүдийн амьдардаг бохир заваан Чикагогийн өмнөд хэсгээр явахдаа төрсөн гэртээ ирсэн мэт санагдав. Энэ дүүрэг чухамдаа Глэй-Бэйгээс огтын ялгаагүй ажээ.

Лара хоттой танилцах зуураа барилга зарах зарлал сонирхон брокерууд руу утасдаж үзжээ. -Таны үнийг сонсоё.

-80 сая доллар...



-60 сая доллар...

-100 сая доллар...

Гурван саяын хөрөнгө гэдэг түүнд өчүүхэн төдийхөн хөрөнгө мэт санагдаад явчихлаа. Лара боломжтой хувилбар бүрийг эргэцүүлэн бодсоор шөнө дунд хүртэл буйдан сандалд шигдэн суув. Сонголт тийм ч олон биш: нэг бол хотын захын бяцхан зочид буудлаар өөрийн их занг хязгаарлах, эсвэл Глэй-Бэй рүүгээ буцаж очих явдал байв. Түүнд үүнээс өөр арга зам олдсонгүй.

Лара маргааш өглөө нь банк орлоо.

Тээгний цаана суух ажилтан эр түүн тийш лавласан харцаар харахад нь,

-Дэд ерөнхийлөгчтэй уулзах гэсэн юм гээд нэрийн хуудсаа залуу эрд сунгав,

Таван минутын дараа Лараг дөч эргэм насны ноомой, нүүр нь мэдрэлийн татганах өвчний улмаас мэдэгдэхүйц чичигнэх Том Питерсоны өрөөнд оруулжээ.

-Камерон авхай, би танд юугаар тус болох вэ? -Би хотод шинэ зочид буудлын барилга эхлэх бодолтой байна. Тэгээд тодорхой хэмжээний зээл авах гэсэн юм. Питерсоны уруул

инээмсэглэн суналаа.

-Үүний тулд л бид энд сууж байна, авхай. Ингэхэд таны зочид буудал юугаараа онцлог юм бэ дээ?

-Сайн дүүрэгт дээд зэрэглэлийн байгууламж босгоно. -Тун сэтгэл татам сонсогдож байна.

-Яг одоо надад ердөө л гурван сая доллар байгаа гэдгийг шууд хэлмээр байна.

Ярилцагч эр бүр ч дарвайтал инээж,  
-Ямар ч асуудал алга гэлээ.

-Нээрээ юу? гэхдээ Ларагийн

нуруугаар хүйт оргив. -Хэрэв та хэрхэн зарцуулахаа мэдэж байгаа бол гурван сая гэдэг ч их мөнгө шүү гээд Питерсон цагаа хяламхийснээ,

-Харамсалтай нь, зочид намайг хүлээж байна. Хамт оройн зоог барин, арай илүү тааламжтай байдалд хэлэлцэхээс татгалзахгүй биз, авхай? гэлээ.

-Дуртайяа. Энэ чинь тун гайхамшигтай байхсан. -Та хаана буусан бэ? -"Палмер"-т.

-Би яг наймд таныг авахаар очье.

-Маш их баярлалаа. Та миний

хэрхэн баярлаж байгааг төсөөлөхгүй л дээ. Надад найдвар тасарсан мэт санагдаж байсан шүү гэв.

-Найдвар тасрана гэж байхгүй. Санаа бүү зов, та зөв газраа олж иржээ.

Оройн 8 цагт Питерсон Лараг машиндаа суулган "Энриччи" ресторанд ирэв.

Тэд ширээний ард суумагц банкны дэд ерөнхийлөгч, -Та над дээр ирсэн чинь тун ухаалаг явдал болсон шүү, Камерон авхай. Хоёул хамтарч бие биедээ их юм хийж чадна. -Хамтарч ий?

-Чухамдаа яг тийм. Гудамжаар гунхсан сайхан амьтад их явах атал тан шиг овсгоотой оролдлого хийчих хүн гарч ирэхгүй юм. Та яагаад хэдэн сайхан хүүхэн суулгачихсан, үнэтэй эмсийн хүрээлэн байгуулж болохгүй...

Ларагийн царай хүрэнтэн барайж,

-Өршөөгөөрэй, та юу гэв ээ?

-Хэрэв та арван сайхан дагина олчихвол, би танд...

Лара даруй ухасхийн босоод үүд рүү хар гүйхээрээ хурдлав.

Маргааш нь Лара өөр гурван  
банкинд очив.

Өөрийн төлөвлөгөөг танилцуулахад  
эхний эрхлэгч,

-Танд л гэхэд та наад хоосон бодлоо  
толгойноосоо авч хая. Үүнээс илүүг  
би танд зөвлөж чадахгүй нь. Үл  
хөдлөх хөрөнгө гэдэг чинь зөвхөн  
эрчүүдийн тоглодог тоглоомын  
талбар. Тань шиг уяхан  
туяхан бусгүйчүүлд тийш очих гарам  
байдаггүй юм гэжээ. -Яагаад тэр  
билээ? гэж Лараг санаа алдан  
асуухад, -Яагаад гэвэл энэ талбарт  
догшин эрчүүд ажилладаг юм. Тэд  
таныг бүхлээр чинь залгичих байлгүй

ГЭВ.

-Би ч Глэй-Бэйгээс амьд мэнд  
гарчихсан л яваа юмсан. Эрхлэгч  
урагш бөхийн,

-Би танд нэг бяцхан нууцыг задлая.  
Чикаго бол Глэй-Бэй биш хэмээв.

\* \* \*

Хоёрдахь банкны менежер эр,

-Камерон авхай, танд тусалж  
чаддагсан бол бид тун ч их баяртай  
байхсан. Наад бодлоо дотроо  
хадгалж үз. Банк таны эд хөрөнгийг  
данслахдаа... менежер эр үгээ



төгсгөж чадсангүй, Лара өрөөнөөс гарч явлаа.

Гуравдахь банкны ерөнхийлөгч нь бууралтаж яваа, ямар л харагдах ёстой яг л тийм биедээ итгэлтэй, илт өдсөн эелдэг ааштай Боб Вэнг гэгч ноёнтон байлаа. Өрөөнд нь түүнээс гадна гуч эргэм насны нилээд үрчгэр костюмтай дорой нэгэн залуу эр байх ажээ. Банкны ерөнхийлөгч,

-Камерон авхай, танд манай дэд ерөнхийлөгчдийн нэгийг танилцуулах гэсэн юм. Энэ хүн бол Говард Келлер гэв. Тэд мэнд мэдэлцэв.

-Ингэхэд танд юугаар туслах вэ, авхай? хэмээн Боб Вэнс чин сэтгэлээсээ элэгсгээр асуув.

-Би Чикагод зочид буудал барих бодлоосоо шантарч татгалзалгүй, санхүүгийн эх үүсвэр олохоор хөөцөлдөж яваа минь энэ.

-Та хаяг андуурсангүй. Ингэхэд та барилгынхаа газрыг үзсэн үү? гэснээ Вэнс инээмсэглэв.

-Хотын "А" бүсэд. Петлийн дотор, Мичиган-авенюгээс холгүй газарт. - Сайхан сонголт байна.

Лара төсөөлөн буй тансаг зочид

буудлынхаа тухай тодруулан ярьж өгөв.

-Яах вэ, таны төлөвлөгөө сэтгэгдэл төрүүлж байна. Ингэхэд гар дээр тань бэлэн хөрөнгө бэл юу байна?

-Гурван сая доллар бий. Үлдсэн мөнгийг би зээлмээр байна. Удтал дуугүй болсны эцэст нь Боб Вэнс,

-Үүнд илүү хянамгай хандах ёстой, гэхдээ манай банк танд тусалж чадахгүй л байхаа даа, Камерон авхай. Асуудлын гол нь таны санаа чинь хэтэвчнийхээ хэрээс хэтэрчихээд байна гэдэгт байна. Хэрэв та магадгүй, биднийг энэ

гурван саяа хувь оруулахыг хүсч,...  
гэв.

-Үгүй баярлалаа, надад зориулан цаг  
зав гаргасанд тань талархая.  
Баяртай, жентельменүүд ээ.

Лара омог бардмаар толгойгоо  
өргөсөөр өрөөнөөс гарлаа. Чикаго  
Глэй-Бэй биш гэдэг үнэн юм байж.  
Гурван сая доллар гэдэг Глэй-Бэйд  
ухаанд багтамгүй их мөнгө атал энд  
Чикагод цөөхөн хэдэн зоосын дайтай  
үнэлэгдэх ажээ.

Лара гудамжинд гаран алхтал гэнэт,  
-Камерон авхай! гэж дуудах  
сонсогдов.

Лара эргэн харвал нөгөө үрчгэр костюмтай дорой эр Говард Келлер түүн рүү яаран дөхөж ирэх үзэгдэв. - За юу гээв?

-Хэдхэн үг солих гэсэн юм. Аяга кофе уух уу? Таагүй нэгэн дурсамж гэнэт санагдан хамаг бие нь золтой л дагжтал чичирсэнгүй.

Арай эндхийн бүх харчуул-сексийн донпюнууд юм биш биз дээ? -Тэр буланд аятайхан кафе бий. Лара мөрөө хавчисхийн, -Тэгье л дээ гэлээ.

Келлер кафены үйлчлэгчид хоёр үг хэлээд бүсгүй рүү эргэн, -Залхааж байгаа бол өршөөгөөрэй, гэхдээ би

танд ямар нэг зөвлөгөө өгч чадахсан гэлээ.

-Бүү зов хэмээн Лара ядарсан байртай өгүүлэв. -Юуны өмнө та бүр анхнаасаа буруу зам сонгожээ. - Таны бодлоор бол, миний санаа хэзээ ч бүтэшгүй хэрэг болж байна уу? гэж Лара мөс мэт хахирган дуугаар асуулаа.

-Харин ч бүр эсрэгээр! Таны хэлээд байгаа зочид буудал үнэхээр гайхамшигтай!

Лара юу ч ойлгохоо болилоо.

-Тэгвэл яагаад...

-Чикагод газар үнэтэй болчихоод байхад та зочид буудал барьж яах нь вэ?

-Та юу гэх гээ вэ?

-Боломжийн хуучивтар барилга хайж олоод, өөрийн хүссэнээрээ өөрчлөн засвал ухаалаг хэрэг бус уу? Хотоор дүүрэн гуравдугаар зэрэглэлийн зочид буудал байгаа, тэднийг боломжийн үнээр худалдан авч болно шүү дээ. Танд л гэж хэлэхэд таны гурван саяар төлбөрийн нэг хэсгийг хийгээд дутсан мөнгөө банкнаас авч тохижилтонд зарцуулчихад таны тохилог, хүсвэл дээдсийн гэмээр

зочид буудал бэлэн болж болно шүү  
дээ,

Лара бодолд автлаа. Келлерын  
саналд авууштай далд ухаан байна.  
Энэ нь илт холын бодолтой алхам  
ажээ,

-Бас нэг юм байна. Хэрэв та  
чадварлаг архитектор, туршлагатай  
барилгачны нэрийг мэдэхгүй бас  
дуурсахгүй бол нэг ч банк  
санхүүжүүлэхийг зөвшөөрөхгүй.  
Банкны эздэд бат ноттой баримт  
батал-гаа хэрэгтэй байдаг юм.

Бүсгүй Базз Стилийг саналаа.



-Одоо л ойлгож эхэллээ. Танай энд сайн архитектор бий юу?

Келлер инээд алдан,

-Олоон, олон гэлээ.

-Зөвлөсөнд тань гялайлаа, Хэрэв би боломжийн газар олчихвол хоёул яриагаа үргэлжлүүлж болохсон болов уу?

-Дуртай цагт тань. Амжилт хүсье!

Ларагийн дотор хүн нь: Яагаад хоёулаа манай гэрт яриагаа үргэлжлүүлж болохгүй байх билээ? гэсэн тэс өөрийг сонсоно хэмээн

хүлээж байлаа.

Гэтэл Келлер ердөө л,

-Дахиад кофе уух уу? гэжээ.

\* \* \*

Мичиган-авенюгээс хоёр хорооллын зайд байх Делавер стритэд зумласан мэт халцарч нурсан, дайны өмнө баригдсан нэгэн хямдхан зочид буудал Ларагийн анхаарлыг татав. Нэр бүхий самбарын үсэгнүүд нь өм цөм унаж: "Кон... ре.. с" зочид буудал гэсэн үг бүдэгрэн ярзайна. Нүүрэн талын тоосгон хананы өнгө ямар байсан нь төсөөлөхийн эцэсгүй

болтлоо зузаан тоосонд дарагдсан  
найман давхар байшин байлаа.  
Лара дотогш орлоо. Зочид буудлын  
дотор тал нь гадна талаасаа бүр ч  
дор жигшмээр байв. Ноорхой  
жийнс, цоорхой углаа цамцтай  
ажилчин эр элэгдсэн хивсэн дээгүүр  
эрт галавын үеийн тоос сорогч чирэн  
чихэнд чийр болтол чарлуулан  
цэвэрлэнэ. Эрхлэгчийн лангуу нь  
тасалбар зардаг өчүүхэн цонхыг  
санагдуулана. Гудмын тэртээ  
төгсгөлд үзэгдэх шат нь хэзээ ч юм  
тамхилах өрөө байснаа аль хэдийнэ  
больсон өрөө тийш хөтлөх ажээ.

Үйлчлэгч үүдний дэргэд тоос  
сорогчоо орхин, лангуу тийш ойртон

ирэв.

-Өрөө хэрэгтэй юу? гэх түүний дуу нь ямар ч аялгагүй аж.

-Үгүй. Би...

Лараг үгээ дуусгаж чадсангүй. Учир нь бөгсөн биеийг нь барьсан бариу банзалтай, будмал царайтай ч, нэг их хөгшин гэмээргүй эмэгтэй саад болжээ. Эмэгтэйн ард нь хижээл, насны эр зогсоно.

-Майк аа, түлхүүр өгөөдөх хэмээн эмэгтэй үйлчлэгчид хэлэв.

Үйлчлэгч эр түүнд түлхүүр сарвайн

өгөхөд, нөгөө хоёр цахилгаан шат руу чиглэлээ.

-Тэгэхээр танд юу хэрэгтэй вэ? гэсээр залуу эр Лара тийш эргэв.

-Танай эзэн зочид буудлаа зарах эсэх нь сонин байна хэмээн бүсгүй сунжруулан хэлэв.

-Одоо үед юуг ч худалдаж авч болдог хойно доо. Танай эцэг эх чинь үл хөдлөх хөрөнгийн ажил эрхэлдэг юмаа даа?

-Үгүй, би эрхэлдэг юм.

Үйлчлэгч эрийн нүднээс гайхлын оч

гялсхийн,

-Хөөх, тэгвэл та ах дүү Даймондтой уулзсан нь дээр юм байна. Тэд иймэрхүү хоног төөрүүлэх газрын бүхэл бүтэн сүлжээтэй гэлээ.

-Тэднийг хаанаас олох вэ?

Залуу Стейт-стритын хаа нэгтээ байх хаягийг хэллээ.

-Би энэ хавийг нягтлан харвал та татгалзахгүй биз?

Тэр мөрөө хавчхисхийлгэн маасалзаж,

-Тэнгэр ивээг! Гэртээ байгаа юм шиг  
л бай л даа. Удахгүй миний босс ч  
болох ч юм билүү хэн мэдлээ гэлээ.

Бурхан үүнийг зөвшөөрөхгүй биз гэж  
Лара бодов.

Тэрээр гярхай нүдээр ийш тийш  
харан үүдний өрөөгөөр аажуухан  
алхлав. Орох хаалгыг гантиг  
баганаар хүрээлжээ. Ларагийн хөл  
доорхи хивс төрхөө хэдийнэ алдсан  
хивсний ирмэгийг сөхвөл дор нь хир  
буртагтаа сааралтсан гантиг хавтан  
үзэгдэв. Хонгил дахь шат түүнийг  
хоёр давхарт хүргэлээ. Гичийн өнгөт  
ханын цаас энд тэндгүй урагдаж  
салбарчээ. Салбархай хананы цаана

гантиг хана судалтан харагдахад зүрх нь түргэсэн оволзов. Шатны хашлагыг хараар буджээ. Үйлчлэгч шагайвар цонхныхоо цаана суугаад ямар нэгэн цаас залхуутайяа эргүүлэн суухыг хараад, Лара халааснаасаа түлхүүр гарган бариулыг хамаг хүчээрээ хусав. Зураас нь зэсийн бүдэгхэн өнгөөр гялалзаж түүний горьдлого үнэн байжээ. Тэрээр цахилгаан шат руу дөхөж очоод хар будгаар түрхсэн торон хаалтыг түлхүүрээр хусав. Мөн л зэсээр хийсэн байх ажээ.

Сэтгэлээ дарж ядсаар Лара үйлчлэгч рүү бууж очин,



-Өрөөнүүдийг үзэж болох уу? гэв.

-Гүнээ хүндэтгэе. Сул байгаагаас хамгийн ойр нь 410 гээд залуу түүнд хэлхээтэй түлхүүр гардуулав.

-Баярлалаа.

Лара цахилгаан шатанд орж, товч дарсанд хуучин загварын бүхээг чичигнэсээр аажим дээшлэв.

Би бүгдийг өөрчлөнө. Бүхээгний ханыг уран хээтэй хивсээр бүрнэ,

Тархинд нь засварын төлөвлөгөө зохиогдож эхэллээ.

410-р өрөө нь хаяж орхисон тосгоны амбаарыг санагдуулам авч, урьдын чансаа чанарыг нь халхалж эс чадна. Өрөө гайхалтай уужим бөгөөд ханын энгээр марзан загварын тавилга тавьж, харин угаалгын өрөө нь авахын тамтаггүй бохир заваан гэдэг аймшигтай ажээ.

Лара амьсгаагаа түгжлээ. Гайхалтай!

Тэрээр шатаар үүдний өрөө рүү буувал гишгүүрийг бас л гантигаар хийжээ.

Лара үг дуугүй түлхүүрийг үйлчлэгчийн өмнө тавилаа.

-За ямар байна? Үзэв үү?

-Үзлээ. Танд баярлалаа. Залуу инээмсэглэн,

-Та нээрэн энэ ноорхой пинг худалдаж авах гээ юу? гэв.

-Би нээрэн энэ пинг худалдаж авмаар байна.

-Чанга байх шив дээ.

Цахилгаан шатны хаалга дэлгэгдэн бүхээгнээс залуухан янхан хүүхэн хорчгор дагуулынхаа хамт гарч ирээд түлхүүрээ, хуйлж ороосон мөнгөний хамт үйлчлэгч эрд

сарвайв. -Баярлалаа, Майк.

-Амжилт хүсье, Берта гээд тэрээр  
Лара тийш эргэн,

-Тэгэхээр та дахин ирэх нь ээ?

-Эргэлзэх юмгүй.

\* \* \*

Түүний дараачийн очих газар нь Хотын архив байлаа. Лара дугариг нүдний шилтэй, хатуу чанд эмэгтэйгээс сонирхсон барилгынхаа намтартай танилцаж болох эсэхийг асууж арван доллар төлсний эцэст "Конгресс" зочид буудлын баримт

бүхий хавтсыг гардан авчээ.

Баримтаас үзвэл ах дүү Даймондууд таван жилийн өмнө зургаан сая доллараар зочид буудлыг худалдан авсан аж.

\* \* \*

Ах дүүсийн оффис нь Стейт-стритийн булан дахь нэгэн хуучны харшид байх аж. Зүсмэл уйтан нүдтэй, оготор час улаан банзалтай бүсгүй,

-Танд юугаар туслах вэ? хэмээн товчхон асуув.

-Би ноён Даймондтой уулзах гэсэн юм.

-Хэнтэй нь уулзах вэ?

-Таны таалснаар больё.

-Тэгвэл Жонтой уулз даа гээд нарийн бичгийн дарга харилцуур аван

-Жон, тантай залуухан авхай уулзахаар ирлээ гэж уянгалуулан ярьж эхэлснээ, боссынхоо үгийг чагнан хэсэг азнаад корье бүсгүй Лара тийш харц өргөн,

-Ямар хэргээр явна? гэв.

-Түүний зочид буудлын нэгийг нь худалдаж авах бодолтой байна. -  
Чамаас зочид буудал худалдаж авах

санаатай байна гэнээ гэж боссдоо  
хэлээд, харилцуураа тавин,

-Ор ор гэв.

Жон Даймонд гэгч дунд эргэм  
насны, нүсэр том бие, малигар  
улаан царайтай нэгэн байв. Хуруу  
хэрийн бүдүүн навчин тамхиа  
баагиулан байх тэрээр Лара тийш  
бүлтгэр хар нүдээр ширтэн,

-Жой надад таныг зочид буудал  
худалдаж авахыг хүсч байна гэсэн  
хэмээснээ түрхэн зуур зогсосхийснээ,

-Таныг харахад, сонгуулийн санал  
өгөх хуулийн нас бие гүйцсэн гэж

итгэхэд хэцүү байна гэлээ.

-Өө, би санал өгөх хуулийн насанд хэдийнэ хүрсэн. Бас танаас зочид буудал авах нас бие гүйцсэн шүү.

-Нээрээ юу? Алийг нь сонирхоо вэ?

-"Конрес"-ыг.

-Юу-уу?

-Хаяг дээр нь ийм л байсан.

"Конгресс" гэж байгаа бололтой дог оо.

-Аан уул нь ч тийм л дээ.

-Түүнийгээ зарах уу?



Даймонд толгой сэгсэрч,

-Чөтгөр ав гэж, яахаа ч мэдэхгүй л байна шүү. Ер нь бол "Конгресс" муугүй орлоготой. Тэгэхээр бид саалийн ганц үнээнээсээ салахыг хүсэхгүй л болов уу даа хэмээв.

-Танд нэрмээс болсон эд байна лээ.

-Тийм гэж үү?

-Барилга ч дур гутмаар юм билээ. Удахгүй нурж унах нь байна билээ.

-Маргалдах юм алга. Тийм байтал та түүгээр яах гээ вэ?

-Зочид буудлаа надад өгчих, би түүнийг сэргээж засна. Мэдээжийн хэрэг тэнд суугчид үлдэхгүй гэсэн ганцхан нөхцөлтэйгээр шүү.

-Үүнд ямар ч асуудал алга. Суугчдыг байлгах хугацаа нэг долоо хоногоор таслана.

-Тэнд хэдэн өрөөтэй вэ?

-Зуун хорин таван өрөөтэй.  
Барилгын ерөнхий талбай нь зуун мянган квадрат фут.

Дэндүү олон өрөөтэй юм. Дажгүй тоог нь цомхотгоод, эвтэйхэн шиг хэдэн өрөө болгочихно. Надад 60- 75

өрөө байхад л хангалттай. Үнийн асуудал үлдлээ.

-Хэрэв би үнэхээр худалдан авахаар шийдсэн бол хэдий хэрийн өртөг танд хангалттай байх вэ?

-Хэрэв би үнэхээр худалдахаар шийдсэн бол арван саяас багагүй байх болно. Анхны үнэ зургаан сая.

Лара мөрөө хөдөлгөн,

-Танд... гэвэл Жон эрс шийдэмгийгээр,

-Үнэ хаялцахгүй гэв.

Ларагийн тархи тэчъядан ажиллаж эхэллээ. Барилгыг өөрчлөн засахад нэг квадрат футэд наян доллар, өөрөөр хэлбэл нийтдээ найман сая доллар болно. Дээр нь тавилга тоноглолын үнэ.

Лара банкнаас хагас хугас мөнгө авч болно гэдгээ мэднэ. Гэтэл асуудлын гол нь анхны өртөг болох зургаан сая доллараас өөрт нь ердөө л гурван сая бэлэн байгаа явдал байв.

Даймонд үнээ санаанд багтамгүй өсгөн хэлсэн болохоор Лара зочид буудлын эзэн байх хүслээ хатамжлан барив.

-Бид тохиролцож болно шүү дээ гэж

бүсгүйг хэлсэнд өрөөний эзэн  
анхааралтай сонсож суув.

-Та хүссэнээ авах... гэхэд нь Даймонд  
инээд алдан,

-Гайхалтай хэрэг гэлээ.

-Харин анхны төлбөр гурван сая  
байх болно.

Мань эр гараа алдлан,

-Болохгүй. Зургаа, тэгээд бэлнээр  
гэлээ.

-Зөвшөөрч байна.

-Хөөх! Та дахиад гурван саяыг

хаанаас олох вэ?

-Танаас.

-Юу?

-Та надад барьцаа болгон өгнө дөө.

-Ингэхэд би танд, өөрийн зочид  
буудлаа зарах гэж мөнгө өгөх хэрэг  
үү?

Яг иймэрхүү асуултыг Глэй-Бэйд Шон  
Макаллистер түүнээс асууж  
байсансан.

-Та өөртөө мөнгө зээлэх журмаар  
асуудлыг шийдвэл яасан юм бэ?

Намайг мөнгөө төлж дуустал барилга таны мэдэлд байх болно. Танд хонжоотой гэдгийг бодолцоорой. Даймонд хэсэг бодолхийлэв. Төдөлгүй түүний уруул дээгүүр сэтгэл хангалуун инээмсэглэл тодров.

-За яахав, авхай танд баяр хүргэе. Та санаснаа авлаа. Говард Келлерын ажлын өрөө нь ечүүхэн жижиг ажээ. Лараг орж очиход залуу эр анх уулзсанаасаа ч илүү ядарч зүдэрсэн харагдана.

-Хүрээд ирэв үү? Ийм хурдан уу?

-Хэзээ ч болно гэж та хэлсэн байхаа. Келлер буйдан сандлаа налан, -За

яриад байгаарай гэв.

-Мичиган-авенюгээс хоёр хорооллын хэр зайтай Деловер-стритэд байдаг "Конгресс" гэдэг хуучин зочид буудал байна. Үнэндээ бол барилга гэж ёстой балгас юм. Би түүнийг худалдаж аваад хотын дээд зэрэглэлийн зочид буудал болгомоор байна.

-Хэлэлцээний нөхцөл ямар юм бэ дээ? Таны төлөвлөгөөг Боб Вэнсэд уламжлая гэж Келлер хэсэг зуур бодол болон суусны эцэст өгүүлэв.

Ерөнхийлөгч зочин бүсгүйн хэрэг зоригийг сонсож байснаа ажлын



дэвтэртээ хэдэн юм тэмдэглэв.

-Зарчмын хувьд болно. Гэхдээ... гээд  
Венс гярхай нүдээр Лараг ширтэн,

-Камерон авхай, та хэзээ ч юм зочид  
буудал эрхэлж байсан уу? гэлээ.

Глэй-Бэй санаанд нь урган орж ирэн:  
бохир заваан өрөө цэвэрлэн, шал  
угааж, бүдүүн баргийн амт  
муутайхан хоол хийж, оршин  
суугчидтай ярьж хөөрөлдөн байсан  
нь санагдав.

-Би уурхайчид, модчингууд  
байрладаг хөлсний байранд  
зонхилох үүрэг гүйцэтгэж байсан.

Мэдээж түүнийг зочид буудал гэж хэлэхгүй л дээ.

-Би "Конгресс"-ыг нүдээрээ үзмээр байна, Боб оо гэж Келлер хажуунаас нь хэлэв.

\* \* \*

Ларад ер бусын урам орлоо. Түүнтэй хамт зочид буудлын гудмаар явах Келлер хүүхний төсөөлж байгаа яг л тэр янзаар өрөөнүүдийг үзэх мэт.

-Эднийг саунтай "люкс" өрөө болгоно. Энд ханан зуух, тэр буланд төгөлдөр хуур байрлуулна. Чикагод ирсэн чинээлэг хүмүүс нэрд гарсан

зочид буудлыг л сонгоно, гэтэл тэд нэг хэвэнд цутгасан мэт адилхан. Тансаг гэсэн учир утга үгүй байдаг. Хэрэв бид тэдэнд шал өөр, илүү халуун дулаан, тэр ч бүү хэл өрөө нь нилээд үнэтэй байвал зочид түүнийг шилж сонгоно. Тэд төрсөн гэртээ тухалж байгаа мэт байх болно. Таны бодлоор, танай банк надад зээл өгөх болов уу? хэмээн Лараг асуухад нь Келлер,

-Буцаж очоод магадлая гэжээ. Келлер хагас цагийн дараа Вэнсийн өрөөнд оров.

-За юу хэлмээр байна? гэхэд нь тэрээр,

-Камерон авхай шийдвэр төгс байна. Надад түүний аяны хумүүст зориулсан байрны санал ихэд таалагдлаа гэв.

-Надад ч гэсэн. Гэхдээ түүний нас бага, цус шингэн туршлагагүйг хэрхэх вэ? Энэ чинь зальт явдал гэсэн үг.

Дөчин минутын дараа гэхэд эрчүүд гарах зардал, ашгийн хувийг тооцоолов.

-Их л эрсдэлтэй гэж бодож байна хэмээн Келлер бодлогоширон хэлснээ инээмсэглэн,

-Бид юу ч алдахгүй л дээ. Муугаар эргэлээ гэхэд "Конгресс"д очоод суучихна гэжээ.

Говард Келлер Ларад утасдав.

-Банкны захиргаа дөнгөж сая танд зээл өгөхийг зөвшөөрлөө.

-Үнэн үү? Арай үгүй байлгүй! Бурхан минь, би танд баярлаж байна гээч!

-Бидэнд зайлшгүй хэлэлцэх зүйл байна. Үүнийг орой, зоогон дээр хийвэл та чадах уу?

-Чадна.

-Сайн байна. Найм хагаст таныг авахаар очье.

Оройн зоог "Империал" зочид буудалд боллоо. Ларагийн сэтгэл догдлон юун хоол ундаа анзаарахтай мантай байлаа.

-Би хэрхэн баярлаж байгаагаа хэлж ч чадахгүй байна. Миний зочид буудал Чикагодоо хамгийн шилдэг нь байх болно!

-Та бүү яар. Таныг үй олон бэрхшээл хүлээж байна. Илэн далангүй байхыг зөвшөөрнө үү, Камерон авхай? - Лара гээч.

-Тийм ээ, Лара. Мэдээгүй бол мэнд сайхан гэгч болоод байна. Чамд туршлага алга.

-Глэй-Бэйд...

-Энд Глэй-Бэй бишээ, тэгээд ч тоглоомын өөр дүрэм үйлчилдэг юм шүү.

-Тэгвэл банк яагаад...

-Ойлгохыг хичээж үз. Бид өглөгийн эзэд биш. Хэрэв банк ашгаа авч чадахаа байвал муу юм болно шүү. Гэхдээ би чиний од хиймортойд тань итгэж байна. Бүх юм болж бүтэх ёстой. Чи арай ганц зочид

буудлаар хязгаарлах бодолгүй  
байгаа биз дээ?

-Мэдээж үгүй. Энэ зөвхөн эхлэл.

-Би ч тэгж бодсон юм. Банк нэгэнт  
хүнд зээл өгсөн л бол тэдний  
ажилтнуудын хэн ч хэлэлцээрт нь  
биечлэн оролцдоггүй юм. Гэхдээ  
бидний тухайд гэвэл би чамд  
чадлынхаа хэрээр туслана.

Келлерийн хувьд бүсгүйг  
төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд гардан  
оролцох хүсэл нь оргилж байлаа.  
Тэдний уулзалтын эхний эгшинээс  
эхлэн тэрээр Ларагийн жигтэй дур  
булаам төрх, түүний урам зоригийнх



нь золиос болжээ. Залуу бүсгүй  
цовоо нэгэн хүүхэд шиг л сэтгэгдэл  
төрүүлнэ. Келлер түүнд таалагдахыг  
галзуутайяа хүсэмжлэх ажээ. Тэрээр:  
Магадгүй, би түүнд алдар цууд  
хүрэхэд надад ганцхан алхам дутуу  
байгаа гэдгийг хэлэх цаг нь ирэх ч...  
хэмээн бодлоо.

## Наймдугаар бүлэг.

Дэлхийн шилжин явах цомын төлөө тэмцээний шувтрагын тоглолт болж байгаа Ригли Фийлдид хөөрөлдөө автан хашгирсан 38710 хөгжөөн дэмжигчид цугларчээ. "Энэ бол Кабууд нэг, Янкууд тэг болсон ес дэх удаагийн хамгийн оргил тохиолдол боллоо. Янкууд цохиход бэлдэж, гадна хоёр байна. Эхлээд Тони Кубик, дараа нь Уити Форд, хамгийн сүүлд Ёоги Берра цохихоор байрлалаа эзэлжээ." гэж зарлалаа.

Мики Мэнтлийг цохилтын талбараас гарахад цугласан олон шуугин хашгиралдав. "Мик" улирлын

туршид нийт 304 удаа шидэж,  
жилийн туршид өөрийн зурваст  
дөчин хоёр удаа үүрэндээ амжиж  
иржээ.

Ригли Фийлдийн тайлбарлагч Жек  
Брикхаус их л гайхсан байдлаар  
"Хөөх, тэд шидэгчээ солих гэж байгаа  
юм шиг байх чинь. Мой Драбовскийг  
гаргачихлаа ... Кабийн менежер Боб  
Шеффинг шүүгчтэй ярьж байна ... за  
хэн гарч ирэхийн цөмөөрөө харцгаая  
... энэ бол Говард Келлер байна! (уг  
нь Howard гэснийг Ховард гэж  
бичмээр, орчуулагч анхнаасаа  
Говард гэсэн болохоор тэрүүгээр нь  
больё) Келлер цохигчийн талбар луу  
алхаж явна, үзэгчид уухайлан

хашгирч байна!" гэж хэлэв. Тэрээр үргэлжлүүлэн "Дэлхийн шилжин явах цомын төлөө тэмцээний бүх л ачаа энэ залуухан тоглогчийн мөрөн дээр байна даа. Тэр агуу Мики Мэнтлийн эсрэг шидэж чадах бол уу? Бид үүнийг хормын дараа мэдэх болно! Келлер одоо талбар дээр гарлаа ... тэрээр байрлалаа эзэлсэн тоглогчдыг тойруулан харлаа ... гүнзгий амьсгаа аван цохиураа өргөн бэлдлээ. Цохилоо ... Мэнтл цохиураа өрлөө ... эргүүллээ ... алдлаа! Нэг шидэлт амжилттай!" гэв.

Үзэгчид нам гүм болов. Мэнтл бага зэрэг урагшлан зогсоод, царай нь ширүүн болж цохиураа бэлдэн

өргөлөө.

Говард гүйгчдийг шалган харав. Өөрт нь маш их ачаалалтай байсан ч тэр чөлөөтэй тайван байлаа. Баригч руугаа дохио өгөхийг харахаар эргээд дараа нь шидэхээр бэлдэн гараа өрлөө.

"Тэрээр өрлөө, шидлээ!" гэж тайлбарлагч хашгирав. "Энэ бол Келлерийн алдарт, эргэлттэй бөмбөг боллоо доо ... Мэнтл цохилоо, алдлаа! Хоёр дах шидэлт амжилттай! Хэрвээ залуу Келлер дахин Микийг алдуулбал Чикаго Каб Дэлхийн аварга боллоо гэсэн үг! Бид Дэвид, Голиат нарыг харж байна,

ноёд хадагтай нараа! Залуухан  
Келлер том лигд тоглоод дөнгөж нэг  
жил л болж байгаа, харин тэр энэ  
хугацаанд атаархмаар нэр алдрыг  
Мики Мэнтлийг Голиат болгосноор  
авчирлаа ... (Дэвид, Голиат хоёр гэж  
нэг нь аварга биет, нөгөө нь үлэмж  
биетнүүд, хоорондоо тулалдан  
жигиг нь ялдаг үлгэр юм байна)  
Бяцхан Келлер түүнийг давж чадах  
болов уу? Бүх юм дараагийн  
шидэлтээр шийдэгдэнэ."

"Келлердахин гүйгчдээ шалган  
харлаа ... за одоо өрлөө ... шидлээ!  
... эргэлттэй шидэж ... Мэнтл  
эргэлттэй ирсэн бөмбөг цохигчийн  
талбарын яг зүрхэнд ирснээс онож

чадсангүй алдлаа ... Гурав дах  
шидэлт амжилттай!" гэж  
тайлбарлагч ориллоо. "Мэнтл  
хожигдлоо! Хүчит Мик алдлаа, ноёд  
хадагтай нараа! Залуухан Келлер  
агуу Мики Мэнтлийг давлаа! Тоглолт  
дууслаа, Цом Чикаго Кабуудад  
очлоо! Хөгжөөн дэмжигчид  
хашгиралдан, улайрч бүгд  
суудлаасаа бослоо!"

Талбай дээр Говард Келлерийн  
багийнхан түүн рүү уралдан очиж  
баярлалдан, түүнийг мөрөн дээрээ  
өргөн талбай дундуур авч ...

\* \* \*

"Говард, ингэхэд чи юу хийгээд байна?"

"Гэрийн даалгавар л даа, ээжээ" гээд арван таван настай Говард Келлер гэмшингүйгээр зурагтаа унтраав. Тоглолт ямар ч байсан алга болчихгүй л байлгүй.

Бейсболл бол Говардын хүсэл тэмүүлэл, түүний амьдрал байв. Хэзээ нэгэн өдөр тэрээр үндсэн лигт орж тоглох болно гэдгээ мэддэг байлаа. Зургаан настайдаа өөрөөсөө хоёр дахин илүү настай хүүхдүүдтэй стикболл тоглодог байсан бол арван хоёртойдоо Америкийн Легион багийн шидэгч болсон байв. Түүнийг



арван тавтай байхад Чикаго Кабууд багийн дасгалжуулагчид залуу хөвгүүний тухай түүний хэвлэлийн төлөөлөгч ингэж хэлэв. "Би түүн шиг тоглогчийг хэзээ ч хараагүй. Энэ хүүд сулавтар гулсуулдаг боловч гарамгайгаар эргүүлдэг чадвар байна, харин сайжирсных нь дараа хараад чи лав итгэхгүй дээ."

Дасгалжуулагч итгээгүй ч дуртай дургүйхэн "За яахав, би харъя л даа" гэлээ. Тэр Говард Келлер тоглож байгаа Америкийн Легионы тэмцээн дээр очиж түүний тоглож байгааг хараад бодол нь шууд өөрчлөгдөв. Тоглолт дууссаны дараа хүүг хайж олоод түүнээс "Чи өөрийн

амьдралдаа юу хиймээр байна даа хүү минь" гэж асуухад Келлер " Бейсболл тоглоно доо" гэж хурдхан хариулав. "Үүнийг сонсохдоо би тун баяртай байна. Чиний манай өсвөрийн багт тоглох гэрээг чинь хийх болно." гэлээ.

Говард энэ сайхан мэдээг эцэг эхдээ хурдан хэлэхээс тэсч ядаж байв.

Келлерийнхан Католик шашныг нарийн чанд шүтдэг гэр бүл бөгөөд Ням гариг бүр сүмд мөргөхөөр явдаг, тэдний хүү ч мөн адил очдог байлаа. Эцэг Говард Келлер ажил хэрэг нь өсч яваа бичгийн машины худалдаачин юм.

Тэрээр гэртээ байх үедээ аль болох их цагийг хүүтэйгээ хамт өнгөрөөхийг хичээнэ. Хүү Говард эцэг эхийн хоёрынхоо алинтай нь ч адил ойр дотно байдаг. Ээж нь хүүгийнхээ сонирхолд нилээн ач холбогдол өгөн тоглож байгаа тэмцээн болгон дээр дэмжихээр очно.

Говард зургаан настайдаа бейсболлын анхныхаа дүрэмт хувцас, бээлийг авлаа. Тэр бол бейсболлыг жинхэнэ шүтэн бишрэгч юм. Бейсболлын тоглолтуудын статистик мэдээллийн талаар, тэр ч байтугай өөрийнхөө төрөхөөс өмнөх үеийн хувьд ч нэвтэрхий толь л гэсэн

үг. Тэрээр хожилд хүргэсэн шидэлт, цохилт, бөмбөг барьж авсан бүхий л тоо мэдээ, ялалт, ялагдал, торгуулийн тоонуудаш цээжээр мэддэг байлаа. Сургуулийнхаа хүүхдүүдтэй мөрийцөн шинэхэн шидэгчээс авахуулаад тухайн багт орох гэж байгаа гишүүдийн нэрсийг тоочоод мөрийгөө авна.

"Арван ес дөчин ес"

"Өө энэ чинь амархан ш дээ" гэж Говард хэлэв. "Доджеруудийн Ньюкомб, Рой, Хаттен болон Бранка. Янкуудын Рейнолдс, Раши, Бирнэ болон Лопат."

"За яахав" гээд нэг багт байдаг хүүхэд үргэлжлүүлэн "Үндсэн Лигийн түүхэнд хамгийн олон дараалан хэн тоглосон бэ?" гэж Гиннесийн амжилтууд номыг харангаа шалгаав.

Говард Келлер бодсон ч үгүй шууд "Луй Гэйриг-хоёр мянга нэг зуун гуч" гэлээ.

"Хэн хамгийн олон удаа бөмбөг барьж авсан бэ?"

"Уолтер Жонсон-нэг зуун арван гурав"

"Хэн өөрийн карьерийн туршид хамгийн олон удаа үүрэндээ ирэх

цохилт хийсэн бэ?"

"Бэйб Рут-долоон зуун арван дөрөв"

Залуу тоглогчийн ур чадварын сураг чимээ тархан, мэргэжлийн дасгалжуулагчид Чикаго Кабууд өсвөрийн лигийн багийн тоглолтын үзээд мэл гайхсан байна. Келлерийг арван долоотой байхад түүнд Сэнт Луис Кардиналууд, Балтимор Ориолууд болон Нью Йорк Янкууд багийн дасгалжуулагчид ханджээ.

Говардын аав хүүгээрээ маш их бахархаж "Хүү минь яг л над шиг байна шүү" гээд тэвэрлээ. Тэгээд "Би залуу байхдаа бас бейсболл

тоглодог байлаа" гэв.

Ахлах сургуулийн төгсгөлийн жилийн зун Говард Келлер Америкийн Легион багийн ивээн тэтгэгчдийн нэгний мэдлийн банкинд туслах мэргэжилтнээр ажиллаж эхэллээ.

Говард нэг сургуулийн царайлаг хөөрхөн охин Бэтти Кьюнлан дотносож эхлэв. Тэд сургуулиа төгсөөд гэрлэх нь бүгдэд тодорхой байлаа. Тэрээр Бэттитай хамт байхдаа бүтэн цагаар ч хамаагүй бейсболлын тухай ярихыг тэр тэвчээртэйгээр анхаарал тавин сонсоно. Говард бейсболлын нэртэй тамирчдын онигоонд маш дуртай,

тэгээд шинийг аль хэдийн олоод мэдчихсэн Беттид ярьж өгдөг байв. Жишээ нь: ""Удирдлагын гол нууц бол эргэлзээтэй байгаа таван залуугаас чамайг гаргаж хаяхаар үзэн ядаж байгаа тавыг авч үлдэхэд байгаа юм" гэж Каси Стингэл хэлжээ." "Нэр хүн Ёоги Бэррагаас цаг хэд болж байгааг асуухад "Чи яг одоогийнхийг асуув уу? гэжээ." Хэн нэг тоглогч шидсэн бөмбөгөөрөө мөрийг нь оноход багийн нэг нь "Гэмтээгүй ч өвдөж байгааг нь тооцохгүй бол түүний мөр нь яагаа ч үгүй ээ."

Залуу Келлер өөрийгөө тун удахгүй агуу тоглогчдын манлай нь болно



гэдгээ мэдэж байлаа. Гэвч Бурхан түүнд амьдралын өөр замыг сонгуулсан юм.

Нэгэн өдөр Говард нэг багт тоглож байсан, түүний сайн найз Жэсситэй хамт сургуулиасаа ирэхэд захиа түүнийг гэрт нь хүлээж байлаа. Захиануудын нэг нь Харвардын Их сургуулийнх нөгөө нь Принцтоны бейсболлын тэтгэлгийн санал байв.

"Хөөх, ямар мундаг юм бэ!" гэж Жэсси хэлээд "Баяр хүргэе!" гэв. Түүний хувьд Келлер бол шүтээн нь болсон байлаа.

"За чи тэгээд алийг нь сонгох гэж

байна даа?" гэж аав нь асуухад

"Би ер нь коллежид сурахын хэрэг байгаа юм уу?" гэж Говард гайхсан байдалтай хэлээд үргэлжлүүлэн "Намайг аль нэг шилдэг багт авчих байхаа" гэв.

Ингэж хэлэхэд ээж түүнд хатуухан шиг "Хүү минь, үүнд чинь зөндөө цаг гарна. Харин чи эхлээд сайн боловсролтой болох хэрэгтэй, дараа нь чи бейсболл тоглох ч юмуу өөрийн хүссэн зүйлээ хийж болно ш дээ." гэлээ.

"За тэгье дээ." гээд Говард "Харвард. Бэтти Уиллэслей руу явна, тэхээр би

түүнд ойр байж чадна." гэж хэлэв.

Бэтти Кьюланд юу гэж шийдсэнээ Говардыг хэлэхэд тэрээр маш их баярлан "Тэгэхээр амралтын өдрүүдээр хоюулаа байнга уулзалдаж байх нь" гэв. Түүний дотны найз Жэсси "Би ч чамайг их үгүйлэх байх даа." гээд уруу царайллаа.

Келлерийн их сургуульд сурахаар авахаас нэг хоногийн өмнө аав нь нэгэн үйлчлүүлэгчийнхээ нарийн бичгийн даргатай хамт хаашаа ч юм зугтан гэрээсээ дайжжээ.

"Тэр яаж ингэж чадав аа!" гэхээс

өөрийг залуу хүү хэлж чадсангүй,  
маш их гайхан цочирдов. Ээж нь ч  
мөн цочирдон "Тэр ... тэр амьдралаа  
өөрчлөхөөр ингэх хэрэгтэй байсан  
юм гэж үү ...", "Чиний аав ... аав чинь  
надаа маш их хайртай ш дээ ... Тэр  
эргэж ирнээ ... ирнэ. Чи хараарай ..."  
гэж ээрэн үглэлээ.

Хэд хоногийн дараа Говардын ээж  
Ноён Говард Келлерийн  
өмгөөлөгчөөс гэр бүл салах тухай  
захиа хүлээн авлаа. Захианд түүний  
үйлчлүүлэгч нь гэр бүлээ албан  
ёсоор салгуулахыг хүссэн, мөн  
хүүхдийн тэтгэлэг өгөх мөнгөгүй,  
харин жижиг байшингаа эхнэртээ  
өгөхийг зөвшөөрсөн гэсэн байв.

Одоо Говардын нуруун дээр түүний ээжийн амь амьдрал бууж ирлээ. "Ээж минь дээ, санаа зовох хэрэггүй дээ. Би тантай үлдэж, таныг асрах болно" гэж санаа тавин хэлэхэд ээж нь "Үгүй ээ, надаас болж чамайг сургуулиа орхихыг би хүсэхгүй байна. Чамайг мэндэлсэн өдрөөс эхлээд аав чид хоёр чинь чамайг их сургуульд сургана гэж төлөвлөсөн юм." гээд хэсэг чимээгүй байснаа "За за энэ талаар өглөө ярилцъя даа, ээж маш их ядарч." гээд өрөө рүүгээ орлоо.

Говард шөнөжин унталгүй өөрийн сонголтын талаар бодлогошров. Тэрээр бейсболлын тэтгэлгээр

Харвардад сурч болно, эсвэл үндсэн Лигт тоглох аль нэг саналыг хүлээн авч ч болох юм. Гэвч энэ хоёр замын алийг ч сонголоо гэсэн ээжийгээ ганцааранг нь үлдээх болно. Энэ л хамгийн хэцүү шийдвэр байлаа.

Маргааш өглөө нь ээжийгээ өглөөний ундаа уухаар өрөөнөөсөө гарч ирэхгүй болохоор өрөөнд нь орвол ээж нь нэг юм руу гөлийн харсан чигтээ орон дээрээ хөдөлгөөнгүй сууж байв. Түүнийг дайрлага дайрчээ.

Тэр хоёрт эмнэлэгт хэвтэх, сайн эмчид үзүүлэх мөнгө байсангүй, Говард буцаад банкиндаа бүтэн

цагаар ажиллах болов. Дөрвөн цагт ажлаа тараад эхийгээ асрахаар гэрлүүгээ яаран ирнэ.

Эмч ээжийг нь үзээд арай хөнгөвтөр дайрлага байсан байна, хэсэг хугацааны дараа гайгүй болно гээд "Тэр маш хүнд цочролд оржээ, гэхдээ тэр сайжирч магадгүй." гэв.

Энэ хугацаанд үндсэн лигийн дасгалжуулагчдаас түүн рүү санал тавин утасдсаар байлаа, гэвч тэр хэзээ ч ээжийгээ орхиж чадахгүй. Ээжийгээ эрүүл болохоор би болно доо гэж өөрийгөө тайвшируулна.

Эм, эмчийн төлбөрийн хуудас ар

араасаа ирсээр.

Бэтти Кьюлан эхэндээ долоо хоногт нэг удаа утсаар ярьдаг байснаа хэдэн сарын дараа цөөрсөөр, сүүлдээ бүр таг боллоо.

Говардын ээж ер сайжрахгүй байлаа. Эмчийг ирж үзэхэд нь "Тэр хэзээнээс хэвийн болэ эхлэх бол?" гэж асуухад "Яг ийм нөхцөл байдалд тодорхой хэлэх тун хэцүү хүү минь, Тэр хэдэн сар, магадгүй хэдэн жил ч ингэж байж магадгүй. Тодорхой хэлж чадахгүй нь, уучлаарай!" гэж хариулав.

Нэг жил өнгөрч дараагийн жил



гарлаа, Говард эхийгээ асран түүнтэй хамт амьдарч, банкиндаа ажилласаар. Нэгэн өдөр Бэтти Кьюланаас тэрээр өөр залууд сэтгэлтэй болсон, мөн ээжийг нь сайжирна гэдэгт итгэж байна гэсэн захиа хүлээн авав.

Дасгалжүүлэгчдын ярих нь багассаар тэгсээр бас таг болов. Говардын амьдрал зөвхөн ээжийгээ асрахад л төвлөрнө. Дэлгүүр явж хүнс цуглуулан, хоол хийж, хажуугаар нь ажлаа хийнэ. Түүнд бейсболлын талаар бодох ч цаг байсангүй. Өдөр бүрийг ингэж өнгөрөөх нь түүнд үнэхээр шаналалтай байлаа.

Ээж нь дөрвөн жилийн дараа нас

барахад Говард Келлер бейсболлыг сонирхохоо больсон байлаа. Тэр одоо жинхэнэ банкир болсон байв.

Түүний бейсболл дах нэр алдрын боломж алга болжээ.

## Есдүгээр бүлэг.

Говард Келлер, Лара хоёр оройн  
хоол идэж суугаад,

-Юунаас эхлэх вэ? гэж Лара түүнээс  
асуув.

-Мөнгөөр цохиж авч болох  
шилдэгийн шилдэг  
мэргэжилтнүүдийн багийг цуглуулья.  
Нэн түрүүнд бидэнд үл хөдлөх  
хөрөнгийн хэлэлцээрт мэргэшсэн  
чадмаг хуульч шаардлагатай.

Тэр ах дүү Даймондуудтай хийх  
гэрээг бэлтгэнэ. Дараа нь дээд  
зэргийн архитектор хайна даа.

Миний санааны мухарт нэг хүн бий.  
Эцэст нь барилгын компанийн ээлж.  
Би чөлөө заваараа хэр тааруу  
тооцоо хийсэн, зочид буудлын  
өрөөнүүдэд гурван зуугаад мянган  
доллар хангалттай хүрэхээр юм  
билээ. Нийт засварын ажилд долоон  
сая орчим доллар орохоор байна.  
Зүй бус алдаа гаргачихгүй бол ажил  
ч гялалзана даа.

Архитекторыг Тед Таттл гэдэг бөгөөд  
ерөнхий саналтай танилцсан тэрээр  
инээмсэглэн хараад,

-Бурхан таныг ивээг. Би аль эртнээс  
ийм санаа хүлээж байсан сан гэжээ.

Арав хоногийн дараа гэхэд бэлэн болсон дотоод тохижилтын ноорог зураглалыг үзээд, мөрөөдөл нь баттай бодит зүйл болсныг Лара ойлгосон байна.

-Одоогийн байдлаар зочид буудал 125 өрөөтэй. Таны зааварчилгааг даган, би тоог нь далан тав хүртэл цөөлсөн шүү.

Зузаан батум цаасан дээр гурван тасалгаа бүхий тавь, хорин таван люкс өрөө байхаар тооцоологдон зураг нь гарчээ.

-Гайхамшигтай! гэж Лара Татлын ажлыг үнэлэн, зураглалыг Говард

Келлерт өгөхөд,

-Ажилдаа орцгооё! Би хэзээний гүйцэтгэгчтэй уулзахаар товлочихсон байгаа. Түүнийг Стив Райс гэдэг юм хэмээн мань эр урам орон хэлжээ.

\* \* \*

Чикаго хот даяар Стив Райсыг алтан гартай, ховорхон заяадаг мэргэжилтэн гэж үздэг аж. Тэрбээр Ларад шударга, илэн далангүй эрчүүдийг бодитойгоор ойлгох сэтгэл татам мэдрэмжийг ойлгуулж өгчээ.

-Говард Келлер танай компанийг

хотын шилдэг нь гэсэн шүү.

-Тэр ч тийм шүү. Компанийн маань уриа "Бид айсуй цагийн хүмүүст зориулан босгож байна" гэдэг юм.

-Чихэнд чимэгтэй сонсдож байна.

-Гэхдээ би үүнийг дөнгөж сая л бодож олсон юмаа.

Эхний алхам нь зайлшгүй шаардлагатай техникийн баримт бичгийг бэлтгэх явдал байв. Шинээр хийх, барих юм болгоныг нарийвчилсан зураглалыг гарган, хуулбарыг ган цувих, чулуучин, хаалга цонхон эдлэлийн

үйлдвэрлэгч, цахилгаанчид гээд  
тоймлон хэлбэл бараг жар шахам  
гэрээт үйлдвэрлэгчид рүү илгээв.

Бичиг цаасны сунжирсан ажил  
дуусмагц Говард Келлер Ларатай  
анхны шаваа тавьсны баяраа  
тэмдэглэхээр удирдлагаасаа хагас  
өдрийн чөлөө гүйжээ.

-Банк чиний хүсэлтэнд татгалзсангүй  
гэжүүү? хэмээн Лара асуув.

-Үгүй. Энэ чинь ажлын маань  
үргэлжлэл л дээ.

Говард өнгөрсөн жилүүдэд сүүлчийн  
удаа хэзээ ийнхүү бүсгүй хүний



дэргэд сэтгэлийн цэнгэл эдпэн  
байснаа таг мартжээ. Тэрээр  
Ларагийн дэргэд байхдаа түүнийг  
харах бүрийд, дууг нь сонсож суух  
бүрийдээ туйлын жаргалтай байлаа.  
Гэтэл: Түүний гэрлэх талаар юу гэж  
боддогийг нь мэдвэл сайхансан  
гэсэн нэгэн бодол залуугийн амар  
заяаг нь үзүүлэхгүй байв.

-Өнөөдрийн мэдээнд тэнгэр  
баганадсан өндөр Сирс-таур бараг  
бэлэн болсон тухай дурьдсан байна.  
Санаанд баггамгүй жигтэй хэрэг шүү,  
зуун арван давхар, дэлхийн хамгийн  
өндөр барилга! -Энэ ч үнэн шүү.

-Говард аа, би хэзээ нэгэн цагт

түүнийг нулимж орхино доо, харж л байгаарай.

Бүсгүйг хэдийнэ мэдэх болсон  
Келлер түүнд итгэлээ.

\* \* \*

Тэд "Уайтхолл" рестораны зоогийн ширээний ард Стив Райстай сууж байлаа.

-Одоо та нар юунаас ажилаа эхлэх вэ? хэмээн Лара барилгачинаас асуухад цаадах нь,

-Одоо бид жинхэнэ дотоод тохижилтондоо орцгооно.

Ерөнхийдөө цонх, хаалга, угаалгын өрөөний зэвүү хүргэм гантигаас бусдыг нь хэвээр үлдээнэ.

Цахилгааны шугамыг үндсээр нь шинэчлэж, ус дамжуулах хуванцар хоолой тавина даа. Бэлтгэл үе шатаа дуусмагц бид таны зочид буудлыг барьж дуусгах болно хэмээн инээмсэглэн өгүүлэв.

-Хэдэн хүн ажиллах вэ?

Стив Райс тас тас хөхөрч,

-Бүхэл бүтэн арми ажиллана даа, Камерон авхай. Нэг бригад цонх, нөгөө нь угаалгын өрөө, гурав дахь нь шал янзлана даа. Хүмүүс нэг

давхраа дуусгамагц дараагийнх руугаа орцгооно доо, гэхдээ тэд голдуу дээрээс доод давхар руу явдаг юм. Төсөлд хоёр ресторан, өрөөний үйлчилгээ байсан байхаа? гэлээ.

-Тийм ээ. Үүнд хэр зэргийн хугацаа шаардах вэ?

-Тооцоогоор заслаа хийж дуусгаад тавилгаар тоноглоход нийтдээ арван найман сар болж байсан даг.

-Сайн цалин пүнлүү амлавал нэг жилийн дотор амжуулж чадна биздээ.

-Сонсоход чимэгтэй байна.

"Конгресс" ном ёсоороо...

-Би өөр нэр өгнө. Зочид буудлыг

"Камерон-Палас" гэж нэрлэнэ гэснээ

Лара гэнэт тэчьядан чичирхийлэхээ

мэдрэв. Эцгийнх нь нэрийг дэлхий

дахинаа мэдэх болно!

Сэргээн засварлах ажил бороо

шаагисан есөн сарын өглөө үүрээр

эхэллээ. Лара барилгачид үүдэн

өрөөний гантиг хананаас тоос тортог

болсон шаваасыг ховхлохыг харж

зогсов. Гэнэт орох хаалгаар Говард

Келлер орж ирэхийг анзаарсан

бүсгүй гайхан,

-Чи яасан эрт босоо вэ? гэж асуув.

-Зүгээр л нойр хулжаад. Миний бодоход бид агуу их хэрэг явдлын босгон дээр зогсож байна шүү.

\* \* \*

Яг арван хоёр сарын дараа гэхэд "Камерон-Палас" өрхөө татан, үүдээ нээлээ. Хэвлэлийнхэн баланд шунасан баавгай мэт улайран шаагилдацгааж, нэгэн уран барилгын шүүмжлэгч "Чикаго трибюн" сэтгүүлд:

"Эцсийн эцэст хот маань гэр орноосоо хол яваа улсад

зориулагдсан "гэр" нь болсон  
жинхэнэ зочид буудалтай болжээ.  
Бидний амьдралд шийдмэгээр  
алхан орж ирсэн Лара Камерон  
хамгийн онцгой анхаарлыг хүртэх..."  
хэмээн бүсгүйн чадварыг сайшаасан  
байлаа.

Сарын дараа гэхэд зочид буудал  
ганц ч сул өрөөгүй болж,  
үйлчлүүлэхийг хүсэгчдийг бүртгэсэн  
уртын урт дараалал үүсчээ.

Келлер илт урам орон,

-Ийм үнэтэй байхад арван хоёр  
жилийн дараа гэхэд бүх зардлаа  
нөхчих юм байна. Гайхалтай хэрэг!

Бид...

-Дэндүү удаан байна. Хөлсөө нэмнэ гэж Лара хэлэв.

Говард үл итгэсэн янзтай уруулаа жимийв.

Үүнийг нь анзаарсан бүсгүй,

-Санаа зовохын хэрэггүй. Бид зээлээ төлцгөөнө, тун ч баяртайгаар төлнө дөө. Тэд хаанаас хоёр ханан зуух, саун, төгөлдөр хуур, тохь тухтай орчныг олох вэ?

Хоёр долоо хоног өнгөрлөө. Боб Вэнсийн өрөөнд хүрч ирсэн Лара



босго алхав уу үгүй юу Келлертэй хамт зогсож буй өрөөний эзэнд хандан,

-Би зочид буудал барих өөлөхийн эцэсгүй бас нэг гоё газар оллоо. Энэ нь яг "Камерон-Палас" шиг гэхдээ үл ялиг том, бас нилээд хээнцэр байх юм хэмээн яагаад ч цааргалахын эцэсгүй өнгөөр дуржигнуулан хэлэхэд нь, Келлер жуумалзан, - Очиж үзэхэд бэлэн гэжээ.

Үнэндээ ч сайхан газар байсан боловч үл ялиг асуудал тулгарчээ. -Та нар хожигджээ. Денгөж өнөө өглөөхөн барилгын бизнес эрхэлдэг Стив Мерчисон гэдэг нэгэн хүн

ирээд, барилгыг худалдан авах санаатай байгаагаа дуулгасан хэмээн брокер нь Ларад мэдэгдэв. - Тэр хэдийг санал болгосон бэ? - Гурван саяыг.

-Танд дөрвийг өгье. Бичиг баримтаа бэлдэж болно. Ахиу үнэ дуулсандаа сандарч тэвдсэн брокерийн нүд нь дүрлийн гялалзаад,

-Зөвшөөрч байна хэмээн түгдчив.

Маргааш нь Ларагийн амьдарч байгаа өрөөнийх нь утас хангинан дуугарлаа.

Тэрээр харилцуур авбал.

-Лара Камерон уу? гэх эр хүний  
бачимдсан баргил хоолой сонсдов. -  
Тийм байна.

Стив Мерчисон ярьж байна. Муу  
гичий минь, ганц удаа чи занганаас  
заяатай гарав гэж мэдээрэй. Чи  
юунд хүзүү толгойгоороо  
холбогдсоноо мэдэхгүй л байх шив.  
Гэхдээ одооноос эхлээд миний  
улаан замд хөндөлдөхгүй байхыг  
хичээж үзээрэй. Эс бөгөөс харамсах  
болно шүү.

Харилцуурт утасны тасалданги дуу  
ёнгинов.

1974 он үйл явдлаар дүүрэн жил

боллоо. Парламентын дээгүүр албан тушаалтнуудыг шүүхэд татдаг журмаас зайлсхийх гэхдээ ерөнхийлөгч Никсон огцорч цагаан ордон дахь түүний суурийг Жералд Форд эзэлжээ. ОПЕК-ын орнууд Баруунаас нефть нийлүүлэхийг хүчингүй болгон, Аргентин улсын ерөнхийлөгчийн суудалд Жабель Перон залрав.

Харин Лара "Чикаго-Камерон-Палас" гэгдэх хоёр дахь зочид буудлынхаа барилгын ажлыг эхэлж, хагас жилийн дараа гэхэд зочид буудлын ажил дуусан, шинэхэн барьсан буудал нь даруй олныг шагшин гайхуулсан газар болжээ. Нэр

хүндтэй "Форбс" сэтгүүлд "Лара Камерон өөрийн бас нэгэн гайхалтай чадвараа үзүүллээ. Түүний үзэл бодол зочид буудлын утга учирьг уг үндсээр нь өөрчилжээ. Камерон авхай цэвэр эрчүүдийн гэх бизнест зоримгоор цөмрөн орсон, төдийгүй сэтгэл татам авхай маань эрчүүдээс хавьгүй илүү, бардаагаар өлхөн ханхалзаж чадах дайчин төлөөлөгч болохоо баталлаа" хэмээн цохон тэмдэглэжээ.

Шөнө оройхон Чарлз Коэн утасдан,

-Баяр хүргэе. Надад ийм ивээгдэгч хэзээ ч байгаагүй юм шүү гэхэд нь,

-Харин надад хэзээ ч ийм багш байгаагүй. Чарлз аа, би тангүйгээр юунд ч хүрч чадахгүй байсан шүү гэж Лара талархвал Коэн эрс татгалзан,

-Битгий дэмий ярь. Яаж ийгээд болох л байсан гэжээ.

1975 онд Питер Бенчлийн "Эрүү" гэдэг сүнс сүгийн тухай ном улсын оршин суугчдыг ихээхэн цочирдууллаа. Дэлхийн хүн ам дөрвөн миллиардад хүрсэн тухай тэмдэглэжээ. Жеймс Хоффийн тээврийн жолооч болон агуулахын ажилчдын үйлдвэрчний эвлэлийн удирдагч ор сураггүй алга болжээ.

Сониноос дөрвөн миллиард оршин  
суугчдын тухай олж уншсан Лара,

-Ийм тооны хүний нийгэмд хэдий  
хэрийн орон сууц шаардлагатайг чи  
тооцоолж чадах уу? гэж Келлерээс  
асуув.

Бүсгүй үнэнээсээ ярьж байгаа эсвэл  
хошигнож буйн алин болохыг  
Говард тэр даруй ойлгосонгүй.

\* \* \*

Дараагийн гурван жилийн хугацаанд  
олон өрөө бүхий дутуу гучуу зүйлгүй  
тансаг хэд хэдэн орон сууц  
сүндэрлүүлээ.

-Би одоо өөрийгөө оффисийн уран барилгад сорьж үзмээр санагдана. Энэ маань Петлийн гол цөм нь болог хэмээн Лара Келлерт саналаа хэлбэл,

-Яг одоо зах зээл дээр хорхой хөдлөм үл хөдлөх хөрөнгө зарагдах гэж байна. Хэрэв тэр чамд тохирно гэвэл банк санхүүжилт хийхэд бэлэн гэлээ.

Үдийн хоолны дараа тэд нөгөө газрыг үзэхээр явцгаав. Зарагдах гэж буй барилгын нүүрэн талд нь нуурын мандал харагдаж, үүнээс илүү атаархмаар газар мөрөөдөхийн ч хэрэггүй ажээ.



-Ямар үнэтэй гэлээ? хэмээн Лара сонирхлоо.

-Би үнийг нь үзсэн. Зуун хорин сая доллар юм билээ.

Бүсгүй сүүрс алдан шүлсээ гүдхийтэл залгин,

-Аймаар юм! хэмээн уулга алдав.

-Лара минь, үл хөдлөх хөрөнгийн бизнест "Зээл" гэдэг нэгэн ид шидтэй үг байдаг шүү дээ.

Лара тэр нэгэн цагт сонссон Б. Х. М буюу Бусад Хүмүүсийн Мөнгө хэмээн Билл Рожерсийн ярьж байсныг эргэн

саналаа. Бурхан минь, тэр цагаас хойш хичнээн жил өнгөрч, ямар их юм өөрчлөгдөө вэ!

Гэхдээ зөвхөн эхлэл. Ердөө л эхлэл гэсэн бодол тархинд нь жирсхийн орж ирэв.

-Ихэнх барилгын гүйцэтгэгч нар гар дээрээ сохор зоос ч үгүй байж яаж ийгээд л эрхэм дээдийг барьж босгодог номтой. -Би бодож байна.

-Уг санаа нь нэг бол түрээсээр өгөх эсвэл барилгыг дам худалдвал зээлээ дараад өөртөө хэдэн юм унагаж, дээр нь банкнаас нэмж зээлээд өөрийг худалдаад авчихна

гэсэн үг л дээ. Энэ чинь хөмөрсөн пирамид үл хөдлөх хөрөнгийн пирамид л гэсэн үг. Үүнийг хамгийн наад захын зардлаар босгоно.

-Ойлгож байна, ойлгож байна хэмээн Лара шивнэв.

-Мэдээж, чи дээд зэргээр хянамгай байх ёстой. Пирамидыг эхлээд цаасан дээр босгоно, өөрөөр хэлбэл ноороглоно гэсэн үг. Хэрэв нэг л юм санаанд нийцэхгүй, шинэ хөрөнгө оруулалтаас орж ирэх ашиг чинь авсан өрөө төлж чадахгүйд хурвэл пирамид нурж чамайг өөрийнхөө дор булшилж орхино.

-Ойлгомжтой. Тэгэхээр би ямар замаар энэ барилгыг өөрийн болгох вэ?

-Хамтарсан байгууллага байгуулах талаар би Вэнстэй ярилцъя. Хэрэв манай банк хүчрэхгүйд хүрвэл, даатгалын компани юм уу нөхдөөсөө зээл авья. Худалдан авч буй барилгынхаа барьцаанд чи тавин мянган доллар авна. Хамаг боломжийг шавхаад чи ирээдүйн ашигийн арван хувийг зээл олгогчдод өгөх ёстой. Ийм мөнгөний төлөө дуртайяа чиний хамтран зүтгэгч болно. Хууль ёсоор чи барилгыг өөрийн өмчид тооцож цаашилбал санхүүг захирч чадах юм.

Лара түүний үг бүрийг нь уудаг цаас мэт өөртөө шингээж байлаа.

Хөөе, чи намайг сонсож байна уу?

-Сонсож байна.

-Тав зургаан жилийн дараа гэхэд барилгын түрээсийг цуцалж, гүйлгээнд оруулан далан таван сая доллараар заран зээлээ төлөхөд чи халаасандаа дор хаяж арван хоёр сая доллартай үлдэнэ.

-Итгэмээргүй юм! Келлер жуумагнан,

-Чиний мөнгө амжилттай өсгөж

байгаа нь засгийн газарт ашигтай шүү дээ, Лара гэв.

-Тэгвэл чи энэ ажлаар хөөцөлдөхгүй юу, Говард аа!

-Өршөөгөөрэй, юу гэв ээ?

-Бид хамтарч ажиллаж болно гэж хэлэх байна. Гэнэт Келлерын ам арган хуурайшиж, яг одоо гаргах мөнгөтэй огтын холбоогүй түүний шийдвэрээс хойчийн амьдрал нь хамаарах биз . Ларатай хамтарч ажиллах нь байна. Тэрээр бүсгүйд хайртай! Өдийг хүртэл хичээн оролдоод хэлж зүрхлэхгүй байгаа урам нь хугарсан тэр нэгэн

оролдлогоо хэлдэг газар ч мөн дөө.  
Тэрээр толины өмнө зогсон хэлэх  
үгээ бэлтгэж бүхэл шөнийн турш  
нойргүй хоносон атлаа өглөө нь  
Ларагийн гоо үзэсгэлэнт дүрийг  
хармагц хаа нэг зүг рүү харж  
хулмалзан "Би чамд хайртай!"  
хэмээн аман дотроо хэлэхчээн  
аядана. Говардын амнаас үүнээс өөр  
ганц ч үг үл унах ажээ. Лара,

-Алив хөө, хоёул энэ жишиг зургийг  
үзье хэмээв. Келлерт үг хэлэх эр  
зориг дутжээ.

Гэтэл одоо бүсгүй хамтрагчаа  
болооч хэмээн санал тавьж өдөр  
болгон мөр зэрэгцэн ажиллах авч

түүнд хуруугаа... хүргэж үл зүрхлэнэ.

-Говард аа, чи миний хүчинд итгэж байна уу?

-Хэрэв тиймгүйсэн бол би харалган байж таарна биз.

-Шинэ цалин одоогийнхоос чинь хоёр дахин өсгөж, дээр нь нийт ашгаас таван хувийг нэмнэ.

-Болох л юм... Би бодож болох уу?

-Юугий нь бодох гэв? Ингээд Келлер ч зөвшөөрчээ.

-Хэлэх ч үг алга...



Лара туунийг мөрлөн түлхээд,

-Тун догь! Хоёулаа ихийг барьж  
босгоно! Чикагод олон аймшигтай  
барилга байна. Барилга болгон нь  
хотын енгө төрхийг шагшин  
магтуулах ёстой гэлээ.

Келлер бусгүйн гарыг атган,

-Лара, гагцхүү бүү няцаарай гэвэл  
бусгүй,

-Хэзээ ч үгүй хэмээн бардам өгүүлэв.

## Аравдугаар бүлэг.

Далаад оны сүүл үеийн эдийн засгийн тогтворгүй өсөлт, далайцтай өөрчлөлт, олон улсын хамтын нийгэмлэгүүдийн тухайд бүрэн ойлголцол сэргэсэн он жилүүд болжээ.

1976 онд Израильчууд "Энтебби"-д явуулсан ажиллагаа амжилтгай өндөрлөж, Хятадад Мао Цзэдун нас нөгчиж, харин Жеймс Картер АНУ-ын гучин ес дэх ерөнхийлөгчөөр сонгогджээ.

1977 онд Чарльз Чаплин, дуучин Элвис Пресли нар ертөнцийн мөнх

бусыг үзжээ.

Лара Чикаго хотод худалдааны асар том цогцолборын барилгыг барьж дуусгалаа.

1978 онд дэлхий дахинаараа Гайанд Гэгээн эцэг Жим Жоун суллагдсан, есен зуугаад хүн сайн дураараа амь эрсэдсэн эмгэнэлт явдлын тухай шаагилдаж байв. АНУ-ын засгийн газар Хятадыш коммунист намтай Панамын сувгаар хөлөг онгоц явуулах олон улсын гэрээг албан ёсоор батлав.

Лара хэдэн арван хамтарсан байгууламж босголоо.

1979 онд Келт-Дэвидэд Израиль.  
Египет хоёр энхийн гэрээнд  
үсэглэцгээж, Три-Майльн арал дээр  
аймшигт осол гарч, исламын шашны  
номлолыг эсэргүүцэгчид Иран дахь  
АНУ-ын элчин рүү довтолжээ.

Лара Чикагогийн хойд дүүрэг болох  
Дирфиелдэд тэнгэр баганадсан  
барилга сүндэрлүүлэн, түүндээ  
тохилог дэгжин рашаан эмнэлэг,  
хотын захад клуб нээжээ.

Дээдсийн хүрээнийхний амьдрал  
Ларагийн сэтгэлийг тэгтэл их  
гижигдсэнгүйгээр барахгүй түүний  
сонирхлыг тун бага татна. Олны дунд  
орох хэрэгтэй болсон үедээ Лара

голдуу жааз хөгжмийн аялгуу эгшиглэсэн газрыг сонгох дуртай ажээ. Алдартай хүмүүс нилээд их цуглардаг "Энди" гэдэг тохилог баар түүний очих дуртай газрын нэг болов. Лара тэнд хосгүй Вон Фримэн, Эрик Шнайдер, Энтони Брэкстон, Арт Хоудстай тааралддаг аж.

Бүсгүйд орь ганцаар байх цаг хугацаа үл олдоно. Тэрээр өдөр, шөнийг ялгалгүй архитектор, барилгачин, цахилгаанчин, ус түгээрүүрийн ажилтан нараас бүрдсэн өөрийн "гэр бүлийн" хүрээнд өнгөрүүлэх ажээ. Ээлжит барилгаа эхлэх тоолондоо Ларад

хязгааргүй хөөрөх сэтгэл төрж,  
Чикаго түүний хувьд асар том тайз,  
харин өөрөө тэр тайзны шилдэг од  
болсноо мэдэрч байлаа.

Зэл татсан мэт ар араасаа цуврах  
Ларагийн бизнесийн амжилт нь  
түүний хамгийн зоримог  
шийдвэрүүдийн ялалт байсан агаад  
тэгсэндээ хувийн амьдрал нь хөсөр  
орхигджээ. Шон Макаллистерийн  
заасан анхны хичээл Лараг удтал бие  
сэтгэлийн жаргал амтлахаас  
жигшээжээ. Бүсгүй ганц шөнийн  
учралаас илүүтэй сэтгэл зүрхийг  
нь эзэмдэн дурыг нь татах ганц ч  
эртэй учирсангүй. Дотоод ухамсрынх  
нь гүнд хаа нэгтээ нэгэн удаа уулзаж,

дахин уулзахад ч бэлэн хэн хүний  
балар бүдэг дүрс хөвөн урсах боловч  
эртний энэ танил нь хэн гэгчийн дүр  
төрх болохыг Лара ялган таньж үл  
чадна. Эл дурсамж түүний тархинд  
гялсхийн орж ирэн гийгүүлснээ удаж  
төдөлгүй бөхөх ажгуу.

Эргэн тойронд нь: итгэл төгс  
бизнесменүүд, нефтийн магнатууд,  
яруу найргийг нарийн үнэлэгчид,  
түүнийг шүтэн бишрэгчид  
чамлахааргүй хангалттай эргэлдэнэ.  
Өгүүлж барамгүй хайр энхрийлэл  
дүүрэн харцаар босс эзэгтэйгээ  
ширтэгсэд бүсгүйн мэдлийн хүмүүс  
дунд ч мэр сэр бий. Лара тэд бүгдтэй  
тэгш, нөхөрсөгөөр харьцан,

гэрийнхээ үүдэнд нөхөр ёсоор гар барин салахаас илүү дотогш орох зөвшөөрөл хэнд нь ч эс олгодог байжээ.

Барилгын бригадын мастер, инээдтэй ирланд аялгатай, үргэлж инээмсэглэж явдаг, аятайхан залуу Пит Райны зүг нүд алдан байн байн харах болсондоо Лара өөрийгөө ихэд гайхах болжээ. Лара мань залуугийн ажиллаж буй объект дээр бараг өдөр алгасалгүй шахам эргэлдэж, материалын нийлүүлэлт, зураглал дахь алдаа мэдгийг шүүн ярилцах гээд зайлшгүй яриа үүсгэх авч үнэн хэрэг дээрээ тэднийг тэс өөр нэгэн нууцлаг зүйл зовоож



байгааг хоёулаа ойлгож байжээ.

-Оройн хоол хамт идэж болох юм бишүү? гэх Райны амнаас унасан "оройн хоол" гэдэг үг онцгой содон утга бүхий сонсогджээ. Зүрх нь туг-түгхийн галзуутай цохилохыг Лара мэдрэн, -Надад татгалзах юм алга гэв.

Орой нь Пит бүсгүйг авахаар ирсэн хэдий ч оройн зоог бүтэлгүйтэн талаар өнгөрлөө.

-Бурхан минь гэж, чи ямар үзэсгэлэнтэй юм бэ? гэж босгон дээр зогсох тэрээр шивнэж, төдөлгүй Лара эр хүний бахим тэврэлтэнд

автсан байлаа.

Аль эртнээс хэдэн сарын турш  
үргэлжилэн зовоосон бүсгүйн хуял  
тачаал сэргэв. Райн ухасхийн Лараг  
тэврэн унтлагын өрөөнд авчирлаа.  
Яаран тайлж хаях хувцас нь  
памбагар зузаан хивсэн дээр дуу  
шуу ч үгүй хөглөрөн унана. Залуу  
эрийн халуу дүүгсэн бие, зангирсан  
булчинг үзүүт Лара өөрийн эрхгүй  
Шон Макаллистерийн үлбэгэр бие  
санаанд нь оров. Дараагийн агшинд  
тэд хэдийнэ оронд орчихсон гоолиг  
биеийг нь илэх Райны хүдэр чийрэг  
гар, булбарай чанга хөхийг нь  
тэмтрэн оролдох хэл нь жаргалд  
автсан Лараг өөрийн эрхгүй дуу

алдуулан ёолуулна. Ээ тэнгэр минь,  
бүсгүй энэ бүхнийг амтлалгүй яасан  
ч их удав даа!

Эцэст нь галзууртал оволзох хуял  
тачаалаа тайлж тамир тасарч, хоёул  
амирлин чимээ замхарлаа.

Райн тохой дээрээ дөнгөж өндийн,  
намуухан дуугаар, -Чи гайхамшигтай  
юм гэв. -Чи ч гэсэн хэмээн Лара  
шивнэв.

Ийм амирлах цэнгэлийг Лара урьд  
өмнө хэзээ ч амсаж үзээгүй. Үг  
цухуйв уу угуй юу өөрийг нь ойлгон,  
түүнтэй нэгэн хэлээр ярих сэтгэл  
уярам зөөлөн, Райн түүний хувьд

ихээхэн утга учиртай болжээ.

Амьдралаас еөр юуг хүсэх ёстой юм бэ? Залуу түүний гарыг нь чангаар атган, -Би өлсөж үхэх нь гэв.

-Чи ганцаараа өлсөөгүй. Яваад сэндвич бэлдээд ирье. -Маргааш хоёулаа заавал хооллоно. Жинхэнэ ёсоор нь. Лара түүний цээжийг дэрлэн, -Эргэлзэх юм алга гэв.

Маргааш өглөө нь Лара барилгын талбай руу очвол Райн тэр дээр давхарт тулгуур моддын дундуур тушаал буулган захирамжилан явж үзэгдэв. Лара өргүүр тийш ойртон очтол өргүүрийн жолоодогч ажилчид маасалзан,

-Өглөөний мэнд, Камерон авхайтан  
гэх тэдний дуунд илт өдсөн увайгүй  
өнгө цухалзав.

Дэргэдүүр нь өнгөрсөн бас нэгэн,

-Өглөөний мэнд, Камерон авхай!  
гэснээ эрчүүд тийшээ жогтой харц  
солилцон байв.

Хамгаалалтын хуванцар малгайтай  
гурван угсрагч эрчүүд Лараг нүд  
бүлтийлгэн ширтээд,

-Өглөөний мэнд, босс оо! хэмээн  
ёжтойхон мэндлэв.

Тэрээр тал бүр рүү мэдэгдэлгүй

харвал энд тэнд зогсох хэсэг бусгаар  
бөөгнөрөх ажилчдын хэн нэг нь нууж  
хаалгүй жуумагнаж, зарим нэг нь нүд  
ирмэлцэж үзэгдэнэ.

Бүсгүйн нүүр минчийн улайж,  
өргүүрийн бүхээг рүү орж, бетонон  
цутгамал суурин дээгүүр ажил  
хэрэгчээр алхлан явах Райны  
давхарт хүрч очив.

Үзэсгэлэнтэй залуу бүсгүйг харсан  
түүний царай гэрэлтэн,

-Миний хүндэт амраг минь! Хэдийд  
хооллох вэ? гэв,

-Зайл чи эндээс! Чи халагдсан гэж

бүсгүй зэвүүцэн зуусан шүднийхээ  
завсраар исгэчүүлэн хэлжээ.

\* \* \*

Лара шинэ төсөл болгоноо өөрт нь  
илгээсэн уриа мэтээр хүлээн авна.  
Түүний хүмүүс таван мянган квадрат  
футээс ихгүй талбайтай даруухан  
оффис, сэтгэлд хоногшсон бизнес  
төв, орчин үеийн зочид буудал  
барьж босгосоор. Гэвч ээлжит  
барилгын онцлог шинжээс гадна  
түүний байрлах газар нь Ларад тун  
чухалд тооцогдоно. Газар, байрлах  
газар байр юунаас илүү хэмээн Билл  
Рожерс үнэн хэлжээ.

Барилгын үйлдвэрлэл дэхь эзэнт  
гүрэн нь улам өргөжсөөр. Лараг  
хотын, олон түмний хэвлэл  
мэдээллийн эх шүтээн нь хэмээн аль  
хэдийнээс үзэх болжээ. Өглөгийн  
үдэшлэг дээр, музейд, дуурийн  
театрт гэрэл зурагчин, гэрэл зургийн  
сурвалжлагчид түүнд  
мэдэгдэлгүйгээр араас нь дагаж,  
бүсгүй олны нүдэн дээр сайн сайхны  
бэлэг тэмдэг болон тодорсоор, одоо  
Лара түмний нүднээс цэрвэхээ  
нэгэнт больжээ. Барьж босгосон  
барилга нь агшин зуурын төдийд  
эгэл хүмүүсийн төдийгүй  
мэргэжилтнүүдэд өндрөөр  
үнэлэгддэг боловч энэ нь басхүү



тийм ч хангалттай бус байх аж. Лара сэтгэлийнхээ угт илүүг хүсэн хүлээж, сөөмийн төдийд үүдээ нээвэл шидтэн гарч ирэн шидэт саваагаар адиславаас хорвоо дэлхий шагшин гайхацгаах мэт санагдана.

Говард Келлер тандаж мэдэх оролдлого дахин нэг хийж,

-Лара чи юу хүсч байна? гэсэнд,

-Бүгдийг гэхээс өөр хариу Лара өгсөнгүй.

Лара нэгэн өдөр,

-Говард аа, бид цэвэрлэгчийн,

цагаан хэрэглэлийн, цонх угаагчийн  
цалинд сард хичнээн мөнгө  
зарцуулдаг болохыг чи мэдэх үү? гэв.

-Энэ чинь зүй ёсных. Үүнийг дэвсгэр  
нутгийн бүтээгдэхүүн гэж хэлж  
болно.

-Тэгвэл энэ дэвсгэр нутгийг худалдан  
авья л даа?

-Чи юу сэдчихээ вэ?

-Бид охин компаниа байгуулах  
хэрэгтэй болжээ. Ийм төрлийн  
үйлчилгээ өөрсөндөө болон бусад  
барилгын гүйцэтгэгч нарт үзүүлье.

Ойшоон үзмээр гайхалтай сайхан санаа байж, ашиг орлого ч оцойж овоотлоо эрс өслөө.

Лара өөрийгөө үл нэвтрэх ханаар хүрээлээд байгааг Говард бүр ч ихээр мэдрэх болов. Бусдаас давуу эрхтэйгээр хажууд нь хавтага шиг эргэлдэх тэрээр ганц ч удаа төрөл төрөгсдийн, өнгөрсөн амьдралынхаа тухай нэг үг амнаасаа унагахыг нь сонсоогүй. Түүнд Лара салхины аясаар туугдсаар цөлд унан ургасан цэцэгний үр мэт эзгүй цөлд эзэнгүй төрсөн юм биш байгаа гэсэн сэтгэгдэл төрнө. Хамтран ажиллах эхлэл тавьж байсан тэр үедээ Келлер бизнесийн цагаан толгойн "А" ч үгүй

хамтрагч бүсгүйгээ элдэв аргаар саам хийн хаацайлан хамгаалдаг байсан бол одоо Лара бүхнийг бие даан шийддэг болж, шавь нь багшаасаа илт давж гарчээ.

Бүсгүйд торж бүдрэх саад тотгор гэж байсангүй. Лара төсөл хэрэгжүүлэх ажилд ханцуй шамлан орсон байхад түүнийг зогсоон барина гэдэг огг боломжгүй хэрэг. Бүхий л талаараа давуу зэрэгтэйг нь хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй, юунд зорьж байгаагаа Лара сайн мэддэг, тавьсан зорилгодоо хүрэхийн тулд танхил бүсгүйгээс гарамгүй их хүч гарч, шаргуу хөдөлмөрлөдөг ажээ.

Эхэн үедээ хамтран зүтгэгч олонх эрчүүд өөрийгөө давуу эрхтэйд тооцон санаархсан үүнийгээ ашиглах гэсэн гэнэн бодлоо хэрэгжүүлэхийг оролддог байлаа. Урьд өмнө бүсгүй хүнд захирагдаж байгаагүй эл байдалдаа зохицох гэж тэд хэсэг хугацаанд нилээдгүй зугаатай байжээ. Нэг бригадын дарга гүйцэтгээгүй ажлын наряд бичин хаасан байхыг Лара илрүүлэн, увайгүй зантай өөдгүй новшийг цугласан олны нүүрэн дээр мэдэгдэн, түүнийг хөөж гэнэ. Өглөөний зургаан цагг ажилчид талбайд уван цуван ирж байхад, босс бүсгүй хэдийнэ ирчихсэн хүлээн

зогсож байдаг нь түрэмгий сексчин мэт санагдана. Хавь ойрд нь Лараг ирэхэд тэд боломжийг ашиглан, баргийн дүлий ч сонсмоор чанга шивнэлдэн онигоо ярив.

-Наран шарлагын газар байсан залуу 'жинхэнэ гоо үзэсгэлэнт бүсгүй усанд хөлөө займчин суухыг харжээ. "Хөөе, үзэсгэлэнт охин минь, ус хүйтэн байна уу?" гэвэл хариуд нь: "Би... би термометр биш"...

Зарим нэг цөс ихтэй эрчүүд шулуухан өднө.

Хоёр гурван ч удаа дэргэдүүр нь өнгөрөх зуур "санамсаргүй" мэт

тонтгор өгзөгийг нь шүргэн,

-Өө авхай, өршөөгөөрэй! гэхэд нь,

-Аймшигтай юм огт алга. Кассанд очоод, намайг чиний тойрохыг зурж, тооцоо хийгээд зайлуул гэснийг хэл гэдэг байв.

Тоглоом нь шоглоом болсныг наадагч эр яс махандаа тултал ойлгож, бүсгүйн байр суурь хүндэтгэлтэйеэ үлдэнэ.

Нэгэн удаа Говардтай хамт явж байсан Лара хэдэн арван дэлгүүр шавааралдсан худалдааны тааруухан хорооллыг анзаарчээ.

Бүсгүй хөл тоормосны гишгүүрийг шаланд тултал жийв.

-Хайран газрыг яасан дэмий үрээ вэ!  
Энд ямар нэгэн хээнцэр барилга барих ёстой. Энэ мухлагууд тэртээ тэргүй өөдтэй орлого оруулахгүй нь лав.

-Санал нэг байна, гэхдээ чи эд бүгдийг худалдаж авч чадахгүй байх гэдэгт асуудлын учир байна. Ямар ч эзний зөрүүд зан хөдлөх нь гарцаагүй.

-Харж л байя даа.

-Лара, ганц хүн л мухлагаа өчүүхэн



муу гэлгүй зарахыг эс зөвшөөрвөөс  
чи эвгүй байдалд орно шүү дээ. Чи  
зарсан мухлагуудыг худалдаад  
авчихлаа гэж бод, харин нөгөөх  
адайр аашт, зоргоороо хүн чамд  
санаснаа барьж босгоход хаалт  
болно. Цаашилбал мухлагуудын эзэд  
чиний төлөвлөгөөг мэдмэгц үнэ нь  
тэнгэрт хадна шүү дээ!

-Тэгвэл, бид нэг ч сүр дуулиан  
бадруулахгүй ээ гэх Лара толгойдоо  
бодлоо боловсруулж эхлэв  
бололтой байснаа,

-Өөрийн хүмүүсийг уулзуулья гэлээ.

-Гэвч болгоомжгүй ганц үг тарвал,

бүх юм баларч орхино шүү.

-Тэгье, хоёр дахин хянамгай байя.  
Харин одоохондоо ерөнхий зургаа  
гаргачихья.

\* \* \*

Кедзи-стрит дахь хороололд талхны,  
төмөр эдлэлийн. үсчин, хувцасны  
дэлгүүр, хувцасны засвар, эмийн  
сан, махны мухлаг, хоёр гурван баар  
гээд өч төчнөөн олон жижиг мухлаг  
ажилладаг ажээ.

-Ганц л зөрүүд худалдаачин бүхнийг  
баллаж орхино гэдгийг л санаарай  
хэмээн Келлер Ларад ахин сануулна.

-Бүү санаа зов. Би тэдэнтэй хэл амаа ололцоно.

Долоо хоногийн дараа ердөө л хоёр буйдангаас өөр тавилгагүй жижиг үсчинд нэгэн эр орж ирлээ.

Хуучин сэтгүүл залхуутайяа эргүүлж суусан эзэн эр толгой өлийлгөн,

-Үсээ засуулах уу, эрхэм ээ? гэв.

Зочин эр эелдэг аашлан инээд алдаж,

-Үгүй ээ. Би дөнгөж сая хүрч ирээд, хотыг үзэж байна. Би Нью-Жерсид үсчинээр ажилладаг юм, гэтэл эхнэр

маань ээждээ ойртон ирэх гэнэ.  
Худалдаж авах үсчиний газар  
олдоно гэж бодсон юм гэлээ.

-Би энэ хавьдаа цорын ганц үсчин  
нь, тэгээд ч өөрийн байраа зарахгүй.

-Мөнгөний тухай яриа эхлэхэд  
бүгдийг худалдаж авч болно, тийм  
биз дээ? Мэдээж хэрэв үнэ тохирвол  
шүү дээ. Таны бодлоор хэд хүрэх вэ?  
Тавин мянга уу? Жар уу?

-Энэ хавьцаа амлавал ч тохирноо  
хэмээн эзэн эр зөвшөөрөв.

-Би ганцаараа хуучин бизнесээ  
эрхлэхээр шийдсэн юм л даа. Та

сонсооч, танд далан таван мянгыг өгье.

-Үгүй, Энэ тухай мартаж үз.

-Зуу.

-Эрхэм ээ, би,..

-Тоног төхөөрөмжөө өөртөө үлдээж болно.

Үсчин эр бодлогоширов.

-Зуун мянган доллар, тэгээд би буйдан, толь, хайчаа өөртөө үлдээнэ гэв үү?...

-Тийм ээ. Надад наадуул чинь

хэрэггүй.

-Би эхнэртэйгээ ярилцах хэрэгтэй байна.

-Тэгэлгүй яахав. Маргааш ирье.

Хоёр хоногийн дараа үсчиний газар зарагджээ.

-Нэг-нойль. Бидэнд ашигтайгаар гэж Лара өгүүлэв.

Дараа нь эхнэр, нөхрийн эрхэлдэг талхны дэлгүүрийн ээлж ирэв. Талх барих пийшинг арын өрөөнд байрлуулсан байшингаас шинэхэн талхны үнэр ханхлана. Худалдаж

авах санал тавин нэгэн эмэгтэй орж  
ирэн эзэнтэй нь,

-Нөхрийгөө нас барсны дараа би  
чамгүй даатгал хуртсэн юм. Бид  
Флоридад бас талх барьдаг байлаа.  
Би танай дэлгүүрийг дуртайяа  
худалдаж авахсан гэж яриа дэлгэв.

-Эхнэр бид хоёр үүндээ бүр дасаж  
орхисон юм гээд эзэн эр цагаан  
хормогчоо тайлах зуур,

-Үгүй дээ. Бидэнд зарах бодол  
төрөөгүй байна гэв. -Одоо тэгвэл  
тийм бодол төрөх болно. Та хэдийг  
санал болгох вэ? -За... гэх эзэн эр  
эргэлзэж буй нь илт. -Дор хаяж

далан таван мянга. -Тэгвэл би танд зууг өгье. Гайхсан эзний нүд нь гялалзан, -Үнэхээр үү? гэлээ. -Үүнд гайхаад байх сүйдтэй юм алга. Маргааш өглөө нь Лара, -Хоёр-нойль хэмээн баярлан сууж байлаа.

Бусад хэлэлцээр мөн л төвөггүй бүтжээ. Оёдолчин, эмийн санч, бааранд мөн л худалдан авах санал тавьсан хүмүүс орцгоосоор хагас жилийн дараа гэхэд Лара бүх мухлагуудыг мэдэлдээ авч, архитектор шинэ барилгын төлөвлөгөө боловсруулах ажилдаа оров.

-Бид ч ялах шив дээ гэж Лара



баяртайгаар Келлерт хэлбэл,

-Бүү яар хэмээн тэрээр хариулав.

-Юу болоов? Чи кофены газрыг хэлээд байна уу?

-Яг тийм. Эзэн нь шууд татгалзана.

-Ахиухан мөнгө санал болго.

-Тэр мөнгийг огт сонирхохгүй байна гэсэн. Лара дургүйцэн мөрөө хавчисхийлгэн,

-Тэр бидний төслийн тухай мэдэж байгаа юм уу? гэж гайхан асуув. - Хаанаас даа.

-Сайн байна. Би түүнтэй өөрөө ярилцана.

Маргааш өглөө нь Лара кофейны газарт ирэв. Тэрээр хорооллын хамгийн адагт уулзварын дэргэд гурван дугуй ширээ, лангууны дэргэд арваад сандал тавьсан байх аж. Жараад насны тийм ч өндөргүй эр цэвэрхэн алчуураар аяга зүлгэн зогсох үзэгдэв. Лара ширээний ард суувал эзэн эр, -Өглөөний мэнд. Та юу захих вэ? гэв. -Кофе, аяга жүржийн шүүс. -За одоохон.

Бүсгүй хижээл эр шүүс шахагчийн дор аяга тосохыг дуугүй харан сууна.

-Үйлчлэгч маань яагаад ч юм ирсэнгүй. Одоо ч үйлчлэгч ажиллуулахад хэцүү болжээ! гээд эзэн эр уур савссан өтгөн кофе аягалаад, лангууны үүдээ нээлээ.

Тэр тахир татуугийн тэрэгтэй хөлгүй нэгэн байх ажээ.

-Баярлалаа. Танай энд их тухтай юм гэж Лара хэлэв.

-Тийм үү? Сонсоход тааламжтай байна.

-Та энд удаж байна уу?

-Арван жил болж байна.

-Гавьяаныхаа амралтанд суух болоогүй юу?

Эзэн эр толгой сэгсрэн,

-Энэ долоо хоногт, энэ тухай асууж буй хоёр дахь хүн нь та болж байна. Үгүй ээ, болоогүй гэх нь тэр.

-Магадгүй, багыг амлаа байлгүй, аан?

-Авхай энд мөнгөтэй холбоотой асуудал огт байхгүй. Энд ирэхээс өмнө би хоёр жил эмнэлгийн орон дээр орь ганцаар хэвтэж өнгөрүүлсэн. Амьдрал маань утга учраа алдан там болоод байтал эмч

маань надад энэ кофены газрыг түрээслэхийг зөвлөсөн юм гээд тэр инээмсэглэснээ, -Энэ ч зөв байсан. Би дахин төрөх шиг болсон доо. Орж ирэгсдийн хөл тасрахгүй. Хүмүүс сэндвич идэхээр орж ирэх зууртаа надтай ярьж хөөрөлдөн, найз нөхөд болцгоодог. Би ч тэдэнд хэрэгтэй! Ийм л байна даа, авхай минь. Энд мөнгөний асуудал огт байхгүй. Дахиад кофе уух уу?

Лара цаашдын ажлаа төлөвлөхөөр Говард Келлер, архитекторыг өрөөндөө дуудлаа.

-Бид кофены газрыг худалдан авах хэрэггүй болсон гэж Келлер хэлээд,

-Би эзэнтэй нь ярилцсан. Түрээсийн төлбөрийн хэлэлцээрийн дагуу хэрэв мухлаг сард тодорхой хэмжээний ашиг өгөхгүй бол, түрээслэгчийн эрх хасагдана. Сүүлийн дөрвөн сард эзэн ганц ч долларын ашиг аваагүй гэсэн. Тэд бидэнтэй уулзахад бэлэн байгаа гэв.

Лара архитектор тийш эргэн,

-Үүнийг хөндий юм шиг хийж болохгүй юм уу? Яг дотор хаалга шиг. Барилгын төрхөнд өөрчлөлт орохгүй биз? гэв.

Архитектор зургийг түрхэн зуурт шинжсэнээ,

-Болно гэж бодож байна. Мэдээж, байгаа янзаар нь үлдээвэл дээр л дээ, гэхдээ.., гэвэл,

-Гэхдээ болно биз дээ? гэж Лараг лавлавал, -Болох нь ч болно хэмээн архитектор зөвшөөрөв. -Лара чи: түрээслэгчийг гудамжинд хөөж гаргаж чадна гэж хэлснийг сонсов уу? гэж Келлер чанга хэлэхэд нь Лара, -Бүх хороолол бидний мэдэлд байгаа тийм үү? гэв.

-Тэр ч тийм л дээ. Эмийн сан, хувцас засвар, үсчин, талхны... гэхэд нь Лара,

-Шинэ оффист ажиллах хүмүүс

мэдээж хаа нэгтээ аяга кофе ууна гэх биз. Тухайлбал бид нар ч гэсэн кофе ууна. Кофены газар тэндээ үлдэх болно гэжээ.

\* \* \*

Лара эцгийнхээ төрсөн өдрөөр,

-Говард аа, чи надад тус болохгүй юу? Чамайг Шотланд руу явуулмаар байна гэв.

-Чи тэнд юу барих санаатай байна вэ?

-Би тэндээс харш худалдаж авмаар байна.



Келлер бүсгүй тийш тээнэгэлзсэн  
янзаар харав.

-Ууланд, Лох-Морлих гэдэг  
жижигхэн газар бий. Энэ нь  
Глермороос Эвилор орох замд  
байдаг юм. Тэр орчим хэд хэдэн  
харш бий. Тийшээ очоод аль нэгийг  
нь худалдаж ав. -Зуны өргөөтэй  
болохоор шийдээ юу?

-Би харшид амьдрахгүй. Тэнд  
эцгийгээ оршуулах гэсэн юм.

-Би Шотланд орж, эцгийг чинь  
оршуулах харш худалдаж авах  
болох нь ээ гэж Келлер аяархан  
давтлаа.

-Чи ташаа сонсоогүй. Надад өөрөө үүнд явах цаг зав алга. Гэр бүлийн хэргийг би ганцхан ганцхан чамд л итгэж чадах байна. Эцгийн шарил Глэй-Бэйн оршуулгын газар бий.

Ингээд Лара анх удаа Говардад өөрийн амьдралынхаа тухай дурсжээ.

-Чи аавдаа их хайртай байсан байхаа.

-Хэлснээр минь хийх үү?

-Ёсчлон гүйцэтгэнэ.

-Шарилыг зөөх үедээ булш ухах хүн

олоорой.

Келлер гурван долоо хоногийн дараа эргэж ирлээ.

-Бүгдийг хэлснээр чинь гүйцэтгэсэн шүү. Чи харшийн эзэн болсон.

Эцгийн чинь шарил цэцэрлэгт, чулуун хананы дэргэд байгаа.

Түүний цаана гүвээ толгод, дэргэд нь бага шиг нуур бий. Үзэсгэлэнтэй шүү! Явж үзэх үү?

-Би юу? Яах гэж тэр вэ?

# Дэд дэвтэр

## Арваннэгдүгээр бүлэг.

Лара 1984 онд Нью-Йоркийг байлдан дагуулах цаг нь иржээ хэмээн үзсэн байна. Түүний энэхүү төлөвлөгөөг сонссон Говард нилээдгүй балмагджээ.

-Чиний энэ санаа чинь намайг түгшээж орхилоо. Нью-Йорк гэдэг чинь манай эндэхтэй хавьцах газар биш. Чи түүний тухай юу мэдэх юм бэ? Юу ч мэдэхгүй шүү дээ. Би ч гэсэн яг адил. Бид... хэмээн үл ойшоосон хахирган дуугаар хэлэхэд нь Лара,

-Намайг Глэй-Бэйгээс Чикагод

ирэхэд яг ингэж хэлж байсан. Энд Нью-Йоркод эсвэл Токиод барилга барих юуны ялгаа байна, хэлээдэх? байшин барих ажил газар сайгүй яг адилхан, тоглоом нь нэг л дүрмээр явдаг шүү дээ.

-Гэхдээ чи энд бүгдийг санааныхаа зоргоор эргүүлж дөнгөсөн. Ингэхэд чи ер нь юу хүсээд байгаа юм бэ? хэмээн Келлер эсэргүүцэхийг оролдов.

-Энэ асуултыг чи аль хэдийнэ асуусан. Нэр минь дуурсагдаж байхыг би хүсч байна. Нью-Йоркод "Камерон-Плаза"-г, дараа нь Камерон төвийг барина. Говард оо,

бас цаашлаад... Цаг нь ирэхээр дэлхийд хосгүй тэнгэр баганадсан хамгийн өндөр өргөөг сүндэрлүүлнэ. Би үүнийг л хүсч байна. Тэгээд "Камерон энтерпрайз" Нью-Йорк руу шилжин нүүнэ.

Нью-Йоркод барилга байгууламж ид хүчээ аван амжилттай өрнөж байлаа. Хотын хувь заяа үл хөдлөх хөрөнгийн хүчирхэг мэргэжилтэн болох Цакендорфийн гэр бүлийн, Гарри Хелмели, Дональда Трампа, Рудинс нарын албан тасалгаанд шийдэгдэж байв.

-Үгүй яах вэ дээ, тийм бол тэдний клубт элсэе л дээ хэмээн Лара

ХЭЛЖЭЭ.

Тэд "Риженси" зочид буудалд төвхнөж аваад, дараа нь хот судлах ажлаа эхэлжээ. Харьцангуй том, асар том метроны галзуутай хөдөлгөөнийг анх харсан Лара ухаанаа төвлөрүүлж чадсангүй нилээд уджээ. Аварга том олон барилгуудын дундуур тасралтгүй урсах машины урсгалтай Нью-Йорк нь асар гүнзгий ангалтай төстэй байх ажгуу,

-Чикагог энүүнтэй харьцуулахад яг л Глэй-Бэй шиг харагдаж байна шүү! хэмээн их л бахадсан янзаар хэлэх Ларагийн гар нь тэсгэлгүй чичигнэж



байв.

-Юуны өмнө бид багаа бүрдүүлэх шаардлагатай. Сайн хуульч хөлсөлж, чадварлаг менежер аваад, Рудинс хэн хэнтэй хавсарч ажилладгийг нь тодруулахыг оролдоё. Чи тэдний хүмүүсийг өөртөө татаж дөнгөх юу магад хэмээн Говардыг өгүүлэхэд нь Лара, -Тэгээд тэр ажилдаа орооч гэв. Нэг өдрийн дараагаар Лара,

-Май энэ надад таалагдсан барилгуудын жагсаалтыг ав. Тэднийг хэн барьсан тухай мэдээд ир. Би архитектортой нь уулзмаар байна гэв. Бүсгүйн урам зориг илт сэргэжээ.

-Банкуудтай тохиролцож зээлийн данс нээлгэе. Чикагод байгаа бэлэн мөнгөө нааш нь шилжүүлэхэд нэг их төвөг болохгүй биз. Мөн брокеруудтай гэрээ байгуулах хэрэгтэй байна хэмээн Говард санаачлагыг гартаа авахыг эрмэлзэн хэлэхэд нь Лара, -Чиний зөв гэсэнд Говард,

-Лара, чи ер нь ханцуй шамлан тулаанд орохын өмнө юуны төлөө ингэж буй билээ гэж боддоггүй байхаа? Чамд төлөвлөсөн юм байгаа юм уу? гэхэд нь,

-Би хэлээгүй билүү? гээд бүсгүй цайлганаар инээмсэглэн, -Бид

Манхэттенийн Төв эмнэлгийг  
худалдаж авна гэжээ.

\* \* \*

Лара гурван өдрийн өмнө Мэдисон-  
авеню дэх үсчинд үсээ янзлуулан  
сууж байхдаа хашлаганы цаана  
өрнөх яриаг чагнан толинд харан  
алмайран сууж байжээ.

-Уокер авхай, бид таныг их үгүйлнэ  
дээ.

-Би ч гэсэн адилхаан, Дарлен минь.  
Би хичнээн жил ч танайхаар  
үйлчлүүлчихэв дээ?

-Арван таван жил болж байна.

-Цаг хугацаа нисэх мэт хурдан өнгөрөх юмаа! Хэн ч гэсэн тэгж бодох байх даа? Хонгор минь, гэвч би Нью-Йоркоос явах гэж байгаадаа огт харамсахгүй байна. -Та хэзээ явах юм бэ?

-Яг одоо явна. Өнөө өглөө бүх ажилтнууд тооцоо хийх тойрох хуудсаа гардаж авцгаасан. Чи төсөөлөөд үз дээ. Хотын сан хөмрөг гэгчид нь бэлэн мөнгөгүй болсноос Төв эмнэлгийг хааж байна гэнэ! Би тэнд хорин жил ахлах сувилагчаар ажилласан, гэтэл тэд надад "Хүн гуай та хаалгаа цаанаас нь хаана уу!"

гэсэн шиг алгын чинээ цаас өгсөн шүү! Шударга төвшин хүн бол нүүрэн дээр ил цагаан хэлнэ биз, тийм үү? Хорвоо дэлхий гэдэг чинь хаашаанаа л эргээд байна даа? Лара эл яриаг чих тавин чагнаж суув.

-Эмнэлгийг хаасан тухай сонин дээр ганц ч үг гараагүй шүү дээ!

-Гарах ч үгүй. Тэд хэл амнаас далдуур өнгөрүүлчих санаатай дагаа. Одоохондоо зөвхөн гар хөлийн үзүүрт нь хөдөлдөг туслах, хамсагч нар нь мэдэж байгаа.

Үсчин түүний үсийг хэвэнд оруулахаар сэнсээ залгах үед Лара

буйдан сандлаас огло харайн босов.

-Өршөөгөөрэй. Камерон авхай. Би арай л дуусаагүй байна. -За яахав. Би завгүй болчихлоо.

Манхэттенийн Төв эмнэлэг гэгч нь Ист-сайдад бүтэн хороолол эзэлсэн, эзэнгүй орхигдсон мэт халзарч холцорч яйжийсан булай муухай барилга байх ажээ. Үүнийг харсан Лара гэрлэн чимэглэл бүхий худалдааны төв, дээд давхруудад нь тансаг сайхан өрөө тасалгаатай тэнгэр баганадсан сүрлэг байшинг нүдэндээ дүрслэн босгов.

Лара Төв байр руу нь ороод, ямар

корпорац эмнэлгийн эзэмшигч болохыг асуувал түүнд Уолт стритэд орших Рожер Бернэмийн хаягийг хэлж өгчээ.

\* \* \*

-Камерон авхай, танд юугаар тус болох вэ?

-Би Төв эмнэлгийг хэзээ мөдгүй зарах гэж байгаа хэмээн сонслоо, Бернэм илт гайхан,

-Хэрэв нууц биш бол та хаанаас олж сонсоо вэ? гэв.

-Гэхдээ үнэн биз дээ? Мань эр хариу

өгөлгүй удсанаа,

-Магадгүй л юм хэмээн үг алдав.

-Тэгвэл би худалдан авагч болж чадах байна. Зарах үнээ хэл дээ.

-Гэхдээ, эмэгтэй,.. Би таныг амьдралдаа анх удаа харж байна шүү дээ, Тэгээд ч би есөн зуун мянган долларын хэлэлцээрийг зүс үзэнгүүтээ хийчих хүн юм шиг байна уу? Надад...

-Есөн зуун мянга гэнэ ээ? гэх үнийн дүн Ларагийн санаанд багтсангүй, гэхдээ эргэж няцах... Тэр тусмаа сайн! Сэтгэл хөдлөм эхлэл байна..



-Тэгэхээр түүний тухай ярилцах уу даа? гэж Лара өгүүлэв. -Юуны ч тухай яриа байхгүй. Бүсгүй Бернэмд зуун долларын багц сарвайв.

-Энэ чинь юу вэ? Яах гэж ингэж байгаа юм бэ? -Тус болооч. Надад дөчин найман цагийн хугацаа шаардагдаж байна. Та уг наймааны тухай албан ёсоор зарлаагүй байгаа шүү дээ. Та юу алдах вэ? Би л таны дуудсан үнийг чинь өгчихвөл хэн ч хажуугаас хачир болж орж ирэхгүй.

-Таны бэл бэнчингийн тухай надад мэдэх юм алга. -Чикагогийн "Меркантайл" банкны ерөнхийлөгч Боб Вэнстэй нь яриадах.

Бернэм саарал нүднийхээ гярхай харцыг Ларагаас үл салган ширтэж, толгой сэгсрэхдээ "солиотой амьтан" гэх маягийн үг амандаа бувтнан байснаа гар нь утасны лавлах тийш суналаа. Лара тэвчээртэйгээр хүлээв.

-Ноён Вэнс үү? Нью-Йоркоос Рожер Бернэм ярьж байна. Миний өрөөнд нэг авхай... гээд тэрээр түгдчихэд нь,

-Лара Камерон хэмээн Лара тодруулав.

-Лара Камерон гэнэ. Хэрэв би түүнийг зөв ойлгосон бол тэр манай компаниас үл хөдлөх хөрөнгө худалдаж авах гэнэ. Энэ нэр танд

ямар нэг юм хэлж байна уу?

Бернэм харилцуураа чихэндээ шигдтэл наасан байлаа.

-Өө тийм үү? Ойлголоо... Үнэхээр үү? Үгүй, үүнийг чинь би мэдэхгүй юм байна. За... за... Танд баярлаа.

Тэрээр харилцуураа тавиад, Лара руу шал өөрөөр, зөөлөрч уярсан харцаар харан,

-Та Чикагод нилээдгүй сэтгэгдэл төрүүлжээ дээ гэв. -Энд ч гэсэн мөн адил төрүүлэх болно. Бернэм багц дэвсгэртийн буланг сөхөж хараад, - Би үүнийг чинь яах болж байна?

гэхэд нь Лара,

-Куба янжуур авч татаарай. За тэгэхээр, надад дөчин найман цагийн хугацаа байх шив? гэжээ. Нөгөө эр мөрөө цэхлэн,

-Чухамдаа яахаа мэдэхгүй л байна. Энэ бүгд... сураагүй юм ч халуухан л байна. За яахав. Таны мэдэлд хоёр өдөр өгье гэлээ.

\* \* \*

-Эхлэх цаг нэгэнт болжээ. Говард аа, чи дөчин найман цагийн дотор санхүүгийн бодлогоо боловсруулж дуусга. -Надад үнийн дүнгээ л

ХЭЛЧИХ.

-Гэхдээ хамгийн ерөнхийг нь шүү. Үл хөдлөх хөрөнгөнд есөн зууг зарна.

Хоёр саяыг нь эмнэлгийг нураах болон барих барилганд зарах ёстой.

Келлер толгой сэгсчин,

-Нийлээд хоёр сая есөн зуун мянган доллар гэв. -Чи ч тооны ухаанд лут шуу.

Говард магтаалын үгийг чихнийхээ хажуугаар өнгөрөөв. -Лара, ийм их уул овоо шиг мөнгө хаанаас олох нь вэ? -Зээлнэ. Хагасыг нь Чикагогоос, хагасыг нь шинээр барих барилгаа

барьцаална. Болж бүтэхгүй асуудал  
огт харагдахгүй байна.

-Гэвч энэ чинь асар их эрсдэлтэй юм.  
Болж бүтэхгүй зүйл зөндөө байна. Чи  
байгаа бүхнээ мөрийд тавьлаа гэсэн  
үг. -Яг үнэн. Тэгээд ч тулалдсаны  
эцэст ялдаг жамтай. Нью-Йоркод  
санхүүжилт нээлгэх нь Чикагогоос  
амар төсөр бүтлээ. Хотын мэр  
Дэниел Кок муудаж өгөршсөн  
барилгыг буулган, түүний ором дээр  
шинэ барилга босгодог барилгын  
гүйцэтгэгч нарыг албан татварын  
нилээдгүй хөнгөлөлт эдлүүлэн, бас  
эхний хоёр жил хотын санд албан  
татвар төлөхгүй байх тусгай  
хөтөлбөрийг батлав.

Банк Ларагийн урьдын авч байсан зээлийн тухай мэдээлэлтэй танилцсаны эцэст тэдний эргэлзээ арилжээ.

Товлосон хугацаа эхэлснээс зургаан цагийн дараа Лара Рожер Бернэмийн өрөөнд хүрэлцэн ирж түүнд гурван сая долларын чек сарвайн,

-Бүх төлбөрийг авчирлаа, таны үнэ миний санаанд нийцсэн шүү. Өө тийм, дашрамд хэлэхэд зуун мянгыг нь та өөртөө үлдээх юм шүү! гэжээ.

Дараагийн хагас жилд Келлер банкнаас салсангүй, харин Лара

архитектортай идэвхтэй ажилласаар байв.

Ажил нь гайхалтай урагштай явагдаж архитектор, барилгачид, маркетингийн шинжээчид өөр өөрийн ажлаа чадмаг гэгч нь гүйцэтгэж, гурван сарын эх гэхэд эмнэлгийг буулгаж дуусан, дөрвөн сар гэхэд төслийн үндсэн шат эхлэхээр төлөвлөгджээ.

Лара ажлын явцтай биечлэн танилцахаар өглөө болгон зургаан цагт барилгын талбай дээр ирдэг байв.

Келлер нэгэн удаа түүний өрөөнд



орж ирээд,

-Лара, чиний зөв байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм байна.

-Бид хатуу чанд хуваарын дагуу явж байна гэв.

-Би чамд хэлсэн шүү дээ. Барилга бол мөнгө барладаг суурь машин.

Нэгдүгээр сарын арван таванд буюу барилга дуусахаар товлосон хугацаанаас хоёр сарын өмнө ажилчид цахилгааны угсралтаа хийж эхэлсэн тэр өдөр Лара барилгын ивүүр моддын дундуур явах нэгэн залууг харж хэсэг зуур зогсов. Тэртээ

дээр зогсох залуу эр тамхилахаар шийдэв бололтой. Халааснаасаа хайрцаг тамхи гаргахдаа тэрээр халаасан дахь эрэг чангалагч төмөр түлхүүрээ доош нь нисгэчихлээ. Түлхүүр эгц дээрээс нь агаар хага зүсэн исгэчүүлсээр унахыг айдаст автан харж зогссон Лара өөрийн эрхгүй хажуу тийш зайлан харайлгахад сандарсан бүсгүй зүрх нь жигтэйхэн хурдан цохилжээ. Залуу "уучлаарай" хэмээн гараараа занган дохиж үзэгдэв. Баргар царайлсан Лара дээш гарахаар өргөгч цамхагийн бүхээгт орлоо. Бүхээг зогсмогц тэрээр хөл дор нь ёроолгүй ангайн харлах нүхийг эс

анзааран нарийн тавцан дээгүүр эрс  
шийдэмгий алхалсаар  
цахилгаанчины дэргэд хүрч ирэн,

-Та түлхүүр унагасан уу? гэж асуув.

- Тийм ээ. Уучлал эрье.

Ларагийн гар гялсхийн, залуугийн  
улаан нүүрэн дундуур тасхийтэл  
алгадаад,

-Та халагдсан. Эндээс зайл! гэв.

-Энэ чинь ердийн л нэг санамсаргүй  
явдал байсан шүү дээ! Би...

-Буу доошоо!

Залуу эр толгой гудайлган цамхаг тийш явав.

Лара гүнзгий санаа алдан, аажим биеээ хянахтайгаа боллоо. Ажилчид бүгд нүдээ бүлтийлгэн боссоо ширтэн зогсоцгооно.

-Та нар юундаа гөлөрч зогсоов?  
Ажилдаа орцгоо хэмээн тушаав.

Лара гэрээ байгуулахаар хөлсөлж авсан Нью-Йоркдоо алдартай хуульч Сэм Госдентой өглөөний цай ууж суув.

-Миний бодлоор бүх юм зохих номоороо явж байна гэж Госденыг

ХЭЛЭХЭД НЬ,

-Бүх юм гайхалтай явагдаж байна. Нээлт хийхэд хоёр гурван долоо хоног л үлдээд байна гээд Лара таатайяа инээмсэглэв.

-Үг хэлэхийг минь болгооно уу?

-Тэгэлгүй яахав. Гэхдээ хуулийн эсрэг ямар ч хэрэг зарга байхгүй гэж найдаж болох уу?

-Өө үгүй дээ, тэрнийгээ ч нэг юм мэдэх байлгүй! Би ердөө л таны хөг өнгөрчээ гэж мөрийцөхөд ч бэлэн байна гээд Госден наг наг хөхрөв.

-Яахлаараа тэр билээ?

-Таны хүчээ өгч байгаа бизнес чинь гагцхүү эрчүүдэд заяагдах тавилантай юм л даа. Түүнд оролцдог цорын ганц эм хүйстнүүд нь хямдхан байр зардаг ширгэж хонхойсон гүн цэнхэр нүдтэй, таяг тулсан азай буурал, эмгэчүүл байдаг юм шүү дээ.

-Тэгэхээр Сэм та надад мөрий тавиагүй биз дээ. Госден ивээнгүй инээд алдан,

-Тэгсэн шүү гэхэд Лара үл ялиг урагш тонгойн,

-Сэм ээ?... гэвэл Госден,

-Сонсож байна хэмээн хайхрамжгүй хэлэв.

-Миний захиргаанд ажиллаж байгаа хүмүүсээс хэн ч өрсөлдөгч шиг ханддаггүй юм. Та халагдсан.

Лара гайхаж алмайрсандаа эрүү нь унжсан эрийг тэр чигг нь орхиод доош ресторан руу буулаа.

Нэг өдрийн дараа, даваа гаригийн өглөө Лара талбай тийш очихоор зам зуур явж байхдаа нэг л ер бусын байхыг зөнгөөрөө мэдрэв. Төдөлгүй машин ч зорьсон газраа ирэн

зогсоход юу болсон нь ойлгомжтой боллоо. Эргэн тойрон үхээрийн нам гүм ноёрхоно. Тон тон тогших алх, цахилгаан өрөмний дүнгэнэх чим.ээ огт сонсогдсонгүй. Бүсгүй итгэж ядсаар гайхан ийш тийш харлаа. Ажилчид багаж зэвсгээ хурааж байх үзэгдэхэд Лара аж ахуй тийш бригадын ахлагч руу харайлгав.

-Юу болоод байна? Долоо болчихоод байна шүү дээ!

-Би хүмүүсээ татлаа.

-Алив надад тайлбарлаад орхи!

-Гомдол ирсэн, Камерон авхай.



-Юун гомдол вэ?

-Та ажилчин зодсон гэсэн.

-Юу-уу? гээд Лара өнөөх будлианы тухай таг мартсан байснаа санан,

-Тийм ээ, тэр үнэн. Гэхдээ тэр өөрөө буруутай гэв. -Та хүн алгадах эрхийн лиценц аваа юу?

-Алив байзнаач, чиний бодсон шиг юм болоогүй! Тэр залуу түлхүүр доош унагаж золтой л намайг алчихаагүй. Тэгээд тэсэж чадсангүй дээ чин сэтгэлээсээ харамсаж байна. Гэсэн ч тэр эрхэм эргэж ажилдаа орохгүй шүү.

-Яг үнэн. Бид ч гэсэн мөн адил. Лара чихэндээ итгэж чадсангүй.

-Энэ чинь даажигнаж байгаа хэрэг үү? гэсэнд,

-Үйлдвэрчний эвлэл даажигнахыг зөвшөөрдөггүй юм. Түүний удирдагч эндээс явах шийдвэр гаргасан. Тэгээд л бид явж байна.

-Гэхдээ та нар гэрээтэй шүү дээ!

- Та гэрээгээ зөрчсөн. Бүх гомдол үйлдвэрчний эвлэл дээр байгаа.

Ахлагч гарч хашааны үүд чиглэлээ.

-Хүлээгээрэй! Би үнэхээр харамсаж байгаагаа хэлсэн шүү дээ. Тэгэхээр ингэе. Би... би залуугийн өмнө уучлал гуйя, тэр ажилдаа эргэж орж болно.

-Камерон авхай, та намайг огт ойлгосонгүй. Залуу эргэж орохыг хүсэхгүй байгаа юм. Хот даяар барилга босч байхад бидэнд ажил хаа мундах вэ. Бас өөр нэг зүйл байна. Бид боссдоо хацар дээрээ жин тавиулаад зогсож байдаг завтай улс биш шүү, авхайхан минь.

Лара түүний араас удтал харан зогслоо. Үүнээс дор юм гэж юу баяхав. Бүрмөсөн балрах нь тэр ээ!

Бүсгүй жолооны ард суугаад  
аймшигт мэдээг Келлерт дуулгахаар  
оффис руугаа хурдаллаа.

Гэвч хэлэх хэрэг байсангүй.

-Аль хэдийнэ мэдсэн. Би дөнгөж сая  
үйлдвэрчний эвлэлтэй утсаар  
ярьлаа.

-Тэд юу гэж байна? гэж Лара яаран  
асуув.

-Сарын дараа хэрхэхээ дуулгана  
гэсэн.

-Сарын дараа гэнээ? Гэтэл бидэнд  
ердөө л... гээд түүний царай нь

хувхай цайгаад явчихав.

-Барилга дуусгах хугацааг би тэдэнд хэлсэн.

-Тэгээд юу гэж байна?

-Энэ тэдний асуудал биш гэж хэлж байна.

Лара буйдан дээр лагхийн унаад өглөө.

-Ээ Бурхан минь гэж! Одоо яах вэ?

-Ухаанд буухгүй л байна.

-Банкыг ятгаж дөнгөх... гэснээ  
Говардын царай ярвайн таталдахыг

хармагц үгээ Лара гүйцээлгүй  
тасалснаа, -За даа, үгүй байхаа даа  
гэснээ гэнэт нүд нь цогтойёо  
гялалзан,

-Өө тэгье! Бид өөр бригад хөлслөөд...  
гэв.

-Лара, Үйлдвэрчний эвлэлийн нэг ч  
гишүүн барилга руу хоншоороо  
цухуйлгахгүй.

-Би тэр өөдгүй новшийг алах ёстой  
байсан юм!

-Үгүй ер өө, энэ чинь бидэнд бузгай  
тус болох байсан байх нь ээ гэж  
Келлер хүйтнээр дуугарлаа.

Лара бухимдан өрөөн дотуур ийш тийш холхиж эхэллээ.

-Хэрэв Сэм Госденийг гуйвал яах вэ? Ээ чөтгөр гэж, би чинь түүнийг халчихсан шүү дээ!

-Яалаа гэж тэр вэ?

-Тийм чухал юм бишээ.

-Сайн өмгөөлөгч олохоор хөөцөлдөж болох л юм хэмээн Говард бодол болон хэлэв.

-Догь санаа байна. Таньдаг хүн бий юу тэгээд?

-Байхгүй. Гэхдээ Сэм нэг удаа Пол Мартин гэдэг нэрийг дурсаж байсан санагдана. Үйлдвэрчний эвлэлтэй үүсч болох маргааны тухай ярилцаж байхад энэ нэрийг хэлж байсан юм.

-Аль фирмд ажилладаг юм бол?

-Мэдэхгүй.

Лара дотуур холбооны товчлуурыг даран нарийн бичгийн даргаа дуудав.

-Кэти, Манхэттенд Пол Мартин гэдэг өмгөөлөгч байдаг гэнэ. Надад түүний хаягийг даруйхан олоод өг.



-Утас нь хэрэггүй юм уу? гэж  
Келлерийг асуухад нь,

-Надад цаг алга. Би уулзалт товлоод  
сууж байж тэсэхгүй нь.

Өнөөдөр түүнтэй уулзана. Тэр  
туслахыг зөвшөөрвөл болоод явчих  
нь тэр. Үгүй бол өөр гарц хайх  
болно. Түүний тархинд: Өөр гарц  
байхгүй гэсэн бодол эргэлдэж  
байжээ.

## Арван хоёрдугаар бүлэг.

Пол Мартины оффис Уолл-стритт дэхь албаны төвийн хорин таван давхарт байрладаг ажээ. Үүдэн дээр нь мөнгөлөг өнгийн төмөр дээр: "ПОЛ МАРТИН. ӨМГӨӨЛӨГЧ" гэсэн хаяг хадаатай байв. Лара гүнзгий гэгч нь санаа алдаад хүлээлгийн өрөөнд нь оров. Хүлээлгийн өрөө нь түүний санаснаас чамгүй даруу юмсанж. Тэнд ердөө л ард нь сэвсгэр цайвар үст бүсгүй суусан будаг нь ховхорч шалбарсан ширээ байлаа.

-Өглөөний мэнд. Танд юугаар туслах вэ?

-Би ноён Пол Мартинтай уулзах хэрэгтэй явна.

-Та уулзалтаа товлосон уу?

-Тэгсэн хэмээн Лара тайлбарлан цаг алдахыг хүссэнгүй товч хариулав.

-Таны нэр хэн бэ?

-Камерон. Лара Камерон гэдэг.

Цайвар үст хүүхэн түүнийг хөлнөөс нь толгой хүртэл эргэлзсэн харцаар нэвт ширтснээ,

-Түр хүлээнэ уу. Ноён Мартин таныг хүлээж авах эсэхийг асуугаадахья

гээд босон цаад өрөө рүү орлоо.

Бид ядахдаа царай зүсээ харалцах ёстой хэмээн Лара бодов. Нарийн бичгийн дарга тэр даруй гарч ирэн,

-Та, ор. Ноён Мартин таныг хүлээж байна гэх нь тэр. Ларагийн сэтгэл нь уужран гүн амьсгаа авлаа.

-Баярлалаа.

Бага шиг өрөөг ажлын ширээ, буйдан, кофейны ширээ, гурван байдлаар тун ч энгийн тохижуулсан байх аж. Энэ ч төрийн түшиг тулгууртай тун ч адилгүй байх шив гэж Лара бодов. Ширээний ард

хээлсэн мэт гүн үрчлээстэй, чин шударга царай, нарийн монхор хамар, зогдор мэт өтгөн буурал үстэй, үзтэл жар шахаж яваа эр сууж байлаа. Түүний дүр төрх нь махчин шувууг санагдуулна. Өмгөөлөгч хуучин загварын саарал ноосон пиджак, нарийхан зангиа, цасан цагаан цамц өмсчээ. Пол Мартин үл ялиг захирамжилсан тод дуугаар,

-Нарийн бичгийн дарга маань намайг тантай уулзалт товлосон гэж хэллээ гэв.

-Намайг уучлаарай. Би тантай заавал уулзах хэрэгтэй байна. Хойшлуулшгүй тун чухал хэрэг

гарлаа.

-Та суугаач, авхай...

-Лара Камерон гэж залруулаад  
сандалд суув.

-Таныг сонсож байна.

Лара амьсгаагаа даран амсхийснээ,

-Надад нэг асуудал гараад байна.  
Энэ нь барилгын тухай асуудал юм л  
даа гэлээ.

Ганц ч ажилчингүй таг зогсчихсон-  
тө.мөр бетонон хорин дөрвөн  
давхар барилга гэж Лара бодов.

-Цааш нь ярь, ярь.

-Ноён Мартин, би барилгын гүйцэтгэгч хүн. Ист-Сайдад барилга бариулж байтал барилгын явцад Үйлдвэрчний эвлэлтэй будлиан үүсчихээд байна.

Өмгөөлөгч чимээгүй чагнана.

-Би өөрийгөө эзэмдэж чадалгүй нэг ажилчныг алгадчихсан юм, гэтэл Үйлдвэрчний эвлэл ажил хаялт зарлачихлаа хэмээн Лара яаран дуржигнуулав.

Мартинь царайд эргэлзсэн байдал тодрон,

-Камерон авхай... Энэ асуудлаар  
яагаад надтай холбоо барих  
болсныг тань ойлгосонгүй гэлээ.

-Би таныг тусалж дөнгөх хүн гэж  
сонссон юм.

-Танд буруу л мэдээлж дээ. Би  
корпорациудтай ажилладаг  
болохоос барилгатай ч,  
Үйлдвэрчний эвлэлтэй ч огт  
холбоогүй.

Ларагийн аюулхай дээр ёгхийтэл  
хатгуулав.

-Өө! Надад хэлэхдээ... Өөрөөр хэлбэл  
та хүчин мөхөсдөөд байна уу?



-Танд ганц хоёр зөвлөгөө л өгч чадах байна даа. Хөдөлмөрийн маргааныг зохицуулдаг өмгөөлөгч олж ав. Тэр асуудлыг шүүхээр шийдүүлээд...

-Ингэж явах цаг алга. Барилга дуусгах хугацаа бараг тулж ирчихээд байна. Би... хоёр дахь зөвлөгөө чинь юу вэ?

-Өөрийнхөө үйл ажиллагааны хүрээг өөрчил. Энэ бизнест та огг нийцэхгүй юм байна гээд Мартины харц түүний чавхайн томбойх хөхөн дээр нь зогслоо.

-Юу-үү?

-Тэнд бусгүйчүүлд багтаж шингэх орон зай байхгүй.

-Тэгвэл тэр орон зай нь хаа байна гэж? Гал зууханд уу? Хүүхдийн өрөөнд уу? гэж Лара хорсолтойяа өгүүлэв. -Тиймэрхүү л гэх үү дээ.

Ёс зүйн хүрээнд биеэ барьж дийлэхээ больсон бүсгүй ухасхийн бослоо.

-Эрхэм ээ, та үлэг гүрвэлийн үеийн отог омгийн юм ярьж байх чинь. Эсвэл эмэгтэйчүүд эрх чөлөөтэй болсон гэсэн сонин содон мэдээг сонсоогүй юм шиг байна.

Өмгөөлөгч толгой сэгсэрч,

-Арай ч үгүй. Гагцхүү бүсгүйчүүл илүү гутамшигтай болоод байна гэв.

-Баяртай, ноён Мартин. Таны үнэт цагаас чинь үрснийг минь өршөөгөөрэй гээд Лара хаалгыг нь тас саван өрөөнөөс гарч, хонгилд гарсан хойноо гүн гэгчийн амьсгаа авлаа. Би алдаа хийжээ. Би мухардчихлаа. Аугаа их хөдөлмөрлөсөн он жилүүд нь талаар өнгөрөх нь тэр. Өөр хэнд хандах вэ? Хэнд ч хандаад нэмэргүй. Бүх юм өнгөрсөөн.

Тэрээр эл хуль оргих гудамжаар

өрөвдөх сэтгэлгүй аварга тоосгон  
ханануудыг эс анзааран хүйтэн  
салхи, шаагин орох бороон дундуур  
алхлана. Галав юүлсэн мэт мэдрэмж  
төрөн сэтгэл нь шаналан чихэнд нь  
Келлерийн: "Энэ чинь хөмөрсөн  
пирамид гэсэн үт... Хэрэв..." гэх үгс  
хангинана. Ийм юм л үзэх байжээ.  
Чикагогийн банк хадгалуулсан мөнгө  
хөрөнгийг нь битүүмжилж, барилгад  
оруулсан бүх мөнгө нь салхинд  
хийсэх нь тэр. Дахиад эхнээс нь  
эхлэх нь, Хөөрхий Говард. Тэр миний  
мөрөөдөлд чин сэтгэлээсээ итгэж,  
харин би түүнийг хуурчээ.

Бороо ч намдан, тэнгэр цэлмэх  
янзтай оочин цоочин сиймийсэн

үүлний завсраас нар зориг муутайхан булталзлаа. Лара гэнэт үүр цайсныг ойлгон сэхээрэв. Тэр бүхэл шөнөжингөө тэнэжээ. Дэмий л нэг тэнэж явсан Лара эргэн тойрноо харлаа. Урдхан талд нь хоёр хорооллын зайд түүний дутуу барьсан шоо дөрвөлжин, баларч гүйцээд байгаа өмч нь арзайж сэрзийн сүргүй үзэгдэв. За яахав, салахын өмнө нэг харья даа хэмээн Лара бодлоо.

Барилгын талбайд хүрэхэд наанадаж нэг хороолол үлдээд байтал ядарч гүйцсэн уураг тархи нь ямар нэг бүрхэг чимээ гарахыг сонсоодхов. Алхам алхамаар

урагшлах тоолонд өнөөх чимээ  
тодрон тодорсоор, хүнд алхны  
хэмнэлттэй цохилт, цахилгаан  
өрөмний тасралтгүй шунгинах дуу  
болох нь мэдэгдэв. Лара чихэндээ ч  
итгэж чадалгүй, хөлийн хурд мэдэн  
харайлгасаар барилгын хашааны  
торон хаалганд тулж очуутаа хөшчих  
нь тэр. Дутуу баригдсан барилга  
дээр ажил хэрэгч хүмүүсийн ийш  
тийш холхих үзэгдлээ.

Бригадын ахлагч инээд алдан дөхөж  
ирээд,

-Сайн байна уу, Камерон авхай! гэв.  
Үг хэлэх ч тэнхэл алдарсан Лара,

-Юу... юу болоод байна? Би... та чинь хүмүүсээ дахин нааш нь зүглүүлэхгүй гэж хэлсэн шүү дээ хэмээн түгдчив. Залуу эр аягүйрхэн толгой бөхийлгөөд,

-Бага зэргийн эндүүрэл болжээ, авхай. Бруно таныг түлхүүр унагаж алчих ч болох байсан гэлээ.

Ларагийн хоолойд бөөн юм торон бөглөрчихөв.

-Гэхдээ тэр...

-Энэ тухай март! Тэр манайхаас гарсан. Ийм явдал дахин гарахгүй гэдгийг батлая. Та санаа зовохын

хэрэггүй. Ажил хуваарийн дагуу ном ёсоор явагдаж байна.

Бүх юм хар дарсан зүүд шиг санагдан, Лара барилгын тулгуур моддын дундуур хөлхөх хүмүүсийг хараад:

Хэн бэ? Хэн эднийг зргүүлж авчрав аа? Пол Мартин уу? гэж бодов.

Бүсгүй оффистоо ирэнгүүт өмгөөлөгч рүү утасдвал харилцуурт нарийн бичгийн даргын,

-Тун харамсалтай байна, ноён Мартин яг одоо завгүй байна гэх дуу сонсдов.



-Түүнийг над руу яриач гэж хэлээд өгөөч.

Үдээс хойш гурван цаг болчихоод байхад утас таг чимээгүй хэвээр. Лара харилцуур аван залгалаа.

-Өршөөгөөрэй, ноён Мартин зөвлөгөөнтэй байна. Тэрээр Лара руу утасдахгүй нь бололтой. Лара таван цагийн алдад хүлээлгийн өрөөнд нь оров.

-Ноён Мартинд Лара Камерон уулзах гэсэн юм гээд хэлээд өгөөч. Цайвар үст бүсгүй шийдэж ядан,

-М-м-эдэхгүй ээ. Одоохон асууя гээд

өрөө рүү сэм орчихоод түрхэн  
зуурын дараа эргэж ирэн,

-Та ор ор гэлээ.

Пол Мартин эгцлэн ширтэн зогсоно.

-Аа, Камерон авхай юу. Та юу гэж  
явна? хэмээн элэгсэг сэтгэлийн, бас  
дайсагнасан хөг үл сонсогдсон төлөв  
дуугаар асуулаа.

-Би танд талархахаар ирлээ.

-Юунд тэр билээ?

-Арга тасарч явахад минь аварсны  
тань төлөө. Үйлдвэрчний эвлэлтэй

уулзсаны чинь төлөө.

Мартин хөмсөг зангидан,

-Ойлгосонгүй гэлээ.

-Ажилчид өнөө өглөөнөөс барилга дээр эргэн ирцгээж асуудал шийдэгдсэн. Талархаж байгааг минь хүлээн авна уу. Би таны хичээл зүтгэлийг...

-Камерон авхай, миний бодоход та эндүүрээд байна. Таны асуудал шийдэгдээ юу? Баяр хүргэе. Гэвч энэ надад огтын хамаагүй хэрэг. Түүний хэлсэн үг тэр даруй Ларагийн ой тойнд бууж өгсөнгүй. "З-заа, тэгвэл..."

Төвөг удсаныг минь уучлаарай...

-Зүгээр дээ, бүү санаа зов.

Өмгөөлөгч түүнийг харцаараа үдэн үлдлээ. Хормын дараахан босгон дээр нарийн бичгийн дарга бүсгүй үзэгдэн,

-Ноён Мартин танд Камерон авхай боодолтой зүйл үлдээлээ гэжээ. Хөх цаасаар ороон, хурц улаан туузаар баринтагласан бага шиг боодолтой зүйл байлаа. Гайхаж сонирхсон Мартин боолтыг аажим задалвал дотор нь гартаа бамбай атгасан дундад зууны үеийн баатрын мөнгөн дүрс гялтганан байлаа. Гэмээ

цагаатгаж байх шив. "Тэр намайг юу гэлээ? Үлэг гүрвэлийн отог омог гэл үү?" Түүний чихэнд нь балчир залууд нь хэлсэн өвөг эцгийнх нь үг сонсогдов. "Пол оо, хүнд бэрх цаг байсан шүү. Залуучууд мафийнхныг номхотгон дарахаар танхай яргачид, Үлэг гүрвэл Витогоос хагацахаар шийдсэн, Хаа сайгүй цусан гол урсаж байвч харчуул маань энэ бүхнийг хийсэн шүү."

Энэ бүхэн эртийн эрт, энд биш, Сицилид болсон юм.

# Арван гуравдугаар бүлэг

## Жибэллина, Сициль

1879 он

Мартинигийнхан бол Сицилийн жижигхэн тосгон болох Жибэллинад ирж суурьшсан өөр нутгийн хүн байлаа.

Энэ нутаг орон зэлүүд, үржил шимгүй, нарны илч хайр найргүй шарсан тийм л газар байлаа. Уг газарт баян газрын эзний эзэмшлийн том суурин байдаг. Эндээс Мартинигийнхан жижиг ферм худалдан аваад тэрийгээ өөрсдөө

амжилттай авч явахаар хичээн ажиллана.

Нэгэн өдөр Жузеппэ Мартинийг ахлагч болтой хүн дуудан "Энэ жижиг ферм чинийх үү?" гэж асуугаад "Газар нь хадархаг юм. Чи энд цаашдаа олив, усан үзэм тариалан амь зууж чадахгүй шүү!" гэлээ.

"Надад санаа тавих хэрэггүй. Би өөрөө дөнгөчихдөг юм" гэж Мартини хариулав.

"Бид бүгдийн төлөө санаа тавьдаг юм." гэж ахлагч зүтгэн "Дон Витод фермийн аж ахуй эрхлэхэд

тохиромжтой сайн газар байгаа, тэр чамайг өөрөөс нь газар түрээслээсэй гэж хүсч байгаа юм."

"Дон Вито болон түүний газрын талаар мэднээ" гэж Мартини амандаа бувтналаа. "Хэрвээ би түүний газрыг түрээслэх болбол тэр миний ургацын дөрөвний гурвыг аваад, дээр нь хүүнд нь гэж үрийг нь бүгдийг хураан авна. Эцэст нь би түүнээс газар түрээслэсэн бусдын адил юу ч үгүй хоцорно. Тэгэхээр түүнд намайг баярлалаа, үгүй гэж байнаа гэж хэлээрэй!" гэж нэмэв.

"Та их том алдаа хийж байна даа, синиор. Энэ бол аюултай орон. Энд



ноцтой осолд өртдөг юм шүү."

"Та нар намайг сүрдүүлж байна уу?"

"Өө яалаа гэж, синиор. Би зүгээр л танд анхааруулж ..."

"Миний газраас зайл." гэж Жузеппэ уурлан хэлэв. Ахлагч түүн рүү удаанаар харж харж, эцэст нь толгойгоо сэгсрээд "Чи ч зөрүүд хүн юм даа" гэж хэлээд явлаа.

Жузеппэ Мартинигийн хүү Айво

"Ааваа, энэ юун хүн бэ?" гэж асуув.

"Тэр нэг томоохон газрын эзэнд ажилладаг хүн." гэж хариулахад хүү

"Энэ хүн надад таалагдсангүй."

гэлээ. Аав нь мөн "Надад ч бас таалагдаагүй, хүү минь" гэв.

Энэ явдлын дараахан шөнө Жузеппэ Мартинигийн тариалан галд өртөж, хэдэн үхэр нь алга боллоо. Ингээд тэр хоёр дах алдаагаа хийв.

Тэр тосгоны цагдаагийн газар руу очин "Надад хамгаалалт шаардлагатай байна." гэхэд цагдаагийн дарга булзааруулсан байртай "За тэгэхээр тэрний чинь тулд л бид энд байгаа юм шүү дээ. Танд ямар асуудал гараа вэ, синиор?" гэв.

"Өнгөрсөн шөнө Дон Витогийн

хүмүүс миний тариаг шатааж,  
үхрүүдийг маань хулгайлсан байна."

"Энэ тэгвэл ноцтой асуудал байна.  
Та баталж чадах уу?"

"Түүний ахлагч манайд ирж намайг  
сүрдүүлсэн юм."

"Тэр тэгээд бид танай тариаг  
шатааж, үхрийг чинь хулгайлна шүү  
гэж хэлсэн юм уу?"

"Мэдээж үгүй л дээ."

"Тэр танд юу гэж хэлээв?"

"Намайг фермээ орхиод Пон

Витогоос газар түрээслэхийг шаардсан."

"Аа харин та татгалзаа юу?"

"Тэгэлгүй яадгийн."

"Синиор, Дон Вито бол их чухал нөлөөтэй хүн. Та түүнийг өөрт чинь газраасаа түрээслэхийг шаардсаны төлөө намайг баривчил гэж байгаа хэрэг үү?"

"Би намайг хамгаалахыг л хүсч байна." гэж Мартини шаардаад "Тэднийг намайг миний газраас шахан зайлуулахыг би зөвшөөрөхгүй."

"Синиор, би байдлбг ойлгож байна.  
Мэдээж би чадах бүхнээ хийх  
болно."

"Танд талархлаа."

"Бүх юм сайхан болно."

Энэ уулзалтын дараагийн өдрийн үд  
дунд Айво хүү хичээлээ тараад  
хотоос гэр лүүгээ явж байхдаа  
аавынх нь ферм рүү хэсэг морьтой  
хүмүүс очихыг харлаа. Тэд  
мориноосоо буун байшин руу  
орлоо. Хэдэн минутын дараа  
түүнийг аавыг чирч гарган газар луу  
түлхэв. Тэдгээр хүмүүсийн нэг нь  
гартаа буу барьжээ.

"Бид нар чамд өөрийгөө аврах боломжийг уг нь өгсөн юм. Одоохон энэ газраасаа яв."

"Үгүй, энэ чинь миний газар. Би ..." гэхэд буу барьсан нөхөр аавын нь хөлний хажууханд газар луу хий буудахыг айж балмагдан Айво харлаа. Тэр хүн аавыг нь

"Гүй" гэж зандрав. Жузеппэ Мартини гүйж эхэллээ. Морьтой хүмүүс зэрлэгээр орилолдон, гүйж байгаа аавыг нь тойрон давхилдана.

Айво нуугдан энэ аймшигт дүр зургийг нүдээ ч цавчилгүй харж байлаа.

Амь зулбан тал руу гүйх хүнийг морьтой хүмүүс даажигнан харж, шороон зам руу дөхөж очингуут тэдний нэг нь давхин хүрч түүнийг газар луу түлхэн унагана. Фермер цусаа гоожуулан туйлдан ядарчээ.

Дээрэмчид түүнийг гүйж болно гэж бодсон бололтой, тэд нэг нь олс авчран аавын нь хүзүүнд углан ойрхон харагдах худаг чиглэн чирлээ.

"Та нар яаж байгаан, би ямар буруу юм хийсэн юм?" гэж тэр орилно.

"Чи цагдаагийн газар луу очсон байна. Ингэх хэрэггүй л байсан юм."

Ахлагч олзлогдогчийн өмдийн доош нь шувт татахад нэг нь хутга гарган, хоёр нь түүнийг мөрөн дээр нь даран газар сөгдүүлэв.

"Энэ бүхэн чамд сургамж болох болноо."

"Үгүй ээ, битгий л дээ, намайг өршөө л дөө." гэж золгүй хүн хашгирна.

Ахлагч инээмсэглэн "Үүнийг эхнэртээ хэлээрэй за" гээд доош тонгойн түүний эрхтнийг хурц хутгаараа огтлон авав. Үүнтэй зэрэгцэн аймшигтай ёолсон хашгиралт агаарт тархлаа.



"Одоо чамд үүний хэрэг гэж байхгүй." гэж толгойлогч хэлээд тасалсан эрхтнийг нь ам руу чихэхэд тэрээр хахаж цацан амнаасаа гарган нулимав.

Тэдний толгойлогч бусдынхаа эл үйлдлийг харж байснаа "Эрхтнийг амт түүнд таалагдахгүй байгаа бололтой." гээд

"Uccidi quel figlio di puttana!" ("Түүнийг цааш нь харуул, чөтгөр ав!") гэж хэлэв.

Нэг дээрэмчин мориноосоо буун газраас хэдэн том чулуу аваад олзлогдогчийн цустай цамц, өмдний

халаасанд чулуугаа бүгдийг чихлээ.

"За ингээд яв даа!" гээд тэд аавыг нь өргөн худагний хашлага дээр тавин

"Замдаа сайн яваарай!" гэж хашгиран түүнийг доош түлхэн унагалаа.

"Ус түүнд яг шээс шиг амтагдах байхдаа" гэж тэд тавлан инээлдээд "Тосгоныхон үүнийг анзаарахгүй байх." гэж хэлээд хэсэг байзнаж худгаас гарах чимээг чагнаж байгаад чимээгүй болонгуут мориндоо мордон байшин чиглэн давхин явцгаав.

Арван настай Айво Мартини бухал

өвсний ард нуугдан, холоос энэ бүгдийг харж байлаа. Дээрэмчдийг холдонгуут худаг руу очин доошоо тонгойн "Ааваа ..." гэж сулхан дуудав.

Гэвч гүнзгий худаг чив чимээгүй.

Дээрэмчид Жузеппэ Мартинийг дуусгаад түүний эхнэр Мариаг хайж байшин руу нь очиход тэр гал тогооны өрөөндөө байлаа.

"Нөхөр маань хаана байна?" гэхэд тэд шоолон инээлдэж "Ус уухаар явсан" гэв.

Тэдний хоёр нь Мариад ойртон "Чи

тун дажгүй хүүхэн юм, даанч тийм хачин царай муутай юмтай яахаараа суучихдаг байнаа." гэв.

"Гэрээс минь зайл!" гэж түүнийг орилоход "Зочиддоо ингэж хандаж болдог юмуу?" гээд нэг нь түүний даашинзыг хүү татан урав. "Чамд одоо бэлэвсрэлийн хувцас өмсөхөөс өөр ажил байхгүй болсон!" гэхэд "Муу араатнууд!" гээд гал дээр буцалж байсан данхыг шүүрч аван шалзлам халуун усыг түүний нүүр лүү цацлаа.

Тэрээр өвдсөндөө чангаар бархиран "Өлөгчин!" гээд бугаа гаргаж ирэн эмэгтэйг буудав. Ахлагч "Малаа!

Эхлээд түүнийг шаагаад дараа нь буудах байсан юм!" гэж хашгирлаа. "За явцгаая, хийсэн ажлынхаа талаар Дон Витод илтгэе!"

Хагас цагийн дараа тэд Дон Витогийн эдлэнд байж байлаа.

"Бид эхнэр, нөхөр хоёрын талаар санаа тавиад ирлээ." гэж ахлагч тайлагнав.

"Аа харин тэдний хүүгийн хувьд?" Ахлагч босс руугаа гайхан харж "Та тэднийг хүүтэй гэж хэлээгүй ш дээ." "Тэнэгүүд минь! Би тэр гэр бүлийн талаар бүрэн санаа тавиарай гэж хэлсэн."

"Гэхдээ тэр ганц л хүүтэй, ноён Дон Вито."

"Хөвгүүд эр хүн болж өсдг юм. Тэгээд өшөөгөө авдаг. Түүнийг ал!"

"Таны хэлснээр хийеэ."

Дээрэмчдийн хоёр нь ферм рүү буцан давхилаа.

Айво эцэг эх хоёроо хоёуланг нь алуулахыг харан цочирджээ. Одоо энэ дэлхий дээр тэр цор гарцаараа хоцорч, очих ч газаргүй, хандах ч хүнгүй боллоо.

Байзаарай! Нээрээ түүнд хандах хүн байгаан байна шүү: аавынх ах,

Нунзио, Палермод. Айво хурдхан эндээс холдохгүй бол болохгүй гэдгийг мэдэж байлаа. Дон Витогийн хүмүүс түүнийг алахаар заавал эргэж ирнэ. Харин яагаад үүнийг эцэг эх хоёрыг нь алангуутаа хийгээгүйд гайхаж байлаа. Хүү үүргэвч рүүгээ бага шиг хүнс хийгээд мөрөндөө үүрэн фермийг хурдхан орхин явав.

Айво нарийхан шороон замаар алхан тосгоныг ардаа орхилоо. Ямар нэгэн чимээ сонсогдох юмуу, тэрэг ирж байвал хурдхан шиг замаасаа гаран модны ард нуугдан яву өнгөрөхийг хүлээнэ. Замд гарснаас хойш цаг орчмын дараа бүлэг

морьтой хүмүүс түүнийг хайн  
давхилдан явахыг тэрээр олж  
харлаа. Тэд нарыг өөрөөсөө холдон  
бараа тасартал нуугдсан газраасаа  
гаралгүй байж байгаад дахин аяллаа  
үргэлжлүүлэв. Шөнөдөө цэцэрлэгт  
орж унтан, модны үр жимс, талбай  
дах ногоогоор хооллож явлаа.  
Ингээд тэр гурван өдөр явав. Дон  
Витогоос холдож аюулгүй боллоо  
гэж үзээд жижиг тосгоноос галт  
тэргэнд суун Палермог зорилоо.

Шөнө дунд Айво авга ахынхаа гэрт  
хүрч очлоо. Нунзио Мартини хотын  
захад, маш сайхан, том байшинд  
амьдарна. Байшин зай талбай ихтэй  
тагт, сэрүүн тавцантай, хашаагаар



хүрээлэгджээ. Айво хонхыг дартал удтал чимээгүй байснаа "Чөтгөр ав гэж хэн бэ?" гэсэн чанга дуу гарав. "Айво байнаа, авга ах Нунзио!"

Хормын дараа хаалга нээгдэн Нунзио Мартини гарч ирлээ. Тэр бол биерхүү, дунд эргэм насны, том хамартай, намирсан цагаан үстний хүн байв. Унтлагын хувцастай Нунзио хүү рүү гайхан харж "Айво! Шөнө дунд чи энд юу хийж яваа юм бэ? Аав, ээж чинь хаана байна?" гэлээ.

"Тэд үхсэн" гэж Айво бувтнав.

"Үхсээн? За дотогшоо ор доо, ор,

ор." Айво бүдчин дотогш орлоо.

"Яасан аймшигтай мэдээ вэ? Юу болсон, тэд осолд ороо юу?"

Айво толгойгоо гудайлган сэгсэрч  
"Дон Вито тэднийг алуулсан."

"Алсаан, яагаад?"

"Аав түүний газраас түрээслэхийг зөвшөөрөөгүй юм."

"Оох"

"Юунаас болж тэр тэднийг алаа вэ? Тэд уг нь ингэдэггүй л юмсан." "Энд хувийн ямар ч асуудал байхгүй ш

дээ." гэж Нунзио Мартини хэллээ. Айво түүн рүү гайхан харж "Хувийн асуудал аа? Би ойлгохгүй байна." гэв.

Дон Витог бүгд мэднэ дээ. Тэр их нэртэй хүн. Тэр хүчтэй, нөлөөтэй, иймээс хүмүүс түүнээс айж хүндэтгэдэг. Хэрвээ тэр аавыг чинь зөрсөн чигт нь үлдээвэл бусад нь мөн дуурайн тэгнэ, тэгээд ирэхээр тэр өөрийн хүч, нөлөөгөө алдана. Тэгэхээр юу ч хийгээд нэмэргүй болсон байна."

Хүү авга руу айн харж "Юу ч гэж үү?" гэлээ.

"Одоо биш дээ, Айво минь, одоо л биш. Юуны түрүүнд чи сайтар унтаж амрах хэрэгтэй харагдаж байна."

Маргааш өглөө нь тэд цайгаа ууж байхдаа үргэлжлүүлэн ярилцлаа.

"За тэгэхээр чи энд миний байшинд надтай цуг амьдраад, ажил хийвэл хэр санагдаж байна даа?" гэж Нунзио асуулаа. Тэр бэлэвсэн, ганцаараа амьдардаг байв. "Би дуртай байна гэж бодож байна."

"Надад чам шиг ухаалаг хүү хэрэгтэй. Мөн чи эрч хүчтэй харагдаж байна."

"Би хүчтэй."

"Сайн байна."

"Та юу хийдэг юм бэ, авга ахаа?"

Нунзио Мартини хүү рүү  
инээмсэглэн "Би хүмүүсийг  
хамгаалдаг юм." гэлээ.

Мафи нь Сицилид анх үүсч гарч  
ирсэн бөгөөд эхэндээ Италийн  
харгис, дарангуйлагч төрөөс ядуу,  
зовсон иргэдийг хамгаалдаг байв.  
Мафи шударга бус явдалтай тэмцэж,  
өшөөг нь авч өгдөг байлаа, яваандаа  
төр нь Мафигаас айхаар хэмжээнд  
хүртэл хүчирхэгжиж, худалдаачид,  
фермерүүд хамгаалалтад нь алба  
гувчуур төлдөг болжээ.

Нунзио Мартини Палермо дах  
Мафийн толгойлогч байлаа. Тэр  
татаасаа өгч байгаа эсэхийг хянан,  
төлөөгүйд нь шийтгэл оногдуулна.  
Шийтгэлийн хэмжээ нь гар, хөлийг  
нь хугалахаас эхлээд удаан,  
шаналгаатай үхэл хүртэл янз бүр  
байна.

Ингээд Айво авга ахдаа хүчин зүтгэж  
эхэллээ. Арван жилийн турш  
Палермо түүний сургууль, авга ах нь  
багш болов. Айво зарлагаас эхлээд,  
яваандаа цуглуулагч, тэгсээр  
цаашилж авга ахынхаа итгэлт гарын  
хүн боллоо.

Айво хорин тавтайдаа Кармела

нэртэй том хөхтэй, сицили охинтой гэрлэн, жилийн дараа тэд Жиан Карло гэдэг хүүтэй болов. Тэд өөрийн гэсэн байртай болэ тэндээ амьдарцгаана. Авга ахыгаа өнгөхөд тэрээр байрыг эзлэн, ажил хэргээ улам амжилттай явуулан цэцэглүүлээ. Гэвч түүнд дуусгах ёстой нэг томоохон ажил байгаа.

Нэгэн өдөр Кармелад "Юм хумаа баглаж янзал. Бид Америк рүү нүүнэ." гэлээ. Эхнэр нь түүн рүү гайхан харж "Бид тийшээ нүүж яахын бэ?" гэлээ. Айво өөрөөс нь асуулт асуухад дургүй. "Зүгээр л хэлснээр минь хий. Би одоо яваад гурав хоногийн дараа ирнэ." гэж

ЭХНЭРТЭЭ ХЭЛЭВ.

"Айво ..."

"Юмаа багла."

\*\*\*

Жибэллинагийн цагдаагийн газрын үүдэнд гурван хар машин тоормослон зогслоо. Зуу гаран кг жинтэй цагдаагийн ахмад сандалдаа шигдэн хэдэн ноёд хаалгаар орж ирэхийг харлаа. Тэд маш сайн хувцасласан, дэгжин харагдана.

"Өглөөний мэнд, ноёдоо! Та нарт юугаар туслах уу?"



"Бид харин өөрт чинь туслахаар ирлээ" гээд Айво үргэлжлүүлэн "Намайг санаж байна уу? Би Жузеппэ Мартинигийн хүү байна." гэв. Ахмадын нүд эргэлдэн "Чи юу!" гэхээс өөрийг хэлж чадсангүй.

"Чи энд юу хийж яваа юм бэ? Энд чамд аюултай."

"Би энд чиний шүднээс чинь болоод ирлээ."

"Миний шүд ээ?"

"Тиймээ." гэхэд Айвогийн хоёр хүн ахмадын хоёр талд гаран гарыг нь ард нь барилаа.

"Чиний шүдэнд эмчилгээ хийх шаардлагатай юм байна. Би одоохон янзлаадахъя." гээд Айво буугаа гарган түүний ам руу нь гохоо дарлаа. Тэгээд хамтрагчид рууга хандан "Алив явцгаая." гэв.

Арван таван минутын дараа нөгөө гурван машин Дон Витогийн байшингийн гадаа ирлээ. Байрны гадаа хоёр хамгаалагч ийш тийш сэрэмжлэн харна. Машин зогсонгуут Айво үсрэн буугаад "Өглөөний мэнд! Дон Вито биднийг хүлээж байгаа." гэв. Нэг хамгаалагч хөмсгөө зангидан "Тэр та нарыг ирэх тухай юу ч ..." гээд үгээ дуусгаж чадалгүй хөсөр унав. Буу том тугалган цэнэглэгдэн,

ангуучдын зэвсэг үрлэг сумаар шүршихэд нөгөө хамгаалагч хэдэн хэсэг болон үсрэв.

Буудалцааныг Дон Вито байшин дотор сонсоод цонхоор шагайн, гадаа юу болсныг мэдэнгүүтээ шургуулгаа онгойлгон гар буугаа авлаа.

"Франко!" гэж дуудаад "Антонио! Хурдал!" гэж бархирахад гадаах буудалцаанаас өөр чимээ сонсогдсонгүй. "Дон Вито .." гэж дуудахад тэрээр огло үсрэн эргэн тойрноо харлаа. Айво гартаа буу барин зогсч "Буугаа хая!" гэж зандрав.

"Би ..."

"Хая гэж байна шүү!"

Дон Вито шал руу буугаа шидээд  
"Юу хүссэнээ авч болно, тэгээд  
хурдан зайл!" гэлээ. Айво хариуд нь  
"Надад юу ч хэрэггүй" гээд "Тэгэхээр  
миний энд байгаа гол шалтгаан бол  
би чамд зарим нэг талаар өртэй  
юм."

"Тэгээд тэр чинь энэ үү, за яахав би  
энийг чинь мартчихна."

"Би бол үгүй шүү. Намайг хэн гэдгийг  
мэдэж байна уу?"

"Үгүй."

"Айво Мартини."

Хөгшин хөмсөг зангидан, санахыг оролдсоноо мөрөө хавчин "Энэ нэр надаа юуг ч сануулахгүй байна."

"Арван таван жилийн тэртээ. Чиний хүмүүс миний эцэг эхийг алсан."

"Тун харамсалтай." гэж Дон Вито уулга алдаад "Би тэдгээр хүмүүсийг шийтгэх болно. Бас би ..." гээд үгийг нь дуусгалгүй Айво түүн рүү очин буугаараа хамар дундуур нь буулгалаа. Цус сад тавин гоожиход "Энэ тийм ч чухал биш." гэж үглэнэ.

"Би ..." гэхэд Айво хутгаа гарган  
"Өмдөө тайл." гэв.

"Яах гэж байгаан? Чи арай ..."

Айвог бугаа өргөөд "Өмдөө тайл  
гэж байна шүү." гэж зандарлаа.

"Битгий!" гэж хашгирахад "Юу хийх  
гэж байгаагаа тунгааж үз. Би хүүтэй,  
бас ах дүү нартай. Хэрэв чи намайг  
хөнөөвөл тэд чамайг мөшгөж олоод  
яг л нохой шиг цааш харуулна."

"Хэрвээ тэд намайг олж чадвал,"  
гээд Айво "Өмдөө." гэв

"Үгүй ээ."

Айво түүний нэг өвдгийг буудлаа.  
Хөгшин өвдсөндөө чанга хашгирав.

"Чамд туслахыг зөвшөөрнө үү." гээд  
Айво түүн рүү очин өмдийг нь тайлж  
дотуур өмдтэй нь үлдээв. "Тэнд тийм  
ч олон юм байхгүй тийм үү? Сайн  
байна, одоо бид хамгийн сайн  
гэснээрээ хийх болно." гээд Дон  
Витогийн эрхтнийг гаргаж ирэн шууд  
огтолчихов.

Дон Вито муужран унахад Айво  
эрхтнийг ам руу нь хийгээд  
"Харамсалтай нь чамайг чулуудах  
худаг даанч алга даа." гэв. Үдэлтийн  
дохио түүн рүү зангаад тэрээр  
хөгшний толгой руу буудан,

байшингаас гарч машин рууга очоод хүлээж байсан хамтрагчиддаа "Алив хөдөлцгөөе!" гээлээ.

"Эднийх их том гэр бүл шүү Бусад нь чиний араас мөшгөнө дөө."

"Тэгж л байг."

Хоёр өдрийн дараа Айво эхнэр хүүгээ дагуулан Нью Йорк орон усан онгоцонд сууж байлаа.

Энэ Шинэ ертөнц нь өнгөрсөн зууны төгсгөлд боломж, аз завшааны нутаг болсон юм.

Нью Йоркод итали гаралтай хүмүүс



их байдаг байлаа. Айвогийн олон найз нөхөд энэ том хотод ирж суурьшин, түүний хамгийн сайн хийдэг ажлыг ашиглахаар шийдэцгээсэн байв. Энэ бол мэдээж айлган сүрдүүлэлтийн хамгаалалт. Мафи өөрийн тэмтрүүлүүдээ энд тэнд байрлуулж эхэллээ. Айво өөрийн овог Мартини гэдгийг англи нэр лүү хувирган Мартин болгон өөрчилөн, мөн өөрийн амжилтандаа сэтгэл хангалуун байв.

Жиан Карло эцгийнхээ урмыг ихээр хугална. Түүнд аавдаа ажиллах ямар ч сонирхол байхгүйн дээр хорин долоотойдоо нэгэн итали охиныг жирэмсэн болгожээ. Тэднийг

чимээгүйхэн гэрлүүлэн, гурван сарын дараа хүү Пол нь төрлөө.

Айво ач хүүдээ том төлөвлөгөөтэй байв. Америкт хуульч маш хэрэгтэй, иймээс тэрээр ач хүүгээ өмгөөлөгч болгохоор шийджээ. Залуу Пол хүссэндээ хүрэх гэдэг эрмэлзэлтэй, ухаалаг хүү байлаа. Түүнийг хорин хоёртой байхад Харвардын Хуулийн сургуульд оруулав. Хүүг сургуулиа төгсөхөд Айво нэр хүндтэй хуулийн фирмд ажилд ороход санаа тавин удалгүй Пол фирмийнхээ хамтрагч боллоо. Таван жилийн дараа Пол өөрийн хуулийн компанитай болоход Айво хууль ёсны бизнест хөрөнгө орууллаа. Гэвч тэрээр

Мафитай холбоогоо таслаагүй хэвээр, ач хүү нь түүний ажил хэргийг гартаа авч явуулдаг болов. Айвог нас барсан 1967 онд Пол итали охин Нинатай гэрлэлээ. Жилийн дараа эхнэр нь түүнд ихэр хүү гаргаж өгөв.

Дал хүрсэн ч Пол завгүй хэвээр байр болно. Түүний гол үйлчлүүлэгчид холбоонд нэгдсэн байдаг учир тэр хүчтэй байдаг байлаа. Том бизнесмен, үйлдвэрийн эзэд түүнд захирагдана.

Нэг өдөр Пол өөрийн нэгэн үйлчлүүлэгч болох нэр хүндтэй банкны эзэн, Полын гэр бүлийн талаар юу ч гадарладаггүй Билл

Роантай үдийн хоол идэж байлаа.

"Чи манай гольфийн клуб Саннивэйлд орох хэрэгтэй." гээд Билл Роан "Чи гольф тоглодог биз дээ" гэж асуув.

"Мэдээж, завтай үедээ."

"Болж байна, Би удирдах зөвлөлд байдаг. Чамайг гишүүнчлэлээр санал оруулахад чи татгалзахгүй биз дээ?"

"Тэгвэл сайн л байна."

Дараагийн долоо хоногт удирдах зөвлөлийнхөн шинэ гишүүний талаар хэлэлцлээ. Пол Мартиний

нэрийг дурдахад "Би түүнийг дэвшүүлсэн юм." гээд Билл Роан "Тэр тун дажгүй хүн байгаа юм." гэлээ.

Удирдах зөвлөлийн өөр гишүүн болох Жон Хаммонд "Тэр чинь итали хүн биз дээ? Манай клубт тэр дагосын (америкууд итали гаралтай хүмүүсийг доромжилж хэлдэг нэр. Монголчууд муу хужаанууд гэдэг шиг) хэрэг байхгүй, Билл ээ." гэж эгдүүцэн хэлэв. Банкир түүн рүү дургүйцэнгүй хараад

"Чи тэгээд татгалзсан санал өгч байна уу?"

"Тийм л болж байна даа."

"За тэгэхээр түүнийг татгалзлаа.  
Дараагийн хүн ..." гээд хурал цааш  
үргэлжиллээ.

Хоёр долоо хоногийн дараа Пол  
Мартин банкны эзэнтэй дахин  
өдрийн хоол хамтдаа идэв. Пол "Би  
ч гольфоо давтаад л байгаа шүү."  
гэж тоглон хэллээ. Билл Роан бага  
эвгүйцэн, санаа нь зовсон байдлаар  
"Бага зэргийн саатал гарсан." гэв.

"Саатал аа?"

"Би чамайг гишүүн болгох санал  
оруулсан. Гэвч удирдах зөвлөлийн

өөр нэг гишүүн чамаас татгалзсан."

"Хөөх, яагаад?"

"Үүнийг чи өөртөө хамаатуулан тусгаж аваад хэрэггүй. Тэр ер нь муйхар хүн, италиудад дургүй юм."

Пол мушийн инээмсэглэн "Энэ надад тийм ч төвөгтэй биш, Билл. Олон хүн италиудад дургүй байдаг ш дээ, энэ ноён ..."

"Хаммонд. Жон Хаммонд."

"Махны худалдаачин уу?"

"Аанхан. Тэр бодлоо өөрчилнөө, би

түүнтэй дахин нэг ярина."

Пол толгойгоо сэгсрэн "Тэгж төвөг удаад яах вэ! Намайг гольфод тэглээ их хорхойсоод байгаа юм байхгүй гэж байна гээрэй."

Зургаан сарын дараа 7-р сарын дунд үед Махны Хаммонд Худалдаа компанийн хөргүүртэй том ачааны тэрэг гахайн гол мах, стикний давтсан мах, гахайн далны цул мах ачин Миннэсртагийн махны үйлдвэрээс Буффало, Нью Жерсигийн дэлгүүр рүү хөдөллөө. Харин ачааны тэрэгний жолооч нар замд машинаа зогсоон хөргүүртэй ачааны хаалгыг онгойлгон орхиод явж оджээ.



Үүнийг сонсоод Жон Хамманд дэлбэртлээ уурлаж, менежерээ дуудлаа.

"Ингэхэд юу болоод байгаа юм бэ?"

"Сая таван зуун мянган долларын мах наранд мууджээ. Яаж ийм юм байж болох вэ дээ?"

"Холбооныхон ажил хаясан байна." гэж ахлах ажилтан хэллээ.

"Бидэнд хэлэлгүйгээр үү? Тэгээд тэд ямар шаардлага тавьж байна? Цалингаа нэм гэнэ үү?"

Ахлах мөрөө хавчин "Би мэдсэнгүй.

Тэд надаа юу ч хэлээгүй, тэгээд яваад өгсөн."

"Холбооны орон нутгийн төлөөлөгчийг намайг уулзъя гэж байна гээрэй. Би энэ асуудлыг шийдвэрлэе." гэж Хаммонд хэлэв.

Үдэд холбооны төлөөлөгч Хаммондын албан тасалгаанд ирлээ. Хаммонд "Яагаад ажил хаях болсноо надад урьдчилан хэлсэнгүй вэ?" гэж шаардлаа. Төлөөлөгч уучлал гуйсан байдлаар "Би өөрөө ч энэ талаар мэдээгүй, ноён Хаммонд. Залуус уурлаад л тэгээд яваад өгсөн. Энэ явдал гэнэт болсон" гэж учирлав.

"Намайг иймэрхүү асуудлыг ойлгон хүлээж авдаг гэж чи мэднэ дээ. Тэгээд тэд юу хүсээд байгаан, цалингаа нэмэх үү?"

"Үгүй ноёнтоон. Энэ нь саван." гэхэд Хаммонд түүн рүү гайхан гөлөрч

"Чи саван гэж хэлэв үү?" гэв.

"Яг тийм. Угаалгын өрөөнд байгаа, тэдний хэрэглэдэг саван их хурц гэсэн." Хаммонд ийм зүйл сонссондоо үнэндээ итгэсэнгүй.

"Саван хэтэрхий хурцаа? Тэгээд тэрнээс болоод би сая таван зууг алдсан гэж үү дээ?"

"Та намайг зэмлээд хэрэггүй. Эдгээр залуус л ..." гэж төлөөлөгч хэлэв.

"Бурхан минь" гээд Хаммонд "Би үүнд чинь итгэж чадахгүй нь. Тэд тэгээд яг ямар саванд дуртай юм бэ дээ - шидэт саван уу?" гээд уурандаа ширээгээ нударгаараа шаагаад авлаа. "Дараагийн удаа залууст асуудал гарвал хамгийн түрүүнд надад мэдэгдээрэй! Ойлгож байна уу?"

"Тэгнээ, ноён Хаммонд."

"Тэднийг ажилдаа буцаад ор гэж хэл. Өнөө орой 6 цаг гэхэд тэдний угаалгын өрөөнд хэрэглэх сайн

савангийн мөнгийг өгөх болно.  
Ойлгомжтой юу?"

"Би тэдэнд хэлье? ноён Хаммонд."

Жон Хаммонд бодлогошрон  
сандалдаа удаан суув. Энэ оронд  
ингэхэд яг юу болоод байна даа,  
Саван шүү! гэж бодлоо.

Хоёр долоо хоногийн дараа 8-р  
сарын бас нэгэн халуун өдөр Сиракус  
болон Бостон руу мах тээвэрлэж  
явсан Хаммондын таван ачааны  
тэрэг мөн л зам дээр хаалга нь  
дэлгээтэй хоцорчээ. Энэ өдрийн  
оройн 6 цагт Хаммонд үүнийг мэдэв.

"Тэд одоо юу гэгцгээж байна?" гэж хашгирлаа. "Шинэ саван тэнд нь тавиагүй юм уу?"

"Тавьсан." гээд менежер нь "Таныг хэлсэн өдөртөө л тавьсан." гэлээ.

"Одоо тэгээд ямар чөтгөрөө нэхэж байна?"

Менежер сулханаар "Би мэдэхгүйн байна. Тэд ямар ч гомдол тавиагүй. Хэн ч надаа юу ч хэлээгүй." гэв.

"Тэр хараал идсэн холбооны төлөөлөгчийг дууд."

Хаммонд оройн 7 цагт холбооны

төлөөлөгчтэй уулзаж байлаа.

"Хоёр сая долларын өртөгтэй мах өнөөдөр үдэд танай залуусаас болж муудлаа." гэж Хаммонд уурандаа мэнчийн орилоод "Тэд галзуурсан юм уу хаашаа юм?" гэв.

"Ноён Хаммонд, энэ үгээ та холбооны ерөнхийлөгчид намайг хэлээсэй гэж хүсээ юү?"

"Үгүй, үгүй." гэж Хаммонд хурдхан хэлээд "Урд нь эдгээр залуусын учруулсан шиг иймэрхүү асуудал надад хэзээ ч тохиолдож байгаагүй юмсан. Хэрвээ тэд илүүг төлөхийг хүсч байгаа бол зүгээр л наашаа

ирээд учраа ололцож болно ш дээ.  
Тэгээд хэдийг гэж байгаа юм бэ?"

"Хэдийг ч биш."

"Энэ чинь юу гэсэн үг вэ?"

"Энэ бол мөнгөний тухай биш, ноён  
Хаммонд."

"Ооох, тэгээд юу юм?"

"Гэрэл."

"Гэрэл ээ?" гээд Хаммонд өөрийгөө  
түүний хэлснийг ойлгосонгүй гэж  
бодлоо.

"Тиймээ. Залуус угаалгын өрөөний



гэрлийг хэтэрхий бүүдгэр байна гэсэн."

Жон Хаммонд сандалдаа лаг хийтэл суугаад, гэнэт дуугүй болов. "Энд яг юу болоод байгаан бол?" гэж тэрээр намуухан асуулаа.

"Би танд хэлсэн ш дээ. Тэд бодохдоо ..."

"Наад балай юмаа орхи. Юу болоод байгаан бэ?" гэхэд холбооны төлөөлөгч "Мэдэхийн бол танд би хэлнээ."

"Хэн нэгэн хүн миний бизнесийг нураахыг хүсч байгаан байна, тийм

биш гэж үү?" Төлөөлөгч чимээгүй боллоо.

"За алив, түүний нэрийг хэлээдэх! Би хэнтэй ярих ёстой вэ?" гэж Хаммонд эцэст нь хэлэв.

"Танд тусалж чадах нэгэн хуульч байгаа. Холбоо түүнтэй хамтарч ажилладаг юм. Түүнийг Пол Мартин гэдэг."

"Пол гэнээ ...?" гэснээ Жон Хаммонд гэнэт саналаа. "Яалаа гэж тэр муу нохойн зулбасаг намайг ингэж сүрдүүлж байгаан? Эндээс зайл! Зайл гэж байна шүү!" гэж хашгирав.

Хаммонд уурандаа түхэлзэн суугаад "Хэн ч намайг сүрдүүлж чадахгүй. Хэн ч шүү!" гэж өөртөө хэллээ.

Дахин долоо хоногийн дараа түүний зургаан ачааны тэрэг, мөн дахин хэд хэдэн тэрэг замдаа хаягдан хоцров. Үүний дараа Жон Хаммонд Билл Роантай зоог барилаа. "Би чиний найз Пол Мартинийн талаар бодлоо л доо. Би түүний гишүүнчлэлийг яарах татгалзжээ." гэж Хаммонд хэлэв.

"Яасан бэ, ингэж хэлж байгаа чинь тун сайхан өгөөмөр байна шүү, Жон."

"Би чамд нөгөө юу гэж хэлэх гэсэн юм л даа, дараагийн долоо хоногийн цугларалт дээр чи Пол Мартинийг дахин дэвшүүлнэ биз, би түүнийг зөвшөөрч саналаа өгнөө."

Тэр долоо хоногтоо цугларалт дээр Пол Мартинийн нэр дахин орж ирж, гишүүд санал нэгтэйгээр түүнийг батлав. Жон Хаммонд өөрөө Пол Мартини руу утасдан:

"Баяр хүргэе! Ноён Мартин. Та Саннивэйлийн гишүүн боллоо. Танийг манай клубт нэгдэж байгаад бид их баяртай байгаа."

"Баярлалаа. Ярьсанд чинь

талархлаа." гэж Пол хэллээ.

Үүний дараа Пол тойргийн шүүгчийн албан тасалгаа руу залган дараагийн долоо хоногт уулзах цаг авлаа.

Ням гаригт Жон Хаммонд, Билл Роан хоёр клуб дээрээ нэг тал болон тоглолоо.

"Чи Пол Мартинтай уулзаж амжаагүй байгаа биз дээ?" гэж Билл Роаныг асуухад Жон Хаммонд толгойгоо сэгсрэн "Үгүй ээ. Гэхдээ би түүнийг гольф тоглох тийм ч их цаггүй болсон болов уу гэж бодож байна. Ерөнхий шүүгч чиний найзыг завгүй байлгахаар болсон." гэлээ.

"Чи юу яриад байнаа?"

"Би тойргийн шүүгчид түүнийг ерөнхий шүүгч болохыг санаархаад байгаа гэсэн мэдээлэл өгөх болно." Билл Роан гайхан "Юу хийж байгаа чи мэдэж байна уу?"

"Намайг үүнийг хийнэ гэж чи мөрийцсөн ч болно шүү. Тэр бол нэг муу жоом, би түүнийг няц гишгих болно."

Даваа гарагт Жон Хаммонд тойргийн шүүгчийн байр луу орох гэж зам хөндлөн гарч машинд дайруулах үхжээ. Энэ ослыг харсан гэрч байсангүй, цагдаа мөн дайрсан

жолоочийг ч олсонгүй.

Энэ хэргийн дараа Пол Мартин Ням гараг бүр эхнэр, ихрүүдтэйгээ Саннивейл клубт очиж өдрийн хоол иддэг боллоо. Тэдний хоол маш сайхан амттай.

Пол Мартин эхнэртэйгээ гэрлэхдээ өөртөө нэгэн чухал амлалт өгчээ. Жишээ нь, нууц амрагаа дагуулан ирсэн ресторанд эхнэрээ хэзээ ч авчирч нэр хүндийг нь гутаахгүй. Түүний гэрлэлт бол амьдралынх нь нэг хэсэг, аа харин бусад асуудал бол өөр хэсэг юм. Полын найзууд бүгд нууц амрагтай байдаг байлаа.

Энэ бол хүлээн зөвшөөрөгдсөн тэдний амьдралын хэв маяг байв. Полын хувьд хөгшин эрчүүд залуу охидыг дагуулаа болгож байгаа нь санааг зовооно. Энэ нь нэр төрөө гутааж байгаа явдал юм. Пол Мартин өөрийн нэр хүндийг чухалчилж үздэг байлаа. Тэрээр жар хүрээд нууц амрагийн асуудлаа зогсооно гэж шийдсэн бөгөөд хоёр жилийн өмнө жаран насны төрсөн өдрөө тэмдэглээд энэ үгэндээ хүрчээ. Эхнэр Нина нь түүний сайн хамтрагч юм, энэ л түүнд хангалттай.

Нэр төрөө гэж.

Лара Камероны тусламж хүсч ирсэн



хүн ийм л хүн байлаа. Пол Мартин Лара Камерон гэсэн нэрийн хүндэтгэдэг, гэхдээ түүнийг ийм дур булаам, залуу сайхныг хараад эргэлзэх сэтгэл төржээ. Тэр хүссэндээ хүрэхээр тэмүүлсэн, бие даасан бас эмэгтэйлэг сайхан бүсгүй. Түүнд өөрөө ч мэдэлгүй татагдаж байгаа мэдэрч байлаа.

Үгүй ээ, тэр хэтэрхий залуу юм гэж бодлоо. Би бол хөгшин хүн, хэтэрхий хөгшин шүү.

Лара анх өрөөгөөр нь ороод гарсан тэр өдөр Пол түүний тухай удаан гэгч нь бодол болж дараа утсаа шүүрч аван залгалаа.



## Арван дөрөвдүгээр бүлэг.

Барилгын ажил шувтрах тийшээ хандав. Лара өглөөгүүр, үдийн цайны дараа өдөртөө хоёр л удаа барилгаар эргэлдэхдээ цоо шинэ, чин сэтгэлийн хүндэтгэх харц өөрийг нь тэмтрэхийг мэдэрдэг болов. Хэн хүний хэл үг, үйл хөдлөл бүрээс хүндэтгэл илэрхийлэгдэж, харах харцнаас нь хайр нэвт шувт гэрэлтэнэ. Ийм гайхамшигтай өөрчлөлтийн ард ноён Мартины гавьяа бий гэдгийг Лара тун сайн ойлгох тусам дуунд нь маргашгүй эрх мэдэл сонсогдох хөгшин харцагатай

адил энэ эрхэмийг бодох тусам  
сэтгэл нь түгшинэ.

Эрслэн шийдсэн Лара түүний  
дугаарт залгалаа.

-Ноён Мартин, хамтдаа үдийн хоол  
идэх үү?

-Камерон авхай, танд дахиад  
асуудал үүсээ юу?

-Үгүй дээ. Би ердөө л бид бие  
биесийг арай илүү таньвал дээргүй  
юу л гэж бодсон юм.

-Намайг уучлаарай. Би үдийн хоол  
иддэггүй юм.

-Тэгвэл оройн хоолонд орвол юу гэхсэн бол?

-Камерон авхай, би эхнэртэй хүн. Гэртээ үр хүүхэд, хань ижилтэйгээ хооллож заншсан юм.

-Ойлголоо. Тэгвэл...

Харилцуурт тасалдсан дуу жингэнэх сонсдов.

"Яачихсан хүн гэхээрээ ийм байдаг байна. Би ямар түүнийг ор руугаа чирэхийг оролдсон биш. Зүгээр л талархсанаа илэрхийлэх л гэсэн шүү дээ, за яахав ээ. Тэр яагаад дургүйцээд байгаа юм бол."

Бүсгүй өмгөөлөгчийн тухай бодлоо таягдан хаяхаар шийдэв.

Ларагийн цээл дуу хоолой зүрхийг нь ерийнхөөс хүчтэй булгилуулан цохилуулна чинээ Пол Мартин санасангүй.

Тэрээр нарийн бичгийн даргаа дуудан,

-Хэрэв Камерон авхай дахин ярих юм бол намайг эзгүй байна гэж хэл хэмээн товчхон захирамжлав. Өдий хэрийн насны эрчүүдэд хорхойг нь татах элдэв шалдвын эмс хүүхнүүд хэрэггүй байтал Лара

Камерон юу юунаас илүү хүчтэйгээр сэтгэлийг нь татах ажээ.

\* \* \*

Ажлын бүх явц Говард Келлерт чамгүй сэтгэл ханамжийг төрүүлж байв.

-Лара, байдал намайг нилээд түгшээж байсныг хүлээн зөвшөөрөх ёстой. Бид хамаг байдгаа гөвчихөөд баларч гүйцэх нь гэж бодож байсан чинь чи ханцуйнаасаа тагтаа нисгэдэг ид шидтэн шиг л байлаа шүү.

Үгүй, би биш. харин Пол Мартин гэж

Лара дотроо андынхаа бодлыг засав. Бүсгүй ачийг нь хариулаагүйд өмгөөлөгч гомдсон нь гарцаагүй.

Туйлгүй баярласан Лара Полд тавин мянган долларын чек илгээжээ.

Гэтэл нэг өдрийн дараа зарлага чекийг нь буцааж авчирчээ. Дугтуй дээр ганц ч үгээр болов тайлбарласан зурвас байсангүй.

Угийн зөрүүд зантай Лара ухасхийн хэзээний мэдэх болсон дугаарт залгавал,

-Уучлаарай, ноён Мартин эзгүй байна гэж нарийн бичгийн дарга



хариулжээ.

Бас л бүтсэнгүй! Пол түүнээс зориуд зугтааж байна гэсэн бодол төржээ,

"Хэрэв тийм юм бол тэр яагаад надад туслан энэ бүгдийг хийгээ вэ?" хэмээн Лара бодов,

Тэр шөнөдөө Лара цурам хийлгүй хоножээ.

Өглөө нь Говард Келлер инээд алдсаар Ларагийн өрөөнд орж ирэв.

-Нөгөөдрийн үзэх Эндрю Уэберын "Аялгуу ба бүжиг" гэдэг мюзиклын хоёр тасалбар байна, харин би орой

Чикаго явах болчихлоо! Чи авахгүй юу?

-Үгүй ээ, би... Байзаарай! хэмээн нэгийг тооцоолсон бололтой.

-Билетийг чинь авна байгаа.  
Баярлалаа, Говард аа гэв.

Тэрээр үдээс хойш нэг тасалбарыг дугтуйлан, яаралтай шуудангаар ноён Пол Мартини оффис руу илгээлээ.

\* \* \*

Пол дугтуйг нээн тасалбарыг гайхан эргүүлж тойруулан үзлээ. Түүнийг

театрт урьжээ! Хэний толгойд ийм ойворгон ухаангүй бодол төрөх нь энэ гээч вэ? Нөгөө Камерон хүүхэнд төрөө шив. Өөр хэнд ч ийм бодол төрөхгүй. Үүнийг эцэслэн зогсоох цаг нь иржээ! хэмээн тэрээр шийдэв.

-Баасан гаригийн орой надад зав байна уу, үзээдэх? гэж өмгөөлөгч нарийн бичгийн даргаасаа асуулаа.

-Та хүргэнийдээ оройн хоолонд очих ёстой, эрхэм ээ. -Хойшлуул.

Мюзикл эхлэх дөхөж Ларагийн дэргэдэх суудал хоосон хэвээр байлаа. Тэгэхээр, мань хөгшин ирэхгүй нь ээ. Түүнийг чөтгөр аваг!

Би чадах бүхнээ хийлээ.

Хөшиг нээгдэхэд Лара гарч явах уу  
эсвээс үзэж дуусгах уу гэдэгт  
эргэлзсээр суутал энэхэн мөчид  
хажууханд нь эрэгтэй хүний дүрс  
сүүдэгнэж,

- Алив гарцгаая! гэх Пол Мартины  
хэлэх нь тушаал мэт сонсогдох нь  
тэр.

Тэд оройн хоол идэцгээхээр Ист-  
Сайд дахь зоогийн газар орцгоов.  
Мартин өөдөөс нь харан тайван  
атлаа бага зэрэг алжаасан харцаар  
Лараг ширтэн суулаа. Үйлчлэгч  
тэдний суусан ширээнд ирээд,

-Юу уух вэ, ноёд оо? гэв.

-Скотч, содтой ус хэмээн Лара захиалгаа өгөв.

-Надад юу ч хэрэггүй гэж Полыг татгалзахад Лара өмгөөлөгч тийш гайхан харлаа.

-Би спиртний төрлийн ундаа амсдаггүй юм хэмээн Пол дургүйцэн хариулав.

Дараа нь тэд хоол захиалцгаав.

-Камерон авхай та надаас юу хүсээ вэ? гээд Мартин түүний нүд рүү эгцлэн ширтэв.

-Өөрийгөө өртэй хэмээн бодож  
явахыг хүсэхгүй байна. Та надад, би  
заавал ч үгүй төлөх ёстой тусыг  
үзүүлсэн. Энэ л намайг шаналгаж  
байна.

-Би хэдийнэ хэлсэн... та ямар ч  
өргүй,

-Гэхдээ...

-Барилга мөд дуусах гэж байгаа  
гэлцэх юм.

-Удахгүй ээ гэснээ Лара золтой л  
"таны ачаар" гэж хэлчихэлгүй цагийг  
нь олж амаа бариад,

-Та ч өөрийнхөө ажлыг арван хуруу шигээ мэддэг биз гэв.

-Тийм л болов уу гэж найдах юм. Чиний ухаанд багтамгүй санаа чинь цементэн зуурмагаар биеллээ олж, хүн ажиллаж, амьдрах барилга болсон байхыг харахад тун гаааламжтай байна. Яг л хөшөө дурсгал шиг, тийм үү?

Бүсгүйн царай зүрхний угаас энхрийхнээр гэрэлтэв.

-Мэдээжийн хэрэг. Би хамгийн шилдэг барилгын гүйцэтгэгч болохоор хатуу шийдсэн юм гэж Лара бат итгэлтэйгээр өгүүлэв.

Бүсгүйгээс ялгарах гүйдэл Мартиныг ховсджээ.

-Энэ ч намайг хачирхуулахгүй байна гэж тэрээр хариулав.

-Ингэхэд та яагаад ирэх болоо вэ? хэмээн Лара асуув.

"Намайг амар тайван орхи" хэмээн хэлэх туйлын ганц зорилгоор ирсэн боловч Ларагийн өөдөөс харан суух Мартин энэ цөөн хэдхэн үгийг хэлж чадахгүй хавчигнах ажээ.

-Миний найз нөхөд шоудах их дуртай байдаг юм.



Лара инээмсэглэн,

-Пол оо, тэгвэл эргээд театр орох уу?  
гэвэл тэрээр толгой сэгсэрч,

-Камерон авхай, би эхнэртэй хүн  
төдийгүй, ханьдаа урьдын адил  
хайртай хэвээр байгаа гэлээ.

-Эхнэрт тань атаархаж байна шүү.  
Барилга 3 сарын 15-нд дуусна.  
Мэдээж бид энэ үйл явдлаа  
тэмдэглэх болно. Та ирэх үү?

Мартин аядуу эелдэг хэлбэрээр эрс  
татгалзсан хариу өгөхөөр үгээ  
эвлүүлж ядан бодолд автав. Удтал  
чимээгүй болсны эцэст, -Очноо

гэжээ.

Барилга дуусгасны баярын үдэшлэг их л даруухан болж, Ларагийн нэр алдар Нью-Йорк даяар хэвлэлийнхэн болон хотын түшмэдийн анхаарлыг татахуйцаар тийм ч чангаар дуурсагдаагүй ч гэлээ зочдын дунд хотын мэрийн гарын туслах, бас "Пост"-ын сурвалжлагч иржээ.

-Бараг бүх талбай эзэнтэй болсон, гэтэл асууж сурагласан хүмүүс тасрахгүй нь гэж Говард Ларад өгүүлэхэд нь, -Сайн байна гэж Лара хайнга дуугаар хэлэв.

Ларагийн тархинд гагцхүү: Пол

Мартин ирэх болов уу? гэсэн цорын ганц бодол эргэлдэж, яагаад ч юм үүнээс өөр чухал асуудал энэ цаг үед байсангүй. Мартин түүнд оньсого хэвээр үлдэж, тэрээр бүсгүйд тусалсан гэдгийг эс тооцвоос...

Бурхан минь, арай ч дээ тэр эцэг шиг нь хүн шүү дээ! Лара хий үзэгдэл мэт бодлоо хүчлэн байж таягдан хаяв.

Зочдоо анхаарах хэрэгтэй боллоо. Гавшгай үйлчлэгчид хүйтэн зууш, шампан дарс тэргүүтнийг ширээнд орж бэлтгэцгээжээ. Пол Мартиныг орж очиход ёслолын ажиллагаа ид дундаа явагдаж байлаа. Танхим дахь уур амьсгал тэс өөрчлөгдөж, ердийн ажлын хувцаснаас дээр гэж

бодон прокатнаас костюм авсан  
болхидуу ажилчид түүнийг хааны гэр  
бүлийн гишүүн аятай мэндчилнэ.  
Мартин тэдэнд ер бусын жийрхэх  
сэтгэгдэл төрүүлж буй нь илт.

"Би корпорациудтай ажилладаг  
болохоос барилгатай ч,  
Үйлдвэрчний эвлэлтэй ч огт  
холбоогүй."

Өмгөөлөгч хотын мэрийн туслах,  
хоёр гурван өндөр хэргэмт  
түшмэдүүдтэй гар барилцан  
мэндлээд Ларад дөхөж ирэв.

-Таныг ирсэнд тун их баярлалаа  
хэмээн бүсгүйг талархахад нь, Пол

уудам танхимыг харц гүйлгэн ажаад,  
-Баяр хүргэе. Та муугүй ажиллажээ  
гэлээ.

-Баярлалаа гэснээ бүсгүй дуугаа үл  
мэдэг намсган, -Би танд гүнээ  
талархаж байна хэмээв.

Мартин залуу бүсгүйн цоггой  
гялалзах нүд түүнд ямар их аз  
жаргал бэлэглэн буйг мэдрэн  
гуниглана.

-Үдэшлэг өндөрлөх тийшээ хандаж  
байна. Яг үнэнийг хэлэхэд би  
хамтдаа хооллоно гэж найдаж  
байсан юм шүү гэж Лара гэнэ алдан  
санамсаргүй хэлчихлээ.

-Би гэртээ эхнэр хүүхдүүдтэйгээ хооллодог гэдгээ давтах хэрэгтэй болох нь ээ гэснээ Пол гэнэт үгээ тасалснаа,

-Коктейль ууя гэвэл санаанд чинь нийцэх үү? гэхэд нь, -Тэгье хэмээн Лара ихэд баяртайгаар хариу барив. Тэд Гуравдугаар авенью дахь давчуу бааранд суун ам хамхилгүй ярьсан атлаа хожим нь чухам юун тухай ярилцсанаа хэн нь ч санасангүй. Тэдний ярилцах үгс нь мань хоёрын тачаах хүслийг хязгаарласан ариун халхавч болж байлаа.

-Өөрийнхөө тухай яриач. Та хэн гээч? Хаанаас ирсэн? Яагаад энэ

бизнесээр оролцох болсон билээ?

Шон Макаллистерын эсгэсэн гурил шиг хөөж мантайсан, үлбэгэр бие Ларагийн санаанд орж ирлээ.

Тийм ч муугүй төгссөн дөө. Дахин нэг давтах болох нь ээ. -Би Глэй-Бэй гэдэг жижигхэн хотод төрсөн, энэ хотын тухай сонссон уу? Аав минь улирлын ажилчдын хоног төөрүүлэх байрны ажлыг эрхэлдэг байсан юм. Түүнийг өнгөрснөөс хойш би ажлыг нь авсан. Суугчдын нэг маань надад туслаж, миний анхны байшингаа барьсан газрыг худалдан авахад тусласнаар бүх юм эхэлсэн. Мартин шанаа тулан сууна.

-Дараа нь би Чикагог зорьсон. Тэнд тэс өөр байшингууд барьсаан. Бага сага мөнгөтэй болмогцоо л Нью-Йоркод ирсэн дээ. Ингээд л гүйцээгээд Лара инээмсэглэв.

Нүдэнд орсон хог мэт ад шоо үзэгч эцгийн хамт өнгөрөөсөн он жилүүд, басамжлан доромжлогдох үгээгүй ядуу байсан тухай, Макаллистерт хэрхэн худалдагдсан тухайгаа мэдээж мартаж... Хараажаар түүний санааг нь мэдсэн Пол бодолд автан, -Амьдрал чинь нилээд хэцүү байжээ хэмээн хэлж болмоор санагдана гэлээ.

-Би огт харамсдаггүй.



-Шинэ төслийн тухай бодож  
боловсруулчихсан л яваа биз дээ?  
Хүүхэн мөрөө хавчисхийн,

-Одоохондоо үгүй. Санаж сэдсэн юм  
гэвэл, нэг бус нилээд олон хувилбар  
ч бий л дээ гэв.

Пол бүсгүйг нүд салгалгүй ширтэхэд  
нь, -Та юу бодно вэ? гэж Лара асуув.

-Үнэнийг хэлэхэд үү? Би эхнэргүй  
байсансан бол өмнө минь дэлхийд  
хосгүй гоо үзэсгэлэнтэй бүсгүй сууж  
байна гэж хэлэхсэн. Нэгэнт би гэр  
бүлтэй хүн болохоор, бид сайн  
нөхөд л болцгоох болно.

Хангалтгай ойлгомжтой биз?

-Ойлгохын цаагуур ойлголоо.

Мартин цагаа хяламхийн харснаа,

-Явах цаг боллоо гээд гар даллан  
үйлчлэгчийг дуудаж,

-Чек биччихгүй юу? гэлээ.

-Долоо хоногийн дараа үдийн хоол  
идэх үү? хэмээн Лара санал  
болговол,

-Үгүй. Таныг шинэ объектоо  
хүлээлгэн өгөхөд болох л юм гэж  
Мартин хариулав.

Пол босон хаалга чиглэн алхаллаа.

Лара шөнө нь тэд уул борооны ажил хийж байна хэмээн зүүдэлжээ.

Мартин халуун биедээ түүнийг наан тэвэрч, хөгшин хүний гэхээргүй чийрэг гар нь гуя юуг нь илэн таалж, уруул нь: "Ай даа, хонгор минь! Чи, чи минь... өршөөж үзээрэй, амраг минь, ганц ч удаа болов чамдаа ямар хайртай гэдгээ хэлээгүйг минь, хайртай... хайртай! хэмээн шивнэнэ.

Дараа нь түүний... бүсгүйн биенд гүн шигдэн орж, тэд бие биедээ уусан...

Амтат зуудэндээ ёолон гиншсэн Лара цочин сэрж, өндийн суугаад

мөр нь салгалан чичирлээ.

Хоёр өдрийн дараа Мартин утасдаж,

-Муугүй газар олчих шиг боллоо.

Вест-Сайд, 69-р гудамж. Зах зээл энэ тухай мэдэхгүй. Зарах сонирхолтой байгаа миний нэг үйлчлүүлэгчийн мэдэлд байгаа юм гэв.

Лара Келлерийн хамт газрыг үзвэл хорхой хүрэм өмч болчих аятайхан гэгчийн байшин байлаа.

-Чамд хэн хэлээв? гэж Говардыг асуувал, -Пол Мартин гэв.

-Өөх! гэх дуунд нь илт буруушаасан

өнгө тодров. -Энэ чинь юу гэсэн үг вэ?

-Лара, би лавлан ухсан... Пол бол мафийн хүн. Түүнээс холхон байгаарай.

-Пол мафитай ямар ч сүлбээгүй! гэж Лара эгдүүцээд, -Тэр бол миний найз. Газар чамд таалагдаж байна уу? гэвэл Говард,

-Гайхалтай сайхан газар юм гэлээ.

Арав хоногийн дараа гэрээ ч санасны зоргоор бүтэв.

Лара Мартинд: "Пол оо, битгий

буцааж илгээгээрэй! Дэндүү энхрий,  
эмзэгхэн юм шүү" гэсэн зурвас  
хавчуулсан цэцэгсийн баглаа  
явуулжээ.

Үдээс хойш утасны хонх жингэнэн  
дуугарч,

-Цэцэг өгсөнд гялайлаа. Дур булаам  
авхайгаас цэцгийн баглаа авч  
үзээгүй юм байна гэх Полын дуу  
ердийнхөөсөө үл ялиг наалинхай  
сонсдов.

-Яагаад тэгж байгааг мэдэх үү? гэж  
Лара асууснаа, - Та ёс суртахуунаа  
алдсан хүн гэсэнд, -Та тэгээд  
хүмүүжүүлэх гээ юу? гэжээ. -Тэр ч

болж байна шүү гэсэнд, Мартин тас тас хөхөрлөө.

-Би үнэнээсээ хэлж байна гэж Лара нухацтай хэлэв. -Эргэлзэх юм алга. - Энэ талаар үдийн хоолон дээр үргэлжлүүлэн ярьж болох юм биш үү?

Пол Ларагийн тухай бодлоо таягдан орхиж чадахаа байжээ. Хашир бурхи шиг болсон хөгшин жаахан л удвал юу юугүй урхинд орон, яг л нэгдүгээр дамжааны залуу мэт гоо бүсгүйд хөл алдан дурлана гэдгээ ч сайн мэдэж байв. Танхил бүсгүйн гэгээн дүр оломгүй сэтгэлийг нь уяруулах аж. Бүсгүйг мартаж нь ухаалаг явдал

болохыг мэдэх авч уулзах учрахаас татгалзан өөрийгөө хазаарлан барьж дийлсэнгүй. Энэ нь эр хүний эр зоригоос ангид илүүтэй дийлдэшгүй хүч түүнийг Лара тийш татах ажгуу.

Нью-Йоркийн нэн алдартай шөнийн "21" гэдэг клубт хооллохоор болцгоожээ.

-Ямар нэг үйлдлийг нуухыг хүсвэл түмний нүдэн дээр ил цагаан хийх нь хамгийн мэргэн явдал юм. Тэгвэл чамайг зохисгүй явдал үйлдэж явна гэж хэн ч хардаж сэжиглэхгүй хэмээн Мартин зарим нэг нууцаа хуваалцав.

-Бид ямар нэг юм нуухыг хүссэн гэж



үү? хэмээн Лара аяар асуулаа.

Бүсгүйн нүдийг цоо ширтэх Пол гэнэт эргэлтгүй шийджээ.

"Ухаалаг, гоо үзэсгэлэнтэй гэхдээ ийм хүүхнүүд хэдэн мянгаараа бий л дээ. Ухаан бодлоосоо түүнийг авч хаяхад ядах юу байхав.

За яахав, би түүнийг өвөртөө оруулна. Гэхдээ цорын ганц удаа тэгээд л болоо".

Гэвч мань хөгшин алд дэлэм эндүүрчээ.

Ларагийн гэрт оруут Пол Мартин

нилээдгүй сандарч буйгаа мэдэрлээ.

-Залуу хүү болсон юм шиг санагдаад байх чинь. Би ч туршлагагүй хүн дээ.

-Дугуй жийж сурч байгаа жаал хүү шиг үү, гэхдээ мэдээж тэр ажлыг санаж байгаа биз дээ. Хувцсыг чинь тайлахыг зөвшөөрөөч гэж Лара шивнэн хэлэв.

Бүсгүй пиджакийг нь мөрнөөс нь мултлан, зангиаг нь суллан аваад цамцных нь товчийг тайлж эхэллээ.

-Лара, ийм явдал болох ёсгүй гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ. - Мэдэж байнаа.

-Би жаран хоёртой хүн. Эцэг шиг чинь хүн байна шүү дээ. Бүсгүй гэнэт зүүдээ санан, агшны төдийд хөшиж орхилоо. Лара түүний цамцыг тайлангаа,

-Мэдэж байна. Чи сайхан биетэй юмаа хэмээвэл цамц нь шалан дээр унан, Мартины цээжин бие нь нүцгэрлээ. -Баярлалаа.

Пол Мартин амьдралдаа энэ үгийг ганц ч удаа эхнэрээсээ сонсоогүй ажээ. Лара чийрэг цээжийг нь алгаараа илэн, -Чи тэнхээ ихтэй байхаа, тийм үү? гэв. Пол зөнгөөрөө гэдсээ чангалан татлаа, -Хэзээ ч билээ дээ, сагсан бөмбөг тоглох

хэрэгтэй болсон... Тэдний уруул халуун янагаар учран, эцэст нь хоёул оронд орцгоон, цаашид болсон бүхнийг Пол урьд өмнө амталж эдлээгүй явжээ. Булчин болгон нь хатууран эрч хүч оргилж, амраг хоёрыг бие тэсгэлгүй тачаадан нийлж, эцэс төгсгөлгүй жаргал эдлэх Полын сэтгэл тэнгэрт тултал хөөрөн үй түмэн од мичидын дунд хилэн хар Орчлонт ертөнцөөр хөвөн байснаа гэнэт хурцаас хурц гэрэл гялсхийн ухааныг нь гийгүүлэв. Эцэст нь Пол удтал хөдөлгөөнгүй хэвтэн гагцхүү цээж нь нэгэн хэмээр түмбэлзэн амьсгална.

-Итгэхийн эцэс алга хэмээн тэрээр

шивнэжээ. Эхнэртэйгээ үйлддэг  
амраглах үйл нь үргэлж нэгэн  
хэвийн уйтгар төрүүлэм байдаг бол  
Лара Полд урьд хожид үзээгүй аз  
жаргалыг бэлэглэжээ. Үйл явдлаар  
төгс баян түүний амьдралын эргэн  
тойронд олон, олон хүүхнүүд  
эргэлдэн байсан атал Ларад хавьтаж  
очих нэгээхэн ч үгүй байжээ. Лара  
өөр хэний ч өгч чадахгүй, өөрийгөө  
цэл залуу болсныг тэр л мэдрэмжийг  
Полд өгч чадсан байна. Пол  
хувцаслах зуур,

-Би чамтай дахиж уулзах болов уу?  
хэмээн Ларагийн асуухыг сонслоо.

-Уулзанаа. "Бурхан минь надад

туслаач! Уулзана"

Наяад он ихээхэн өөрчлөлт гарсан он жилүүд болжээ. Уолл-стритийн хэрэм өөрийн түүхийн эрс хувиралыг тэсвэрлэн гарч, Рональд Рейган АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогджээ. Хаа нэгтээ алс цөлд ираны шах нас нөгчиж, исламын мундагчуудын сүм мятрашгүй Анвар Садатын сэтгэлийг үүрд амирлуулжээ. Төрөөс Тегеранд барьцаанд байсан АНУ-ын иргэдийг гурван сая доллараар чөлөөлүүлжээ.

Сандра О'Коннорт Дээд зөвлөлийн анхны эмэгтэй төлөөлөгч болох нэр төртэй аз тохиожээ.

Хэрэгтэй цагт хэрэгтэй газар нь байж байдаг нь Ларад ихээхэн аз дайрчээ. Үл хөдлөх хөрөнгийн бизнесийн хүрээ цэцэглэн мандаж, хаа сайгүй мөнгөний үнэр ханхалж, банкууд тээнэгэлзэх юмгүйгээр дурын төсөлд боодол боодол мөнгө цацалж эхэллээ.

Зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг конторын эздийн гэдэс нь моодойн гээг нь шоодойтлоо цадацгаан сэтгэл ханамжтайяа гараа илбэцгээнэ. Үнэт цаасны эрэлт санаанд оромгүй найдвар төрүүлэх болов. Энэ цаг үед акцийн үнэ буурахаас хамгаалах гэсэн нь санхүүгийн суутан хэмээгдэх Майк

Микленын эргэлттэй ч нийцэхээ байлаа. Акц олны дунд "хог новш" хэмээгдэх болсон авч барилгын гүйцэтгэгч нарын хувьд үнэ ханшгүй болсон эдгээр цааснууд нь гайхмаар их ашиг олох замыг нь нээжээ. Гагцхүү залхуурч суулгүй, гар сунган ажиллах хэрэгтэй байлаа.

-Жаран есдүгээр гудамжинд албаны төв барихаа болилоо. Харин зочид буудал барина гэж Лара мэдэгдэв.

-Яагаад тэр вэ? Энэ чинь бизнесменүүдэд маш тохиромжтой байрлал шүү дээ. Зочид буудлыг хорин дөрвөн цагийн туршид угтаж, үдэж, үйлчлэх болно. Харин албаны



төв яах вэ? Тав арван жил түрээс авчихна тэгээд л болоо шүү дээ. хэмээн гайхсан Келлер өгүүллээ.

-Тэгвэл зочид буудал чамд хязгааргүй их эрх мэдэл өгнө шүү, Говард аа. Найман сард бужигнасан олон зочид ирэхэд чи тэднийг өрөөнд нь оруулан, зугаацуулж, хооллоно. Надад таалагдаж байна! Гүйцээ, зочид буудал барина. Нью-Йоркийн шилдэг архитекторуудтай Скодмор, Меррил, Питер Айзенман, Филипп Жонсонтой уулзалт тогло хэмээн Лара эрс хариулав.

Архитекторуудтай товлосон уулзалт нь бараг л хоёр долоо хоног шахам

үргэлжиллээ. Уригдан ирэгсдийн хэн нь ч дорой хүйсийн төлөөлөгч бүсгүй хүнтэй хамтран ажиллах туршлага үгүй гэдгээ үзтэл илт өгүүлэн, тэнгэрийн ивээгч мэт дүр эсгэн хамраа сөхөцгөөх ажээ.

Харваас бардам янзтай нэг эр,

-Хэрэв та хүсвэл би танд хуулбар... гэхэд нь Лара үгийг нь таслан,

-Тэр үгүй шүү. Харин ч эсрэгээр бусад хүмүүс биднээс хуулах ёстой. Гол хаалганы хоёр талаар усан оргилуур ярайж, хүлээлгийн өрөөний ханыг гантиг чулуугаар бүрнэ. Хажууханд нь хурлын

танхим... маш тансаг, маш тансаг байх... гээд Лара үргэлжлүүлэн ярилаа.

Ярианы эцэст зочин эр Ларагийн санааг нь ойлголоо. Дараа нь Лара багийнхантайгаа уулзав. Ерөнхий асуудал эрхэлдэг Жим Белон, хуульч Терри Хилл, төслийн менежер Том Крайтон, Хиггинсын удирдсан архитекторын товчооны агентлаг, Олмонта, Кларк хоёр зар сурталчилгааны агентлагийн Том Скотт нар өрөөнд нь цуглаж, анхны сууриа тавьжээ.

-Долоо хоногт нэг удаа уулзацгаая, гэхдээ та нар надад өдөр бүр

мэдээгээ явуулж байна шүү. Бү ажил нарийн хуваарь, чанд төсвийн хэмжээнд явагдах болно. Та нар хамгаас шилдэг учраас сонгож авсан юм шүү. Би өөрийнхөө шийдвэрт харамсах явдал гарахгүй гэдэгт итгэж байна. Асуулт байна уу? хэмээн Лара өгүүлжээ.

Тэдний асуултанд хариулахад Лара хоёр орчим цаг зарцуулжээ. -За ямар байна? хэмээн Лара өрөө нь суларсны хойно Говардаас асуув.

-Ярих юм алга, босс оо. I

Ийм урт удаан хугацааны туршид Келлер анх удаагаа бүсгүйг I ийнхүү

нэрлэж, Лара ч үүнийг нь үнэлжээ.

Санамсаргүй байтал Чарлз Коэн гэнэт утасджээ. -Би Нью-Йоркод байна, хамт хооллох уу? -Тэгэлгүй яхав, Чарлз аа! Лара "Сарди" ресторанд ширээ захиалав.

-Чи ч арван хуруу тэгш сайхан харагдаж байна шүү. Царайнаас чинь амжилт гэрэлтэн байна, Лара гэж Коэн бүсгүйг бахдав.

-Энэ зөвхөн эхлэл гэж байсныг санаж байна уу? гээд Лара инээмсэглэн, - Тэгэхээр байна шүү, Чарлз аа... "Камерон энтерпрайз"-д орохгүй юу? Би чамд хувь өгье, тэгээд.,. гэхэд

нь Коэн толгой сэгсэрч,

-Үгүй. Баярлалаа, Лара. Чи бол замаа дөнгөж эхэлж байна, харин би эцэст нь хүрчихсэн хүн. Хагас жилийн дараа чөлөөндөө гарна гэв.

-Хааяа ч гэхнээ сураг дуулгаж байгаарай, тэгэх үү? Би сураг чимээгүй алга болохоос чинь айж байна шүү.

Пол Мартин Ларагийн өрөөний хаалгаар орох яг тэр торгон мөчид, - Хонгор минь, би чамд сюрприз бэлдсэн шүү хэмээн Ларагийн хэлэхийг сонсжээ.

Ингэж хэлээд Лара түүнд хэдэн хавтгай кардон хайрцаг гардуулав. - Охин минь, өнөөдөр миний төрсөн өдөр биш шүү. -Алив онгойлгоодох.

Хайрцагнаас Бергдорф Будмэны фирмийн хэд хэдэн цамц, зангиа гарч ирэв.

-Надад ийм, бас ийм цамц, заигиа зөндөө бий шүү дээ! хэмээн Пол инээд алдав.

-Гэхдээ яг ийм ч биш шүү. Эднийг өмсөөд чи өөрийгөө залуу хүү болсон мэт санагдах болно. Би бас чамд сайн оёдолчин олсон шүү. Долоо хоногийн дараа Мартин Ларагийн

шалснаар үсний засалтаа  
өөрчлөхөөр болов. Пол толинд  
харан жуумалзав.

"Би үнэхээр өөрийгөө залуу болсныг  
мэдэрч байна. Энэ бүхэн Ларагийн  
гавьяа мөн!" Пол Мартины эхнэр нь  
нөхрийнхөө өөрчлөгдөн буйг  
анзаарахгүй байхыг хичээжээ.

\* \* \*

Анхны зөвлөгөөн дээр Говард  
Келлер, Том Крайтон, Жим Белон,  
Терри Хилл нар уригджээ.

-Барилга хурдавчилсан аргаар  
баригдана хэмээн Лараг мэдэгдэхэд



алмайрсан эрчүүд харц солилцов.

-Эрсдэл ихтэй гэж Келлер  
хариулахад нь,

-Юу хийхээ мэдэж байвал ямар ч  
эрсдэлгүй гэж Лара тас дайрав.

Том Крайтон үг хэлэх зөвшөөрөл  
эрэн,

-Камерон авхай, хамгийн аюулгүй  
арга бол нэг шатыг дуусмагц  
дараагийнхдаа орох явдал байдаг  
юм. Үүний тулд эхлээд тэг  
тэмдэглэгээ хийн, талбайгаа  
тэгшилнэ, дараа нь хундамент  
доогуурх суурийн нүхийг ухаж,

хоолойг тавина, дараа нь... гэтэл,

-... модон хашлагыг хийн зуурмагаар дүүргэн, төмөр хийцийг гагнана. Би ЭНЭ бүхнийг мэднэ гээд Лара мөн л үгийг нь тасдав.

-Тэгвэл яагаад?...

-Ийм ажил хоёр жилийг барна. Би хүлээж суумааргүй байна гэж Лара татгалзав.

-Хурдавчилсан арга бол нэг зэрэг хэд хэдэн ажиллагааг зэрэг гүйцэтгэхийг хэлж байгаа юм. Өчүүхэн төдий л үл ойлголцлоос болж бүх юм баларч гүйцнэ. Жишээлэхэд: цахилгааны

шугамын ховилоор муруй сарий  
ханатай босч мэднэ.

-Тэгэхээр ийм юм гаргахгүйг хянаж  
байх хэрэгтэй гэж Лара нухацтай  
хэлээд,

-Нарийн сайн хуваарын дагуу  
ажиллавал барилга жилийн дараа  
дуусч, ингэснээрээ хорин сая  
долларыг хэмнэнэ гэв.

-Тэр ч тийм л дээ. Гэвч чи хувь  
заяагаараа тоглож байна гэж Келлер  
хатуухан үг чулуудав.

-Би яг ийм тоглоомд дуртай хэмээн  
Лара үг сөргөн хэлжээ.



## Арван тавдугаар бүлэг.

Лара эл зөвлөгөөнийхөө тухай Пол Мартинд ярьлаа.

-Тэдний зөв ч байж болох юм.  
Эрсдэл дэндүү ихтэй байна гэж Пол  
ХЭЛЭВ.

-Гэхдээ америкийн чинээлэг  
бизнесменүүдийн нэг Мралт. бас  
америкийн архитектор бас барилгы  
гүйцэтгэгч Юрис хоёр орсон байгаа  
гэж Лара тайлбарласан,

Мартин түрхэн зуур чимээгүй  
сууснаа.

-Итгэж байна гэлээ.

Лара өрөөндөө дугаар нь утасны лавлахад ороогүй утас тавиулжээ. Энэ нь зөвхөн Полдзориулсан гэдэг нь ойлгомжтой. Мартин ч гэсэн зөвхөн Лараг ярих тусгай аппарат тавиулж өдөртөө хэд хэдэн удаа бие бие рүүгээ холбоо барьжээ.

Амраг хоёр бололцоо олдмогц бүсгүйн гэрт очицгоодог болов. Энэ уулзалт нь Мартинд амьдралын утга учирьг мэдрүүлэн, Лара түүний хувьд юу юунаас эрхэм болжээ.

Бүсгүйг Мартинтай ойртон дотноссоныг мэдсэн Говард Келлер

ихэд түгших болов.

-Лара миний бодлоор чи ихээхэн алдаа хийж байна. Энэ тун аюултай хүн шүү гэхэд нь Лара,

-Чи дүгнэлт гаргах гэж дэндүү яарч байна. Пол бол сайн хүн гэхэд,

-Чи түүнд хайртай юм уу? хэмээн Говардыг асуувал Лара бодолд автлаа. Мартин хоосорч хөндийрсөн сэтгэлийг нь дүүргэсэн нь үнэн, гэхдээ бүсгүй түүнд хайртай билүү?

-Үгүй.

-Тэгвэл мань эр чамд дурлачихаа

юу? -Тийм ээ.

-Болгоомжтой байгаарай. Соргог байхаа надаар хэлүүлэлттүй мэднэ биз дээ хэмээн Келлерын зовнин өгүүлэхэд Лара инээмсэглэн хацар дээр нь үнсээд,

-Говард аа, чиний халамж намайг уярааж байна шүү гэжээ.

\* \* \*

Барилгын талбайн голд зогсох Лара дараачийн мэдээг сонсоод,

-Пит ээ, бид модонд нилээд их мөнгө зарж байна гэж чамд



бодогдохгүй байна уу? гэв.

Төслийн шинэ удирдагч Питер Рис толгой сэгсрэн, -Камерон авхай, модон хийц үргэлж дутагдаж байна. Бид хоёр дахин ихийг захих хэрэгтэй гэхэд Лара бодолд автан,

-Чинийхээр бол хулгайлаад байна уу?

-За нэг тиймэрхүү л гэхээс.

-Хэн гэдгийг нь хэлж чадах уу?

-Мэдэх юм алгаа.

-Талбайд шөнийн манаач бий, тийм

үү?

-Байгаа. Ганц хүн бий.

-Тэр юу ч үзэж хараагүй юу?

-Юу ч хараагүй.

-За яах вэ. Гэсэн ч энд овсгоотой хүн гэгээн цагаан өдөр, гэрэлтэй шар нарнаар ч санаагаа гүйцэлдүүлж болмоор хөл ихтэй байдаг юм байж. Хэн ч хулгайч байж болно. Сэжиг таамгаа надтай хуваалцаж чи тун ухаалаг алхам хийлээ. Сайн байна, би өөрөө энэ асуудлаар хөөцөлдөнө.

Үдийн хоолны дараа Лара хувийн

мөрдөгч Стив Кейнтэй хэдийнэ  
ярилцан суулаа.

-Гэгээн цагаан өдрөөр ажилчид яаж  
машин мод барилгаас гаргах билээ?  
хэмээн Кейныг эргэлзэн асуухад,

-Үүнийг та л надад хэлж өгөх ёстой  
болоод байна гэж Лара хэлэв.

-Харуул манаа бий биз дээ?

-Бий нь ч бий.

-Харуул хуруу дүрэлцдэг бололтой.

-Таны наад "бололтой" гэдэг чинь  
надад огт сонин биш байна. Хэргийн

эзнийг олж мэдчихээд ганцхан баримт л илтгээрэй.

-Би бригадын гишүүний дүрд тоглож болох уу?

-Болохгүй нь юу байхав. Маргааш өдөр нь детектив эр ажилдаа орлоо.

Лара энэ тухай Келлерт дуулгавал тэрээр эрс буруушаан,

-Чи энэ ялих шалихгүй будлиантай хутгалдахын хэрэггүй байсан юм. Би өөрөө учрыг нь олчихно шүү дээ гэжээ.

-Надад асуудал шийдэх таалагддаг

юм. Келлер үүнээс өөр хариу мэдээж хүлээгээгүй. Стив Кейн тав хоногийн дараа Ларагийн өрөөнд орж ирлээ.

-Ямар нэг юм илрүүлэв үү?

-Би бүгдийг нь учрыг олчихлоо.

-Шөнийн харуул уу?

-Үгүй. Талбайд мод ердөөсөө ч орж ирдэггүй юм байна.

-Үүнийг чинь юу гэж ойлгох вэ?

-Үнэндээ тэгж л байна даа.

Үйлдвэрлэлээс гарсан нимгэн банз Нью-Жерси дэхь өөр барилга руу

ачигдаж, харин та хоёр ч удаа  
падаанаар үнийг төлсөн байна гэж  
мөрдөгч эр тайлагнав.

-Үүний ард хэн гээч байх юм бэ?  
хэмээн Лараг асуувал Кейн  
хулгайчийн нэр цолыг нь хэлж өгчээ.

Маргааш нь Лара ажилчдын  
зөвлөлгөөн хийхдээ хуульч Терри  
Хилл, Говард Келлер, Жим Белон,  
Питер Рис нарыг оролцуулжээ.  
Тэдний зэрэгцээгээр Ларагийн ноён  
Конрой хэмээн танилцуулсан нэгэн  
эр ширээнд суулаа.

-Эхлээд ажлын явцтай танилцая гэж  
Лара зөвлөгөөнийг эхлэвэл Рис

өндийв.

-Бүх ажил нарийн хуваарийн дагуу явж байгаа шүү, Камерон авхай.

Хурдавчилсан аргын тухайд таны зөв байжээ. Ямар нэг саатал байхгүй.

Ажилчид цахилгааны шугамын угсралтын ажилдаа орцгоосон.

-Сайн байна.

-Алдагдсан модны тухай сураг байна уу? гэж Келлер асуув.

-Одоохондоо юу ч алга. Хүмүүсийг бие биенээ ажиглаж байхыг даалгасан гэж Рис хариуллаа.

-Энэ талаар санаа зовохын хэрэггүй болсон. Бид хулгайчийг илрүүлсэн гээд Лара ширээний төгсгөлд суугаа эр тийш толгой дохин, -Ноён Конрой луйварчинг илрүүлсэн. Ноён Конрой чухамдаа мөрдөгч хүн гэлээ.

-Тэр энд юу хийж байгаа юм? гэж Рис толгой өлийлгөн түгшсэн янзтай хэлэв.

-Чамайг авч явахаар хүлээж байна. Питер ээ.

-Яах гэж-яах гэж тэр вэ?

Лара босон цонх руу дөхөж очин,



-Жентельменүүдээ, ноён Питер Рис манай модон хийцнүүдийг зүүн тийш наймаалжээ. Тайлан уншиж байгаад банз хаа нэг тийшээ алга болоод байгааг мань эрийн мөрөө баллахаар мэрийж буйг нь мэдсэн юм гэлээ.

-Хүлээгээрэй. хүлээгээч! Би... та намайг ташаа ойлгожээ! хэмээн менежер эгдүүцэв.

-Түүнийг эндээс аваад яв гэж Лара тушаагаад Стив Кейн Рисыг өмнөө оруулан гаргаад хаалга хаангуут,

-За одоо зочид буудлын нээлтийн ёслолын ажиллагааны тухай

ярьцгаая хэмээв.

Ёслолын өдөр ойртохын хэрээр барилгын уур амьсгал нилээд халуухан болж, Лара хараалч эм мэт энд тэндгүй харайлган голж өөчлөн, эгдүүцэн хашгичих болов.

Тэрээр шөнө дундад харилцуур шүүрэн авч,

-Говард аа. ханын цаас ачсан контейнер ирээгүй гэдгийг чи мэдэж байсан уу? гэв.

-Ээ Бурхан минь гэж, Лара одоо үүрийн дөрвөн цаг болж байна шүү дээ хэмээн Говардыг нойрмоглоход,

-Нээлтээ хийхэд гуравхан сар үлдээд байна. Эсвэл зочдод бетонон хана харуулж шавайг нь хангах гээ юу?

-Өглөө больё л доо.

-Өглөө болчихоод байна, Говард аа!

Лара тэсвэрлэхийн эцэсгүй болжээ. Тэрээр рекламн менежер Том Скоттыг дуудуулав.

-Ноён Скотт оо, танайх нялх хүүхэдтэй юу? хэмээн Лараг асуувал гайхсан Том,

-Үгүй ээ, хүүхдүүд маань аль хэдийнэ том болцгоосон. Юу болоо вэ? гэв.

-Зар сурталчилгааны төлөвлөгөөг үзээд хүүхэд хийсэн, тэгэх тусмаа нялх хүүхэд хийж гэж бодлоо. Нас бие гүйцсэн хүн байж ийм ч юм бодож олох гэж дээ.

Скотт царай барайлган,

-Хэрэв таны санаанд ямар нэг юм таарахгүй... гэж түгдчихэд нь,

-Надад бүгд таалагдахгүй байна! Гоё ганган нь хаа байна? Гайхамшигийг бахадсан нь хаа байна! Ямар ягтаа тулсан дорой бодолтой юм бэ! Таны дэвшүүлээд байгаа наад санал чинь ерийн нэг буурчийн газарт л таарах юм биз. Харин манай зочид буудал

бол тэс өөр шүү, ноён СКОТТ оо. Би Нью-Йоркод жинхэнэ сувд эрдэнэ бэлэглэж байхад та чинь түүнийг маань зэгэл саарал бул чулуу болгож байх шив. Та энэ ажлыг хийж хүчрэх үү? гэж Лара зандрав.

-Чаднаа, Камерон авхай. Хоёр долоо хоногийн дараа...

-Даваа гаригт шинэ төлөвлөгөөг хийгээд танилцуул гэж Лара хүйтнээр өгүүлэв.

Зар сурталчилгааны компани Америк даяар хүрч ажилсан байна. Тэд нээлтээ хийхээр зэхэж буй зочид буудлын тухай сонин, сэтгүүлээр зар

түгээн, замын хажуугаар зочид  
буудлын тухай тод гэгчийн зурагт  
самбарууд өлгөжээ.

-Миний бодлоор сэтгэгдэл төрүүлж  
байна шүү. Таны зөв байжээ хэмээн  
хонгилд Ларатай тааралдсан Скоттыг  
өгүүлэхэд бүсгүй тайвнаар,

-Миний зөв байх тийм ч чухал биш.  
Харин таны зөв байхыг би хүсч  
байна. Яагаад гэвэл би танд хөлс  
төлж байгаа гэж өгүүлэв. Лара  
нийгмийн харилцааны менежер  
Жерри Таунсендээс,

-Урилгануудыг тараасан уу? гэвэл  
менежер эр,

-Бүгдийг тараасан. Ихэнх зочид хариу мэдэгдсэн. Татгалзсан хариу ирээгүй. Камерон авхай, баяр маань өлзийтэй сайхан болно хэмээв.

-Тэгэхгүй өөр яахав гээд Говард Келлер хамар дороо бөвтнөснөө,

-Өдий төдий мөнгө зарж байхад! гэлээ.

Лара инээд алдан,

-Банкны эзэн, та бүү харамч зан гарга. Сая сая хүмүүс буудлаар орж гаран, алдар цуутнууд нисч ирцгээх болно гэдгийг бүү март гэхэд,

-Амаа хамхиж, гэмээ наминчлая даа,  
Лара минь гэж Говард бууж өгөв.

Нээлт болохоос хоёр гурван долоо  
хоногийн емнө ажилчид ханын цаас  
наан, хивс дэвсэн, зураг өлгөх гээд  
хамаг ажил давхацжээ. Лара таван  
хүний бүрэлдэхүүнтэй комисс  
дагуулан өрөө болгоноор орж,

-Хөшиг нь тавилганыхаа бүрээсэнд  
тохирохгүй байна. Соль.

-Төгөлдөр хуур нь аман хуур шиг  
дуугарч байна. Хөглөгчийг дууд.

-Ханан зуух нь татахгүй байна.  
Янданг шалга.



Лара эл бүгдийг өөрийн гараар хийхэд ч бэлэн байлаа. Нэг мэдэхэд гал зууханд, таван минутын дараа угаалгын газарт, бас таван минутын дараа гэхэд агуулахад орчихсон тушаал өгөх, шаардахдаа шаардан, гүйхдаа гуйн явав.

Ларагийн зочид буудлын эрхлэгчээр авсан гуалиг эр,

-Камерон авхай, биеэ бодоорой доо. Аар шаар юм гаралгүй яахав гэхэд нь,

-Надад, манай зочид буудалд ийм явдал гарах ёсгүй хэмээн Лара эрс хариулав.

Зочид буудлын нээлтийн өдөр Лара гурван цагт орноосоо годхийн бослоо. Нойр нь хаачих нь тэр вэ? Юун унтаж хэвтэх вэ? Пол Мартинтай яаралтай ярих хэрэгтэй, гэвч үүр шөнийн заагаар бүсгүй ярьж зүрхэлсэнгүй. Хувцаслан гарч, гудамжаар дэмий нэг сэлгүүцлээ.

"Бүх юм ном ёсоороо байх болно. Эрхлэгчийн компьютерийг зэхчихсэн. Гал тогооны гурав дахь пийшинг тохируулна. 1007-р өрөөний бариулыг солино. Өчигдрийн халагдсан хоёр маанаг амьтдын оронд Говард шинэ үйлчлэгч олчихно. Пентхаусын агааржуулагч..."

Оройн зургаан цагт зочдын түрүүч нь ирж эхэллээ. Үүдний дэргэд зогсох хамгаалагчид урилгаа үзүүлэхийг тэднээс шаардах ажээ. Сунагар урт лимузингууд хүрч ирэн нэртэй улс төрчид, алдартай тамирчид, корпорациудын ерөнхийлөгч нар бууцгаана. Зочдынхоо нэрсийн жагсаалтыг Лара өөрөө гардан хийсэн болохоор зарим нэг үл бүтэх хүмүүсийг эргэлзэх юмгүйгээр хасчээ.

Бүсгүй асар том хүнхэр таазтай, үүдэн өрөөнд зочдоо угтан зогсоно.

-Сайн байна уу, Лара Камерон байна. Тантай уулзсан даа...

-Лара Камерон. Хүрэлцэн ирсэнд...

-Гэртээ байгаа юм шигтухлаарай...  
Хүмүүсийн дундуур явах Говард  
Келлерыг харсан Лара түүнийг дохин  
дуудаж,

-Хотын мэр ирэхгүй юм байх даа?  
гэж асуувал Говард,

-Чи мэдэж байгаа шүү дээ, тэр  
завгүй, тэгээд ч... гэв.

-Би түүний хувьд тийм ч чухал  
шувуухай биш байх нь ээ, аан? гэж  
Лара эгдүүцэн хэлэв.

-Эрт орой хэзээ нэг цагт тэр

эндүүрсэнээ ойлгох болно. Яг энэ мөчид мэрийн гарын туслах Ричард Брук түүнд дөхөж ирлээ.

-Таны хүрэлцэн ирсэн явдал бидний хувьд ихээхэн нэр хүндийн хэрэг, ноён Брук ээ!

Одоо "Нью-Йорк Таймс"-ын архитекторын талын асуудлыг өгүүлдэ Тодд Грейсоныг хүлээх л үлджээ. Нөгөө Тодд чинь хааччих ваа? Хэрэв түүнд л тааяагдвал бид яллаа гэсэн үг!

Пол эхнэрийн хамтаар иржээ. Сэтгэл татам аятайхан, дэгжин хувцасласан хатагтай Мартиныг Лара анх удаа

харж буй нь энэ. Бүсгүйн сэтгэлд  
гэмших сэтгэл өөрийн эрхгүй төржээ.

Нэг гэр бүлийн хоёр бүсгүйгээс хоёр  
алхмын зайд ирж зогсов.

-Камерон авхай, тантай танилцахыг  
болгооно уу. Би Пол Мартин. Энэ  
миний эхнэр, Нина. Урьсан явдалд  
тань баярлалаа хэмээн Пол  
танилцуулав.

Лара ёсыг бодон түүний гарыг  
хормоос илүүгүй атгасангүй,

-Тун баяртай байна. Тааваараа  
тухлацгаагаарай гэлээ.

Пол магадгүй тав эсвэл зургаан удаа  
ч үзэж харсан үүдэн танхимыг  
гүйлгэн хараад,

-Камерон авхай, энд жинхэнэ орд  
харш сүндэрлэжээ! Энэ зочид буудал  
танд зүй ёсны нэр алдрыг авчрана  
гэдэгт бүү эргэлзээрэй гэв.

Нина Мартин Лараг нүд салгалгүй  
ширтэн байлаа.

-Ерөөлөөр болог гэж урам орсон  
Лара хариулав. Сонин юм даа, эхнэр  
нь мэдсэн юм биш байгаа гэж Лара  
хулмалзан боджээ.

Нэг хэсэгтээ зочдын цуваа

тасарсангүй.

Цагийн дараа үүдний өрөөнд  
зогссоор байх Лараг хайсан Говард  
Келлер,

-Чи чинь хааччих ваа? Хүмүүс  
чамгүйгээр зоогондоо ч ам хүрэхгүй  
байна. Явцгаая! гэв.

-Би Грейсоныг олж харсангүй гэж  
Лараг сүүрс алдахад нь,

-"Таймс"-ын шүүмжлэгч үү? Тэр аль  
хэдийнэ ирчихсэн! гэв.

-Юу?



-Тийм ээ, тийм. Дээд давхруудаар явж байгаа.

-Чи яагаад надад хэлсэнгүй вэ?

-Би чамайг мэдэж байгаа юм л бодсон шүү.

-Тэр юу гэж байна? Ямаршуу харагдаж байна? Сэтгэл хангалуун байна уу?

-Юу хэлэхийг нь сонсоогүй. Ёс жаягаа даган смокинг өмссөн байна билээ. Сэтгэл нь хангалуун байгаа эсэхийг нь мэдээгүй.

-Гэхдээ тэр ганц ч үг хэлсэнгүй юу?

-Ганц ч үг хэлээгүй. Лара хөмсөг  
зангидан,

-Хэрэв таалагдсан л бол тэр нэг юм  
хэлэхсэн. Энэ чинь муугийн ёр доо,  
Говард аа гэлээ.

Үдэш сайхан өнгөрч, зочид ханатлаа  
идэж уун, шинэ зочид буудлын  
цэцэглэн мандахын ерөөл  
дэвшүүлцгээж байлаа.

Эцэст нь Лараг эцэс төгсгөлгүй  
найрсаг үгээр булцгаав.

-Камерон авхай, та ийм... ийм  
сайхныг бүтээж...

-Дараагийн удаа Нью-Йоркод  
ирэхдээ заавал ч үгүй энд  
буудаллана..

-Өрөө болгон төгөлдөр хууртай!  
Сайхан санаа.

-Надад ханан зуух ихэд...

-Тантай дуртайяа андын холбоо...

"За яахав. "Нью-Йорк таймс" бахдан  
магтахгүй байсан ч гэсэн тэртээ  
тэргүй ялалт биднийх болсон" гэж  
Лара боджээ.

Бүсгүйн харц Мартины гэр бүл дээр  
санамсаргүй тусвал тэд гарах

хаалгыг чиглэн явж байв.

-Танд чин сэтгэлээсээ баяр хүргэх ёстой юм байна. Камерон авхай. Маргааш еглөө гэхэд таны зочид буудлын талаар хот даяар шуугих болно гээд Пол Мартин хүндэтгэл үзүүлэн мэхийн ёслов.

-Танд гүнээ талархаж байна, ноён Мартин. Бас дахин баярлалаа!

-Тавтай амраарай, Камерон авхай гэж Нина төлөв дуугаар өгүүлэв.

-Тавтай амраарай, хатагтай Мартин! Гэр бүлийн хоёр үүдэнд очсон хойно эхнэр нь нөхөртөө,

-Тэр их үзэсгэлэнтэй юм, тийм үү,  
Пол оо? хэмээн шивнэх нь Ларагийн  
чихийг дэлсчээ.

Пүрэв гаригийн өглөө Лара Бродвей  
42-р гудамж хоёрын уулзвар тийш  
"Нью-Йорк Таймс"-ын шинэ дугаар  
авахаар харайлгалаа. Хот дээгүүр  
нойрмоглон, залхуурсан мэт үүр  
цайж байв. Сонины хуудсыг  
шажигнатал эргүүлэн "Барилга"  
гэсэн буланг нээвэл Лара,

Тодд Грейсоны:

"ОЛОН ЖИЛИЙН ТУРШИД  
МАНХЭТТЕНЭЭР ЗОРЧИН ЯВАГЧДАД  
ТӨРСӨН ГЭРТЭЭ БАЙГАА ЮМ ШИГ НЬ

БАЙЛГАЖ ДӨНГӨХ ТИЙМ ЗОЧИД  
БУУДЛААР ИХЭЭХЭН ДУТАГДАЖ,  
ГАЧИГДАЖ БАЙЖЭЭ. ХАРИН  
"КАМЕРОН ПАЛАЗ"-ЫН ТОХИЛОГ  
ДОНЖ МАЯГ НЬ ИЙМ БОЛОЛЦООГ  
ОЛГОЖ ЧАДЖЭЭ. ЛАРА КАМЕРОН  
ХОТОД..." гэсэн нийтлэлийг уншлаа.

Баярласандаа дуу алдан хашгирахад  
ч бэлэн Лара тэр даруйдаа Келлерт  
утасдав.

-Биднийг хүлээн зөвшөөрчээ!  
"Таймс"-ыг дэлгээд үзээч! гэж Лара  
бахдан хашгирав. Говард нүдээ  
нухчин, орноосоо өндийн сууж,

-Сайн байна! Юу гэж бичиж вэ? гэв.

Лара нийтлэлийг уншиж өглөө.

-Баярлалаа, Лара. Одоо ханатлаа унтаж болно хэмээн нойрмог Говардыг хэлвэл,

-Ханатал унтах ий? Чадна гэж үү? Би бас нэг газар олсон! Банк онгоймогц явж зээлийн талаар...

"Камерон Плаза" гайхалтай гэмээр амжилтанд хүрч, нэг өдрийн дараа гэхэд зочид буудлын бүх өрөө нь эзэнтэй болж, эрхлэгч хагас жилийн хэрэглээний зүйлүүдийг тавьж олгожээ.

-Энэ бол зөвхөн эхлэл. Хамгийн

багаар бодоход Нью-Йоркод  
барилгын бизнес эрхэлдэг арван  
мянга орчим хүн бий. Мэдээж  
Трампа, Рудинс, Рокфеллер, Стернээс  
доогуур байр суурь эзлэдэг хүмүүс  
зайгаа тавьж өгөх болно. Нүдний  
үзүүрт бүх юм тэс өөрөөр харагдаж,  
бид хотын шинэ нүүр царай болно,  
Говард аа!

Утас зогсоо зайгүй хангингаж,  
банкууд зээл өгөхийн тулд хамгийн  
ашигтай нөхцөл тавин ам мэдэн  
өрсөлдөцгөөх болов. Лара  
брокеруудтай идэвхийлэн  
харилцаж, тэднийг ресторанд  
оруулан, дуурь үзэхийг урьж,  
"Риженси"-д цайлан суух зуураа үл



хөдлөх хөрөнгийн зах зээлийн тухай мэдээг шуналтайяа цуглуулж байлаа.

Лара сүр дуулиан гаргалгүй хоёр ч газартай болж, барилгын ажлаа эхлүүлжээ.

Пол Мартин утасдан,

- "Бизнес уик"-ын сүүлийн дугаарыг уншив уу? Чи эхний аравт орсон байна, миний хонгорхон охин минь. Чиний ажлыг бүтэмжтэй явна гэцгээж байна! гэжээ.

- Хичээж байнаа, Пол оо.

- Үдийн хоолонд хамт орьё гэвэл

завгүй гэх үү?

-Яаж ийгээд зохицууламз гэж Лара хариулав.

Ийнхүү Полтой ярьж байхад алдартай чадварлаг архитекторчидын дарга ирчихсэн хүлээн, ширээн дээр шинэ төслийн ноорог зураг дэлгэж байлаа.

-Энэ танд таалагдах болов уу, хатагтай Камерон оо. Барилгын нүүрэн хэсэгт яг таны хүссэний дагуу маяг донжийг нь тааруулахыг хичээсэн. Та үүнийг хар даа, би тайлбарлаад...

-Тайлбарлахын хэрэггүй. Би зураг муугүй уншчихдаг юм. Тэгэхээр наад зургаа зураачид аваачаад өгчих хэмээн Лараг хэлэхэд,

-Өршөөгөөрэй, та юу гэв ээ? гэж архитектор асуув.

-Зураач гол хаалганы, амрах тасалгааны өрөөнүүдийн, хонгилын өнгөт зургийг хийг. Банкныхан дүрслэн бодохдоо маруухан улс байдаг юм. Тэд шугам зураг гээчийг ойлгох нь юу л бол. Би тэдэнд ямар барилга болохыг өнгөт зурагаар үзүүлмээр санагдана хэмээн Лараг өгүүлбэл тэрээр,

-Мэргэн санаа байна шүү! гэж  
магтлаа. Нарийн бичгийн дарга нь  
өрөөнд орж ирээд,

-Хожигдсоныг минь өршөөгөөрэй,  
Камерон авхай гэхэд,

-Кэти уулзалт 9 цагт гэж товлосон  
байсан. Гэтэл 9. 15 болчихоод байна  
гэж Лара зэмлэвэл,

-Сэрүүлэг дуугарсангүй, тэгээд ч би...  
хэмээн Кэти дугдчив.

-Дараа нь ярилцамз гээд Лара  
архитектор тийш эргэв. Тэдний  
зөвлөлгөөн бараг хоёр цаг шахам  
үргэлжилж зочноо үдсэний хойно

Лара буйданд тухлан,

-Кэти, наашаа суугаач гэлээ. Нарийн бичгийн дарга үгийг нь даган буйданд суув.

-Чи ажилдаа дуртай байна уу, хэлээдэх дээ?

-Дуртай, Камерон авхай.

-Ойрын өдрүүдэд гурав дахь удаагаа хожигдож байна. Би дөрөв дэхийг нь тэвчихгүй шүү.

-Өршеөгөөрэй, босс оо. Надад... миний бие нэг л базаахгүй байна.

-Юу болоо вэ?

-За даа, ялихгүй юм даа...

-Ялихгүй юм гэдэг чинь тэгээд  
чамайг ажилдаа цагтаа ирэхэд чинь  
садаа болоод байгаа юм биз дээ.  
Алив чи хэлээдэх гэж Лараг  
захирамжилсанд аргагүйдсэн Кэти,

-Нойр нэг л бишээ. Камерон авхай,  
яг үнэнийг хэлэхэд би айж байна  
гэхэд нь Лара,

-Юунаас тэр вэ? гэлээ.

-Би хавдартай болжээ.

-Өө! гээд Лара хэсэг дуугүй болсноо,

-Эмч нар юу гэж байна? хэмээн арай зөөлрөнгүй асуув.

Кэти ч тэсгэл алдан мэгшин, шүлсээ гүдхийн залгиад,

-Эмчид очоогүй гэлээ.

-Хараач хөөе, эмчид хандаагүй байх нь! Бурхан минь, бид чинь ширэнгэн ойд байгаа юм уу гээд Лара харилцуур шүүрэн авч,

-Намайг Петерс эмчтэй яриулаад өгөөч гэснээ харилцуур буцаан тавьлаа.

-Мэдээж энэ бүхэн чиний уран зөгнөл байлгүй дээ, гэвч эмчид үзүүлэхэд юуны буруу байхав гэв.

-Миний ээж, ах хоёр маань хавдраар нас барцгаасан юм. Эмч нарыг надад хавдартай гэсэн онош тавихыг би хүсэхгүй байна хэмээн Кэти хэлэв.

Утасны хонх жингэнэн дуугарахад Лара авч,

-Тийм үү? Хаана гэнээ? Хэнтэй чалчиж байгаа нь надад падгүй хэрэг. Даруйхан над руу залга гэж хэл гээд Лара харилцуураа чулуудчихав.



Нэг минут ч өнгөрөөгүй байтал дахин утас дуугарлаа.

-Алан уу? Үгүй, би зүгээр. Миний нарийн бичгийн дарга Кэти Тернер яг хагас цагийн дараа гэхэд чам дээр очно. Нарийн сайн үзээдэх, ойлгов уу? Чи ч бидэнд их тусладаг даа. Баярлалаа, Алан? гээд Лара эмчтэй яриагаа өндөрлөв.

-"Слоун-Кеттеринг" эмнэлэг рүү одоохон яв. Петерс эмч чамайг хүлээж байгаа.

-Камерон авхай, танд юу гэж хэлэхээ мэдэхгүй байна.

- "Маргааш хожигдохгүй" гэж л хэлэхгүй юу.

Өрөөний үүд онгойн Келлер орж ирлээ.

- Асуудал гарлаа, босс оо.

- За сонсоё.

- Бид 14-р гудамжны хорооллоос бараг ихэнх оршин суугчдын нүүлгэсэн, гэтэл "Дорчестер апартаментс" гэдэг байр суллахгүй үлдчихээд байна. Зургаан байр хөлслөгчид нүүхээс эрс татгалзаж, хотын захиргааныхан хачир нэмэх мэт тэднийг хөөхийг зөвшөөрөхгүй

байна.

-Тэдэнд ахиухан мөнгө амла.

-Хэргийн учир мөнгөнд бишээ.

Насаараа тэнд амьдарсан улс шинэ газар очихыг хүсэхгүй байна. Тэндээ тухтай байна гэнээ.

-Тэгвэл тухгүй байхыг мэдрэх болно доо.

-Чи юу гэх гэв?

Лара ширээний араас босон,

-Очиж үзэцгээе гээд үүд чиглэв.

Машины их урсгал тэднийг хаман

авч, 14-р гудамж тийш аваачлаа.  
Лараг орон гэргүй зэгэл саарал  
царай, ноорхой хувцас, ялихгүй ядуу  
эд хогшлоо цүнхэнд чихсэн гунигтай  
дүр төрх угтлаа.

-Энэ чинь Америк орон мөн гэж үү л  
гэж бодмоор юм байна! Ямар  
ичгүүртэй юм бэ? хэмээн Лара  
эгдүүцэн үглэв.

"Дорчестер апартаментс" гэх зургаан  
давхар барилга цагийн аясад  
элэгдэж, өгөршиж муудсан хана  
туурга нь хоногоо хүлээх мэт  
санагдана.

Лара машинаас бууж, тэр байрыг

хэсэг харж байснаа,

-Энд хэдэн гэр бүл байгаа гэлээ? гэв.

-Арван зургаа нь аль хэдийнэ нүүсэн.  
Харин зургаа нь нүүхийг  
зөвшөөрөхгүй байна.

-Тэгвэл арван зургаан өрөө сул байх  
нь ээ?

-Тийм ээ. Чи намайг гайхшруулж  
байна шүү. Сул өрөөнүүдээр яах гээ  
вэ?

-Өрөөнүүдийг эзэгнэх хэрэгтэй.

-Өөрөөр хэлбэл хөлслөх гээ юу?

Ингэх хэрэг...

-Би хөлслөх гээгүй. Харин Нью-Йоркын орон гэргүй олон мянган хүмүүст туслах гэсэн юм. Бид үгээгүй хоосон хүмүүсийн талаар анхаарал тавих болно. Ийш нь аль болох олон хүн оруул. Бас тэдэнд хоол хүнс авчрах талаар бодолцоорой гэж Лара хэллээ.

-Муугүй л санаа байна гээд бүсгүйн санааг ойлгосон Келлер дургүйцэн ярвайлаа.

-Говард аа, бид ядуу доодост тусламж өглөг үзүүлж буяны ажил хийж болохгүй гэж үү? Хотын эрх

баригчдын хүчрэхгүйг хийж хүмүүст орох орон өгөх болно!

Лара тоосгон хана руу дөхөж очин дээш өлийн харж байснаа,

-Тэр цонхнуудыг банзаар хад гэж тушаалаа.

-Юу?

-Тэгвэл байшин хоосонтой адил болно. Дээд давхарт хүн амьдарч байгаа юу? Тэр дээвэр дээр цэцэрлэгэрхүү юм байгаа юм уу?

-Тийм ээ.

-Хөвөөгөөр нь тойруулаад зар сурталчилгааны самбар босго.

-Гэхдээ... гэж Говардыг ээрч түгдэрсэнд Лара,

-Ажилдаа ор хэмээн тушаалаа.

Лара оффистоо эргэн ирэхэд нөгөө нэг нарийн бичгийн дарга бүсгүй нь,

-Петерс эмч ярьсан, Камерон авхай гэх дуулдахад,

-Намайг холбоодох! гэлээ.

Алан харилцуур тэр даруй аваад,

-Лара чиний асрамжинд байгаа



хүнийг үзлээ гэв.

-За яасан бэ?

-Зарим нэг эдийн нэхдэс хатуурсан нь хортой хавдар байж болмоор байна. Миний хувьд тэр хэсгээс нь даруйхан эдийн шинжилгээ өг гэж хэлмээр байна.

-Хоёр дахь мэргэжилтэний онош чамд шаардлагагүй юу? гэж Лараг эргэлзэн лавлахад,

-Сонсооч хөө, би чинь...

-Харин надад зайлшгүй чухал байна. Бие даасан шинжээч урьж, үр дүнг

даруйхан надад мэдэгд! Кэти хаа байна.

-Ажил руугаа явсан гэж эмч эр хариулав.

-Баярлалаа, Алан.

Лара харилцуураа тавиад дотуур холбооны товчлуурыг дарж,

-Трейси, Кэтийг ирэхээр нь нааш нь оруул гэж тушаав.

\* \* \*

Лара толгой бөхийлгөн хуанли ширтэн сууна. "Камерон энтерпрайз

барилгын ажлаа эхлэхэд гуч хоног үлдээд байхад "Дорчестер"-ын асуудлыг шийдэж амжих болов уу?

Зөрүүд зургаан хуцнууд. За яахав, хэр удаан зөрүүдлэхийг чинь харъя л даа хэмээн Лара бодов.

Нүүр нь үл ялиг хавагнаж нүд нь сэжиглэсэн янзтай гялалзах Кэти орж ирлээ.

-Дуулсаан, Кэти. Надад их харамсалтай байна хэмээн Лара түүнээс түрүүлэн ам нээв.

-Тэгэхээр би үхэх нь ээ гээд нулимсаа арай ядан тэвчих бүсгүй

ШИВЭГНЭН ХЭЛЛЭЭ.

Лара суудлаасаа ухасхийн босож,

-Наад тэнэг бодлоо тархинаасаа авч хая! Анагаах ухаан дээд түвшиндээ хүрчихээд байна. Хагалгаа хийлгээд бүх юм сайн сайхан болно гэж найрсаг зангаа илэрхийлэн бүсгүйн мөрөн дээр гараа тавин өгүүлэв.

-Камерон авхай, надад хөрөнгө бэл...

-Энэ талаар би санаа тавих болно. Петерс эмч дахин нэг шинжилгээ хийж, түүний онош батлагдвал чи эмнэлэгт хэвтэнэ. Харин одоо харьж

амар гэлээ.

Кэтийн энгэр дээр шүүдэр мэт  
нулимсан дусал ар араасаа цувран  
урсаж эхэллээ.

-Би... Баярлалаа, Камерон авхай.

"Хэн ч түүний хүн чанарыг мэдэхгүй.  
Хэн ч шүү" хэмээн нулимс  
дуслуулсаар өрөөнөөс гарах нарийн  
бичгийн дарга хүүхэн дотроо  
боджээ.

## Арван зургадугаар бүлэг.

Даваа гаригийн өглөө нэгэн хүн  
Ларагийн ажил дээр хүрэлцэн  
иржээ.

-Хот төлөвлөлтийн комиссын  
О'Брайен гэгч ноёнтон тантай уулзах  
гэнэ, Камерон авхай гэж Трейси  
мэдэгдэв.

-Ямар зорилготой явна гэнэ?

-Тэр хэлээгүй.

Лара дотуур холбооны товч даран,

-Говард оо, наашаа ороод ирээч

гэчихээд Трейсид хандан, -Ноён  
О'Брайанаас лавлаадах гэлээ.

Бүх ирландчуудын адил нүүр дүүрэн  
сэвхтэй Энди О'Брайан гэгч тэр эр  
удмын сунжирсан аялганаасаа салж  
чадаагүй нэгэн байлаа.

-Камерон авхай юу? Амрыг эрье гэж  
зочин эр сунжруулан мэндчилсэн  
боловч Лара зочин эрийг суухыг  
урьсангүй,

-Ноён О'Брайан. таныг сонсож  
байна. Танд юугаар туслах вэ? гэлээ,

-Таныг хууль зөрчиж байна гэж айх  
юм, Камерон авхай.

-Нээрээ юу? Хаана тэр билээ? хэмээн  
Лара гайхсан мэт асуухад,

-14-р гудамж дахь "Дорчестер  
апартаментс" таны мэдэлд байгаа  
юу? гэж тэрээр асуув.

-Тиймээ, миний мэдлийнх.

-Манай комисст орон гэргүй зуугаад  
хүн тэндхийн хоосон өрөөнүүдийг  
эзэгнэж, дураараа дургиж байна  
гэсэн мэдээлэл ирсэн байна.

-Тэр үнэн, тэгээд та яах гэв. Хот  
тэдэнд туслахгүй байхаар нь би  
туслахаар шийдсэн юм гээд  
Говардын орж ирэхийг харуут,



-Энэ ноён Келлер, харин энэ ноён  
О'Брайан хэмээн тэднийг  
танилцуулав.

Эрчүүд гар барин мэндэллээ.

-Би О'Брайанд ядуу улсын хувь  
заяанд анхаарал тавих буяны ажил  
эрхэлж байгаагаа тайлбарлахыг  
оролдож сууна гээд Лара Говардын  
нүд рүү ширтэв.

-Өөрөөр хэлбэл та тэднийг урьсан  
байх нь ээ, тийм үү?

-Тэгсэн, тэгээд юу гэж?

-Танд лиценз бий юу?

-Юуны лиценз билээ? гэж Лара сөргөн О'Брайанаас асуув.

-Хэрэв та орогнох газар зохион байгуулж байгаа бол хотын захиргаагаар зөвшөөрөгдсөн байх ёстой. Тун нарийн дүрэм журам...

-Өршөөгөөрэй, ноён О'Брайан, тэр тухайд огт санаанд орсонгүй. Би даруйхан лицензийг албан ёсоор нь хөөцөлдөж авья.

-Эргэлзэж байна.

-Юунд тэр вэ?

-Байранд үлдсэн оршин суугчид

таныг өөрсдийгөө албадан  
зайлуулахыг санаархаж байна гэж  
үзэж байна хэмээн О, Брайан  
хариулав.

-Жинхэнэ солиорол гэдэг чинь энэ  
биз.

-Камерон авхай, цуглуулсан орон  
гэргүй тэнүүлчдээс байрыг суллан  
чөлөөлөхөд хотын захиргаа танд  
дөчин найман цагийн хугацаа өгч  
байна. Тэднийг явмагц та таглаж  
хаасан цонхны хаалтуудыг авч хаях  
заавар авах болно хэмээн ярвалзав.  
Жаахан байзнавал түүний тэсвэр  
алдагдахыг гэнэт Лара мэдэрчээ.

-Ингээд болоо юу? гэх Ларагийн дуу төмөр хусах мэт хяхтналаа.

-Үгүй ээ, дуусаагүй байна, авхайтан. Байшингийн дээвэр дээр бяцхан цэцэрлэг босгож буй эр таны босгосон самбар түүний цэцэрлэгт хор хөнөөл үзүүлж байна хэмээн гомдоллож байгаа. Та түүнийг бас авч хаях ёстой шүү.

-Хэрэв би энэ бүгдийг хийхгүй гэвэл яах вэ?

-Та энэ бүгдийг хийх л болно. Яг одоо танд тун ярвигтай асуудал үүсчихээд байна. Биднийг аргагүйдэн шүүхэд очуулахгүй

байвал та дэмий цуу яриа тарахаас  
сэргийлж чадах болно шүү гэснээ  
О'Брайан хааш яйш толгой дохих  
аядаад,

-Өдрийг тавтай өнгөрүүлээрэй! гээд  
хаалга чиглэв. Түүний араас өрөөний  
үүд ч хаагдлаа.

-Хүмүүсийг даруйхан гаргах хэрэгтэй  
гэж Келлерийн хэлэхэд,

-Үгүй шүү гэж Лара түүний зүг харах  
ч үгүй татгалзан зөрөв.

-"Үгүй" гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тэр  
хэлэхдээ...

-Би дүлий биш, түүний чалчихыг хоёр чихээрээ сонссон. Бүр олон хүн тийш нь оруул. Байшин заадас бүгдээрээ салж унаг. Терри Хилл дээр оч, хэргийн учрыг түүнд хэл. Тэрээр хугацааг хойшлуулах арга сүвэгчлэг. Сарын сүүл гэхэд зөрүүд зургаан хуцаас салах хэрэгтэй, тэгэхгүй бол бид бүхэл бүтэн гурван сая доллараа алдах нь хэмээн захирамжлав.

Дотуур холбооны нарийхан жингэнэх дуу сонсдож,

-Петерс эмч холбогдоод байна,  
Камерон авхай хэмээн сонсогдсонд  
Лара харилцуур аван,

-Сайн уу, Алан гэлээ.

-Бид дөнгөж сая хагалгаа хийж дууссанаа хэлэх гэсэн юм. Ямар нэг хүндрэл гараагүй, Кэтийн бие тун сайн байгаа гэлээ.

-Энэ чинь сайхан мэдээ байна! Би түүнийг эргэж болох уу? гэж Лараг асуухад нь Петерс,

-Өнөөдөр ч болно. Үдээс хойш ирнэ биз гэлээ.

-Би заавал очноо. Баярлалаа, Алан! Өө тийм тооцоогоо над руу явуулчихаарай гэж Лара хэллээ.

-Тохирлоо.

-Эмнэлэг тавин мянган долларын шагнал хүртэнэ гэж даргадаа хэлээрэй гээд Лара харилцуураа тавин Трейсид хандаж,

-Хонгор минь, Кэтийн тасгийг цэцгийн баглаагаар дүүргэ. Би дөрвөн цагт тэнд очно гэжээ.

Терри Хилл нүсэр хүнд алхалсаар орж ирлээ.

-Таныг баривчлах эрхийн бичиг бичигдсэн байна.

-Юу-уу? хэмээн Лараг гайхвал,



-Орон гэргүй хүмүүсийг тэр байрнаас гарга гэж танд сануулсан юм уу? гэж Терри лавлав.

-Тийм ээ, гэхдээ...

-Лара тэдэнтэй маргалдахын хэрэггүй. Сүх, иш хоёрын тухай эртний үлгэрийг санаж байна уу?

-Намайг үнэхээр баривчилж чадах уу?

-Өөр яахав. Хотын захирагчдын захирамж хоёрдмол ойлголтгүй байдаг юм.

-За яахав. Хүмүүсийг гаргая л даа

гээд Лара Келлер тийш харсанд  
тэдний харц мөргөлдөв.

-Тэднийг нүүлгэ, гэхдээ битгий хээр  
гадаа хаячихаарай. Энэ чинь  
шударга бус явдал шүү. Хэн нэгнийг  
туслуулахаар ав. Хурдалж үз. Цагийн  
дараа гэхэд тэнд хүн үлдэх ёсгүй  
гэснээ суудлаасаа босон,

-Би танд дахиад хэрэг болох уу?  
Баривчлахаар ирэхэд би энд сууж  
баймааргүй байна, намайг эргэж  
ирэхэд асуудал шийдэгдсэн байх  
ёстой гэлээ.

Дотуур холбооны дохио хангинав.

-Камерон авхай, тойргийн  
прокурорын хоёр жентельмен  
тантай уулзах гэнэ гэлээ.

Лара Говард руу дотуур холбооны  
аппарат тийш дохингуут, Келлер  
товчлуурыг даран,

-Камерон авхай гадагш гарсан гэж  
хариултал,

-Хэзээ эргэж ирэх вэ? гэж үл таних эр  
өөдөөс нь асуув.

Келлер, Лара тийш харвал бүсгүй  
мөрөө хавчиж үзэгдэхэд нь,

-Мэдэхгүй гээд Келлер ч товчлуураас

гараа авлаа.

-Би галын шатаар буулаа гэж Лара хэлэв.

Эмнэлгийн байр байдаг бүсгүйн зэвүүцэх сэтгэлийг төрүүлэв.

Эмчлүүлэгчид цонхийж ёнхойн доройтож, амь тавьсан эцэгтэй нь адил санагдаж бүсгүй ихэд аягүйцэв, Ямар чөтгөр нь намайг нааш нь дуудав аа? Өөр хиих юм байсангүй юу?

Лара Кэтийн тасагт орвол жижгэвтэр өрөөг бүхэлд нь цэцгээр дүүргэжээ. Кэти дэрээ налан орон дээрээ хагас сууж байлаа.

-Бие чинь яаж байна? гэж Лараг асуухад нь бүсгүй,

-Эмч айдгаа авдрандаа хийсэн хэмээн хэлсэн гээд инээмсэглэв.

-Тун сайн. Дашрамд хэлэхэд ажил ихтэй, хоолойд тулчихаад байна. Чи надад их хэрэгтэй байна санж гэж Лара хэлэв.

-М -м -мэдэхгүй, танд хэрхэн талархахаа мэдэхгүй юм, Каме-рон

-Талархах юу байхав.

Лара намхавтар ширээн дээр байх харилцуурыг авч Терри Хиллын

дугаарт залгалаа.

-Тэд явсан уу? гэж асуув.

-Сууж л байна. Таныг ирэхийг хүлээх санаатай даг аа. Алив Говардтай холбоо барь. Байр сулармагц би очимз гээд Лара харилцуураа тавин,

-Кэти, ямар нэг юм хэрэгтэй болбол дуулгаарай. Маргааш болтол баяртай гээд гарч одлоо.

Лара жолоочдоо Хиггинс, Олмонт ба Кларк нарын архитекторын товчоонд хүргэж өгөхийг хүслээ.

Бүсгүйг орж очиход Кларк

суудлаасаа босон,

-Ямар таатай сюрприз вэ, Камерон авхай. Танд юугаар туслах вэ?

-14-р гудамжны төслийн баримт танд бий юу? гэж Лара зөрүүлэн асуулаа.

-Надад бий гээд Кларк босоо тавиураас зузаан гэгчийн хавтас аван,

-Энэ байна гэлээ. Төсөлд хэдэн өндөр цамхаг, олон арван дэлгүүртэй худалдааны бүс бүхий орон сууцны байшингийн зураг байх ажээ.

-Үүнийг өөрчлөх хэрэгтэй байна гэж Лара хэлэв.

-Яагаад өөрчлөх болов оо? хэмээн архитекторыг гайхан асуухад Лара зохиомжийн голд хуруугаараа хатган,

-Яг энд барилга байгаа. Ерөнхий схемьг нь тэр хэвээр үлдээнэ, гэхдээ балгаснуудыг түүний эргэн тойронд нь хамруулчихаарай гэж Лараг хэлэхэд,

-Балгаснуудыг төсөлд оруулах гэж үү? Өөдтэй юм болохгүй.

Үзэшгүй муухай юм болно шүү дээ!



гэж хариулав.

-Миний шаардсаныг хий. Шинэ зургийг би үдээс хойш үзмээр байна гээд Лара үүд чиглэв.

Лара машинаасаа Терри Хиллтэй ярьлаа.

-Говардаас сурагтай юу? гэвэл Хилл,

-Ярьсан, байшин суларсан гэлээ.

-Сайн байна. Тойргийн прокурорыг ол. Тэгээд намайг хоёр өдрийн өмнө хүмүүсийг нүүлгэх тушаал өгсөн боловч гүйцэтгэх хүн нь өвдсөн байсан гэж хэл. Энэ тухай мэдмэгц

намайг өөрөө асуудлыг шийдвэрлэсэн гээрэй. Одоо би оффис орлоо, Терри. Прокурор баривчлах эрхийн бичгээ хүчингүй болгох биз гэлээ.

Лара жолоочдоо хандан,

-Цэцэрлэгг хүрээлэн дундуур явья. Битгий яараарай гэжээ.

Лара. Говард Келлер, Терри Хилл гурав ширээний ард сууцгаана. Говард,

-Оршин суугчид бас л зөрүүдэлсээр байна. Би мөнгөөр толгойг нь эргүүлчих гэтэл нэмэр болсонгүй.

Тав хоногийн дараа бульдозер  
ажлаа эхлэх гээд байна гэж  
Говардын тайлагнахад,

-Кларкад зураг төслийг өөрчлөх  
даалгавар өгчихсөн гэж Лара хэлэв.

-Би зургийг үзсэн. Энэ засвар чинь  
тун буруу санаа байна, босс оо, Сүр  
төгөлдөр барилгын дунд нэг муу  
модон балгасыг үлдээж болохгүй.  
Банк орж, барилга эхлэх хугацааг  
хойшлуулахаас гэж Говардыг  
өгүүлтэл Лара.

-Харин ч урагшлуулах хэрэгтэй гэж  
эргэлсэн янзгүй хэлэв.

-Юу?

-Гүйцэтгэгч рүү ярь. Бульдозерууд маргааш ажлаа эхлэг хэмээн Лара тушаав.

-Маргааш ий? Лара чи чинь...

-Өглөөний зургаан цагт эхлэг. Бригадынхан эртхэн төсөл зургаа гардан авсан байх талаар санаа тавиарай гэж Лара эрс хариулав.

-Юу л болох бол доо?

-Харж л байя.

Маргааш өглөө хүнд техникийн

түжигнэх чимээ "Дорчестер апартаментс"-ын оршин суугчдыг дуг нойрноос нь сэрээх нь тэр. Нойрмог нүдлэсэн царай цонхны цаанаас булталзан замдаа таарсан болгоныг хуу дайран байшин руу ойртон ирэх аймшигтай том механизмыг гайхан ширтэцгээнэ.

Аварга бульдозер түжигнэх чимээ тэднийг түгшээжээ. Нэгдүгээр давхарт амьдардаг ноён Хэрши унтлагын хувцастай гудамжинд харайлган гарч ирээд, бригадын даргад хандан,

-Та нар юу хийж байгаа чинь энэ вэ?  
Та нарт зөвшөөрөл байхгүй шүү дээ

гэв,

-Хэн танд тэгж хэлээв?

-Хотын захиргаа! Үүнийг эвдэх эрх танд байхгүй! гээд Хэрши "Дорчестер" тийш заахад нь,

Бригадын дарга хуйлаастай ажлын зургаа гаргаж ирэн,

-За тэгэхээр, маргалдах юм алга. Энэ барилга байрандаа үлдэх юм байна гэжээ.

Оршин суугч эр хөмсөг зангидан,

-Алив хөө, хараадахья гээд зураг руу

тонгойсноо тэр даруй,

-Чөтгөр ав гэж! Манай байшинг тойроод шинэ хорооллын хана хэрэм босгох нь ээ? гэлээ.

-Яг үнэн, эрхэм ээ.

-Тэд солиорчээ! Бохир заваан, тоос шороог яах юм болж байна.

-Энэ надад хамаагүй. Таныг зай тавьж өгөхийг хүсье, би ажлаа хийх ёстой шүү. Хагас цагийн дараа Трейси дотуур холбоогоор,

-Ноён Хэрши тантай хоёрдугаар шугамаар ярих гэнэ гэвэл Лара,

-Намайг эзгүй байна гэж хэл гэжээ.  
Хэршиг гурав дахаа залгахад Лара  
шууд,

-Таныг сонсож байна. Юугаар  
туслахсан бол? гэж асуувал,

-Камерон авхай, тантай уулзах  
хэрэгтэй байна гэж оршин суугч  
ноён Хэршиг хэлэхэд нь,

-Би завгүй байна. Танай тэнд юу  
болчихоов? Зоригтойхон хэлээдэх  
гэхэд нь

-Би оршин суугчидтай ярилцаад  
байр суллахыг зөвшөөрснөө танд  
дуулгахад таатай байх болов уу гэж



бодож байна гэжээ.

-Энэ асуудал нэгэнт шийдэгдсэн.  
Хойшид та бүгдэд хэн ч төвөг  
удахгүй гэж Лара хариулав.

-Ийм дуу чимээнд чинь унтаж амрах  
арга алга!

-Юун дуу чимээ билээ?

-Яагаав барилгын дуу чимээ л  
байхгүй юу? !

-Ямар барилга? Хэн тэр тухай танд  
хэлээ вэ?

-Бульдозерыг оруулсан хүн надад

зургийг нь үзүүлсэн.

-Нээрээ юу? Тэгвэл тэр хүн чинь ажлаасаа халагдсан гэх Ларагийн дуунд үнэхээр уурласан янз тодрон,

-Энэ чинь нууц мэдээлэл байсан юм гэжээ.

-Хүлээгээрэй. түр хүлээгээч. Эрүүл ухаантай улс шиг яагаад хэл амаа ололцож болохгүй байх гэж? Бид нүүчихвэл танд хожоотой биз дээ. Тэгээд ч бид манарсан тоосон дунд үлдмээргүй байна. Хэн барилгын талбайн дунд амьдрахыг хүсэх билээ дээ?

-Ноён Хэрши, таны асуудал надад хамаагүй гэх Ларагийн дуу илт зөөлөрч.

-За яахав, тэгэхлээр "Дорчестер"-ын оршин суугчид гурван долоо хоногийн дотор нүүвэл миний санал хүчин төгөлдөр хэвээр байх болно гэлээ.

Утасны цаад үзүүр дэх эр,  
ханиалгаснаа,

-Би бусадтайгаа зөвлөх ёстой, тэд ч татгалзахгүй гэж бодож байна. Баярлалаа, Камерон авхай гэх сонсогдов.

-За хаанаас даа, ноён Хэрши. Харин ч би танд талархах ёстой гэж Лара хариулав.

Сарын дараа гэхэд 14-р гудамжинд ажил оволзож эхлэх нь тэрээ.

"Камерон энтерпрайз"-ын алдар хүнд улам батжиж, Лара Бруклиндэд тэнгэр баганадсан өргөө.

Уэстчестерт худалдааны төв,

Вашингтонд засгийн газрын

барилгын чимэглэлийг хийжээ.

Далласт хотын захиргааны орон

сууц, Лос-Анжелест захиргааны

тансаг байгууламжийг босголоо.

Хөрөнгө зөөр нь ч нэмэгдэж, мөнгө

гол мэт урсан орж ирэн компанийн

эзнийг улс даяар мэдэх болжээ.

Нарийн бичгийн дарга Кэти нь ажилдаа эргэж оров.

-Би ажилдаа орлоо хэмээн мэндлэхэд Лара түүнийг ширтэн,

-Бие чинь яаж байна даа? гэв.  
Нарийн бичгийн дарга бүсгүй,

-Үүнээс сайн байх гэж юуг хэлэх вэ?  
Баярлалаа,...

-Эрч хүч ямар байна даа? хэмээн асуух нь Кэтийг бүр гайхшруулж орхив.

-Давгүй ээ. Би... хэмээн түгдчвэл,

-Тун баяртай байна. Эрч хүч чамд хэрэг болно. Миний хувийн туслах бол. Ахиу цалинтай, болно биз гэх нь тэр. -Юу юу гэж хэлэхээ мэдэхгүй нь ээ.

-Тэгвэл юу ч хэлэхийн хэрэггүй. Чи чадна гээд нарийн бичгийн дарга бүсгүйн гарт хуудас цаас байхыг харсан Лара,

-Бас наадах чинь юу вэ? гэж асуув.

-“Турман” сэтгүүл таны дуртай хоолыг олны хүртээл болгон нийтлэх гэнэ. Та хэлээд өгөхгүй юу?

-Үгүй. Тэр дэндүү... Байзаарай гээд

хэсэг бодолхийлснээ.

-За алив бичээд ав гэв.

Лара аль эртний мартагдсан тэр нэгэн амт аманд нь мэдрэгдэх шиг болтол жорыг удтал уншин суулаа. Нүдний нь өмнө хөлсний байшингийн тортог татсан булан дахь цахилгаан зуух үзэгдэж, хананы цаана өвчтэй эцэг нь хөлбөрөх үзэгдээд ирлээ. Лара сэтгүүлийг зайлуулан цааш түлхлээ.

Хол ойроос ирсэн явуулын улс ч түүнийг андахаа байжээ. Рестораны танхим дундуур явж өнгөрөх зуурт нь түүнийг танин, сэтгэл хөдлөсөндөө

өөр хоорондоо шивнэж байх нь олонтоо сонсогдох авай. Зүрх сэтгэлийг нь эзэмдэм харцуул гэрлэх санал тавих авч огтын хэрэггүй улс байх тул Лара тэднийг эс ойшооно. Харин одоо хэр нь тэр нэгэн хүнийг хүлээгээд байгаагаа өөрөө ч үл ойлгох агаад амьдралдаа ганц ч удаа хараагүй атлаа тэр нэгэн танил царайг хүлээсээр байх нь гайхалтай ажгуу.

Лара өглөөний таван цагт босож, жолооч Макс нь барилгын талбайд хүргэж ирлээ. Тэрээр овоолсон элсэн дээр зогсон аварга том краны цамхагийг ширтэн: Үгүй ээ, аав минь та эндүүрчээ. Би ачийг чинь хариулж



чадахтай болсон шүү! гэж амандаа шивэглэв.

Ларагийн ажлын өдөр болгон нураах мэт пижигнэх алхны чимээ, Бульдозерын чангаар хүржигнэх дуу, ган төмөр тонших дуунаар эхлэнэ. Бүсгүй өргөгч цамхагийн дээд давхарт гарч, салхинд нүүрээ илбүүлэн зогсоно. Энэ миний л хот!

Тэд орондоо хэвтэцгээж байлаа.

-Чамайг хоёр монтажчины тойрохыг зурсан гэж сонслоо хэмээн адар ширтэн хэвтэх Пол Мартин хэлэв.

-Анхиагүй амьтад шангаа хүртсэн.

Ажиллахыг хүсэхгүй байгаа юм

гэж Лараг хэлэхэд, -Ямар ч байсан чи алганы амт үзүүлэхгүй шийдчихэж сурчээ гээд

Мартин жуумалзав.

-Тэр эрийг анх алгадаж л бүх юм эхэлсэн биш үү? Би чамтайгаа учирсан даа!

-Лос-Анжелос руу нисэх ажил гарсан. Хамт явж болох юм. Хоёр гурван өдрийн зав гаргах уу?

-Дуртайяа явмаар байна санж, гэвч боломж алга, Пол оо. Би ч цаг

нартай уралдаж амьдарч явна шүү дээ. Мартин өндийн суулаа.

-Охин минь, чи цуцталаа ажиллаад ядрахгүй байна уу? Надад ч зориулах цаг завгүй болох нь байна шүү? Лара түүний халуу дүүгэх гуяыг дэрлэн,

-Бүү дэмий ярь. Хэзээ ч тэгэхгүй гэлээ.

Хотын энэ хэсэг нүдэнд нь ил байсан хэдий ч Лара өдий болтол түүнийг анзааралгүй явжээ. Уг газар Уолл стритээс Олон улсын худалдааны төв хүрэх замд орших бөгөөд худагдаа эрхэлэхэд юунаас ч илүү таарах

ажээ! Бүсгүй хэдэн арван удаа дэргэдүүр нь явахдаа нүд тогтоон хараагүй байжээ. Жаахан өмнөхөн олоод харсансан бол: дэлхийд хосгүй тэнгэр баганадсан барилга энд сүндэрлэх нь гарцаагүй байв. Тэрээр Говардын:

-Лара, чи өндрөөс үсэрч үзэх гээд байх шив. Бяц үсрэнэ дээ! гэж хэлж байсныг нь сонсох шиг болов.

Гэвч Келлерийн хэлсэн үг түүнийг зогсоож чадсангүй. Лара оффистоо ирүүт бүхий л ажилтнуудыг өрөөндөө дуудан,

-Бид Уолл-стритээс холгүй орших

эрэг орчмын газрыг худалдаж авна.  
Тэнд дэлхийд хосгүй, хамгийн өндөр  
барилгыг барина гэлээ.

-Лара...

-Говард аа. хэрэв чи татгалзахгүй  
бол чамайг эхлэхээс урьтан би  
яригаа дуусгая. Газрын давуу талын  
тухайд ярихын ч хэрэггүй. Тэнд  
оффис авахыг хүсэгчдийн тулаан  
болох бий вий. Манайхаас өндөр  
барилга баригдтал зай ч бий, лай ч  
бий гэдгийг мартаж болохгүй. Хамаг  
хужир нь үүнд байгаа юм даа.  
Тэнгэр баганадсан барилга маань  
захиргааны газар болох юм. Түүнийг  
"Камерон-тауэр" гэж нэрлэе гэв.

-Хаанаас ашиг олох вэ?

Лара дүүрэн тооцоо бүхий хуудас цаас Келлер тийш сунгалаа. Говард хэзээний няхуур санхүүчийн харцаар нүд гүйлгэн хараад,

-Чи ч аргагүй л зовхи нь нээлттэй од нь гийсэн бүсгүй юмаа гэхэд нь Лара,

-Би юмыг бодитойгоор хардаг.

Говард аа, бид зөвхөн шинэ барилгын тухай яриагүй байна!

"Камерон тауэр" бүгдийн манлай болох ёстой гэв.

Келлер бодолд автлаа.

-Лара, чи өлмий дээрээ цөмцөгнөж явах болж дээ.

-Энэ үзүүлбэр надад ер бусын үзэгдэл биш, тийм үү дээ? гэж Лараг бардам асуухад Келлер,

-Дэлхийд хамгийн өндөр... гэж сонсдох төдий давтлаа.

-Өө, тийм. Банкууд амар заяа үзүүлэхгүй өдөр болгон утасдаж, тоолж барамгүй мөнгөний санал дэвшүүлж байна. Тэд бидэнд бөөн мөнгө зээлэх бололтой гэж Лара хэлэв.

-Зээлж л байг л даа, Чи нэгэнт

шийдсэн юм хойно.

-Аль хэдийнэ шийдсэн.

Келлер гүнзгий санаа алдаад  
хүрэлцэн ирэгсдийг тойруулан харж,

-За за. Тэгвэл газар худалдаж авах  
захиалга өгье дөө гэхэд нь Лара  
инээмсэглэн,

-Чи хожигджээ. Би дөнгөж сая  
өгчихөөд ирлээ. Дашрамд хэлэхэд  
энэ газрын гэрээг Стив Мерчисон  
эзэмшиж байгаа гэлээ.

-Санаж байна, сайн санаж байна.  
Бид Чикагод түүний хамар дороос



нь зочид буудлыг нь хулгайсан биз дээ.

"Муу гичий минь, ганц удаа чи занганаас заяатай гарав гэж мэдээрэй. Чи юунд хүзүү толгойгоороо холбогдсоноо мэдэхгүй л байх шив. Гэхдээ одооноос эхлээд миний улаан замд хөндөлдөхгүй байхыг хичээж үзээрэй. Эс бөгөөс харамсах болно шүү".

-Чи ой сайтай байна шүү.

Энэ хугацаанд Мерчисон Нью-Йоркын мандан бадарч яваа барилгын гүйцэтгэгчдийн нэг

болжээ.

-Лара энэ чинь намайг нэг л баярлуулахгүй байна. Мерчисон энэрэх сэтгэлгүй хүн, тэрээр өрсөлдөгч нараа хумхийн тоос болгож дөнгөдөг юм шүү хэмээн Келлерийг өгүүлэхэд нь,

-Чи түүнд дэндүү их хүндэтгэл үзүүлж байх шив дээ гэж Лара сөргөжээ.

Шинэ төсөлд оруулах банкны мөнгө нүд ирмэхийн зууртгүй гайхалтай хурдан бүтжээ. Дэлхийд хосгүй тэнгэр баганадсан барилгын тухай санаа санхүүч нарыг айн сүрдүүлж, Ларагийн нэр хаа сайгүй цуурайтан

хүчирхэгжив.

Камерон авхай бүгдийг даван хэнд ч дийлдэшгүй ажил хэрэгч бүсгүй болон хувирчээ. "Энэ хүүхэн үүнийг чадаж байгаа юм бол би яахлаараа чадахгүй байх вэ?" гэсэн жөтөөч нэгэн бодол хэн хүний санаанд орж ирэх нь цөөнгүй. Гоо сайхны алдартай фирм-өөрийн сүүлийн бүтээгдэхүүнийг Ларагийн хүндэтгэлд зориулан нэрлэх болжээ. Лара хүндэтгэлийн зоог, тусгай хүлээн авалтанд уригдаж, ярилцлага авахыг хүссэн сэтгүүлчдийн гуйлтанд залхаж эхэлжээ.

Бүсгүй хаа явсан газраа амжилт

дагуулан явах ажгуу.

-Өөрийн барилгын компанийг байгуулья. Манайд туршлагатай ажилчдын бригад байна. Бусад гүйцэтгэгч нарт тэднийг хөлслөө гэж Лара бас нэгэн шийдээ хэлбэл Келлер,

-Муугүй санаа байна хэмээн сайшаав.

-За сонин сайхан юутай вэ? "Камерон-тауэр"-ын суурь хэзээ тавигдах гэж байна? гэж Лараг асуухад,

-Гэрээ хийгдчихсэн байгаа. Гурван

сарын дараа гэвэл Лара сандлын  
түшлэг налан гэдийж,

-Говард аа, чи төсөөлж байна уу?  
Дэлхийд хосгүй өндөр шүү дээ?гэлээ.

Хөгшин Фрейд үүнийг юу гэх нь л  
сонин байна хэмээн Говард  
бодлогоширон суув.

Суурь тавих ёслолын ажиллагаа нь  
сайтар найруулсан жүжигэрхүү юм  
болж, эзэн авхайн дүр мэдээж  
Ларад оногджээ. Гудзон голын эрэг  
хавиар тархаад байгаа эл явдлыг  
зөвхөн телевизийн камер төдийгүй,  
нүдээрээ үзэхээр ирсэн сониуч улсын  
гурван зуун хос нүд гөлийн ширтэж

байлаа. Цасан цагаан өнгийн  
лимузин барилгын талбайн хилийг  
нэвтрэн

орж ирэхэд хүмүүс,

-Нөгөөдөх чинь тэр байна! Тэр  
байна! хэмээн хашгиралдацгаалаа.

Лара хурсан олны түрэлтээс  
хамгаалан цагдаа, хамгаалалтынхны  
тойрон бүчсэн хотын мэрийн зогсож  
буй намхавтар индэр тийш талбай  
хөндлөн гаран гунхалзан алхах зуурт  
нь зургийн аппаратны гялбуур гэрэл  
энд тэндгүй гялсхийнэ.

Өргөн саравч дор банкны эзэд,

компанийн захирлууд, зар сурталчилгааны товчооны эрхлэгчид, гүйцэтгэгч фирмүүдийн удирдагч нарт зориулсан сандлуудыг эгнүүлэн тавьсан байв. Саравчнаас тавиад метрийн зайд аварга эксковатор, бульдозерууд эгнэн жагсаж, тэдний цаахна хүнд даацын тавиад ачааны тэрэгний цуваа ярайна.

Камерон авхай хотын мэр,  
Манхэттены тойргийн захиргааны ерөнхийлөгч хоёрын дунд өөрт нь тусгайлан зассан суудалд суулаа.  
Ганц нэг дусалсаар бороо шивэрч эхлэхэд түүний ард зогсох Жерри Таунсенд боссынхоо дээр хар халхавч барихаар яаравчлахад Лара

инээмсэглэн түүнийг болиулав.

-Манай хот өнөөдөр сэтгэл догдлом өдрийг үзэх гэж байна. "Камерон-тауер"-ын суурийг тавих гэж байгаа нь Манхэттены хувьд түүхийн шинэ үеийг нээж байна. Энэ газар дээр тун удахгүй уран барилгын нэгдсэн чуулга болсон орон сууц, худалдааны төв, үзэсгэлэнгийн цогцолбор бүхий дэлхийд хосгүй өндөр цамхаг... хэмээн хотын мэр камер тийш харан нээлтийг эхлүүлэв. Түүнийг зогсосхийх зуурт хурсан олны алга ташилт нижигнэлээ.

-Хаашаа ч хараа билчээхэд Камерон



авхайн гайхамшигт бүтээл бидний нүдэнд тусаж, тэднээр бахархах сэтгэл өөрийн эрхгүй төрдөг. Хойд зүгт хоёр километрийн тэртээд гээд тэрээр баруун гараараа заан, - Камерон төв, түүний цаахна "Камерон Плаза" бас олон арван орон сууцны барилгууд шагшигдан магтагдсаар байгааг харж болно. Номхон далайгаас Атлантын дапай хүртэл зочид буудлын "Камерон" сүлжээ тархжээ гээд мэр нүүр дүүрэн инээмсэглэн хажуудаа суугаа бүсгүй рүү мэхийн хүндэтгэж,

-Энэ бүсгүй самбаа овсгоотой, ухаалаг төдийгүй зүйрлэшгүй үзэсгэлэнтэй юм! гэлээ.

Цугласан олон уухай түрэн  
хашгиралдав.

-Ноёд, хатагтай нараа, Камерон  
авхай та бүхний өмнө гарч ирнээ гэж  
хотын мэр өндөр дуугаар хөөрөн  
хашгирав. Лара босож, урагш хэд  
алхан мэртэй зэрэгцэв. -Элэгсэг  
халуун үг хэлсэнд гялайлаа, эрхэм ээ.  
Хайртай хотдоо бага ч болов  
зүйлийг бэлэглэж чадсандаа би  
туйлын баяртай байна. Яг энэ мөчид  
би аавынхаа үгийг саналаа. Тэр  
хэлэхдээ, хүн энэ орчлонд... гэснээ  
сонины хуудаснаас зүсийг нь  
хэдийнэ мэдэх болсон Стив  
Мерчисонтой харц тулгарсан Лара  
агшны төдийд дуугуй болсноо

төдөлгүй үргэлжлүүлэн. -Түүнийг жаахан ч гэсэн илүү сайхан болгохоор ирдэг гэсэн сэн. Аавын минь гэрээслэл биелсэн гэж найдаж байна хэмээв.

Бүсгүйн толгойд: Мерчисон энд юугаа хийж доншуучилж яваа юм болоо? гэсэн бодол зурсхийжээ.

Хотын мэр олны алга нижигнүүлэн ташихын хамтаар Ларад барилгачны час улаан дуулга, гялалзсан хоромон хүрз гардуулаад,

-Камерон авхай, ажилдаа! хэмээв.

Бүсгүй хөрсийг нь сийрүүлж

урьдчилан зэхсэн шоо дөрвөлжин газар очиж хүрзээ жадлан зоолоо.

Гэрэл зургийн сурвалжлагчид ч хальс үл хайрлан шажигнатал зураг дарж, нүд сохлом гялбуур гэрэл энд тэндгүй гялсхийв. Дараа нь эрхэм хүндэт зочиддоо хундагатай шампан дарс барилаа. Лара ийш тийш сэм харвал Мерчисон үгүй болжээ.

Хагас цагийн дараа гэхэд лимузин оффис руугаа эргэв.

-Миний бодлоор ёслолын ажиллагаа давгүй болоо шүү. Ёстой гайхалтай хэмээн Жерри Таунсенд арын суудлаас буухаар арай чамай зүтгэх

зууртаа өгүүлэв.

-Тийм ээ, давгүй боллоо. Баярлалаа, Жерри хэмээн Лара инээмсэглэн хариулав.

Тавин давхар Камерон төвийн өрөөнүүд дэх "Камерон энтерпрайз"-ын ажилчид толгой өндийх завгүй ажилладаг байлаа. Боссынхоо айсуй явааг мэдсэн тэд цахилгаан шатнаас буух Лараг хармагц ажил руу толгой шаан шамдацгаав.

-Дотогш орцгооё хэмээн өрөөнийхээ үүдэнд зогтуссан Лара Таунсендад хэлэв.

Булангийн уужим том өрөөний цонх гол руу, хотын хамгийн ажил хэрэгч хэсэг тийш хардаг аж.

-Аав чинь яаж байна, Жерри? Гайгүй юу?

"Аавын тухай тэр юу мэдээд байна вэ?"

-Тэр... Гайгүй дээ.

-Би ч бас тэгж бодсон юм. Гэгээн Виттын бүжиг гэл үү? гэж Лараг асуувал,

-Тпйм ээ хэмээн Жерри харамсан хариуллаа.

Энэ аймшигтай өвчин хүндэрч нүүр нь хар аяндаа татганаж, үе мөч нь захирагдахаа бүрмөсөн алддаг ажээ.

-Та аавын тухай хаанаас мэдээ вэ? гэвэл,

-Би аавын чинь хэвтэж байгаа эмнэлгийн захирлуудын зөвлөлийн хуралд оролцож суухдаа хоёр эмчийн ярилцахыг дам сонссчихсон юм гэж Лара хариулав.

-Аав найдваргүй болсон хэмээн Таунсенд дурамжхан хэллээ.

-Гэхдээ эдгээх эм тан олдтол шүү дээ. Би зарим нэг лавлагаа авсан.

Швейцарьт олон жилийн туршид ийм өвчтөнг ажиглаж байгаа нэг мэргэжилтэн байдаг юм. Тэрээр эцгийг чинь эмнэлэгтээ хэвтүүлэх хүсэлтэй байгаагаа хэлсэн. Бүх зардлыг төлчихнө гэж Лара хэлэв.

Таунсенд санамсаргүй байтал ийм үг сонссондоо хэсэг зуур хэл нь гацсан мэт таг дуугүй болчихлоо.

-За яах гэж байна? гэж Лараг шавдуулахад нь,

-Надад... би зөвшөөрч байна хэмээн арай ядан түгдчин хэллээ.

Би боссыгоо огт мэдэхгүй явжээ. За



даа, хэн ч, яаж ч мэдэх вэ дээ?

Хүний нийгмийн түүхэнд их бага үйл явдал шийдэгдэн үргэлжлэх боловч Лара тэднийг огтхон ч анзаарсангүй. Америкийн иргэд Рональд Рейганыг хоёр дахь удаагаа сонгож, алс тэртээх Орос оронд Михаил Горбачев гэгч нэгэн эрхэм Зөвлөлт улсын коммунист намын нойрмог лидер Константин Черненкогийн суурийг сэлгэсэн байна.

Лара хотын ядуу давхрагынханд зориулан Детройтод орон сууц барьжээ.

1986 онд АНУ-ын Дээд шүүхээс

биржийн мэдээллийг хууль бусаар худалдсаных нь төлөө Айвен Боэскээс зуун сая долларын торгууль албадан төлүүлж, шунаг брокер эрийг гурван жилээр хорих ял заасан байна.

Лара Куинсийн захиргааны барилгын ажилдаа оржээ. Захиалагчид өөрсдөө бүсгүйн эрэл сурал болцгоон, энэ удаад Кельнээс нөлөө бүхий немц санхүүчидийн групп Ларатай уулзахаар хүрэлцэн ирэв. Нисэх онгоцны буудалд тосч авахад немцүүд ядарч зүдэрснээ гомдоллоход нь Камерон авхай, -Жентельменүүд ээ, миний завтай

байгаа цорын ганц цаг энэ. Үдийн хоолны дараа би Гонконг нисэх ёстой хэмээн тэр даруй амыг нь таглаж орхив.

Лара зочиддоо кофе өгч, өөрөө цай оочлон суухад эрчүүдийн нэг нь ер бусын амт мэдрэгдэж байна хэмээхэд нь тэрээр,

-Надад зориулан тусгайлан хураасан кофены үрээр хийсэн юм. Дахин нэг балгахад та тааламжтай сайхан амтыг нь бүрэн мэдрэх болно гэлээ.

Хэлэлцээр туйлын амжилттайгаар буюу бусгүйн амжилтаар өндөрлөв.

Хүний амьдрал ар араасаа цуварсан үйл явдлаар дүүрэн байх авч өдөр болгон шахуу аахар шаахар будлианы тайлал болох гайхалтай нээлтээр тасрахгүй ажээ. Лара Үл хөдлөх хөрөнгийн үнэ хаялцах худалдаанд Стив Мерчисонтой хэд хэдэн удаа тулгарсан боловч шидээр гэлтэй цаг үргэлж өрсөлдөгч эрээ давж дөнгөдөж байв.

-Чи хааяа ч болов хазаараа татаж, далдхан шиг байвал зүгээрсэн гэж Келлерийг түүнд сануулахад,

-Ямар үлийгээ хийх гэж тэр билээ! Харин мань эр л нуугдаж суух л хэрэгтэй үйлтэй дэгээ! гэсэн аж.

Нэгэн өглөө эртээр зарлага гялалзсан  
ягаан цаасаар нямбайлан  
ваадагнасан хайрцаг авчирчээ.

Муугүй бэлэг бололтой гээд Кэти  
боссынхоо өмнө хайрцгыг

-Нилээд хүнд юм билээ. Хэрэв наана  
чинь бүрх малгай байвал, таны  
толгойд аюул заналхнйлж байна  
гэсэн үг! гэж Кэти хэллээ.

Ихэд сонирхсон Лара боодлын  
цаасыг урж, тагийг нь авлаа. Дотор  
нь хар шороо байх нь тэр. Алтан  
эмжээртэй гялгар нэрийн хуудас  
дээр:

"Фрэнк Э. Кэмпбелл. Буяны үйлчиягээ. Өдөр шөнөгүй ажиллана." гэсэн байжээ.

Ларагийн ажил хэрэг нь ганц ч цаг саатан зогсоно гэдэг даанч нэг үгүй, хүрд мэт эргэлдсээр байлаа. Тэрээр сонины нүүрнээс засгийн гаар хүнд суртлын уршигаас үүдэн яагаад ч тоноглож чадахаа байсан тоглоомын талбайн тухай уншмагцаа л өөрийн хөрөнгөөр хүүхдийн хотхон байгуулж хотын захиргаанд бэлэглэжээ.

Хэвлэлийнхэн өгөөмөр бэлгийн эзэнг тэнгэрт тултал магтацгааж, "Пост" сонин тал шахам нүүрэндээ:

"ЛАРА КАМЕРОН БҮХНИЙГ ЧАДНА!"  
гэсэн нийтлэл бичиж шуугиан  
тарьжээ.

Лара долоо хоногтоо нэг юм уу хоёр  
удаа л Пол Мартинтай уулзаж, харин  
өдөр болгон шахуу хоёр биентэйгээ  
утсаар ярина.

Саутхэмптонд харш худалдан авсан  
нь түүнийг үнэтэй үслэг эдлэлийн  
чамин тансаг гоёл чимэглэл, үнэтэй  
машины ертөнцөд татан оруулж,  
хувцасны дэг маягт алдартай  
урчуудын загвар түрэн орж иржээ.

"-Надад шинэ дашинз хэрэгтэй  
байна.

-Тэгээд яах юм бэ? Би я.мар мөнгө тарих биш. Өглөгийн газар руу оч.

-Аав аа, тэнд чийь дайдаа хуучин хувцас байдаг шүү дээ". Лара шинэ хослол захиаллаа.

Хамт ажиллагсад нь түүнд гэр бүлийг нь орлоно. Лара тэдний талаар санаа тавьж, гарах зардалд гар татдаггүй ажээ. Бүсгүй тэдний төрсөн өдөр, хуримын ойг нь мартдаггүй төдийгүй хүүхдүүдийг нь сайн сургуульд оруулан, цалин тэтгэлэг өгдөг байлаа. Өгөөмөр сэтгэлийнх нь хариуд талархахыг оролдоход угийн сэтгэл хөдлөлөө илэрхийлж сураагүй Лара аягүйрхэх ажээ. Энэхүү



сургамжийг эцэг нь түүнд олгосон юмсанж.

Бүсгүй өөрийгөө үл нэвтрэх ханаар хязгаарлах бөлгөө. Цаашид намайг хэн ч гомдоохгүй. Хэн ч.

# Гутгаар дэвтэр

## Арван долоодугаар бүлэг.

-Говард аа, өглөө Лондон ниснэ. -Юу болоо вэ?

-Макинтон лорд засуулах объектоо ирж үз гэж урьсан. Хоршин ажиллах тухай ярилцана.

Брайан Макинтош Британи дахь ул хөдлөх хөрөнгийн нилээн чинээлэг шинжээчдийн нэг байлаа.

- Бид хэдэн цагг нисэх буудалд очсон байх ёстой вэ? гэж Келлерийг асуухад нь,

-Би ганцаар явахаар шийдсэн

хэмээн Лара хариулав.

-Яаж байгаа нь тэр вэ?

- Чи эндээ намайг орлож үлд.

Келлер ч зөвшөөрөн толгой дохиж.

-Тэгье ээ. Юунд ч бүү санаа зовоорой гэлээ.

-Санаа ч зовохгүй ээ. Хэнд найдаж болохоо би мэднэ хэмээн Лара хэлэв.

Лондон хүрэх нислэг нь ямар ч сааталгүй өндөрлөн, хувийн "Боинг-727" онгоцны дугуй нисэх зурваст

зөөлөн газардав. Яг энэхэн мөчид түүний амьдрал ямар сорилтын босгон дээр ирээд байгааг Лара мэдээгүй л яваа ажээ. "Кларижез" зочид буудлын эрхлэгч Рональд Жоунз үүдний танхимд түүнийг тосч авлаа.

-Тантай дахин уулзаж надад асар их аз завшаан тохиож байна, Камерон авхай. Таныг өрөөнд чинь хүргэж өгөхийг болгооно уу. Өө тийм, таны нэр дээр хэдэн мэдээлэл, цахилгаан утас ирсэн байгаа гэв.

Люкс өрөөний засал тансаг тохьтой ажээ. Хятадын хоёр гангар ваарыг Брайан Макинтош, Пол Мартин

хоёрын илгээсэн цэцэгсээр дүүргэж,  
Рональд Жоунзын онцгой  
захирамжаар шампан дарс, хөнгөн  
зуушаар ширээ засчээ.

Лараг өрөөний босгоор дөнгөж  
алхангуут утас нь хангинан  
дуугарлаа. Ганц минутын зай  
завсаргүй АНУ-аас,

- Архитектор зарим нэг бүрдэл  
хэсгийг тодруулах гэнэ. Энэ харьцаа

-Цементийн нийлүүлэлт  
хожимдоод...

-Анхны Үндэсний банк манай шинэ  
гэрээнд оролцоход бэлэн...

-Сан-Франциско хотын дарга таныг хүрэлцэн ирэх талаар мэдэхийг...

-Угаалгын өрөөний тоноглол... -... цаг агаарын байж байгааг ээ. Бид хуваараасаа арай чамай...гэхчилэн ярьцгаав.

Арга хэмжээ авахыг шаардсан асуулт бүр нь тохирсон хариултаа авсны эцэст өлдөрлөхөд Лара сая л эцэтлээ ядарснаа мэдлээ. Бүсгүй хундаганд шампан дарс хийж аваад зочид буудлын арк бүхий үүднээс суугчдын тансаг "ройс-ролл", "бентли" машин хөдлөхийг ажиглахаар цонхны өргөн тавцан дээр сандайлан суув.

Лара маргааш өглөө нь Брайан Макинтоштой хамт голын эрэг дагуу хоёр квадрат мильд үргэлжлэх яйжийж далжийсан бяцхан байшингууд, урт урт гологдсон агуулах бүхий газрыг үзэхээр явцгаалаа.

-Сайд нарын танхим бидэнд албан татварын нилээд хөнгөлөлт үзүүлэхээ амлаад байгаа. Чухамдаа энд цоо шинэ хот сүндэрлэх ёстой юм шүү гэж Брайан ярив.

-Би бүгдийг л бодолцохыг хичээмз гэх авч Лара хэдийнэ нүднээ үзэж дүрслээд шийдчихсэн байжээ.



-Дашрамд хэлэхэд надад концертын хоёр тасалбар байна. Эхнэр маань үдшийг клубт өнгөрөөнө. Та сонгодог хөгжимд хэрхэн ханддаг вэ? гэж Брайан санал болгов.

Энэ талаар үлэмж бүдэг бадаг төсөөлөлтэй явдаг Лара,

-Ихэд таашаана гэчихлээ.

-Филипп Адлер, Рахманиноваг тоглоно шүү дээ гээд Брайан хамт яваа бүсгүй тийш нэгийг хүлээсэн янзтай харсан боловч төгөлдөр хуурчийн нэр Ларад юуг ч эс хэлэх бөлгөө.

-Гайхалтай!

-Тэгвэл тохирох шив. Дараа нь "Скоттс"-т хооллоцгооё. Би долоод ирж таныг авна гэж Брайан хэлжээ.

Тэр үдэш нь яачихав гэлтэй уйтгар төрүүлсэнд Лара: "Би юунд зөвшөөрөв дөө хэмээн гуниглан бодоод халуун ваннд хэвтэхээс өөр сайхан юм байсангүй. Үгүй яах вэ, өглөө Нью-Йорк буцах юм чинь юуны хамаа байх вэ?"

Хатан хааны наадмын танхим хөгжмийг үнэлэн цэгнэгч: цардсан цагаан хүзүүвч бүхий смокингтой жентельменүүд, төлөв даруу үдшийн

даашинзтай хатагтай нараар пиг дүүрчээ. Ямбаны цэнгэл эдлэх гэж буйгаа бахархан суух үзэгчид өөр хоорондоо шивэр авир ярилцана.

Макинтош хөтөлбөр тараагчаас хоёрыг худалдан авч, Лараг хүндэтгэл үзүүлэн суулгасны дараа өөрөө суудлаа эзлэв. Бусгүй зузаан цаасан дээрх хөтөлбөрийг эргүүлэн мөр бүрийг нүд гүйлгэн

"Лондонгийн филармони найрал хөгжим... Рахманинов. Төгөлдөр хуурт зориулсан 3-р концерт, до минор, 30-р туурвил. Төгөлдөр хуурч Филипп Адлер..." хэмээн уншлаа.

Говард руу утасдахаа мартажгүй

юмсан. 5-р авенюгийн газрыг дахин нэг бодолцож үзэг хэмээн Лара өөртэйгөө ярина.

Гэрэлтүүлэг удирдаач дээр тусахын цагт алга ташилт нижигнэх авч энэ нь Лара түүний бодлоос сатааруулж дөнгөсөнгүй.

"Бостоны гүйцэтгэгч дэндүү хөшүүн юм. Ямар нэг урамшуулал хэрэгтэй болох нь. За яахав, Говард түүнд шагнал амлаг".

Дахин алга ташилж нижигнэж, фрак өмссөн нэгэн эр төгөлдөр хуурын дэргэд дугуй сандал дээр сууж байв. Удирдаач эр дохиураар даллахад

танхим даяар яруухан аялгуу  
эгшиглэлээ.

Хуурын товчлуур дээгүүр гүйх  
Филипп Адлерын нарийн савхан  
хурууг нүд гүйцэн харж хариулахын  
эцэсгүй ажээ. Ларагийн ард суух  
хатагтай техас аялгуугаар,

-Агнес аа, санаанд багтамгүй сайхан  
байна, тийм үү дээ? хэмээн шивнэх  
сонсдов.

Лара золтой л гэдрэг эргэн  
харчихсангүй.

"Лондонд хэлэлцээр хийнэ гэдэг нэр  
төдий л явдал юм байна. Хотын

дүүрэг ч гэж алга. Хэн хүнгүй хүссэн газраа амьдардаг юм байна. Газар, Байрлал, Бодлого" гээд түүнд санал болгосон, Колумбын талбайгаас холгүй орших газарт баригдах хамгийн сүүлд авсан төслийг эргэн саналаа. "Энэ ч шал өөр хэрэг." Ард нь дахиад л чангаар,

-Түүний нүүр царайг ээ... Тэр зүйрлэшгүй эр юм аа! Жинхэнэ суут!... хэмээн тэсгэлгүй шивнэх дуулдав.

Лара дахин анхаарлаа төвлөрүүлэхийг чармайв. "Нэг квадрат фут ашигтай талбайн зардал дөрвөн зуугаад долларт багтана.

Хэрэв барилга зуун тавин сая гэвэл,  
газар зуун хорин тав, тэгвэл ерөнхий  
төсөв нь..."

-Ээ Бурхан минь! гэж ард нь уулга  
алдлаа. Ларагийн тэвчээр  
барагдлаа.

-Жинхэнэ ид шид! Сэтгэл татсан эр  
юм!

Найрал хөгжмийн байрлах  
хөндийгөөс бөмбөрийн нижигнэх  
дуу танхим даяар дүнгэнэн,  
хөгжмийн эрч хурдсан, хийл хөгжим  
эгшиглэж,

-Ард нь суух хатагтай биеэн хянах

чадвараа алдсан бололтой,

-Чи сонс доо! Үгүй ээ, би чадахгүй нь... гэж гинших сонсогдов. Лара шүдээ тас зуулаа. "Хамгийн бага зардлаар бүрээд авахад болоод явчихна, арван хувьд нь зээл өгөхөд дор хаяж гучин таван саяыг өгнө, дээр нь барилгын шимтгэлийн..."

Хүчирхэг найрал хөгжмийн аянд агаар хүртэл доргин чичрэх шиг санагдана. Хөгжим гэнэт таг чимээгүй болон агшны төдийд зааланд үхээрийн нам гүм ноёрхон байснаа үзэгчид гэнэт суудлаасаа огло харайн босч: "Браво! Браво!" хэмээн хашгиралдав.



Фрак өмссен эр бүгдэд мэхийн ёслож харагдлаа.

Харин мань Лара толгой өлийж харсан ч үгүй.

"Зургаан хувийн ашигт ноогдох татварыг таван сая найман зуу... гэж тооцож..."

-Гарамгай юмаа, тийм ээ? хэмээн  
Брайан Макинтош намуухан хэлэхэд  
нь,

-Өө тийм юм гэх Лара дахиад л түүнд саад болсонд харамсаж буйгаа нуун үгийг нь дагуулан хариуллаа.

-Алив, тайзны араар очицгооё.  
Филипп миний найз хэмээн хамт  
яваа эр санал болгох нь тэр.

-Үнэнийг хэлэхэд би... гэж Лараг  
тээнэгэлзэхэд Брайан гараас нь  
шүүрэн аваад гарахаар зүтгэх зуур,

-Камерон авхай, түүнийг тантай  
танилцуулахад надад таатай байх  
болно гэжээ.

Тэд явсаар жүжигчдийн хувцасны  
өрөөнд явж очлоо. Үүдний тэнд  
шүтэн бишрэгчид нь хөлхөлдөнө.  
Макинтош үүдийг тогшлоо.

-За. та юу гэв, эрхэм ээ? гэж дүрэмт

хувцастай эр нарийхан завсар гарган  
үүдийг хагас нээн асуув.

-Лорд Макинтош байна. Би ноён  
Адлертэй уулзах гэсэн сэн.

-Өө, тэгэлгүй яахав, эрхэм ээ.  
Орогтун.

Тэрээр Лара, Брайан хоёрыг оруут л  
хаалгаа хавхийтал хаачихлаа.

-Энэ хүмүүс яах гээд байгаа юм бэ?  
хэмээн Лара асуувал үйлчлэгч эрийн  
нүдэнд гайхсан өнгө илрэн,

-Өөрсдийн шүтээндээ талархал  
илэрхийлэх гэж байгаа юмаа,

хатагтай гэв.

"Шүтээн гэв үү?"

-Зочдын ногоон өрөө рүү ороорой,  
эрхэм ээ хэмээн дүрэмт хувцас  
бүхий эр захирамжлав.

-Танд баярлалаа.

"Тавхан минут, тавхан минутын  
дараа гэхэд би ажилдаа орсон  
байна" хэмээн огтын сонирхолгүй  
зүйлдээ залхсан Лара тэсэхээр  
шийджээ.

Зочны ногоон өрөө гэгч нь пиг  
дүүрэн хүнтэй байв. Буйдан сандалд

залрах төгөлдөр хуурч эрийг эр  
эмгүй тойрон халхлан бүчжээ.  
Бүчсэн олон төдөлгүй зам тавин  
зайлахад Ларагийн зүрх хүчтэй  
оволзоод явчихлаа. Тэртээ алс дахь  
ой ухаанаас нь өдий олон жилийн  
туршид түүний хайж байсан бүдэг  
бадаг балархай дүр төрх гэнэт өмнө  
нь сууж байх нь тэр. Бүсгүйн хүүхэд  
насны зүүд мөрөөдөл нь гэнэт  
биелэх нь тэр ээ. Мөрөөдлийн хан  
хүү! Цайвар үстэй, өндөр нуруутай  
дайчин эр буйдан сандалд залрана.  
Түүний цэвэр царай нь чин зоригтой,  
жир бус эрч хүчийг илтгэнэ. Фрак,  
цасан цагаан эрвээхэй зангиа нь:  
"Жаахан охин Лараг угаагуурын

дэргэд сав суулга угаан зогсож, гал зууханд цэл залуу эр орж ирүүт түүний араас нь дөхөж ирээд чихэнд нь: Танд туслахыг болгооноу?" гэж шивнэх тэр нэгэн мэдрэмжийг төрүүлэх авай.

Брайан Лара тийш түгшсэн янзтай харан, -Та зүгээр үү? гэж асуув.

-Надад... зүгээр ээ, зүгээр хэмээн Лара сандчин хариулав. Бүсгүй амьсгаа нь давчдаад ирлээ. Филипп Адлер инээмсэглэсээр өндийн босч ирэн Лара тийш гар сунгахад нь тэртээ хол өнгөрсөн хүүхэд ахуй цагт нь инээж байсан тэр нэгэн инээмсэглэл нь мөн болохыг бүсгүй

ажиглажээ.

-Хөөе, Брайан! Уулзсанд чинь баяртай байна шүү! Сайн байна, чи манай өрөөнд орж ирэхээс залхуурсангүй шүү!

-Би ийм боломжийг алдахгүйээ, Фил ээ. Чи өнөөдөр хэн болохоо нэг үзүүллээ дээ.

-За! За!

-Энэ авхайтай танилцана уу. Лара Камерон. Лара түүнийг нүд салгалгүй ширтэх зуур амнаас нь, -Та алга болчихгүй... гэсэн уг уначихлаа.

-Өршөөгөөрэй, хатагтай та юу гэв ээ?  
Бүсгүй хацарт цус юүлэгдэв үү гэлтэй  
халуу оргин улайлаа.

-Үгүй. Юу ч гээгүй. Би... гээд Лара  
түгдэрлээ. Тэрээр дахиад ганц ч үг  
хэлж чадсангүй. Эргэн тойронд нь,

-Филилп, та үүнээс илүү сайн тоглож  
байгаагүй шүү!

-Рахманинов танд өртэй болжээ!  
хэмээн энд тэндээс ам хамхилгүй  
магтаалын үг чулуудацгаасаар  
байлаа. Үнэтэй бриллантаар нүдээ  
бүлтэртэл гоёж гоодсон эмэгтэйчүүд  
түүний ханцуйнаас чангааж,  
фракынх нь торгомсог энгэрийг



ээлдэгээр илж таална. Дуг  
нойрондоо зүүдэлж буй мэт  
Ларагийн мөрөөдөл нь биелэжээ.

-Хоёул явах уу? гэж Брайан түүнээс  
асуух сонсогдов.

Үгүй! Ларагийн хөл нь бул чулуу шиг  
байрнаасаа хөдөлсөнгүй. Тэр үлдэх  
ёстой, яриа үүсгэж, энэ бүхэн зүүд  
биш гэдэгт үнэмших ёстой.

-Явалгүй яахав.

Өглөөний 8 цагт Лара Лондон-Нью-  
Йоркийн чиглэлийн нисэх онгоны  
бүхээгт суудлаа эзэлсэн байв.

Хувь заяа биднийг дахин учруулах болов уу?

Санаа бодол нь байн байн жүжигчний өрөө тийш бэлчинэ. Лара хүүхэд насны зүүдний мөрөөдөлд автан амьдарна гэдэг инээдтэй явдал хэмээн өөрийгөө ятгахыг оролдсон боловч нэмэр болсонгүй. Бодолд автан гөлрөх Ларад Филипп Адлерын дүр тодорч, дуу нь сонсогдоно.

Бид уулзах ёстой!

Өглөө эртэд Пол Мартин утасдан,

-Сайн уу, охин минь. Би их санасан

шүү. Лондон ямар байна даа? гэв.

-Гайхалтай. Хачин сайхан юм гэж  
Лара бахдан өгүүлэв.

Гэвч Полтой ярьсны хойно  
Рахманиновын 3-р концертыг  
гайхуулам тоглогч эрийн тухай  
бодол санаанаас нь үл хагацав.

-Хурлын танхимд бүгд цугларчихлаа,  
Камерон авхай, Таныг хүлээж байна.

-За очлоо.

-Куинсын төлөвлөгөө нурсан гэж  
Келлер хэллээ.

-Яагаад тэр вэ? Бид бүгдийг тохиролцчихсон гэж би бодсон шүү дээ гэж Лараг гайхан асуухад нь,

-Би ч гэсэн тэгж л бодсон. Гэтэл дүүргийн захиргааны зөвлөлөөс сэлбэн засах төлөвлөгөөнөөс татгалзсан хэмээн Келлер хариулав.

Лара танхимд суух архитектор, хуульч, инженер, зар сурталчилгааны агентлагийн төлөөлөн буй хүмүүсийг нүд гүйлгэн харлаа.

-Ойлгосонгүй. Дүүргийн иргэдийн дундаж жилийн орлого 9000 доллар байхад, харин байрны сарын

хураамж нь 200-гаас багагүй байна.  
Бид тэдэнд шинэ орон сууц олгоно.  
Гэхдээ хуучин хөлсөөр нь шүү дээ.  
Тэд баярлах ёстой сон! Гэтэл үгүй  
байна, харин ч хамраа сөхөцгөөж  
байх шив! Үүнийг л ойлгохгүй юм!

-Үнэндээ бол зөвлөлийнхөн бүгд  
татгалзаагүй л дээ. Ямар нэгэн Эдит  
Бенсон гэгч дарга эмэгтэй хор  
найруулаад байна.

-Түүнтэй уулзалт товлоодохоорой.  
Би өөрөө ярилцамз.

Лара Эдит Бенсонтой уулзахдаа  
барилгын хэлтсийн эрхлэгч Билл  
Уайтманыг байцуулжээ.

-Илэн далангүй хэлэхэд хэмээн мэнд усаа мэдэлцэнгүүтээ Лара шууд л яриандаа орж,

-Таны татгалзаад байгаа явдал бидэнд ихээхэн санамсаргүй тохиолдол болоод байна. "Камерон энтертайз"-ны зүгээс дүүргийг үндсээр нь өөрчлөх сэргээн босголтонд зуун сая долларыг хөрөнгө оруулахад бэлэн байна л даа, гэтэл орон нутгийн захиргааны зөвлөл татгалзаад... гэлээ.

-Камерон авхай, та илэн далангүй байхыг хүсэж байна уу? гээд хатагтай Бенсон түүний үгийг таслан,

-Тэгвэл та зөвхөн хүмүүст туслах гэсэндээ хөрөнгө оруулаагүй гэдгээ хүлээх хэрэгтэй. Танд ашиг хэрэгтэй биз дээ хэмээв.

-Тэр ч мэдээж, гэсэн ч бид ямар нэг ажил хийх хэрэгтэй биз, Үүнийг хийх цорын ганц арга нь хүмүүст туслах явдал. Дүүргийн орон сууцны нөхцөл сайжирч, бас...

-Тантай санал нэгдэж чадахгүй нь, өршөөгөөрэй. Манай дүүрэг харьцангуй амар тайван ногоон бүсэд тооцогддог. Та нарыг тийш нь орууллаа гэж бодье л доо, түүнийхээ хариуд бид өч төчнөөн машин тэрэг хөлхөлдсөн орчин тойрон нь

бохирдож, даац нь хэтэрсэн  
гудамжыг л хүлээж авна. Үгүй дээ,  
ийм орчин бидний хэнд ч хэрэггүй.

-Бидэнд ч гэсэн адил. Компани ийм  
аймшигийг бүтээх гээгүй л юмсан...  
хэмээн Лара бууж өгсөнгүй.

-Аймшиг гэнээ?

-Би цэргийн хуарангийн тухай  
яриагүй байна. Төсөлд дуу чимээ  
нэмэгдэх, нарны гэрэл дутагдах, хог  
хаягдлын талаар урьдаас тусгадаггүй  
юм. Хүмүүс урьдын л адил дасаж  
заншсан орчиндоо амьдрах болно.  
Үзүүлсэн загвар бидний хийсэн маяг  
үзүүлбэр бишээ. Төслийг манай



улсын нэрт архитектор Стэнтон Филдинг зохиож, Вашингтоны шилдэг дизайнер Эндрю Бартон загварыг гардан гүйцэтгэсэн юм гэж Лараг тайлбарлавал Эдит Бенсон яаж ч тайлагнаад санаагаа өөрчлөхгүй гэдгээ илэрхийлэх мэт гараа дэлгэн, мөрөө хавчисхийлгээд,

-Ийм хүч чармайлт гаргасан ч надад үнэхээр харамсалтай байна. Өөр яриад байх юм алга даа гээд суудлаасаа өндийлөө.

Энэ төслийг хэрхэвч алдаж болохгүй хэмээн Лара бодоод: Энэ төсөл оршин суугчдад л хэрэгтэй гэдгийг энэ хүүхэн олж харахгүй байгаа юм

байх даа? За тийм байж. Хүмүүсийн тусын тулд юм хийх гэж бийдаг. Гэтэл чамд: Ингэхийн хэрэггүй гэж хэлээд байх юм даа.

Гэнэт Ларад нэгэн бодол зурсхийн орж ирээд,

-Түр хүлээгээрэй. Хэрэв андуураагүй бол зөвлөлийн бусад гишүүд хэлэлцээр хийхэд бэлэн байгаа гэсэн байхаа? Бүгдээрээ, танаас бусад нь гэл үү? гэж яаран асуув.

-Тэр ч тийм хэмээн өнөө хүүхэн эрс шулуун хариуллаа. Лара гүнзгий гэгч санаа алдав.

-Гэвч та бид хоёрт ярилцах юм байна гээд Лара түгдэрснээ, - Үнэндээ бол бараг амин хувийн сэдэв л дээ. Хүмүүсийн айлгаад байгаа сэргээн засварт зориулж буй хөрөнгө надад хайран биш гэж та бодоод байх шиг байна уу даа? Би тантай нэг нууцыг хуваалцмаар байна, энэ нууц маань энэ өрөөний дөрвөн хананаас гадагш гарах биш дээ. Надад аминаасаа илүү хайрладаг арван настай бяцхан охин бий. Охин маань эцэгтэйгээ шинэ тохилог сууцанд орно гэж найдаж байгаа юмсан гэлээ.

Хатагтай Бенсон хаалганд хүрч амжилгүй тэр дороо зогслоо.

-Би... би таныг охинтой гэж мэдээгүй юм байна.

-Түүний тухай хэн ч мэдэхгүй. Би хэзээ ч гэрлэж байгаагүй л дээ. Охины минь албан ёсны халамжлагч нь түүний эцэг нь байгаа юмаа. Энэ тухай сонин хэвлэлийнхэн шиншилж орхивол... та ойлгож байгаа биз дээ хэмээн Лара өгүүлэв.

-Ойлгож байна.

-Сохор зоосны төлөөнөөс болж би охиндоо ямар нэг муу юм хийхийг хэзээ ч зөвшөөрөхгүй гэдгээ танд батлан хэлмээр байна. Энэ төсөл зөвхөн охинд ммнь төдийгүй түүнтэй

адил мянга мянган охидод баяр  
баясгалан авчрах болно гэж Лара  
хэллээ.

Өрөөнд нам гүм болон, удтал чимээ  
тасрав.

-Танд л гэж хэлэхэд... байдалд одоо  
тэс өөрөөр хандах ёстой боллоо,  
Камерон авхай. Та надад бодох  
хугацаа олгооч! гэж Эдит Бенсон  
өгүүлэв.

-Эргэлзэх юу байхав. Би тун их  
баяртай байна.

Амар тайван амьдардаа охин минь-  
хэрэв надад охин байсан сан бол би

туйлаас тайван байх болно хэмээн  
Лара боджээ.

Гурван долоо хоногийн дараа хотын  
комисс төлөвлөгөө ёсоор уг төслийг  
баталжээ.

-Сайн байна. Одоо хамгийн гол нь  
Филдинг, Бартон хоёрыг төсөлдөө  
татан оруулах хэрэгтэй байна гэж  
Лараг хэлэхэд нь Говард Келлер  
удтал бодож сууснаа,

-Чи сая түүнийг хааш нь ч  
гарахаарүйгээр шахаанд оруулжээ!  
Гэхдээ юун охины тухай яригдаад  
байна аа? хэмээн асуув.

-Ажлын сонирхлын үүднээс тэр дээ, хүү минь. Өөр бусад юмыг бүү мартаарай даа.

-Тэд үнэнийг мэдвэл ч бид балрах бий вий гэж Билл Уайтман өгүүлэв.

Нэг сар гэхэд 63-р гудамжны барилгын ажил өндөрлөжээ. Хүлээж авах комиссын гишүүд дөчин таван давхар орон сууцны цамхагийн бүх давхруудыг нягтлан үзлээ. Дээвэр дээрх арван гурван уужим өрөө тасалгаа, хөл бөмбөгийн талбай шиг саравчит тагт бүхий хоёр давхар пентхаусыг Лара өөртөө зориулан үлдээжээ. Тэрээр шилдэг загвар чимэглэгчээр шинэ байрныхаа

заслыг хийлгэсэн аж. Шинэ байранд орсныг баярыг нь тэмдэглэхээр бараг зуугаад зочид хүрэлцэн ирсэн байв.

-Гэрт цорын ганц юм-эр хун л дутаж байна даа гэж хэн нэгний дагуул эмэгтэй хорсолтойёо өгүүлэх чихийг нь дэлсчээ.

Лара Филипп Адлерийн тухай дурсан, мань эр яг одоо завтай байгаа болов уу? хэмээн бодлоо.

Лара, Уайтманыг өрөөнд нь орж ирэхэд Говард Келлертай бараг цаг шахам нилээн ширүүхэн маргалдчихаад сууж байлаа.



-Мэнд үү. босс оо! Завтай юу? гэж Уайтманыг асуувал Лара буйдангаас босч,

-Говард аа, одоо маргалдахаа больё. Билл ээ, яагаав, асуудал гараа юу? гэв.

-Хайртай эхнэртэй маань холбоотой юм.

-Эр эмийн хооронд илжиг бүү жороол гэдэг байхаа. Гэр бүлийн итгэлийг тэрсэлсэн явдал миний хүрээний асуудал биш шүү гэж Лараг хэлэхэд нь.

-За хаанаас даа, тэс өөр асуудал.

Эхнэр маань, амармаар байна гээд байх юм. Парижийн хаа нэгтээ-ганц хоёр долоо хоног, тэгээд бүр надтай хамт гэнэ шүү хэмээв.

Лара дургүйцэн хөмсөг зангидаж,

-Парижид ий? Ажил гэж хүзүүгээр татчихаад байна шүү дээ! гэлээ. - Мэдэж байнаа. Гэхдээ надад нилээд хэдэн хоногийн нөхөн амралт бий, харин Лилиан бид хоёр сүүлийн үед хамтдаа тун ховор явах болжээ. Тэр өнөө өглөө "Билл ээ, хэрэв чи тушаал ахиж цалин чинь нэмэгдэж байгаа бол надтай хаа нэг тийш удаан хугацаагаар явах ёстой" гэжибайх юм хэмээн Уайтман хэлэв.

Ларагийн нүд нь хмлэнтэйгээр  
гялалзаад ирлээ.

-Жил болж байж л тушаал  
дэвшихийг горьдох хэрэггэй дээ.  
Уайтман мөрөө хавчисхийлгэн,

-Жилийн дараа юу болохыг хэн  
мэдэх вэ? Тэгж байтал Куинстой  
дахиад хэрэг мандвал яах билээ?  
Гэнэт хижээл настай хатагтай Эдит  
Бенсонд ямар нэг сураг дуулдсан  
байвал яах вэ? Эсвэл энэ бүхэн  
хамаагүй хэрэг үү? гэлээ. Лара  
өөрийн эрхгүй биеэ цэхлэн,

-Би чамайг ойлголоо гэв. Билл ч үүд  
рүү алхлав.

-Миний үгийг сайн бодолцоорой,  
босс оо. Би дуртай цагтаа яриагаа  
үргэлжлүүлэхэд бэлэн байна шүү.

Бүсгүй албадан байж инээмсэглэх  
дүр үзүүлэн,

-Өө тэгэлгүй яахав хэмээлээ.

Уайтман гарч одлоо.

-Бурхан минь, энэ чинь юу гээч  
болох нь энэ вэ? гэж Говард  
Келлерийг арай ядан дуугарахад нь  
Лара,

-Далайлган сүрдүүлэг гэдэг юм  
гэжээ.

Маргааш нь Лара. Пол Мартин хоёр "21" клубт хооллож байв.

-Пол оо. би чамтай нэг юм зөвлөх гэсэн юм. Нэг нарийн асуудал... гээд бүсгүй Билл Уайтмантай ярилцсанаа Полд хүүрнэв.

-Мань эрийг тэр хөгшин шуламд үнэхээр хов хүргэнэ гэж чи бодоод байна уу? хэмээн Мартин асуулаа.

-Мэдэхгүй. Хэрэв хов хүргэчихвэл надад төлөвлөлтийн комиссынхонтой чамгүй таагүй явдал учрах гээд байна.

-Чиний оронд байсан бол би тэгтэл

санаа зовохгүйсэн. Уайтман ердөө л бардам амлаж байгаа биз хэмээн Польшыг хэлэхэд Лара санаа алдан,

-Тэгж л найдахаас гэв.

-Рино руу ухасхийх юм биш үү?

-Уучлаарай, бүтэшгүй хэрэг.

-Би чамайг тийш зугтая гээгүй.  
Казино худалдаж ав, эсвэл зочид буудал.

Бүсгүй сэрээгээ тавиад,

-Чи үнэхээр ярьж байна уу? гэж асуув.

-Тэндхийн казиногийн зочдын байрны нэг нь юу юугүй лицензээ хураалгах болсон гэж найз нар маань хэлж байна лээ. Ойлгооч, Рино гэдэг чинь-алтны судал л гэсэн үг. Зочид буудал дөнгөж худалдахыг сонсмогц мянга мянган ажил хэрэгч улс тийшээ ухасхийн хошуурцгаах болно доо. Уул номондоо бол дуудлага худалдаа зохиох ёстой, гэлээ ч миний нэг үйлчлүүлэгч надад туслахаар ам гарсан юм гэж Полыг хэлэхэд Лара шийдэж ядан эргэлзэв.

-Мэдэхгүй юм. Би ч зээлэнд хүлэгдчихээд байна. Банк намайг бүх өрөө дарахгүй бол зээл өгөхгүй гэж Говард хэлсэн.

-Чамд банк явахын хэрэг юу байна?

-Тэгээд хаанаас олох гэж?

-Чи "хогны" тухай таг мартжээ дээ. Уолл-стритэд муу явдлаа далдлах гэсэн өч төчнөөн конторууд санал дэвшүүлнэ. Таалагдаж буй барааныхаа таван хувийг гарга, жаран таван хувийг нь конторын "хог" оор төл, харин дутаад байгаа гучин хувийг чинь тоглоомын бизнест эрхэлдэг ямар ч гадаадын банк өгнө. Швейцар, Герман эсвэл Японы аль нь ч чамд үйлчлэнэ. Тэд үй олноороо зээглэн байгаа.

Бүсгүйн сонирхол нь төрж эхэллээ.



-Сэтгэл татам сонсогдож байх чинь.  
Чи нээрээ надад энэ зочид буудлыг  
худалдаж авч чадах юм уу?

Пол жуумалзан,

-Энэ чамд өгөх Зул сарын баярын  
бэлэг болог гэв.

-Чи ч гайхамшигтай юм! Чи яагаад  
надад ийм сайн байдаг юм бэ  
хэлээч?

-Ухаанд буухгүй нь хэмээн Мартин  
хариуллаа.

Хариулт тун энгийн:

Лара Полын хувьд ихээхэн утга учиртай. Түүнгүйгээр Полын амьдрал хамаг утга учраа алдах юм. Чи бол миний хоёр дахь "би" хэмээн Пол өөртөө хэлжээ.

\* \* \*

Говард Келлер түүнийг өрөөнд нь хүлээж суув.

-Чи хаачихав аа? Хоёр цагт зөвлөлгөөн хийх гээд...

-Говард аа, надад "хог"-ын тухай яриад өгөөч. Бид энэ акцийг хэзээ ч хэрэглэж байгаагүй байх аа? Үнэт цаасыг нь яаж үнэлдэг юм бэ? гэж

Лара асуув.

-За-за... Дээд мөрөнд нь гурван "А" үсгээс бүтсэн индекс байдаг. "АТ ба Т" энэ нь компанийн хэлбэр. Дараа нь АА. А, ВАА гэснээ хамгийн дор нь -2"В". Тэд нар л өнөөх л "хог" шүү дээ. Нилээд акц хадгалагчдаа жилд есөн хувийг өгдөг бол "хог"-арван дөрвийг өгдөг юм. Гэвч зүйрлэхийн эцэсгүй эрсдэлтэй. Чи бас юу сэдчихээд энэ тухай асуугаад байгаа юм бэ? гэж Келлер асуув.

Лара бүгдийг тайлбарлав.

-Казино гэнэ ээ? Казино юу, Лара?  
Энэ бүгдийн цаана Пол Мартин

байгаа биз, тийм биш гэж үү?

-Үгүй. Үүний цаана би байгаа юм. Чи Бэттери-паркийн талаарх бидний саналын хариуг авсан уу? гэж Лара лавлав.

-Авсан. Тэр урмыг чинь хугалах бий.

-Гэхдээ худалдахаар зарлаа биз дээ?

-Жаал жуул юм байна лээ.

-Тойрч булзааруулаад яахав!

-Газар бэлэвсэн хатагтай Элеонор Ройсийн мэдэлд байдаг аж. Тэр газрын төлөө тулаанд өөрсдийгөө

хүндэтгэн үздэг гүйцэтгэгчид  
бүгд оролцож үзсэн.

-Тэдний хэн нь тэгээд биднээс илүү  
үнэ санал болгосон юм бэ? гэж Лара  
асуув.

-Бэлэвсэн хатагтай мөнгийг нулимж  
орхидог нь илт. Тэр эмд мөнгө ус  
далай шиг цалгилж байдаг юм  
билээ.

-Тэр хатагтай тэгээд юу хүсээд  
байгаа юм бэ? -Талийгаач  
нөхрийнхөө дурсгалыг  
мөнхжүүлэхийг хүсч байгаа юм.  
Түүнийгээ Альебрт Швейцар шиг л  
агуу эмч гэж үздэг юм билээ.

Нөхрийнхөө нэрийг дэлхий даяар алдаршуулахыг хүсч, ямар нэг худалдаа наймааны асуудал гарч ирэхээр л айдаст автдаг гэсэн. Стив Мерчисон түүнин хөлд сөгдөх гэж нэг бус удаа оролдсон гэж би сонслоо.

Лара хоёр минут орчим хэр дуугүй сууснаа,

-Говард аа, чи өөрийн эмчтэй биз дээ? гэж асуув.

-Юу гэнээ? Өе, мэдээж байлгүй яахав.

-Хэн гэдэг юм бэ?

-Сеймур Беннет. "Мидтаун"  
эмнэлгийн ерөнхий мэс засалч хүн  
дээ.

Маргааш өглөө нь Сеймур Беннет  
эмчийн үзлэгийн өрөөнд Ларагийн  
хувийн хуульч Терри Хилл орж  
ирлээ.

--Ноён Хилл ээ, нарийн бичгийн  
даргыг хэлснээр та надтай яаралтай  
уулзах хэрэгтэй гэсэн, гэхдээ  
эмнэлэгтээ огг холбоогүй асуудал  
гэсэн байхаа. Таныг сонсож байна.

-Ер нь бол явж явж эмнэлэгтээ  
холбоотой зарим нэг асуудал байна,  
профессор оо. Би тэтгэлэгийн

эмнэлэг байгуулж, түүндээ хандив оруулах групп цуглуулах санал тавьж явна. Бид эмчилгээний зардлаа төлөх чадваргүй хэн бүхэнд туслахыг хүсч байна гэлээ.

-Тун сүрхий буянтай санаа байна. Тэгээд надаас юу шаардаа вэ?

Терри Хилл тайлбарлаж эхэллээ.

Дөнгөж нэг хоног өнгөрөөд байлаа. Агуу хүний бэлэвсэн эхнэрийн зочдын ерөөнд суух Беннет эмч мөнгөн халбагаа цайны тавган дээр үл ялиг харжигнуулан тавьлаа.

-Хатагтай Ройс оо, буян амласан



ариун сэтгэлтнүүд надыг тантай  
холбоо барь гэсэн юмаа. Тэд орчин  
үеийн тохилог клиник эмнэлэг  
барьж түүнийгээ таны талийгаач  
нөхрийн нэрээр нэрлэж, түүний  
дурсгалд зориулагдах юм байна.

Настай эмэгтэйн үрчгэр царайд  
туйлын амарлингуй инээмсэглэл  
тодорч,

-Энэ үнэн үү? хэмээн асуулаа.

Сэтгэл сэргээсэн яриа хагас цаг  
шахам үргэлжилж, зочин эрийг үүд  
хүргэн үдэж өгөх бэлэвсэн эхнэр,

-Жорж минь, тун их баярлана даа,

ноён Беннет ээ. Намайг зөвшөөрч байна гэж найз нартаа уламжлаарай гэжээ.

Хагас жилийн дараа уг газар дээр өргөгч цамхагууд сүндэрлэн босож, барилгын ажил эхэлжээ. Барилга барьж дуусахад уйтгар төрүүлэм бараг нурж унах нь шахсан оромжны суурин дээр гантигаар бүрсэн захиргааны корпус, анхны худалдан авагчаа хүлээн авсан худалдааны төв, үүд хаалгаа нээсэн театраас бүрдсэн бүтэн хороолол босжээ. Энэ бүх гайхам сайхан барилгын арын хашаанд нь неон гэрлээр анивчин гялалзах рекламаас алсхан газар нэг давхар даруухан

барилга босжээ. Уг байшингийн  
үүдэн дэх самбар дээр:

"ЖОРЖ РОЙСЫН НЭРЭМЖИТ  
ЭМНЭЛЭГ" гэсэн хаяг хадсан  
харагдана.

## Арван наймдугаар бүлэг.

Лара Зул сарын баяраа гэртээ тэмдэглэхээр шийджээ. Зочны өрөөний угтвар ширээн дээр хорь шахам урилга хэвтэх авч Пол Мартин ирнэ гэсэн тул тэдний нэгэнд нь хариу өгөөгүй аж.

-Би үдшийг Нина, хүүхдүүдийн хамт өнгөрөөх ёстой, гэсэн ч ганц цагийн ч болов зав гаргаад, заавал ч үгүй очно гэж Мартин хэлжээ.

Филипп Адлер одоо Лондонд байгаа болов уу. Юу хийж байгаа бол? хэмээн Лара бодлогоширов.

Цонхны цаана үзэгдэх өвлийн дүр  
төрх Зул сарын нээлт болсныг  
мэдэгдэх гэсэн мэт агаарт эргэлдэх  
цасан ширхэгүүд дундаас аварга том  
барилгууд үзэгдэх төдий сүүдэгнэж,  
хаа нэгтээ тэртээ дор эл хуль оргих  
гудамд цасан будан манарах ажээ.

Хаалганы хонх уянгалаг дуугаар  
хөгжимдөх мэт дон дон дуугарч  
Лара ухасхийн очиж нээвэл босгон  
дээр баруун гартаа бэлгээр  
дүүргэсэн томоо гэгчийн хайрцаг  
тэвэрсэн Пол зогсож байлаа.

-Үүнийг авах гэж оффис орох хэрэг  
гараад хэмээн уучлал эрсэн өнгөөр  
өгүүлэв.

"Эхнэртээ мэдэгдэхгүй гэж тэр."

-Пол оо, чи намайг үргэлж л эрхлүүлэх юм. Яах гэж тэгдэг юм бэ? хэмээн Лараг хэлбэл,

-Би ингэхийг хүсч байна. Алив нээгээд үзээч гэж Пол хэллээ.

Бүсгүйн царайд баярлан инээмсэглэл тодрохыг үзэх гэсэн Полын хүсэл Ларагийн сэтгэлийг уяруулна.

Түүний зэхсэн бэлэг нь үнэтэйгээс үнэтэй, сайтар бодсон нь илт байлаа. Картьегаас авсан цагаан алтан гинж, яах аргагүй Бриссоны

гар хийцийн хэдэн ширхэг хүзүүний ороолт, ном, Дундад зууны үеийн XIV Людовикийнх уу? Хатан хаан Викториагийн үеийн ч юм уу алин болохыг бүү мэд, эрт цагийн чулуун цаг, бас нэг бага шиг цагаан дугтуй байлаа. Лара дугтуйг задлан зузаан гялгар цаас гарган ирэв. Түүний голд нь шовх хэлбэрийн хазгай готик хэлбэрийн үсгээр:

"Рино. Зочид буудал, казино,  
"Камерон" гэж бичжээ.

-Би Ригод зочид буудлын эзэн боллоо гэж үү? хэмээн Лара гайхан асуув.

-Чи түүний эзэн болно. Дуудлага худалдаа долоо хоногийн дараа явагдана. Чи баярлах болно гэдгийг би батлаж байна гээд Пол инээмсэглэв.

-Казиног яах вэ? Би чинь ямар ч туршлагагүй шүү дээ.

-Чамд туршлага байхын хэрэггүй. Би казиног удирдах мэргэжлийн хүн олно. Зочид буудлыг бол чи өөрөө дөнгөх юм хойно доо.

-Юу гэж хэлэхээ ч мэдэхгүй ив. Чи миний төлөө ихийг хийлээ!

Мартин түүний гарыг энхрийлэн



атгаад,

-Бага байна, тун бага. Энэ дэлхий дээр чамд бэлэглэчих юм олдохгүй юм. Үүнийг минь санаж яваарай.

-Үргэлж санаж явна хэмээн Лара тангараг мэт жавхлантайяа өгүүлэв.

Пол цагаа хяламхийн харж.

-Харилгүй болохгүй нь. Би ч...

-Юу гэв?

-За зүгээр дээ. Зул сарын мэнд хүргэе, Лара!

-Зул сарын мэнд. Пол оо...

Бүсгүй цонх руу очлоо. Тэнгэр тэр чигээрээ үл нэвтрэх цагаан хөшгөөр хучигджээ. Нэг л далдын бүрхэг түгшүүр төрөн Лара хүлээн авагчаа залгалаа. Тэртээ холын холоос хаа нэгтээгээс нэвтрүүлэгчийн: "...манай баярын хөтөлбөрт: Бостоны симфони найрал хөгжимчид оролцож байна. Бетховен. Төгөлдөр хуурын Тавдугаар концерт. Төгөлдөр хуурч-Филипп Адлер" хэмээн зарлах сонсогдов.

Гайхамшигтай хөгжмийг сонсох Лара түүний чичигнэх урт нарийн хуруу нь товчлуур дээгүүр хэрхэн гүйхийг нь санаандаа ургуулан үзэж суулаа. Аялгуу тоглож дууслаа.

Бид уулзах ёстой. гэж бүсгүй бодлоо.

\* \* \*

Билл Уайтман ажил хэрэг дээрээ дээгүүр ангиллын мэргэжилтэнд тооцогддог ажээ. Албан тушаалын бүх шат дамжлагаар явсаар жирийн нэг ажилчнаас дээд тушаалын удирдагч болтлоо дэвшсэн тэрээр ихээхэн эрэлт хэрэгцээтэй нэгэн байлаа. Ажил үйл нь Биллд баяр баясгалан авчирч. мань эр муугүй цалин хүртдэгч яваа яваандаа илүүд санаархах болжээ. Жил ирэх тутам найз нөхөд нь бэл чинээтэй болсон байхыг ажигласан мань мэргэжилтэн эр ердөө л цалин

хөлсөндөө сэтгал хангалуун явсаар  
үлдсэн байв.

"Хэрэв зээ харалган л юм биш бол эд  
нар миний ачаар л элбэг дэлбэг  
хангалуун амьдралд умбаж  
байгаага мэдэх ёстойсон. Эзэн  
авгай бялуугаа идэж, надад хатсан  
талхны үртсээ чулуудаж байх шив"  
хэмээн Билл боджээ.

Лара, Эдит Бенсонтой уулзсан тэр  
нэгэн өдрөөс хойш байдал  
өөрчлөгдлөө. Муу юм модон улаатай  
гэгчээр Ларагийн залилан мэхэлсэн  
хуурмаг явдал нь хүзүүг нь ороож  
сүйрүүлж дөнгөх байв. Нутгийн  
захиргааныхан үнэнийг мэдвэл

Камерон авхай бизнесээсээ хагацах болно.

Гэвч Билл Уайтман эрхэм түшээдэд хэргийн үнэн учрыг нээхийг нэг ч их яарсангүй. Түүний толгойд илүү нарийн хорон төлөвлөгөө боловсорчээ. Босс авгайнхаа залиг яагаад гөнжүүр болгон ашиглаж болохгүй байх билээ? Камерон авхай Биллд хүссэн болгоныг нь, бүгдийг өгөх болно. Тушаал ахиж, цалин нэмэх тухай босс авхайдаа дурссаны хойно Уайтман хувь заяа нь өөрөө боломжийг олгох болно гэдгийг ойлгожээ. "Чөтгөр ав гэж, Ларад өөр сонголт үгүй болсон. Барьцаа багаас нь эхлэн аажим

ахиулна даа."

Зул сарын баяраас хойш хоёр хоногийн дараа "Ист-Сайд" төслийн ажил эхэллээ. Билл Уайтман барилгын аварга том талбайг харцаараа гүйлгэн ширтэн зогсох зуур: "Тийм ээ, эндээс жинхэнэ мөнгөний үнэр ханхалж байна, энэ удаад аманд орсон шар тосыг хэлээрээ түлхэнэ гэж гонжнийн жоо доо!" гэж боджээ.

Бульдозерууд залхуутайяа газар тэгшлэн, хүнд даацын ачааны машинууд ар араасаа цувран хаалгаар орж ирцгээнэ. Гэтэл нэг экскаваторын бутлуурын сум нь

агаарт дүүжигнэн сул зогсож байх нь тэр. Уайтман эксковаторын жолоочийг чиглэн дөхөж очуутаа дүүрэн шороо хутгасан шанаган дор зогсон,

-Хөөе, Жесси, юугаа хнйгээд байгаа юм бэ? гэж хашгирав.

Жолооны хөшүүрэгтэйгээ ноцолдох залуу хариуд нь товчхон үг хэлсэн авч Билл түүний хэлсэн үгийг нь ойлгосонгүй,

-Юу, юу гэнээ? хэмээн хариу хашгирав.

Бүх юм нүд ирмэхийи зуур болж

өнгөрлөө. Ган тросс тас үсэрч, аварга том шанага Уайтманыг газарт шигтгэн эгц дээрээс нь даран унах нь тэр. Хүмүүс осолын газар тийш тал талаас ухасхийцгээсэн боловч нэгэнт оройтсон байлаа.

-Хүрд гацаад, Бурхан минь, яагаад ийм юм болчихов оо? Би Биллд хичнээн хайртай гээч хэмээн жолооч эр хожим нь техникийн аюулгүй албаны комиссынхонд гомдоллон тайлагнажээ.

Лара золгүй явдлыг мэдсэн даруйдаа Пол Мартинд утасдан,

-Чи Биллийн тухай дуулсан уу? гэж



асуув.

-Сонссон. Мэдээгээр явж байна лээ.

-Пол оо, чи...

-Энэ тухай март! Хүний ул шагайсан олхиогүй амьтан яадгийг хараа биз. Эцсийн эцэст шударга ёс үргэлж ялах тавилантай байдгийг санаж ав хэмээн Полын хариулах сонсдов.

Лара харилцуур тавин: "Тэгэхээр шударга ёс миний талд байгаа хэрэг үү?" хэмээн бодлоо.

"Рино" зочид буудлын дуудлагын худалдаа нь хэдэн арван хүчирхэг

худалдан авагчдын дурыг нь  
гозолзуулан сорнирхолыг нь татжээ.

-Би хэзээ үнийн саналаа хэлэх вэ?  
гэж Лара Мартинаас асуувал цаадах  
нь,

-Чи юу ч хийхийн хэрэггүй. Яадаг ч  
болтугай намайг хэлтэл хүлээзнэ.  
Бусад нь үймэлдэж л байг гэжээ.

Дуудлага худалдаанд оролцогчдын  
битүүмжилсэн дугтуйг ирэх тав  
дахьд нээхийг хүртэл хүлээх хэрэгтэй  
болов. Лхагва гариг болсон хэдий ч  
зохион байгуулах хороо Ларагаас  
ямар нэг санал хүлээж аваагүй  
хэвээр байлаа. Сандарч мэгдсэн

Лара Пол Мартин руу утасдвал,

-Тайван байж бай. Эрт байна хэмээн лүндэгнэх нь тэр.

Үнийн санал хураалтыг таслахаас цагийн өмнө Ларагийн утас амь орсон мэт хангинан дуугарлаа.

-Цаг боллоо! Хамгийн дээд санал хорин сая хүрээд байна. Чи таван саяар өсгөөд өг гэж Полыг ярихад Ларагийн амьсгаа нь давхцаад иржээ.

-Тэгэх юм бол би чинь сохор зоос ч үгүй халаасаа гүвж гүйцэх нь байна шүү дээ!

-Надад итгэ! гэх Полын дуунд итгэл төгс байдал тодорч,

-Зочид буудал чинийх болно.

Хамгийн гол нь сэргээн засварлах ажилаа эхлэх хэрэгтэй. Энэ таван саяыг зовлонгүй нөхчих мэдлэгтэй хүн олж нягтлангаар тавьчих гэжээ.

Дуудлагын худалдааны дүн нэг өдрийн дараа гарч Лара Камерон ялагчаар тодорчээ.

Хоёр өдрийн дараа Лара, Говард Келлер хоёр Рино орохоор мордлоо.

Зочид буудал "Рнно-Палас" нэртэй

хэвээр байв. Нэгдүгээр давхарыг тэр чигт нь казино эзэгнэж, таван зуугаад өрөө бүхий тансаг буудал байлаа. Өөрийгөө Тони Уилки хэмээн танилцуусан нэгэн эр Лара, Говард хоёрыг казиногийн танхим тийш дагуулан оров.

-Эндхийн хуучин эзнийг нь нилээн мэхэлсэн дээ гэж тэрээр явуут дундаа хэллээ.

-Яаж тэр вэ? хэмээн Келлерийг сонирхвол.

-Дам сургаар хэдэн залуус байнга мөнгөний хайрцаг руу нь савраа...

-Өөрөөр хэлбэл хулгайлдаг байжээ?

-За тийм дээ. Казиногийн эзэн энэ тухайд ер сэжиглээгүй. -Тэгнэ дээ.

-Хэн нэг нь газар дээрээ баригдсан гэсэн, Мөрийтэй тоглоомын комиссын шалгалтынхан гэнэт орж ирж, зальт ажиллагаа илэрсэн юм. Хөөрхий, харамсмаар явдал болсон шүү. Зоосон мөнгө гол шиг л урссан гэнэ лээ.

-Үүнийг чинь дуулсан гэж санхүүгийн баримтыг нямбай судалсан Говард өгүүлэв.

Үзэж дуусаад тэд хоёулхнаа үлдсэн

хойно Лара,

-Полын зөв байж. Энэ чинь жинхэнэ алтны судал юм байна гэхэд Келлерийн уруул дээгүүр сэжиглэсэн янэын инээмсэглэл тодрохыг анзаарсан Лара,

-За, бас юу болчихов? гэлээ.

-Нэг л ойд буухгүй байна, уучлварай. Иймэрхүү заль мэхтэнтэй зам нийлэхгүй нь дээ.

-Ямар заль мэх вэ? Бид чинь сайн үүлдрийн саалийн үнээтэй болж байна шүү дээ гэж Лараг гайхахад нь тэрээр,

-Хэн тэгээд саалийн үнээг чинь хариулах болж байна даа? гэж асуув.

-Хүмүүс олдоноо.

-Хаанаас тэр вэ? Бойскаутаас уу? Энд туршлагатай мөрийтэй тоглоомч хэрэгтэй. Миний танилуудын дунд тийм хүн байхгүй дэг. Чамд байгаа юм уу? хэмээн Келлерийг асуухад бүсгүй дуугарсангүй. -Чи Полд найдаж байгаа хэмээн мөрийцөхөд ч бэлэн байна. -Полыг зөнгөөр нь орхи гэж хүсэх байна хэмээн Лара эсэргүүцэв. -Дуртайяа зөвшөөрье. Чамд ч гэсэн зөнгөөрөө явахыг зөвлөе? Энэ санаа чинь надад



бахдалтай санагдахгүй л байна даа.

-Куинсын тухай юу гэж хэлснээ эргээд нэг санаач. Хьюстон гудамждахь худалдааны төвийн тухай тэр шүү. Ганц үг үсэг орхилгүй сана даа! Гэтэл тэд ашиг өгч байна уу, үгүй юу?

-Лара, би чиний гэрээ хэлцлүүдийн шударга ариунд хэзээ ч эргэлзэн шүүмжилж байгаагүй ээ. Саваагүй нохой саранд хуцнагэгчээр чи заримдаа дэндүү ихэд санаархан зүтгэх шиг надад санагдах

юм. Одоохондоо дургүйцэж байгаа ч гэлээ хэзээ нэгэн цагт бүхий л өнгөрсөн зам мөрөө эргэж харах цаг

нь ирэх бий вий.

Лара Келлерийн хацрыг энхрийлэн  
илээд,

-Тайвширч үз дээ гэв.

Мөрийтэй тоглоомын комиссын  
гишүүд Ларатай чухамдаа л  
жентельмен эрсийн эелдэг  
хүндэтгэлээр хандан уулзлаа.

-Залуу, үзэсгэлэнтэй авхайтай нүүр  
тулан уулзах завшаан бидэнд  
өдрийн од шиг тун ховор тохиодог  
юмсан хэмээн дарга эр бусдыгаа  
төлөөлөн наалинхай өгүүлснээ,

- Таминь ээ. хараач, тэнгэрийн нар хүртэл хурц гэрэлтэж байх юм! гэж хошигнов.

Үнэндээ Лара егүүлшгүй үзэсгэлэнтэй харагдаж байлаа. Тэр Донн Кэроны хийцийи цайвар саарал өнгийн нимгэн ноосон костюм, цэрд шиг цав цагаан цамц өмсөн, Пол Мартины бэлэглэсэн хүзүүний ганган нь дэндсэн торгомсог ороолтуудын нэгээр гоёжээ.

Бүсгүй инээмсэглэн талархаж,

-Баярлалаа гэв.

-Бид таны төлөө юу хийж болох

байна? гэх тэд бүсгүйн тусын тулд юу хийхээ юунаас ч илүү сайн мэдэх атлаа ийнхүү асуух нь илт өдсөн янзтай сонсдов,

-Би энэ хотод Невадагаас дөнгүүр эрхэмсэг зочид буудал барих зорилгоор Ринопод ирээд байна. Би байгаа барилгын дээр нь нэмж таван давхар барина, харин хажууд нь мянга мянган жуулчид дуртайяа хөлхөлдөн зугаацах төв нээнэ гэлээ.

Комиссын гишүүд харц солилцоод, эцэст нь тэдний дарга эр,

-Таны санаа хотын иргэдийн чинээлэг амьдралд ихээхэн тус

болно гэж бодож байна. Комиссын гол зорилго бол хуулийн бүрэн хүрээнд ажиллахад хяналт тавих ёстой гэв.

-Ноёд оо, намайг торны цаана жиргэж суухыг хүсэхгүй хүн гэдэгт итгээрэй хэмээн Лара эрс хариулав.

Бөглүүт дуугаар инээх сонсдов.

-Камерон авхай, таны алдар хүнд олноо шагшин магтагддаг гэдгийг бид мэднэ. Гэвч танд казино эрхлэх туршлага үгүй болов уу гэж эмээх юм.

-Тэр үнэн. Нөгөө талаас нь ажилд

тохирох зэгсэн шударга мэргэшсэн,  
мэдээж комиссынхны сайшаал  
хүртэх хүн олоход тийм бэрх гэж үү?  
Эрхэм жентельменүүд ээ, Би та  
бүхний зөвлөгөөг хүлээж авахад  
бэлэн байна.

Буурал үстэй нэгэн хөгшин  
суудлаасаа өндийн.

-Та батлан даалт өгч, санхүүгийн  
хүрээнд... гэсээр эхэлтэл дарга эр  
түүний яриаг нь гүйцээлгэсэнгүй,

-Том оо, энэ тал дээр бүх юм ном  
ёсоороо. Камерон авхай бидэнд  
шаардлагатай бичиг цаасыг  
явуулсан. Би чамд хуулбарыг өгүүлэх

талаар анхааръя гэв.

Лара тэвчээртэйгээр хүлээнэ.

-Яг одоо шууд бэлэн хэлж чадашгүй  
нь, Камерон авхай хэмээн тэрээр  
Ларад хандан хэлээд,

-Гэвч лиценз авахад ямар нэг  
асуудал үүсэхгүй гэж бодож байна  
гэлээ.

-Тун их найдаж байна, эрхэм ээ. Би  
гар хумхин суухыг тэвчдэггүй юм гэж  
Лара хариулав.

Дарга эр хөмсөг өргөн,

-Авхай, манай энд ажил албыг алгуур хийж заншсан юм. Танд албан ёсны хариуг сарын дараа өгнө гэхэд нь,

-Сар ий? гэж урам хугарсан Лара гайхав.

-Тиймээ. Нэг сар. Бүгдийг хянаж шалгахад бидэнд хугацаа хэрэгтэй байдаг юм.

-Ойлгож байна. За за, тэгье.

Зочид буудлын хүлээлгийн танхимын урт гудмаар бэлэг дурсгалын мухлаг, жижигхэн дэлгүүрүүд ярайжээ. Шилэн бүхээгний цаана хөгжмийн



хорхойтнуудад зориулсан зүсэн  
зүйлийн юмс дотроос Филипп  
Адлерын суулийн лазер дискны зар  
сурталчилсан зарлал байхыг Лара  
олж харав.

Дуу хөгжим урьдын адил Ларагийн  
сэтгэлийг эс хөдөлгөсөн хэвээр байх  
ажээ. Гэвч Лара ямартаа ч болов  
нүүрэн дээрээ Филипп Адлерийн  
инээмсэглэсэн зураг бүхий дискийг  
худалдан авчээ. Нью-Йорк орох зам  
зууртаа Лара,

-Говард аа, чи Филип Адлерын  
тухай мэдэх үү? гэж асуув. -Бусдын л  
адил даа. Одоогоор түүнийг дэлхийн  
тэргүүн төгөлдөр хуурч гэж тооцож

байгаа юм. Адлерыг шилдэг симфони найрал хөгжмийг дагалдаж байгаа. Би хаанаас ч билээ дээ, түүнийг залуу авьяас билэгтнүүдэд тусгай фонд байгуулсан гэж уншсан юм байна хэмээн тэрээр хариулав.

-Фондын нэрийг мэдэх үү?

-Миний санаж байгаагаар "Филипп Адлер-фонд" гэсэн байх аа.

-Тэдэнд миний нэрийн өмнөөс арван мянган долларын чек явуулаарай.

Келлер гайхсан харцаар Лараг цоо ширтэж,

-Лара, чи хөгжим огт сонирхдоггүй юм шиг надад санагддаг юмсан

-Сонирхож эхлээд байна.

Сонингийн нүүрэн дээр:

" ТОЙРГИЙН ПРОКУРОР ПОЛ  
МАРТИНЫ ТУХАЙ:

ӨМГӨӨЛӨГЧ МАФИТАЙ  
ХОЛБООТОЙ"

гэсэн гарчигтай цөөн хэдэн үгтэй  
нийтлэл бичсэн байлаа.

Лара нийтлэлийгуншаадтэр даруй  
Пол руу утасдан,

-Юу болоод байнаа? гэж асуув.

Мартин эс тоомсорлон "хм" гэж хамраа дуугарч,

-Мань эр дахиад чөтгөр шулмын анд гарах гэж буйгаа зарлахаар шийдсэн бололтой. Прокурорын газраас миний нэр төрийг гутаах гэж хэдэн жил оролдож байгаа нь гэм биш зан болчихсон юм. Сонгууль дөхөөд ирэхлээр тэд арвынхаа арыг барж зүтгэцгээгээд, эцэст нь толгой руутаа шаацгаах хэрэг гардаг юм. Бүү тоо, охин минь гэв.

-Оройн хоол цугтаа идэх үү?.

-Тэгэлгүй яахав.

-Мулбери-стритэд бидэнд хэн ч саад болохооргүй нэг газар бий.

Хооллож суух зуур,

-Мөрийтэй тоглоомын комиссын гишүүдтэй уулзсан уулзалт чинь амжилттай болсон уу? гэж Пол асуулаа.

-Амжилттай гэж бодож байна. Хэдийгээр энэ бизнест дөргүй ч гэлээ надад тун элэгсэг хандсан шүү.

-Чамд дөртэй байхын хэрэг ч байхгүй. Би казиногийн ажилд

чадалтай залуу авна. Хуучин эзэн нь шунаг сэтгэлээсээ болоод л ухаанаа алдсан юм билээ гэснээ Мартин ярианы сэдвээ өөрчлөн,

-Барилгын ажил чинь ямаршуу байна даа? гэв.

-Гайхалтай сайн байгаа. Би гурван төсөл дээр ажиллаж банна.

-Лара, чамайг ядартлаа ажиллаагүй гэж найдаж болно биз?

"Келлер ч гэсэн яг ингэж хэлж байсан сан".

-Би ядраагүй ээ. Бүх юм хуваарь

ёсоор төсвийн дагуу явагдаж байгаа.

-За яамай даа. Чамд ямар нэг бэрхшээл төвөг учрахыг би хүсэхгүйсэн.

-Төвөг учрахгүй ээ гээд Лара гарыг нь атгаж,

-Миний өмнө чи гэсэн даатгалын сүлжээ бий шүү дээ гэхэд нь,

-Надад итгэж болно хэмээн Мартин хариулав.

Хоёр долоо хоногийн туршид Филипп Адлерээс сураг чимээгүй өнгөрлөө. Лара Келлерыг өрөөндөө

дуудан,

-Говард аа, чи чек явуулсан уу? гэж асуухад нь тэрээр,

-Явуулсан. Тэр өдөрт нь явуулсан гэлээ.

-Хачин юм даа. Тэр утасдмаар юм гэж гайхширсан Лараг өгүүлэхэд Келлер мөрөө хавчисхийлгэн,

-Магадгүй тоглолтоор яваа байлгүй гэлээ.

-Тийм ч байхаа даа гээд Лара урам хугарснаа далдлах гэхдээ,



-Куинсын ажил ямар шүү байна? гэж асуув.

-Төсөлд урьдаас тааж боломгүй зардал гарах бий гэж эмээх байна гэж сэтгэл зовсон Келлер хариуллаа.

-Нэг найдвартай түрээслэгчтэй гэрээ хиймээр байна.

-Тэр чинь хэн гэгч вэ?

-"Мьючуэл иншуранс" гэдэг даатгалын компани. Ерөнхийлөгчийг нь Хорэс Гутман гэдэг юм. Мань эр шинэ ажлын байр хайж байгаа гэнэ лээ. Манай барилга санаад нь нийцнэ гтж бодож байна хэмээн

Лара өгүүлэв.

-Би асууж лавлахад бэлэн байна.

Ярилцагч эр нь дэвтэрт тэмдэглэл хөтлөхгүй байхыг анзаарсан Лара,

-Говард аа, чи намайг хачирхуулж байна шүү. Өчүүхэн төдий зүйл бүхэн чиний толгойд тогтож үлдэх үү дээ? гэвэл,

-Босс оо, би чинь гэрэл зургийн хальс шиг л ой санамжтай шүү дээ гээд Келлер жуумалзан,

-Бэйсбол тоглож байсан үеэс л тэр шүү хэмээгээд: "Тэр цагаас хойш

хичнээн ч жил өнгөрөө вэ.

"Чикагокобс"-ын гийж явсан од,  
хөгжөөн дэмжигчдийн итгэл  
найдвар..." гэж бодсоноо,

-Заримдаа энэ маань хараал идэм  
заналтай санагдаж, гэрэл зургийн  
хальсанд буусан мэт зарим нэг  
зүйлийг мартагнахыг их хүсэх юм  
даа гэлээ.

-Архитекторчтай ярь, тэд ажилдаа  
орцгоог. "Мьючуэл иншуранс"-т  
хэдий хэрийн талбай хэрэгтэйг  
мэдээдэх.

Хоёр хоногийн дараа Келлер түүний  
өрөөнд дахин орж ирээд, -Лара,

чамд дуулгах муу мэдээтэй ирлээ гэв. -За хэлээдэх.

-Жаал жуул мэдээлэл цуглууллаа. "Мьючуэл иншуранс"-ын тухайд чиний зөв байжээ. Тэд үнэхээр шинэ барилга авах санаатай байгаа, гэхдээ Гутман Юнионсквер тийш байн байн шогшоод байгаа гэнэ. Тэнд манай хуучин анд Стив Мерчисоны контор байрладаг юм хэмээн Говард босс авхайдаа тайлагнав.

"Дахиад л Мерчисон! Үгүй дээ, тэр намайг сурдүүлнэ гэж санаж байгаа бол санасны гарз байлгүй!" хэмээн бодсон Лара чухамдаа тэр л булшны

шороо илгээснээс гарцаагүй гэдэгт итгэлтэй байлаа.

-Гутман гэрээгээ байгуулчихаж уу?

- Одоохондоо үгүй.

- За яахав, энэ талаар би өөрөө хөөцөлдье!

Үдийн цайнаас хойш Лара ийш тийш залгасны эцэст түүнийг аз дайрчээ.

Барбара Росуэлл харилцуур аван,

-Хорэс Гутманыг уу? Танилгүй яахав. Тэр чамд юунд хэрэг болоо вэ гэж асуув.

-Би түүнтэй уулзмаар байна.

Барбара, чи надад тус болооч. Ирэх хагас сайнд түүнийг оройн хоолонд уриач, тэгэх үү? гэсэнд,

- Түүнийг урьсанд тооцчих хэмээн найз бүсгүй нь хэлжээ.

Оройн зоог энгийн атлаа тун ч тансаг боллоо. Росуэллын харшид арван дөрвөн хүнд зориулан ширээ засчээ. Хэдийгээр Хорес Гутманы эхнэр Алис Гутманы бие барагтай байгаа ч гэлээ Хорес Гутман өөрөө ирсэн байв. Лараг түүний дэргэд суулгахаар зохижуулсан байлаа. Хорес Гутман саяхан жаран нас хүрсэн атлаа наснаасаа илүү овортой, үрчлээс

бүхий ширүүн царай, зөрүүд маягийн эрүүтэй нэгэн ажээ. Лара сэтгэл татах хамаг л илбэ жилбээ гаргахаар шийдсэн бололтой, хар торгон үдшийн даашинзных нь ар нуруу тэр чигтээ нүцгэрч, хүзүүгээ сувдан сондороор чимсэн нь зохисон гэдэг ванлий, цаанаа нэг донжтой харагдана.

-Тантай танплцахсан гэж би эртнээс мөрөөсөж явлаа. Таны тухай их ярих юм! гэж Лара үнэнээ өчсөнд.

-Би ч бас таны тухай ихийг сонссон шүү, авхай. Таны хөдөлмөрийн үрээр хотын нүүр царай үнэхээр өөрчлөгдсөн шүү гэв.

-Чадах бүхнээ л хийж байна. Хот үүнийг хүртэх ёстой хэмээн Лара даруухнаар хариулав.

-Нууц биш бол, та хаанахын вэ?

-Индианы Гэригийнх гэж Лара хэнэг ч үгүй хэллээ.

-Хөөх тийм үү? гээд Гутман бүсгүйг гэнэт сонжсон янзтай ширтсэнээ,

-Энэ чинь манай хот шүү дээ! Та ч бас манай Индиан мужийн хужеруудын нэг байх нээ хэмээн Гутман дуу алдав.

Лара инээмсэглэн,



-Тийм ээ, Бурхан минь гэж яасан сайхан дурсамж вэ! Аав маань "Пост трибюн"-д ажиллаж, би Рузвельтийн нэрэмжит сургуульд явж байж билээ. Бид амралтын өдрөөр Глисон цэцэрлэгт хүрээлэнд очиж, ил гал дээр мах шарж иддэгсэн. Би бас боулингийг их сонирхож байлаа шүү дээ. Арван хоёр, Хорьдугаар гудамжны уулзвар дахь заалыг та мэдэх үү? Би тэндээсээ нүүх дургүй байсан сан.

-Гэвч та энд тун ихийг бүтээсэн шүү, Камерон авхай.

-Лара гэдэг юмаа.

-Тийм ээ, Лара. Танд дахиад бодож боловсруулж байгаа агуу төлөвлөгөө бий юу?

-Яг одоо Куинсэд 200 мянган квадрат фут ашигтай талбай бүхий 30 давхар барилгын тун чухал төсөл дээр ажиллаж байна.

-Тийм үү? гэж Гутман бодол болон дуу нь тасарлаа.

-Хөөе та яав? Ямар нэгэн болохгүй юм байна уу? гэж Лара гэмгүй царайлан асуухад нь эрхэм Гутман,

-Үгүй-үгүй. Зүгээр бид хоёр долоо хоног шахуу тиймэрхүү ажлын байр

хайж байгаа юм гэлээ.

-Нээрэн үү? Тэгээд олсон уу?

-Арай олоогүй, гэсэн ч...

-Та манай зураг төслийг нь үзэхгүй юу? Бэлэн болсон байгаа шүү.

Гутман нүдээ анивчин байж,

-Үзвэл зүгээрсэн гэлээ.

-Танд аваад очиж болно шүү дээ. Даваа гаригийн өглөө гэвэл ямар байна? гэж Лара барьцаа лавшруулан асуулаа.

-Таныг хүлээж байя.

Тогооч Барбара Росуэллийн ур  
чадвар зочдынхоо сэтгэл ихэд  
нийцжээ.

Хорэс Гутман гэртээ эргэж ирээд  
эхнэрийнхээ унтлагын өрөөнл орж,

-Хонгор минь, бие чинь яаж байна?  
гэхэд нь,

-Баярлалаа, хайрт минь. Арай  
дээрдэж байна. Барбарагийн  
үдшийг аятай өнгөрөөв үү? гэж эхнэр  
нь асуув.

Гутман орны ирмэг дээр сандайлан  
суугаад,

-Аятай байлаа. Мэдээж, тэнд чи минь үгүйлэгдэж байсан шүү, гэхдээ би үнэнийг хэлэхэд сэтгэл хангалуун үлдсэн. Чи Лара Камероны тухай дуулсан уу?

-Сонсолгүй яахав, түүний тухай сонсоогүй хэн байхав.

-Хачин эмэггэй юмаа. Ойлгомжгүй гэдэг нь. Над шиг Гэрид төрсөн гэж хэлсэн. Хотын тухай бүгдийг нь Глисон цэцэрлэгт хүрээлэн, Арван хоёр, Хорь дугаар уулзвар дахь боулингийн тухай бүгдийг мэдэж байна лээ.

-Тэгээд юу нь ойлгомжгүй байна

гэж? хэмээн эхнэр нь гайхан  
лавлахад Гутман жуумалзан,

-Энэ цовоо хүүхэн чинь Глэй-Бэйд  
мэндэлсэн юм шүү дээ гэжээ. Даваа  
гаригийн өглөө хуйлаастай калькан  
цаас сугавчилсан Лара

Хорэс Гутманы хүлээлгийн өрөөнд  
орж ирэхэд нарийн бичгийн дарга  
нь найр тавин үүд нээж өглөө.

-Тантай уулзсандаа баяртай байна,  
Лара. Суугаач. Лара түүний өмнө  
калькаа дэлгээд сандал суун, Хорэс  
гуай, юуны өмнө таныг зурагтай  
танилцахаас өмнө үнэнээ хэлэхийг  
минь сонсооч гэв.

Гутман бу йдангаа гэдрэг налан,

-За юу гэв? хэмээв.

-Энэ Гэригийн тухай түүх...

-Гэри юу болоов?

-Би амьдралдаа ганц ч удаа  
Индианд очоогүй. Ердөө л танд  
сэтгэгдэл төрүүлийг хүссэндээ  
зохиож ярьсан юм гэж Лара хэлэхэд  
нь, Хижээл насны женгельмен эр  
тачигнатал хөхөрч, -Авхай, таны  
цайлган сэтгэл намайг татгалзах  
аргагүй болгож орхилоо. Заль  
мэхээрээ би таныг гүйцэхгүй нь  
боллолтой. За-за! Сайн байна, алив

үзье. Та юу авчраа вэ? гэжээ, Хагас цаг шахуу зургийг судалсны эцэст Хорэс Гутман толгой өндийн урам орсон янзтай,

-Ер нь би байна шүү. өөр газар сонгосон байснаа болилоо гэв.

-Бүр... үү?

-Харин танайх ямар илүү болзол тааих юм бэ дээ?

-Та тэнд жинхэнэ аз жаргалын мэдрэнэ дээ. "Мыочуэл иншуранс"-ыг хүссэн болгонооээдлэх талаар би биечлэн хянах болно. Та арван хувийн хямд шинэ ажлын байртай



болно гээд Лара учиртайхан  
инээмсэглэв.

-Хөөе! гэхдээ бусад газар надаас  
хэдийг нэхэж байгааг та  
мэдэхгүй шүү дээ.

-Тэр хамаагүй ээ. Та дурын тоогоо  
хэл л дээ.

-За Лара, та ч үнэндээ Гэрид төрсөн  
байж болмоор овтой юм.

Тохирлоо!

Лара оффистоо эргэж ирээд ширзэн  
дээрээсээ Кэтигийн үлдээсэн:

"Филипп Адлер ярьсан" гэсэн  
зурвасыг олжээ.

## Арван есдүгээр бүлэг.

"Уолдорф-Астори"-ийн сүр жавхлантай үүдэн танхим "Карнеги-холл" концертоос ганцыг ч алгасдаггүй хөгжмийн хорхойтнуудаар пиг дүүрчээ. Хүмүүсийн дундуур зүтгэн явах Лара. Филипп Адлерыг харцаараа эрнэ.

Гурав хоногийн өмнө болсон утасны яриа бүсгүйн чихэнд сонсогдсон хэвээр.

-Камерон авхай. Филипп Адлер байна.

Ларагийн ам нь гэнэт хуурайшин

аргаад явчихжээ.

-Тэр даруйд нь талархаж чадаагүйг минь өршөөгөөрэй. Би Европод явж байлаа л даа. Тэгээд таны өгөөмөр бэлгийн тухай өноөдөр л дууллаа.

-Би сэтгэлийн ханамж эдлэхийг хүссэн юм. Хамгийн гол нь тэр битгий харилцуураа чулуудчихааеай.

-Надад... Үнэнийг хэлэхэд танай фондын тухай арай тодорхой мэдэхийг дуртайяа хүсэх байна. Яагаад бид уулзаж, ярилцаж болохгүй байх вэ? гэж Лара дуржигнуулав.

Утасны нөгөө үзүүрт удтал чимээ

тасарав.

-Хагас сайнд "Уолдорф-Астори"-д өглөөгийн цэнгүүн болно. Та завтай юу? гэж Филиппийн хэлэхэд Лара ажлын хуанли руугаа харц чулуудав. Хагас сайны орой Техасын банкны эзэнтэй оройн зоог барих ажээ.

-Завтай гэж бүсгүй бодож түгдэрэлгүй хариулав.

-Сайн байна! Танд тасалбар явууламз.

Филипп Адлер хаа ч үзэгдсэнгүй.

Лара цугларагсдын дундуур аажим

явах зуураа хумүүсийн ярихыг  
сонсоно.

-... тэгээд цээл хоолойт дуучин:  
"Доктор Клемперер оо, би дээд хоёр  
си өнгийг гаргах л үлдээд байна. Та  
одоо сонсох уу эсвэл орой болохыг  
хүлээх үү?"

-... тийм шүү, мэдээж удирдаачийн  
дохиур бүгдийг шийднэ. Ямар яруу  
сайхан гээч!

-... солиороо юу? Стравинский  
дэндүү ойлгомжгүй! Түүний  
хөгжмийг робот л бичиж чадах  
байлгүй. Сэтгэл хөдлөм мэдрэмж нь  
хаа байна? Ветерийн хөгжмийн

зохиолч Барток бол ч харин  
эсрэгээр, биднийг жинхэнэ сэтгэл  
хөдлөлийн далайд...

-... тэр бүсгүй ердөө л товчлуураа л  
балбахаас өөрцгүй. Түүний Шопеныг  
тоглож байгаа нь яг л аяны марш  
шиг л...

Эдгээр ярианаас Лара юу ч  
ойлгосонгүй алмайран явж байтал  
Адлер харагдах нь тэр ээ.

Филипп шүтэн бишрэгчдээрээ  
хүрээлүүлэн зогсож байлаа.

Төгөлдөр хуурчийн ард зогсох нэгэн  
бүсгүй,

-Таныг до минорын сонатыг тоглож байхад Рахманинов инээж байхыг нь би харсаан. Үнэн шүү! Энэ намуухан шилжих... гэж итгэлтэйгээр өгүүлэхэд Филипп инээмсэглэн,

-Танд баярлалаа хэмээв.

Хараа муутай, асар том бриллантан хүзүүний зүүлттэй эмгэн түүний зүг нүдээ онийлгон,

-Та энэ мартагдсан нотыг хаанаас олсон юм бэ? Би түүнийг худалдаж авч болохсон болов уу? Үүнийг би Бетховен мөн гэж огт төсөөлөөгүй шүү!



Лара Адлер хоёрын харц мөргөлдөв.

-Өө! Бурхан минь, өршөөгөөрэй...  
гэсээр тэрээр арай ядан шүтэн  
бишрэг ч авхай нарын дундаас  
сугаран гарч, Ларатай гар барин,

-Оройн мэнд, Камерон авхай. Таны  
ирсэн чинь тун сайн хэрэг! хэмээн  
мэндчилэв. -Баярлалаа гээд Лара  
эргэн тойрныг харснаа,

-Би сайн сайхныг үнэлэгч өчнөөн  
олон хүн энд цуглана хэмээн  
бодсонгүй шүү гэлээ.

Филипп толгой дохин,

-Танд сонгодог хөгжим бас таалагддаг гэж бодож болох уу? гэв. Лара "Бяцхан Энии", "Хөх тарианы талбай", "Байшингийн дэргэдэх толгод гэдэг дууг сонсож өссөнөө саналаа.

-Таалагддаг. Аав минь сонгодог хөгжимд дуртай болгож хүмүүжүүлсэн юм.

-Чек илгээсэнд тань их баярлалаа. Таны өгөөмөр...

-Надад фондынхоо тухай яриач хэмээн хүсэх байна. Хэрэв...

-Өө, Филипп байна! Хэлэх ч үг алга!

Гайхалтай! Хосгүй... гэсээр  
шаагилдсан олон хүн тэр хоёрыг  
бүчээд авав.

-Хэрэв та ирэх долоо хоногт завтай  
бол... гэхдээ Лара олны шуугианыг  
давах гэж дуугаа өндөрсгөхөөс өөр  
аргагүй болжээ.

Адлер толгой сэгсэрч,

-Харамсалтай нь маргааш Рим руу  
явна гэв.

Бүсгүйн урам хугарлаа.

-Тэгвэл...

-Гэхдээ долоо хоногийн дараа эргэж ирнэ. Тэгэхэд...

-Тэгье!

-... бид хөгжмийн талаар ярилцаж болох юм. Ларагийн сэтгэл нь уужран инээмсэглэж,

-Тэгэлгүй яахав. Тун баяртай байна гэв.

Энэ мөчид нэг нь ар дагзандаа адууны сүүл мэт үсээ боосон, нөгөө нь чихэндээ мөнгөн ээмэг гялтгануулсан дунд зэргийн насны хоёр эр тэдэн рүү дөхөж ирлээ.

-Филипп ээ, чи бидний маргааныг таслаад өгөөч. Листийг тоглож байхдаа чи гишгүүр дээр гишгэдэг эсвэл төгөлдөр хуурыг хамаг хүчээр нь дуугарахыг эрхэмлэдэг үү, үүнийг хэлээд орхиоч?

-Гишгүүр гэв үү? Төгөлдөр хуурын гэсэн үү? Лара юун тухай яриад байгааг огт төсөөлсөнгүй. Гурван эр нотыг түргэтгэх, аялгууны цэвэр тунгалаг, ёслох тухай ч гэх шиг мэргэжлийн шүүмжлэлд умбан ухаан тавин орцгоожээ.

Лара Филипп Адлерыг ширтэнгээ:

Энэ бол түүний ертөнц. Би үүнд

уусах ёстой хэмээн боддоо.

Маргааш өглөө нь Лара Манхэттены хөгжмийн сургуулийн нүсэр үүдийг татан орлоо. Чийдэн асаасан ширээний ард суух ажилтан эмэггэй үг дуугаралгүй толгой өлийн харав.

-Би профессоруудын хэн нэгтэй уулзмаар байна гэж Лара хэлэв.

-Чухам хэнтэй нь юм бэ? хэмээн эмэгтэйг гайхсан янзтай асуувал,

-Ялгаагүй ээ, хэн нь ч хамаагүй гэж Лара хариулав.

-Хүлээж ажаамуу гээд эмэггэй босон

зэргэлдээ өрөө рүү орлоо. Ганц хоёр минутын дараа өрөөнд зарааны ус мэт сөрдийсөн буурал халимаггай дунд хэрийн нуруутай, жентельмен орж ирэн,

-Өглөөний мэнд, би Леонард Майер байна. Би танд туслаж чадах болов уу? гэлээ.

-Ноён Майер аа, би сонгодог хөгжим сонирхож явна хэмээн Лара хариулав,

-Өө, та манайд элсэх гээ юу? Та ямар хөгжмийн зэвсэгтэй вэ? -Ямар нь ч байхгүй. Би ердөө л сонгодог хөгжмийн тухай дориухан мэдэж

авах гэсэн юм,

-Авхай, та хаяг андуурсан болов уу гэж эмээх юм. Бид сонирхогчдын хүлээж авдаггүй билээ.

-Би таныг хоёр долоо хоногийн цаг зав гаргасны чинь төлөө таван мянган доллар төлье хэмээн Лара шийдэмгий гэгч нь хариулав.

Гайхалтай хачин үг сонсож сандарсан профессор Майерын нүд нь анивчиж,

-Өршөөгөөрэй авхай, таны нэрийг би дуулаагүй... гэхэд нь Лара,



-Камерон. Лара Камерон гэдэг юм гэв.

-Та сонгодог хөгжмийн тухай ярилцсаны төлөө таван мянган доллар төлнө гэв үү? гэх профессор бүсгүйн хэлсэн үгийг одоо хэр нь ухварлаагүй нь илт.

-Тэгнээ. Хүслээ биелүүлэхийн тулд таны сурагчдын бүх тэтгэлэгийн хандивлахад ч бэлэн байна гэж Лара хэлэв.

-Ингэх хэрэггүй биз хэмээн Майер бараг шивнэх шахуу амандаа бувтнав.

-За сайн байна.

-Хэзээ... э-э-э та хэзээ эхлэх вэ? гэж түгдчвэл Лара, -Яг одоо гэх нь тэр.

-Би яг одоо хичээлтэй байна, гэвч та зөвшөөрвөл мөчийи дараа...

Тэд хоосон ангид сууцгаана.

-За тэгэхээр, бүр эхнээс нь. Камерон авхай та сонгодог хөгжмийн тухай юу мэдэх вэ?

-Тун бага мэднэ.

-Ойлгомжтой. За яах вэ, хөгжмийг ойлгох оюун ухааны ба сэтгэл

хөдлөлийн гэсэн хоёр хандлага байдаг юм. Агуу хүмүүсийн хэн нэг нь нэг удаа хөгжим хүний өөрийнх нь сэтгэлийн нүдийг нээж өгнө хэмээн хэлсэн байдаг. Агуу хөгжмийн зохиолчид үүнийг баталдаг юм гэж Майер лекцээ эхэллээ.

Лара чих тавин сонсоно.

-Та ядахдаа хэн нэгний нэрийг ч гэхнээ мэдэх үү?

-Бүр ч бага мэднэ гэж Лараг хариулахад профессор хөмсөг зангидан,

-Өршөөгөөрэй. би бүр ойлгохоо байлаа, ингэхэд таны сонирхол яагаад сонгодог хөгжим рүү...

-Би мэргэжлийн хөгжимчинтэй ярилцахын үүднээс хангалттай мэдэх хэрэгтэй... Төгөлдөр хуурчтай гэж хэлье л дээ гэж Лара санаагаа хэллээ.

-За за гээд Майер агшин төдий бодолхийлснээ,

-Тэгвэл өөрөөр ярилцанаа. Би танд хэдэн лазерын диск өгье гээд тэрээр гар сунган шүүгээиээс тав зургаан ширхэг цэнхэр хайрцаг татаж авснаа.

-Эндээс эхлэе. Та анхааралтай сонсож бай. Моцартын 21-р концертын allegro. Брамсын нэгдүгээр концертын adagio, Рахманиновын 2-р концертын moderate энэ байна. Эцэст нь залхахгүй бол Шопены төгөлдөр хуурын концертыг ав гэлээ.

-Зөвшөөрч байна.

-Хоёр гурван хоногийн дараа бид... гэж профессорыг ам нээтэл Лара үгийг нь таслан,

-Би маргааш ирнээ хэмээв.

Лара Филипп Адлерын тоглолтын

бичлэг бүхий хэдэн дискийг ширээн дээр тавьлаа.

-Өө! Маэстро Адлер бол шилдгийн шилдэг! Та бас түүнийг анзаараа юу? гээд Майерын царай гэрэлтэв.

-Тэгсэн.

-Флипп Адлер сонатыг тун ч чадмаг тоглодог юм даа.

-Сонат ий?

Профессор санаа алдан,

-Энэ үг танд юуг ч хэлэхгүй байна уу? гэв.

-Харамсалтай нь мэдэх юм алга.

-Сонат-гэдэг бол гурав юм уу дөрвөн янзын аяс болон шинж чанар бүхий хөгжмийн зохиол. Ийм зохилыг зөвхөн төгөлдөр хуур эсвэл хийл хөгжим дээр дангаар нь тоглож байвал түүнийг сонат гэж нэрлэдэг юм. Найрал хөгжимд зориулсан сонатыг симфони гэдэг юм шүү дээ,

-Тун сайн ойлголоо хэмээн Лара хариулав.

Филипп Адлерийн Лист, Бетховен. Барток, Шопен, Моцартын бичлэгийн учрыг олох гэж нилээд хэдэн өдөр өнгөрлөө.

Лара ой ухаандаа шингэтэл сайтар ойлгохыг чармайна.

-Миний бодлоор Адлер Листэд их элгэмсүү ханддаг бололтой, Түүний тухай ярьж өгөөч гэж Лара профессороос хүсэв.

-Ференц Лист өөрийн гойд авьяасыг бүр хүүхэд байхдаа илрүүлсэн юм. Томчуул балчир хүүг шагшин магтацгааж байлаа. Язгууртан ноёд түүнийг дурлалт хүүхэн шигээ л нүд бүлтийн үзэцгээдэг байжээ. Лист амьдралынхаа эцсийн мөчид түүнийг шаламгай жонглёрчин, эсвэл сургуультай нохой шиг үзэх юм хэмээн гомдоллох...



-Харин Бетховены тухайд?

-Өө, энэ бол эмгэнэлтэй намтар даа. Бетховен бол өөрийгөө хамгийн золгүй хүн гэж тооцдог байжээ. Алдар хүндийн оргилд мандан бадарч явсан тэр үедээ тэрээр зохиож бүтээсэн эрхэм дээж бүтээлүүдээ голон гунигтай, зовлонг мэдрүүлсэн бүтээл туурвиж эхлэн "Баатарлаг" болон "Пасторальндю" симфонио бичжээ.

-Тэгвэл Шопен ямар намтартай вэ?

-Шопеныг зөвхөн төгөлдөр хуурт зориулсан хөгжим зохиож байна гэж шүүмжилцгээж зэмлэж...

-Франц. Америкийн сургуулийн хооронд асар их ялгаа байдаг. Францчууд хөгжмийн тансаг, ариуныг шүтэн үнэлж, хөгжмийн техникийн уламжлал болох сувд мэт өөгүй дуу авиаг эрхэмлэдэг...

Тэд хичээл бүр дээр Филипп Адлерын дискийг сонсож, эцэст нь шүүн хэлэлцэнэ. Хоёр долоо хоногийн дараа Майер,

-Та намайг гайхшруулж орхисныг би хүлээн зөвшөөрөх ёстой. Хөгжмийн зэвсгийн ард сууж, азаа сориод үзэхгүй юу? гэхэд нь Лара инээмсэглэн.

-Танд баярлалаа гээд профессорт амласан төлбөрөө төлөн чек гардууллаа.

Одоо Адлерийн эргэж ирэхийг хүлээх л үлдлээ.

## Хорь дугаар бүлэг.

Терри Хилл өглөө эрт утасдаж,  
өдрийн ажил урагштай эхэллээ.

-Лара, чи юу?

- За юу болоов?

-Дөнгөж сая мөрийтэй тоглоомын  
комиссоос чамд лиценз өгөх боллоо  
гэсэн мэдээ иржээ!

-Сайн байна, Терри.

-Бас бус зүйлийг уулзаж байгаад  
ярилцья. Одоохондоо: Бидний өмнө  
ногоон гэрэл аслаа гэсэн ганц л зүйл

тодорхой байна. Миний бодлоор тэд чиний араас арааны шүлсээ асгаруулсан бололтой гэж Терри даажигнахад нь,

-Одоо ч ханцуй шамлан ажилдаа орноо. Баярлалаа. Терри!  
хэмээн Лара хэлэв.

Лара шинэ сониноо Говардад дуулгав.

-Тэгэхээр бид бэлэн мөнгөний хуримтлалтай болох нь дээ. Энэ ч олон асуудлыг шийдэхэд дөхөмтэй юм боллоо гэж Говард хэлэв. Лара хуанли хараад,

-Хоёр дахь өдөр тийшээ нисэцгээе.  
Ажилдаа орох цаг боллоо гэв.  
Дотуур холбоо гэнэт амь орох мэт  
холбогдож намуухан дуугаар, -Ноён  
Адлер, 2-р шугамаар ярьж байна.  
Түүнд таныг...

-Би ярья гэснээ Лара харилцуур  
аван, -Филипп үү? гэв.

-Камерон авхай, эргэж ирсэнд минь  
талархаач. -Баяр хүргэе. "Бурхан  
минь би ямар и.х санав аа"

-Би хэтэрхий түргэдэж байж  
магадгүй, гэсэн ч та өнөө орой  
надтай оройн хоол идэхийг  
зөвшөөрөхсөн болов уу?

Гэтэл Лара, Мартинтай оройн хоол идэхээр товлочихсон байжээ.

-Дуртайяа зөвшөөрье. Өнөө орой би завтай!

-Хаашаа очих вэ? гэж Филипп Адлерийг асуухад нь,

-Хаа ч яахав гэх Ларагиын дуу уулзахсан гэхээс тэсэн ядах мэт байлаа.

-Хоёулаа "Бардам баск" кафед очих уу?

-Болох л юм.

-Оройн наймд үүдэнд чинь очих уу?

-Тэг.

-Уулзатлаа баяртай!

Лара харилцуураа тавиад  
инээмсэглэв. Царай нь аз  
жаргалтайяа гэрэлтэн байлаа.

-Филипп үү? гэж Говард түүнээс  
лавлав.

-Аан-хаан. Говард аа, би гэрлэлээ  
гэж Лара баясан өгүүлбэл залуу  
золтой л шүлсэндээ хахаж  
цацсангүй,



-Тоглоод байгаа юм уу? хэмээн  
гайхан асуув.

-Огтхон ч үгүй.

Намуухан дуугаар өгүүлэх Ларагийн  
үгс Келлерийг хүнд нударгаар  
цохиод авах шиг боллоо. Ээ Тэнгэр  
мннъ, би чий түүнийг алдах нь ээ!  
гэж бодсоноо агшны төдийд: "Гэвч  
би хэнийг хуурахыг хүсэх билээ |  
Зөвхөн өөрийгөө шүү дээ".

-Лара, чи чинь түүнийг мэдэхгүй шүү  
дээ! гээд Говард: Хм! Бүхий л  
амьдралаа баллах нь! гэж харамсан  
бодоод,

-Лара чи засашгүй алдаа гаргаж байна гэлээ.

-Үгүй огтхон ч алдаагүй гэтэл Пол Мартинд тусгайлан тавьсан хувийн утас нь хангинаж эхлэв.

Лара харилцуураа авангуутаа,

-Мэнд үү, Пол? гэлээ.

-Лара, хэдпйд хооллох вэ? Наймд уу? гэж Пол асуув.

Бүсгүй гэмшсэн янзтай,

-Өө Пол оо, бага сага бичиг баримтанд засвар хийх ажил гарах

нь шиг бололтой. Би яг чам руу утасдах гэж..

-Ямар нэг юм болохоо байгаа юу?

-Үгүй дээ, бүү санаа зов, бүх юм ном ёсоороо. Римээс уулзах ёстой хүн ирээд... гэсэн нь чухамдаа үнэн байжээ.

-Тэгвэл миний аз дутжээ. За за. дараа больё доо, охин минь.

-Сэтгэл зоволтгүй шүү.

-Би дуулсаан. Лиценз бүтсэн гэл үү? хэмээн Полыг асуухад,

-Тэгсээн бүтчихсэн гэж Лара хариулав.

-Хонгор минь, Рино чамд олз омог өгнөө.

-Унтаж байхдаа хүртэл өөрийгөө тэнд байгаагаар зүүдлээд байгаа шүү. Өнөөдөр амжихгүй болсныг өршөөгөөрэй, Пол оо. Маргааш ярьдаа.

Харилцуураа тавих зуур Келлер түүнийг цоо ширтэж буйг нь Лара мэдэрчээ. Түүний харцнаас зэмлэл тодорно.

-Ямар нэг юм чамайг зовоогоо юу,

Говард аа?

-Тнйм. Чиний өрөөний илүүдэл холбооны хэрэгслүүд.

-Чиний үгийг юу гэж ойлгох ёстой болж байна?

-Энд дэндүү олон утас байна. Мартинаас ирэх дуудлага бол муугийн ёр шүү, Лара.

-Пол Мартин биднийг хэдэн ч удаа гай гамшигаас аварсныг мэдэх үү? Өөр юу байна?

-Юу ч алга.

-Тэгвэл бүр сайн байна. Ажилдаа ор!

Филипп ширээний ард суугаад хүлээж байлаа. Лара шагшин гайхах хүмүүсийн харцыг эс хайхран тийшээ очив. Бүсгүйг харсан даруйд суудлаасаа өндийн босох Адлерыг үзмэгц Ларагийн зүрх хүчтэй булгиллаа.

-Би арай хожимдоогүй биз дээ?

-Ганц минут ч хожимдоогүй. Та гайхам сайхан харагдаж байна шүү гэх түүний хоолой догдолсондоо үл мэдэг чичигнэж сонсогдов.

Лара цаг шахам толины өмнө

эргэлдсэн аж. "Юу өмсөх вэ? Төлөв түвшин палааж уу? Дэгжин костюм уу? Хөнгөмсөг маягийн цамц өмсөх үү? Тэгж тэгж Диор фирмийн даруухан загварыг шилжээ".

-Баярлалаа, Филипп ээ.

Тэд хоёул тухлан суусны дараа Адлер.

-Би өөрийгөө дүүрчихсэн мангуу амьтан гэж бодох боллоо гэх нь тэр.

-Яагаад тэр билээ?

-Нэг л санаанд багтаж өгөхгүй л байна даа. Та чинь чухамдаа нөгөө

олныг шагшруулдаг Камерон авхай  
мөн юмаа даа!

Лара ичингүйрэн инээмсэглэж.

-Уучилж үзээрэй гэв.

-Бурхан минь! гэж. Зочид буудал,  
тэнгэр баганадсан барилга,  
худалдааны цогцолбор гээд л! Улс  
даяар ийш тийш холхихдоо таны нэр  
алдрыг би хаа сайгүй сонссон сон!

-Тэр чинь муугүй байна даа. Тэгвэл,  
намайг мартаж завдалгүй явжээ.

Адлер гярхай харцаар түүний царайг  
ширтэнэ.



-Надад ямар нэг сануулга хэрэггүй.  
Хүмүүс ердөө л таны гоо үзэсгэлэнг  
ам мэдэн магтацгааж байна.  
Залхахгүй байна уу?

Лара "ярьж л байг" гэж хэлэхээр ам  
нээсэн боловч,

-Та эхнэртэй юу? гэсэн үгийг өөрийн  
мэдэлгүй унаган хэлээ  
хазан чимээгүй болов.

Адлерын уруул инээн чичигнэж, -  
Үгүй. Гэр бүлийн амьдрал надад  
зохихгүй гэв. -Яагаад тэр билээ? гээд  
Лара агшин зуур амьсгаагаа түгжин:  
"Гэхдээ тэр" ... гэж бодвол.

-Яагаад гэвэл би жилийн ихэнх хэсгийг тоглолтоор явж өнгөрөөдөг хүн дээ. Өнөөдөр-Будапештад, маргааш Берлинд. Парижид эсвэл Токиод... гэж тэрээр өгүүлэв.

Бүсгүй сэтгэл уужран санаа алдан,

-Ойлгомжтой, Филипп ээ. Өөрийнхөө тухай яриач гэлээ.

-Танд юу сонин байна вэ?

-Бүгдийг нь сонсмоор байна гэж Лараг хэлэхэд,

-Өө. тэгвэл дор хаяж таван минут тэвчээр заан суух болох нь дээ гээд

Адлер мушигнан инээв.

-Үгүй. Нухацтай асууж байна. Ярьж өгөөч...

Адлер гүнзгий гэгч санаа алдаад,

-Эцэг эх маань венец гаралтай улс. Аав маань хөгжмийн удирдаач, ээж хөгжмийн багш байлаа. Гитлерийн бөмбөгдөгч онгоцноос сүрдсэн эцэг, эх маань бууриа орхин Бостонд нүүж ирсэн гэдэг. Тэнд л би энэ ертөнцөд мэндэлсэн юм даа хэмээн өгүүлэв.

-Та үргэлж төгөлдөр хуурч болно гэж бодож байсан уу?

-Үргэлжид бодож байсан. Би төгөлдөр хуурч болно гэдгээ үргэлж мэддэг байсан.

-Та хаана хөгжим тоглож сурсан юм бэ?

-Арван дөрвөн нас хүртлээ ээжээрээ заалгаад, дараа нь би Филадельфи руу Кертисын дээд сургуульд явсан юм.

-Филадельфи танд таалагдсан уу?

-Маш их таалагдсан.

-Ганцаардал таныг зовоохгүй байв уу?

-Огт үгүй.

-Би арван найман настайдаа Детройтсийн симфони найрал хөгжмийн хамт анхныхаа концертыг тоглож билээ.

-Аймаар байсан уу?

Филипл Лара тийш харан зальжин инээмсэглэж, -Одоо ч би тайзан дээр гарахдаа айдас төрдөг юм шүү гэв. - Аялан тоглох ямар байдаг вэ?

-Өө, хэзээ ч уйддаггүй шүү. Би нэг удаа Филидельфийн симфони хөгжминн хамт Брюссель орохоор явлаа л даа. Тэндээсээ Лондон орох

байтал, манан ихтэйгээс онгоц  
саатаж биднийг Шипхол,  
Амстердамын нисэх буудалд  
автобусаар хүргэж өглөө л дөө.  
Гаалийн түшмэл, ачаа тээврийн  
онгоц нь бидэнд багадах тул нэг бол  
хөгжмийн зэвсгээ, эсвэл ачаа  
тээшийн алийг нь авахаа сонгохыг  
бидэнд тайлбарлалаа. Мэдээж бид  
хөгжмийн зэвсгээ авалгүй яахав.  
Лондонд тоглох концерт юу юугүй  
эхлэх болчихсон байсан тул бид  
сахал хуузаа ч хусаагүй, футболк,  
жийнсэн өмдтэй тоглолт хийж билээ.  
Лара түүнийг дагалдан инээж,

-Үзэгчид та нарыг Ура хашгиран  
хүлээж авсан гэж андгайлья гэлээ.

-Ёстой үнэн. Индианад бас нэг явдал болж билээ. Тоглолтын төгөлдөр хуурыг цоожилчихсон байсныг нь эвдэх хэрэг гарсан шүү. Бүсгүй хм-хм гэж хамраараа дуугарч,

Харин Филипп үргэлжүүлэн,

-Ноднин жил Римд болсон Бетховенийн их наадмын дараагаар хөгжим шүүмжлэгчдийн нэг нь: "Адлер бидний чихийг хайрлахгүй байна. Тайзнаас зэрлэгээр бархирах авиа сонсогдож, гол сэдэв нь баларч, бариа эзгүйрчээ"... гэж байсансан. -Аймшигтай юм! гэж Лара харамсан халаглав.

-Хамгийн аймшигтай нь төгөлдөр хуурын ард би сууж байгаагүй юм! Би онгоцноос хожигдсон байлаа л даа! Бүсгүй ярианд нь ам халан урагш тонгойн,

-Өөр сонин адал явдал юу болж байсан бэ? гэлээ. Бас Сан-Палуд хамгийн хариуцлагатай мөчид хуурын маань гишгүүр хоёулаа хэмхрээд уначихаж билээ.

-Тэгээд та яасан бэ?

-Гишгүүргүйгээр Шопены сонатыг тоглож дуусгасан. Бас нэг удаа төгөлдөр хуур маань... гэж ярих Филиппийн дуунд урам орсон нь



илт мэдрэгдэж,

-Лара, би ч азтай хүн шүү. Миний гараар дамжин сонсогчдын сэтгэл өөр ертөнцөд аялаж байна гэдэг тун ч таатай хэрэг шүү. Хөгжим хүнийг сэрүүнд нь мөрөөдүүлдэг увьдастай юм. Заримдаа би хөгжим бол бидний оюун ухааны цорын ганц баримт гэж боддог. Хэрэв миний үт хэтэрхий гоё ганган мэт санагдаж байвал өршөөгөөрэй.

-Огтхон ч үгүй. Таны авьяас хүмүүсийг аз жаргалд умбуулдаг.

Таныг Дебюссиг тоглохыг сонсохдоо нүдэнд тэнгисийн эзгүй эрэг, тэртээ

тэнгэрийн хаяанаа дарвуулт хөлөг...

-Надад ч гэсэн.

-Таны Скарлатти надад ийш тийш  
хөлхөлдөх гудамж, туурайн тачигнах  
чимээ, битүү тэрэгний тачигнах дуу...

Энэ бүхнийг сонсох Адлерт ихээхэн  
тааламжтай байгаа нь түүний  
царайнаас илт байлаа.

Лара дотроон профессор Майерт  
гүнээ талархаж суув.

Үйлчлэгч эр захиалгат хоолыг  
авчирлаа.

Филипп дарснаас ганц балган,

-Лара, би өөрийнхөө тухай яриад дуусчихлаа. Одоо таны тухай ярилцая. Та яагаад заавал барилгын ажилыг эрхэмлээ вэ?

Бүсгүй хэсэг зуур бодлоо төвлөрүүлэн,

-Хэцүүхэн асуулт байна. Та гараараа, харин би толгойгоороо бүтээдэг. Би барилга барьдаггүй, харин барилгын боломжийг хангаж, бүтээдэг юм л даа. Зүүдэндээ тоосгон уул, ган төмөр гүлдмай, шуудайтай цементийг үздэг. Би архитектор, инженер, чулуучин гээд мянга

мянган хүнд ажил өгдөг. Миний туслалцаатайгаар тэдний гэр хоёр идэхгүй ч хоосон хонохгүй амьдарч байна. Тэдний бүтээж босгосон барилгад бусад хүмүүс аж төрж, миний худалдааны төвөөр аз жаргалтай худалдан авагчид хөлхөлддөг юм. За за, зөндөө ярьчихлаа. Өршөөгөөрэй гээд Лара ичингүйрэн инээлээ.

-Та ч гайхалтай эмэгтэй юм. Та үүнийгээ мэдэх үү?

-Танд ийм сэтгэгдэл терсөнд баярлалаа

Лара сүүлийн хундага дарсаа шимэх

зуур: Энэ бол хайр сэтгэл юм гэдгийг  
ойлгов. Түүний мөрөөдөлт хан хүү нь  
дэргэд нь сууж байна

\* \* \*

Бүсгүй орондоо орсон боловч нойр  
нь хулжжээ. Тэр орон дээрээ Филипп  
Адлер шиг эр хүн энэ хорвоод  
байхгүй гэдэгг эргэлзэх юм алга.  
Гэнэт утас нь хангинаж, Лара инээд  
алдсаар харилцуур аван,

-Филипп ээ... гэлээ.

Харилцуурт Пол Мартины дуу гарч,

-Охин минь чамд ямар нэг юм

тохиолдоогүй гэдэгт итгэх гэхдээ  
ярьж байна гэх сонсогдов.

-Би зүгээр ээ, Пол оо.

-Уулзалт ямар болов доо?

-Тун сайхан боллоо.

-Санаа минь амарлаа. Маргааш  
хамтдаа хооллох уу?

Лара эргэлзсний эцэст,

-Тэгье хэмээн хариулав.

Лара: Одоо "яах вэ?" гэсэн хүндхэн  
бодолд автлаа.

## Хорин нэгдүгээр бүлэг

Өглөө нь зарлага тэвэр дүүрэн час  
улаан сарнайн баглаа хүргэж ирлээ.  
Тэгэхээр өчигдөр үдэш түүнд бас  
таалагджээ гэж Лара бодоод Ларад  
гомдох сэтгэл төрөн, өглөөжингөө  
Филиппийн утасдахыг хүлээсээр суув.  
Алмайрч суухын чөлөөгүй ажил  
ихтэй байсан ч гэсэн Лара анхаарлаа  
төвлөрүүлэн биеэ эзэмдэж чадсангүй  
Өдрийн хоёр цагт нарийн бичгийн  
дарга Кэти,

-Таны ярилцлаганд урьсан нарийн  
бичгийн дарга нар хүрэлцэн иржээ  
гэж хэлэв.

-Оруул, оруул. Гэхдээ нэг нэгээр нь шүү. Дадлага туршлагатай, өндөр мэргэжилтэй саналаа өгөгсдөөс гучин

настай, сайхан бие хаатай, хар үстэй Гертруд Микст аз дайрчээ.

Лара түүний товч намтрыг үзээд, ихэд таашаалаа.

-Үл хөдлөх хөрөнгийн талаар та тун сайн ойлголттой юм байна.

- Тийм ээ, авхай. Би тан шиг босстой байж үзээгүй л явна. Үнэнийг хэлэхэд би энд цалингүй ч гэсэн ажиллахыг зөвшөөрөхөд бэлэн



байна. Лара инээд алдан.

-Дэндүү илүүц эрсдэл ч гэсэн та сайхан санал тавьлаа. Ажилдаа орж болно гэжээ.

-Баярлалаа,авхай.

-Гэхдээ эхлээд оффист болж байгаа явдлын талаар шүүмжлэн хэвлэлд ярилцлага өгөхгүйг сайн дураар зөвшөөрч гарын үсэг зурна. Та үүнийг зөвшөөрч байна уу? гэж Лараг асуухад Гертруд,

-Усыг нь уувал ёсыг нь дагна гэдэг байхаа. Би зөвшөөрч байна хэмээв.

-Кэти бусдыг нь тайлбарлаад өгнө.

Лара нийгмийн харилцааны хэлтсийн дарга Таунсендтэй яриагаа өндөрлөсний эцэст,

-Жерри аав чинь яаж байна? гэж асуув.

-Аав Швейцарид байгаа. Эмчлэгч эмч нь хөгшинд найдвар байгаа гэж үзэж байна гэх Таунсендын дуу нь үл ялиг намсан,

-Камерон авхай, энэ бол таны л гавьяа гэлээ.

-Хүнд болгонд боломж байдаг юм.

Илүү сайн болно гэж найдаж сууя даа.

-Баярлалаа. Танд юу гэж... гэтэл түүний үгийг таслан Лара суудлаасаа өндийн,

-Уучлаарай, Жерри, намайг хүлээж байгаа гээд гараад явжээ.

Таунсенд бүсгүйн араас удтал ширтэн зогсов.

Лараг Нью-Жерси дэх ээлжит төслийг боловсруулж буй архитекторчид хүлээж байв.

-Эрхэм жентельменүүд ээ, би төсөлд

сэтгэл хангалуун байна, гэвч бага сага тодруулга хийж өгмөөр санагдана. Яг энд гурван тийшээ харсан нуман хаалга хийж, ханыг нь гантигаар бүрнэ. Дээврийг нь орой дээрээ гэрэлт цамхагтай пирамидаар хийе. Үүнийг хийхэд нэг ч их асуудал үүсэхгүй болов уу? гэж Лара нэгэн содон санал нэмэв.

-Ямар ч асуудал алга хэмээн хүүхний санааг бүрэн дэмжсэн архитекторч нар хариуллаа.

Архитекторчид гарсны дараа, дотуур холбоо жингэнэн дуугарлаа.

-Камерон авхай, ээлжийн мастер

Раймонд Паффи хойшлуулшгүй хэргээр ярих гэнэ хэмээн нарийн бичгийн дарга нь мэдэгдэв.

Лара харилцуураа аван,

-Сайн уу, Раймонд оо гэж мэндлэвэл, ихэд цухалдсан залуу,

-Камерон авхай, манайд төвөгтэй асуудал гарчихлаа гэв.

-Тэгээд яриач.

-Манайд бетонон хавтан буулгасан чинь бүгдээрээ ан цавтай юм, Би буцаах гэж байгаага танд урьдаар дуулгах нь зөв гэж үзлээ л дээ. Бүсгүй

агшны төдийд бодол болсноо.

-Яахын эцэсгүй муу юм уу? гэв.

-Тийм ээ, тэд нормд тэнцэхгүй,  
тэгээд ч...

-Сэлбэн засч болох юм уу?

-Уул нь ч болно л доо, гэвч үнэтэй л  
болох байхдаа.

-Тэгвэл засчих.

Даффи тээнэгэлзэн, минут хэртээ  
чимээ тасарснаа,

-Би танд хэлсэн. Та л босс шүү дээ  
гэв.

Бүсгүй харилцуураа тавьлаа. Хотод бетонон хийц нийлүүлдэг хоёрхон фирмтэй, тэдэнд муухай ааш гаргана гэдэг нь амиа хорлосонтой адил хэрэг болох ажээ.

Аль хэдийнэ оройн зургаан цаг болж, Лара Филиппийн утасдахыг хүлээхээ болилоо. Тэрээр фондынх нь утасны дугаарт залган,

-Филипп Адлертай холбож өгөөч гэлээ. -Тэр тоглолтоор явсан. Танд юугаар туслах вэ? Тоглолтоор явах тухай Филипп огт дурсаагүйсэн.

-Хэрэггүй, баярлалаа.

Тоглолтоо ч хат даа. Бух юм өнгөрөх шив?

Ажлын өдөр шувтарч байтал Стив Мерчисон санамсаргүй айлчиллаа. Өрөөний үүд гэнэт саван дэлгэгдэж босгон дээр эр хүний сүрдмээр дүрс тодров.

-Гун хүндлэлт ноён Мерчисон танд юугаар туслах вэ? гэж Лара асуув.

-Чи хэдэн удаа миний зам дээр тээглэж хэвтэх гээ вэ?

-Танд асуудал гараа юу? хэмээн бүсгүй ажиг ч үгүй хэлэхэд нь,



-Тиймээ, чамтай л асуудал үүсээд байна. Би гуйгаагүй байхад улаан

зам дээр хөндөлдөхийг хэзээ ч тэвчдэггүй хүн шүү гэлээ.

-Хэрэв ноён Гутмамы тухай ярьж байгаа бол...

-Түүний тухай, тэр тухай л чалчаад байна.

-... тэгвэл энэ женгельмен миний төслийг таныхаас илүүд үзсэн юм.

-Чи л уруу татаа биз. Би нэг удаа сануулсан билээ. Дараагийн удаад сануулга гэж байхгүйг мэдээрэй. Чи

бид хоёр нэг дээвэр дор багтаж сууж  
болшгүй нь. Дараагийн удаад  
чамайг зүгээр орхихгүй шүү.

Хаалга тас саван хаагдлаа.

\* \* \*

Пол Мартин бүсгүйн гэрт зассан  
ширээний ард сууна.

Оройн зоог нэг л уйтгартай байгааг  
анзаарсан Пол,

-Охин минь, чи нэг л сэтгэл түгшсэн  
янзтай байх чинь. Ямар нэг юм  
болоо юу?

Лара хүчлэн байж инээмсэглээд.

-Үгүй дээ, бүх юм зүгээр гэчихээд Филипп явах болсноо яагаад хэлсэнгүй вэ? гэж бодов.

-Риногийн ажил хэргээ хэзээ эхлэх санаатай байна? гэж Пол асуув.

-Ирэх долоо хоногт би Говардтай хамт тийшээ ниснэ. Арван сарын дараа нээхээр төлөвлөж байна.

-Арван сарын дараа хүүхэд төрүүлэхийг ч төлөвлөж болно шүү дээ.

-Юу-уу? гээд Лара гайхан Мартиныг

ширтвэл, Пол гарыг нь энхрийлэн  
илээд,

-Лара, би чамд хэрхэн ханддагийг чи  
мэднэ дээ. Чи миний амьдралын  
утга учирыг орвонгоор нь эргүүлсэн.  
Надад хоёулаа хүүхэдтэй болмоор  
санагдах юм.

Бүсгүйд хариуд нь хэлэх үг  
олдсонгүй.

-Би чамд бяцхан сюрприз бэлдсэн  
гээд Пол энгэрийн халааснаасаа  
хавтгай хайрцаг гаргаж ирэн,

-Алив нээгээч гэв.

-Пол оо. чи надад өч течнөөн...  
хэмээтэл Пол үгийг нь таслан,

-Нээгээд үзээч гэлээ.

Бүсгүй тагыг нь авбал маргад  
эрдэнийн сондор байлаа.

-Ямар гоё юм бэ!

Мартин сондорыг амраг бүсгүйнхээ  
булбарай хүзүүнд зүүж өгөөд,

-Явья гэж тачаадсан сөөнгө дуугаар  
хэлээд унтлагын өрөө тийш алхлав.

Гэнэт Ларагийн дотор нь бачуураад  
ирлээ. Тэрээр Полд хэзээ ч

дурлаагүй явсан ч, Пол түүний тусын тулд ихийг хийснийх нь телөөсийг төлөх л ёстой байсан бүсгүйд өврөө хуваалцах нь тийм ч хэцүү биш байжээ. Гэвч одоо байдал өөрчлөгдөн. Лара хайр дурлалтайгаа учирчихаад байлаа. Тэнэг эм, тэнэг. Одоо Филтэй дахин уулзах хөг өнгөрчээ.

Лара хувцсаа дурамжхан гэгч нь удаанаар тайлж эхлэв. Пол хэсэг зуур тачаадан жаргалтайяа энхрийлж байснаа,

-Ай-ай! Охин минь, би ухаан тавих нь... гэж ёологнов.

Лара нүдээ анин, манан дундаа  
Филипп Адлерын царайг олж  
харахыг чармайлаа.

Ажил ном ёсоороо урагштай явж  
Риногийн төсөлд ямар нэг төвөг саад  
учирсангүй, "Камерон-тауэр"-ын  
барилга Ларагийн алдар хүнд хэрхэн  
өссөн шиг дээш тэмүүлэн  
сүндэрлэсээр байлаа. Лара хоёр,  
гурван сарын турш Филипп Адлер  
руу хэд хэдэн удаа залгасан авч.

-Ноён Адлер Бээжинд... -Ноён Адлер  
Парижид...-Ноён Адлер Сиднейд...  
гэхээс өөр хариу үл сонсоно. Эцэст  
нь цөхөрч гүйцсэн Лара: "Тэр чигтээ  
тэндээ үлдэг цаашаа" хэмээн

боджээ.

Лара хагас жилийн хугацаанд заналт өрсөлдегч Стив Мерчисоны улаан хамар дороос нь гурван сайхан объектыг нь гартаа оруулж чадлаа.

Нэг өдөр Говард Келлер түүний өрөөнд орж ирэн,

-Мерчисон чамайг хорхойтсон шүдэндээ зууна хэмээн заналхийлж байна гэж ярьцгааж байна.

Сэрэмжтэй байхад илүүдэхгүй болов уу? Тэр аюултай шүү, Лара гэв.

-Би мөчөөгөө өгөхгүй. Тэр өөр бизнес эрхэлж болох юм биш үү?



-Энэ ч тоглоом биш шүү. Тэр...

-Говардаа, түүний тухай бодлоо толгойноосоо авч хая. Лос-Анжелест нэг муугүй газар байна гэж өчигдөр надад мэдэгдсэн. Дуудлага худалдаа нь хараахан зарлагдаагүй байгаа. Хэрэв яаравчилж чадвал аманд орсон шар тос гэсэн үг. Маргааш тийшээ ниснэ гэж Лара шийдэмгий гэгч нь хэлжээ.

Ларагийн чихийг сортойлгосон өнөөх газар нь хуучин "Балтимор" зочид буудлаас холгүй таван акр талбайг эзэгнэх аж. Лара, Говард хоёрыг дагалдан явах брокер эр ам хамхилгүй,

-Хатагтай, энэ янзын байрлал сайтай газар шүү. Энэ талаар сэтгэл хоёрдон эргэлдэхийн хэрэггүй. Та энд орон сууц, дэлгүүр. театр гээд хот доторх бичил хотыг босгож... хэмээн ярьж гарахад Лара,

-Үгүй ээ гэх нь тэр.

Брокер эр буруу дуулав уу гэсэн аятай гайхан,

-Өршөөгөөрэй. авхай та юу гэв ээ? гэж асуув.

-Би үгүй гэж хэлсэн.

-Яагаад тэр вэ?

-Орчин нь хүн амьдрах аргагүй газар юм байна гэж бодож байна. Хот баруун тийш тэлж байна. Шоргоолж шиг олон хүнийг сонгосон замаас нь эргүүлнэ гэдэг тийм ч амаргүй гэж Лара тас түс хариулав.

-Гэхдээ... -Миний сонирхлыг өөр юм, өөрөөр хэлбэл нэгдүгээр зэргийн засаг захиргааны төв татаад байна. Хэрэв сайн дүүрэг олбол... гээд Келлерт хандан,

-Говардаа бид цагаа дэмий алджээ. Үдээс хойш буцья гэв.

Зочид буудалдаа эргэж ирмэгц Келлер сонин худалдаж аваад,

-Зах зээлээр юу байна, үзэцгээе гэлээ.

Үзээд өгье ч гэсэн үл хөдлөх хөрөнгийн захаар тэдний сонирхлыг татах өөдтэй газар байсангүй. Харин Ларагийн харц "Орой хаана очихвэ" гэсэн хэсгийн:

"ФИЛИПП АДЛЕР ӨНӨӨДӨР ГОЛЛИВУД-БОУЛД" гэсэн содон гарчиг дээр гэнэг тогтож сонин барьж буй хуруу нь чичигнэв.

-Маргааш харинаа гэж Лараг гэнэт шийдвэрээ өөрчлөхөд нь Говард нүдээ онийлгон.

-Чамд хөгжим нь сонин содон байна уу? Эсвэл тоглогч нь уу? Гэж асуухад нь,

-Чи хоёр билет худалдаад авчихаарай гэж Лара жишим ч үгүй хариулав.

\* \* \*

Лара урьд нь ил задгай асар том театрт ирж байгаагүй юмсанж. Эргэн тойрон нов ногоон толгодоор хүрээлэгдсэн байгалиас бүтээгдсэн энэ цэцэрлэгт хүрээлэн тийш бүхэл жилийн туршид хэдэн зуун мянган хүмүүс зугаалахаар ирдэг ажээ. Одоо бүр ч олон хүн цуглажээ.

Хөгжимчин эрийг тайзан дээр гарч ирэхийн хамтаар аадар бороо асгах мэт алга ташилт гзнэт нижигнэж, Филипп Адлерийг төгөлдөр хуурын дэргэд явж очиход бүр ч чангаар нижигнэлээ. Лара Келлерын гарыг базан,

-Филипп сайхан залуу биш гэж үү. хэл дээ? хэмээн шивнэв. Говард таг дуугүй өнгөрлөө.

Адлер сандалд суунгуут, хөгжим агшин зуурын төдийд сонсох танхимыг бүхэлд нь эрхэндээ оруулан, ид шидийн мэт түүний нөлөөгөөр танхим тэр аяараа хэмнэлтгэй амьсгалах мэт санагдаж,

хилэн хар тэнгэрт гийх одод хүртэл  
улам тодоор хөгжилтэйеэ гялалзлаа.  
Үдшийн нам гүм агаарт төгсгөлийн  
аяс замхрахад үзэгч олон нэгэн зэрэг  
суудлаасаа огло харайлган босч, энд  
тэндээс: Bravo! Bravo!  
хэмээн орилолдоцгоов.

Филипп гүн хүндэтгэл үзүүлэн  
мэхийн ёсоллоо.

-Алив доошоо бууя! гэж Лара сэтгэл  
нь догдолж хоолой нь чичигнэн  
хэллээ.

Жүжигчдийн хувцасны өрөө рүү орох  
хаалга нь найрал хөгжимчдийн суух  
"Дун"-гийн араар байх аж. Хувцас

солих өрөөний үүдэнд хүмүүс  
бөөгнөрөн овоорч, хүдэр чийрэг  
хамгаалагчид зээглэн зогсчээ.

-Камерон авхай, ноён Адлертай  
уулзахыг хүсч байна хэмээн Келлер  
хамгаалагчид хандав.

-Таныг хүлээж байгаа юу. авхай?  
хэмээн хамгаалагчийг лавлах Лара,

-Хүлээж байгаа хэмээн  
хариулчихлаа.

-Түр хүлээнэ үү гээд тэр хаалгаар  
орон алга болсноо тэр даруй эргэн  
ирж. -Орцгоогтон! гэв.



Лара Говардын хамт хурц  
гэрэлтүүлэг бүхий уужим өрөөнд  
орвол олон шүтэн бишрэгчдийн  
дундаас Филиппийг арай ядан ялгаж  
таньлаа.

-Ноён Адлер аа, та алтан гартай хүн  
юм! Би амьдралдаа хэзээ ч ийм  
сайхныг...

-Танд баярлалаа.

-... хөгжим урам зоригийг...

-... бас удирдаачид. Түүнгүйгээр...

-... би наашаа ирэх үү болих үү гэж  
их бодлоо л доо! хэмээн тал талаас

нь шаагилдах олны дунд Филипп зогсох ажгуу.

Филипп Адлер Ларагийн ирснийг мэдмэгц нүүр дүүрэн инээмсэглэн,

-Өршөөгөөрэй, би очихсон гэж хүссэн сэн... гэсээр олны дундаас арай гэж сугаран гарч ирээд.

-Лара! Би таныг энд ирнэ гэж бодоогүй шүү! гэлээ.

-Бид өнөө өглөө ирлээ танилц. энэ миний хамтран зүтгэгч Говард Келлер гэж Лараг танилцуулахад.

-Тааламжтай байна хэмээн Келлер

хүйтнээр хэлэв.

Филипп гэдрэг эргэн ханхар цээжтэй  
тагдгар эр тийш.

-Миний зохион байгуулагч Уильям  
Эллербиг танилцуулахыг болгооно  
уу гэснээ Ларад хандан,

-Хоёр цагийн дараа "Беверли-  
Хилтон"-д хүлээн авалттай. Очихыг...  
гэтэл,

-Дуртайяа зөвшөөрч байна! хэмээн  
Лара хоёр биеэ төлөөлөн урьтаад  
хариулжээ.

\* \* \*

"Беверли-Хилтон" зочид буудлын  
үүдэн танхимд Лараг аялгуут  
хөгжим. өөр хоорондоо хүүрнэлдэн  
зогсох дэгжин хувцасласан хүмүүс  
угтлаа.

-... хүмүүсийн емнө зүг рүү явуулах  
тутам онгод нь гаардаг болохыг  
хэдэнтээ тэмдэглэсэн...

-... Листийг тоглох үед түүний  
төгөлдөр хуур бүхэл бүтэн найрал  
хөгжмийн орлодог...

-... хонгор минь. зөвшөөрөхгүй л  
байхаа даа. Лист эсвэл  
Паганины судалбар аяс нь  
Бетховенийг тоглохтой яагаад ч

зүйрлэшгүй... -...төгөлдөр хуурч  
өөрийн сэтгэл хөдлөлөөрөө илүү их...  
"Эд өөр хэлээр харилцаж чаддаггүй  
юм байна даа" гэж тэдний ярихыг  
сонсон гайхах Лара бодлоо. Урьдын  
адил овоорсон олон тал талаасаа  
шавуулсан бүхний шүтээн эр Адлер  
Лараг хармагц гараараа даллаж  
үзэгдэв.

-Өө! Таныг хүрэлцэн ирсэнд чинь  
баярлалаа хэмээн түүнийг өгүүлэхэд  
нь Лара. -Би ийм боломжийг  
алдахыг хэрхэвч зөвшөөрөхгүйсэн  
гэв. Хос хоёрыг сэм ажин зогсох  
Келлер: Ингэхэд би ер нь төгөлдөр  
хуур тоглож сурах хэрэгтэй байсан  
дагаа. Ядахдаа үргэлжилсэн үгийн

зохиол ч гэхнээ оролдох байж дээ.  
Тэрээр зөрүүд, галзуу барын аманд  
гараа хийхээс буцахааргүй цөс  
ихтэй. тэгсэн мөртлөө дур булаам  
үзэсгэлэнтэй бүсгүйтэй хэзээ учирлаа  
даа? хэмээн бодож зогсов.

-Би өглөө Нью-Йорк руу буцах ёстой,  
гэхдээ хамтдаа ядаж өглөөний цай  
ууж болох юм шүү гэж Лараг  
хэлэхэд,

-Харамсалтай нь чадахгүй. Токио руу  
ниснэ гэж Адлерийг хариулахад  
бүсгүй гонсойн зүрх иь базаллаа.

-Яах гэж байгаа юм бэ? гэвэл Филипп  
тас тас хөхрөн,

-Ингэж л би амин зуулгаа хийдэг юм шүү дээ. Би жилдээ зуун тавь, заримдаа хоёр зуугаад концерт тоглодог юм гэв.

-Хэд хоног явах юм бэ дээ?

-Найман долоо хононо.

-Би их санана даа гэж бүсгүй амандаа бувтнав. Ямар их үгүйдэгийг чи мэддэг ч болоосой!

## Хорин хоёрдугаар бүлэг.

Лара хэдэн долоо хоногийн туршид Келлерийн хамт Атлант руу Энсли цэцэрлэгт хүрээлэн, Данвудад газар шинжлэхээр гурав дөрвөн ч удаа нисчээ.

-Данвудын үнэ ханшийг тодруул. Тэнд сайнаас сайн захиргааны төв барьж болно гэж бүсгүй Говардад тушаав. Атлантын асуудлын дараагаар Шинэ Орлеон хот дугараагаа хүлээж байлаа. Лара хоёр хоногийн туршид хотын төвийн амьдралыг судалж, эцэст нь Понтчартрейн нуурын эрэгт нэг өдрийг өнгөрүүлжээ. Үзсэн хоёр



газар нь хоёул санаанд нийцжээ.

Эргэж ирснээс нь хойш нэг өдрийн дараагаар Келлер өрөөнд нь орж ирэн,

-Лара, Атлантагаас муу мэдээ иржээ гэв.

-Юу болоов?

-Биднээс урьтчихжээ.

-Яалаа гэнээ? Хэн тэр вэ? Дуудлага худалдааг товлоогүй байсан биш үү?

-Мэдэж байна. Мэдээлэл алдагдсан бололтой гэж Келлерийн гайхшран

өгүүлэхэд Лара мөрөө  
хавчисхийлгэн,

-Нулимж орхиё. Үргэлж манлайлагч  
байж яаж болох вэ гэлээ.

Гэвч дараа нь байдал бүр дордож,  
тэр оройдоо Говард бас дахин Лараг  
шаналгажээ.

-Понтчартрейны хэлэлцээр бас  
баларчээ гэсэн муугаас муу мэдээг  
сонордуулав.

Долоо хоногийн дараа тэд Сиэтл  
орон. Мерсер, Киркленд арлуудтай  
биечлэн танилцан Нью-Йорк хотод  
ирсэн хойноо,

-Говард аа. Кирклендээс аз авчрах юм шиг байна шүү, энэ талаар хөөцөлд гэв.

-Чиний зөв өө.

Нэг хоног өнгөрч, хэлтсийн дарга нарын тайланг сонсон суусан Лара Келлерт хандан,

-Кирклендийн захиалга албан ёсны болсон уу? гэж асуувал,

-Бид хоцорчихсон байна лээ гэж алмайруулж орхив. Бүсгүй хахсан хүн шиг хэсэг дуугүй сууснаа,

-За тийм байдяг байж. Тэгвэл Говард

аа, хэн биднийг овоо хараандаа  
онилоод байгааг мэдэхийг хичээ гэв.

Говард Келлер хорин дөрвөн цагийн  
өмнө хэргийн эзний хэн болохыг  
мэдсэн байжээ.

-Стив Мерчисон л байна билээ.

-Тэгвэл, энэ бүх хэлэлцээр түүнийх  
болох нь ээ?

-Тийм, түүнийх.

-Манай ажилтнуудын хэн нэг нь  
урвагч байх нь ээ.

-Яг үнэн. Лара мушийн ёоз

муутайхан жуумалзав. Лхагва гаригийн өглөө гэхэд нэгэн хувийн мөрдөх агентлагт захирагдагсдынхаа өнгөрсөн намтар түүхийг ухахыг даалгажээ. Тэсэн ядан хүлээсэн амжилт нь бүтэлгүйтэв.

-Лара, бид танай ажилтнуудыг бүгд чин шударга гэж дүгнэлт өгмөөр байна. Харилцуур утас. оффисийн хаана ч чагнах "цох" зоогдоогүй байна.

Ларагийн арга мухардлаа.  
Тохиолдол уу?

Лара санамсаргүй тохиолдол гэдэгг итгэсэнгүй.

Куинс дахь жаран найман давхар орон сууцны барилгын бараг тал нь дуусч, Лара гүйцэтгэсэн ажлаа үзүүлэхээр шинжээчдийг урив.

Эрэлт хэрэгцээний дагуу давхар дээшлэх тусам байрны үнэ нэмэгдэнэ. Жаран найман давхар цамхагийн тавин долоон давхрыг нь орон сууцанд зориулах ажээ.

Пол Мартины зааж өгсөн аргын дагуу Үйлдвэрчний эвлэлээс өдөөдөг тоо томшгүй маргаанаас мултрахын тулд барилгын ажилтан орон тоо, цалингийн цэсэнд хэдэн арван хий үзэгдлүүдийн нэр зоогддог байлаа. Техникийн аюулгүй албаны

захиралд, техник хяналтын хэлтсийн координаторт, хяналтын ахлах байцаагчидад цалин олгодог байв. Эхэн үедээ Лара эргэлзэж байлаа.

-Бүү харамла. Ийм зардал гаргах нь гарцаагүй зөв. Энэ мөнгийг тэд чамд саад хийхгүй л гэж хүртэцгээж байгаа юм хэмээн Пол зөвлөжээ.

Лара орой тэднийхээр явдлын далимд ороод гарах зууртаа багавтар гурван өрөөгөөр нь шагайснаа,

-Говард аа, яг л хулганы хавханд орсон юм шиг санагдаж байна. Чамайг даруйхан өөр байранд

оруулах хэрэгтэй юм байна гэжээ.

Ингээд Говард түүний шахалтаар  
еөр байранд нүүж оржээ. Хэд  
хоногийн дараа офистоо орой  
болтол суугаад шөнийн нэг цагийн  
алдад ажил нь шувтрах тийшээ  
хандахад,

-Чи яг үхсэн хүнийг санагдуулж  
байна. Алив гэртээ харь гэж Лара  
ядарсан Говардыг хяламхийн харуут  
хэлэхэд,

-Сайхан санаа байна. Өглөө  
уулзацгаая гэж хэлээд Келлер томоо  
гэгч нь амны хэмжээ авчээ.



-Өглөө яарсны хэрэггүй шүү гэж Лара түүнийг гарахын өмнө сануулав.

Говард жолооны ард суун хөдөллөө. Тархинд нь сүүлчийн хэлэлцээрийн тухай, Ларагийн чадварлаг гэрээ байгуулсан тухай бодол залхуутайяа эргэлдэнэ. Чөтгөр ав гэж, ийм босстой ажиллана гэдэг хорвоод ховорхон тохиох аз завшаан шүү. Келлер сэтгэлийнхээ гүнд хаа нэгтээ нь ид шидэнд итгэсээр явах ажээ. Говард аа, хонгор мннь, би харалган явжээ! Надад Пол ч, Филипп Адлер ч хэрэггүй. Би чамд хайртай, ганцхан чамд!

Адгийн мануухай!

гэж бодоод өөрийн арчаагүйг бодон  
хараал урсгав.

Келлер суудаг давхартаа гаран,  
цоожны нүхэнд түлхүүрээ  
шургуулав. Хачин юм даа, түлхүүр нь  
орохгүй байх юм. Дахиад оролдсон  
авч бас л болсонгүй. Санамсаргүй  
байтал хаалга нээгдэн. босгон дээр  
үл таних эр гарч ирэн,

-Та чинь юу хийж байгаа нь энэ вэ?  
гэж хүнгэнэсэн дуугаар жигшсэн  
янзтай асуулаа.

Говард сандран тэвдэж.

-Би... би энд амьдардаг юм гэв.

-Яалаа гэнээ?

-Гэхдээ... гэтэл тархии дундуур нь  
няслаад авах шиг болж,

-Ээ тэнгэр минь, ө-өр-өршөөгөөрэй.  
Саяхан би энд амьдарч... хэмээн  
ээрч түгдэрч байтал хамрынх нь  
өмнүүр хаалга тасхийн хаагдав.

Чөтгөр гэж, би яахлаараа мартаж  
орхих нь энэ вэ? Унан тустлаа  
ажиллажээ дээ...

-Охин минь, чи үргэлж завгүй байх  
юм аа! Чамгүйгээр би их  
ганцаардаж байна шүү гэх Мартины  
дуу харилцуурт сонсогдов.

-Ажил ихтэй байна. Пол оо гэсэнд,

-Өнөөдөр үдийн хоол хамтдаа идье гэж Полыг хүсэхэд нь "Тэр миний төлөө ихийг хийсэн биш үү!" гэсэн бодол Лараг зүүгээр хатгах шиг болж,

-Тэгье, би баяртай байна гэлээ. Түүнийг гомдоох гэж үү? Яалаа гэж тэр вэ? Тэд "Ноён Чжоу" гэдэг хужаа рестроранд сууж байв.

-Чи мөчөөгөө өгөхгүй шазруун юмаа! Хавь орчинд юу ч болж байсан үргэлж л оройд нь гарсан явах юм. Рино дахь ажил чинь яаж байна? гэж Пол асуув.

-Муугүй яваа гэснээ Лара нэг мөчийн туршид урамтай гэгч нь Риногойн сонин хачнаа хуваалцаад,

-Хоёр сарын дараа гэхэд нээчихнэ гэжээ.

Тэднээс нэг ширээний цаана сууж байсан эр, эм хоёр босон гарах хаалгыг чиглэлээ. Гарч яваа эрийн ар нуруу нь Ларад нэг л танил санагдаад явчихав. Нөгөө эр үл ялиг хажуу тийш харвал түүний царай тод гэгч нь харагдаж өст дайсан өнөөх гайхал Стив Мерчисон явж байжээ. Яг энэ мөчид дагуул хүүхэн нь цүнхээ нээн уруулын будгаа гаргахаар тонгойход мь ахиулж харсанд,

Ларагийн нарийн бичгийн дарга  
Гертруд Микс дүрээрээ зогсож байх  
нь тэр ээ!

-Үгүй ер өө! гэж Лара өөрийн  
мэдэлгүй дуу алдчихлаа.

-Яав, юу болов? гэж Пол сандран  
асуухад нь.

-Үгүй-үгүй, гойд юм биш гтж Лара  
хариулжээ. Лара офистоо дөнгөж  
ирээд Келлерыг өрөөндөө дуудлаа.

-Говард, хоёр сарын өмнө Финикст  
үзсэн газрыг санаж байна уу? -Санаж  
байна. Бид голсон шүү дээ. Чи  
түүнийг дэндүү бөглүүд газар г эсэн

шиг билээ.

-Би бодлоо өөрчиллөө гээд дотуур холбооны товчлуурыг даран,

-Гертруд аа, ороод ирээч гэвэл,

-За, Камерон авхай гэж нарийн бичиг нь хариулаад өндөр өсгий дээрээ тов тов алхалсаар цоглог гэгч нь өрөөнд орж ирэв.

-Финиксийн ах дүү Бэронд захидал илгээгээдэх гэхэд Гертруд Микс хүүхэн тэмдэглэж авахаар зэхлээ.

-Эрхэм жентельменүүд ээ, би Скоттсдэйлын газрын талаарх

өөрийн шийдвэрээ хянаж үзээд даруйхан гэрээ байгуулан гарын үсэг зурахад бэлэн байна. Учир нь тэр газар оруулсан хөрөнгийг хурдан хугацаанд нөхөж чадна гэж бодлоо хэмээн Лара үгчлэн бичүүлэх зуур Келлер юу ч ойлгохгүй гайхан сууж байлаа.

Лара цааш нь үргэлжлүүлэн,

-Үнэ өөрчлөгдсөн эсэхийг тодруулж өгөхийг туйлаас эрхэмлэн хүсье гэснээ Гертруд га, бичив үү? гэж асуухад нь,

-Биччихлээ. Камерон авхай. Ингээд гүйцээ юу? гэв.



-Гүйцлээ.

Говард нарийн бичгийн даргыг харцаараа үдсэний хойно Ларад хандан,

-Чи юу болоод байгааг тайлбарлаад өгч болох уу? Манай шинжээчид тэр газрыг ашиггүй болохыг бүгд нэгэн дуугаар дүгнэсэн. Хэрэв чиний...

-Тайвширч үз. Гэрээ хийгдэхгүй гэж Лара хариулав.

-Тэгвэл яах гэж... хэмээн Говард бачууран асуулаа.

-Хэрэв миний таамаглал зөв бол,

Стив Мерчисон тэр хэлэлцээрийг  
байгуулах ёстой юм. Тэр өнөөдөр  
Гертрудтай хамт хооллож  
явна билээ.

Келлерын нүд загасных шиг огт  
цавчилгүй гөлийн,

-Тэнгэр намайг ниргэг хэмээн  
амандаа бувтнав.

-Чи хоёр гурав хоног хүлээж  
байгаад ах дүү Бэронтой холбоо  
бариаарай гэв.

Хоёр хоногийн дараа Говард  
баясгалантай инээсээр өрөөнд нь  
орж ирэн,

-Чи ончийг нь олжээ. Мерчисон нөгөө өгөөшийг тэр чигт нь залгиж, хэнд ч хэрэггүй тавин акр газрын хууль ёсны эзэмшигч болчихжээ хөөрхий гэжээ.

\* \* \*

Лара Гертруд Миксийг өрөөндөө дуудан,

-Чи халагдсан гэж заналтай дуугаар мэдэгдвэл нарийн бичгийн дарга хүүхний нүд нь бүлтийн.

-Халагдсан гэнээ? Яалаа гэж тэр вэ? гэв.

-Тантай хамтрагч хүн надад таалагдахгүй байна. Стив Мерчисонд хэлснийг минь мэдэгдэж болно гэлээ.

Гертрудын царай барайгаад ирлээ.

-Гэхдээ, би...

-Хаалгаа цаанаас нь хаачихаад, хамтрагч Стивтэйгээ дураараа дургиж, дулаан хөнжилдөө жиргэж яв даа хэмээн шүд зуун өгүүлэв.

\* \* \*

Шөнө дундад Лара жолооч Макс руу утасдан,

-Машинаа орох хаалган дээр аваад ирээч гэв.

-За, Камерон авхай.

Бүсгүйг доош бууж очиход, машины хөдөлгүүр сонсдох төдий хүржигнэж. түүнийг хүлээж байлаа.

-Хаашаа явах вэ, Камерон авхай?

-Манхэттеннйг нэг тойроодох доо. Би юу бүтээснээ нэг үзмээр санагдчихлаа гэхэд нь,

-Өршөөгөөрэй, авхай, та юу гэв ээ? гэж гайхсан жолооч асуужээ.

-Би өмч хөрөнгөө үзмээр байна гэж Лара үгээ сунжруулан хэлэв.

Лимузин байрнаасаа зөөлөн хөдөлсөөр Худалдааны төв, орон сууцны хороолол, захиргааны үүдэнд тус тус зогссоор, цаашлан Камерон скверийн дэргэдүүр гарч, "Камерон -Плаза", одоохондоо араг яс мэт сэрдийн байх "Камерон-тауэр"-ийн Камерон төвийг дайран өнгөрлөө. Лара машины цонхоор харан энэ тансаг хэмээгдээд байгаа барилганд хэн амьдарч, хэн ажиллах талаар бодолхийлэн явлаа.

Надад энэ хотыг сайхан болгох санаа минь бүтсэн. Би санаснаа

биелүүлсэн. Гэвч яагаад сэтгэл минь  
дундуур, санаа минь амрахгүй  
байна. Юу дутаа вэ?

Юу дутагдаад байгааг бүсгүй мэдэж  
авлаа.

Өглөө нь Лара Адлерийн зохион  
байгуулагч руу утасдан,

-Өглөөний мэнд, ноён Эллерби гэв.

-Өглөөний мэнд, Камерон авхай.  
Танд юугаар туслах вэ?

-Филипп Адлер энэ долоо хоногт  
хаана тоглолттой байгааг би мэдэх  
гэсэн юм.

-Өө тэр тун ачаалалтай хуваарын дагуу тоглож яваа. Маргааш орой Амстердамд, тэндээсээ Милан ниснэ, дараа нь Венец. тэгээд... Танд түүний маршрутыг бүгдийг нь нэрлэх үү?

-Үгүй баярлалаа, энэ чинь л хангалттай. Надад ердөө л сонирхолтой байсан юм, танд гялайлаа.

-Танд туслахдаа үргэлж баяртай байх болно. Лара Келлерыи өрөөнд орлоо.

-Говард аа, би Амстердам орох хэрэг гарлаа гэхэд нь тэрээр гайхан,



-Бидэнд тэнд ажил гараа юу? гэж асуув.

-Тийм ээ, нэг санаа терөөд гэж Лара булзааруулан хариулаад.

-Нягталж үзээд чамд дуулгана. Надад онгоц бэлдүүл гэв.

-Гэхдээ Берт онгоцоороо Лондон явсныг чи мартаа юу? Нисгэгчтэй холбоо бариад маргааш гэхэд энд бай гэж хэлье л дээ.

-Надад өнөөдөр л онгоц хэрэгтэй гэх Лара өөрийнх нь дуу хоолой ийм хатуу шаардлага тавьсандаа ч мэл гайхаж хоцорч, -За яахав, чиглэлийн

онгоцоор явъя гэлээ. Лара өрөөндөө эргэж ирээд Кэтид,

-Амстердам орох билет худалдаж авна уу. Даруйхан нисэх онгоцнйх шүү гэж тушаав.

-Тэгье, Камерон авхай. Үүд нээгдэн Келлер орж ирлээ.

-Чи удах юм уу? Хариуцлагатай зөвлөлгөөн хийх хугацаа хаяанд тулчихаад...

-Намайг ганц хоног, эсвэл хоёр хоног хүлээ гэв.

-Би хамт явах уу?

-Баярлалаа, Говард. Дараагийн удаад хамт явна биз.

-Би Вашингтоны сенатор найзтайгаа ярилцсан. Түүний хэлснээр засгийн газарт манай татварын хөнгөлөлтийг бүгдийг нь хасах хуулийн төсөл орж байгаа гэнэ лээ. Хэрэв хууль батлагдвал бид ашиггүй хоцрох нь.

-Мангуу амьтад. Үүгээрээ тэд бүх л барилгын компаниудыг сүйрүүлж дуусгах нь ээ.

-Тийм ээ. Манай найз эсэргүүцэх бодолтой яваа.

-Түүнийг ганцаараа биш гэдэгт итгэж

байна. Хууль бол хов хоосон санаа.  
Нэгдүгээр... гэтэл түүнин хувийн утас  
дуугарлаа. Лара харилцуур тийш  
хайхрамжгүй харав. Утас дуугарсаар  
байв.

-Чи авахгүй юм уу? гэж Келлер  
асуувал Лара,

-Үгүй хэмээн эрс хариулав.

\* \* \*

Таван удаа удтал дуудсны эцэст Пол  
Мартин харилцуураа тавьлаа.  
Ларагийн тухай бодол түүний  
толгойноос салж өгдөггүй. Сүүлийн  
үед бүсгүй нэг л хөндийрөн, нэг л

жийрхүү байх болжээ. "Арай өрсөлдөгч эр гарч ирлээ гэж үү? Үгүй, Лара минийх. Минийх хэвээр үлдэнэ"

"КЛМ" авиа компанийн онгоцоор ниссэн нь Ларад ихээхэн тааламжтай санагджээ. Бизнес-ангилалын суудлынхан ялдам үйлчлэгчдийн халамжинд бөмбөрч явсаар ирцгээв.

Сэтгэл нь хөдөлсөн Лара хөөрхөн царайтай үйлчлэгч бүсгүйчүүлийн санал болгох тансаг хоол, зууш, ундаа, анхаарал халамжийг эс хайхарчээ.

"Бн чинь юу гээчнйг хийж байна?  
Тэнд намайг хэн хүлээж байгаа юм  
бэ? Фил надад ганц цагийн зав  
гаргах завгүй байгаа. Илүүц  
наалинхай зан гаргах нь хүрсэн  
жаахан амжилтыг нь баллаж орхих  
юу магад. Гзвч ухрана гэхэд дэндуу  
оройтжээ, Оройтож ".

Кэти утсаар Транд" зочид буудалд  
өрөө захисан ажээ.

-Буудал маань танд таалагдана гэж  
бодож байна, Камерон авхай  
хэмээн лангууны дэргэд зогсох  
үйлчлэгч их л найр тавин  
инээмсэглэв.

-Тэгэлгүй дээ. Би Филипп Адлерыг ээлжит тоглолтоо өнөө орой хийнэ гэж сонссон. Хаана тоглохыг та мэдээгүй биз?

-Мэднээ авхай.

-Надад тасалбар авчнрч чадах уу?

-Гүн хүндэтгэлтэйеэ биелүүлье, авхай.

Лараг өрөөнийхөө босго алхаж амжаагүй шахуу байтал утас нь хангинав.

-Нислэг сайн уу? гэж Говард Келлер асуулаа.

-Баярлалаа.сайн явж ирлээ.

-Лара, би дөнгөж сая Долдугаар авенью дэхь гэрээний талаар хоёр банкны эзэнтэй уулзлаа.

-Тэгээд?...

-Хоёулаа уухайн тас шүүрч авна билээ!

-Тэгнэ гэдгийг би мэдээд байсан юмаа хэмээн бүсгүй баярласнаа нуухыг ч оролдсонгүй хэлээд,

-Архитектор, инженерүүдийн багаа бүрдүүлж эхэл, ажилдаа орог гэв.



-Ойлголоо. Маргааш утасдана.

Лара харилцуураа тавиад: Келлер байхгүй байсан бол би ер нь яах байсан юм болоо? Түүнтэй золоор учирсан шүү! Говарддаа тохирсон хань яагаад олж болохгүй байх билээ? хэмээн боджээ.

Тоглох гэж буй концерт бүр нь Филипп Адлерт анхны тоглолт мэт үргэлж санагддаг аж. Найраг хөгжилтэй өглөөний сургуулилт хийсний дараагаар тэрээр хөнгөн цайлаад оройн тоглолтын тухай бодлоос ангижрахаар кино театр руу явлаа. Филипп хэдийгээр дэлгэц ширтэн суух авч тархинд иь

товчлуурын даралт, түдлэг зай авах  
тухай бодол ар араасаа залган  
тасралтгүй цуварч, хуруунууд нь  
сандлын тохойлдуур дээр  
хэмнэлтэйгээр тогшино. Урд нь  
суусан эр эргэж харан,

-Та өвдгөө балбахгүй байж болохсон  
болов уу? хэмээн зэвүүцэн шивнэх  
хүртэл ийнхүү тогшоод байгаага ч  
мэдсэнгүй.

-Бурхан минь, өршөөгөөрэй!

Филипп босон гадагш гарлаа. Эргэн  
тойрон ажил албандаа яарч  
сандарсан улс холхилдоно. Тэрээр  
Ботаникийн цэцэрлэгийн уулзвар

дахь хотын түүхийн танхимаар хайнгадуухан гэлдэрч, захын талбайгаар яаралгүйхэн алхаллаа.

Филипп тоглолтын өмнө бага зэрэг дугхийж авахаар үдээс хойш дөрвөн цагт өрөөндөө эргэж ирэв. Дээд давхарт нь оройг чилтэл хүлээж ядах Лара Камерон байгаа гэсэн бодол түүний толгойд огт буугаагүй нь лав.

Филипп яг долоон цаг гэхэд Амстердамын төвд орших хуучны тохилог театр "Концертгебоу"-ын албаны хаалган дээр ирлээ. Театрын хонгилоор тэвчээргүй шүтэн бишрэгчдийнх нь түрүүч ирчихсэн холхиж байлаа.

Тэрээр театрын захирлыг орж  
ирэхэд фракаа өмсөж байв.

-Ноён Адлер аа, бүх билет  
шавхагдаж зарагдсан. Би нилээд  
хэдэн хүмүүст татгалзсан хариу өгөх  
хэрэг гараад байна. Хэрэв та ганц  
хоёр хоног саатахыг зевшөөрвөл ч!  
Мэдэж байна, энэ боломжгүй  
гэдгийг мэдэж байна, гэхдээ би ноён  
Эллербитэй ярилцвал...

Санаанд нь хөгжим бодогдох  
Филипп дүлий хүн мэт түүний үгийг  
нь сонссонгүйд, аягүйрхсэн захирал  
хаалга тийш ухарчээ. Агшны дараа  
үүдийг нь тогшин,

-Эрхэмсэг удирдаач, найрал хөгжимчид маань бэлэн болсон, ноён Адлер аа гэв.

Цаг боллоо. Тэрээр гараа урагш сунгахад хуруунууд нь үл мэдэг чичирхийлэх ажээ. Тайзан дээр гарахын өмнөх сэтгэл хөдлөл нь хэзээ ч барьж днийлдэхгүй нь дэг ээ. Агуу их Горовиц, Роунинтейн, Серкин нар ч гэсэн сэтгэл хөдлөлийг мэдэрч байсан гэсэн. Филиппийн өлөн ходоод нь гэнэт хоржигнон дуугарч, зүрх нь хүчтэй цохилоо.

Яагаад би дандаа ингэж тарчилдаг юм болоо ? гээд тэрээр толь руу нэг хараад хувцасны өрөөнөөс гарч, урт

хонгилыг туулан, тайз тийш гардаг дугуй шатаар өгсөж эхлэв. Сүүлчийн гишгүүр дээр хөл тавьмагц, хурц тольдуурын гэрэл нүүрийг нь төөнөж, алга ташилт нижигнэлээ. Чадварлаг хуруунууд нь товчлуурт хүрмэгц нөгөө тарчлан чичигнэх нь ор мөргүй алга болчихлоо. Төгөлдөр хуурын ард тэр өөрөө биш айвуу тайвуу байдлаараа хэнийг ч гайхшруулах, магтап гайхагдан түмний сэтгэлийг татсан тэс өөр нэгэн сууж байв.

Танхим даяар хөгжим эгшиглэлээ.

Лара хамаг биеэр нь цахилгаан гүйдэл цохилох шиг болохыг

мэдэрлээ. Филиппыг хармагц бүсгүй ховсдуулсан мэт болон "би" гэсэн бие хүн нь үгүй болох шиг. Бид эхнэр, нөхөр болно. Би үүнийг мэдэж байна хэмээн бодлоо.

Бүсгүй арагш гэдийн сандлын түшлэгээ налан ид шидийн мэт хөг аялгуунд бүтэн биеэрээ уусан орлоо.

Тоглолт ердийнхөөрөө ялгуулсан ялалтаар өндөрлөж, тоглолт дуусмагц хувцас солих өрөөний үүдэнд бөөн бужигнаан үүсэв. Филипп шүтэн бишрэгчид, хөгжимчин анд нөхөд гэсэн хоёр бүлэг хүмүүсийн баяр хөөрийг хуваалцаад сурчээ. Шүтэн

бишрэгчид нь улайран дайрцгаадаг бол харин хөгжимчин нөхөд нь гялалзсан авьяасыг нь үнэлэн, сэтгэл зүрхний угаас талархал илэрхийлдэг байна.

Амстердамд Филиппийн олон бишрэн шүтэгчид бий. Яг одоо тэрээр инээмсэглэн гарын үсгээ дурсган. өөрт огтын хамаагүй хар элгийн ч гэхнээ хэн нэгнийг анзааралгүй өнгөрөөж гомдоох вий хэмээн улангасан овоорох хүмүүсийн дунд зогсож байлаа. Үргэлж хаа нэгтээ булангаас. Та намайг санаж байна уу? гэж хашгирах тэр бүрийд тэрээр: Хөөе! Таньдаг хүн байх чинь! хэмээн



толгой дохидог ажээ.

Филипп английн удирдаач,  
Лондонгийн филармонийг үндэслэгч  
Томас Бичамийн өтөлсөн ой ухаанаа  
бусдаас нуухын тулд бодож олсон  
залийн тухай сайн мэднэ. "Та намайг  
санаж байна уу?" гэхэд нь эрхэм  
удирдаач маань байнга: "Хөө  
тэгэлгүй яахав! Ажил ямар байна?  
Аав нь сайн уу? Тэр юу хийж байна  
даа?" гэж асуудаг байжээ. Ээлжит  
тоглолтын дараа нэгэн бүсгүй:  
"Эрхэм ээ, та өнөөдөр урьд  
урьдынхаасаа илүү тоглолоо. Та  
намайг санаж байгаа биз?" гэж  
асуухад нь Бичам эелдэгээр толгой  
бөхийлгөн: Саналгүй яахав! Аав нь

сайн биз, юу хийж байна даа? гэж зуршил ёсоор асуувал бүсгүй:  
"Баярлалаа, аав сайн. Эрхэм аав маань урьдын адил Британыг удирдан жолоодсон хэвээр байгаа" хэмээн хариулах хүртэл түүний заль нь амжилттай байжээ.

Филипп хөтөлбөр дээр гарын үсэг зурсаар зогсох зуурт чихнийх нь үзүүрт,

-Өнөөдөр жинхэнэ Брамс...

-Төгсгөл нь намайг уяраа...

-Би таны бүх дискийг худалдаж...

-Ээжид маань зориулаад гарын үсэг зурж өгөөч... гэх яриа сонсогдоно.

Гэнэт тэр хэн нэг нь халуун харцаараа төөнөхийг мэдрэн дээш өлийн харсанд, хаалганы дэргэд Лара зогсож байлаа.

-Өршөөгөөрэй... өршөөгөөрэй... гэсээр Филипп зүтгэсээр хаалга тийш хүрч очин Ларагийн гарыг атган авч,

-Ямар гайхамшигтай сюрприз вэ? Амстердам тийш юу таныг татаа вэ? гэлээ.

"Лара, балгоомжтой байгаарай!"

-Ажилтай. Зочид буудалд концертын

зар байхыг хараад үзье гэж бодсон юм гэснээ "Ямар ч сэжиг авахшүй бчз, аан?" хэмээн бодоод, -Филипп ээ, та өнөөдөр зүйрлэшгүй сайхан тоглолоо! гэв. -Баярлалаа. Би... гэснээ эргэн бас нэгэн гарын үсэг зурчихаад, -Хамт оройн зоог барих уу? гэв.

-Тэгье.

Тэд Лейдсестраат дахь "Бали" ресторанд хооллолоо. Орох хаалганы босго давмагц шүтэн бишрэгчид ширээний араасаа ухасхийн босон алга нижигнүүлэв. Нэгдсэн улсад бол ч наоад зориулан алга ташина даа гэж Лара бодсоноо

тэр даруй даган яваа эрээрээ  
үнэнхүү бахархжээ.

-Ноён Адлер аа, таныг хүлээж авна  
гэдэг бидний хувьд ихээхэн  
хүндэтгэл байх болно хэмээн  
үйлчлэгч эр өгүүлээд тэднийг ширээ  
тийш хөтөллөө.

-Баярлалаа.

Лара суудлаа эзлэсний хойно  
рестораны заалыг гүйлгэн хараад.

-Эндхийнхэн таныг ихэд хайрладаг  
юм байна гэвэл Филлипп толгой  
сэгсрэн,

-Намайг бишээ, хөгжмийг хайрлацгаадаг юм. Би бол ердөө л зуучлагч. Үүнийг би олон жилийн өмнө ойлгосон юм. Би нилээд биедээ эрэмшсэн залуу болон өссөн л дөө, гэтэл нэг удаа гоцлол концерт тоглож дуусгатал хүмүүс ч алга ташилтаа нижигнүүлж эхлэн, би ч тэнэг инээмсэглэлээр нүүрээ чимэн гүнээ мэхийн ёсоллоо. Тэнгэрийн ивээлээр баярласан удирдаач маань багц хуудас нотыг шүүрч аван агаарт савчиж гарах нь тэр. Тэгтэл алга ташилт бүр ч чангаар нижигнэж, үзэгчид Моцартад талархаж байсан юм. Би тэр сургамжийг хэзээ ч мартажгүй.

-Өдөр болгон нэг л юмаа тоглоод байхдаа та залхахгүй байна уу? -Үгүй дээ. Нэгэн хэвийн тоглолт гэж энэ хорвоо дээр байдаггүй юм. Хөгжим нэг байлаа ч, удирдаач нь, найрал хөгжимчид нь өөр өөр байдаг юм шүү дээ.

Филипп үйлчлэгчтэй хэд гурван үг сольсны дараагаар үргэлжлүүлэн,

-Хөгжимчин хүн үргэлж эрхэм төгс тоглохыг эрмэлздэг боловч яагаад ч боломжгүй хэрэг, яагаад гэвэл хөгжим гэдэг чинь биднээс дээгүүр, биднээс илүү эрхэм байдаг юм. Хөгжмийн зохиолчийн санааг ойлгоё гэвэл үргэлж шинэлэг хэлбэрийг

эрэлхийлж байх ёстой.

-Тэгээд та хэзээ ч сэтгэл ханаагүй хэрэг үү?

-Сэтгэл ханаагүй. Зохиолч болгон өөрийн онцгой, үгүй ядаж авиаг илэрхийлдэг өвөрмөц шинж чанартай байдаг юм. Би Дебюсси. Брамс, Гайднаг тоглох бүрдээ хүн бүрийнх нь тусгай дэвсгэр хөгийг хайж олохыг оролддог юм.

Тэдний зүг: мах, загас, дэгдээхэй. будаа. ногоо, амтат зуушаас бүрдсэн Индонез тогооч нямбайлан бэлтгэсэн хорин хоёр төрлийн хоолыг овоолсон тэргэнцэр айсуй.



-Арай эднийг бүгдийг нь идэх юм биш биз дээ? гээд Лара инээд алдав.

-Голландчууд хоолонд дургүй байхыг тэвчдэггүй улс шүү гээд Филипп нүдээрээ инээв.

Филипп бүсгүйгээс харц үл салган ширтэх зуураа энэ залуу бүсгүй түүнд нэг л үл ойлгогдом сэтгэл түгшээсэн жаргалд хүргэхийг мэдэрлээ. Олон сайхан хүүхнүүд эрхэлж наалинхайтаж байсан. Гэвч сэтгэлийнх нь гүнд тэдний хэн нь Ларатай эн зэрэгцэхгүй гэдгийг тэр хүлээн зөвшөөрөх хэрэгтэй боллоо. Эрч хүчтэй атлаа танхилхан Лара өөрийн гоо үзэсгэлэнтэйг өгүүлээд

зогссонгүй, Бүсгүйн дуу хоолой нь  
цээл бас тачаангуй юм уу даа?

"Тийм ээ, түүний бүх юм надад  
таалагдаж байна."

-Та дараа нь хаашаа хөлгийн  
жолоогоо залах бодолтой байна  
даа". гэж Лара асуухад,

-Маргааш Милан, дараа нь Венец,  
Вен, тэндээсээс Париж, Лондон,  
Нью-Йорк орно гэв.

-Сайхан сонсогдож байна шүү  
хэмээн Лара өгүүлвэл Филипп инээд  
алдан,

-Онгоц буудалд шахалдан  
түлхэлцэж, зочид буудлын уйтгартай  
өрөө, рестораны хоол. Хүний урманд  
хэзээ ч ингэж ярьж байгаагүй юм  
шүү! Энэ бүх хэвшлээс хөгжим л  
сатааруулж байгаа нь яамай даа.  
Одоо эндээс шувуухай ниснэ! хэмээн  
зураг дарахыг үзэн ядахыг яана гээч!

-Би огт ойлгосонгүй.

-Олны нүдэн дээр үзмэр болж, огтын  
хамаагүй хүмүүс тийш инээмсэглэн,  
үргэлж хар элгийн улс, танихгүй  
хүмүүсийн дунд явна гэдэг хэцүү  
байдаг юм.

-Үүнийг чинь би биеэрээ амсаж

мэдсэн гэж Лара намуухан дуугаар өгүүлэв.

Оройн зоог өндөрлөхийн алдад,

-Тоглолтын дараа амрахыг тэсгэлгүй хүсдэг юм! Хоёул сувгаар зугаалах уу? гэж Филипп хэлэв.

-Би санал нэг байна.

Тэд ресторанаас гараад эргийн гудамжийг хөндлөн гарч усан онгоцны бага шиг зогсоол дээр ирлээ. Хав харанхуй саргүй шөнө байсан авч мянга мянган жижигхэн гэрэл гялтганан хотыг гэрэлтүүлнэ. Усны гадаргуу дээр тусах тэдний

долгиолон найгах сүүдэр ид шидийн  
үлгэрийг санагдуулна. Хөлөг онгоцны  
ахмадын өрөөн дөх цагаан хоолой  
дөрвөн хэл дээр:

"Одоо бид дундад зууны үед  
баригдсан, хамгийн чинээлэг  
худалдаачин наймаачдын оршиж  
сүүж байсан барилгуудын дундуур  
явж байна. Та бүхэн тэдний хосгүй  
нандин хийцэд анхаарлаа хандуулна  
уу. Бидний замд сүмийн хонх...  
сүвгийн дээгүүр арван хоёр гүүр.,.  
Өглөөн манан дундах хайлаас  
моддын дунд уран зураачдын  
зургийн тавиур нуугдан байхыг..."  
хэмээн бүүвэйлэх мэт  
намуухнаар хүүрнэнэ.

Тэртээ ард Амстердамын хамгийн хавчиг, ердийн орох хаалганаас өргөнгүй байшин болох Смалсте-Уйс, дараа нь Габсбургийн овгийн үндэслэгчдийн нэг Максимилианыг хаан ширээнд өргөмжилсөн Вестеркерк ард нь хоцорчээ. Эргийн хоёр талаар хэдэн зуун гэр бүлийн орон гэр нь болсон завинууд ярайна.

-Сайхан хот юмаа хэмээн Лара шүүрс алдав.

-Та энд ирж байгаагүй юм уу? гэж Филипп асуулаа.

-Үгүй.

-Та ажлаар ирсэн гэл үү? гэхэд нь  
Лара гүн санаа алдаад,

-Үгүй гэлээ.

-Миний санахад...

-Би энд тантай уулзах л гэж ирсэн  
юм хэмээн бүсгүй хэллээ.

Филиппийн цээжинд халуу дүүгээд  
иржээ.

-Надад... үүнийг чинь сонсоход  
таатай байна.

-Бас нэг үнэнээ хүлээх ёстой. Би  
сонгодог хөгжимд дуртай гэсэн. "Энэ

тийм биш шүү.”

Филиппийн завьж инээмсэглэлдээ  
чичигнэж,

-Мэднэ гэлээ.

-Мэднэ гэнэ ээ?

-Профессор Майер бол миний  
хуучин анд минь юмаа. Филипп  
Адлерын уран бүтээлийн талаар  
танд лекц уншиж байхдаа над руу  
ярьсан юм. Хөгшин таны  
төлөвлөгөөний талаар надад  
болгоомжлуулсан.

-Тэр зөв л болгоомжлуулж дээ. Та



найз бүсгүйтэй юу?

-Энэ тийм чухал юм уу? гэж  
Филиппийг асуухад Лара  
ичингүйрэн,

-Өршөөгөөрэй. Би маргааш ниснэ,  
тэгээд бүх юм...

Филипп гарыг нь энхрийлэн илээд,

-Алив эрэг рүү явцгаая гэлээ.

Зочид буудалд ирэхэд үйлчлэгч  
Ларад Говард Келлерээс ирсэн багц  
илгээмжийг гардуулахад уншсан ч  
үгүй цүнх рүүгээ чихчихэв. Дараа  
боломз. Одоо тун чухал хэрэг байна.

-Чиний өрөөнд орох уу, минийхэд орох уу? хэмээн Филипп шивэгнэхэд нь,

-Чинийхэд гэж хэлэхдээ бүсгүй бараг хашгирах дөхжээ.

Лара энэ мөчийг бүхий л амьдралынхаа туршид хүсэн хүлээж, өдий урт удаан хугацааны туршид орон зай эзгүйрч үгүйлэгдээд байсан юмаа оллоо. Хүүхэд наснаас нь хойш амар заяаг нь үзүүлээгүй сэтгүүлийн гялгар хуудсан дээрх урт хормойтой хар хөх фрак өмсөж. цасан цагаан эрвээхэй зангиа зүүсэн өндөр нуруутай, цайвар үстэй, айхтар харцтай, цэнхэр нүдтэй үл мэдэг

инээмсэглэл тодруулсан залуу эр хунтайж нь Филипп байсан юмсанжээ.

Филиппийг үүд нээх зуур Ларагийн хамаг бие нь халуу дүүгэн зогсон байлаа. Тэд босго даван оруут тэврэлдэн, Филиппийн уруул тачаадан чангаар үнсэхэд бүсгүй эсэргүүцсэнгүй. Хамаг бие нь сулран "Бурхан минь! Ээ бурхан минь" хэмээн Лара бодох зуур өөрийн мэдэлгүй Филиппийн хувцсыг нь тайчиж гарчээ.

Өглөөний нам гүмийг аяндын нижигнэх чимээ тасдан, Амстердам тэр чигээрээ хар тугалга мэт зузаан

үүлээр хучигдаж, аадар борооны  
дуслын түрүүч цонхны шилийг  
тогшиж эхэллээ. Горхины мэт урсах  
борооны ус барилгын ханыг илсээр  
ховил даган шожигнож, тоосгоны  
булан бүрийг үнсэн таалсаар нов  
ногоон таримал зүлгэн дээр чимээ  
аниргүй шингэнэ. Алгуур эхэлсэн эрч  
улам улам хурдлан түргэсэж, зуны  
намуухан бороо хар салхи болон  
хувирч, нүүр нүдгүй балбах усан  
ташуурын хүч улам догшрон  
ширүүссээр туйлдаа хүрч, нүд  
сохлом хурц цахилгаан цахилж,  
тэнгэр чихний хэнгэрэг хагарам  
чангаар дуугарлаа.

Аянга гэнэт эхэлсэн шигээ гэнэт

чимээгүй болов. Тамир нь тасарсан Лара бүхэл бие цогцсоороо түүний зүрхний галзуутай цохилохыг чагнан Филиппийн тэвэрт хэвтэнэ, "Хөл дор тань газар хэрхэн эргэлдэхийг мэдэж байна уу?" гэсэн хуучны дууны үг Адлерын санаанд орж ирлээ. Бурхан л мэдэх байх даа. Бас ямар хурдтайг нь ч гэсэн. Хэрэв Ларагийн хөргийг хөгжмөөр тоймлон дүрслэе гэвэл Шопены "Баркарол" л байж таараа. Эсвэл Шуманы "Фантаз" уу?

Тэдний бие сэтгэл дахин өдөөгдөн сэргэв.

-Филипп ээ... гэж тамир нь барагдсан сөөнгө дуугаар Лара дуугарлаа. -Юу

гээв?

-Чи намайг Милан хамт явахыг хүсэж байна уу?

-Хүсэж байна. Хүсэж байна! хэмээн түүний цээжнээс намуухан гэнгэнэх дуу сонсдоход,

-Хамт явнаа... гэж Лара хариуд нь шивэгнэжээ. Бүсгүйн урт долгиолсон үс дэрэн дээр задран тарсан харагдана. Цонхны цаана дахиад л бороо орох сонсогдов. Лара өрөөндөө эргэж ирмэгцээ Говард руу утасдав. -Говард аа, чи унтаж байна уу?

-Үгүй. Би голдуу өглөөний дөрвөн цагт гэрийн даалгавраа хийдэг юм. Чамаар сонин юутай вэ? гэх түүний хоолой нь нойрмог дуугаар сөөнгөтөв.

Бүсгүй бүгдийг ярихсан гэхээс хэл нь загатнах ажээ.

-Онцын сонин юм алга. Би Милан нислээ гэв.

-Хаашаа гэнээ? Бидэнд Италитай ажил хэргийн сүлбээ бий билүү?

Олон юм бий, тун н олон юм бий хэмээн Лара бодов.

-Чи миний илгээмжүүдийг уншив уу?  
хэмээн Говард асуув.

Би тэр тухай таг мартжээ.

-Үзэж амжаагүй л явна.

-Казиногийн тухай цуу яриа...

-Ямар яриа гараа вэ?

-Дуудлага худалдааны хороонд  
зохион байгуулагчийн нэр дээр  
гомдол ирсэн гэнэ гэхэд нь,

-Бүү санаа зов. Пол Мартин бүх  
асуудлыг шийдчихнэ гэж Лара итгэл  
төгс хариулав.



-Чи мэдэх юм хойно юу хэлэх вэ. Чибосс шүү дээ.

-Миний онгоцыг Милан руу явуул. Тэнд хүлээж байг.

-Тэгье, гэхдээ...

-Унт даа. муужгайхан минь.

\* \* \*

Өглөөний дөрвөн цаг гэхэд Пол Мартин дугхийгээгүй сууна. Ларагийн өрөөний автомат хариулагчид түүний хэд хэдэн яриа хадгалагдсан боловч түүний хэн ч сонсохгүй нь мэдээж. Лара урд нь

эзгүй байх тухайгаа үргэлж дуулгадаг  
байсан сан. Юу болоо юм бол?

Тэр юу сэдчихээ вэ?

Охин минь, болгоомжтой л байж  
үзээрэй! Тун болгоомжтой!

## Хорин гуравдугаар бүлэг.

Филипп Адлер, Лара хоёр Миланд ирээд "Антика Локайда Соль - срерино" гэдэг арван хоёрхон өрөөтэй, жижигхэн буудалд буун, үд дунд хүртэл ухаангүй дурлалын амтанд булхаж хэвтэж, дараа нь өлөн гэдэс нь цоройндоо наалдах шахам өлсөцгөөн Комо нуурын эрэг тийш машинаар гарчээ. Д'Эсте харшид тансаг зоог тэднийг хүлээж байлаа.

Яг санаснаар нь Ла Скала дахь концерт нь ширүүхэн алга ташилтаар өндөрлөлөө. Жүжигчний зочны өрөө бас л хөл тавих зайгүй

болжээ.

Лара хана налан зогсож, хөгжмийг ухаан тавин үнэлэгчдийг ажиглаиа. Тэдний хэдэн арван гар илж таалахаар, гарын үсэг авахаар, дурсгалын зүйл бэлэглэхээр Филипп тийш сарвайж тэмүүлцгээх ажээ. Гэтэл олон сайхан хүүхнүүд илт шалиглан өдөхийг харсан Ларагийн зүрхэнд хардах сэтгэл ёгхийн төрөв. Фендийн даашинз бүхий нэгэн өндөр америк хүүхэн санамсаргүй байтал,

-Ноён Адлер, хэрэв та маргааш завтай бол би харшдаа явцуу хүрээний нехдийн хамт зоог барих

гэж буйг минь санаандаа  
баггаачихгүй юу. Тун явцуу хүрээнд  
шүү хэмээн наалинхайтахыг нь Лара  
сонсчихжээ.

Өөр газар байсан бол ч Лара энэ  
гичийг өөрийн гараар багалзуурдаад  
авахсан.

Филипп инээмсэглэн.

-Ээ-э-э... Танд гялайлаа, би очиж  
амжихгүй гэлээ. Бас нэг хүүхэн  
түүний халаасанд зочид буудлынхаа  
өрөөний түлхүүрийг хийхээр гараа  
шургуулахыг завдахад нь Филипп  
толгой сэгчин зайлуулав.

Хүүхнүүд түүнийг улам бүчин  
бүсэлцгээв. -Үнэхээр гайхалтай  
байсан шүү!

-Гайхамшигтай хөгжим! Одоо хүртэл  
чихэнд минь сонсдож байна.

-Хатагтай. танд гүнээ мэхийн ёслоё  
хэмээгээд Филипп толгой бөхийлгөн  
талархав.

Бас нэгэн шүтэн бишрэгч бүсгүй,

-Та манай харшид очихыг  
зөвшөөрөөч дээ гээд гараас нь  
зуурлаа.

-Харамсалтай нь амжихгүй.

Энэ бүх шалиглал хэзээ ч төгсөхгүй юм шиг Ларад санагдаад явчихлаа. Филипп ид шидээр гэлтэй тэднээс мултарч дөнгөн гарч

-Алив зугтая! гэхэд нь Лара,

-Ай даа гээд инээмсэглэв.

Тэд гарах хаалга тийш хурдалжээ.

Тэд театрын нэг давхарт байрлах "Биффи" хэмээх ресторанд орцгоов. Филиппийн танхимд оров уу үгүй юу тэнд байгсад суудлаасаа босон баярлалдан алга нижигнүүлэн ташицгаав.

Заалны зохион байгуулагч эр хар  
гүйхээ э хүрч ирэн, гүнээ мэхийн  
ёслоод,

-Ноён Адлер аа, та бидэнд их  
хүндэтгэл үзүүллээ хэмээн гүнээ  
мэхийн ёслоод, хос хоёрыг  
танхимын дунд байх хүндэтгэлийн  
ширээнд суулгав. Үйлчлэгчид  
дохихын зуургүй хундага нь шампан  
дарсаар бялхан дүүрэв.

-Бидний төлөө! гээд Филипп хундага  
өргөв.

-Бидний төлөө.

Филиппэд шагшин бахдаж буйгаа



илэрхийлэх гэсэн хүмүүс байн байн ширээнд дөхөж ирцгээн, ихэнх нь гарын үсгийг нь хүсэмжлэх ажээ.

-Дандаа ингэдэг үү? гэж Лараг сонирхвол,

-Яаж ч болохгүй юм чинь энэ дээ гээд тэрээр мөрөө хавчисхийлгэн,

-Төгөлдөр хуурын ард сууж байхад хүртэл гарын үсэг, ярилцлага авах нь тасардаггүй юм гэлээ.

Түүний хэлснийг батлах гэсэн мэт бас нэгэн хөгжмийн хорхойтон тэднийг чиглэсээр дөхөж ирэв.

-Чи энэ удаагийн тоглолтыг минь мартахын аргагүй болголоо гэж Филипп Ларад хэлээд хөтөлбөр дээр гарын үсэг зурж дуусган үзгээ далд хийнгээ,

-Маргааш би Венецид тоглолттой. Би чамайг санана даа гэж хэлэв.

-Би Венецид очиж үзээгүй юм байна!

Ларагийн хувийн онгоц нисэх буудалд тэднийг хүлээн жолоогоо сойжээ. Филипп мөнгөн хөлгийг гайхсан харцаар гөлийн ширтэж,

-Тэгээд энэ чинийх юм уу? гэв.

-Минийх ээ. Нисэцгээх үү? гэж Лараг асуухад,

-Авхай та намайг бүрмөсөн уруу татчихлаа гэв.

-Бүү эргэлз!

Гучин таван минутын дараа "Бойнг-727" онгоц Марко Пологийн нисэх буудалд газардав. Суналзсан урт лимузин тэднийг усан онгоцны зогсоол хүргэж ирэхэд өрөө захисан "Киприани" буудал байрлах Гуидекка арал хүргэж өгөх хөлөг онгоц бэлэн зэхий зогсож байжээ.

-Өөр буудалд буувал дээр хэмээн би

бодлоо. Бусдын анхаарлыг татахын хэрэг юу байна гэж Лара тайлбарлаад хөлгийн тавцан руу гарангаа,

-Чи энд хэдий хугацаагаар байх юм бэ дээ? гэж Лара асуувал Филипп,

-Ганц л хононо. Маргааш Ла Скалад тоглолттой, дараа нь бид Вена орно шүү дээ гэлээ.

Бид гэнаа? хзмээн Ларагийн сэтгэл уярлаа. Филипп бусгүйгээс урьтан,

-Чи надаас болж чухал ажлаа алдаагүй биз? гэв.

-Надад чухал ажил байхгүй.

-Хэрэв үдээс хойш чи ганцаараа өнгөрөөх болбол яах вэ? Би чинь, сургуулилттай шүү дээ.

-Битгий зов, би ганцаараа дөнгөнө.

Хаалгач эр тэдний чемоданыг өрөөнд оруулж ирсний дараа Филипп Ларад,

-Би театр руу явах боллоо. Венец гайхалтай хот шүү, үзэж сонирхоорой! Орой болтол түр баяртай! гэв.

Амраг хоёрын уруул золголдон

чангаар үнсэлцлээ.

-Үгүй, би хаашаа ч явмааргүй байна гэж Филипп тачаадан шивнэв.

Лара түүнийг дуртай дургүй түлхэн холдуулж,

-Амжилт хүсье! гэв.

Түүнийг явмагц Лара Келлер руу залгавал,

-Чи чинь хаа явна аа? Чамайг хоёр хоног хайлаа гэж Говард тэсгэлгүй асуув.

-Венецид байна.

Удтал дуугуй болсны эцэст,

-Яасан суваг худалдаж авах гээ юу?  
хэмээн Говард ёжтойхон асуухад нь,

-Чи яаж таав аа? хэмээгээд Лара тас  
тас хөхрөв.

-Лара, чи энд их хэрэгтэй байна!  
Фрэнк Роузад муугүй төлөвлөгөө  
байна. Төлөвлөгөө нь ч надад  
таалагдаж байна л даа, гэхдээ чиний  
зөвшөөрлийг авмаар... гэхэд нь  
Лара,

-Таалагдаж л байвал-ажлаа эхэл!  
гэж эрс хариулав.

-Чамд жижиг сажиг юм ч сонин биш байна уу? гэж Говардын урам хугарсан нь илт мэдэгдэв.

-Дараа больё. Говард аа. Дараа боломз.

-О'кэй. Тэгвэл Вест-Сайдын хэлэлцээрийн тухайд... чи зөвшөөрч... гэтэл Лара үгийг нь тасдан,

-Зөвшөөрч байна гэж үгийг нь гүйцэд сонсолгүй хариулав.

-Лара чи зүгээр үү? гэх Говардын дуу гайхаж цөхрсөн янзтай байв.



-Би хэзээ ч ийм сайхан байхыг мэдэрч байгаагүй юм байна.

-Чи хэзээ ирэх юм бэ? гэж Говардыг асуухад нь,

-Мэдэхгүй ээ. Би утасданаа. Говардаа гээд Лара харилцуураа тавьчихлаа.

Венец үлгэрийн ид шидээр биелсэн гэлтэй үзээд ханамгүй үзэсгэлэнтэй хот байлаа. Лара Гэгээн Маркийн талбайгаар, жуулчид пиг Дүүрсэн Вева ден Скьявонаар аажим алхлан явах зуур Филиппийн тухай бодож явлаа. Лара явсан газрын гарын бэлэг болгон нарийн бичгийн дарга

нартаа аахар шаахар хүзүүний  
ороолт, хүзүүтэй цамц, түрийвч,  
Говардад маш үнэтэй зангиа  
авахаар ганган дэгжин хаягаараа  
даллан дуудах нарийи гудамж тийш  
эргэв. Лара үнэт эдлэлийн  
дэлгүүрээс Филиппэд алтан  
оосортой "Пьяж" цаг худалдаж  
аваад,

-Та дээр нь: "Филиппэд Ларагаас,  
хайртай" гэж сийлж өгөөч гэж Лара  
хайрт хан хүүгийнхээ нэрийг  
дурьдахдаа түүнийг ихэд үгүйлжээ.

Филипп таван цагийн алдад зочид  
буудалдаа эргэж ирлээ. Тэд буудлын  
задгай хашаанд суун кофе ууцгаах

зуур Лара эрэлхэг царайнаас нь харц  
үл салган: Бал сараа энд өнгөрөөвөл  
мөн сайхнаа! хэмээн бодов.

-Үүнийг чамд гээд Лара бэлгийн цаг  
хийсэн хилэнгээр бүрж чимэглэсэн  
савыг түүнд өглөө.

Филипп савыг нээж үзээд толгой  
сэгсэрч,

-Тэнгэр минь! Энэ чинь тэр чигээрээ  
бөөн мөнгө байна шүү дээ! Яах гэж  
тэр вэ, Лара? гэв.

-Чамд таалагдахгүй байгаа юм уу?  
хэмээн Лара урам хугаран асуувал  
Филипп,

-Маш их таалагдаж байна. Гэвч чи...  
гэхэд нь бүсгүй үгийг нь таслан,

-Чш-ш! Дуугүй зүүгээд, намайг  
бодож яв гэв.

-Чиний тухай бодоход бэлэг сэлтний  
хэрэггүй шүү дээ. Баярлалаа!

-Бид хэдэд театрт очих ёстой билээ?

-Долоод очноо.

Лара бриллантаар чимсэн цагаа  
хяламхийн харж,

-Тэгвэл бидэнд хоёр цагийн зай  
байгаа юм байна даа хэмээн

дүрсгүйтэн хэлжээ.

Театр үзэгчидээр пиг дүүрсэн байлаа.

Хөтөлбөр дуусмагц Лара тайзны араар явж очвол мөн л Лондон, Амтердам, Парижид болсон шиг хорь гаруй хүүхнүүд Филиппийг хоргоон зогсоцгоохыг хараад:

Хэрэв би байгаагүй боя тэр эдний хэнтэй нь шөнийг өнгөрөөх бол доо? гэсэн бодол зурсхийн орж ирэв.

Ресторанд орвол зочид буудлын эзэн Арриго Кипприанни Филиппийг элэгсэгээр угтан,

-Эрхэм ээ, тантай уулзана гэдэг ямар аз завшаантай хэрэг вэ! Мөн хатагтай таныг ч гэсэн! Орцгооггун, тавтай морилцгоогтун! хэмээн нахилзан ёсорхоод танхимын буландахь ширээ тийш хөтөллөө.

Филипп нэг шил "Беллини" дарс авчрахыг хүсээд,

-Эндхийн хоол сайтай газар шүү гэв.

Гэвч хожим нь тэд юу идсэнээ огт санахгүй байжээ. Дурлалд мансуурч яваа нь Филиппийг гэнэт түгшээж эхлэв. Толгойд нь: Чадахгүй, нуруун дээрээ үүрэг хэмээгч ачааг үүрч чадашгүй нь. Энэ огтын боломжгүй

хэрэг. Би чинь хэн сэн билээ дээ?  
Нүүдэлчин эр шүү дээ! гэсэн бодол  
эргэлдэнэ. Лара Нью-Йорк буцаж тэд  
салах нь гарцаагүй болчихоод  
байгаа нь түүний цээжийг маажих  
шиг болох авч Филипп юуг ч  
өөрчилж чадахгүй нь.

Хооллож дууссаны дараагаар  
Филипп,

-Лидод нэг аятайхан казино байдаг  
юм. Чи тоглох уу? гэхэд нь Лара  
инээд алдлаа.

-Юу нь инээдтэй байна вэ?

Бүсгүй барилгын бизнесийн хүрдэнд

эргэлдэж буй олон зуун сая  
долларын тухай бодоод,

-Зүгээрээ, явцгаая! гэв.

Хөлөг онгоц тэднийг Лидо арал дээр  
хүргэж ирлээ.

Тоглоомын байшингийн агуу том  
цагаан ордон тохьтой дэгжин  
жентельменүүд, бриллиант  
гялалзуулсан ганган дагуул  
хүүхнүүдээр пиг дүүрчээ.

-Мөрөөдөгчид! гэж Филипп ёгтлон  
хэлэв.

Ногоон цэмбэн бүтээлэгтэй



ширээний ард суугаад хагас цаг  
болсны дараа тэрээр,

-Лара, намайг аз дайрах гээд байсан  
юмаа. Чи надад амжилт авчирлаа  
хэмээн дуу алджээ.

Үүрийн 3 цагт Лара, Филипп хоёр  
казиногоос гараад, дахиад л гол нь  
харлан өлссөцгөөснөө мэдлээ.

Хүргэж өгсөн хөлөг онгоц нь тэднийг  
буцаан Гэгээн Маркийн талбайд  
хүргэж өгөхөд тэд Дундад зууны  
гудамжаар зуугаад метр алхаад  
Филипп "Кантина до Мори"-гийн  
үүдэнд зогсов. Филипп Ларад  
хандаж,

-Энэ Венецийн шилдэг бакаро шүү гэв.

-Эргэлзэх юм алга. Бакаро гэж юу юм бэ? гэж Лара асуув.

-Далайн хишгээр бэлтгэсэн жижигхэн сэндвич өгдөг дарсны мухлаг.

Нүсэр чулуун шат эртний зэс дэнлүү унжуулж, ханын дагуу шил үлээх урлагаар бүтээсэн эрхэм дзэж бүтээлүүдийг ярайтал өрсөн тохиолог танхимд орцгоов.

Үүр цайж байхад тэд буудалдаа эргэж ирэн Филиппийн өрөөнд

орлоо.

Хувийн "Боинг" онгоц өглөө эрт  
Венийн зүг жолоогоо заллаа.

-Тэнд чамайг тэс өөр эрин зуун  
хүлээж байгаа. Олон улсын агаарын  
тээврийн нисэгч нар: "Ноёд, хатагтай  
нараа. Манай онгоц Венийн нисэх  
буудалд газардах гэж байна.

Сандлынхаа түшлэгийг гэдийлгээд,  
тамхи татахаас түдгэлзэж хүлээнэ үү.  
Таны цагийн зүү зуун жилийн өмнөх  
үед очно гэдгийг бүү мартаарай" гэж  
зарлах дуртай байдаг юм хэмээн  
Филиппийг бахдалтайяа ярихыг  
сонсоод Лара инээмсэглэв.

-Энэ хотод миний эцэг эх гэрэлт хорвоод мэндэлсэн юм Тэдний ярихыг сонсоод би атаархаж үхэх шахдаг байлаа.

Машин Рингитрассээр явж байх зуур Филипп үнэгэй гоё тоглоомоороо гяйхуулан хөөрөх хүү шиг,

-Энд Моцарт, Гайди, Бетховен амьдарч... Өө, өршөөгөөрэй, чамайг сонгодог хөгжмийн мэргжилтэн гэдгийг таг мартаж орхиж гэв.

Машин "Империал" зочид буудлын үүдэнд зогслоо.

-Хонгор мииь, би концертын танхим

руу очих хэрэгтэй байна. Гэхдээ  
хоёул маргааш бүхэл өдрийг  
хамтдаа өнгөрөөнө гэж тангараглая.  
Би чамд Венийг үзүүлнэ гэхэд нь  
Лара инээмсэглэн,

-Маргааш хурдан болоосой хэмээв.  
Филипп Лараг чангаар тэврэн,

-Одоо цаг завгүй нь харамсалтайяа  
гэлээ.

-Тиймээ, харамсалтай. Филипп  
түүний духыг нь энхрийлэн үнсээд,

-Зүгээрээ, шөнө нөхөмз гэв.

-Амлалаа шүү. Чи!

Концерт "Музикверайн"-ны танхимд боллоо. Филипп Шопен, Шуман, Прокофьевыг тоглон гялалзсан амжилттай өндөрлөв.

Жүжигчний хувцас солих өрөөнд хөл тавихын эцэсгүй дүүрчээ. Хаа нэгтээгээс немц хэлээр,

-Ноён Адлер та биднийг алмайруулж орхилоо!

-Миний талархлыг хүлээж...

-Австри орон танд их өртэй... гэхчилэн дуу алдацгаахад Филипп тэд бүгдэд юу ч юм нэгийг хариулах авч түүний харц Ларагаас салсангүй.

Тэд "Империаал" буудалд  
хооллохоор зоогийн танхимд орох  
зуур,

-Ноён Адлер та бидэнд гүн хүндэтгэл  
үзүүллээ. Би хоёр дугаар эгнээнд  
сууж байсан шүү. Гойд сайхан  
тоглолт болсон. Гойд сайхан! хэмээн  
хаалгач эр дуу алдан угтав.

-За даа, энэ ч дэгсдүүлж байна гэж  
Филипп түүний амнаас бэлэн зэхий  
урсах найрсаг үгсийг даруухнаар  
таслав.

Рестораны хоол тансаг гэдэг нь  
тоймгүй байсан ч бие биесэд шунан  
татагдах мань хоёр хоолны

тансагийг тэгтэл мэдэрсэнгүй янзтай  
Филипп Лараг залгичихна уу гэлтэй  
гөлийн ширтэж байснаа, сөөнгөтсен  
тасалданги дуугаар,

-Явцгаая? гэжээ,

\* \* \*

Нэг л биш болоод байгааг зөв совин  
нь түүнд өгүүлнэ. Лара хэзээ ч хэл  
сураггүй алга болдоггүйсэн, эсвэл  
хүүхэн түүнээс зориуд зугтаад байна  
уу? Хэрэв тийм бол ямар нэг  
шалтгаан байх ёстой.

Би үүнийг хэрхэвч зүгээр  
өнгөрөөхгүй хэмээн Пол Мартин



гансран бодно.

\* \* \*

Хөшигний цаанаас сарны туяа  
өрөөнд дураар нэвтрэн орж ирээд  
хана даган сүүдэгнэн бүжиж найгаж  
эхлэв. Лара, Филипп хоёр саран  
авхайн бүжиглэхийг үг дуугүй  
ажиглан орондоо хэвтэнэ. Сарны  
туяа нэг нийлэн, нэг салан улам  
хурдлан бүжлээ. Гэнэт салхи  
сэржигнэж хөшгийг сэвж сарны туяа  
алга боллоо.

Өглөө нь Филипп.

-Бидний мэдэлд бүх л өдөр байна.

Би чамд их юм үзүүлэх ёстой гэлээ.

Өглөөний цайны дараагаар тэд нар машин явах хориотой Картнер-штрасс тийш яаралгүйхэн алхаллаа. Олон дэлгүүрийн шилэн үзмэрт зорчигчдод зориулсан гоёмсог хувцас, алдартай гоёл чимэглэл, хуучны эд өлгийн зүйлсийг дэлгэн тавьжээ.

Филипп гоёмсог сүйх тэргэний дэргэд очиж улаач эртэй хэд гурван үг солилцоод тэд сүйх тэргийг эзэгнэн цэцэрлэгт хүрээлэнгийн зүг хурдаллаа. Тэд Шеннбрунскийн ордонг, үдээс хойш нь морин тойруулгыг хоёр тасалбар аван

цэвэр цусны араб морьдыг жавхаалаг үзүүлбэрийг үзлээ. Дараа нь тэд орчныг ажиглах аялалын аварга дүүжинд сууцгаажээ.

Тэд доош бугаад амтат нарийн боовороо нэрд гарсан "Демаль" нэртэй кофейны газрыг чиглэв.

Ийнхүү аялах зуурт Лара гоёмсог бараккогийн хэв загвар орчин цагийн модернизмын чиглэлтэй эв нийлэн зохицсон уран барилгын хийцийг бахдан явжээ. Харин Филипп хөгжмийн зохиолчдын тухай л ярьж явсан байна.

-Лара, чи Франц Шуберт эндээс эгэл

дуучнаас эхэлсэн гэдгийг мэдэх үү?  
Тэр Эзэн хааны найрал дуунд  
оролцдог байсан бөгөөд арван  
долоон настай байхад хоолой нь  
эвдрэнгүүт түүнийг хаалганы цаана  
өшиглөх нь шахуу гаргаж хаясан  
гэдэг юм. Залуу эрд хөгжимд хүчээ  
сорьж үзэхээс өөр сонголт үлдээгүй  
гэсэн хэмээн хуучлан ярив.

Гудамжны зуушны газарт хоолонд  
орсон тэдэнд тийм ч их хугацаа  
орсонгүй. Дараа нь Гринцингэд  
хөнгөн зууш идэж, хундага цагаан  
дарс шимэн суух зуур Филипп,

-Дунай мөрнөөр зугаалбал ямар  
байна? гэхэд,

-Дуртайяа гэж Лара дуу алдав.

Орой болж, намуухан салхи исгэрэн, үдшийн гялаан тэргүүлсэн ганц хоёр одод тэнгэрт гялтгаж эхлэв.

Тэд биднийг аз жаргалтай байгаад баярлан гэрэлтүүлж байна. гэж Лара хөгжилтэй гялалзах оддыг харан бодов.

Аялалын хөлөг онгоцны тавцан дээр "Хөх Дунай" гэдэг аялгуу намуухан эгшиглэнэ.

Тэртээ алсад тэнгэрийн хаяанд од харвахыг харсан Филипп,

-Хүслээ бодож амжив уу? гэж асуухад нь Лара нүдээ аньлаа.

-Амжсан уу? гэж тэр дахин асуухад нь,

-Амжсан хэмээн Лара шивнэх шахам бувтнав.

-Чи юу хүссэн бэ?

-Хэлэхгүй, хэлчихвэл биелэхгүй гэснээ Лара: Заавал биелэх ёстой гэж боджээ.

Филипп хөлгийн хашлага тохойлдон,

-Сайхан байна шүү, тийм ээ? гэж

асуухад нь,

-Фил ээ, үргэлж ийм сайхан байж болно ш дээ гэж Лара хэлэв.

-Чи юу гэж хэлэв ээ?

-Хоёулаа яагаад гэрлэж болдоггүй юм бэ? хэмээн Лара хариу асуув.

Товч тодорхой, бас тун ч ойлгомжтой асуулт байв. Сүүлийн хэдэн өдрийн туршид Филипп өөрөсөө нэг бус удаа ингэж асуусан. Тэр Ларад хайртай гэдэгт эргэлзэх юм алга. Эргэж хоргон түдгэлзээд байхын хэрэггүй атлаа даанч ийм холбоо тогтоож болошгүй нь ээ.

-Лара, энэ бүтэшгүй хэрэг.

-Яагаад тэр вэ? Болохгүй гэх ямар шалтгаан байна?

-Би тайлбарласан шүү дээ, хонгор минь. Би чинь дэвэн дэлхийгээр хэсэж явдаг хүн. Чи ч гэсэн үргэлж ийш тийш тэнэж байхыг хүсэхгүй биз дээ? гэж арга мухардсан Филиппийг хэлэхэд,

-Тэр ч тийм л дээ, гэхдээ... хэмээн Ларан ам нээсэнд Филипп,

-Бүтэхгүй, огт бүтэхгүй. Маргааш би чамд Парижийг үзүүлэмз... гэж үгийг нь таслав.



-Фил ээ, би Париж нисэхгүй ээ.

Адлерт буруу сонссон мэт санагдан  
гайхаж,

-Яагаад тэр вэ? гэв.

Лара гүнзгий санаа алдаад,

-Бид дахин уулзахгүй гэв.

Филиппийн нүд нь харанхуйлаад  
ирлээ.

-Яагаад тэр вэ. Лара! Би чамд  
хайртай шүү дээ!

-Би ч гэсэн чамд. Фил ээ, би чинь  
балчир охин биш, би чиний араас

шүтэн бишрэгчдийн дунд ороод  
гүйж явж чадахгүй. Надтай надгүй  
шүтэн бишрэгч бүсгүйчүүл юу эс  
мундах вэ хэмээв.

-Лара, надад чамаас өөр хэн ч  
хэрэггүй. Гэхдээ бидний гэрлэлт тун  
удахгүй салалтаар төгсөнө гэдгийг чи  
ойлгооч. Чамд ч, надад ч, бидний  
хэнд ч илүү эрхэм болсон хувийн  
амьдрал байна. Хоёул үргэлж  
хамтдаа байхыг хүслээ ч энэ  
боломжгүй хэрэг.

-Тэгэхээр миний зөв байжээ. Бид  
дахин уулзахгүй гэх Лара жихүүдэс  
даан хүйтнээр өгүүлэв.

-Байз л даа, гуйж.., Алив хоёул өрөөндөө очье, тэгээд ярилцая...

-Үгүй ээ, Филипп ээ. Би чамд хайртай, гэсэн ч үгүй. Бүх юм өнгөрсөн.

-Би итгэхгүй байна. Чи бодлоо өөрчлөх болно.

-Санасны гарз биз. Уучлаарай.

Буудал хүртэл тэдний хэн нь ч ганц ч үт дуугарсангүй. Цахилгаан шатны дэргэд зогсох тэр мөчид Филипп,

-Миний өрөөнд орцгооё, хүн хэлээрээ мал хөлөөрөө гэдэгсэн,

зөвлөлдөө... гэв.

-Үгүй, хонгор минь үгүй.

Өрөөний босгыг алхуут утас нь хангинан дуугарах сонсогдож Лара үүдээ ч хаалгүй харилцуур тийш ухасхийв.

-Фил ээ...

-Би Говард байна аа. Бүхэл өдөржингөө чамтай ярих гэж... гэх сонсогдов.

Лара урам хугарснаа арай ядан дарж,

-Ямар нэг асуудал гараа юу? гэв.

-Бурхны авралаар үгүй л дээ. Ердөө л ажил гэж толгойтой үснээс их болчихоод байна. Чамайг хэзээ ирнэ гэж хүлээж байх вэ? хэмээн Говард үнэхээр түүнийг үгүйлсэн бололтой асуув.

-Маргааш. Өглөө гэхэд Нью-Йоркод очсон байна гэж бодож байна гээд Лара харилцуураа тавьлаа.

Дахин утас дуугарахыг хүлээсээр хоёр цаг суух авч, утасны аппарат таг чимээгүй. Би засахад бэрх алдаа хийжээ. Ингэж тулган шаардахын хэрэг юу байв аа? Би түүнийг алдсан.

Хүлээж л... Хэрэв Парижид... хэрэв...  
хэрэв. Бүсгүй хамтын амьдралынхаа  
хөргийг ургуулан бодохыг оролдсон  
боловч бүүдгий зэвхий саарал  
өнгөөр будагдана. Энэ янзаар  
үргэлжилж болохгүй! Бид хоёр  
биедээ зориулагдан бүтээгдсэн!  
Лара хувцсаа ч тайлалгүй орон  
дээрээ хэвтэж, утсаа дэргэдээ тавив.

Нойр нь хүрэх янз алга.

Гэсэн ч нэг мэдэхэд Лара бөх гэгч нь  
унтсан байлаа.

Филипп яг л торонд хашигдсан  
золгүй зэрлэг араатан лүгээ адил  
өрөөн дотуур ийш тийш холхино.

Тэрээр өөрийн эрхгүй өөрийгөө  
болон Лараг хорсон зүхэж нударга  
зангидах ажээ.

Хүүхнүүдийг хараал идэг! Аав нь:  
Чиний амьдрал бол-хөгжим. Оргилд  
нь хурэхиин тулд бусад юмыг март!  
гэж захисансан. Ларатай учиртал энэ  
бүхнийг умартаж чадсан. Гэтэл одоо,  
одоо яах нь энэ вэ? Чөтгөр ав!  
Хамтдаа баивал бид хоёр ямар аз  
жаргалтай байна гээч! Тэр нагаад  
энэ бүхтшг нурааж....

Хайр сэтгэл ч намайг Ларатай  
албадан гэрлүүлэхгүй.

\* \* \*

Утас хангинан дуугарч Лараг бөх  
нойрноос нь сэрээхэд Лара нүдээ  
нухалсаар өндийн суугаад биеийн  
чилээг гарган суняв. Өглөөний  
зургаан цаг болж байлаа. Лара  
нойрмоглосоор харилцуурыг  
тэмтчин аваад,

-Говард уу? гэлээ.

Гэтэл Филиппийн дуу гарч,

-Хуримаа Парижид хийвэл ямар вэ?  
гэх нь тэр.

Хорин дөрөвдүгээр бүлэг.

Лара Камерон, Филипп Адлер нарын



гэрлэлтийн тухай сурвалжлага  
дэлхийн бүх л улс орны сонин  
хэвлэлээр нийтлэгджээ.

"Нью-Йорк таймс" сонинг хажуу  
тийш нь чулуудаж орхиод Говард  
амьдралдаа анх удаагаа мал  
болтлоо уужээ. Нэгэнт захирагдахаа  
больсон уруул ам нь: "Энэ зүүд, нэг  
мэдэхэд л би сэргэнэ. Лара бид хоёр  
нэг баг, бид хоёр бие биедээ  
зориулагдсан. Бидний дундуур хэн ч  
орох ёсгүй хэмээн үглэнэ.

Мансууртлаа уух нь хоёр өдөр  
үргэлжилж, гурав дахь өдөртөө  
эрүүлжсэн Говард Париж руу ярив.

-Хэрэв бүгд үнэн бичээд байгаа юм бол Филиппэд: Чи туйлын азтай эргэдгийг дамжуулаарай гэхэд нь,

-Бүгд үнээн хэмээн Лара батлав.

-Дууг чинь сонсоход чи ч гэсэн сэтгэл хангалуун байгаа юмаа даа?

-Тиймээ. Төсөөлөх ч юм биш.

-Лара, би чиний өмнөөс их баярлаж байна шүү. Хэзээ эргэж ирэх гэж байна даа?

-Фил маргааш Лондонд тоглолттой. Тэндээсээ Нью-Йорк орно.

-Чи Пол Мартинтай ярьсан уу?  
хэмээн Говардын гэнэт асуухад нь  
Лара тэр даруй хариулсангүй хэсэг  
чимээгүй байснаа, -Үгүй ээ, яриагүй  
гэв.

-Миний бодлоор, ярих л хэрэгтэй  
байсан юм хэмээн Говард түүнийг  
буруушаан зэмлэв.

-Чиний зөв өө. Би очингуутаа л ярина  
гэх Ларад Полтой зайлшгүй ярина  
гэдэг нь далан булчирхайгаа тоочин  
үнэнээ хүлээхээс илүүтэйгээр түүнийг  
түгшээх ажээ.

-Уулзахыг тэсэн ядан хүлээж сууя.  
Чамайг их үгүйлж байна шүү гэж

Говардыг хэлэхэд,

-Говард аа, би ч гэсэн чамтай уулзахыг ихэд хүсч байна гэх Лара огт худал хэлсэнгүй.

Түүнгүйгээр би хэн байх байсан бипээ гэж боджээ. Хувийн "Боинг" хөлгийн дугуй онгоцны буух зурвасын замаар тоормослон мөрөө үлдээсээр газардаж, тэднийг анан хүлээж байсан сурвалжлагчид хөл мэдэн хурдлав.

Ла-Гуардиагийн зорчигчидод зориулсан хоолой тийш их биеэн наан зогслоо. Шатны дэргэд зогсох нисэх буудлын менежер,

-Хамгаапагчид тэднийг талбайгаас гарга гэж тушааж чадах байна хэмээн шивнэв.

Лара Филиппэд хандан,

-Эдэнтэй ганц уулзаад, гараас нь мултрая. Тэгэхгүй бол биднийг хэзээ ч амар заяа үзүүлэхгүй байх болно гэв.

-Тэлье хэмээн Филипп зөвшөөрчээ.

Гэнэт зохиогдсон хэвлэлийн хурал хоёр цаг шахам үргэлжлэв.

-Та нар хаана танилцсан бэ?

-Та урд сонгодог хөгжмийг эрхэмлэн сонирхож байсан уу, хатагтай Адлер аа?

-Танилцаад хэр удаж байна вэ?

-Та нар Нью-Йоркод амьдрах уу?

-Ноён Адлер та тоглолтоо орхих уу?

Энд тэндээс эцэс төгсгөлгүй булсан асуулт дуусч Лара, Филипп хоёр хүлээж байсан лимузин рүүгээ явцгаав. Бас нэг машин ачаа тээшийг нь авахаар зогсож байлаа.

-Би ийм тансаг байдалд дасаагүй шүү гээд тансаг хэрэглээний машины

арьсан суудалд суух зуур Филипп хэллээ.

-Дасна аа! гээд Лара инээв.

-Бид хаачих юм бэ? Тавин долдугаар гудамжинд миний байр байдаг юм шүү дээ гэж Филиппийг хэлэхэд нь,

-Манайд илүү тохьтой гэж бодож байна. Үзэж хараад, таалагдвал эд хогшлоо авчирна биз дээ хэмээн Лара түүнийг тайтгаруулав.

Лимузин "Камерон Плаза"-гийн үүдэнд ирж зогслоо. Филипп Ларад хандаж.

-Энэ барилга чинийх юм уу? гэв.

-Ганц минийх бишээ. Хэд хэдэн банк эзэмшдэг юм.

-Сэтгэл хөдөлгөж байна шүү.

Лара түүний гарыг атган,

-Сайн байна, би үүнийг л хүсэн хүлээж байсан юм шүү гэв.

Гантиг чулуун шалтай үүдний танхимын энд тэндгүй ваартай гоёмсог цэцгээр чимжээ. Цахилгаан шатны үүдний дэргэд хэдэн арван нөхөд нь,



-Гэртээ тавтай морил, хатагтай  
Адлер аа! Тантай уулзсандаа  
баяртай байна, ноён Адлер аа!  
хэмээн найрсагаар угтахыг харсан  
Филипп гайхан алмайрчээ.

-Гэгээн гэрэлт Бурхан минь гэж! Энэ  
бүхэн чинийх юм уу, Лара? хэмээн  
түгдчин асуухад нь Лара,

-Биднийх ээ, хонгор минь гэв.

Цахилгаан шатны бүхээг аажим  
өгсөж, дөчинтавдугаар давхрыг  
бүхэлд нь эзэгнэсэн пентхаусын  
үүдэнд хүргэж ирэв. Үйлчлэгч эр  
нахилзан гэрийнх нь үүдийг нээж  
өгөн,

-Хатагтай Адлер аа, эргэж ирсэнд чинь баяртай байна! гэлээ.

-Баярлалаа, Симмс ээ.

Лара нөхрийгөө эртний чамин гоё цуглуулгын танхим, уужим саравчит тагт, зочны өрөөний ханын зуух, зоогийн танхим, эздийн унтлагын өрөө, зочдын дөрвөн унтлагын өрөө, үйлчлэгчдийн гурван өрөө, номын сан, ажлын өрөө бүхий гэр орноо мухар ч үлдээлгүй танилцуулаад,

-Фил ээ, ямар байна даа? Дасах нь уу? гэж асуув.

Адлер инээмсэглэн,

-Бага зэрэг давчуу л юм, гэвч болно биз дээ хэмээн хошигнов.

Цуглуулгын танхимын гол дунд жинхэнэ концертын "Бехштейн" гэдэг төгөлдөр хуур хун цагаан өнгөө гялалзуулан байхыг Филипп хараад дөхөж очин товчлуурыг нь дарлаа.

-Дуу хуур ч гэж янзтай эд байна шүү гэв.

-Энэ чамд өгөх миний хуримын бэлэг. I

-Арай үгүй байлгүй дээ гээд тэр төгөлдөр хуурын ард суун Бетховены "Талархал" хэмээх магтаалын

аялгууг тоглолоо.

-Биднийг ирэхэд хуурыг хөглөсөн байхыг тушаасан юм. Таалагдаж

байна уу хэмээн Лара булаг мэт эцэс төгсгөлгүй ундрах хөгийг сонсон асуухад нь,

-Асуух юу байх вэ? Лара минь, юу гэж хэлэхээ ч сайн мэдэхгүй нь гэлээ.

-Юу ч битгий хэл. Тогло доо, хонгор минь гэхэд нь Филипп төгөлдөр хуурын араас хэдийнэ босч,

-Дараа тоглоё. Эллерби руу ярих хэрэгтэй байна. Тэр миний эрэл

суралд гараа биз гэхэд нь Лара,

-Хонгор минь, утас номын санд бий гэлээ.

Лара ажлын өрөөндөө ороод, автомат хариулагчаа залгалаа. Пол Мартинаас ирсэн: "Лара. чи хаа явна? Охин минь, их санаж байна шүү," "Лара, чамайг нэгдсэн улсад байхгүй гэж бодлоо. Тэгээгүй бол чи ярих л байсан даа?... ", "Балчир охин минь, би санаа зовж эхэллээ, сураг чимээ өгөөч..." гэсэн хэд хэдэн бичлэг хадгалагджээ. Гэнэт Пол Мартины дуу өөрчлөгдөн: "Дөнгөж сая хуримын чинь тухай сонслоо Үнэн юм биз дээ? Бид ярилцах

хэрэгтэй" гэх сонсогдов.

Гэнэт босгон дээр инээд алдсан  
Филипп зогсчихсон,

-Энэ нууцлаг ноёнтон хэн бэ? гэж  
асуув.

Лара түүн рүү эргэн,

-Зүгээр л... хуучны танил маань  
гэлээ.Филипп Лараг тэвэрч,

-Нөхөр хардах ёстой юу? гэлээ.

-Нөхөр хэнтэй ч хардахын хэрэггүй.  
Чи бол миний хайртай цорын ганц  
хүн, чи үүнийг мэднэ шүү дээ..

Үдээс хойш Филипп төгөлдөр  
хуурынхаа ард суумагц Лара Пол  
Мартины утсанд залгавал тэр даруй  
харилцуурыг аван,

-Чи эргэж ирээ юу? гэх түүний дуу  
төмөр мэт хяхтнав.

-Тэглээ гээд бүсгүй ер бусын муу  
ёрыг совингоороо мэдрэн хамаг бие  
нь хүйт оргив.

-Лара, сонин содон мэдээ чинь  
намайг цочирдуулсан гэдгийг хэлэх  
ёстой.

-Өршөөгөөрэй, Пол оо... Би... Бүх юм  
гэв гэнэт ийм болчихлоо хэмээн

Лара түгдчив.

-Хэлэх ч үг алга.

-Өршөөгөөрэй.

-Бидний харьцаанд юу ч саад болохгүй гэж би бодож байсан сан. Бид бие биедээ хичнээн дотно...

-Тийм ээ, Пол оо, гэвч... гээд бүсгүйг дуугүй болоход тэрээр,

-Ярь, ярь хэмээв.

-Мэдэж байгаа биз дээ, би...

-Маргааш хоёулхнаа хооллоё.

"Виттель"-д шүү. Нэг цагт гэх нь тэр.



Энэ бол хүсэлт биш, харин хатуухан тавьсан тушаал байлаа.

Лара хэрхэхээ мэдэхгүй эргэлзлээ.  
Гэхдээ зовлонг эцэс төгсгөлгүй үргэлжлүүлэхийн хэрэг юу байна вэ?

-Тэгье, би хоцрохгүй ээ.

Харилцуурт утасны тасалданги дуу хангиналаа.

Маргааш Пол хичнээн их хонзогнож уурлах бол оо? Түүний хорсол хилэн нь юунд хүргэх бол?

## Хорин дөрөвдүгээр бүлэг.

Маргааш өглөө нь Лараг Камерон төвийн үүдээр орж очиход хамтран ажиллагчид нь цугларчихсан,

-Баяр хүргэе, хатагтай Адлер аа! -  
Ямар сайхан сюрприз гэгч энэ вэ?

-Таныг аз жаргалтай байна гэдэгт итгэлтэй байна шүү! гэх мэтчилэн найрсаг ерөөлөөр угтав.

Говард түүнийг өрөөнийх нь үүдэнд хүлээж байв.

-Сонгодог хөгжимд тэгтэл дурлаагүй бүсгүй гэхэд чи ихийг хийж амжжээ!

гээд Лараг чанга тэврэв. Бүсгүй чин сэтгэлээсээ инээн,

-Нээрэн үү? гэв.

-Би хатагтай Адлерт дасаж занших хэрэгтэй болох нь ээ! гэхэд бүсгүйн нүүр дүүрэн гэрэлтсэн инээд замхарчээ.

-Бизнесийн сонирхлын үүднээс би Камерон авхай хэвээрээ үлдвэл дээр гэж чи бодохгүй байна уу?

-Таны тааллаар больё, босс оо. Ямартаа ч чамайг эргэж ирсэнд би баяртай байна. Ажил гэж толгойтой үснээс их дээ, хөө.

Тэд Ларагийн ерөөнд орцгоон  
бүсгүй Говардын өөдөөс харан  
буйданд тухлан суугаад.

-За. ажлаар сонин сайхан юутай вэ,  
яриад байгаарай гэв.

-Вест-сайдын зочид буудалд их  
зардал шаардах нь байна. Сүүлийн  
өдрүүдэд Техасаас худалдан авагч  
тодроод байхлаар нь би объектыг  
биечлэн очиж үзлээ. Барилга ой  
гутмаар байна лээ, бүхэлд нь засах  
хэрэгтэй, гэтэл үүнд дор хаяж тав,  
зургаан сая доллар лав орох  
болчихоод байна.

-Худалдан авагч зочид буудлыг үзсэн

үү?

-Үгүй. Маргааш түүнийг аваачиж үзүүлэхээр тохирсон.

-Үзүүлэхээ долоо хоноогоор хойшлуул. Будаг шунхдах хэсэгчилсэн бригад хөлсөлчих. Худалдан авагчийг үзэхээр очиход нь хүн амьтан хөлхөж байг гэж Лара тушаалаа.

Келлер жуумалзан,

-Ойлголоо. Фрэнк Роуз нэг зураг авчраад миний өрөөнд сууж байгаа гэв.

-Үзье л дээ гэж Лараг хэлэхэд,

-Одоо "Мьючуэлл иншуранс"-ын тухай ярилцъя. Андуураагүй бол тэд шинэ барилгыг түрээслэхийг хүссэн гэл үү? За тэгвэл, гэрээнд гарын үсэг зураагүй байгаа. Компанийн удирдлага эргэлзээд шийдэж ядаж байгаа бололтой дог оо гэж Говард өгүүлэхэд Лард тэмдэглэлийн дэвтэртээ нэг юм тэмдэглээд,

-Би тэдэнтэй өөрөө ярилцана. Цааш нь ярь гэлээ.

-Готэмийн банкнаас дараагийн төсөлд далан таван сая доллар зээлэх болсон.

-Тэгээд юу гэж байна?

-Тэд өөрсдийн саналаа хэлсэн.  
Манай хугацааг дэндүү сунжируу  
гэж үзэж байна лээ.

-Тэдний хүү нь хэд юм бэ?

-Жилийн арван долоон хувь.

-Уулзалт товлочих. Би хорийг өгнөө.

Келлер айн толгой сэгсэрч,

-Хорин хувь гэнээ? Лара минь,  
бодолтой байсан нь дээргүй юу, хэн  
ч ийм хүү төлдөггүй юм! гэлээ.

-Би хорин хувийн дороос хуурай

гарч ирнэ. Харин арван долоон хувийн боол болж үхдэл шиг хэвтэхгүй гэж Лара шазруун хэлэв.

-О'кэй.

Ийнхүү Лара, Говард Келлер хоёр хэвшсэн заншлын дагуу хэлэлцэн суусаар үд дунд хүрч, нэг цагт арван тав дутуу байхад Лара, -Пол Мартинтай хамт хооллох ёстой гэв. Келлерийн сэтгэл түгшин,

-Болгоомжтой л байж үзээрэй, чамайг хамт идчих вий гэв.

-Үүнийг чинь юу гэж ойлгох болж байна?



-Пол Мартин бол сицили эр.  
Сициличууд юу ч өршөөдөггүй бас  
юуг ч мартдаггүй юм шүү.

-Говард аа, бид тайзан дээр  
жүжиглээгүй шүү. Юун мелодрам  
ярина вэ? Пол ийм жигшүүртэй юм  
хийх хүн биш.

-Тийм л байгаасай билээ гэж  
найдахаас даа.

\* \* \*

Лараг ресторанд орж очиход, Пол  
Мартин хэдийнэ ирчихсэн сууж  
байлаа. Тэрээр ихэд царай алдан,  
нүднийх нь доогуур хар хүрээ татсан

байхыг харсан Лара;

Нойргүй хоножээ дээ хэмээн бодов.

-Мэнд үү гэх Мартин босохыг ч хүссэнгүй.

-Сайн уу, Пол оо гээд Лара өөдөөс нь харан суув.

-Автомат хариулагчид чинь өч төчнөөн тэнэг яриагаа бичсэнийг минь уучлаарай. Хаа явааг чинь мэдэхгүй... гээд тэр мөрөө хавчисхийлгэв.

-Пол оо, би чамд хэлэх байсан юм. гэтэл бүх юм ингэж гэв гэнэт...

-Мэдэж байна, мэдэж байна гээд  
Мартин түүнээс харц салгалгүй  
ширтээд,

-Охин минь, чиний царай сэргэж  
сайхан харагдаж байна шүү гэв.

-Баярлалаа.

-Та нар хаа танилцаа вэ?

-Лондонд.

-Чи тэгээд тэр даруйд нь Адлер  
чамгүйгээр амьдарч чадахгүй  
гэдгийг ойлгосон хэрэг үү? хэмээх  
Полын дуунд харуусал тодорлоо.

-Пол оо, бидний холбоо үнэхээр сайхан байсан л даа, гэвч миний хувьд энэ нь нэг л хангалтгүй санагдаж байлаа. Сэтгэл зүрх минь ихийг шаардаж, надад орой болгон гэр рүү минь чангаах хэн нэгэн хэрэгтэй байсан юм шүү гэж Лараг өгүүлэхэд тэрээр ихэд анхааралтай чагнаж суув.

-Би чиний сэтгэлийг шаналгая гэж огт бодоогүй, ердөө л... ердөө л ийм л юм болчихлоо хэмээн Лараг үргэлжлүүлэхэд Пол бас л таг чимээгүй сууна.

-Ойлгохыг хичээж үзээч!

-За за гэх Мартины уруул дээгүүр  
хүйт оргим инээмсэглэл тодорч,

-Надад сонголт алга шив, тийм үү?  
Ам алдвал барьж болохгүй гэгчээр  
нэгэнт хийсэн юмыг буцааж болох  
биш дээ. Гэхдээ би, энэ тухай  
согиноос мэдээд жинхэнэ дайрлагат  
дайруулчих шиг болсон. Бид бие  
биедээ халуун дотно байсан юм шиг  
санагдаж билээ гэлээ.

-Чиний зөв өө. Би урьдчилж хэлэх  
ёстой байсан гом гэж Лара давтав.

Пол бүсгүйн хацрыг энхрийлэн  
илээд,

-Охин минь, чи ухаан бодлыг минь эзэмдэж, солиоруулсан шүү. Би одоо яг л эргүүтчихсэн төлег аятай явна. Чи миний хувьд гайхамшигт эрдэнэ минь байсан юм шүү. Би чиний хүссэн бүхнийг чинь, гагцхүү хуримын бөгжнөөс бусдыг нь өгч чадах байсан юм. Гэсэн ч би чамд хайртай хэвээрээ. Аз жаргалтай байгаарай гэв.

Ларагийн дотор нь уужран гүн амьсгаа авч,

-Баярлалаа, Пол оо хэмээв.

-Би хэзээ нөхөртэй чинь танилцах вэ?

-Долоо хоногийн дараа бид найз нарыгаа урина. Ирнэ биз дээ?

-Очноо. Адлерт чамайг сайн халамжлаарай, эс тэгвээс надтай уулзах хэрэг гарна шүү гэж хэлнэ.

Хүүхэн инээмсэглэн,

-Тэгээрэй л дээ! гэжээ.

Говард Келлер түүнийг оффистоо тэсэн ядан хүлээж байлаа.

-За, үдийн хоол ямаршуу болов доо?  
хэмээн түгшсэн янзтай асуухад нь  
Лара,

-Сайхан болсон. Чи дэмий санаа зовжээ. Пол жинхэнэ жентельмен шиг биеэ барьж чадлаа гэж хариулав.

-Тэр нь ч дээр биз. Маргааший чиний уулзалтыг товллоод... гэхэд нь.

-Хойшлуул. Би маргааш гэрээсээ хошуугаа ч цухуйлгахгүй. Бид хоёр бал сараа тэмдэглэж байгаа шүү дээ. Битгий ай, хэдхэн хоног л болно гэж Лара түүний үгийг нь таслан өгүүлэв.

-Чамайг аз жаргалтай байхыг харахад таатай байна.

-Энэ чиль л намайг айлгаж байна.



Өдөн дэрнээс толгой өндийлгөн босч  
иртэл энэ бүхэн зүүд байх юм шиг  
санагдах юм. Хүн хэзээ ч ийм аз  
жаргалтай байж болно гэж бодож  
явсангүй хэмээн Лараг хэлэхэд,  
Келлер инээд алдаад,

-За за, би уулзалтыг яаж ийгээд  
зохицуулья гэв.

-Баярлалаа гээд Лара түүний хацар  
дээр үнссэнээ.

-Долоо хоногийн дараа бид хоёр  
үдэшлэг зохионо. Чи уригдсан  
байгаа шүү гэжээ.

\* \* \*

Үдэшлэг бямба гаригт, тэдний тансаг пентхауст нь болов. Цардсан цагаан бүтээлгээр хучигдсан уртаас урт зоогийн ширээг тойрон зуугаад зочид хөлхөлдөнө. Лара хамт ажилладаг банкны эзэд, барилгачид, архитектор. хотын захиргааны түшмэд, Үйлдвэрчний эвлэлийн удирдагчидыг гэр бүлийнх нь хамтаар урьжээ. Филиппийн талаас мэргэжлийн хөгжимчид, тэдний спонсор, шүтэн бишрэгчид иржээ. Тэс өөр хоёр бүлгийн хүмүүс баярын үдэшлэгийг нь золтой л баллаж орхисонгүй.

Асуудлын гол нь хоёр бүлгийн хүмүүс яагаад ч санаа бодол нь

нийлсэнгүй. Тэд өөр өөрсдийн сонирхлыг эрхэмлээд байгаа нь үнэхээрийн төвөгтэй байх ажээ. Нэг туйл нь бизнес, архитекторын тухай халуун яриа өрнүүлж байхад нөгөөдөх нь зөвхөн хөгжим хүүрнэнэ.

Лара төлөвлөлтийн комиссын гишүүнийг гурвал хөгжимчид тийш аваачлаа, Туршлагатай нэрт эдийн засагч эр мэтгэлцээний утгыг ойлгохыг ихэд мэрийнэ.

-Чи Россини Вагнерийн дуурийг хэрхэн үнэлснийг мэдэх үү? Тэрээр бөгсөөрөө төгөлдөр хуурын товчлуур дээр нь лагхийтэл суугаад: Түүний

бүтээл чинь энэ дээ! гэсэн гэдэг.

-Вагнер шангаа хүртэх ёстой. Венийн театрт Тофманы үлгэрүүд"-ийг тоглож байхад гал гарч, дөрвөн зуугаад хүн түймэрт амь эрсэдсэн юм. Вагнер энэ тухай дуулаад: Оффенбахыг шунан дурлагчдын дээд зэргийн шийтгэл, үүнээс мултрахыг бодсоны гарз! гэж хэлсэн гэдэг хэмээн ярилцахыг сонссон эдийн засагч эр сэм холдон одлоо.

Эзэгтэй гүйцэтгэгч эрчүүдэд нөхрийнхөө хоёр найзыг танилцуулав.

-Хамгийн тавөгтэй нь гэрээ дуусахаас

өмнмө оршин суугчдын дор хаяж  
гучин таван хувь нь нүүж ирэх гээд  
байна гэж нэг бизнесмен нөгөөдөө  
тайлбарлахад цаадах нь,

-Хэрэв миний саналыг мэдэхийг хүсч  
байвал энэ цэвэр ус гэдэг шал дэмий  
ажил! гэлээ.

-Зөвшөөрч байна...Зочид буудлыг  
санаа амар эрхлэх нь дүнтэй дээ.  
Манхэттенд хамгийн даруухан өрөө  
нь хоногийн хоёр зуун доллартай  
байна шүү дээ. Жилийн дараа  
гэхэд...

Хөгжимчин эрс тэдний дэргэдээс  
чимээ ч үгүй холдлоо.

Хурсан зочид ийнхүү тэс өөр хоёр хэлээр ярьцгаана.

-Венчүүдийн ялгагдах онцлог нь ул мөргүй болсон хөгжмийн зохиолчдыг хайрладаг тэдний хайр...

-Шинэ цогцолбор 47, 48 дугаар гудамжны хоорондох хоёр талбайд байрлана. "Чейз-Манхэттен" барилгыг санхүүжүүлэхээр...

-Тэр тийм ч агуу удирдаач биш гэдгийг хүлээн зөвшөөрч байна, гэсэн ч түүний дохиур эзэмшсэн арга барилыг нь...

-Олонхи эгэл ардууд 1929 оны

хямрал эдийн засагт сайн түлхэц  
өгсөн гэж боддог юм билээ. Хүмүүс  
үл хөдлөх хөрөнгөнд мөнгө  
хуримтлуулах...

-... Горовец олон жил төгөлдөр  
хуурын ард суухаас татгалзсан, мань  
эр хуруунд нь шилний...

-... ерөнхий төлөвлөгөөг үзсэн. 8-р  
авеню дэхь гурван давхар барилга  
сонгодог зохицолтой, дотроо  
гулдман... гэхчилэн өөр өөрсдийн  
чиглэлийн яриа өрнүүлэх ажээ.

Пол Мартин ганцаараа иржээ.

Лара түүний ирснийг мэдмэгцээ

угтаж очин,

-Пол оо, хэлсэн амандаа хүрсэн чинь сайн байна гэж Лара хэлэхэд нь,

-Би ирэхгүй байж чадсангүй гээд тэрээр ийш тийш харан,

-Филипп хаа байна? гэлээ.

Лара түүнийг сугадан хамтран ажиллагчдынхаа дунд зогсох нөхрийнхөө зүг алхав.

-Хайрт минь, миний эртний анд Пол Мартинтай танилц гэвэл Филипп алхам урагшлан дөхөж,



-Тун таатай байна, эрхэм ээ гэв.

Эрчүүд гар барилцлаа.

-Ноён Адлер та ч азтай хүн юмаа.  
Лара гайхамшигтай бүсгүй шүү гэж  
Пол Мартиныг өгүүлэхэд,

-Өдөр, шонөгүй түүнд үүнийгээ  
батлаж байгаа гэснээ Лара  
инээмсэглэв.

-Үүнийг батлах гэхийн хэрэггүй шүү  
дээ, хонгор минь. Би мэднэ, би  
хичнээн их аз жаргалтай байна гээч  
хэмээн Филипп хэлэв.

Мартин түүний нүд рүү цэхлэн

хараад,

-Яс махандаа шингэтэл ойлгож байгаа биз дээ? гэх нь тэр.

Лара үүсч буй түгшүүрт байдлыг мэдрэн аюулыг зайлуулахаар.

-Пол оо, коктейль уух уу? гэвэл,

-Үгүй ээ, баярлалаа. Чи мартаа юу? Би уудаггүй шүү дээ хэмээн Полыг эгдүүцэн хэлэхэд бүсгүй уруулаа хазлан,

-Өө тийм л дээ. Тэгвэл чамайг зочидтойгоо танилцуулья гэлэ.

Тэд зочид хөлхөх танхим тийш эргэв.

Хөгжимчдийн хэн нэг нь хажуудах хүндээ,

-Маргааш "Карнеге-холл"-д Леон Флейшер тоглох гэнэ ээ. Ийм боломжийг алдаж болохгүй хэмээн дуртай дургүй үг солин сууснаа хажуу дахь Пол Мартин, Говард Келлер хоёрыг хялам хийн,

-Түүний тоглолтыг үзсэн үү? гэлээ.

-Үгүй.

-Энэ чинь жинхэнэ гайхамшиг!  
Тэгээд бас болоогүй, ганц гараараа

тоглохыг нь анзаараарай.

-Үгүй ер! Яагаад ганц гараараа тоглодог юм бол?

-Арван жилийн өмнө гэнэт Фляйшнерийн баруун гарт нь хэсэг газрын судасны бөглөрөлтийн хам шинж илэрсэн гэнэ лээ.

-Гэхдээ яаж нэг гараараа тоглож байна?

-Франц Шмидт, Корнгольд, Равель гээд олон зохиолчид зөвхөн зүүн гараар тоглоход зориулж тусгайлсан концерт бичсэн байдаг юм. Тэднийг ийнхүү ярилцах зуур бусад зочид

Филиппийг төгөлдөр хуураар тогло  
хэмээхэд,

-За тэгье. Би өөрийн тал бие минь  
болсон хайртдаа зориулья гээд  
Филипп хуурынхаа ард суулаа.

Танхим нам гүм пентхаус даяар  
Рахманиновын концерт эгшиглэж,  
агуу их сонгодог хөгжим зочдыг  
нөлөөндөө автуулав. Хөгжмийн  
эгшиг зогсож, нам гүм болоход алга  
ташилт нижигнэж пентхаусын хана  
доргих шиг боллоо.

Цагийн дараа зочид уван цуван  
тарж эхэлсээр, сүүлийн зочноо  
үдсэний хойно Филипп,

-Миний бодлоор тэд сэтгэл хангалуун явцгаалаа гэв. -Гэхдээ чи үдэшлэгийг үзэн яддаг шүү дээ! гэж Лараг хэлэхэд тэрээр эхнэрээ тэврэн,

-Яаж байна. Дургүй маань нүүрэн дээр ил байсан уу? гэв.

-Дараагийнхныг таван жилээс наана хийхгүй гэдгийг амлаж байна. Фил ээ, манайд янз бүрийн гаригийн хүмүүс ирсэн гэсэн мэдрэмж чамд төрөв үү? гэхэд нь,

Филипп түүнийг энхрийлэн үнсээд,

-Бурхан өршөөг! Бид ч өөрсдийн ертөнцдөө л амьдарч байна. Алив

хөө явж, жаргалаа эдлэцгээе! гэжээ.

## Хорин тавдугаар бүлэг.

Өглөөгүүр гэртээ ажиллахаар шийдсэн Лара, -Чамаасаа холдмооргүй байна гэж Филиппэд хэлэв. Кэти шинэ нарийн бичгийн даргыг ярилцлагад оруулахаар пентхаус тийш илгээжээ. Лара хорин тав орчим насны, мариалаг цовоо бүсгүй Мэриан Беллийг тэдний босгыг давах хүртэл арваад хүнтэй уулзаад амжжээ.

-Суугтун.

-Баярлалаа,авхай.

Лара бүсгүйн товч намтрыг гүйлгэн



үзээд, -Уэллсийн коллежийг төгссөн юм уу? гэв. -Тийм ээ.

-"Урлаг судлаач"-ийн мэргэжлээр төгссөн юм байна. Тэгээд яагаад нарийн бичгийн дарга болохыг хүсээ вэ?

-Авхай, би танаас ихийг сурч чадна гэж бодож байна. Би тэнцэх эс тэнцэх нь хамаагүй, гагцхүү би таныг эртнээс шүтэн биширч явдаг юм, хатагтай Камерон.

-Нээрэн үү? Яагаад тэр билээ?

-Та бол миний мөрөөдөл. Та өөрийн хүчээр оргилд нь гарч чадсан хүн

ЮМ.

Лара залуу бүсгүйг сонирхон харлаа.

-Манай ажил хүнд. Би өглөө эрт босдог. Таны ажлын байр энд байх болно. Өглөөний зургаад ирсэн байгаарай гэвэл бүсгүй,

-Хатагтай Камерон, ямар ч асуудал алга. Энэ миний анхны ажил биш гэлээ.

Мэриан бүсгүй Ларад үнэхээр таалагдсанд тэрээр инээмсэглэн,

-Туршилтын хугацаа долоо хоног шүү гэлээ.

Долоо хоногийн дараа хувь заяа нь түүнд жинхэнэ гарын бэлэг илгээсэн болохыг ойлголоо. Мэриан нягт нямбай, эрч хүчтэй, ажилтан болох нь мэдэгдэн, хоёр бүсгүй бие биедээ тун ч амархан дасчээ. Лара үдээс емнө гэртээ ажиллаад, үдээс хойш офис руугаа явдаг болов.

Өглөөгүүр гэр бүлийн хоёр цайлсны дараагаар Лараг нарийн бичгийн даргадаа захидал бичүүлж ойр зуурын ажлаа амжуулах зуур Филипп гурав, дөрвөн цаг төгөлдөр хуурын ард байнга суун гараа дасгалжуулж, заримдаа тэрээр Ларагийн хүсэлтээр шотландын эртний "Бяцхан Энни", "Хөх тариан талбай", "Байшингийн

дэргэдэх дов" гэдэг дууг тоглож, мөн тэд хоолой хоршин дуулцгаадаг байв. Үдээс хойш Лараг явахын өмнө тэд үдийн хоолоо идэцгээдэг болов.

-Надад Глэй-Бэйн тухай ярьж өгөөч гэж Филиппийг хэлэхэд,

-Өө, тэгвэл дор хаяж таван минут тэвчээр заан суух болох нь дээ гээд Лара инээв.

-За яах вэ, би чин үнэнээсээ хүсч байна.

Лара хөлсний байрны тухай дурссан боловч эцгийнхээ тухай ганц ч үг хэлж чадсангүй, харин Чарлз Коэны

тухай ярихад нь Филипп,

-Чамайг аз дайрчээ. Би түүнтэй  
дуртайяа уулзахсан гэлээ.

-Уулзаарай л даа.

Лара Шон Макаллистерын түүхийг  
нуусангүйд Филипп нударга  
зангидан ширээ шааснаа,

-Тэр өөдгүй новш үхвэл таарна!  
Хойшид чамайг хэн ч гомдоохгүй  
гээд Лараг чангаар тэвэрчээ.

Нөхөр нь тоглолтонд бэлтгэн  
намуухан, арай хурдан, бүр ч  
хурднаар эгшиглүүлэн тоглоход нь

тэр аялгууг Лара чагнан суудаг  
болов.

Лара, хөгжмийн аялгуунд уусан  
тоглож байх үед нь Филиппэд,

-Хонгор минь, найз нар маань  
биднийг хагас сайнд Лонг-Айлендад  
урьсан, тийшээ очих уу?

Эсвэл,

-Надад Нил Саймоны хоёр тасалбар  
өглөө.

Эсвэл,

-Говард биднийг оройн хоолонд

урьсан гэх зэргээр элдэвийг  
өгүүлэхэд нь Филипп тухай бүрд нь  
тэвчээртэй гэгч нь биеэ барьдаг  
байжээ.

Нэг удаа тэсгэл алдууран,

-Лара, тоглож байхад минь надад  
бүү саад болохыг мергөж гуйя.

Анхаарал сарниад байна гэжээ.

-Өршөөгөөрэй. Чамайг ингэж  
бодлогоширон дасгал хийхийн хэрэг  
юу байгааг нэг л ойлгохгүй юм. Чи  
одоохондоо тоглолтгүй байгаа шүү  
дээ гэж Лара хариулахад,

-Сургуулилт маань надад тоглох боломж өгдөг юм. Чи байшин барьж байхдаа хаа нэг газар нь алдаа мадаг гарвал чамд засах боломж гардаг биз дээ. Зураг хянаж байх зуур цахилгааны сүлжээнд өөрчлөлт оруулах хэрэг гарахад байшин баригдсаар л байдаг биз. Тэгвэл хөгжим тэгдэггүй, хөгжимд засаж засварлах хоёр дахь оролдлого гэж байдаггүй юм. Намайг тайзан дээр гарсан цагт нот өв тэгш зөв дуугарах ёстой гэлээ.

-Ойлголоо, хонгор минь. Уучлаарай. Филипп төгөлдөр хуурын ардаас босон түүнийг тэвэрч,



-Нэг хуучны яриа байдаг. Морин хийл барьсан нэгэн эр Тавдугаар авенюгаар явж байснаа төөрөн ийш тийш харан гайхаж хоцорч гэнэ, Тэр дэргэдүүрээ явах нэгэн эрхмийг зогсоон.

-Эрхэм ээ, "Карнеги Холл"-д яаж хүрэх вэ? гэтэл хариуд нь,

-Сургуулилах л хэрэгтэй дээ, эрхэм ээ. Урт удаан хугацааны сургуулилт хэрэгтэй гэж хэлсэн гэдэг гэв.

Лара хөхрөн,

-Тогло доо, тогло, би явлаа гэв.

Бүсгүй номын сандаа орж, хөгжим хангинахыг сонсон:

"Бурхан минь, яаж яваад надад ийм аз учрав аа, Мянга мянган хүүхнүүд миний оронд суугаад агуу Филипп Адлерыг дуртайяа сонсох байх даа! хэмээн боджээ.

Тэрээр энэ сургуулилт нь хааяа ч гэхнээ завсарлаж байвал зүгээр хэмээн үздэг ажээ.

Тэд оройдоо ханан зуухны дэргэд сууцгаан даам тоглодог агаад энэхүү мөчийг Лара бүхнээс илүү эрхэмлэдэг байлаа.

Риногийн Казиногийн нээлт болоход тоотой хэдхэн хоног үлдээд байв.

Зургаан сарын өмнө Жерри Таунсендтэй ярилцаж байхдаа Лара,

-Долоон уулын цаадах газрын оршин суугчид хүртэл энэ тухай мэдээсэй гэж би хүсч байна. Хүлээн авалтыг "Максим"-аас хөлсөлсөн ахлах тогооч бэлтгэнэ. Тэнгэрээс оддыг буулгаж ир, Фрэнк Синатраас эхлээд бүгдийг нь аажимдаа буулга. Зочдын жагсаалтанд Голливудынхныг бүгдийг урь. Нью-Йорк, Вашингтоны нөлөө бүхий улсуудыг урь! гэсэн байна.

Хагас жилийн дараа бүсгүй зочдын

нэрсийн жагсаалтыг хальт мөлт  
хараад,

-Жерри, та муугүй ажиллажээ. Хэдэн  
татгалзсан хариу авсан бэ? гэвэл,

-Хорин хоёрыг авсан даа. Зургаан  
мянгаас тэр шүү дээ гэжээ.

-Болж л байна хэмээн Лара урамтай  
өгүүлсэн аж.

Өглөө нь Говард Келлер утасдан,

-Лара, сайхан мэдээ дуулгая. Хагас  
цагийн өмнө Бернээс банкны эзэд  
наашаа ниссэнийг мэдэгдсэн.

Хэлэлцээр маргааш эхлэнэ гэв.

-Гайхалтай байна, Говард аа. Есөд офист уулзацгаая хэмээн баярласан Лара хариулав.

-Би тэдэнд дамжуулья.

Оройн хоол идэж суутал Филипп,

-Лара, маргааш би бичлэгтэй. Чи бичлэгт очиж үзээгүй байх аа, тийм үү? гэлээ.

-Тийм ээ, үзээгүй.

-Очиж үзэх үү? гэхэд нь бүсгүй эргэлзэн:

Швейцарийн банкны эзэдтэй хийх

уулзалт яах билээ? гэж бодсон атлаа,

-Тэгье гэгчхлээ.

Хооллож дууссаны дараагаар Лара  
ажлын өрөөндөө орж Келлер руу  
залган,

-Маргааш надгүйгээр эхэлж  
байгаарай. Би бага зэрэг хоцрох нь  
гэлээ.

Дуу бичлэгийн студи нь Гучин  
дөрөвдугаар гудамж дахь таазнаас  
нь аппарат дүүжилсэн агуулах шиг  
томоо гэгчийн байранд байрлах  
ажээ. Том заалны тэг дунд нь  
үйлчилж буй техникийн

мэргэжилтнүүдээс зузаан шилэн хашлагаар өвч битүү тусгаарласан хоргонд гучаад найрал хөгжимчид суужээ. Ларад энэ залхуутай ажил хэзээ ч дуусахгүй мэт санагдав.

Нэг засварлагаагаар нь Лара Келлер руу залгавал,

-Чи чинь хааччих ваа? Бид аахар шаахар зүйлийн талаар ярилцсан. Эд нар чамайг хүлээгээд байна! гэв.

-Цаг юм уу хоёр цагийн дараа очно. Зочдыг саатуулж бай гэжээ.

Хоёр цагийн дараа гэхэд бичлэг үргэлжилсээр л байв. Лара дахиад л

утас руу явж очин,

-Уучлаарай. Говард аа, очиж чадахгүй нь. Тэднийг маргааш ир гээч гэв.

-Лара юун яаралтай ажил гараа вэ?

-Миний нөхөр гээд бүсгүй утсаа тасалчихав.

Орой болсон хойно гэртээ ирсний дараа Лара,

-Ирэх долоо хоногт Рино орно гэвэл,

-Яах гэж байгаа юм бэ? гэж Филиппийн нүд нь орой дээрээ



гарах шахам бүлтийн асуув.

-Тэнд миний зочид буудал,  
казиногийн нээлт болно. Гурав  
дахьд онгоц захисан байгаа гэвэл  
Филипп,

-Ээ, ч-ч-чөтгөр! гэж хараав.

-Хонгор минь, юу болоо вэ?

-Уучлаарай, Лара, би чадахгүй ээ.  
Лара гайхаж,

-Яагаад чадахгүй гэж? хэмээвэл,

-Би хэлээгүй бил үү? Даваа гаригт  
аялан тоглолт эхлэнэ гэж Филипп их

л ажил хэрэгчээр хэлэв.

-Юун тоглолт билээ? гэсэнд,

-Эллерби зургаан долоо хоногийн аялал зохион байгуулж. Австрали... гэтэл Лара үгийг нь тасдан,

-Австрали ий? гэж гайхаж тасран асуулаа.

-Тийм ээ. Дараа нь Япон, Гонконг...

-Үгүй ээ. Филипп ээ, энэ хамаагүй. Өөрөөр хэлбэл... энэ бүхэн чамд ямар хэрэгтэй юм бэ? Чи явах албагүй. Бид хамт байх ёстой хэмээн Лараг дуржигнуулсанд,

-Яг үнэн, Лара. Хамт явцгаая гэж Филипп хэлжээ.

-Бл завгүй гэдгийг чи мэднэ шүү дээ. Ямар ч байсан энэ удаад чадахгүй нь. Шийдвэрлэх олон асуудал тулгараад байна. Чамайг явуулмааргүй байна! хэмээн гомдолтойёо хэлэхэд нь нөхөр нь,

-Хонгор минь, би ч гэсэн явмааргүй л байна. Гэхдээ хурим хийхээс өмнө энэ бол миний амьдрал гэж хэлснийг минь санаж байгаа биз гэлээ.

-Санаж байна. Тэгэхэд бүх юм өөр байсан. Одоо байдал өөрчлөгдсөн.

Фил ээ!

-Лара, байдал урьдын адил хэвээрээ. Урьдын адил би чамд ухаангүй хайртай, чамгүйгээр би ердөө л амилсан шулам болж хувирах байх шүү.

Үүнийг үгүйсгэхийн аргагүй.

Нөхрийгөө явангуут Лараг аймшигтай ганцаардал нөмрөн авлаа. Ажил хэргийн уулзалтын ид дунд тэрээр Филиппийг бодон, яриа хэлэлцээр нь огт сонирхолгүй болчихов.

Лара Филиппэд үнэндээ амжилт

хүсэх авч, нөхөр нь түүнд энд дэргэд нь хэрэгтэй байлаа. Орондоо ормогц хамт зургаалж явснаа, түүний хэлсэн эелдэг үгсийг чихэндээ сонсон, хэдэн цагаар бодон түүний гар хий үзэгдэл мэт илэх нь хүртэл мэдрэгдэх шиг болно.

Филипп өдөр болгон утасдах бүрийд бүр ч дордоно.

-Хонгор минь, чи хаа байна?

-Токиод явж байна.

-Тоглолт яаж байна?

-Чамайгаа санаж уйтгарлахыг эс

тооцвол тун гайхалтай байна.

-Би ч гэсэн санаж байна гэх Лара ямар их санаж байгаагаа хэлж чадсангүй.

-Маргааш Гонконг орно, тэгээд...

-Чи гэртээ байж байвал дээр байсан юм гэж хэлүүт бүсгүй болгоомжгүй үг алдсандаа харамсжээ.

-Чадахгүй гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ.

Удтал дуугүй боллоо.

-Мэдээжийн хэрэг, чи чадахгүй л дээ,

Гучин минут шахам үргэлжилсэн яриа бүсгүйн сэтгэлийг зэврээж орхилоо. Бас энэ дургүй хүргэсэн цагийн ялгааг ээ! Ларагийн хувьд хоёр дахь өдрийн шөнө нь, харин Филиппийн хувьд гуравдахь өдөртэйгээ хэдийнэ золгосон байлаа! Шөнө дундад, үүр цайхын өмнөхөн утасны хонх жингэнэн дуугарч сэрээсэн нь энэ ажээ.

-Филиппийн ажил ямар байна? гэж Келлер асуув.

-Сайн сайн. Юу түүнийг хатгаад ийм юм хийлгээд байгааг хэлээд өгөх хүн байна уу? гэж Лара гуниглав.

-Ийм юм гэсэн чинь юу гэсэн үг вэ?

-Яагаав дээ? Энэ тоглолт л... Яах гэж тэр вэ? Тэр мөнгөөр дутагдаж гачигдах биш дээ.

-Тэгэлгүй яахав. Мөнгө Филиппийн хувьд юу ч биш гэдэгт итгэж байна. Харин энэ бол түүний амьдрал.

Ганц ч үг газар гээхгүй өмөөрч байх шив гэж Лара бодлоо. Тэрээр оюун ухаандаа нөхрийгөө сайн ойлгох авч бие сэтгэл нь эс тэвчих ажээ.

-Хөөе, босс оо. Та чинь түүнийг нөхрөө болгосон биз дээ, эр хүн чинь эд хогшил биш шүү гэж Говард



ХЭЛЭВ.

-Би түүнийг эд хогшил болгох гээгүй.  
Би ердөө л Филийн хувьд бүхнээс  
илүү байх болов уу л гэж горьдож  
байсан юм... гэснээ үгээ ч гүйцээлгүй,

-За энэ тухай ярихаа орхизноё,  
Говард аа. Би ч жинхэнэ дэлт бүргэд  
болж хувирч байх шив гэв.

Лара Уильям Эллерби руу утасдан,

-Эрхэм ээ, та одрийн хоол идэх  
завтай юу? хэмээв.

-Зав гаргаж чадна шүү. Хатагтай  
Адлер аа, ямар нэг яаралтай хэрэг

гараа юу?

-Үгүй ээ, үгүй. Ердөө л уулзах гэсэн юм.

Тэд "Лё Цирк"-ийн үүдэнд уулзацгаав.

-Филипптэй ярилгүй удаа юу? гэж Эллерби сонирхон асуухад нь Лара,

-Бид өдөр болгон ярьж байгаа гэхэд,

-Азийн аялан тоглолт амжилттай явагдаж байгаа шүү гэж Эллерби урамтай өгүүллээ.

-Сонссон.

-Хатагтай Адлер аа, өтөл намайг илэн далангүй байхыг минь болгооно уу? Филиппийг хэзээ ч гэрлэнэ гэж бодож яваагүй юм шүү. Тэр бол үйл хэрэгтээ чин үнэнч сахил хүртсэн хуврага хүнтэй адил урлагийн тэнгэртээ үнэнч хүн шүү.

-Тийм бололтой гээд Лара түгдчин,

-Гэхдээ Фил дэвэн дэлхийгээр тойрч, дэндүү удаан яваад байгаа юм биш үү? гэсэнд,

-Өөрийг чинь ойлгосонгүй гэж Эллерби хэлэв.

-Тэр одоо ар гэртэй хүн. Юуны төлөө

нэг улсаас нөгөө улс руу нисээд байгаа юм бэ? гэхэд нь ярилцагч эрийн царайг харсан Лара гэнэт сэрдхийн сэрэмжлэн буруу үг алдсанаа засахыг оролдон,

-Өөрөөр хэлбэл тэр мэдээж, ер нь бол Нью-Йоркод байран суурин суух албагүй л дээ. Та ч Бостон, Чикаго, Лос-Анжелесээр аялан тоглолт зохион байгуулж чадах биш үү? Хол явуулалгүй... хэмээлээ.

-Та... энэ асуудлаа ноён Адлертэй ярилцсан уу? гэж Эллерби болгоомжтой асуув.

-Үгүй ээ. Эхлээд тантай зөвлөхөөр

шийдсэн юм л даа. Эрхэм ээ, энэ чинь боломжтой биз дээ? Филиппэд мөнгө хэрэггүй! гэж Лара адгав.

-Хатагтай Адлер аа, таны нөхөр тоглолт тутмаас гучин таван мянган доллар хүртдэг. Өнгөрсөн жилд дөчин дөрвөн тоглолт хийсэн шүү.

-Тийм л дээ, гэхдээ...

-Хичнээн төгөлдөр хуурч оройд нь гарч чадсан тухай, тэргүүн суурийг эзлэхийн тулд тэд хэрхэн өрсөлддөг талаар та төсөөлж байна уу? Дэлхий дээр хурууныхаа өндгийг цоортол төгөлдөр хуур эзэмшсэн мянгаад төгөлдөр хуурч байдаг, гэтэл тэдний

тав зургаахан хүнийг олонд алдартай суутанд тооцож болно. Филипп Адлер бол тэдний нэг, Би авхай таныг хөгжмийн ертөнцийг таньж мэдээгүй юм байна гэж бодож байна. Түүний өрсөлдөгчид гайхалтай улс байдаг юм шүү. Гоолиг биетэй, франк өмссөн эр тайзан дээр гарч ирэн, сонсогчдын баясган тоглоно, гэтэл тэр тайзны араар нуугдаад байвал тансаг хоолны мөнгийг юугаар төлөх билээ. Филипп оройд нь гарах гэж багагүй хүч, хугацаа зарсан. Гэтэл та намайг түүний алдар хүндээс нь салгаад өгөөч гэж гуйж байх шив?

-Үгүй ээ! Би ердөө л санал...

-Таны санал чинь зөвхөн түүний ахиж дэвших нэр хүндийг нь баллана. Та үүнийг хүсэхгүй, тийм биз?

-Тэр ч тийм ээ гээд Лара түгдрэн,

-Хэрэв андуураагүй бол Филипп танд өөрийн шан харамжны арван таван хувийг нь өгдөг байх аа? гэлээ.

-Яг үнэн.

-Би таныг хохироохыг огт хүсэхгүй байна гэснээ Лара үгээ цэгнэн,

-Хэрэв Фил үзэгчдийн өмнө ховор тоглохоор шийдвэл би таны

хохирлыг гань дуртайяа...

-Хатагтай Адлер аа, энэ сэдвээ нөхөртэйгээ ярилц. Үйлчлэгч ирлээ юу захиx вэ? гэж бүсгүйн үгийг тасалжээ.



## Хорин зургадугаар бүлэг.

"Нью-Йорк таймс" сонинд тоймч Лиз Смайсын бичсэн:

"Мөдхөн Төмөр хүүрзгэний сортоогий нь дарах нь" гэсэн лут том гарчиг бүхий нийтлэлд:

"Кендаллайт-пресс" хэвлэлийн газраас удахгүй гарах гэж буй түүний ажилтан асан бүсгүйн бичсэн номын тухай бардам эзэгтэй нь сонсвол "Камерон-Плаза"-гийн дээвэр дээр босгосон тохилог үүр нь ганхах болов уу? Хүүрзгэний үнэн түүх тэсрэх бөмбөг мэт сэтгэгдэл төрүүлж байна!" гэсэн байлаа.

Лара сонинг зэвүүцэн хумхиж хаяв.

Халагдсан Гертруд Миксийн хийж байгаа ажил. Өөр хэн ч биш!

Лара Жерри Таунсендыг дуудлаа.

-Лиз Смайсын бичсэнийг уншив уу?

-Дөнгөж сая уншлаа. Босс оо, бид бага сага юм хийж дөнгөнө. Хэрэв та...

-Үгүй ээ Жерри, бид бага сага биш ихийг хийж чадна! Хамтран зүтгэгч болгон миний нууцыг задруулахгүй үүрэг хүлээн гарын үсэг зурсан. Гертруд Микст нууц задруулах

эрхгүй. Би хэвлэлийн газрыг хариуцлагад татаж, шүүхэд өгөх бодолтой байна гэж Лара хэллээ.

Таунсенд толгой сэгсчин,

-Би үүнийг чинь зөв гэж зөвлөхгүй гэлээ.

-Яагаад болохгүй гэж?

-Хэвлэлээр дүүрэн шуугиан дэгдэнэ. Хэрэв бүгдийг эс тоон өнгөрөөвөл, зүйрлэж хэлбэл бороо дусагнах болно, эсэргүүцбэл догшин шуурга дэгдэнэ гэж хэлмээр байна.

Ларагийн санаа амарлаа.

-Хэвлэлийн газар хэнийх болохыг нь мэдээдэх гэв.

Цагийн дараа гэхэд Лара "Кендаллайт-пресс" хэвлэлийн газрын эзэн Генри Зайнфельдтай ярьж байв.

-Лара Камерон ярьж байна. Миний ойлгосноор, та миний тухай ном хэвлэхээр бэлдэж байгаа гэнээ.

-Лиз Смайс бага зэрэг түргэдчихжээ, гэхдээ ер нь бол үнэн л дээ, авхай.

-Хэрэв ном хэвлэгдэж гарах юм бол, та хүний хувийн амьдралд халдсан гэж хуулийн хариуцлага хүлээх

болно шүү гэдгийг сануулж байна  
гэвэл харилцуурт,

-Таныг урьдаар өмгөөлөгчтэйгөө  
зөвлөлдөхийг зөвлөх байна. Хатагтай  
Камерон, та бол олны танил болж,  
товойж гарсан хүн мөн. Өршөөж  
үзээрэй дээ, тэгэхээр танд хувийн  
амьдрал гэж байх ёсгүй. Бас нэг зүйл  
гэвэл, хэрэв Гертрудын гар бичмэлд  
итгэвэл өлөгчин барс мэт таны ааш  
аягт хэн хүнгүй атаархах юм билээ  
гэв.

-Гертруд Микс миний тухай ямар ч  
мэдээлэл өгөхгүй гэж цагаан цаасан  
дээр хараар бичсэн ам тангараг  
байгаа шүү гэж Лараг хэлэхэд,

-Хонгор авхай минь, энэ бол та хоёрын хоорондын асуудал. Тэр хүүхэндээ л заргаа мэдүүлж үз хэмээн эс тоов.

Гэвч зарга мэдүүж явсаар байтал нөгөө номонцор нь гарчих байлгүй!

-Би энэ номыг хэвлүүлэх сонирхолгүй байна. Харин танай зардлыг нөхөн төлж, бас... хэмээн Лараг саналаа хэлэхээр завдтал эзэн эр үгийг нь тасдан,

-Тэгээд л зогсчих. Таныг тун ч аюултай газар гишгэж гэж бодохоос ар нуруу руу хүйт оргин, айдас төрчихлөө. Бид яриагаа дуусгавал

дээр юм шиг байна. Сайн сайхныг хүсье! гэлээ. Өөдгүй новш!

Лара Келлерт утасдан өрөөндөө дуудаж,

- "Кендаллайт-пресс"-ын тухай сонсов уу? гэхэд нь Говард Келлер мөрөө хавчисхийлгэн,

- Тэр чинь арчаагүй угаадасны нүх шиг газар. Жигшүүртэй дуулиан тарих гэж чармайж байх шив, ноднин жил өөрсдийн бохир угаадастаа Мадонног, Шер...

- Бүх юм ойлгомжтой. Баярлалаа гэж Лара хэллээ.

Толгойн өвчин нь Говард Келлерт  
амар заяа үзүүлэхээ байжээ.

Сүүлийн үед өвдөлт нь хүчтэй,  
давтамж нь ихсээд байгааг тэрээр  
анзаарчээ. Үүний шалтгаан нь  
ядаргаа болох нь илт ажээ. Эсвэл  
өлсөөд толгой нь хагарчих гээд  
байна уу? гээд Келлер дотуур  
холбоогоогоор нарийн бичгийн  
даргатайгаа холбогдон,

-Бесс ээ, зарлагыг идэх юманд  
явуулаадахаач гэлээ.

Дотуур холбоо чимээ алга.

-Хөөе, Бесс ээ?



-Сонсож байна. ноён Келлер ээ? Та тоглоод байгаа юм уу даа?

-Тоглох ий? Яагаад тэгж хэлнэ вэ?

-Та чинь хагас цагийн өмнөхөн хооллосон шүү дээ?

Ар нуруугаар нь хүйт даагаад явчихыг Говард мэдрэв.

-Хэрэв хүсч байгаа бол, би...

-Хэрэггүй ээ, баярлалаа.

Говард таваг салат, бифштекс, бас... идсэнээ саналаа. Бурхан минь, би юу болоод байнаа?

-Уучлаарай, Бесс ээ. Би мангартаж байна.

Энэ үнэн. Гэхдээ юу болоод байна вэ?

Рино дахь "Камерон-палас"-ын нээлтийн ажиллагаа нь үндэсний баярын хэмжээнд болж өнгөрлөө. Зочид буудлын бүх өрөөг бараг хагас жилийн өмнө захиалан дуусч, казиногийн заалаар мянга мянган хүн хөлхөлдөнө. Лара эрхэм дээд зочид нь тохьгүй байхыг эс үзээсэй билээ гэхдээ солиормоор их мөнгийг зарцуулжээ. Ринод мяндагтан хэн бүхэн ирсэн байлаа. Зөвхөн тэр л дутаад байна даа

хэмээн Лара бодно. Үнэхээр Филипп Адлер эзгүйдэж байгаа нь илт. Тэрээр эхнэртээ:

"Миний амьдралын хөг аялгуу болсон чамдаа. Санаж байна, хайртай шүү, Фил" гэсэн зурвас бүхий цахирмаа цэцгийн баглаа илгээжээ.

Лара цэмцгэр смокингтой эрчүүдийн дунд Пол Мартин явж байхыг нь олж харлаа. Тэрээр том том алхалсаар гантиг шатаар өгсөв.

-Баяр хүргэе. Чи оройд нь гарч чадлаа шүү хэмээн Полыг хэлэхэд Лара,

-Баярлалаа, Пол оо. Чамайг туслаагүй бол би гар мухардаж, хоосон хоцрох байсан шүү гэлээ.

Мартин ийш тийш харан,

-Филипп хаа байна? гэв.

-Түүнийг эрж хайхын хэрэггүй. Аялан тоглолттой яваа гэж Лара дуу муутайхан хэлэв.

-Бас л товчлуураа балбасаар яваа хэрэг үү? Лара, ийм өдөр явлаа гэж үү? Тэр чамтай хамт байх ёстой байсан юм хэмээн Полыг эгдүүцэн хэлэхэд нь,

-Фил хамт явахыг их хүссэн л дээ  
гээд бүсгүй албадан байж  
инээмсэглэв.

Буудлын эрхлэгч Ларад дөхөж ирэн,

-Ажил урагштай шүү, Камерон  
авхай! Ирэх гурван сард энэ зочид  
буудалд ганц ч сул өрөө  
олдохооргүй болтлоо захиалагдсан  
шүү! хэмээн урамтайяа өгүүлэв.

-Дональд аа, энэ эрчээрээ ажиллаад  
байгаарай!

Хамгийн аазгай хөдөлгөсөн  
мөрийтэй тоглоомыг Ринопд  
авчруулахаар тусгайлсан

төлөөлөгчийг Бразил, Япон руу хөлслөн явуулсан ажээ. "Люкс" ангиллын өрөөний тоноглолд Лара арав шахам сая доллар оруулсан агаад оруулсан бүх зардлаа нүд ирмэхийн зуур нөхчихнэ хэмээн тэрээр тооцоолсон ажгуу.

-Эндээс хүрзээр ч алт ухаж ч болно шүү гэж эрхлэгч хэлснээ,

-Би яагаад нөхрийг чинь олж харахгүй байна вэ? Түүнтэй гар барих гэсэн юмсан гэв.

-Филипп байхгүй хэмээн Лара хариулав.

Бас л товчлуураа балбасаар яваа.  
Эргэн тойрны нүд гялбам гял цал,  
тансаг сайхан хурсан олны

анхаарлыг татах боловч цэнгүүний  
эзэн хатагтай Лара бүхний харааг  
булаана. Сэмми Кан "Миний сэтгэлд  
нийцсэн газар" гэдэг дуу зохиосны  
нэгдүгээр бадаг нь "Сэтгэл татам  
Лара" гэж эхэлдэг ажээ.

Бүсгүй товчхон үг хэлж цугларагсад  
чих тавин чагнаж байснаа толгой  
дээр аянга нижигнэх мэт алга  
ташлаа. Тал бүрээс нь  
сурвалжлагчдын уртаас урт иштэй  
микрофонууд сунаж, гэнэт  
зохиогдсон хэвлэлийн бага хурал

саваагүй нэгэн сурвалжлагчийн,

-Таны нөхөр хаа байна? гэж асуух  
тэр мөчийг хүртэл өөлөх юмгүй  
сайхан болж байлаа.

Ларагийн зүрх рүү өгхийтэл  
хатгуулав. Фил яагаад хамт байж  
болсонгүй вэ? Тоглоято хойшлуулж  
болох л байсан шүү дээ.

-Филипп хүрэлцэн ирж амжихгүйгээ  
мэдээд урам нь хугарсан хэмээн  
Лара залж орхив.

Ёслолын ажиллагааны дараагаар  
нийтийн бүжиг зарлахад Пол Ларад,



-Бүжиглэх үү? хэмээн урилаа.

Лара түүнийг сугадан авав.

-Охин минь, өөрийгөө ийм орд харшийн эзэгтэй гэж бодоход ямар сэтгэгдэл төрж байна? гэж Мартин цэл залуу гуалиг эр шиг танго бүжгийн аяанд чадварлаг бүжиглэх зуураа асуув.

-Яг л үлгэр шиг санагдаж байна. Тус болсонд их баярлалаа гэж Лара хэлсэнд Пол,

-Найз нөхөд юуны тулд байдаг билээ, аан? Дашрамд хэлэхэд, хүмүүсийн дунд хэд хэдэн мэргэжлийн

тоглоомчид байна. Болгоомжтой байгаарай! Олонх хүмүүс бүхэл бүтэн хөрөнгөө хаяцгааж тэгснээрээ өөрийгөө ялан дийлэгч гэж бодож явдаг юм шүү. Зарим нэгд нь машин бэлэглэ, зарим нэгнийг өрөөнд нь сайхан хүүхнээр үйлчил, тэдний хэн нь ч ихэмсэглэх өвчтэй улс байдаг юм шүү хэмээн зөвлөхөд Лара,

-Би үүнийг чинь бодолцоноо гэв.

-Алив халуухан биеэрээ наалдаач!  
Чи гуалиг үзэсгэлэнтэй биетэй...  
хэмээн Полыг өгүүлэхэд,

-Пол оо... гэж Лара цааргалахад Пол,

-Мэдэж байна. Мэдэж байна.

Филипп чамайг сайтар халамжлах ёстой гэж хэлж байсныг минь санаж байна уу? гэлээ.

-Санаж байна.

-Тэгэхээр, миний бодлоор тэрээр даалгаврыг минь биелүүлэхгүй байгаа бололтой гэв.

-Филипп явах болсондоо ихэд урам нь хугарсан хэмээн хэлээд, "Үнэхээр урам ий хугарсан ч болоосой" гэсэн харамсах бодол Ларагийн толгойд харван орж иржээ.

Шөнө орой болсон хойно утасны

хонх жингэнэн дуугарч, алсад байгаа нөхрийнх нь дуу түүний ганцаардлыг улам мэдрүүлэв.

-Лара, хонгор хайрт минь, бүхэл өдөржингөө чамайгаа бодлоо. Ажил чинь ямар байна даа?

-Нээлт ярихын эцэсгүй сайхан болсон. Ганцхан чи л их үгүйлэгдсэн шүү.

-Харин надад чи минь дутагдаж байна.

Тийм бол чи яагаад энд биш өөр газар явна вэ?

-Фил ээ, би чамайг их санаж байна.  
Хурдан ирээрэй!

\* \* \*

Говард Келлер зузаан гэгчийн дугтуй  
барьсаар Ларагийн өрөөнд орж  
ирээд,

-Лара, энэ чамд таалагдана гэдэг юу  
л бол доо гэлээ.

-Бас юу вэ? хэмээн Лараг асуувал  
Говард дугтуйгаа түүнд сарвайн,

-Гертруд Миксийн гар бичмэлийн  
хуулбар. Яаж олж авсныг битгий  
асуугаарай. Бид хоёулаа торны

цаана сууж мэднэ шүү гэлээ.

-Чи уншчихсан уу? гэхэд нь Келлер  
толгой дохин,

-Уншсаан гэлээ.

-Тэгээд? гэж гайхсан Лараг асуухад  
нь,

-Өөрөө эхлээд сайн унш. Микс  
өөрийг нь эзгүй байхад хүртэл  
манайд болсон бүхний тухай бичсэн  
байна. Өөдгүй амьтан их лав ухаж  
шүү гэв.

-Сайн байна, Говард аа. Баярлалаа.

Лара түүнийг гарч явахыг хүлээж  
байгаад дотуур холбооны  
товчлуурыг даран,

-Кэти, ямар ч утасны дуудлагыг  
хүлээж авахгүй шүү гэлээ.

Лара дугтуйг задлаад, уншиж  
эхэллээ.

Гертруд Миксийн илэн далангүй  
бичсэн нь байдлаас үзэхэд сүрдсэн  
янзтай. Өө сэвгүй, хурцалсан хэв  
маягаар бичсэн хэллэгүүд нь  
зорилгодоо хүрэхийн төлөө юу ч  
хийхээс буцдаггүй шургуу тэмцэгч  
эмэгтэйн хөргийг бүтээжээ. Гертруд  
түүний хүний эрхэнд үл автдаг биеэ

даасан чанар, зарим үед гаргадаг овилгогүй занг нь, ажиллагсдаа дарангуйлан захирах дадалтайг чадварлагаар бичиж гойд сайхан найруулсан байх аж. Зохиогч бүсгүй харин Ларагийн эр зориг, ойр дотныхондоо гар сунгадаг өгөөмөр өглөгч зангийг нь тухай дурсалгүй өнгөрчээ.

"... Төмөр хүүрзгэнэ уулзалтанд оролцогчдыг урт удаан хугацааны нислэгээс дөнгөж бууж ирүүт нь өглөө эртэд ажил хэргийн уулзалтаа хийхийг эрхэмлэдэг. Харин Камерон өөрөө..."

"...Японы банкны эзэдтэй уулзаж



байх үеэр нарийн бичгийн дарга бүсгүй нь мансууруулагч бодис уусгасан цайгаар зочдоо дайлж, харин Лара өөрөө тархины цусны эргэлтийг сайжруулдаг сэргээштэй кофе уужээ..."

"...Немцүүдэд мөн л мансууруулагчтай кофе өгч, харин Камерон авхай өөрөө сэргээш дусаасан цай..."

"...Хотын захиргаанаас Куинсын газрын зөвшөөрлийг татгалзахад Лара өөрт байхгүй охиныхоо тухай түүх зохиож, барин тавин худал хэлснийхээ шанд санасандаа хүрч төслөө хэрэгжүүлж чаджээ..."

"...Дорчестер апартаментс"-ын оршин суугчид барилгыг чөлөөлөхгүй байгааг мэдмэгц Лара суларсан байранд нь гудамжны тэнүүлчдийг хуйгаар нь цуглуулсан... гэх мэтчилэн цааш нь бичжээ.

Лара төгсгөлийн хуудсыг уншиж дуусаад удтал бодол болон сууснаа харилцуур авч Говард Келлерийг дуудан,

-Надад нэгдсэн улсын бүхий л корпорациудын тухай, санхүүгийн байдлын талаар мэдээлэл худалддаг "Дан Энд Брэдстрит"-ийнхэн хэрэгтэй байна, тэд "Кендаллайт-пресс"-ын эзэн Генри Зайнфельдын

тухай сонирхог гэлээ.

-Ойлголоо гээд Говард гарч одов.

Мөчийн дараа Келлер эргэж ирэн,

-Генри Зайнфельдын рейтинг нь "С" бүлэгт хамаарагдаж байна хэмээн мэдэгдэв.

-Энэ чинь юу гэсэн үг вэ?

-Боломжит хэмжээнээс доогуур түвшинд байна гэсэн үг. "0" бүлэг нь хамгийн муу нь ч гэлээ зарим нэг банк зээл өгөхийг зөвшөөрдөг бол "С" бүлэг нь дөрвөн үзүүлэлт доогуур түвшингийнх. Хүчтэйхэн дугтрахад

"Кендаллайт-пресс" шалдан хоцрох болно. Зайнфельд дөнгөн данган амь зуугачаан болж байгаа нэгэн юм байна гэж Говард Келлер тайлагналаа.

-Баярлалаа, Говард аа.

Лара өөрийн өмгөөлөгч Терри Хилл руу утасдав.

-Терри та хэвлэлийн газрын эзэн болох талаар урьд хожид бодож байгаагүй биз? гэсэнд,

-Хатагтай Камерон үүнийг чинь юу гэж ойлгохыг тушаахсан бол? гэж гайхсан өмгөөлөгчийг бөвтнөхөд нь,

-Би таныг "Кендаллайт-пресс" хэвлэлийн газрыг худалдаж авахыг хүсэж байна. Эзэн нь Генри Зайнфельд гэдэг хүн бий гэв.

-Ямар ч асуудал алга. Та хэдий хэрийн юм төлж чадах вэ?

-Таван зуугаас эхэл. Зөрүүдлээд эхлэвэл саяыг санал болгож болно. Хэлэлцээрт ойрын хугацаанд хэвлэгдэхээр төлөвлөгдөөд байгаа бүх номын хэвлэх эрхийг авсан байх ёстой шүү. Миний нэрийг бүү дурсаарай гэж Лара тушаалаа.

"Кендаллайт-пресс" хэвлэлийн газар нь Гучин дөрөв дүгээр гудам жин

дахь хуучирч холцорсон байшинд байрлах ажээ. Генри Зайнфельд хавчиг нарийхан үүдэн өрөөнд нь нарийн бичгийн дарга суусан даруухан өрөөнд байрлах ажээ. Нарийн бичгийн дарга үүдийг нээн,

-Ноён Хилл тантай уулзахаар ирлээ гэж хүүхэн өөрийн дадсан зангаар илтгэхэд нь,

-Орог, орог гэж өрөөний эзэн зөвшөөрөх сонсогдов.

Терри Хилл аль өглөө утсаар ярин Зайнфельдад очих тухайгаа урьдчилан дуулгасан юмсанжээ.

-Ноён Хилл ээ, танд юугаар туслахсан бол? гэж цонхны дэргэд зогсох эрхлэгч эрийг асуухад нь,

-Би таны бизнесийг худалдаж авахыг хүссэн немцийн компанийг төлөөлж явна гэж Хилл хэрэг зоригоо илтгэв.

Хуруу шахам бүдүүн навчин янжуур татан амттайхан утааг нь уугиулан уушиглах Зайнфельд,

-Би бизнесээ зарахгүй гэв.

-Өө яасан харамсалтай хэрэг вэ!  
Немцүүд америкийн зах зээл дээр орохыг хүсчээ. Тэд "Кендаллайт-пресс" ийм боломжийг олгоно гэж

бодоцгоож байгаагаа уламжилсан юмсан гэж Терри хэллээ.

-Би өөрийн хэвлэлийн газрыг ганц тоосгоноос нь эхлэн барьж босгосон юм даа, ноён Хилл ээ. Миний хувьд төрсөн хүүхдүүд шиг минь байдаг юм. Тэгэхээр худалдаж арилжих тухай яриа байх ёсгүй гэв.

-Таныг ойлгож, хүндэтгэж байна хэмээн Хилл хүндэтгэлтэйеэ хэлээд,

-Ихэд сонирхож байгаа үүднээс тэд таван зуун мянган долларыг санал болгож байна гэлээ.

Зайнфельд шуналтайяа сорж байсан



утаандаа золтой л хахаж цацсангүй,

-Таван зуун мянга ий? Чөтгөр ав, яг одоо надад дор хаяж сая долларын олз өгөх ном хэвлэгдэх гэж байна. Үгүй дээ, эрхэм ээ. Таны санал чинь тохуурхал шиг сонсогдож байна гэв.

-Миний санал бол бурхны хишиг гэсэн үг. "Кенделлайт пресс"-ийн хөрөнгө зоорь нь тэглэчихээд байгаа, таны өр зуун мянгаар хэтэрсэн байхыг би шалгаж мэдсэн. Тэгвэл зургаан зуугаар гэж тохирьё, энэ миний эцсийн үг шүү.

-Үлдсэн амьдралынхаа туршид дотроо гэмшиж явах гэж тэр үү?

Хэрэв таны үйлчлүүлэгчид чинь үнээ дор хаяж долоон зуун мянга болгож өсгөвөл...

-Баяртай, ноён Зайнфельд аа. Бид өөр худалдагч олно гэдэгтээ итгэлтэй байгаа гээд Терри Хилл хаалга руу эргэв.

-Хүлээгээрэй! Унтууцахын хэрэг алга. Үнэнийг хэлэхэд эхнэр маань намайг ажлаа орхи гээд байгаа л даа. Магадгүй цаг нь болоон ч юм билүү? гэж Зайнфельд бөвтнөхчөө аядав.

Терри ширээнд дөхөж очин пиджахныхаа дотор халааснаас нугалсан хуудас цаас гарган,

-Энэ худалдаж авах гэрээ. Надад зургаан зуун мянган долларын чек байгаа. Чагт тавьсан газар нь гарын үсгээ зурчих гэжээ.

\* \* \*

Лара Кэтигээс Келлерийг даруйхан олохыг хүслээ.

-Бид дөнгөж сая "Кендаллайт-пресс"-ыг худалдаж авчихаад байна гэж Говардыг орж ирэхэд нь Лара хэлэв.

-Баяр хүргэе. Чи тэгээд түүнийг яах бодолтой байгаа юм бэ? гэж Говардыг ажил хэрэгчээр лавлахад нь,

-Юуны өмнө Гертруд Миксын нүд хорсгосон зохиолыг тасдаж хаяна. Түүний номыг лангуун дээр очуулахгүй байх талаар хянаж байгаарай. Хэрэв тэр шүүхээр эрхээ хамгаалуулахыг оролдвол зарга дор хаяж жил сунжрах болно гэж Лара хэлэв.

-Хэвлэлийн газрыг татан буулгах юм уу? хэмээн Говардыг асуухад нь,

-Мэдээж үгүй. Хүн олоод тавьчих, ажиллаж л байг. Зардлыг нь албаны хэрэгцээний төлбөрт шингээе гэж Лара хэлжээ.

Говард Келлер өрөөндөө эргэж

ирээд нарийн бичгийн дарга  
Бессдээ,

-Одоо захидал явуулах хэрэгтэй  
байна. Бичээд аваарай. "Хеллман  
истейт" компани. Жек Хеллманд.  
Хүндэт Жек ээ, би таны саналыг  
Камерон хатагтайтай ярилцаад бид  
хоёул одоогийн байдлаар зарласан  
төсөлд оролцож чадахгүй хэмээн  
шийдлээ. Тэр ч бүү хэл бид өөрсдийн  
сонирхлыг онцлон тэмдэглэх... гэтэл  
нарийн бичгийн дарга бүсгүй үзгээ  
тавихад нь,

-Яасан бэ, Бесс ээ? гэж Говард  
гайхан асуулаа.

-Ноён Келлер ээ?

-Юу болоо вэ?

-Та энэ захидлыг өчигдөр хэлж бичүүлсэн шүү дээ гээд нарийн бичгийн дарга хүүхний нүд түүний өөдөөс бүлтийн харав.

Говард толгой сэгсэрч,

-Арай үгүй байлгүй дээ гэлээ.

-Захидлыг өглөөний шуудангаар илгээсэн хэмээн нарийн бичгийн даргыг гайхаж цөхрөн хэлэхэд Говард инээхийг оролдон,

-Өршөөгөөрэй. Бесс ээ. Би сумтай болсон шиг байна гэж хариулав.

Өдрийн дөрвөн цаг гэхэд Говард Сеймур Беннет эмчийн үзлэгийг өрөөнд сууж байлаа.

-За, за таны бие лагшин тун сайн байна, эрхэм ээ! Ядарч туйлдсан ямар ч шинж алга гэж эмч хэлэв.

-Ой ухаан самуурч байгаа нь юуных вэ? хэмээн Келлерыг асуухад нь эмч,

-Ноён Келлер ээ, та амралгүй удсан уу? гэж асуув.

Говард бодол болон байснаа,

-Таван жилийн өмнө амарсан юм байна. Ажил ихтэй завдахгүй явна гэлээ.

Сеймур Беннет эмч инээгээд,

-За тэр харж байгаа биз дээ? Тархи мэдрэл ч гэсэн амрах хэрэгтэй. Иймэрхүү явдал таны бодсоноос ч олонтоо тохиолддог юм. Ганц хоёр долоо хоног хотоос гарахыг зөвлөж байна. Толгойноосоо хамаг ажлаа гаргаж хая! Цоо шинэ хүн болоод эргэж ирнэ, чин үнэн үг шүү! гэв.

Эмчийн өрөөнөөс гараад Келлер сэтгэл нь уужрам санаа алдан,



Хагас цаг шахам явсаар Говард  
ажилдаа эргэж ирээд

-Долоо хоног надгүйгээр байж барах  
уу? хэмээн Ларагаас асуувал,

-Баруун гараасаа хагацана гэдэг  
надад юуны амар байх билээ. Юу  
болоо вэ? гэж бүсгүй гайхан лавлав.

-Беннет эмч намайг бага зэрэг амрах  
хэрэгтэй гэж байна. Яг үнэнийг  
хэлэхэд, Лара минь, сүүлийн үед  
миний ой ухаан нэг л биш дэг ээ гэж  
Говардыг үнэнээ хэлэхэд Ларагийг  
сэтгэл түгшин толгой өлийлгөн  
түүнийг ширтэж,

-Ноцтой юм биш биз дээ? гэв.

-Бурхны авралаар үгүй. Одоохондоо шүү. Гэтэл энэ эрүүл мэнд намайг цухалдуулаад байх боллоо. Гавайд хоёр гурван өдөр амрая гэж бодож байна хэмээн Говардыг хэлсэнд Лара,

-Миий онгөцыг аваад яв гэв.

-Баярлалаа, онгоц чамд хэрэг болно шүү дээ. Чиглэлийн онгоц байхад надад хангалттай,

-Компани бүх зардлыг даана гэхэд Говард,

-Бас дахин баярлалаа. Би өдөр болгон ярих...

-Хэрэггүй. Ажлыг чөтгөр аваг, чи өөрийгөө л бод. Чиний өнхрөөд өгөх л дутаж гэнэ хэмээн Лара үгийг нь таслан хэлэв.

\* \* \*

Өглөө эрт Филипп утасджээ.

-Ноён Адлер Тайбэйгээс ярьж байна хэмээн дотуур холбоогоор Мэриан Беллийн дуу хадан Лараг сэрээлээ.

Лара харилцуурыг шүүрэн авч,

-Байна. Фил үү? гэсэнд Фил,

-Сайн уу, хонгор минь. Орон нутгийн холбоочид ажил хаялт зарлаад зургаа долоон удаа залгаж байж л холбогдлоо. Чи яаж байна? гэв.

Их л гунигтай байна даа.

-Сайн байгаа. Тоглолт ямар болж байна даа?

-Гойд сонин юмгүй. Чамайг л их санаж байна гэж нөхөр нь хариулах сонсогдов.

Харилцуурт хэн нэгний хөгжилтэй инээд, хөгжмийн дуу бүдэгхэн

сонсогдов.

-Фил ээ, чи хаа байгаа юм бэ?

-Өө, энд надад хүндэтгэл үзүүлэн оройн зоог барьж байна. Иймэрхүү арга хэмжээ байдаг гэдгийг чи юу эс андах вэ?

Гэнэт харилцуурт бүсгүй хүний тас тас инээх сонсогдлоо.

Мэриан юу гэсэн бэ? Тайбэйгээс гэсэн үү?

-Мэдэлгүй яах вэ.

-Би Лхагва гаригт очно.

-Филипп ээ?

-Юу гэв, хонгор минь?

-За даа, юу ч гээгүй. Хурдан ирээрэй.

-Яараад л байна. Үнсье.

Лара харилцуураа тавьлаа.

Хүндэтгэлийн зоогны дараа тэр хаачих бол? Энэ эмэгтэй хэн бэ? хэмээн хардах сэтгэл өөрийн эрхгүй нөмрөн авахад бүсгүй өөрөө ч хүртэл гайхлаа. Урьд өмнө Лара хардах гэдгийг огт мэддэггүй байлаа.

Бүх юм сайн сайхан байна, бүр

дэндуу сайхаи шүү. Би түүнийг  
алдахыг хүсэхгүй байна. Хүсэхгүй!

Лара орондоо хэвтэн яг энэ мечид  
нөхөр нь юу хийж байгааг  
төсөөлөхийг оролдлоо.

Говард Келлер Кон-Бичийн наран  
шарлагын газар гавайн нарны  
элчинд биеэ илбүүлэнхэн таатайяа  
амарч байлаа.

Тэнгис амгалан тайвнаар налайж8  
Говард өдөртөө хэдэн км газар  
сэлэн, бие нь нар салхинд борогшин  
тосон бор болжээ. Гольф тог лосны  
дараа тэрээр бариа засалд орон,  
дэмий шаналгадаг хий хоосон бодол

санаа нь Нью-Йорктоо үлдэж, бие нь хэзээ ч одоогийнх шиг ийм сайхан байхыг тэр хэзээ ч мэдрээгүй аж. Беннетийн зөв байжээ. Амралт гэдэг туйлын эрхэм хэрэг юм байна. Гэхдээ эргэж очиход ажиллах эрч минь буурахгүй.

Ой ухаан нь самуурсан хэвээр байгаа эсэхийг батлана гэдэг нь Говардыг бүхнээс илүү шаналгана.

Амралтын сүүлийн үдэш болж, шөнө дундад нисэх онгоцонд суун маргааш өдрийн дөрвөн цаг гэхэд Говард Манхэттенд эргэж иржээ. Эхлээд ажлаар орно!



-Таныг хүлээж байлаа, ноён Келлер!  
Та гайхалтай сайхан харагдаж байна  
шүү! хэмээн нарийн бичгийн дарга  
нь инээмсэглэн мэндэлжээ.

-Баярлалаа... Говард Келлер  
үүднийхээ дэргэд зогсон хөшиж,  
нүүр нь таталдан ярвайлаа.

Энэ чинь хэн сэн билээ?

## Хорин долдугаар бүлэг.

Үдийн ундны дараа тэр лимузинд суун жолоочдоо нисэх буудал руу явахыг тушаалаа. Шатаар бууж яваа нөхөр нь охио цагийн зүүдний мөрөөдөл нь болсон хан хүүг нь дахин санагдуулав.

Бурхан минь гэж, Фил ямар үзэсгэлэнтэй юм бэ?

Тэд тэврэлдэн золгов.

-Хайрт минь, би чамайг их саналаа.

-Хонгор минь би ч гэсэн чамайг их саналаа.

-Их санасан уу? гэж Лараг асуухад  
Филипп,

-Иймхэн саналаа гэж Филипп зүү  
чимхэх мэт эрхий долоовор хуруугаа  
нийлүүлэн хэлэхэд,

Өөдгүй амьтан бэ?

-Ачаагаа яасан бэ? гэж Лара асуулаа.

-Одоо авчирна.

Цагийн дараа гэхэд тэд гэртээ  
ирэхэд нарийн бичгийн дарга  
Мэриан Белл үүд нээж,

-Ноён Адлер, тантай уулзахад таатай

байна хэмээн инээмсэглэн угтав.

-Баярлалаа, Мэриан гээд Филиппийш тийш харан,

-Бүхэл бүтэн жил эзгүй байсан юм шиг санагдаж байх чинь гэлээ.

-Хоёр жил гээч гэж Лара залруулан хэлснээ,

"Дахиад намайг ганцааранг минь битгий орхиорой" гэж хэлэх гэснээ нэгийг санав бололтой амаа хамхив.

-Хатагтай Адлер аа, би танд хэрэг болох уу? гэж Мэрианыг асуухад Лара,

-Үгүй, баярлалаа. Үлдсэнийг өөрөө гүйцээчихье. Хэдэн захидал байгаа, маргааш болтол байж л байг. Одоо ажил хийх сонирхол алга гэв.

-Тэгвэл сайн сайхныг хүсье авхай! гээд Мэриан цахилгаан шат чиглэлээ.

-Сайн хүүхэн шүү гэж Филипп аяархан бувтнавал,

-Таалагдаа юу? гээд Лара түүний цээжинд наалдаж,

-Алив, хэр зэрэг санаснаа үзүүлээдэх гэлээ.

Лара гурван өдөр офисоороо үзэгдсэнгүй.

Тэр Филиппийн дэргэдээс холдохгүй хамтдаа байж, ярилцан, гарыг нь атган сууж, нөхөр нь жинхэнэ амилсан хан хүү хэмээн өөрийгөө итгүүлэхийг чармайж байжээ.

Лара өглөөгүүр шуудангаа авч хэдэн захидал бичүүлж байхад Филипп урьдын адил төгөлдөр хуурын ард сууж байв.

Гурав хоносны дараа үдийн хоол идэж суух зуураа Лара Рино дахь казиногийн нээлтийн тухай хуучлав.

-Чи байгаагүй нь харамсалтай Тэнд  
би ёстой гайхамшигийг бүтээсэн  
шүү! хэмээн Лараг бахдалтай  
өгүүлэхэд Филипп,

-Надад ч гэсэн харамсалтай байна,  
хонгор минь! гэв,

Бас л товчлуураа балбахаар явсан  
уу.

-Зүгээр ээ, чамд дахин нэг боломж  
олгоё. Сарын дараа хотын мэр  
надад түлхүүр гардуулах  
ажиллагаатай гэж Лара хөгжилтэй  
хэлэхэд Филипп гашуудан санаа  
алдаж,

-Лара, би бас л дэргэд чинь байж чадахгүй болов уу гэж эмээж байна гэлээ.

Бүсгүй өөрийн эрхгүй халбагаа харжигнуулан алдаж,

-Энэ чинь юу гэсэн үг вэ? гэлээ,

-Эллерби шинэ аялан тоглолт зохион байгуулжээ. Гурван долоо хоногийн дараа би Герман руу ниснэ гэж Филипп хэллээ.

-Үгүй байлгүй дээ! гэж Лара бачууран хэлсэнд Фил,

-Гэрээнд аль хэдийнэ гарын үсэг



зурчихсан, би түүннйг өөрчилж чадахгүй гэв ээ.

-Өөрчлөх л болно доо! Чи ер нь хэзээ гэртээ байх хүн бэ? гэж Лара бухимдан хашгирав.

-Лара, энэ тоглолт онц чухал шүү дээ! хэмээн Филиппийг хэлэхэд нь,

-Тэгвэл бидний гэрлэлт ямар гэж? Тийм чухал биш гэж үү? хэмээн Лара бачимдан өгүүлэхэд нь, Филипп,

-Лара... хэмээн сөөнгөтөв.

-Чи явах албагүй! Надад нөхөр хэрэгтэй болохоос, түр зуурын...

хэмээх түүний дуунд уур хилэн  
буцлан байв.

Мэриан Белл гартаа багц захидал  
барьсаар хоолны өрөөнд орж  
ирүүтээ,

-Бурхан минь, уучлаарай, би саад  
болчих уу даа. Энд таны гарын үсэг  
хэрэгтэй болоод... гэж ээрч түгдрэв.

-Мэриан явж бай. Би чамайг  
дуудамз хэмээн Лараг хайхрамжгүй  
өгүүлсэнд нарийн бичиг хүүхэн  
аягүйцэн,

-Тэгье. хатагтай Адлер аа гээд  
шурдхийн эргэлээ.

Эхнэр, нөхөр хоёр түүний араас дуу ч үгүй харан сууна.

-Би чамайг аялан тоглох ёстойг мэдэж байна. Гэхдээ үргэлж биш л дээ. Чи явуулын наймаачин эртэй адилхан болох нь хэмээн Лараг эгдүүцэхэд,

-Нээрээ юу? гэж Фил хүйтнээр өгүүлэв.

-Хэд хоногийн дараа явж болох биш үү хэмээн Лараг хэлэхэд нь,

-Лара, энэ ажиллагаа чамд чухал болохыг би ойлгож байна, гэвч чи намайг ойлгооч, би тоглохгүй байж

болохгүй! Би чамаар, чиний хийж бүтээж байгаа бүхнээр бахархдаг. Харин чи? Чи надаар бахархахыг хүсэхгүй байна гэж үү? гэж Филипп асуув.

-Хүсч байна. Өршөөгөөрэй Фил ээ, би ердөө л... Лара арай ядан нулимсаа барив.

-За за хонгор минь. Бидний хувьд бүх юм урагштай байна шүү дээ гэснээ Филипп Лараг тэврэн,

-Эргэж ирээд хоёул удаан хугацаагаар амралтаар явна аа гэлээ. Амарна гэдэг санасны гарз. Дэндүү их ажилтай байна гэж Лара

бодоод,

-Энэ удаад чи хаашаа явах юм бэ?  
гэж асуухад Фил,

-Герман, Норвеги, Дани, Япон орно.  
Тэндээсээ гэртээ эргэж ирнэ дээ гэж  
хариулав.

Бүсгүй гүнзгий санаа алдаад,

-Ойлгомжтой гэж сунжруулан хэлэв.

-Бид хамт явдаг ч болоосой билээ!  
Чамгүйгээр би их ганцаардана даа.

Лара харилцуурт сонсогдсон  
эмэгтэйн тас тас хийн хөхрөхийг

гэнэт санан,

-Тэгтлээ их ганцаардана гэж үү? гээд  
Лара албадан инээхчээ аядан,

-Чи миний онгоцыг аваад яв, энэ нь  
чамд илүү төвөг чирэгдэлгүй байх  
болно гэлээ.

-Чамд онгоц хэрэг болохгүй гэж үү?

-Огт хэрэг болохгүй. Яадаг ч болтугай  
чамайг эргэж иртэл тэр шүү. -Энэ  
хорвоо дээр чам шиг хүүхэн байхгүй  
шүү гэж Филипп хоолой чичигнүүлэн  
хэлэв.

Лара түүний хацрыг энхрийлэн

илээд,

-Хонгор минь, миний хэлсэн үгийг санаж яваарай гэлээ.

\* \* \*

Аялан тоглолт нь урьдын ажил амжилттай явагдаж байлаа. Берлины үзэгчид дахиулсаар, Филипгшйг тайзан дээрээс удтал буулгасангүй. Хувцас солих өрөө нь тэвчээргүй шүтэн бишрэгчдэд дарагджээ.

-Таны концертыг үзэх гэж би гурван зуун милийн тэртээгээс...

-Эндээс холгүй миний харш бий, та очиж чадахсан...

-Би зоог бэлтгэсэн, хоёр хүнийх, тэгээд...

Тэд бүгд л баян чинээлэг, гоо үзэсгэлэнтэй гэж жигтэйхэн, бүгд л түүнтэй шөнийг хамтдаа өнгөрүүлэхийг огт эргэлзэхгүй зөвшөөрөх нь илт. Гэсэн ч Филиппийн сэтгэл зүрхийг өөр хүн эзэмдэж байжээ.

Тэр Копенгагенаас Ларатай ярив.

-Би чамайгаа их санаж байна шүү.



-Би ч гэсэн, Филипп ээ. Концерт ямар болов доо?

-Намайг тоглож байхад зааланд хэн ч шивэр авир гэхгүй байна билээ. Лара инээд алдан,

-Сайны шинж дээ! Хайрт минь, би яг одоо зөвөлгөөнтэй байна, уучлаарай. Цагийн дараа зочид буудалд очиход чинь утасдая гэлээ.

-Хонгор минь, би зочид буудал руугаа явахгүй. Концерт зохион байгуулагч хүлээн авалт...

-Яалаа гэнээ? Тэнд мэдээж бага залуу насны охинтой л байхдаа?

гэснээ Лара мулгуу үг хэлснээ  
мэдэнгүүтээ өөрийгөө хараалаа.

-Юу?

-Юу ч гээгүй. Фил ээ, намайг хүлээж  
байна. Дараа ярья.

Лара харилцуураа тавиад ширээ  
тойрон суух эрчүүд рүүгээ эргэлээ.  
Говард Келлерын нүдэнд түгшүүр  
тодрон,

-Хатагтай Камерон, та зүгээр үү?  
гэлээ.

-Зүв зүгээр. Зөвлөлгөөн цаашид нэг л  
уйтгартай үргэлжиллээ. Ларагийн

толгойноос Филиппийн тухай бодол  
салсангүй, тэр хүлээн авалт  
өндөрлөхөд хорхой хүрэм мариалаг  
немц хүүхэн ганган хөгжимчний  
халаасанд өөрийнхөө түлхүүрийг сэм  
шургуулж байгаа гэсэн бодол  
толгойд нь эргэлдэнэ. Хардах сэтгэл  
оюун ухааныг нь цаламдан авчээ.  
Лара яаж ч чадахгүй байгаадаа  
өөрийгөө зүхэн үзэн ядна.

\* \* \*

Ёслолын ажиллагаа өндөрлөж Лара  
болон хотын даргыг сэтгүүлчид  
бүчин авлаа.

-Таны нөхөр хаана байна? Би гэр

бүлийн зураг... Бүсгүй дахиад л  
уучлал эрэх хэрэг гарч,

-Филипп энд хүрэлцэн ирэхийг их  
хүссэн юмаа, гэтэл... хажуунаас нь  
Пол Мартин дөхөж ирэн,

-Тэр дахиад л чамайг орхиод  
явчихаа юу? гэлээ.

-Фил явах болсондоо их харамссан  
шүү!

-Чалчаа дэмий үг! Ийм өдөр тэр  
чамтай хамт байх ёстой! Чөтгөр ав  
гэж хаашаа янзын нөхөр гээч вэ!  
Үгүй дээ, түүнтэй заавал ч үгүй  
ярилцах хэрэггүй юм байна.

Ларагийн нойр нь хулжин орондоо хөлбөрч хэвтэнэ. Филипп хүртэл дор хаяж хэдэн арван мянган милийн зай байна. Түүний толгойд нь Пол Мартины: Чөтгөр ав гэж хаашаа янзын нөхөр гээч вэ! Үгүй дээ, түүнтэй заавал ч үгүй ярилцах хэрэгтэй юм байна гэж хэлсэн үг эргэлдэнэ.

Филипп америк нутгийнхаа хөрс шороон дээр гишгэмэгц амар амгалан, аз жаргалыг мэдэрчээ. Түүний тээшинд гангар шаазан, өнгө өнгийн нимгэн торгон цамц, алтан саагаар угалз хатгасан жижгэвтэр цүнх, дотор нь индранил эрдэнийн шигтгээ бүхий чамин хийцтэй

бугуйвч байгаа аж.

-Ямар гоё юм бэ! Баярлалаа, хонгор  
минь! хэмээн Лара дуу алдав.

Өглөө нь Мэриан Беллд,

-Би өнөөдөр бүхэл өдөржингөө  
гэртээ ажллана гэжээ.

Лара үдээс өмнө захидал төлөвлөж  
суухад, нөгөө өрөөнөөс Шубертын ая  
хангиж байлаа.

Амьдрал үнэхээр сайхан байна.  
Гэтэл Филипп ийм сайхан байдлыг  
яагаад эвдэх гэдэг юм болоо?

Уильям Эллерби менежир утасдан,

-Баяр хүргэе, Фил! Тоглолт амжилттай болов уу? гэв.

-Тэглээ. Европынхны сонгодог хөгжмийн гайхамшигт мэдрэмж нь хэвээрээ байна шүү гэвэл,

-Өчигдөр би "Карнеги-Холл"-ын удирдлагуудтай ярилцсан юм. Ирэх тав дахад буюу арван долоонд, санамсаргүй байтал тоглолт хийх цаг олдлоо. Тэд чамайг тоглуулах санаатай байгаа юмсанж. Чи юу гэмээр байна вэ? хэмээн Эллерби гэв.

-Дуртайяа.

-Сайн байна. Би бас бус зүйлийг нь тодрууламз. Өө тийм, дашрамд хэлэхэд, чи тоглолтынхоо хүрээг хумих санаатай байгаа юм уу? гэж асуувал Филипп гайхан,

-Хумих ий? Яагаад тэр билээ? хэмээв.

-Би саяхан Ларатай уулзсан юм. Түүний хэлснээр чи зөвхөн нэгдсэн улсаар тоглолтоо хязгаарлахад дургүйцэхгүй гэсэн дээ. Эсвэл би буруу ойлгосон юм болов уу?

-Тэгж дээ. Би энэ тухай эхнэртэйгээ



ярилцана аа. Филипп Эллербитэй  
ярьж дууссанахаа дараа Мериан  
Беллд яаралтай захидал хэлж  
бичүүлж байсан Ларагийн ажлын  
өрөөнд орж,

-Та биднийг түр орхино уу? гэв. -  
Тэгэлгүй яахав, ноён Адлер аа гээд  
нарийн бичгийн дарга бүсгүй гарч  
одлоо.

-Лара, сая Эллерби ярьлаа.

-Чи түүнтэй миний аялан тоглолтын  
тухай яриа юу?

-Тэгсэн. Ингэх нь бидний хэн хэнд  
дээр гэж надад бодог...

-Гуйя, дахин ийм юм бүү хийгээрэй.  
Би чамд ямар их хайртайг чи мэднэ.  
Гэвч чи бид хоёрт тус тусын ажил  
хөдөлмөр бий. Би чиний, чи миний  
хэрэгг оролцохгүй гэдэг дүрэм  
тогтооё. Шударга биз? гэлээ.

-Шударга байна, Фил ээ,  
Өршөөгөөрэй, гэвч надад чи их  
үгүйлэгдэх юм. Уучлана биз дээ?  
гэснээ,

Лара босож, түүний цээжинд  
наалдав.

-Уучилсан, тэгээд энэ тухай мартъя.

\* \* \*

Говард Келлер хавтастай гэрээний төсөл барьсаар пентхаус руу орохоор өгсөж явав.

-Лара, ажил ямар байна вэ? гэж асуухад,

-Гайхалтай сайн байгаа гэж Лара хариулав.

-Амьдрал хөгжмөөр дүүрэн эгшиглэж байна уу, аан? хэмээн Говард ёжилсон янзтай асуухад,

-Амьдрал хөгжимчнөөр дүүрэн байна. Говард аа, чиний ямар агуу болохыг төсөөлөхгүй дээ гэлээ.

-Чи хэзээ ажилдаа очих вэ?

-Ганц хоёр хоногийн дараа гэж  
Лараг хэлбэл Говард Келлер толгой  
дохин,

-О'кэй. Чиний хэрэг гараад байна  
шүү гэсээр тэд ажилдаа шамдан  
орцгоов.

Өглөө нь өмгөөлөгч Терри Хилл  
утасдаж,

-Лара, Невада улсын мөрийтэй  
тоглоомын комиссоос факс иржээ.  
Тэд чиний лицензийг сонирхож  
байна. Үнэ ханшийн талаар дуулах  
гэнэ гэв.

-Гэнэт юу болоо вэ?

-Бас хэн нэг нь дуудлага худалдаанд эргэлзэж байна гэж гомдоллосон гэнэ. Комиссынхон арван долоонд чамайг Ринод хүлээж байхаа мэдэгдсэн шүү.

-Терри, энэ хэр зэрэг ноцтой вэ? хэмээн Лараг асуухад өмгөөлөгч эргэлзэн,

-Чи луйвардах оролдого хийгээгүй биз дээ? гэлээ.

-Мэдээж, үгүй гэж Лараг хариулахад,

-Тэгвэл санаа зовохын хэрэггүй. Би

чамтай хамт байх болно гэж Терри Хилл хэллээ.

-Хэрэв би арван долоонд очихгүй байвал яах вэ? гэж Лара асуув.

-Тэгвэл Шүүхийн зарлан дуудах гардана даа. Ингэх хэрэггүй л болов уу.

-За, за.

Лара харилцуураа тавьснаа, тэр даруй шүүрэн авч Пол Мартины утсанд залгав.

-Лара юу?

-Тийм байна, Пол оо.

-Чи ярихгүй удлаа шүү.

-Тэглээ, нилээд уджээ. Би Риногийн асуудлаар... гэж Лараг яриагаа эхэлтэл Мартин,

-Сонссон гэхэд нь Лара гайхан,

-Тэнд үнэхээр асуудал үүсээ юу? гэлээ.

Мартин тас тас хөхөрч,

-Үгүй дээ. Атаа жөтөөчдийн л өдөөн хатгалга, өөр юу ч үгүй гэв.

-Пол оо, чи үүндээ итгэлтэй байна

уу?

-Тэгэлгүй яахав, охин минь. Бид хуулийн эсрэг юу ч хийгээгүй, Бүгд л ингэж хийдэг шүү дээ. Бүү санаа зов!

-Чи намайг ятгаж чадлаа. Одоо санаагаа зовоохгүй гээд Лара санаа амран хариулав.

Үдийн хоолон дээр Филипп,

-Намайг "Карнеги холлд" тоглуулах болсон гэхэд нь Лара инээмсэглэн,

-Хонгор минь, би чиний өмнөөс баярлаж байна. Би шинэ даашинзаа өмсөнө. Хэзээ вэ? гэж асуулаа.



-Арван долоонд болно хэмээн  
Филиппийг хэлбэл Ларагийн  
инээмсэглэл арчигдан,

-Еэ! хэмээн дуу алдав.

-Юу болоо вэ? гэж Филиппийн  
асуухад нь,

-Би очиж чадахгүй нь, Фил ээ. Рино  
нисэх ажилтай, өршөөгөөрэй гэсэнд,

Филипп түүний гарыг атган,

-Бидний ажил үргэлж давхцаж байх  
юм. За яахав. Бурхан ивээг.

Өмнө маань бүхэл бүтэн амьдрал

байна даа! гэжээ.

\* \* \*

Өглөө нь Келлер утасдан,

-Лара, чи хүрээд ирээч.

Хойшлуулшгүй ажил гараад байна гэв.

-Цагийн дараа очлоо гээд офистоо хүрч ирэн хурлын зааланд орвол зөвлөлгөөн ид дундаа явагдаж байлаа.

-Хоёр ч хэлэлцээр баларч гүйцээд байна. Хьюстон дахь манай барилгад орохоор тооцоолж байсан

Даатгалын компани дампуурчээ.  
Одоохондоо өөр түрээслэгч алга  
хэмээн Келлер мэдэгдэв.

-Олно доо гэж Лара хариулав.

-Энэ тийм ч амаргүй хэрэг. Татвар  
оногдуулах шинэчлэл биднийг хяхаж  
хясаж байна. Чөтгөр гэж, бүгдийг нь  
хясаж байна. Конгресоос  
гүйцэтгэгчдэд үзүүлдэг хөнгөлөлтийг  
хүчингүй болгожээ. Барилгын салбар  
уналтанд орж, банкууд сандарч  
үймэлдэж эхлэх нь бололтой.

Бернэм Ламберт бизнесээ орхиход  
бэлэн болчихоод байна. "Хог"-ийн  
гэгдэх акцууд аажим тэсэрдэг мина  
болж хувирчээ. Манай объект уудын

тал хувьд нь хүндхэн асуудал тулгараад байна. Манай эхлэлийн шатандаа яваа гурван барилга байгаа. Санхүүжилтгүйгээр тэднийг дуусгана гэж санасны гарз болоод байна.

Лара бодолд автан байснаа,

-Бид хүндрэлийг давж гарна.  
Идэвхгүй хөрөнгөө зараад барьцаагаа төлнө! гэлээ.

-Тэнгэрийн ивээлээр, Риногоос урсах бэлэн мөнгөний урсгал бас үлдэж байна. Эндээс жилд тавин сая доллар орно!

Лара дуугарсангүй.

\* \* \*

Арван долооны баасан гаригт Лара Рино руу нисэх болж, Филипп эхнэрээ нисэх буудалд хүргэж өгөхөд онгоцны шатны дэргэд Терри Хилл түүнийг хүлээж зогсов.

-Хэзээ ирэх вэ? гэж Филиппийг асуухад,

-Маргааш ирэх байхаа. Энэ нэг их удах ажил биш гэж Лара хариуллаа.

-Би чамайг санана даа.

-Би ч гэсэн адил хонгор минь.  
Филипп нисэх зурвасаар хурдлах  
"боинг" онгоцны араас удтал харан  
зогслоо. Бурхан минь, би түүнийг  
яасан их санана гээч! Лара шиг хүн  
энэ хорвоод үгүй шүү!

Мөрийтэй тоглоомын комиссын  
албан тасалгаанд лиценз өгөхөөс  
өмнө түүнтэй уулзаж байсан өнөөх  
жентельменүүд сууж байхыг нь Лара  
харлаа.

Гэвч энэ удаад уулзалт албан ёсны  
байдлаас хэтэрсэнгүй.

Лараг тангараг өргүүлэн, нарийн  
бичгийн дарга нь албан ёсны

протокол өмнөө дэлгэн тавьж,  
комиссын дарга,

-Камерон хатагтай, комиссын  
гишүүд танд өгсөн казиногийн  
лицензтэй холбоотой ноцтой  
асуудал үүсгээд байна гэж хэллээ.

-Чухам ямар асуудал вэ, эрхэм ээ?  
хэмээн Терри Хилл даруухнаар  
асуув.

-Бид энэ тухай одоо ярилцамз гээд  
дарга дахин Ларад хандан,

-Хэрэв андуураагүй бол, энэ  
тоглоомын ертөнцөд таны худалдаж  
авч байгаа хамгийн анхны газар

байхаа, хатагтай? гэлээ.

-Тийм ээ. Анхных.

-Та юун дээр үндэслэн өөрийн саналаа ирүүлсэн бэ? Тодруулбал, та үнэлгээгээ хэрхэн тогтоосон бэ?

-Ийм асуултаар юу хэлүүлэх гээд байгааг мэдэж болох уу? гэж өмгөөлөгч хажуунаас нь асуув.

-Түр хүлээгээрэй, Хиллээ. Таны үйлчлэгчид хариулахыг зөвшөөрнө үү.

Терри Хиллийг толгойгоо дохиход нь,



-Миний шинжээчид зах зээлийн байдалд шинжилгээ хийсний үндсэн дээр надад үнэлгээгээ танилцуулсан. Баттайг нь бодолцоод би дээд хэмжээг нь хэдээр нэмсэн дээ гэж Лара хариулав.

Дарга өөрийн тэмдэглэлээ нягтлан үзээд,

-Таны үнэлгээ дуудлагын худалдаанд оролцогчдын санал болгосон хамгийн дээд хэмжээг таван саяаар өсгөсөн байна лээ гэв.

-Тийм үү?

-Тэр үед та энэ тухайгаа мэдсэн үү?

гэж эрхэм дарга асуув.

-Үгүй. Мэдээж үгүй гэж Лара хариулав.

-Хатагтай Камерон, та Пол Мартин гэгчийг таних уу? Хилл мөн л хажуунаас оролцон,

-Ойлгосонгүй, энэ юунд хамаатай... гэв.

-Эрхэм ээ, бүх юм өөрийн цаг хугацаатай байдаг юм шүү хэмээн үгийг нь таслаад Ларад хандан,

-За, хатагтай Камерон та юу гэх вэ? гэлээ.

-Надад таны асуултанд хариулахад огт хэцүү юм алга. Тийм ээ, би Пол Мартиныг танина.

-Та түүнтэй ажил хэргийн холбоотой юу?

Лара түдгэлзэн байснаа,

-Үгүй, Пол ердөө л миний найз гэв.

-Хатагтай Камерон, Пол Мартиныг мафийн загалмайлсан эцэг гэж үздэгийг та мэдэх...

-Татгалзаж байна, эрхэм ээ! Цуу яриа нь буруушаах үндэслэл болох

-За за, ноён Хилл ээ, би асуултаа татаж авлаа. Хатагтай Камерон, та сүүлийн удаа Пол Мартинтай хэзээ уулзсан, эсвэл утсаар ярьсан бэ?

Лара дахиад эргэлзэж,

-Яг сайн санахгүй байна. Ний нуугүй хэлэхэд нөхөрт гарснаас хойш би ноён Пол Мартинтай тун ховор харилцах болсон. Дээдсийн хүрээний хэмжээнд ганц хоёр уулзалтанд таарсан, тэгээд л болоо гэлээ.

-Та түүнтэй байнга утсаар холбоо барьдаггүй хэрэг үү?

-Нөхөрт гарснаас хойш үгүй.

-Та хэзээ ч юм ноён Мартинтай казиногийн сэдвээр ярилцаж байсан уу?

Лара Терри Хиллийн зүг харвал өмгөөлөгч эр нүдээ анин дохиж харагдав.

-Ярилцаж байсан. Намайг дуудлага худалдаанд ялсны дараа Пол надад баяр хүргэхээр ярьсан. Дараа нь намайг лиценз гардаж авахад бас ярьсан гэж Лара хариулав.

-Үүнээс өөр яриа байсан уу?

-Үгүй.

-Камерон хатагтай, таныг тангараг өргөснийг чинь сануулж байна шүү би.

-Тийм ээ, эрхэм ээ.

-Та худал мэдүүлэг өгснийхөө төлөө хариуцлага хүлээдэг тухай мэднэ биз дээ?

-Мэднэ, эрхэм ээ.

Дарга хуудас цаасыг дээш өргөн сэгсчиж,

-Энд оролцогчдын саналыг

битүүмжлэн дуудлага худалдааг  
эрхлэн явуулагчидад гардуулснаас  
хойш Пол Мартин та хоёрын бие  
бие рүүгээ ярьсан арван таван  
удаагийн дуудлага тэмдэглэгдсэн  
байгаа гэх нь тэр.

## Хорин наймдугаар бүлэг.

Дор хаяж гурван мянгаад суудал бүхий асар том зааланд орж ирсэн хэн ч, тэр ч бүү хэл агуу хөгжимчи ч өөрийгөө өчүүхэн оодой мэт санан сүрдэх биз ээ. Баасан гаригийн үдэш хөл гишгэх зайгүй болтлоо цугларч бүр нэмэлт суудал тавиулан ийм олон үзэгчдийн сэтгэлийг "Карнеги холл"-д татаж чадсан ийм их аз цөөхөн хэдэн төгөлдөр хуурчдад тохиожээ. Филипп Адлерийг тайзан дээр гарч ирэхэд хөгжмийн мэргэжилтнүүд удтал алга ташин угтав. Алдараа цуурайтуулсан хөгжимчин төгөлдөр хуурынхаа ард



суун, агшин өнгөрөх төдийд үзэгчид алдарт хөгжмийн эгшигийг сүслэн сонсох ажгуу.

Энэ удаагийн концерт Бетховены бүтээлүүдийг тоглох байлаа. Филипп жил шахам зохиогчийн санааг бүрэн гаргах бэлтгэл сайтар хийсэн, гэвч одоо түүний санааг зөвхөн Лара эзэмдэн бодолд нь эргэлдэнэ.

Секундын төдийд хуруу нь хурдаа алдан саарах авч Бурхны авралаар танхим дахь хэн ч үүнийг анзаарсангүй. Тоглолтын эхний завсарлага болоход алга ташилт мөндөр буух мэт нирхийн тачигнаж Филипп тайзны араар орлоо.

Түүний замд "Карнеги-Холл"-ын дарга гарч ирэн. -Ноён Адлер аа, гайхамшигтай! Үзэгчид ид шидийг үзлээ! Цангаагаа тайлах уу? Аяга шүүс уух уу? гэв.

-Үгүй, баярлалаа.

Филипп өрөөндөө ороод үүдээ сайтар хаав. Юуных ий шүүс вэ? Тэр гэртээ л харихыг тэсгэлгүй хүсэн, Ларагийн тухай бодол амар заяаг нь үзүүлсэнгүй. Бие биесийг хайрлах тэдний хайр нь хүндхэн сорилыг туулуулж байгаа бололтой.

Эхнэрийгээ Рино руу нисэхийн өмнө тэд тар тур хийгээд авсансан.

Ямар нэг юм хийх хэрэгтэй. Чухам юу хийх вэ? Буулцан тохиролцох ямар нэг арга олох хэрэгтэй хэмээн Филипп бодож байтал хаалганы цаанаас,

-Ноён Адлер аа, таван минут үлдлээ гэх сонсогдов.

-Танд баярлалаа, очлоо.

Концертын төгсгөлд Есдүгээр симфонийн 4-р хэсгийг тоглолоо. Танхимд хурсан үзэгчид туйлдаа хүртэл сэтгэл нь хөдөлжээ. Эцсийн хөгийг тоглож дуусан нам болоход үзэгчид тайз руу ухасхийн тэмүүлцгээв. Филипп гүнээ мэхийн

ёслох зуураа:

Гэртээ харья, харья! Ларатай  
ярилцах хэрэгтэй! Хойшид ингэж  
үргэлжшж болохгүй! гэж бодсон  
боловч тэр даруй түүний эзгүй  
байгааг нь саналаа.

Энд тэндгүй: Браво! Браво! Бис!  
хэмээн орилолдон алга ташина. Ийм  
үед тэрээр богинохон шиг зохиол  
тоглохыг огт татгалзаж байгаагүй  
атлаа энэ удаад тэрээр тоглохыг  
хүссэнгүй. Филипп хувцас солих өрөө  
рүүгээ очиж хувцаслалаа. Цонхны  
цаана Нью-Йоркийн гудамжнаа  
аянга бууж цахилгаан цахилж  
үзэгдэв. Цаг агаарын мэдээгээр

оройдоо аадар бууна гэж зарлаж байсан, шаагин орох аадар борооны ус албаны хаалганы дэргэд овоорох шүтэн бишрэгчдийг хөөж чадсангүй. Филипп урьдын адил тэдэнтэй зууралдахыг эс хүссэн тул аадар намдтал хүлээхээр шийдэв. Түүнийг өрөөнийхөө үүдийг нээн гарч ирэхэд аль хэдийнэ шөнө дунд болчихсон, хонгил эзгүйрэн хоосорчээ. Үүдний дэргэд лимузин байсангүйд Филипп: Зүгээр, такси зогсоочихно гэж боджээ. Тэр шалбааг дүүрсэн гудамжинд гарлаа.

Сэрүүн салхи хавирга нэвт үлээн. Тавин долоодугаар гудамж харанхуй мананд бүрхэгджээ.

Филипп 6-р авеню тийш эргэтэл  
бахим чийрэг нэгэн эртэй халз  
мөргөлдчихлөө.

-Уучлаарай, "Карнеги-холл" руу яаж  
очих вэ? гэж үл таних эр үгээ зөөж  
ядан асуув.

Ларад ярьж байсан хошигнол нь  
санаанд нь орж Филипп золтой л:

Сургуулилах хэрэгтэй дээ, эрхэм ээ  
гэж хэлчихсэнгүй.

Филипп гэдрэг эргэн харанхуйд  
бүүдийи үзэгдэх аварга барилгыг  
заан,

- "Карнеги-Холл" таны өмнө байна  
гэлээ.

Үл таних эр түүн тийш нэг алхан  
дөхөж ирээд зүүн гар нь шалмаг  
хөдлөн Филиппииг хананд шахаж,  
баруун гарт нь хутга гялсхийж,

- Түрийвчээ өг! гэлээ.

Зурх нь галзуутай дэлсэлж, Филип  
огт эргэлзэлгүйгээр,

- Тайвшир анд минь. Чи түрийвчийг  
минь авна гэлээ.

Хурц хутга хоолойд нь шигдэж,

-Алив өгөөдөх! гэж сайхь эр төмөр  
хоолой мэт хөндий дуугаар  
хүнгэнүүлэв.

-Сонсооч хөө, юунд...

-Амаа тат!

Филипп дуулгавартайгаар түрийвчээ  
гаргаж өгтөл тэр даруй луйварчин  
эрийн халаасанд ороод алга боллоо.  
Түүний үнэт цаг шуналт эрийн  
сонирхлыг татав бололтой цагийг нь  
авах гэж Адлерын зүүн гарыг нь  
булгалах нь шахам татаад,  
сарвууных нь үеэр хурц хутгаараа  
хэрчих нь тэр ээ.



Улаан цус олгойдон урсаж, эзгүйрч  
хоосорсон гудамж даяар,

-Аа-а-аа хэмээн амь тавих мэт  
орилох дуу хадлаа.

Тэр ухаан алдаж, нойтон цардмал  
замаар ув улаан нарийхан горхи  
урсаж эхэллээ.

# Дөтгөөр дэвтэр

## Гучдугаар бүлэг.

Мэриан Белл болсон явдлын тухай Ларад дуулгасан ажээ. Нарийн бичгийн дарга хүүхэн ихэд сандарчээ.

-Шарх нь ноцтой юм уу? гэж Лара урьтан асуув.

-Одоохондоо тодорхойгүй байна. Ноён Адлер эмнэлэгт байгаа гэлээ.

-Би одоо нислээ.

Өглөөний зургаан цагт Лараг эмнэлгийн хүлээн авах өрөөнд яаран орж ирэхэд цочирдож балмагдсан

Говард Келлер түүнийг тосон уулзав.

-Юу болох нь энэ вэ? гэж сандарсан Лара хоолой чичигнүүлэн асуув.

-Дээрэмчин довтолсон бололтой. Ноён Адлер дөнгөж "Карнеги-Холл"-оос гарсан байна. Түүнийг ухаангүй хэвтэж байхад нь цагдаагийн эргүүл олсон гэсэн хэмээн Говард хариуллаа.

-Эмч нар юу гэж байна?

-Шөрмөсийг нь тасалсан байна гэсэн. Филипп ухаан орсон, гэхдээ их л гутарч сэтгэлээр унасан байгаа.

Тэд эцэс төгсгөлгүй үргэлжлэх урт хонгилоор явсаар тусгай тасаг руу орлоо.

Филипп дусал залгуулчихсан хэвтэж байв.

-Фил ээ... Фил!

Бүүр түүрхэн, бүдэг манан дундаас дуудах сонсдогдож Филипп нүдээ нээв. Орных нь дэргэд зогсох Лара, Говард Келлер хоёрын дүрс давхралдаж, нүд нь харанхуйлав.

-Надад юу тохиолдоо вэ? гэх түүний ам нь хуурайшин аргаж, арай ядан дуугарах аж.

-Чамайг дээрэмджээ, гэхдээ бүү зов, бүх юм сайхан болно гэж Лара хэлэв.

Тэрээр толгойгоо хөдөлгөн зүүн гараа харлаа.

Зузаан марлиар боосон зүүн гараа хармагц агшны төдийд ой ухаан нь сэргэн,

-Хурц хутга байсан... Гүн зүсэж үү? гэж асуулаа.

-Мэдэхгүй ээ, хайрт минь. Битгий санаа зов. Одоо эмч ирнэ.

-Одоо үед манай эмч нар

гайхамшигийг бүтээдэг болсон гэж  
Келлер булангийн тэртээгээс  
тайвшруулан хэлэх дуулдав.

Филиппийн нойр тэсгэлгүй хүрэн,

-Би түрийвчээ өгсөн шүү дээ...

Миний гарыг зэрэмдэглэхийн хэрэг  
юу... Тэр... гарыг минь... дэмий л гэж  
тэрээр амандаа арай ядан бувтнав.

Хоёр цагийн дараа Деннис Стэнтон  
эмч тасагт орж ирэхэд түүний царай  
Филиппэд бүхнийг хэлээд өгчээ.

-Эмч ээ, надад үнэнийг хэлээч. Би  
сонсох эрхтэй биз гэж Филипп  
шаардав.

Мэс засалч эмч гүн санаа алдаад,

-Тун муу мэдээ дуулгах болох нь дээ,  
ноён Адлер аа гээд уруу царайллаа.

-Хэл, хэл.

-Шөрмөс чинь тасдсан учраас сарвуу  
хөдөлгөөнгүй болно. Энд, бас энд  
мэдрэл нь гэмтсэн байгаа гээд  
Стэнтон өөрийнхөө гар дээр зааж,

-Энэ нь гарын мэдрэмж алдагдана  
гэсэн үг. Мэдрэлийн 1-р төгсгөл нь  
эрхий хуруу, долоовор, дунд  
хуруунд, 2-рх нь бүх сарвуунд  
үйлчилдэг юм хэмээв.



Филипп цөхөрсөндөө амьсгаа нь давчдаж, нүдээ аньлаа. Минут хэртээ өнгөрч тэрээр дуугарах сэхээ ормогцоо,

-Өөрөөр хэлбэл, надад... Би хэзээ ч зүүн гараа хөдөлгөж чадахгүй юу? гэхэд нь,

-Тийм ээ. Амьд үлдсэн хувь заяандаа талархсан нь дээр биз. Дээрэмчний хутга артерын судсыг хагалснаас та их цус алдсан.

Таны гарт жар шахам оёдол тавьсан, эрхэм ээ хэмээн мэс засалч эмч эелдэгээр тал засан тайлбарлав.

-Бурхан минь, бүр юу ч хийж чадахгүй болох гэж үү? хэмээн Филипп арга тасран асуухад нь,

-Юухан хээхнийг ч хийнээ. Таны гарт суулгасан хиймэл суулгац нь дадаж дасвал, яваандаа гар тань зарим нэг хөдөлгөөнийг хийж чадах л юм.

Гэсэн ч хөдөлгөөний тоо, хэмжээ их хязгаарлагдмал байна гэдгийг хэлэх ёстой гэв.

Амьд сүг явснаас үхсэн нь дээр байж дээ гэж Филипп бодлоо.

-Шарх анъж эхлэхэд та асар их өвдөлтийг мэдрэх болно, ноён Адлер аа. Мэдээж танд өвчин

намдаах үүднээс мэдээгүйжүүлэх эм өгнө. Эрт орой хэзээ нэг цагт өвдөлт намдана гэдгийг батлан хэлэх байна.

-Тэгтлээ их өвдөхгүй байх юмсан. Өвдөхгүй л юмсан! Хэмээн Филипп залбирав.

Түүнийг хүлээж буй аймшигаас яагаад ч аварч чадахгүй нь лав боллоо.

Филипптэй уулзахаар эмнэлэг дээр цагдаагийн мөрдөгч ирэн орных дэргэд зогсоход өнгөрсөн нийгмийн хүн болов уу гэмээр, жар орчим насны, ядарсан царайтай, нүд нь

муудсан бололтой хүн байлаа.

"Намайг түрүүч Манчини гэдэг, Ноён Адлер. Танд ийм явдал тохиолдсонд тун харамсалтай байна." гээд үргэлжлүүлэн "Тэд үүний оронд таны хөлийг хугалж чадаагүй нь тун харамсалтай юм. Би гэхдээ ингэж хэлэх гэсэн ... юм л даа ... хэрэв хугалсан бол л ..." гэв.

"Таны юу гэх гэснийг би ойлгож байнаа." гэж Филипп хэлэх үед Говард Келлер өрөөнд орж ирлээ. "Би Лараг хайж явна л даа." гээд Филиппийг нэг л сонин хараад "Өө уучлаарай!" хэмээв.

"Лара энэ хавиар байгаа." гээд "Энэ түрүүч Манчини,. Говард Келлер."  
гэж тэр хоёрыг танилцуулав.  
Манчини Келлер лүү хараад

"Та нэг л танил харагдаад байх чинь.  
Бид урд нь уулзаж байсан бил үү?"

"Би тэгж бодохгүй байна шүү."

Гэнэт Манчинигийн царай гэрэлтэн  
"Келлер! Ээ Бурхан минь, чи чинь  
Чикагод бейсболл тоглож байсан  
шүү дээ."

"Тиймээ. Харин та яаж мэддэг ...?"

"Би нэг зун Кабуудын дасгалжүүлэгч

байсан юм. Би одоо болтол таны эргүүлэгтэй шидэлт, бөмбөгний атгалтыг чинь санадаг юм. Танд уг нь том боломж, карьер байсан даа."

"Тиймээ, За тэгэхээр намайг өршөөнө үү ... би ..." гээд Келлер Филипп рүү харан "Би Лараг гадаа хүлээж байя даа" гэж хэлэнгүүтээ өрөөнөөс гарч явлаа.

Манчини Филипп рүү эргэн "Тан руу халдсан хүнийг та харж чадсан уу?" гэж асуув.

"Тэр Кавказ царайтай эрэгтэй хүн байсан. Том биетэй, метр ная орчим өндөртэй, илүү өндөр ч байж

магадгүй."

"Тэр хүнээ та дахин харвал таних уу?"

"Танина." Тэр царайг хэзээ ч мартажгүй биз.

"Ноён Адлер, дээрмийн халдлагын хэргүүдээс үзвэл, ер нь илэн далангүй хэлэхэд надад бол танд халдсан хэрэг их цаг зарсан харагдаж байгаа юм. Энэ бол яг ч мэргэжлийн дээрэмчдийн хийсэн хэрэг биш гэх гээд байна л даа. Энэ хотод зуугаад илүү гудамжны дээрэмчид байгаа. Тэднийг газар дээр нь баривчлаагүй тэд

дээрэмдсэн зүйлээ аваад ум хумгүй зугтсан юм." гээд тэмдэглэлийн дэвтрээ гарган "Таны юуг дээрэмдэн авсан?"

"Түрийвч, бас бугуйн цагийг минь."

"Ямаршуухан цаг байсан бэ?"

"Пиажет"

"Цаг тань ямар нэг онцгой содон тэмдэгтэй юү? Жишээ нь, ямар нэгэн бичиг ч юм уу?"

Энэ нь Ларагийн түүнд бэлэглэсэн байсан байлаа. "Тиймээ. Цагны ар талд "Филиппэд хайрт Ларагаас""



гэсэн байгаа. Түрүүч дэвтэртээ бичиж авлаа.

"Ноён Адлер ... танаас асуух хэдэн асуулт байна л даа. Та энэ хүнтэй өмнө нь тааралдаж юмуу уулзаж байсан уу?"

"Өмнө нь уулзаж байсан уу гэнээ?"  
Үгүй. Яажийна?" гээд Филипп түүн рүү гайхан харав.

"Надад их сонин санагдаад байна."  
гээд түрүүч дэвтрээ хойш тавиад

"Тэгэхээр, бид юу хийж чадахаа харан байж больё доо. Та их азтай хүн юм, ноён Адлер."

"Тийм гэж үү?" гэх Филиппийн хоолойнд гуниг харуусал дүүрэн сонсогдлоо.

"Тийм ээ. Энэ хотод хэдэн мянган гудамжны дээрэмчид гэмт хэрэг үйлдэж байна, бидэнд тэр болгонтой хөөцөлдөж цаг зав үнэндээ алга. Харин манай ахмад таны жинхэнэ шүтэн бишрэгч. Тэр таны бүх тоглолтын СД-ыг цуглуулсан гээд бод доо. Танд халдсан этгээдийг барихын тулд тэр чадах бүхнээ хийнэ гэсэн. Бид таны тодорхойлсон цагны шинж тэмдгийг улс даяарх ломбардууд руу илгээнэ."

"Хэрэв түүнийг барихын бол миний

гарыг буцааж өгч чадах эсэхийг асуугаарай." гэж Филипп гунигтайхан хэллээ.

"Юу гэнээ?"

"Юу ч биш дээ."

"Бид тун удахгүй танд шинэ мэдээ дуулганаа. Өдрийг тавтай өнгөрүүлээрэй!"

Лара Келлер хоёр мөрдөгчийг хонгилд хүлээж байлаа. Лара түүнийг гарч ирэхийг хараад

"Та надтай уулзана гэсэн гэв үү?" гэж асуув.

"Тийм ээ. Надад танаас асуух хэд хэдэн асуулт байна." гэж мөрдөгч Манчини хэлээд

"Хадагтай Адлер, танай нөхөрт таны мэдэхээр ямар нэгэн дайсан байгаа юу?" гэхэд Лара хөмсгөө зангидан

"Дайсаан? Үгүй. Яасан?"

"Хэн ч түүнд атаархаж байгаагүй юу? Магадгүй өөр хөгжимчин ч юм уу? Түүнийг бэртэж гэмтэхийг хүссэн хэн нэгэн ч юм уу?"

"Та үүгээрээ юу хэлэх гээд байна? Энэ чинь жирийн нэг гудамжны дээрэм биш болж байна уу?"

"Нууцгүй хэлэхэд энэ бол жирийн нэг дээрэм байгаагүй үзтэл илэрхий байна. Дээрэмчин эхлээд таны нөхрийн бугуйг огтлоод дараа нь түрийвч, цаг хоёрыг авсан байна."

"Би тэгээд ямар ч өөр ялгааг олж харахгүй ..."

"Энэ бол ямар аргагүй урдаас төлөвлөсөн халдлага байсан байна. Нөхөр тань ямар ч эсэргүүцэл үзүүлээгүй. Балчир хүүхэд ч ингэж хийхгүй нь лав, гэвч ..." гээд мөрөө хавчин "Би удахгүй холбоо барих болно." гээд тэр явав.

"Бурхан минь!" гээд Келлер "Тэр

үүнийг зохион байгуулалттай хэрэг гэж үзэж байна." гэлээ.

Лараг цонхийхийг хараад Келлер аажуухнаар "Ээ Бурхан минь! Пол Мартинийн хийсэн ажил! Харин тэр яагаад ингэж байгаан бол оо?" гэж хэлэв.

Лара ингэж хэлж арай л чадсангүй. "Тэр ... тэр магадгүй энийг надад тус болж байгаа гэж бодож хийсэн байх. Филипп үргэлж ... үргэлж л гадагшаа яваад, Пол тэрийг нь дандаа ... дандаа буруушаадаг байсан. Түүнтэй ярилцах хэрэгтэй юм байна. Ээ, Говард минь!" гэж ээрч муурлаа. Тэгээд Лара толгойгоо түүний

мөрөнд наан урсах нулимсаа архив.

"Тэр ёстой нохойн хүү юм даа!" Би чамайг түүнээс хол бай гэж үргэлж сануулдаг байсан даа."

Лара гүнзгий амьсгаа аван "Филипп зөв зүгээр болох болно. Тэр тэгэх ёстой." гэлээ.

Гурав хоногийн дараа Лара Филиппийг эмнэлгээс гарган гэртээ аваачлаа. Тэр цонхийн чичирч байв. Мариан Белл хаалганы дэргэд тэднийг угтаж авлаа. Тэр өдөр бүр Филиппийг эргэн түүнд ирсэн мэдээ, захиаг авчирч өгдөг байсан юм.

Дэлхийн өнцөг булан бүрээс түүний шүтэн бишрэгчид харамслаа илэрхийлсэн, сэтгэл зассан, хурдан илааршихыг хүссэн захиа, ил захидал, утасны дуудлага илгээжээ. Сонингууд эл хэргийн тухай дуу дуугаа авалцан бичиж, Нью Йоркын гудамжны хүчирхийлэгчийг буруушаана.

Утас нь дуугарахад Лара номын санд байж байв. "Тантай ярья гэнээ. Ммм ... Ноён Пол Мар ... байна" гэж Мариан хэлэхэд "Би түүнтэй ярьж чадахгүй нь." гэж Лара хариулав. Лара тэндээ хөшөө шиг зогсон аль болох чичрэхгүйг хичээж байлаа.



## Гучин нэгдүгээр бүлэг.

Нэг шөнийн дотор Ларагийн амьдрал нь тэс өөрөөр эргэх нь тэр.

-Өнаөдрөөс эхлэн би гэртээ ажиллана. Филиппийн дэргэдээс холдмооргүй байна гэж Ляра Говардад хэлжээ.

Түргэн эдгэрэхийг хүссэн утасны дуудлага, захидал тасралтгүй ирсээр, тэр бүгдэд үнэнч туслагч, хамгаалагч болсон Мэриан Белл л хариу илгээх болжээ.

-Хатагтай Камерон, энэ бүгдийг надад найдаж орхи. Танд үүнээс

дутахааргүй сэтгэл зовоосон яжил  
бий гэхэд нь Лара,

-Баярлалаа. Мэриан гэв.

Уильям Эллерби хэд хэдэн удаа  
утасдсан боловч Филипп ярихаас  
татгалзав.

-Одоо надад хэн ч хэрэггүй. Чамаас  
өөр бусад хэн ч хэрэггүй гэж тэрээр  
Ларад хэлжээ.

Стэнтон эмчийн зөв байжээ. Гар нь  
өвдөх гэж солиоруулах шахах  
боловч Фил тэсвэрлэхийн эцэсгүй  
болсон цагт л мэдээ алдуулах эмээ  
ууж байлаа.

Лара нөхрөөсоо алхам ч холдсонгүй.

-Хайрт минь, бид сайн эмч олно шүү дээ. Тэдний хэн нэг нь чамд туслаж чадах болно. Саяхан би нэг профессорын тухай... гэтэл Филипп үгийг нь таслан,

-Ямар ч нэмэргүй ээ. Би зэрэмдэг хүн хэмээн боолттой гараа харан өгүүлэв.

-Яана гэнээ? хэмээн Лара зэмлээд,

-Чи олон юм хийж чаддаг болно. Энэ бүгдэд би л буруутай. Хэрэв би Рино руу яваагүй, чамтай хамт байсан бол ийм юм болохгүй байсан. Надад...

гэтэл Филипп мушийн инээж,

-Чи намайг аль болох гэртээ байлгахыг хүссэн дээ. Тэгэхээр чиний хүсэл биелжээ гэв.

-Нэгэн мэргэн хүн: "Хүслээ хязгаарлаж бай, эс тэгвээс хэрэгжиж мэднэ" гэж хэлсэн байдаг юм хэмээн Лара сөөнгө дуугаар хэлснээ,

-Тийм ээ, би чамайг аль болох гэртээ байлгахыг хүссэн, гэхдээ ийм үнэ цэнээр биш шүү! гэлээ.

-Бүү шанал. Би ямар нэг юм бодож сэдэх хэрэгтэй байна. Гай газар дороос гэгчээр бүх юм гэнэт болсон.

Одоохондоо...би ноцтой байдлыг харахан мэдрээгүй л байна гэж Филипп түүнийг тайвшруулахыг оролдов.

Говард Келлер орж ирэн,

-Мэнд үү, Фил ээ. Бие чинь яаж байна? гэлээ.

-Гайхалтай сайн. Үүнээс сайн байна гэж юу байхав.

-Тэнэг асуулт асуусанд уучлаарай хэмээн Говардыг гэмшин бувтнахад,

-Бүү тоо, Говард аа. Би сэтгэлээ барьж чадсангүй гээд эрүүл гараа

урагш сунган,

-Тэр өөдгүй новш баруун гарыг минь сийчсэн ч болоосой! Зүүн гараар тоглоход зориулан бичсэн арваад концерт байдаг юм шүү дээ гэв.

Келлер саявтархан: Франц Шмидт, Корнгольд, Равель гээд олон олон зохиолчид зүүн гараар тусгайлан тоглоход зориулан зохиосон концерт байдгийг сонсож байсан байна.

Үүнийгээ Пол Мартинаас сонссон юмсанж.

Стэнтон эмч нэгэн өдөр боолтыг

авах болсон гэж үзээд боолтыг  
задалбал аймшигтай улаан нялга  
болсон сорви нүцгэрэн ил гарлаа.

-Сарвугаараа нугалж болохгүй нь  
уу? гэж эмчийг асуухад Филипп  
нэгэнтээ оролдоод,

-Болохгүй нь ээ гэв.

-Өвдөж байна уу?

-Өвдөх гэж тамлах юм, гэсэн ч би  
үрлэн эмүүдийг чинь дахиж уухгүй  
шүү.

-Ямартаа ч байсан нэг жор үлдээе  
дээ. Ноён Адлер аа, 2-3 долоо

хоногийн дараа өвчин намдана,  
итгээрэй гээд Стэнтон эмч босон,

-Харамсалтай, тун харамсалтай.  
Үргэлж өөрийгөө таны шуналтай  
шүтэн бишрэгчид тооцож явсан сан  
хэмээн харамсан өгүүлэхэд нь,

-Дэлгүүрээр дүүрэн миний дискнүүд  
бий дээ хэмээн Филипп тасалданги  
дуугаар хэлжээ.

-Ноён Адлерыг өөр мэс заслын сайн  
эмчид үзүүлбэл дээргүй юу? хэмээн  
нэг удаа Мэриан Беллийг асуухад,

Лара бодол болон,



-Үзээд алдаж болох л юм. Тэглээ гээд муу юм юу л болоо аж дээ гэсэн байна.

Гэвч Филипп түүний үгийг сонсохын ч хүссэнгүй.

-Ямар хэрэгтэй юм бэ? Стэнтон эмч хэлэхдээ... гэж Филиппийг татгалзахад нь Лара,

-Стэнтон Бурхан биш дээ. Би ямар ч байсан эмч олж үзүүлнэ хэмээн үгийг нь тасдан хэлжээ.

Нэг өдрийн дараа цэл залуухан эр пентхауст морилон ирэв. Лара түүнийг дагуулан Филипп дээр орж,

-Филипп ээ, танилц. Энэ Россман эмч. Тэр Колумбын эмнэлэгт ажилладаг. Би түүнийг чиний гарыг үзэж өгөөч гэж гуйсан юм гэлээ.

-За, за гэж Филипп үл итгэсэн янзаар дуугарлаа.

-Ноён Адлер аа, ханцуйгаа шамла даа хэмээн эмчийг хүсэхэд Филипп үг дуугүй захирагдахад Россман сарвууг нь няхуур гэгч нь үзлээ.

-Нилээд гэмтжээ, гэсэн ч итгэл алдах хэрэггүй биз ээ. Хуруунуудаа хөдөлгөж чадах уу? гэв.

Адлер оролдоод үзсэнд,

-Аан-хаан. бүгд хөдөлж байна гээч!  
Улам сайжруулах хэрэгтэй юм байна  
гэж эмч эр ихэд урамшин хэлэв.

Өвдсөндөө Филиппийн нүд нь  
харанхуйлаад ирлээ. Эхний  
удаагийн сургуулилт нь хагас цаг  
шахам үргэлжилжээ. Россман эмч  
явахын өмнө салах ёс гүйцэтгэн,

Маргааш уулзая, эрхэм ээ гэв.

-Үгүй. Огт хэрэггүй хэмээн Филипп  
өвдсөндөө халшран өгүүлэхэд нь  
Лара,

-Фил!, Чи хуруу гараа хөдөлгөхийг ч  
оролдохгүй байгаа юм уу? гэв.

-Би оролдсон! Лара минь, ойлгож үз, миний гар үхчихсэн, тэгээд ч амь орох хөг нь өнгөрсөн гэж Филиппийг архирахад,

-Фил ээ... гэх Ларагийн нүдэнд нулимс мэлтэглэв.

-Өршөөгөөрэй... надад хугацаа өгөөч дээ хэмээн Филипп хэлэхчээ аядав.

Шөнө хөгжим хангинан Лараг сэрээлээ. Лара орноосоо өлмий дээр ээ мяраасаар танхимд орж ирвэл мөрөн дээгүүрээ халаад нөмөрсөн Филипп төгөлдөр хуурын ард суучихсан баруун гар нь товчлуур дээгүүр шаламгай гүйж байлаа.

Гэтэл Лараг хармагц шалмаг  
хуруунууд нь хөшиж орхих нь тэр.

-Унтахад чинь саад болчихов уу?  
Уучлаарай.

Лара хуур тийш дөхөж очин,

-Хайрт минь... чи минь! гэж ээрэхэд  
нь Филипп,

-Ямар гашуун хувь заяа гээч вэ, тийм  
үү? Төгөлдөр хуурчтай гэрлэж,  
зэрэмдэг эртэй амьдрах болох нь!  
гэв. Лара мөрөөр нь тэврэн,

-Чи зэрэмдэг биш шүү! Чи бүгдийг  
чадна гэв.

-Больш үз!

-Би бодохдоо...

-Мэдэж байна. Миний буруу Лара, миний буруу гэснээ Филипп эрэмдэг болсон гараа савчин,

-Яагаад ч үүнтэй эвлэрэхгүй нь ээ гэв.

-Явж унтая хэмээн Лараг өгүүлэхэд нь Филипп,

-Үгүй. Чи явж бай. Би жаахан сууна гэжээ. Тэр ирээдүйн тухай бодсоор үүр цайтал суулаа. Юуных нь ирээдүй байх билээ?

Лара, Филипп хоёр оройн хоолоо идэцгээн, үдшийн мэдээ үзээд унтахаар хэвтэцгээв.

-Лара би, эр нөхрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй нь ээ. Би... сексийн тухай бодох тэнхэл алга. Үүнд чиний буруу байхгүй шүү гэж Филиппийг хэлэхэд Лара эгдүүцэн орон дээрээ өндийн суугаад,

-Би чиний бие эрхтэнд болж гэрлээгүй! Би чамд хайртай, хайртай! Бэлгийн хавьтал хийхгүй байх нь намайг огт айлгахгүй. Тэврээд л хэвт, тэгээд л болоо гэжээ.

Филипп эрүүл гараараа түүнийг

биедээ наан тэврэв.

-Өршөөгөөрэй Лара. Чамдаа би хайртай шүү.

Ларагийн найз нар нь зоогонд урьсан боловч Филипп гэрээсээ гарахаас дургүйцэн,

-Лара, чи яв. Энэ чамд хэрэгтэй, бизнес чинь үүнийг шаардаж байгаа гэв.

-Шаардаж л байг. Надад чи л хэрэгтэй. Бид гэртээ сайхан хооллоноо хэмээн Лара бас татгалзав.



Ларагийн тогооч Филиппийн дуртай  
хоолонд гаршин бэлтгэсэн боловч  
түүний идэх дур нь оргүй алга  
болжээ. Ажил хэргийн зөвлөлгөөн  
бүрийг Лара пентхаустаа явуулан,  
гадагш гарах ажил гарсан үедээ,

-Мэриан би ганц хоёр цагийн дараа  
ирнэ, ноён Адлерыг анзаарч  
байгаарай гэж хэлэхэд нь нарийн  
бичгийн дарга,

-Тэгнээ, хатагтай Адлер аа гэдэг  
байлаа.

Нэг өглөө Лара,

-Хайрт минь, чамайг ганцааранг

чинь үлдээмээргүй байна. гэтэл  
Кливленд орох ажил гарлаа, ердөө л  
өдрийн ажил. Тэснэ биз дээ? гэвэл,

-Асуух юу байх вэ! Мэдээж шүү дээ.  
Санаа зоволтгүй яваарай гэж  
Филипп хэлэв.

Мэриан түүнд хэдэн захидал  
гардуулав.

-Та гарын үсгээ зурахгүй юу, ноён  
Адлер аа?

-Мэдээж хэрэг гэснээ муухан  
жуумагнан баруун гараа даллаж,

-Баруун гартайгаа үлдсэн минь зол

болжээ, тийм үү? Өршөөгөөрэй,  
Мэриан, би таныг миний өмнөөс  
хариу бичих юм гэж огт санаагүй  
шүү гэхэд нь бүсгүй гайхан,

-Ноён Адлер аа, та юу ярина вэ? Та  
чинь найз нөхөдтэйгээ уулзах  
хүсэлгүй байгаа биз дээ? гэвэл  
Филипп,

-Миний найз нар завгүй байгаа. Тэд  
тоглолттой. Үүнийг ойлгоход тийм  
хэцүү байна уу? хэмээн ууртайгаар  
хэлээд танхим тийш эргэжээ.

Мэриан түүний араас уйтгартайгаар  
харав. Харин нэг цагийн дараа  
Филипп компьютерийн ард суугаа

Мэрианы өрөөнд орж ирээд,

-Мэриан аа! гэхэд нь,

-За, ноён Адлер аа, таныг сонсож байна? гэж нарийн бичгийн дарга бүсгүй хэлэв.

-Намайг уучлаарай. Би тэвчишгүй бүдүүлэг харьцжээ.

-Зүгээр ээ, эрхэм ээ.

Филипп ойролцоох сандалд тухлан сууж,

-Би өөрийгөө эрэмдэг болсон гэж бодоод гэрээсээ гарахгүй байгаа юм.

Хүмүүс зэрэмдэглүүлсэн гарыг минь  
гөлийн ширтэх болно, надад тэдний  
өрөвдөх сэтгэл огт хэрэггүй хэмээн  
хүүрнэж эхэллээ.

Мэриан дуугүй суусаар,

-Мэриан та их эелдэг юм, би үүнийг  
чинь үнэлж байна, чин үнэн шүү.

Танд ч хүртэл арга ядах үе гардаг  
биздээ. Өндөрт гарах тусам, улам их  
өвдөхөөр унадаг гэж ярьдагийг та юу  
эс андах вэ. Би хэтэрхий өндрөөс  
нисчээ. Надад хатан хаан алга  
ташиж... гэснээ Филипп гашуудан  
толгой сэгсэрч,

-Миний хөгжмийг бүх л дэлхий

даяар Хятад, Орос, Энэтхэг, Герман  
бахархаж... гэснээ хоолой нь  
зангиран нүдэнд нь нулимс  
гүйлэгнээд ирлээ.

-Би усан нүдэлсэн уйланхай амьтан  
болж хувирсан юм шиг санагдаагүй  
биз? гээд тэрээр арай ядан биеэн  
барьж байгаа нь илт харагдав.

-Ноён Адлер аа... таныг хувь заяа  
тань ивээх болно.

-Үгүй ээ! Бүх юм өнгөрсөн! Би  
зэрэмдэг хүн болсон!

-Тэгж бүү яриач! Таны эхнэрийн зөв,  
та ихийг хийж чадна. Өвчин

намдмагц, та яг урьдынхтай адил  
болно гэж Мэриан бүсгүй итгэл төгс  
хэлэв.

Адлер халааснаасаа алчуур гарган  
нулимсаа арчин,

-Гэгээн тэнгэр минь гэж, нус  
нулимстайгаа холилдох л дутаж гэнэ  
дээ! хэмээвэл,

-Нулимс сэтгэлийг чинь тайтгаруулж  
байгаа бол дотроо онгойтол уйл,  
уйл гэж бүсгүй өгүүлэв.

Филипп толгойгоо өлийлгөн,

-Мэриан, та хэдтэй вэ? гэж асуухад

нь бүсгүй,

-Хорин зургаатай хэмээн хариулав.

-Таны хаанаас ийм цэцэн ухаан гарна вэ?

-Юуных нь цэцэн ухаан байх вэ, ноён Адлер аа. Би ердөө л таны амсаж буй зовлонг чинь ойлгож байна. Ийм эмгэнэлт явдал тохиолдохгүй байхын тулд хэн ч юугаа ч хайрлахгүй байх байсан. Харин бодит байдлыг яаж ч өөрчлөхгүй. Та хойшид хэрхэх замаа хайж олохыг хичээж оролд доо.

-Мэриан та энд цагаа дэмий үрж



байна даа. Та сэтгэл судлаач болох байж дээ.

-Та юм уумаар байна уу?

-Үгүй ээ, баярлалаа. Харин хоёул бэкгэммон тоглох уу?

-Дуртайяа зөвшөөрье, ноён Адлер аа.

-Тийм бол чи намайг зүгээр л Филипп гэж дуудаж байвал ямар вэ?

Энэ мөчөөс хойш тэд өдөр бүр бэкгэммон тоглох болжээ.

Өмгөөлөгч Терри Хилл Ларад

утасдаж,

-Муу мэдээ дуулгах болох нь ээ гэхэд  
нь Лара биеэ бэлтгэн эзэмдээд,

-За алив илтгээрэй гэсэнд,

-Мөрийтэй тоглоомын комиссоос  
лизензийг хүчингүй болгож, танд ял  
тулгах нь бололтой гэж өмгөөлөгч  
хэлэв.

Ларагийн амьсгаа нь бачуураад  
ирлээ. Пол Мартины "Бид хуулийн  
эсрэг юу ч хийгээгүй. Бүгд л ингэж  
хийдэг шүү дээ. Бүү санаа зов!" гэж  
хэлсэн нь санаанд нь орж ирэв.

-Терри, одоо юу хийж болох вэ?

-Яагаад ч нэмэргүй ээ. Хошуугаа ч цухуйлгах хэрэггүй. Би энэ талаар хөөцөлдье гэлээ.

Лара энэ бүгдийг Говардад ярихад тэрээр уулга алдан,

-Чөтгөр алгадаасай билээ! Риногоос орж ирэх мөнгөөр барьцааны мөнгөө төлчихнө гэж найдаж байсан сан! Тэд лицензийг чамд буцааж өгөх үү? гэж асуув.

-Мэдэхгүй ээ.

Говард бодолд автан,

-За яах вэ, Чикагод байгаа зочид буудлаа зарахад Хьюстоны төлбөрийг хийхэд хангалттай хүрнэ. Үл хөдлөх хөрөнгийн зах зээл туйлын тогтворгүй байна. Зээлийн конторууд сүйрлийн ирмэгт тулчихсан, Бернэм Ламбөрт өөрийн ажилбараа цомхотгож эхэлжээ. "Хог"-ийн гэгдэх акцууд жинхэнэ хог болжээ. Хэзээ нэг цагт хямралыг хүлээн зөвшөөрөх болох нь дээ. Банкнууд өрөө нэхэн, намайг зовоож эхэллээ. Тэд удтал ярилцацгаав.

Маргааш өдрийн "Бизнес уик"  
сэтгүүлд "ЭЗЭНТ ГҮРЭН ГАНХАЖ  
БАЙНА! ЛАРА КАМЕРОНД ЭРҮҮГИЙН

ХЭРЭГ ТУЛГАЖ БАЙНА. ТӨМӨР  
ХҮҮРЗГЭНЭ НАРАНД ҮЛДЭЖ ЧАДАХ  
БОЛОВ УУ? гэсэн томоос том  
гарчигтай нийтлэл хэвлэгджээ.

Лара зэвүүцэн сэтгүүлийг базаж  
авснаа,

-Яасан ичгүүргүй загнана вэ! Би  
тэднийг шүүхэд өгнө гэлээ.

-Тийм ч өөдтэй санаа биш байна  
даа! гэж Келлер гонгинов.

-Говардаа, миний бодлоор  
"Камерон-тауэр" бараг тэр чигээрээ  
түрээслэгдээд дуусчихсан билүү?

-Далан хувь нь түрээслэгдсэн, түрээслэх санал ирсээр байна. Ер нь "Саузерн иншуранс" хорин давхрыг нь, "Интернэшнл инвестменс" арван давхрыг тус тус аваад байгаа.

-Үлдсэн талбайг өгч дуусгавал бидний асуудлыг шийдвэрлэж дөнгөх мөнгөтэй болох нь ээ. Барилга хэзээ дуусах вэ?

-Зургаан сарын дараа дуусна.

-Говард аа, бид дэлхийд хосгүй өндөр барилга хүлээж авна гээд Лара ажлын ширээн дээрх өндөр барилгын загвар тийш эргэлээ. Нэг давхарт нь худалдааны шилэн

лангуунууд, дээд давхарт нь орон сууц, түүний дээр офисууд байрлах ажээ.

-Зар сурталчилгааны ажлаа эхлэх болжээ хэмээн Лара хэлэв.

-Зөвшөөрч байна гэснээ Келлер хөмсөг зангидсанд,

-Юу болоо вэ? гэж Лараг гайхан асуув.

-Зүгээр ээ... Стив Мерчисоны тухай бодлоо л доо. Тэр энэ газрыг авах гэж их чармайсан даа гэж Говард хэлэв.

-Гэвч газар биднийх болсон! гэж  
бахдалтайяа өгүүлэхэд нь,

-Тийм ээ, биднийх болсон гэж  
Келлер сунжруулан хэлэв. Лара  
Жерри Таунсендыг дуудан,

-Жерри "Камерон туар"-ын нээлтийг  
нэг л ер бусын онцгой байдлаар  
хийвэл сайн сан. Бодож сэдсэн юм  
байна уу? гэж асуув.

-Байнаа. Нээлт есөн сарын арванд  
болох гэлүү?

-Тийм ээ.

-Энэ өдөр анхаарлыг тань татахгүй



байна уу?

-За-а-даа... Өө, миний төрсөн өдөр үү дээ? гэж Лара асуулаа.

-Яг зөв. Давхар баяр тэмдэглэнээ гэж Таунсенд урамтай өгүүлэв.

Лара духаа илснээ,

-Болж байна! Сэтгэж шүү, Жерри. Бүгдийг урья! Дэлхий донсолтол нь шуугиан тарья. Зочдын нэрсийн жагсаалтыг гаргахаас эхлээ. Хоёр зуун хүн уривал ямар байна гэлээ.

Туансенд сэтгэл хангалуунаар мөрөө хавчисхийлгэн,

-Эргэлзэх юм алга. Эцсийн хувилбарыг та батлаарай гэлээ.

Лара босож, ширээн дээрээ хумхиж хаясан сэтгүүлийг авч дундуур нь хуваагаад хогийн сав руу илгээснээ,

-Би тэдэнд үзүүлээд өгнөө гэжээ.

-Уучлаарай хатагтай Камерон. Үндэсний барилгын холбооноос гуравдугаар шугамаар ярих гэнэ. Тав дахь өдрийн оройн зоогонд урьсан тэдний урилгын хариуг өгөөгүй юм байна? гэж нарийн бичгийн дарга хүүхнийг хэлэхэд Лара,

-Уучлалт гуйчих, би очиж чадахгүй

гэхэд нь Мэриан,

-Тэгье ээ, хатагтай гээд гарч явав.

-Лара чи надаас болж даянч аятай зожиглож суухын хэрэггүй. Дээдсийн хүрээний ажиллагаа их чухал шүү хэмээн Филипп зэмлэн хэллээ.

-Чи надад бүхнээс чухал. Парижид бидний гэрлэлтийн баталгааг гардуулсан тагжгар ламтан: "Насан үүрд зовлон жаргалд хамтдаа байгаарай" гэж хэлсэн байх аа. Ямартаа ч гэсэн надад тэгж санагдсан шүү. Миний франц хэл мэддэггүйг чи мэдэх юм хойно доо гэвэл Филипп инээмсэглэн,

-Харин би чамд ямар их хайртайг чи мэднэ дээ. Гэтэл би чамайг одоо там руу чирч байх ч гэж дээ хэмээв.

Лара нөхрөө тэврэн,

-Андуурч байна, хонгор минь.  
Жаргалын орон руу хөтөлж явна гэжээ.

Филипп хувцаслан, Лара товчийг нь товчлоход түүнд туслаж байлаа.  
Нөхөр нь толь руу хяламхийн харж,

-Чөтгөр гэж, би яг л хиппи нар шиг харагдаж байх чинь, үсээ засуулахсан гэлээ.

-Мэрианыг чиний үсчин рүү яриулах уу?

-Үгүй ээ, хонгор минь. Би гадагш гармааргүй байна.

Маргааш өглөө нь үсчин түүнийг зочдын танхимд хүлээж суужээ.

-Юу вэ? хэмээн Филипп эргэлзэн Лараг харлаа.

-Хайрт минь, үс сайхан бол зүс сайхан гэдэг. Тэр долоо хоног бүр ирэх болно гэж Лара хэлэв.

-Чи гайхамшигтай юмаа!

-Энэ зөвхөн эхлэл шүү, Фил ээ.

Маргааш өдөр нь бөс даавууны үлгэр барьсан оёдолчин иржээ.

-Энэ чинь юу болоод байна вэ? хэмээн Филипп тааварлаж ядан асуулаа.

-Чи-чиний шүүгээнд зургаан фрак, дөрвөн смокинг, гурван костюм л байна. Гадаад үзэмжиндээ анхаарах цаг болжээ! гэж Лараг хэлэхэд,

-Яах гэж тэр вэ? Би хаачих юм бэ? хэмээн Филипп гайхан асуусан ч гэлээ тэр оёдолчинд зайлшгүй шаардлагатай хэмжээ авахыг зөв

шөөрчээ.

Долоо хоногийн эцсээр гуталчин ирсэн байв.

-Бас яах нь вэ? гэж Адлер залхсан янзтай асуухад,

-Одоо гуталны ээлж!

-Лара би гэрээсээ гарахгүй шүү дээ хэмээн Филиппийг дур гүйцэхэд нь,

-Мэдэж байна. Гэвч гадагш гарахад чинь бүгд бэлэн байг гэвэл тэрээр эхнэрээ үнсэн,

-Би хэнд ч хэрэггүй болсон хүн шүү

дээ гэв.

-Наадахыг чинь сонсохоороо л нэг боллоо.

Офист болж байсан зөвлөлгөөн дээр  
Келлер,

-Бид Лос-Анжелес дахь худалдааны  
цогцолбороосоо хагацах болох нь  
дээ. Банкууд зээлээ даруй төлөхийг  
шаардаж байна хэмээн мэдэгдэв.

-Гэвч тэд тэгж зүрхлэхгүй...

-Лара тэд аль хэдийнэ хөдлөөд  
эхэлцгээсэн. Бид төлбөрийг хичнээн  
хойшлуулаад байгаа билээ.



-Ганц хоёр объектоо барьцаанд тавиад мөнгө авч болно биз дээ гэж Лараг хэлэхэд,

-Манай данс улайчихаад байна. Удахгүй "Камерон-таур"-ын жаран саяыг төлөх ёстой хэмээн Говард тайван гэгч нь тайлбарлав.

-Мэдэж байна. Нээлт болтол дөрвөн сар байна. Банкны төлбөрийг хойшлуулахаар тохиролц!  
Барилгачид хуваарь ёсоор ажиллаж байгаа юу?

-Тийм ээ гэснээ Келлер бодол болон Лараг ширтэв. Жилийн өмнө Ларагийн толгой дээр ийм асуулдал

буухгүй байх байсан даа. Тэр үед тэрээр ажил хэргээ гарын таван хуруу шигээ мэддэг байсан сан.

-Өршөөгөөрэй, би чамайг офис дээрээ ахиу цагаар ажиллавал дээр хэмээн бодох юм. Байдал хяналтаас гарч, зөвхөн чиний л шийдэж чадах асуудлууд хуралдчихаад байна гэж Келлер хэлэхэд нь,

Лара дурамжхан толгой дохиж,

-За за, маргааш өглөө энд ирсэн байна гэлээ.

-Менежир Уильям Эллерби ярьж байна гэж Мэрианыг мэдэгдэхэд,

-Намайг түүнтэй ярьж чадахгүй гэж хэл гээд Филипп түүнийг харилцуур орхисон ширээ хүртэл нь араас нь харсаар суув.

-Уучлаарай, ноён Адлер завгүй байна. Түүнд юу дамжуулах вэ? За, заавал хэлнэ. Баярлалаа, эрхэм ээ гээд Мэриан буйдан тийш нэг алхам дөхөж,

-Тэр тантай хооллох гэнэ гэв.

-Одоо нэгэнт хүртэж чадахаа байсан шан харамжны тухай санасны ч хэрэггүй биз дээ.

-Магад ч үгүй. Болсон явдлаас хойш

Эллерби таныг үзэн ядаж байгаа даа.

-Бурхан минь гэж, Мэриан. Миний үг яриа тэгж хэлээд байна уу? гэж Филипп гайхан асуувал,

-Тийм ээ, ноён Адлер аа хэмээн угийн шударга зантай нарийн бичгийн дарга бүсгүй эрс хариулав.

-Та намайг яаж тэвчиж байна вэ? гэж Адлерыг хэлэхэд бүсгүй инээмсэглэн,

-Энэ тийм ч хэцүү бишээ гэв.

Нэг өдрийн дараа Уильям Эллерби

дахин залгахад Филипп угаалгын  
өрөөнд байсан тул Мэриан өөрөө  
түүнтэй ярьжээ. Адлерыг гарч ирэхэд  
Мэриан бүсгүй,

-Ноён Адлер аа, Эллерби дахиад  
ярьсан гэвэл,

-Дараагийн удаа ярихад нь миний  
утасны дугаарыг март гэж түүнд  
хэлээрэй хэмээн Филипп дургүйцэн  
хэлэв.

-Та үүнийгээ өөрөө хэлж болох юм?  
Пүрэв гаригийн нэг цагт та түүнтэй  
үдийн хоол идэх ёстой гэв.

-Юу?

-Тэр "Лё цирк"-эд очих санал болгосон, гэхдээ би жижгэвтэр ресторан байвал илүү зохимжтой гэж бодлоо. Эллерби таныг "Бээжин нугас" рестораны үүдэнд хүлээж байх болно. Би жолоочид хаягийг өгчихнө.

-Та миний өмнөөс яахыг минь төлөвлөх зориг гаргажээ дээ, Мэриан аа? гэж Филипп хорсолтой гэгч нь хэллээ.

-Ноён Адлер, та өөрөө хэзээ ч ингэж шийдэж чадахгүй. Та намайг халсан ч болно хэмээн бүсгүй ажигч үгүй хэлэв.

Филиппийн нүд гайхсандаа гялалзаж  
байснаа эцэст нь уруул нь сунан  
мушийн инээмсэглэж,

-Яагаад үгүй гэж? Би хятад хоол  
идэлгүй уджээ! гэжээ.

Лараг гэртээ ирэхэд Филипп,

-Пүрэв гаригт Эллербитэй үдийн  
хоол идэх болсон гэв.

-Хэлэх ч юм алга, хайрт минь! Гэхдээ  
чи яаж ийм шийдвэр гаргаа вэ? гэж  
Лара гайхан асуухад нь,

-Мэриан шийдсэн юм. Намайг гэртээ  
бүгээд цоожтой суугаад байж

болохгүй гэнээ гэв.

-Нээрэн үү? Мэриан ухаалаг бүсгүй шүү! гэснээ Гэтэл чи миний үгийг сонсохгүй байсан даа гэж Лара боджээ.

-Харин тийм ээ. Мэриантай би маргалдаад нэмэргүй бололтой дог оо.

Тэнэг, би дүүрчихсэн тэнэг юмаа!  
Эднийг хоёулхныг нь орхиж болохгүй. Филипп одоо тун ч арчаагүй эмзэг байгаа!

Мэриан Белл эндээс явах ёстой гэдэг нь эргэлзээгүй болжээ.



Маргааш орой нь Лара тэднийг  
хөлөгг тоглоомоор наадаж байхад  
ньтаарчээ!

Энэ бол тэдэнтэй тоглох бидний  
тоглоом!

-Танд дандаа л хоёр "зургаа"  
буугаад байвал би таныг яаж хожих  
вэ? гэж Филипп инээд алдан  
хэлэхийг сонсов.

Лара танхимын үүдэнд зогтусан  
зогслоо. Хүүхэн нөхөр нь хамгийн  
сүүлд хэзээ инээсэн билээ гэдгийг таг  
мартжээ.

-Оройн мэнд, хатагтай Адлер аа! гэж

Мэриан инээмсэглэн угтав.

Филипп цовоо гэгч нь буйдангаас босч,

-Сайн уу, хонгор минь! Энэ охин намайг дотоожтой минь үлдээтэл шалдалж орхих нь! гээд нөхөр нь эхнэрээ үнсэв.Их гайхуулцгаах нь ээ.

-Хатагтай Адлер аа, би танд хэрэг болох уу?

-Үгүй ээ, Мэриан. Одоо явж болно. Таныг маргааш өглөө хүлээж байя.

-Баярлалаа, ахайтан. Сайн сайхныг хүсье!

-Баяртай.Мэриан.

Цахилгаан шатны хаалга чимээгүй  
шахам хаагдахад Филипп,

-Энэ Мэриан тун сайн хамтран  
зүтгэгч шүү! гэлээ.

Лара түүний хацрыг энхрийлэн  
илээд,

-Хайрт минь, би чиний өмнөөс  
баярлаж байна гэв.

-Офисын ажил ямар байна даа?

-Сайн байнаа.

Хүүхэн өөрийн асуудлаар нөхрийгөө

тарчилгахыг бодсонгүй. Дахин Рино орж комиссын гишүүдтэй уулзах хэрэгтэй. Ядахад лицензийн эрхийг хаавал алдагдлыг тэсвэрлэх ёстой. Гэлээ ч ийм муу юм болохгүйн төлөө чадах бүхнээ хийх хэрэгтэй дээ.

-Филипп ээ, Би ажилдаа үлэмж их цаг гаргах хэрэгтэй болоод байна. Говард ганцаараа дөнгөхгүй нь гэв.

-Хайрт минь, Миний төлөө санаа бүү зов.

-Хэд хоногоос Рино орно. Хамт явж болно шүү дээ.

Филипп толгой сэгсэрч,

-Би ийм юманд явахад бэлэн биш байна. Одоохондоо шүү гээд тэрээр зүүн гар руугаа хяламхийв.

-За за, хайрт минь. Тэнд би хоёр, удлаа гэхэд гурав хононо.

\* \* \*

Мэриан Беллийг өглөө эртлэн пентхаус өөд өгсөж ирэхэд нь Лара түүнийг цахилгаан шатны дэргэд хүлээж байжээ. Филипп арай босоогүй байлаа.

-Мэриан... ноён Адлер төрсөн өдрөөр минь бэлэглэсэн индранил эрдэнийн бугуйвчийг санаж байна

үү?

-Санаж байна, хатагтай Адлер аа.

-Та түүнийг хамгийн сүүлд хэзээ харсан бэ?

-Таны орны дэргэдэх ширээн дээр байхыг харсан.

-Яг үнэн үү?

-Үнээн. Юу болоо вэ?

-Алга болсон юм шиг байна. Мэриан гайхан гэдрэг ухарлаа.

-Алга болсон гэнээ? Гэвч хэнд...

-Би үйлчлэгчээс асуусан. Хэн ч, юу ч мэдэхгүй байна.

-Цагдаа дуудаж болох юм...

-Хэрэггүй дээ. Нэр хугарахаар яс хугар гэдэг биз дээ.

-Би таныг ойлгосонгүй.

-Үнэхээр ойлгосонгүй юу? Үнэнээ хүлээсэн нь дээр биз дээ.

Мэриан бүсгүй Лараг нүд бүлтийн ширтэж,

-Хатагтай Адлер, би таны бугуйвчийг аваагүй гэдгийг та мэдэж байгаа шүү

дээ гэлээ.

-Би үүнийг яаж мэдэх вэ? Мэриан та явах болж дээ.

Лара хүн гүтгэсэн нүглийнхээ төлөө өөрийгөө үнэн сэтгэлээсээ үзэн ядаж байлаа.

Хэн ч Филиппийг надаас авах ёсгүй.  
Хэн ч шүү.

Өглөөний цай уух зуур тэрээр,

-Фил ээ, би өөр нарийн бичгийн даргатай болж магадгүй боллоо гэв.

Филипп сэрээгээ тавин, -Мэрианыг



ях гэж байгаа юм бэ? гэв.

-Тэр эндээс явах гэнэ. Түүнд Сан-Францискод сайн ажил санал болгосон...

-Өө! Яасан харамсалтай юм бэ, манайд байх түүнд таалагдаж байна гэж би бодож байсан юмсан.

-Тийм байсан гэдэгт эргэлзэхгүй байна. Гэвч чи түүний замд саад болохыг хүсэхгүй биз дээ? Өршөө, хайрт минь.

-Мэдээж, үгүй л дээ. Би Мэрианд сайн сайхныг л хүснэ. Тэр...

-Тэр одоо ирэхгүй.

-За яахав, шинэ тоглогч хайж олох хэрэг гарах нь ээ. -Жаахан хүлээнэ.

Ажлаа цэгцэлчихээд, хоёул тулалдана гэж эхнэр нь хэлжээ.

Филипп Уильям Эллербийн хамт "Бээжин нугас" рестораны булангийн ширээнд сууж байв.

-Филипп ээ, чамтай уулзсандаа тун баяртай байна. Би чам руу ярьсан боловч...

-Өршөөгөөрэй, Уильям. Би уулзахыг хүсээгүй юмаа.

-Цагдаагийнхан тэр өөдгүй новшийг эрж байгаа гэдэгт найдаж байна.

-Дэслэгч Манчини гудамжны дээрэм түүний хийдэг ажил биш гэж тун ч эелдэгээр хэлж байсан. Гэхдээ цагдаа нар алдагдсан муурыг эзэнд нь олж өгөх гэж их зүтгэнэ дээ.

Удтал дуугүй байсны эцэст Эллерби итгэл муутайхан,

-Миний ойлгож байгаагаар чи төгөлдөр хуурын ард суухгүй юм шив дээ? гэв.

Филипп өвчтэй гараа сунган,

-Үүнийг хардаа. Энэ үхчихсэн гэлээ.  
Эллерби урагш бөхийн,

-Чиний өмнө бүхэл бүтэн амьдрал  
байна гэв.

-Ийм гартай намайг яа гэх гэв?

-Сургах хэрэгтэй!

-Энэ тухай би бодоогүй биш бодсон.

-Тэгвэл чамайг юу зовоогоод байна?  
Саяхан над дээр Рочестер дахь  
Истмены хөгжмийн сургуулийн  
захирал найз маань ирсэн. Чам шиг  
багштай болохын тулд тэд юу ч  
хийхэд бэлэн байна лээ. Филипп

хөмсөг зангидан,

-Гэхдээ заавал нүүх хэрэг гарна.  
Лара Нью-Йоркд үлдэх болно гээд  
тэрээр толгой сэгсэрч,

-Үгүй, энэ бүтэхгүй хэрэг. Белл ээ, тэр  
надад ямар их үнэтэй болохыг чи  
мэдэж байна уу? гэв.

-Төсөөлж байнаа төсөөлж байна.

-Надаас болж Лара бүх ажлаа хөсөр  
орхисон. Надад түүний сэтгэлээр  
тахил өргөх хүсэл алга.

-Фил ээ, Рочестерээс дамжуулж буй  
саналыг бодож үзэхийг зөвлөх

байна.

-Найздаа, урьсанд чинь сэтгэл ханамжтай байна, гэвч татгалзсан хариу өгнө гэж хэлээрэй.

-Бодлоо өөрчилбөл надад дуулгаарай.

-Заавал дуулганаа.

Филиппийг эргэж ирэхэд Лара эзгүй, офис руугаа явсан байлаа. Адлер Эллербитэй ярилцсанаа бодон гэр дотуураа ийш тийш дэмий л холхиж гарав. Багш болоход татгалзах юм алга, эсвэл Рочестер руу нүүхийг Ларагаас гуйх уу? Түүнгүйгээр би

тэнд тэсэхгүй. Хаалга онгойв.

-Лара юу?

Босгон дээр Мэриан зогсож байлаа.

-Уучлаарай, ноён Адлер аа. Хэн ч байхгүй гэж бодсон юм шүү. Би түлхүүр өгөх гэж ирсэн юм.

-Би таныг Сан-Францискод байгаа л гэж бодлоо шүү. Мэриан гайхаж,

-Сан-Францискод ий? Яах гэж тэр вэ? гэв.

-Тэнд таныг шинэ газар ажилдурьсан юм биш үү?

-Намайг ямар ч ажилд уриагүй.

-Лара хэлэхдээ...

Мэриан бүгдийг ойлголоо.

-Тэгэхээр эхнэр тань намайг хөөсөн тухайгаа ганц ч үг дуугарахыг хүсээгүй юм байна л даа.

-Хөөсөн гэнээ? Тэр танд сайн ажил санал болгосон гэсэн шүү дээ.

-Надад хэн ч, хаанаас ч сайн ажил санал болгоогүй. Филипп сааталд орсон мэт алхсаар түүнд дөхөж,

-Алив сууцгаая гэв. Тэд өөд өөдөөсөө



харан буйданд суув.

-За алив, юу болсныг хэлээдэхээч?  
гэж Филиппийг асуухад нь Мэриан  
гүнзгий амьсгаа авлаа.

-Таны эхнэр, намайг... танд  
санаархаж байна хэмээн бодсон  
бололтой.

-Яалаа, яалаа гэнээ?

-Тэр намайг таны бэлэглэсэн  
бугуйвчийг хулгайлсан гэж  
буруутгасан. Энэ нь халах шалтаг  
болсон юм. Бугуйвч энд хаа нэгтээ  
байгаа.

-Итгэхгүй... Итгэхгүй байна! Лара хэзээ ч ийм юм хийхгүй. Филиппийн нүд хий гөлийжээ.

-Мэдэхгүй... мэдэхгүй нь юу гэж хэлэхээ ч мэдэхээ байлаа. Магад эхлээд Ларатай ярилцаад, дараа нь...

-Таныг гуйя хэрэггүй! Тэр намайг энд ирснийг мэдээгүй чигээрээ үлдсэн нь дээр гээд Мэриан босов.

-Та тэгээд хаачих юм бэ?

-Битгий санаа зов. Надад ажил олдоно.

-Мэриан, би танд юугаар ч юм тус болж чадах...

-Баярлалаа. Хэрэггүй.

-Та ажил олдоно гэдэгт итгэлтэй байна уу?

-Олдоно оо. Филипп ээ, биеэ бодоорой.

Хаалга аяархан хаагдах чимээ сонсогдов.

Филипп буйдан сандалд хөдөлгөөнгүй суусаар байлаа. Ларайм юм хийлээ гэж үү? Тэр яагаад юу ч хэлсэнгүй вэ? Мэриан үнэхээр

бугуйвчийг хулгайлчихсан, Лара  
урмыг минь хугалахыг хүсээгүй ч юм  
болов уу? За даа, мэдээж Мэриан л  
худлаа хэлээ биз дээ.

## Гучин хоёрдугаар бүлэг.

Петли дүүргийн яг төвд орших Стейт-стридэд нэгэн ломбард байх аж.

Жесси Шоу үүдийг нь түлхэн орвол хаалган дээр өлгөсөн жижигхэн хонх жингэнэн дуугарлаа. Лангууны ард суух ахимаг насны эр толгой өндийлгөн,

-Өглөөний мэнд, эрхэм ээ. Танд юугаар тус болох вэ? гэлээ.

Шоу халааснаасаа бугуйн цаг гарган,

-Үүнийг хэдээр тавьж болох бол? гэв.

Хөгшин эр нүдэндээ томруулдаг шил

барин,

- "Пьяж" байна! Цаг ч гэж цаг юмаа гэлээ.

- Тиймээ "Пьяж" байгаа юм. Уул нь ч тавьмааргүй л байна, гэвч заяа тавилан гэдэг хэцүү юм хойно. Та намайг зөв л ойлгоорой доо гэхэд нь ломбардыг эзэн мөрөө хавчисхийлгэн.

- Ойлгоно гэдэг миний ажил. Энэ лангууны ард суухдаа янз янзын түүх бишгүй л нэг сонслоо доо.

- Хэд хоногийн дараа би ирж авна, нэг дэх өдрөөс хэтрэхгүй. Нүдний

хор орохооргүй газар олов  
бололтой. Харин одоо надад бэлэн  
мөнгө хэрэгтэй байна, шударга  
үнээр шүү гэлээ.

Хөгшин цагийг нь авч эргүүлж  
тойруулан сайтар үзэж байснаа,  
таган дээрх хэзээ ч юм сийлбэр  
байсан бололтой, үсэг нь арилан  
мөлийсөн байхыг нь үзвээс  
зүлгүүрээр зүлгэсэн бололтой.

-Түр хүлээгээрэй, эрхэм ээ. Хэрэв  
болгоовол механизмыг нь шалгаж  
болох юм. Зарим нэг шилдэг  
маркуудыг Банпсонгод үйлдвэрлэдэг  
юм, тэндэхийн урчууд гэж муу  
аргатай улс даа! гээд хөгшин

хажуугийн өрөө рүү орж, хурц  
чийдэн асаан нүдэндээ томруулдаг  
шил зүүлээ. Энд тэнд тасарч  
бүдгэрсэн нарийхаи, бараг үл  
үзэгдэх зурааснууд нь: Ф... П... Л... С...  
АЙ" гэсэн үсэг болох нь мэдэгдэв.

Ломбардын эзэн ширээний  
шургуулганаас цагдаагийн үлдээсэн :  
"Филиппэд Ларагаас, хайртай" гэсэн  
хэдэн товч үгтэй зурвас бичсэн  
хуудас цаасыг гаргаж ирэв.

Түүний гар нь чичигнэсээр  
харилцуур тийш гараа сунгатал  
хаалганы цаанаас, тэвчээргүй  
үйлчлэгчийн,



-Хөөе, бушуулж үзээч ээ! Авах юм уу, үгүй юм уу? гэж хашгирах сонсогдов.

-Очлоо, очлоо! Таван зуу байхад болох уу хэмээн үүд нээх зуураа ломбардны эзэн хэлэв.

-Таван зуу гэнэ? Цаг ч гэж...

-Тааллаараа л бол доо.

-Чөтгөр аваг, чамайг! Алив! гээд Шоу алгаа тосоход нь,

-Баримт бөглөх ёстой доо гэж ломбардны эзэн хэлэв.

-Алив тэр баримт чинь хаа байна?

Хөгшин эр лангуун дээр хүснэгт  
бүхий хуудас цаас гаргаж тавьлаа.

Жон Жоунз, Хаит-стритийн 27 гэж  
Шоу өөрт нь үл захирагдах  
чичигнэсэн гараар татлан бичлээ.  
Чикагод Хант-стрит нь хаана ч  
байдаг гэдгийг, ноён Жон Жоунз гэгч  
нь байдаг үгүйг хэн ч мэдээ аж дээ.

Жесси түрийвчээ халааслаад,

-Ихэд талархлаа, эрхэм ээ гэв.

Үйлчлүүлэгчийг гарч явангуут хөгшин  
эр харилцуураа шүүрэн авчээ.

\* \* \*

Жижүүрийн мөрдөгч хорин минутын дараа ирэв,

-Түүнийг энд байхад нь яагаад утасдсангүй вэ?

-Би утасдахыг оролдсон л доо, гэтэл үйлчлүүлэгч эр дэндүү ууртай байсан юм гэж өвгөн хэлэв.

Мөрдөгч баримтыг нүд гүйлгэн ширтлээ.

-Нэр хаяг нь мэдээж зохиомол биз дээ хэмээн өвгөнийг хэлсэнд,

-Эргэлзэх юм алга... Гэвч тэр үүнийг өөрөө бичсэн үү? гээд мөрдөгч

ЖОГОТОЙ ИНЭЭМСЭГЛЭВ.

-Тэгсэн, өөрөө бичсэн.

-Ийм тохиолдолд тэр биднийх боллоо л гэсэн үг.

Хотын цагдаагийн удирдах газрын компьютер, баримтан дээр баруун гарынхаа хээг үлдээсэн эрийн нэрийг гаргаж ирэхэд ердөө л хоёр минут зарцуулсан ажээ.

Жесси Шоу.

\* \* \*

Өрөөнд Ларагийн хөлсөлж авсан

ахимаг насны эр орж ирэн,

-Уучлаарай, ноён Адлер аа, тантай  
утсаар ярья гэж байна. Дэслэгч  
Манчиний гэнэ. Түүнд... гэтэл  
Филипп,

-Би өөрөө гээд Адлер харилцуурыг  
аван,

-Байна уу? гэлээ.

-Филипп Адлер уу?

-Тийм байна.

-Дэслэгч Манчини ярьж байна. Би  
эмнэлэг дээр тантай уулзсан даа.

-Санаж байна.

-Жижиг сажиг мэдээлэл олдож эхлэлээ. Андуураагүй бол манай шеф бүх л ломбард руу хүмүүсээ явуулна гэж би хэлсэн шиг санагдана.

-Би үүнийг бас санаж байна.

-Тэгэхээр таны цаг Чикагогоос олдсон. Түүнийг ломбардад өгсөн хүнийг ч илрүүлсэн. Та үзвэл таньж чадах уу? гэж мөрдөгчийг хэлэхэд нь Филипп шууд л,

-Чадна гэв.

-Сайн байна.

\* \* \*

Ларагийн өрөөнд хөл нь газар хүрэхгүй болтлоо баярлаж хөөрсөн Жерри Таунсенд орж ирлээ.

-Босс оо, зочдын жагсаалтыг гаргачихлаа. Бодох тусам энэ санаа маань надад их таалагдах юм. Таны дөчин насны ойг тэнгэр баганадсан дэлхийд хосгүй барилгын нээлтийн хамт хийнэ! Би том зүрх гарган дэд ерөнхийлегчийг урьчихлаа. Ноён Мур таны эртний шүтэн бишрэгч шүү дээ гээд Таунсенд хуудас цаас өмнө нь тавьлаа.

Лара Вашингтон, Нью-Йорк,  
Голливуд, Лондонгийн бүхий л  
мяндагтан түшмэд, бизнесменүүд,  
кино оддын нэрийг уншаад,

-Жерри, муугүй болжээ. Чамайг  
сайшаан магтая гэв.

Таунсенд хуудас цаасаа авч нугалан  
халааслаад,

-Тэгвэл би урилгаа явуулж эхлэе дээ.  
Карлост танхим, хоолны цэс хоёрын  
талаар бодох тушаал өгсөн байгаа.  
Хоёр зугаад хүн ирнэ. Зайлшгүй  
тохиолдолд хэн нэгнийг нь хасах  
эсвэл нэмж болно. Ялдамд асуухад  
Риногоос сурагтай юу? гэлээ.



Лара өглөө нь өмгөөлөгч Терри Хиллтэй ярьсан аж. "Дээд шүүх асуудлыг хэлэлцэж байгаа. Тэд буруутгах дүгнэлт гаргах магадлал өндөр байна", "Юунд үндэслэж тэр вэ? Намайг Пол Мартинтай хэдэн удаа ярьсан гэж тэр үү? Чөтгөр ав гэж, тэдэнд ямар нотолгоо байгаа юм бол?", "Лара, бүү бачуур би Чиний талд шүү", "За тэгвэл ямар нэг юм хийгээч! Чи чинь өмгөөлөгч шүү дээ/ Энэ новшийн шалбаагнаас намайг салгаад аваадах!"

-Ямар ч сонин юм алга. Бүх юм хэвэндээ.

-Сайн байна. Миний санаж

байгаагаар, та Филиппийн хамт хотын мэрийн харшид оройн зоог барих байхаа.

-Тэгнэ.

Лара эхлээд урилганаас татгалзахыг завдсан боловч Филипп түүнийг үгэндээ оруулж чаджээ.

-Энэ хүмүүс чамд хэрэгтэй. Тэднийг гомдоох хэрэг юу байна. Яв яв! гэжээ.

-Чамтай л явмаар байна хэмээн Лараг хэлэхэд нь,

-Мэдээж хамт явна. Би зожиглож

суухаа больсон гэж Филипп хэлжээ.

Тэр нөхрийнхөө хувцаслахад туслан зангиаг нь зүүлгэн, ханцуйг нь чагтан товчоор чагталлаа.

Филипп толины өмнө өөрийн арчаагүй байдлыг харан дотроо хараан зүхнэ.

-Бид яг л Кен, Барби хүүхэлдэйнүүд шиг байна уу, аан? гэв.

-Чи юу гэв ээ?

-Юу ч гээгээгүй.

-За ингээд боллоо, хайрт минь. Чи

одоо дур булаам харагдаж байна!

-Баярлалаа.

-За за, одоо өөрийгөө будаж шунхадья. Бидэнд цаг бага байна, харин хотын эрхэм дарга маань хожигдоход дургүй хүн шүү.

-Чамайг номын санд хүлээж байдаа.

Хагас цагийн дараа Лара бэлэн боллоо.

Оскар де ла Реннгийн цасан цагаан даашинзтай Лара харж ханашгүй үзэсгэлэнтэй болжээ.

Түүний зүүн гарын бугуйнд  
индранил эрдэнийн бугуйвч  
гялалзан байх нь тэр.

\* \* \*

Филиппийн нойр нь хулжин бүхэл  
шөнийн туршид тарчилжээ. Дэргэд  
нь амгалан тайван нойрсох эхнэрээ  
хараад Мэрианыг буруут-гасан  
шударга бус хэргийн тухай бодон  
зэвүүцнэ. Энэ тухай Ларатай ярих нь  
гарцаагүй. Гэхдээ юуны өмнө эхлээд  
Мэриантай уулзах ёстой. Филипп  
өглөө эртлэн босч, Лараг унтаагаар  
нь орхин гарч, такси барин,

-Гринич Виллиж хэмээн очих хаягаа

ХЭЛЭВ.

Тэрээр шатаар өгсөн явсаар  
хаалганд нь тулж очоод, хонхны  
товчийг дарлаа. Төдөлгүй нойрмог  
дуугаар,

-Хэн бэ? гэх бүсгүйн дуу гарлаа.

-Филипл байна. Бид ярилцах  
хэрэгтэй байна.

Мэриан бүсгүй үүдээ нээн,

-Ноён Адлер уу даа? Юу болоо вэ?  
гэсээр өглөө эрт ирснийг нь гайхан  
асуулаа.

-Бид ярилцах хэрэгтэй болоод байна.

-Та орооч гэхэд нь Филипп дотогш орлоо.

-Хар үүрээр ирж байгааг минь уучлаарай, гэвч яаралтай ажил гараад ирлээ.

-Өө тийм үү? Тэгээд гэж Мэриан бүсгүйг хэлэхэд нь Филипп гүн гэгч санаа алдаад,

-Бугуйвчны хувьд таны зөв байжээ. Лара өчигдөр түүнийгээ зүүчихсэн байна билээ. Мэриан, би өөрийн зүгээс уучлал гуйхаар ирлээ. Би

бодохдоо... хэлэхэд ч хэцүү хэл халтираад байна! гэв.

-Та эхнэртээ итгэхгүй байж чадаагүй байлгүй дээ?

-Би түүнтэй хожим ярилцана. Юуны өмнө тантай уулзах нь зөв гэж бодсон юм.

-Зөв юм хийжээ. Танаас гуйхад, энэ тухай Ларатай бүү ярилцаарай.

-Яагаад тэр вэ? Юу түүнийг ийм зохисгүй хэрэг үйлдэхэд хүргэв ээ? хэмээн харуусан хэлэхэд нь,

-Та мэдэхгүй байна гэж үү? гэж



Мэриан бүсгүй асуув.

-Яг үнэнийг хэлэхэд мэдэхгүй байна.  
Тэр бодлогогүй юм хийжээ.

-Тэгвэл би Лараг танаас илүү ойлгож байна. Тэр хайр сэтгэлээсээ болж ухаанаа алдаж, эхнэр тань таныг дэргэдээ байлгахын тулд юу ч хийхээс буцахаа байжээ. Ларагийн амьдралд танаас өөр хэн ч байх-гүй, Филипп ээ. Та түүний хувьд бүх юм нь. Яг л таны хувьд тэр ямар их үнэ цэнэтэй билээ, түүн шиг чинь шүү дээ. Та үүнийг хүлээн эөвшөөрнө биз дээ?

-Тэгэлгүй яахав.

-Тэгвэл энэ бүхэнд цэг тавих хэрэгтэй. Цаашид шүүж байцаагаад байвал та нарын харьцаа бэхжинэ гэдэг юу л бол доо. Би зовж түдэх юмгүй ажил олчихно.

-Гэвч шударга байх хэрэгтэй шүү дээ!

Мэриан уйтгартай гэгч нь инээмсэглэж,

-Хорвоо ертөнцөд шударга явдал ховор доо, тийм үү? Санаа бүү зов, би алга болчихгүй гэснээ Уг нь Лара биш, би л хатагтай Адлер болчихсон сууж байх байсан даа хэмээн боджээ.

-Мэриан би таны тусын тулд нэг юм хийхийг зөвшөөрөөч. Монгө үргэлж бүхний үүд хаалгыг нээх түлхүүр..

-Баярлалаа, ноён Адлер аа. Хэрэггүй дээ.

Бүсгүй ихийг хэлмээр байсан боловч, яах гэж тэгэх билээ? Зүрх дурлаж байхад...

-Филипп ээ, эхнэртээ эргэж оч доо.

\* \* \*

Шинээр баригдаж буй барилгын талбай Петлигээс бага зэрэг урагш Уобаш-авеньюд байрладаг ажээ.

Хорин таван давхар офисийн барилгын тэн хагас нь хэдийн дуусчээ.

Чикагогийн цагдаагийн машин гэж мэдэгдэхээргүй нэгэн суудлын тэрэг уулзвар дээр зогсон хоёр мөрдөгч эр буун барилгын хашааны үүд тийш очиж,

-Бригадын даргыг хаанаас олох вэ? гэж манаачаас асуухад,

-Тэр байна гэж манаач хаалганаас тавиад метрийн цаахна зогсон хамгаалалтын дуулга бүхий залууг загнан зогсох чийрэн эрийн зүг заажээ.

Мөрдөгчид тэдэн рүү дөхөж очив.

-Өршөөгөөрэй, та эндхийн ахлах нь уу? гэж асуувал енөөх эр дурамжхан гэгч нь,

-Би энд зүгээр нэг ахлах бишээ. Би эндхийн Бурхан нь байна. Юу хэрэггэй вэ? гэв.

-Та Жесси Шоу гэдэг хүнийг таних уу?

-Шоуг уу? Мэдэлгүй яахав. Тэр тэнд байгаа гээд бригадын дарга дээш өлийн бараг хорин давхарт ажиллаж буй гагнуурчны зүг заав.

-Түүнийг буугаад ир гээч.

-Юу болоо вэ? Жесси түвэгтэй

асуудал гаргаа юу?

-Бид түүнээс хэдэн юм асуумаар байна.

-О'кэй, о'кэй гээд бригадын дарга дэргэдүүр нь өнгөрөх нэгэн ажилчныг зогсоон,

-Хорин давхарт гараад Жессид түүнийг дор хүлээж байна гэж хэл хэмээн зарлигдав. Шоу арваад минутын дараа ирлээ.

-Жесси, тэр хоёр чамтай уулзах гэнэ гээд бригадын дарга конторын зүг том том алхлан одов. Гагнуурчин жуумалзан,

-Сайхан далим гарлаа байна. Тамхи  
аа татаж авъя байз. Юугаар тус  
болох вэ, ноёд оо? гэв.

Мөрдөгч халааснаасаа цаг гарган,

-Энэ таных уу? гэвэл түүний царайд  
тодорч байсан инээмсэглэн нь ул  
мөргүй арилж,

-Биш ээ гэлээ.

-Итгэлтэй байна уу?

-Бүрэн дүүрэн гэснээ Шоу зүүн гараа  
сунган цагаа харуулан,

-Би "сейко" цагтай гэлээ.

-Та үүнийг ломбарданд тавиа биз дээ гэж мөрдөгчийн нэг нь ширүүхэн хэлсэнд,

-Өө тийм л дээ! гээд тэр духныхаа хөлсийг арчин,

-Чөтгөр шиг харамч амьтан таван зууг л өгсөн шүү! "Пьяж"-д тэр шүү дээ! гээд газарт нулимав.

-Гэхдээ сая энэ таных биш гээ биз дээ?

-Минийх бишээ.

-Та хаанаас аваа вэ?



-Олсон юмаа.

-Яасан азтай юм бэ? Хаанаас олоо вэ?

-Гэрийнхээ хажуухнаас гэснээ Жесси үлгэрээ зохиож эхлэх цаг болжээ дээ гэж бодоод,

-Гадаа гудамжнаас олсон юм. Машинаас буутал нэг юм гялалзаад, тонгойгоод хартал цаг байсан юм гэв.

-Бурхны авралаар нартай байжээ дээ, тийм үү?

-Бурхны авралаар нар гийж байсан.

-Ноён Шоу та ийш тийш аялах дуртай юу?

-Харин ч үгүй шүү, яснаасаа дургүй.

-Харамсалтай хэрэг ээ. Ингэхэд танд Нью-Йорк орох хэрэг гарах нь дээ. Бид юм хумаа төхөөрөхөд чинь туслана. Тэд машин чиглэн явлаа.

Шоугийн гэрт мөрдөгчид нэгжлэг хийж эхлэхэд нь,

-Хөөе. залуус аа! Нэгжих эрхийн бичиг байгаа юм уу? гэвэл мөрдөгч,

-Түүний хэрэг бидэнд байхгүй. Бид ердөө л чамд чемодан саваа

баглахад чинь л тусалж байна гэв.

Нэг мөрдөгч хувцасны шүүгээг дэлгэн гутлын тавиураас хайрцаг-тай юм гаргаж ирэн,

-Том оо, хараач! Бидэнд илгээсэн Сант-Клаусын бэлэг байх чинь ээ! гэлээ.

Дотуур холбоогоор Кэтийн дуу хадаж,

-Ноён Дональд Тилли дөрөвдүгээр шугамаар ярьж байна, хатагтай Камерон гэв.

Тилли "Камерон тауэр" төслийн

удирдагч билээ. Лара харилцуураа  
аван,

-Байна! гэв.

-Хатагтай Камерон, манайд жаахан  
асуудал гараад байна.

-Яриач!

-Өглөө түймэр гарсан. Одоо  
унтарчихсан!

-Бүр эхнээс нь ярь!

-Трансформаторт богино холбоо  
үүсч гэнэт буудаад. Хэн нэг нь буруу  
холболт хийсэн бололтой!

-Одоо яаж байна.

-Ороомгийг солих хэрэг гарч байна.

-Түргэлж үз, байдлыг надад мэдэгдэж байгаарай. Лара орой болсон хойно гэртээ ядарч туйлдчихсан хүн ирлээ.

-Чи өөрийгөө хайрлахгүй хүн юмаа! Би чамд яаж туслах вэ? гэж Филипп асуув.

-Хайрт минь, Баярлалаа. Ажил их байлаа. Филипп эрүүл гараараа түүний хүзүүгээр тэвэрч,

-Би чамд ухаангүй хайртай гэж

хэлсэн байхаа гэхэд нь Лара инээн,

-Дахиад сонсоход ч бэлэн байна гэв.

-Би чамд ухаангүй хайртай.

Хүүхэн нөхөртөө наалдан: Би үүнийг л хүсч байлаа. Энэ л надад дутаад байсан юмсан хэмээн бодов.

-Фил ээ, ажил төрлөө цэгцэлчихээд, хоёулаа хаашаа ч юм бэ явья, тэгэх үү? Чи бид хоёр-хоёулхнаа?

-Тэгье! Заавал явна.

Би түүнд Мэрианы тухай хэлэх ёстой. Энэ мэдээж жигшүүртэй л дээ.

Гэхдээ би түүнийг алдахыг хүсэхгүй байна гэж Лара бодов.

Маргааш нь Тилли утасдан,

-Босс оо, та шалны гантигийн захиалгыг хойшлуулаа юу? гэв.

-Тэгж бодоогүй юм байна. Юу болоов?

-Мэдэхгүй, тэгвэл өөр хэн нэг нь хойшлуулжээ дээ. Өнөөдөр өглөө авчрах байсан юм. Үдээс хойш нийлүүлэгчтэй ярьтал таны захирамжаар захиалгыг хоёр сараар хойшлуулсан гэх юм. Лара дүрсхийн уурласнаа,

-Ойлгомжтой, бид хэр зэрэг хугацаа алдаад байна? гэв.

-Хэлж мэдэхээ байлаа.

-Тэдэн рүү яриад гантигийг даруй авчир гэж хэл гэлээ.

Говард Коллер Ларагийн өрөөнд орж ирэн,

-Лара банкны эзэд цухалдаж эхэллээ. Тэднийг тайвшруулж чадна гэдэгтээ итгэл алдраад байна гэв.

-Говард аа, ажил дуустал тэсээч. Тун жаахан, ердөө л гурван сар үлдлээ шүү дээ.



-Би ч бас тэдэнд ингэж хэлсэн. За даа, өөр юм бодож олье доо гэтэл тэдний яриаг тасдан дотуур холбоогоор,

-Ноён Тилли, нэгдүгээр шугамаар ярих гэнэ гэх Кэтийн дуу хадав. Лара гараа дохин,

-Говард аа, байж бай! гээд харилцуур авсанд,

-Хатагтай Камерон бас нэг асуудал гарчихлаа.

-Битгий ярьж цөхөөд бай. Хурдан хэлээдэх гэж Лара уурсангуй хэлсэнд,

-Энэ удаад цахилгаан шаттай холбоотой. Удирдах аппарат нь жагсаалаас гарсан юм болов уу, дохиолол нь хутгалдаж гүйцжээ. Бүхээгийг нь дээш нь явуулахад доошоо бууж, эсрэгээр ажиллаад байх юм, Амьдралдаа ийм юм огт үзсэнгүй юмсан.

-Таны бодлоор бас л хэн нэгний санаа юу?

-Хэлэхэд хэцүү байна. Магадгүй ердийн нэг техникийн алдаа ч байж болох юм.

-Засахад хэр удах вэ?

-Уг нь засварын хүмүүс ажилдаа орцгоосон л доо.

-Үр дүнг нь хүлээж сууя гээд Лара харилцуураа тавьлаа.

-Ямар нэг юм болоо юу? гэж Келлерийн асуухад Лара түүний асуултыг чихнийхээ хажуугаар енгөрөөж,

-Говард аа, Стив Мерчисоны тухай сураг ажиг юу байна? гэлээ. Келлер гайхаж,

-Юу ч сонсоогүй явна. Юу болоо вэ? гэхэд нь Лара,

-Зүгээр л, эмэгтэй хүний саваагүй зангаар л асуусан юм гэв.

"Камерон-тауэр"-ийг санхүүжүүлж буй банкны консорциум нь санаа амар байх үндэслэлгүй ажээ. Зөвхөн Лара Камероны эзэнт улс төдийгүй, Төмөр хүүрзгэний олон хоршоо үйлчлүүлэгчид хүндхэн байдалд ороод байв. "Хог"-ийн гэгдэх акцуудын нэр хүнд унаж, бизнесийн ертенц даяар аюулын гамшиг нүүрлэлээ.

Говард Келлерийг зургаан банкны эздийг хүлээн авч буй өрөөний уур амьсгал түгшүүртэй байлаа.

-Манайд танай төлөх ёстой зуун сая долларын үнэт цаас хуримтлагдчихаад байна. "Камерон тауэр" урьдчилан зээлдэгчийн жагсаалаас хасагдах нь бололтой гэж хотын банкны ерөнхий хорооны хүн хэллээ.

-Та хоёр зүйлийг таг мартжээ. Нэгд, Лара өнөө маргаашгүй казиногийн лицензээ авна. Тэр цагт бэлэн мөнгөний урсгал ямар ч өрийг өлхөн дарчихна байх. Хоёрт: "Камерон тауэр"-ын барилгын ажил хуваарын дагуу явагдаж байгаа. Тэнгэр баганадсан барилга ерэн хоногийн дараа үүд хаалгаа нээх болно. Нийт талбайн далан хувийг

түрээслэчихээд байгаа, харин нээгдсэн цагт нь бидэнд сөөм хэрийн ч сул газар үлдэхгүй.

Эрхэмүүдээ! та бүхний хөрөнгө найдвартай гарт байна. Лара Камероны нэр төр гайхамшигийг бүтээдэг юм шүү гэлээ.

Зургаан эрчүүд зөвхөн банкны эзэд л хоорондоо ойлголцох тийм нэгэн харцыг солилцоод,

-Эрхэм ээ, бид хоорондоо зөвлөлдөх хэрэгтэй байна гэв.

-Яриа юу байх вэ, ноёд оо. Би Ларагийн өрөөнд орлоо гээд өрөөнөөс гараад явав.

-Банкныхан бидэнтэй зөвшилцөх байх гэж бодох юм. Гэвч баттайг нь бодолцон ямар нэг үл хөдлөх хөрөнгөө зарья гэж Говард Ларад хэлэхэд,

-Тэг тэг гэж шууд зөвшөөрчээ.

Лара амьдралынхаа зорилго болсон ажлаа аврахын тулд үүр цүүрээс үдшийн бүрий хүртэл ажиллах болов. Тэр Филипптэй бараг уулзалдахгүй шахам явж, нөхрийгөө зовоохгүйг чармайна.

Тэртээ тэргүй түүний зовлон шаналал багадаагүй.

Даваа гаригийн өглөөний зургаан  
цагт Тилли утасдаж,

-Хатагтай Камерон, таныг барилга  
дээр ирэх хэрэгтэй гэж бодох юм  
гэлээ.

Ларагийн аюулхай орчимд нь ёгхийн  
хатгууллаа.

-Юу болоо вэ?

-Та нүдээрээ үзсэн нь дээр байхаа.

-За за гээд Лара Говрадыг дуудан,

-Говардаа барилга дээр нэг юм  
болжээ. Явцгаая! гэв.



Гучин минутын дараа лимузин барилгын төмөр хаалгаар орж явав.

-Тилли хэргийн учир юунд байгааг хэлсэн үү?

-Үгүй. Гэлээ ч би ар араасаа цувран гарах санамсаргүй явдалд итгэхээ болиод байна.

-Би чиний үгний тухай огт бодсонгүй. Стив Мерчисон энэ газрыг авах гэж улайрч байсан байхаа? Үр дүн нь энэ дээ хэмээн Говард гашуудан хэллээ.

Талбай дахь ажилчид ачааны машинаас том том шилнүүдийг болгоомжгой буулгаж байлаа. Тилли

хаанаас ч юм гүйж ирэн,

-Ашгүй та ирчихээ юу? гэлээ.

-За яриад байгаарай.

-Энэ манай захиалсан шил биш байна! Өөр өнгийн, овор хэмжээтэй юм. Бид үүнийг хэрэглэж болохгүй гэж Тиллийг дуржигнуулахад Лара, Келлер хоёр харц солилцоод,

-Хэмжээгээр нь тааруулаад зүсэж болохгүй юм уу? хэмээн Говард асуулаа.

Тилли арга тасраад байгаа бололтой

гараа савчин,

-Ээ дээ! Шилний хэлтэрхийний овоо босгох байх даа гэлээ.

-Хаана захиалсан юм бэ? гэж Лара түүнээс асуув.

-Нью-Жерсигийн "Гласс энд Сайдинг" компанид захисан юм.

-Би тэдэнтэй ярина. Шиллэх ажил хуваарь ёсоор хэзээ дуусах вэ?

Менежер эр тооцоолон бодож эхэллээ.

-Хэрэв хоёр долоо хоногийн дотор

гэхэд материалаа авчирвал бид алдсан хугацаагаа нөхчихнөө.

Нилээд цамнах л байх, гэвч хүмүүс маань дуусганаа гэв.

"Гласс энд Сайдинг" компаний дарга Отто Карн тэр дороо харилцуураа авав.

-За, хатагтай Камерон оо? Танайд асуудал үүсээ юу? гэв.

-Үгүй ээ, ноён Карн аа. Харин танайд асуудал үүсээд байна. Та манай руу өөр шил илгээчихжээ. Хоёр долоо хоногийн дотор би шаардлагатай шилээ авахгүй бол та бизнесийн тухай мартаж болох нь дээ. Гурван

зуун мянган долларын өртөг бүхий төслөө нураахыг хүсээ юу? гэв.

-Би юу ч ойлгохгүй байна. Түр хүлээхгүй юу?

Дарга таван минут хэртээ болсноо,

-Бурхныг бодож намайг уучлаарай, хатагтай Камерон! Захиалгыг буруу хийжээ! Ийм юм болж л дээ...

-Танайд юу болох надад огт хамаагүй. Захиалгыг даруй ачуул, тэгээд л гүйцээ хэмээн Лара үгийг нь таслан хэллээ.

-Тэгэлгүй яахав!

Ларагийн санаа амарлаа.

-Хэзээ явуулах вэ?

-Хоёр гурван сарын дараа...

-Хоёр гурван сар гэнээ? Энэ чинь боломжгүй хэрэг. Шил яг одоо хэрэгтэй байна.

-Гүнээ харамсаж байна, хатагтай Камерон. Яагаад ч хурдалж чадахгүй гэв.

-Та намайг ойлгосонгүй. Онцгой байдлын тухай яриа болж... хэмээн Лара цухалдав.

-Танд туслахыг ихэд хүсэхсэн. Миний хүмүүс эрвийх дэрвийхээрээ ажиллаад ч, захиалгыг хоёр гурван сарын дараа авах болно. Энэ чинь байна шүү... үгээ сунжруулан зөөж ядахад нь Лара харилцуураа шидэж орхилоо.

-Итгэмээргүй юм! Дон оо, чи өөр компани мэдэх үү? хэмээн Лара Тиллигээс асуусанд,

Менежер эр шанаагаа илэн,

-Одоо оройтсон байхаа. Тэд бүгдийг тэгээс эхлэнэ, бас байнгын үйлчлүүлэгчидээ гомдоохыг бодохгүй нь гарцаагүй гэлээ.

-Лара, надад нэг санал байна гээд  
Келлер түүнийг сугадан, хажуу тийш  
нь аваачаад,

-Гэвч... гээд түгдэрэхэд нь Лара,

-Ярь, ярь гэв.

-Чиний найз нөгөө Пол Мартинд  
холбоо сүлбээ бий дээ. Эсвэл тэр хэн  
нэгнийг мэднэ, эсвэл... гэхэд нь Лара  
толгой дохин,

-Сэтгэж байна шүү! Чи! гэжээ.

\* \* \*

Хоёр цагийн дараа Лара Пол



Мартины офист сууж байлаа.

-Охин минь, чиний утасдахад миний хичнээн их баярласныг чи төсөөлөхгүй дээ. Бид сүүлийн удаа хэзээ хаана уулзлаа! Лара чи ч дагина шиг л харагдаж байна! гэлээ.

-Баярлалаа, Пол оо!

-За юугаар тус болох вэ?

Лара шийдэж ядан байснаа,

-Хүнд байдалд орох лээрээ л чам руу гүйж ирэх юм даа гэв.

-Үүний тулд л бид найз нөхөд байгаа

биз дээ, үгүй гэж үү?

-Тийм ээ, чи ч жинхэнэ үнэнч найз шүү. Яг одоо надад тун хэрэгтэй байна.

-Алив хэлээч. Ээлжит ажил хаялт уу?

-Үгүй. "Камерон тауэр"-тай холбоотой асуудал. Мартин хөмсөг өргөн,

-Би танай барилгыг хуваарын дагуу явагдаж байгаа гэж сонссон юм сан.

-Тийм ээ. Үнэндээ хуваарь ёсоор явж байлаа л даа. Гэтэл Стив Мерчисон надад өшөө авалт зарласан

бололтой. Эртээдээс хойш барилга дээр сонин хачин явдлууд гараад байх боллоо. Өнөөдрийн өдрийг хүртэл бид яаж ийгээд мултарч гараад дөнгөж байлаа, гэтэл одоо... Асуудал үнэхээр ноцтой болж, нээлтийн ёслолын ажиллагаа болохгүй нь бололтой. Пол оо, би үүнийг тэвчиж чадахгүй гэв.

Ларагийн цээжинд уур хилэн нь буцлан байж ядаж байгаа бололтой харагдана.

-Зургаан сарын өмнө Нью-Жерсид шилний захиалгаа өгсөн юм. Өнөө өглөө захиалга хийгдэж, барилга дээр огт шаардлага хангаагүй шил

буулгасан байна гэлээ.

-Чи тэр компанитай ярьсан уу?

-Ярьсан. Тэд алдаагаа хоёр гурван сарын дараа л засаж чадна гэх юм.

Гэтэл шил долоо хоногийн дараа хэрэгтэй бодлоод байна!

Шилгүйгээр ажилчдад хийх ажил алга. Хэрэв нээлт хойшлогдвол, би гэдэг хүн байдаг бүхнээ алдах болоод байдаг.

Мартин бодол болон толгой сэгсэрч,

-Ийм юм болохгүй охин минь. Би юу хийж чадахаа үзье л дээ гэхэд нь,

Лара урам орон мөр нь тэгширч,

-Пол оо, надад... гэснээ үг нь гарч  
өгсөнгүй,

-Баярлалаа, Пол оо гэв.

Мартин бахим алгаараа түүний  
гарыг нь атган,

-Үлэг гүрвэл амьсгалж л байгаа шүү!  
Маргааш утасдья гээд инээмсэглэв.

Өглөө эрт Ларагийн олон сар дуугүй  
байсан хувийн утас нь намуухнаар  
чичирхийлэн дуугарлаа.

-Байна! Пол уу?

-Лара, би чамайг сэрээчихээгүй биз?  
Би хуучин найз нөхөдтэйгээ ярьлаа.  
Нөгөөх чинь бүтэх болсон. Бага зэрэг  
ташуурдахгүйгээр бол бүтэхгүй  
байсан биз ээ, гэсэн ч тэд ирэх даваа  
гаригт захиалгыг биелүүлнэ гэсэн.

Даваа гаригт Лара дахиад л Пол  
Мартнн руу залган,

-Пол оо, шил ирээгүй л байна гэв.

-Тийм үү? гээд Пол удтал дуугүй  
болсноо,

-Лара би бүтээнэ, чамд амлаж байна  
гээд Мартины дуу нь зөөлөрч, -  
Дахин чиний дууг сонссондоо

баяртай байна шүү гэв.

-Пол... хэрэв тэд энэ удаад...

-Битгий санаа зов. Чи шилээ авна.

Ажлын өдөр дуусах тийшээ хандаж байтал шил ачсан машин ирээгүй хэвээр байлаа. Говард Ларагийн өрөөнд орж ирэн,

-Би дөнгөж сая Дональд Тиллитэй ярьлаа. Хамгийн цаад тал нь Баасан гариг гэхэд шил ирчихвэл хуваарь нэг их тасрахгүй. Бид балрахгүй нь.

Пүрэв гариг гэхэд юу ч өөрчлөгдсөнгүй.

Лара "Камерон тауэр"-руу очсонд. Барилгын талбай хов хоосон болж, сүрлэг өргөгч цамхаг олон давхар барилга дээгүүр омог бардам тэнгэр өөд цойлон зогсжээ.

Яасан ч зөвшөөрөхгүй. Хэн ч намайг басамжлах эрхгүй! Хэмээн Лара бодлоо.

Лара офистоо ирээд Пол Мартин руу утасдсанд,

-Харамсалтай нь ноён Мартин одоо алга. Та хэлэх үгээ үлдээчихгүй юу? гэж нарийн бичгийн дарга нь хэллээ.

-Түүнийг над руу ярь гээрэй! гээд



Лара Келлер тийш эргэн,

-Говард аа, надад нэг асуудлыг тодруулаад өгөөч. Стив Мерчисон тэр компанийн эзэн мөн эсэхийг мэдээдэх гэлээ.

Хагас цагийн дараа Келлер эргэж ирэхэд түүний царай нь үхдэл мэт цонхийн цайжээ.

-Мэдсэн үү? Хэлээдхээч! Хэнийх юм бэ? хэмээн Лара давчдан асуувал,

-Мэдсэн. Компани Делаверт бүртгэгдсэн "Этна энтерпрайз" корпо-рацид хамаардаг юм байна.

- "Этна энтерпрайз" гэнэ ээ?

- Тийм ээ. Түүнийг хоёр жилийн өмнө худалдсан байна. Корпорацийн эзэн нь Пол Мартин байжээ гэх нь тэр.

## Гучин гуравдугаар бүлэг.

Хэвлэлийнхний дэгдээсэн дуулиан шуугиан улам бүр газар авлаа. Лараг тэнгэрт тултал мандуулж байсан тэр л ган үзэгтнүүд түүний нэрийг шалбаагт хутгаж чадаж байв. Жерри Таунсенд Говардын өрөөнд орж ирээд,

-Үнэндээ, миний сэтгэл нэг л тайван бус байна гэв.

-Юу болоо вэ?

-Чи сонин уншсан уу?

-Уншсаан уншсан. Цаас цоохорлох

донтонгууд ар араа саа хөвөрч байх шив гээд Говард ярвайв.

-Би Ларагийн төрсөн өдрийн тухай л бодоод явна. Урилгыг аль хэдийнэ тараасан, гэтэл сэтгүүлчдийн найруулсан жүжигнээс болоод уригдсан хүмүүс надад татгалзсан хариу өгч байна. Тэд өөрсдийн алдар нэрийг гутаахаас жийрхэцгээж байгаа аж. Бидний хэрэг бүтэлгүй тийшээ л хандах нь бололтой.

-Чи тэгээд яах бодолтой байна ?

-Баярыг хойшлуулья. Би аятайхан шалтаг олноо.

-Магадгүй, чиний зөв биз. Хэрэв Лара эвгүй байдалд орвол их харамсалтай юм болно доо.

-Тэр ч тиймээ. За, за явж ажлаа бодъё. Чи түүнд хэлчих үү дээ?

-Тэгье, би хэлчихье хэмээн Говард хариулав.

Өмгөөлөгч Терри Хилл утасдаж,

-Дөнгөж сая надад нөгөөдөр Дээд шүүхийнхэн Ринопд цуглаж, таны мэдүүлтийг сонсох гэнэ, хатагтай Камерон. Би тантай хамт явна гэлээ.

\* \* \*

Жесси Шоуг байцаасан протоколоос.  
Байцаагч дэслэгч Сол Манчини.

М: Өглөөний мэнд. ноён Шоу. Би дэслэгч Манчини байна. Бидний ярианы бичлэг хийгдэх болно гэдгийгтанд мэдэгдье.

Ш: Тусалж байгаа юм биз дээ.

М: Та өмгөөлөгч авахаас татгалзсан гэв үү?

Ш: Надад өмгөөлөгчийн хэрэг байхгүй. Хүн цаг олоо л биз, тэгээд юу гэж. Үгүй дээ, та нарт намайг амьтан шиг барьж торонд хашихыг шаардаа юу.

М: Ноён Шоу та Филипп Адлерийг таньдаг уу?

Ш: Танихгүй. Түүний нэрийг хэн хүнгүй мэддэг хэрэг үү?

М: Таныг түүнд халдан довтол гэж хэн ч мөнгө төлөөгүй хэрэг үү?

Ш: Би түүний тухай хэзээ ч сонсоогүй гэж хэлээд байна шүү дээ.

М: Чикагогийн цагдаагийн газар таны гэрээс тавин мянган доллар олсон. Ийм их мөнгө хаанаас олоо вэ?

Ш:(дуугарсангүй)

М: Ноён Шоу та юу хэлэх вэ?

Ш: Хожсон юмаа.

М: Хаанаас?

Ш: Морин уралдаан... хөл  
бөмбөгийн тэмцээнээс

М:Та ч азтай юмаа.

Ш: Магадгүй ээ.

М:Та Чикагод ажилладаг уу?

Ш: Тийм ээ.

М: Хэзээ ч юм Нью-Йоркод ажиллаж  
байсан уу?



Ш: Ажиллаж байсан.

М: Цагдаагийн архивч Кунсэнд таны жолоодож байсан экс-коваторын шанаганд барилгын мастер Билл Уайтман дарагдаж үхсэн гэсэн мэдээлэл байна. Энэ үнэн үү?

Ш: Үнэн, золгүй явдал болсон юм.

М: Та тэнд удаан ажилласан уу?

Ш: Санахгүй байна.

М: Би таны ой ухааныг сэргээгээд өгье л дөө. Яг далан хоёр цагийн өмнө та энэ хэрэг явдал болохоос өмнө Чикагогоос нисч ирээд хоёр

хоногийн дараа тийшээгээ буцжээ.  
Энэ үнэн биз?

Ш: Маргалдах юм алга.

М: "Американ эйрланс" компаний баримтаар ноён Адлерт халдсанаас хоёр өдрийн өмнө та Чикагогоос Нью-Йоркод ирээд, нэг өдрийн дараа буцсан. Та ямар зорилгоор ийнхүү аялаа вэ?

Ш: Театрт орох гэсэн юм.

М: Та үзсэн дуурийнхаа нэрийг санаж байна уу?

Ш: Үгүй. Мартчихаж.

М.Эксковарын хэрэг зарга үүсч байх үед таны ажил ологч чинь хэн байсан бэ?

Ш: "Камерон энтерпрайз".

\* \* \*

Келлер Ларатай зөвлөж суулаа. Тэд бараг цаг шахам хэвлэлийн компанийн зоргоороо орилолдон учруулж буй гайг нь хэлэлцсэний эцэст Лара,

-Өөр юу байна даа? гэв.

Говард хөмсөг зангидан барайв. Түүнийг Ларад нэг юм дамжуулахыг

хүссэн. Хэн хэллээ? Юу гэж хэл гэлээ?  
Тэр огт санасангүй. Ээ Бурхан минь  
гэж. Тийм чухал зүйл биш байжээ  
дээ?

Шинэ нарийн бичгийн дарга нь,

-Ноён Адлер аа, тантай ярих гэнэ.  
Тэр өөрийгөө мөрдөгч Манчини  
гэсэн гэв.

Филипп харилцуураа авлаа.

-Өдрийн мэнд дэслэгч ээ. Танд  
юугаар туслах вэ?

-Ноён Адлер аа, танд дуулгах сонин  
байна.

-Тийм үү? Та дээрэмчнийг олоо юу?

-Би нүүр тулан уулзаж байж ярилцах хэрэгтэй байна. Болох уу?

-Бололгүй яахав.

-Би хагас цагийн дараа очлоо.

Юу яриад байгаа юм болоо, мөрдөгч яагаад утсаар ярьж болохгүй байв аа! гэж Филипп болоод харилцуураа тавих зуур бодов.

Дэслэгч Манчинийг ирэхэд нарийн бичгийн дарга нь түүнийг танхимд хүргэж өглөө.

-Сайн байна уу, ноён Адлер аа.

-Тантай уулзсандаа баяртай байна дэслэгч ээ. Таныг анхааралтай сонсьё.

-Бид дээрэмчнийг баривчилсан.

-Нээрээ гэж үү? Гайхаж байна шүү. Таны хэлснээр бол цагдаагийн ханд гудамжны дээрэмтэй хөөцөлдөж явах цаг байдаггүй гэж хэлсэн санагдана хэмээн ийм юм сонсоно чинээ бодоогүй байсан Филипп хэлэв.

-Тэр өрийн нэг дээрэмчин бишээ.

Филипп үл анзаарагдам хөмхий зууж үзэгдэв.

-Өршөөгөөрэй, юу гэв ээ?

-Энэ этгээд барилгын ажилчин. Чикаго, Нью-Йоркод ажилладаг. Цагдаагийн мэдээллээс үзэхэд түүнийг дээрэмчин, орон байрны хулгайч, зодоон хийдэг гэж байна. Тэр залуу цагийг ломбардад өгсөн. Баримтан дээр хурууныхаа хээг үлдээсэн байна билээ гээд Манчини халааснаасаа цаг гарган,

-Энэ таных уу? гэлээ.

Филипп алтан цагийг харах авч гар

хүрэх хүсэл өчүүхэн ч төрсөнгүй.

Нүдний нь өмнүүр:

Хурц хутга, цусан горхины  
аймшигтай зураг хөвөрлөө.

Адлер биеэ хүчлэн бариад гараа  
сунган, "Пьяж" цагийг аван тагийг нь  
үзэв. Зүлгүүрийн тортогоор үүссэн  
зураасны цаанаас үл ойлгогдом ганц  
нэг үсэг харагдана.

-Тийм ээ. Минийх мөн байна.

Манчини цагийг болгоомжтой гэгч  
нь эргүүлэн авлаа.

-Цаг хэсэг хугацаанд манайд эд  
мөрийн баримт болон үлдэх болно.



Би таныг маргааш очиж хэрэгтнийг таних ёстой гэж хэлмээр байна.

Яргачин эрийн ой гутам царайг дахин харна гэж бодохоос Филиппийн дотор нь бачуураад ирлээ.

-Заавал очно.

-"Палас Плаза"-ийн 212-р өрөөнд, арван цагт очоорой.

-Тохирлоо. Та яагаад түүнийг жирийн нэг дээрэмчин биш гэв ээ? хэмээн Филипп асуув.

Манчини агшин зуур түдгэлзсэнээ,

-Түүнийг танд халдсаных нь хариуд  
шан төлсөн байна гэв,

-Юу? хэмээн дуу алдах Филиппийн  
ой ухаанд нь энэ хэрэг нэг л  
багтсангүй.

-Танд тохиолдлын явдал жирийн нэг  
санамсаргүй явдал биш ажээ. Тэр  
новш хүчин зүтгэснийхээ хариу шанд  
тавин мянган доллар хүрт-сэн  
байна.

-Итгэхгүй нь, намайг зэрэмдэглэх нь  
хэнд хэрэгтэй байсан юм бэ? хэмээн  
Филипп үгээ зөөж ядан хэлэв.

-Таны эхнэр чинь түүнийг хөлсөлжээ!



## Гучин дөрөвдүгээр бүлэг.

"Таны эхнэр чинь түүнийг хөлсөлжээ!" Лара юу? Энэ хэргийн цаана Лара байгаа гэж үү? хэмээн бодмогц Фнлиппийн хамаг бие нь хүйт даалаа. Яах гэж тэр вэ?

"Өршөөгөөрэй. Чамайг ингэж бодлогоширон дасгал хийхийн хэрэг юу байгааг нэг л ойлгохгүй юм. Чи одоохондоо тоглолтгүй байгаа шүү дээ..."

"Чи явах албагүй! Надад нөхөр хэрэгтэй болохоос... Чи яг л доншуур наймаачин шиг тэнэж..."

Мэриан: "Лара намайг таны түүнд бэлэглэсэн индранил эрдэнийн бугуйвчийг хулгайлсан хэмээн буруутгасан. Лара тантай хамт байхын тулд юу ч хийхээс..."

Эллерби: "Дашрамд хэлэхэд, чи тоглолтынхоо хүрээг хумих бодолтой байгаа юм уу? Саяхан би Ларатай уулзсан..."

Тийм ээ, энэ Лара байж.

Цагдаагийн удирдах газрын даргын өрөөнд тойргийн прокурор, цагдаагийн комиссар, дэслэгч Манчини нар сууж байлаа.

-Бид хардлагандаа галзууран хийрхсэн тэнэгтэй зууралдаагүй. Энэ эмэгтэйн цаана нилээд хүнд нударга байна. Таны цуглуулсан баримтуудад ноцтой юм юу байна, дэслэгч ээ?

-Би "Камерон энтерпрайз"-ийн боловсон хүчний хэлтсээс лавлагаа авсан. Жесси Шоуг Лара Камероны шууд тушаалаар ажилд авсан байна гээд Манчини толгой өлийн цонх руу харц чулуудаад,

-Би танай босс барилгын ажилчдаа өөрсдөө биечлэн шилж авдаг уу? гэж асуусан. Гэтэл надад: Мэлзэж үгүй гэж хариулсан даа? гэв.

-Өөр юу байна?

-Барилгын хэлтсийн дарга Билл Уайтман ажилтнуудынхаа өмнө Лара Камероны тухай нууц мэдээлэл бий, тун удахгүй хөлгүй их баяжина хэмээн онгирч байсан гэсэн цуу яриа байна. Гэтэл хэдэн өдрийн дараагаар Билл Уайтман, Жесси Шоугийн жолоодож байсан эксковатрын хүнд шанаганд дарагдаж үхсэн байна. Тэр явдлын өмнөхөн Шоу Чикагогоос Нью-Йорк орж ирсэн бөгөөд золгүй явдлын дараахан буцаад явжээ. Уайтманы үхлийг сайтар найруулсан болох нь огт эргэлзээгүй. Дашрамд хэлэхэд хоёр талын онгоцны тасалбарыг

"Камерон-энтерпрайз" төлсөн байна билээ.

-Харин Филипп Адлерийн хувьд?

-Мөн л иймэрхүү бүдүүвчээр Шоу халдлага болохоос хоёр хоногийн өмнө Чикагогоос ирээд, маргааш нь буцсан. Хомхой сэтгэлээсээ болж цагийг нь мулталж аваагүй бол бид түүнийг хэзээ ч илрүүлж чадахгүй байсан.

-Тэгвэл хэргийн шалтгаан нь юу вэ? Яах гэж зэрэмдэглэв гэж комиссар асуув.

-Үйлчлэгч нарынх нь хэлж



байгаагаар Лара нөхөртөө ухаангүй хайртай гэнэ. Нэг удаа тэдний дунд аялан тоглолтоос болж ширүүхэн маргаан үүссэн гэнэ лээ. Хатагтай Адлер үргэлж нөхрийгөө дэргэдээ байлгахыг хүсдэг гэсэн.

-Тэрээр одоо ч гэрээсээ гарахаа болио биз дээ?

Тойргийн прокурор босож, өрөөгөөр холхиж нааш цааш алхангаа,

-Хатагтай өөрөө энэ талаар юу гэж байх юм бэ? Бүгдийг үгүйсгэж байна уу? гэж асуулаа.

-Түүнтэй хараахан уулзаагүй байгаа.

Эхлээд асуудлыг таньтай хэлэлцэе гэж бодсон юм.

-Тэгэхээр, Филипп Адлер дээрэмчин эрийг таних чадалтай байгаа юу?

-Чадалтай байгаа.

-Сайн байна. Хатагтай Адлертай уулз. Түүнд хэлэх юм бий байх.

\* \* \*

Дотуур холбоогоор Кэти,

-Хатагтай Адлер аа, дэслэгч Манчини тантай уулзах гэнэ хэмээв. Түүний царай харамссан янзтай харагдав.

-Ямар асуудлаар уулзах гэнэ вэ?

-Тэр дуугарахгүй байна.

-За яахав, орог.

Манчини болгоомжилсон янзтай орж ирлээ. Баттай нотол-гоогүйгээр Лараг гэмт хэрэгт буруутгана гэдэг тийм ч амаргүй даваа байлаа. Гэсэн ч үзээд алданаа гэж тэрээр боджээ.

Мөрдөгч эр өрөөнд Говард Келлерыг байх юм чинээ бодсонгүй.

-Өдрийн мэнд, дэслэгч ээ.

-Өдрийн мэнд, авхай.

-Та ноён Келлертэй аль хэдийний танилцаа биз.

-Өө тэгэлгүй яахав. Түүнээс илүү сайн дамжуулагч Чикагогоос олдохгүй шүү.

-Жесси Шоу гэгч танай Чикаго дахь барилгад ажилладаг. Тэр бас Куинсын барилга дээр ажиллаж байсан. Түүний эксковаторын шанаганд дарагдаж... гэснээ дэслэгч халааснаасаа тэмдэглэлийн дэвтрээ гаргаж ирэн эргүүлснээ үргэлжлүүлэн,

-Билл Уайтман гэдэг хүн эрсэдсэн байна. Мөрдөн байцаалтаар золгүй

явдал гэсэн дүгнэлт гарсан гэлээ.

Лара татгасхийснээ шүлсээ гүдхийн залгиад,

-Тэгээд... гэсэн боловч Говард Келлер түүний үгийг нь хэлүүлсэнгүй,

-Дэслэгч ээ, манай компанид мянга шахам ажилчид ажилладаг. Бид толгой дараалан таних ёстой гэж үү? гэлээ.

-Өөрөөр хэлбэл, та Шоутай танил уу? хэмээн дэслэгч түүний үгийг сөргөн асуув.

-Үгүй. Би ч, Камерон авхай ч, хэн ч

танихгүй.

-Би Камерон авхай эсвэл хатагтай Адлер үүнийг батлахыг илүүд үзэхсэн гэж дэслэгч хэгжүүрхэв.

-Түүний тухай огт дуулаагүй юм байна.

-Таны нөхөрт халдсанахаа шанд Жесси Шоу тавин мянган доллар хүртсэн байна.

-А-а-арай... арай үгүй байлгүй! гэх Ларагийн царай цонхийн цайлаа.

За даа, би ч байндаа онов бололтой гэж дэслэгч Манчини бодов.

-Энэ тухай та бас л мэдэхгүй юу?

Бүсгүй тэр даруй асуултын учрыг нь ойлгосонгүй.

-Та... та яаж зүрхлэнэ вэ? гэх Ларагийн нүдэнд мөс мэт хайрах уур хилэн цоргиж,

-Хэрэв Филиппийг зориудаар зэрэмдэглэсэн бол хэн болохыг нь би мэдэх ёстой! гэв.

-Та ганцаараа мэдэхийг хүсээгүй. Ноён Адлер ч гэсэн хүсч байгаа.

-Та энэ тухай Филипптэй ярилцаа юу?

-Ярьсан. Би...

Агшиний дараа гэхэд бүсгүй хонгилоор хар хурдаараа гүйж байлаа.

Танхимд өндөр өсгийтэй гутлын товших чимээ тодхон сонсогдов. Филипп унтлагынхаа өрөөнд өрөөсөн гараараа эв хавгүйхэн хөдөлж эд хогшлоо хурааж зогсов.

-Фил ээ... чи юу хийж байна? хэмээн Лараг асуухад тэрээр эргэж харан,

-Явлаа! гэж ганц үгээр хариулав.

-Яагаад тэр вэ? Чи арай энэ... энэ



тэнэг түүхэнд итгэлээ гэж үү?

-Лара, худлаа ярьж боллоо.

-Би худлаа хэлээгүй! Сонсооч!  
Филипп ээ, би чамд хайртай шүү  
дээ!

Филипп түүн рүү эгцлэн ширтэж,

-Цагдаагийнхан энэ хүнийг танайд  
ажилладаг гэсэн. Хийснийхээ... шанд  
тавин мянган доллар хүртсэн гэсэн.

-Мэдэхгүй! Мэдэхгүй! Тэр надад огт  
хамаагүй! Итгэхгүй байна уу? гэж  
Лара цөхрөн хашгирлаа.

Адлер таг дуугүй суусаар.

Лара хариу хэлэхийг нь хүлээлгүй  
эргэн сохор хүн мэт тэмтчсээр  
унтлагын өрөөнөөс гарлаа.

\* \* \*

Филиип хямдхан зочид буудалд  
буудаллан шөнийг нойргүй  
өнгөрөөжээ. Ларагийн дүр нүдэнд нь  
үзэгдэж, түүний зарим нэг яриа үе үе  
санаанд орж ирээд байлаа.

Надад... Үнэнийг хэлэхэд танай  
фондын тухай арай тодорхой  
мэдэхийг дуртайяа хүсэх байна.  
Яагаад бид уулзаж, ярилцаж

болохгүй байх вэ?Та эхнэртэй юу?  
Өөрийнхөө тухай яриач...

Таны Скарлатт иадад ийш тийш  
хөлхөлдөх гудамж, туурайн тачигнах  
члмээ, битүү тэрэгний тачигнах  
дуу...Чи намайг Милан хамт явахыг  
хүсэж байна уу?...

Түүний хайр, халамж... Би арай  
аидуурч яваа юм биш биз?

"Палас-Плаза"-д очвол дэслэгч  
Манчини түүнийг бага шиг зааланд  
дагуулан орвол тэртээ хананд нь  
жижгэвтэр тайзархуу тавцан зассан  
байлаа.

-Одоо наашаа хэдэн хүн орж ирнэ.  
Таны даалгавар бол тэдний дунд  
таны мэдэх царай байгаа эсэхийг  
таних явдал шүү.

Лара энэ хэрэгт хутгалдсан л байгаа  
биз хэмээн Филипп бодлоо.

Тайзан дээр бие бялдар, нас шүд  
ойролцоо долоон эрчүүд гарч  
ирэхэд Жесси Шоу дунд нь зогсож  
харагдав. Түүнийг хармагц

Филиппийн зүрх нь галзуутай  
цохилон, чихэнд нь: Түрийвчээ! гэж  
хашгирах сонсогдон зүүн гар нь  
янгинан өвдлөө. Энэ бүхний цаана  
Лара байна гэж үү?

-Ноён Адлер аа, анхааралтай  
хараарай гэж дэслэгч Манчини  
энгийн тайвнаар хэллээ.

Өнөөдрөөс эхлээд гэртээ ажиллана...

-Ноён Адлер аа!

Хайрт минь, бид сайн эмч олно...

-Танд хэрэгтнийг таньж заах  
чадвар...

Би чиний бие эрхтэнд болж  
гэрлээгүй! Би чамд хайртай,  
хайртай! Бэлгийн хавьтал хийхгүй  
байх нь намайг огт айлгахгүй.  
Тэврээд л хэвт, тэгээд л болоо...

Тэд хамтдаа сайхан байлаа.

Унтлагын өрөөнд болсон сүүлийн яриа:

Би чамд хэзээ ч муу юм хийхийг хүсэхгүй.

-Ноён Адлер аа... Цагдаагийнхан андуурчээ. Лара би чамд итгэж байна!

-Эдгээр хүмүүсийн дунд... гэх Сол Манчинигийн дуу гэнэт сон-согдов.

-Мэдэхгүй гэж Филипп товчхон хариулав.

-Юу-уу?

-Би түүнийг олж харахгүй байна.

-Та чинь довтолсон хүнээ сайн харсан гэсэн шүү дээ.

-Тэр ч тийм л дээ.

-Тэгвэл түүнийг заагаадах даа.

-Чадахгүй нь. Энэ долоон эрсийн дунд тэр алга. Манчинигийн царай үрчийн таталдаж,

-Та итгэлтэй байна уу? гэлээ.

-Туйлын итгэлтэй.

-За за, тэгвэл энэ бүхэн дууслаа,  
ноён Адлер аа. Хамтран ажилласанд  
баярлалаа.

Лараг олох хэрэгтэй. Даруйхан олох  
хэрэгтэй! гэж Филипп бодов.

\* \* \*

Лара ажлын өрөөндөө цонх руу  
гөлийн сууна. Филипп түүнд  
итгэсэнгүй. Энэ баримтыг ойлгон  
Пол Мартины тухай бодох бүрийд  
сэтгэл нь тэсвэрлэхийн эцэсгүй  
шанална.

"Мэдээж, энэ бүхэн Мартины урт  
гарын гай. Тэр яах гэж ингэнэ



вэ? Миний хэлснийг санаж байгаа биз? Тэр өөрийн үүргийг нэг л биелүүлэхгүй байгаа бололтой. Филипптэй ярилцах хэрэг гарах нь ээ/”

Говард Келлер царай гэж цорой болчихсон орж ирлээ.

-Дөнгөж сая мэдэгдлээ. Лара аа! Бид "Камерон-тауэр"-ыг алдах нь байна! "Саузерн иншуранс", "Интернэшнл инвестменст" хоёр биднийг хугацаандаа дуусгаагүй гээд гэрээгээ цуцалчихлаа. Барьцааны төлбөр-ийг яах вэ? Тэнгэр баганадсан өндөр... Надад тун харамсалтай байна. Энэ бүхэн чамд ямар их утга учиртайг би

сайн ойлгож байна.

Лара толгойгоо алгуур эргүүлэн түүн рүү харахад нь Келлер түүний тас нар нүдтэй цонхийсон царайг хараад ихэд цочирдлоо.

Лара яг л сүг сүүдэр мэт харагдав.

-Чи намайг сонсов уу? Бид "Камерон-тауэр"-ыг алдах нь байна!

-Сонссон, Говард аа. Бүү санаа зов. Би шинээр зээл аваад төлчихнө гэх түүний дуу нь гайхалтай тайван сонсогдов.

Ларагийн айвуу тайван байдал нь

Говардыг айлгаж орхилоо.

-Шинэ зээл ий? Яаж тэр вэ? Цаг нь болохоор биднийг дампуурсан гэж зарлах байлгүй.

-Говард аа...

-Юу гэв?

-Хайр дурлал ийм хэврэгхэн байж болно гэж үү?

-Чи юу гэвээ?

-Филипп явчихсан гэх Ларагийн хэлсэн товчхон өгүүлбэр түүнд бүгдийг тайлбарлаад өглөө.

-Би... Өршөөгөөрэй. Лара гэв.  
Хүүхний уруул дээгүүр үл ойлгогдом  
инээмсэглэл тодорч,

-Хачин байгаа биз, тийм үү? Би  
хамаг байдгаа алдлаа. Эхлээд  
Филиппийг, дараа нь ажлаа алдлаа.  
Говард аа. чи энэ бүхэн юу болохыг  
мэдэх үү? Энэ чинь хувь заяа минь  
шүү дээ. Тэр миний эсрэг байна, Хүн  
өөрийн хувь заяатайгаа тэмцэж  
болдоггүй юм байна.

Лара хэзээ ч ингэж ярьж байгаагүй  
билээ. Келлерийн зүрх нь хүчтэй  
базаллаа.

-Лара...

-Гэхдээ энэ бол төгсгөл бишээ. Үдээс хойш Дээд шүүхийнхэнтэй уулзахаар би Рино орно. Хэрэв...

Дотуур холбоо чадхийн аяархан дуугарлаа.

-Дэслэгч Манчини тантай уулзах гэнэ, Камерон авхай гэв.

-Орог, орог.

Келлер эргэлзэн толгойгоо өлсхийлгэн,

-Манчини юу? Тэрэнд юу хэрэгтэй юм бэ? гэв.

Лара гүн амьсгаа аваад,

-Говард аа, намайг баривчлах гэж байгаа юм гэлээ.

-Чамайг баривчлах ий? Чи юу ярина вэ?

-Цагдаа нар намайг Филиппэд халдсан хэргийг зохион байгуулсан гэж үзэж байгаа юм хэмээн Лара хайхрамжгүй хэллээ.

Өрөөний үүд нээгдэн Сол Манчиний орж ирэв. Тэрээр Лара, Келлер хоёрыг нүд гүйлгэн ээлжлэн хараад ширээнд дөхөж ирлээ.

-Надад таныг баривчлах эрхийн бичиг байна.

Говардын царай хүрэнтэж харлан, бүх биеэрээ өөрийн мэдэлгүй эргэн, Лараг халхлан зогслоо.

-Ийм байх ёсгүй. Тэр юунд буруутай юм бэ?

-Таны түмэн зөв, ноён Говард Келлер ээ. Эрхийн бичигт таны нэр бичээстэй байгаа.

## Гучин тавдугаар бүлэг.

Говард Келлерийн байцаасан тэмдэглэл. Мөрдөгч Сол Манчини.

М: Ноён Келлер та эрхтэйгээ танилцсан уу? К: Танилцсан.

М: Та өмгөөлөгч авахгүй юм уу?

К: Надад өмгөөлөгчийн хэрэггүй. Би дуудсан цагт өөрөө тан дээр хүрч ирнэ. Лара энд ямар ч буруугүй.

М: Та Жесси Шоуг Филипп Адлерт халдсаных нь шагналд тавин мянган доллар өгсөн үү?

К: Тэгсэн.



М: Яагаад тэр вэ?

К: Филипп Ларагийн амьдралын там болгосон юм. Тэр нөхрийгөө гэртээ байлгахыг гуйж мөргөдөг боловч тэр нь аялан тоглолтоор санжигнаж явахыг илүүтэйд үзэж байсан юм.

М: Тэгээд та түүний гарыг зэрэмдэглэхийг хүсжээ.

К: Бас ч бүх юм тийм биш л дээ. Жесси хэтрүүлчихсэн байна лээ.

М: Билл Уайтманы тухай яриач.

К: Арчаагүй новш. Тэр Лараг далайлган сүрдүүлэхийг оролдсон

юм. Би үүнийг тэсвэрлээгүй юм.  
Тэгээгүй бол Ларагийн нэр хүнд унах  
байсан.

М: Та түүнийг үхэлд хүргэжээ.

К: Тийм ээ, Ларагийн төлөө.

М: Лара таны төлөвлөгөөний тухай  
мэдсэн үү?

К: Мэдээж үгүй. Тэр хэрхэвч  
зөвшөөрөхгүй. Үгүй, үгүй. Та ойлгож  
байна уу, би түүнийг хамгаалах  
ёстой байсан юм. Түүний өмнөөс  
үхэхэд ч бэлэн байна,

М: Эсвэл үхэлд хүргэх.

К: Дэслэгч ээ, танаас ганц юм асууя.  
Намайг гэдгийг та яаж мэдээ вэ?

\* \* \*

"Палас-Плаза"-гийн байранд ахмад  
Бронсон,

-Сол оо, чи түүнийг гэж яаж мэдээ  
вэ? гэхэд дэслэгч,

-Келлер тун ч нямбай няхуур  
хөдөлсөн, гэтэл өчүүхэн төдий  
сэжүүрийн үзүүрийг анзаараагүй. Би  
ч гэсэн тэр сэжүүрийг алдах шахсан  
юм. Манай мэдээлэлд Шоуг Арван  
долоон настай, бэлтгэлийн хувцас  
хулгайлсных нь төлөө Чикагогийн

запуучуудын шигшээ багаас хөөсөн гэсэн байсан. Би үүнийг үзүүт тэр хоёр нэг багт тоглож байсан гэж бодсон. Ингэж л анх удаа Келлерийн нэрийг тодруулсан даа. Миний асуухад тэрээр Жесси Шоугийн тухай амьдралдаа ганц удаа ч сонсоогүй гэж тун итгэлтэй хариулсан. Би "Сан таймс"-ын спортын тайлбарлагч байсан найз руугаа утасдсан. Тэрээр энэ хоёрыг тун сайн найзууд гэдгийг санаж байсан. Багийнхан нь ч хүртэл тэр хоёрыг найзууд гэдэг байсан гэж нотолсон. Чухамдаа Келлер Шоуг "Камерон-энтерпрайз"-ад ажиллахад нь тусалсан. Ларагийн өмнө Шоугийн тухай ганц ч үг

дурсаагүй гэлээ.

-Сол оо, өөлөхийн аргагүй ажил байна шүү. Манчини толгой сэгсэрч,

-Байз байз, гэтэл энэ бүхэн эцсийн дүндээ огтын ач холбогдолгүй болж өнгөрсөн. Хэрэв юу ч сэжиглэлгүйгээр Лара Камеронтай зууралдаад байсан бол, Келлер өөрөө бидэн дээр ирж, үнэнээ хүлээх байсан юм.

Түүний дасаж дадсан ертөнц нь сүйрч нурлаа. Лара түүний үнэнч шударга найдвартай, байц хад мэт тулга түшигтэй Говард нь энэ бүхнийг хийсэн гэхэд тэрээр итгэж

ядна.

Тэр энэ бүгдэйг миний төлөө хийсэн.  
Би түүнд туслах ёстой.

Дотуур холбоогоор Кэтийн дуу  
хадан,

-Хатагтай Камерон, машин үүдэнд  
ирсэн, та бэлэн үү? гэв.

-Бэлээн. Ринод Дээд шүүхийнхэн  
түүний мэдүүлгийг хүлээж байв.

Лара офисоос гарч явснаас таван  
минутын дараа Филипп утасдав.

-Тун харамсалтай байна, ноён Адлер

аа, та хоцорчихлоо. Лара Рино руу явчихсан гэв. Түүний урам хугаран,

-Хэрэв хатагтай Адлер тантай холбоо баривал намайг хүлээж байна гэж хэлээрэй.

-Заавал хэлнэ, эрхэм ээ.

Филилп дахин нэг дугаарт залган арваад минут ярьсны хойно, Эллерби руу залгалаа.

-Уильям аа, би ер нь Нью-Йоркод багш болж үлдэхээр шийдлээ гэв.

\* \* \*

-Тэд намайг яах бол оо? гэж Лараг асуухад өмгөөлөгч,

-Яаж тааж мэдэх вэ? Эхлээд шүүгчид таны мэдүүлгийг сонсоно, харин дараа нь таныг буруугүй гэж үзэн тоглоомын газрыг буцааж өгнө, эсвэл баримт хангалттай гэж үзэн шүүхэд шилжүүлнэ дээ. Хэрэв тэд шүүхэд шилжүүлбэл, танд хорих ял онооно гэхэд нь Лара амандаа бувтнав.

-Өршөөгөөрэй, Камерон авхай та юу гэв?

-Би-аавын зөв байж гэж байна. Энэ бол хувь заяа.



Шүүгчид дөрвөн цаг шахам  
Ларагийн мэдүүлгийг сонсон сууц-  
гаалаа. Тэд түүнийг хэрхэн "Камерон  
Палас"-ыг болон мөрийтэй  
тоглоомын газрын эзэн болсон тухай  
асууж шалгаалаа. Терри Хилл гадагш  
гарсан хойно Ларагийн гарыг  
чангаар атган,

-Камерон авхай, та биеэ гайхалтай  
эзэмдлээ! Бүх юм сайн сайхан болно  
гэж бодож байна. Тэдэнд шууд  
нотлох баримт байхгүй учраас...

Өмгөөлөгч гэнэт дуугүй болоход нь  
Лара эргэн харлаа. Амрах

тасалгаанд хоёр энгэртэй даруухан пиджак, цасан цагаан цамцтай буянтайг илтгэсэн буурал үсээ богинохон засуулсан Пол Мартин итгэл төгс алхаж явав.

-Түүнийг гэрчээр дуудлаа гэж үү? Пол таныг үнэн сэтгэлээсээ үзэн ядаж байгаа юу, хэлээч? гэж Терриг асуувал,

-Ойлгосонгүй, Жерри... гэж Лара гайхав.

-Лара хэрэв Мартиныг мэдүүлэг өгөх үүрэг хүлээлгэсэн бол бид баларлаа гэсэн үг. Та торны цаана суух болох нь.

Хүүхэн харц буруулан өөр тийш харлаа.

-Гэхдээ, ийм нөхцөлд... мэнд мэдэхийн хэрэггүй.

-Тийм учраас л би асуусан юм. Тэр таныг өөртэйгээ хамт үгүй хийхийг хүсэх болов уу?

-Мэдэхгүй...

-Лара.чамтай уулзсандаа баяртай байна! гэсээр Пол Мартин тэдэнд дөхөж ирлээ.

-Би дуулсан, чамд таагүй явдал тохиолдоо юу? Харамсаж байна шүү,

охин минь гэх түүний нүд хий  
гөлийнө.

Лара Говард Келлерийн хэлсэн:

Тэр сицили хүн. Сициличүүд хэзээ ч  
өршөөдөггүй! Хэзээ ч мартдаггүй юм.  
Хичнээн агуу хүн байлаа ч гэсэн өс  
хонзонгоор ангаж цангаж явдаг гэж  
үү? Бүсгүй үүнийг эс мэджээ.

Пол Мартин явахаар цааш эргэхэд  
нь Лара,

-Пол оо... гэвэл тэрээр хөшиж орхив.

-За юу гэв?

-Бид ярилцах хэрэгтэй гэж Лара хэлэв.

Хэсэг дуугүй зогсож байснаа,

-Тэгье л дээ гээд Пол нээлттэй хаалгыг заан,

-Тэнд хэн ч бидэнд саад болохгүй гэв.

Терри Хилл тэр хоёрыг араас нь харсаар хоцорлоо.

Ямар ч үнээр болсон хамаагүй тэдний яриаг сонсохсон хэмээн өмгөөлөгч тэчьядан боджээ.

Лара юунаас эхлэхээ мэдсэнгүй.

-Охин минь, чи юу хүсээ вэ?

Бүх юм бүсгүйн санаснаас илүү хэцүү санагдаад ирлээ. Эхний үгээ арай ядан амнаасаа унаган,

-Чамайг надыг тавьж орхиоч гэж хүсэх байна гэв.

Пол гайхан хөмсгөө өргөж,

-Тавих ий? Би чамайг бариад байгаа хэрэг үү! гэхдээ Мартины дуунд цагаахан сэтгэлтэй хүний өгөөдөх өнгө сонсогдов.

Бүсгүйн цээж давчдан амьсгалахад  
бэрх боллоо.

-Намайг хангалтгай шийтгэсэн гэж чи  
бодохгүй байна уу?

Мартины царай тааж мэдэхийн  
эцэсгүй болов.

-Пол оо, бид цагийг сайхан  
өнгөрөөсөн. Филиппийг эс тооцвол  
чам шиг ойр дотно эр хүн надад  
хэзээ ч байгаагүй. Би чамд их өртэй ч  
амьдралдаа чамд ганц ч муу юм  
хийгээгүй, итгээрэй. Чиний эрх  
мэдэл, одоо намайг хөнөөх нь  
байна. Чи үүнийг хүслээ гэж үү?  
Намайг торны цаана суувал чи

жаргалтай байх юм уу? гээд арай  
ядан нулимсаа тэвчиж,

-Пол оо, чамайг гуйя. Намайг  
амьдралд минь буцааж тавиач. Би  
дайсан биш гэдгийг ойлгооч! гэв.

Мартины харц урьдын адил юуг ч эс  
илэрхийлнэ.

-Би чамаас хүлцэл эрье. Би...  
тэмцсээр байгаад туйлдаж гүйцлээ,  
Пол оо. Чи яасан... гээд Ларагийн  
хоолой нь чичигнэв,

Хаалга тогшин, шүүхийн түшмэл  
шагайж,



-Шүүгчид таныг хүлээж байна, ноён  
Мартин гэв.

Пол Мартин агшин зуур зогтуссанаа  
гарч одлоо. Өнгөрсөн. Бүх юм  
өнгөрсөн гэж Лара бодов.

Өмгөөлөгч Терри Хилл гялсхийк орж  
ирлээ,

-Би байна шүү түүнийг тэдэнд юу  
хэлэхийг сонсохсон гэхээс тэсэхгүй  
нь ээ, Бурхан л мэдэг дээ. Тэвчих  
хэрэгтэй, Лара тэвчих хэрэгтэй.

Тэд хүлээсээр, минут ар араасаа  
үргэлжилсээр. Гэнэт үүд нээгдэн  
Мартин мэдүүлэг өгч байсан

танхимаас гарч ирлээ,

Тэрээр ихэд царай алдсан харагдана. Пол хөгширчээ. Үүнийхээ төлөө намайг буруутгана даа хэмээн Лара бодов.

Пол Мартин тээнэгэлзсэнээ түүнийг чиглэн ирлээ.

-Лара, би чамайг уучилж чадна. Чи намайг дүүрчихсэн мангуу амьтан болгож орхисон. Яг чамтай адилхан надад өөр хэн ч байгаагүй. Тэгэхээр би чиний өмнө өртэй хүн. Би тэдэнд нэг ч үг хэлээгүй. Ларагийн нүдийг нулимс бүрхээд ирлээ.

-Пол оо... Надад чамаар...

-Энэ миний бэлэг болог. Төрсөн өдрийн мэнд хүргэе, охин минь гээд түүнийг цааш алхаснаас нилээд хожуу Лара түүний хэлснийг ойлголоо. Өнөөдөр чинь түүний төрсөн өдөр шүү дээ! Сүүлийн долоо хоногийн туршид өч төчнөөн үйл явдал ар араасаа цувран тохиолдсоор найр наадам нь мартагдаж орхижээ. "Камерон плаза"-д хоёр зуун зочин тэсэн ядан хүлээж байгаа! Лара Терри Хилл тийш эргэн,

-Би орой Нью-Йоркод байх ёстой. Тэнд намайг хоёр зуун хүн хүлээж

байгаа. Шүүгчид миний явахыг зөвшөөрөх болов уу? гэв.

-Хүлээгээрэй гээд Терри босож хаалга хаагаад эргэж ирэх хүртэл бүхэл зуун өнгөрөх шиг санагдлаа.

-Та санасан зүгтээ явах эрх чөлөөтэй шүү дээ, Лара. Эрхэм шүүгчид өөрсдийн шийдвэрийг өглөө л айлдах болно, гэвч энэ нь одоо цэвэр ёс төдий л ажил. Шөнө дундад хүрээд ирнэ биз. Дашрамд хэлэхэд Пол Мартин танд үнэн хэлсэн шүү. Тэд түүнээс ганц ч үг олж сонсоогүй.

\* \* \*

Гучин минутын дараа гэхэд Лара хувийн "Боинг-727"-ийнхоо бүхээгт суун, өтгөн хар үүлтэй, цахилгаан цахих тэнгэрт нисэж явжээ.

-Та зүгээр үү?

Лара толгой дохиж,

-Зүв зүгээр гэв.

Зочид аль хэдийнэ ирчихсэн хүлээж байгаа. Лара мөрөө цэхэллээ. Тэр бол хэзээ ч цуцаж мохошгүй Лара Камерон шүү дээ!

"Камерон-плаза"-гийн асар том хов хоосон танхимын дунд Лара ганцаар

ёрдойн зогсож ийш тийш харна.

Би мянга мянган хүмүүсийн амьдралыг өөрчлөх дэлхийн хамгийн өндөр барилгыг босгосон. Гэтэл одоо энэ бүхэн маань банкны эздийн гарт орох боллоо! Чихэнд нь эцгийнх нь: Хувь заяа минь үргэлж миний эсрэг байх юм гэх нь сонсогдов. Төрсөн нутаг Глэй-Бэй нь санагдан, сүлд хийморьгүй хөлсний байр, сургуульд орж байсан анхны өдөр нь санагдаж: За одоо "P" үсгээр эхэлсэн үг хэлээрэй гэж байсан нь бодогдлоо.

Нүдэнд нь Билл Рожерс үзэгдэж, Юуны өмнө Б. Х. М гэдгийг чи

тогтоож ав гэв. Бас Чарлз Коэний захилгат хоолыг бэлггэж байсан нь санагдав.

... хэрэв би барилга бариад таалагдвал та таван жилээр түрээслэхийг зөвшөөрөх үү...

... яасан ч үгүй. Гэрээг арван жилээр хийнэ,

Дараа нь Шон Макаллистер: Надад бага зэргийн шагнал хэрэгтэй эсвэл урамшуулал ч гэнэ үү, хүссэнээр... үнэнээ хэлээч Лара, чи найз хархүүтэй байсан уу?,

Түүний араас Говард Келлер: Чи

бүгдийг ойлгосонгүй!... Бид хамтдаа ажиллаж болох л байсан...

Ингээд эцэст нь амжилтууд, санаанд оромгүй сүр дуулиантай амжилтууд нь нүдэнд нь эрээлжлэв.

Бас Филипп Адлер, түүний мөрөөдлийн хан хүү. Энэ түүний хамгийн том гарз байлаа.

-Лара... хэмээн дуудахад нь эргэн харвал Жерри Таунсенд ард нь зогсож байв.

-Карлос чамайг энд байгаа гэж хэлсэн юм. Баярын ажиллагаа болоогүй нь надад үнэхээр



харамсалтай байна.

Ларагийн хуруунууд чичигнэн түүний пиджакных нь товчийг оролдож эхэллээ.

-Юу... юу болсон юм бэ?

-Говард хэлээгүй юм уу?

-Юу ч хэлээгүй.

-Хэвлэлийнхний дэгдээсэн шуугианаас болж бид хоёр зуун зочноос татгзлзсан хариу олныг хүлээн авсан тул хүлээн авалтыг хойш-луулахаар шийдсэн юм. Би Говардыг танд дамжуулахыг гуйсан

сан...

Яг үнэнийг хэлэхэд Лара минь,  
сүүлийн үед миний ой ухаан нэг л  
биш дэг ээ.

-Өө, яахав гэснээ бүсгүй танхимыг  
нүд гүйлгэн дахин нэг хараад,

-Би энд мөч хэртээ байчихлаа шүү  
гэв.

-Та юу гэв ээ?

-Жерри, бүү анзаар гээд Лара үүд  
чиглэн явлаа.

-Офис руу очих уу? Дуусгах ёстой

бага сага ажил бий юмсан гэж  
Жерриг хэлэхэд нь Лара,

-О'кэй гэлээ.

Би дахин ийш хөл тавихгүй шүү дээ  
хэмээн Лара гашуудан бодлоо.

Жерри цахилгаан шатны бүхээгт  
орсон хойно,

-Надад Келлерийн тухай хэлсэн.  
Түүнийг энэ бүхнийг хийсэн гэхэд  
итгэж чадахгүй нь гэв.

-Энэ бүхний хариу нь би шүү дээ,  
Жерри. Ганцхан би.

-Лара, энд таны буруу байхгүй ээ.  
Хүүхэн гэнэт өөрийгөө туйлгүй  
ганцаардаж байгаагаа мэдэрлээ.

-Тэгэхээр, Жерри, та оройн хоол  
идээгүй бол...

-Уучлаарай, Камерон авхай. Би орой  
ажилтай гэв.

-Зүгээр ээ, бүх юм сайхан болно.

Цахилгаан шат зогсон тэд буулаа.

-Таны гарын үсэг зурах бичиг  
баримтууд зөвлөлгөөний өрөөнд бий  
хэмээн Таунсенд хэллээ.

Зөвлөлгөөний өрөөний үүд хаалттай байлаа. Жерри түлхүүрийг Ларад өгөхөд тэрээр үүдийг нээн царс модон хүнд хаалгыг нээнгүүт гэнэт дор хаяж дөчөөд хүн хоолой нийлүүлэн:

"Төрсөн өдрийн мэнд хүргэе..." гэх сонсогдов.

Өрөө Ларатай он удаан жил мөр зэрэгцэн ажиллаж байсан архитектор, барилгын инженер, гэрээ гүйцэтгэгчид, менежерүүдээр дүүрчээ. Тэдний дунд Чарлз Коэн, профессор Майер, Хорэс Гутман Кэти, Жерри Таунсендын аав хүртэл зогсож байлаа.

Лара тэр даруй түүний Филипп нь зогсож байхыг олж харав. Адлер гараа алдалсаар эхнэрээ угтан авлаа.

- Лара... Лара нулимсаа арай гэж барьсаар, нөхрийнхөө цээжинд наалдав.

Гэртээ ирчихэж! Би гэртээ ирчихлээ!  
Надад өөр юу ч хэрэггүй.

Зочид тэднийг тал талаас нь бүчин авлаа. -Лара төрсөн өдрийн мэнд хүргэе!

-Чи охин тэнгэр шиг үзэсгэлэнтэй харагдаж байна!

-Чи гайхсан уу, аан? хэмээн асууж шаагилдацгаав.

Лара Жерри Таунсендэд хандан,

-Жерри, та яаж... гэвэл Жерри мөрөө хавчисхийлгэн,

-Энэ бүхнийг Филипп санаачилсан гэлээ.

Цагаан бүтээлгээр бүтээсэн ширээ тийш үйлчлэгчид яаравчлан хурдалж зоогийн ширээ бэлдэцгээв.

-Хэрхэн гэдэг тийм чухал биш, гэхдээ би чамаар бахархаж байна шүү, Лара! Чи зорьсондоо хүрчээ гэж

Чарлз Коэн хэллээ.

-Би энэ эмэгтэйд үхэн үхтлээ өртэй хүн шүү гэж аав Таунсенд намуухан дуугаар хэлэв.

-Би ч бас! хэмээн Кэти дуу алдах сонсогдлоо.

-Ерөөл хэлье! Надад хэлэх ерөөл байна! хэмээн хүү Таунсендийн аргил хоолой бүгдийн дууг дараад,

-Энэ орчлонгийн хамгийн шилдэг боссынхоо төлөө! гэлээ. Эцэст нь Филиппийн ээлж болж, тэрээр нухацтай үг хэлэхээр бэлтгэж байснаа санаанд оромгүй намуухан



дуугаар,

-Миний хайртай хүний төлөө гэлээ.  
Лара нулимсаа барьж чадсангүй.

-Би... би маш их баярлаж байна...  
Одоо надаа Та бүхэндээ баярлалаа!  
гээд бүсгүйн сормуусыг даган  
нулимс дуслахад Филиппэд наалдан,

-Хайрт минь, чамдаа бүр ч их  
баярлалаа! Би хэзээ ч төрсөн өдрөө  
ийм сайхан тэмдэглэж байсангүй  
шүү! гэв. Терри Хиллийн:

Шөнө дундад хүрээд ирнэ биз гэж  
хэлж байсан нь санаанд нь орон,

-Бурхан минь, би Рино руу буцах ёстой! гэлээ.

Филипп инээмсэглэн, -Би Ринопд очиж үзээгүй юм байна гэв. Хагас цагийн дараа тэд нисэх буудал руу хурдалж байлаа. Лара Филиппийн гарыг атган:

Тэгэхээр би юугаа ч алдаагүй байх нь ээ! Надад хэдий хэр амьдрах хугацаа үлдсэн бийна, тэр амьдралаа зөвхөн түүний төлөө л зориулна. Бусдыг нь мартана аа. Түүнтэй хамт байж, халамжлах болно, өөр юу ч хэрэггүй хэмээн бодож явав.

Тэрээр машины цонхоор гадагш ширтэн явж байснаа гэнэт,

-Макс аа, машинаа зогсоо гэлээ.

Тоормос хяхтнан дуугарч машин зогсоход, Филипп төмөр тороор хашаалсан хоосон газрыг харан гайхаж,

-Лара яасан бэ? гэж асуув.

-Фил ээ, хар даа.

-Харж байна. Юуг тэр вэ?

-Харахгүй байна гэж үү?

-Юуг тэр вэ?

-Бурхан минь, энэ чинь ёстой гайхамшиг! Тэр баруун гар талд нь худалдааны төв байна! Дунд нь би хоёр орон сууцны цамхаг босгоно, харин зүүн гар талд байгаа тэр газарт гурван барилга барих зай элбэг байна. За харав уу? гэхэд нь Филипп гайхсандаа ховсдуулсан мэт боллоо. Лара түүний гарыг нь атган,

-Энэ чамд барих миний бэлэг гэжээ.

**ТӨГСӨВ.**